ЗАХИАЛАГЧ

**НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР**

ГҮЙЦЭТГЭГЧ:

**“ЭН БИ СИ СИ” ХХК**
Авто замын зураг төсөл, зөвлөх үйлчилгээ

**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 41 ДҮГЭЭР ХОРОО, 124 ДҮГЭЭР СУРГУУЛЬ, 158 ДУГААР ЦЭЦЭРЛЭГ ХҮРТЭЛХ ШИНЭЭР БАРИГДАХ АВТО ЗАМЫН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ**

# ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

УЛААНБААТАР ХОТ 2023 он

НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН
ХӨГЖЛИЙН ГАЗАР

"ЭН БИ СИ СИ" ХХК
Авто замын зураг төсөл,
зөвлөх үйлчилгээ

**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 41 ДҮГЭЭР ХОРОО, 124 ДҮГЭЭР СУРГУУЛЬ, 158 ДУГААР ЦЭЦЭРЛЭГ ХҮРТЭЛХ ШИНЭЭР БАРИГДАХ АВТО ЗАМЫН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ**

# ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

Гүйцэтгэсэн: Инженер Б.Баяржаргал

Шалгасан: Ерөнхий инженер С.Ганхуяг

УЛААНБААТАР ХОТ 2023 он

# 100 - ЕРӨНХИЙ

## БҮЛЭГ 100 - ЕРӨНХИЙ


| | | |
|---|---|---|
| 101 | БАЙРШИЛ БА ХАМРАГДАХ ГАЗРУУД | 1-3 |
| 102 | ГЭРЭЭНД ХАМРАГДАХ ЗҮЙЛҮҮД | 1-3 |
| 103 | ЗУРАГ | 1-4 |
| 104 | ХӨТӨЛБӨР/ТӨЛӨВЛӨГӨӨ | 1-4 |
| 105 | АЖЛЫН ДАРААЛАЛ | 1-5 |
| 106 | ИНЖЕНЕРТ ТАНИЛЦУУЛАХ ЖУРАМ | 1-5 |
| 107 | АЖИЛ ХҮЛЭЭН АВАХ АКТ | 1-6 |
| 108 | БАРИЛГЫН АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ АРГАЧЛАЛ | 1-6 |
| 109 | ТӨСЛИЙН ЧАНАРЫН ХЯНАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ | 1-7 |
| 110 | ХЭМЖИЛТИЙН НЭГЖ, ТОВЧИЛСОН ҮГС БА НЭР ТОМЬЁО | 1-8 |
| | (а) Хэмжилтийн нэгж | 1-8 |
| | (б) Товчилсон үгс | 1-9 |
| 111 | СТАНДАРТ ШААРДЛАГУУД | 1-10 |
| 112 | БУСАД ГҮЙЦЭТГЭГЧ | 1-11 |
| 113 | АЖИЛЧДЫГ ТЭЭВЭРЛЭХ | 1-11 |
| 114 | ТҮР БАРИЛГА | 1-11 |
| 115 | БАРИЛГЫН АЖИЛД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГУУД | 1-12 |
| 116 | ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА АВААР ОСОЛ | 1-15 |
| 117 | ХАШАА ХААЛГЫГ ХАМГААЛАХ, ЗАСВАРЛАХ | 1-18 |
| 118 | ИНЖЕНЕРИЙН БАЙГУУЛАМЖ, ШУГАМ СҮЛЖЭЭГ ХАМГААЛАХ | 1-18 |
| 119 | ИНЖЕНЕРИЙН БАЙГУУЛАМЖИЙГ ШИЛЖҮҮЛЭХ | 1-20 |
| 120 | ЗАСГИЙН ГАЗАРТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ | 1-20 |
| 121 | ГАЗАР АВАХ | 1-20 |
| 122 | УСАН ХАНГАМЖ | 1-21 |
| 123 | МАТЕРИАЛ БА ХИЙЦ ХЭСГҮҮД | 1-22 |
| 124 | ЦООНОГ БА ШИНЖИЛГЭЭНИЙ НҮХНЭЭС АВСАН МАТЕРИАЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ | 1-22 |
| 125 | МАТЕРИАЛ, ХИЙЦ ХЭСГҮҮДИЙГ ХАДГАЛАХ | 1-22 |
| 126 | ШИНЖИЛГЭЭНИЙ СЕРТИФИКАТ | 1-23 |
| 127 | ГЭРЭЛ ЗУРАГ | 1-23 |
| 128 | ЗАМЫН САМБАР | 1-23 |
| 129 | ТАЛБАЙН ЛАБОРАТОР | 1-23 |
| | (а) Ерөнхий | 1-23 |
| | (б) Талбайн лаборатори | 1-24 |
| | (i) Талбайн лаборатори | 1-25 |
| | (ii) Талбайн лабораторийн тоног төхөөрөмж, аппарат хэрэгсэл | 1-25 |
| | (iii) Талбайн лабораторид байрлуулах стандартууд | 1-31 |
| 130 | ЗАМЫН ДАГУУ МОД ТАРИХ | 1-31 |
| 131 | БАЙГАЛЬ ОРЧНЫ ЧАНАРЫН ХЯНАЛТ | 1-32 |
| 132 | ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР | 1-32 |

## 101 БАЙРШИЛ БА ХАМРАГДАХ ГАЗРУУД

Энэхүү Гэрээг бүрдүүлж буй ажил Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэг 41-р хороо, 124 дүгээр сургууль, 158 дугаар цэцэрлэг хүртэлх шинээр баригдах авто зам юм.

Замын дагуух чиглэлийн талаарх нарийвчилсан мэдээллийг Зурагт үзүүлсэн болно. Хэсэг тус бүрийн эхлэл, төгсгөлийн цэгүүд нь Зурагт заасны дагуу байх ба ажил эхлэхээс өмнө эдгээрийн талаар Инженерийн зааварчилгааг авна.

Ажлын Талбайд, зурагт үзүүлсэн дараах зүйлс хамаарах буюу эсвэл Инженерийн зөвшөөрөлтэйгөөр гэрээнд тусгагдсаны дагуу байна. Үүнд:

- Замын зурвас газар,
- карьерууд,
- шороон ордууд,
- хаягдал зайлуулах газар,
- туслах замууд,
- түр замууд,
- Гүйцэтгэгчийн түр байгууламжууд,
- Хадгалах, агуулах газрууд
- Түр лагерууд,
- Талбайн лабораториуд,
- Инженерийн ажлын байр ба оршин суух байрууд
- Замын дагуу тарих модны зурвас, түүнийг ургуулах, хамгаалах байгууламжууд
- Замын дагуу байгуулах үйлчилгээний цогцолбор.

## 102 ГЭРЭЭНД ХАМРАГДАХ ЗҮЙЛҮҮД

Гэрээнд Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэг 41-р хороо, 124 дүгээр сургууль, 158 дугаар цэцэрлэг хүртэлх гудамжинд (цаашид барилгын ажил гэж нэрлэнэ) шинээр барих ажлууд багтана. Төлөвлөж буй авто зам 7м өргөн асфальтбетон хучилт, хоёр талдаа 3м өргөн явган хүний замтай, нэг талдаа 2м өргөн ногоон байгууламжтай гудамж зам юм.

Гэрээнд хамрагдах ажил нь дараах гол зүйлүүдээс бүрдэх ба гэхдээ зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй:

(а) Инженерийн хэрэгцээнд зориулсан талбайн лабораториуд, лабораторийн тоног төхөөрөмж, оршин суух байр, ажлын байр, хяналтын байр, тэдгээрийн тавилга, тоног төхөөрөмж, унаа зэргийг хангаж, засвар үйлчилгээг хийх,

(б) Талбайг цэвэрлэх, улаан шугам тавих, гадаслагаа хийх,

(в) Далан барих, уул даваany хэсэгт гүнзгий ухмал хийх гэх мэт замын ухалтын ажил,

(г) Ажилд ашиглах материалыг олдворлоход шаардагдах нэмэлт ажлууд,

(д) дугуй, дөрвөлжин хоолой, тэдгээрийн толгой,далавч барих, орох гарах амсрын бэхэлгээг хийх,

(е) шуудуу, хөрсөн доорх шүүрүүлэлт, жижиг ус зайлуулах байгууламжууд, хажуугийн болон уулын шуудуу, бусад төрлийн шуудуунууд, (жишүү байрлалтай хоолой), шуудууны доторлогоо хийх гэх мэт, гэхдээ зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүйгээр ус зайлуулах шаардлагатай бүх байгууламжуудыг барих ажлууд,

(ё) ердийн болон хүчитгэсэн арматуртай төмөр бетон гүүр барих,

(ж) инженерийн шугам сүлжээг шилжүүлэх, зайлуулах, өндөрлөх, хамгаалах,

(з) хүйтэнд тэсвэртэй үе, суурийн доод үе, буталсан чулуун суурь ба хөвөө барих,

(и) асфальт бетон хучилт ба гадаргуун давхар өнгө боловсруулалт хийх,

(й) замын тоноглолыг хангаж суурилуулах,

(к) төмөр замын гармыг барих, дохиолол, гэрэлтүүлгийн тоноглолыг бэлтгэж суурилуулах,

(л) Ажлын талбайгаар өнгөрч буй хөдөлгөөнийг зохицуулах,

(м) Ажлыг хэрэгжүүлэх нөхцөл боломжоор хангах үүднээс шаардлагатай нэмэлт ажлуудыг хийх,

(н) Барилга хүлээн авсан гэрчилгээг олгох хүртэлх ажлыг бүхэлд нь хариуцах, баталгаат засварын хугацааны туршид засвар арчлалтыг хийж гэмтэл согогийг арилгах ажлыг гүйцэтгэх.

## 103 ЗУРАГ

Гэрээний нөхцлүүдэд заасан зургууд нь тендерийн бичиг баримтанд орсон бөгөөд зургуудыг гэрээнд заасны дагуу хангана.

Зохистой хэмжээнд ажлыг хэрэгжүүлэхийн тулд инженерийн тухай бүрд өгөх зааврын дагуу гэрээний нөхцөлүүдийн дэд-зүйл 7.1-д зааснаар тэдгээр зургуудыг өөрчлөх болон нэмэх байдлаар засварлах боломжтой. Гүйцэтгэгч, тендерийн бичиг баримтын 3-р ботид орсон зургуудын хамт тэдгээр зурганд хийсэн өөрчлөлт нэмэлт зэргийг харгалзан ажлыг хийж гүйцэтгэнэ.

## 104 АЖЛЫН ХӨТӨЛБӨР ТӨЛӨВЛӨГӨӨ

Зам барилгын ажлыг гүйцэтгэхдээ Гэрээний нөхцлүүдэд заасан ажлын хөтөлбөр/төлөвлөгөөг CPM /PERT аргачлалаар сүлжээ графикийн хэлбэрээр бэлтгэсэн байх ба үүн дээр, төслийн зам баригдах газар орны цаг агаарын нөхцлийг харгалзан хийгдэх бүх бэлтгэлийг хангах, машин техник, тоног төхөөрөмж, материал, сэлбэг хэрэгсэлийг оруулж ирэх, барилгын ажлыг явуулах, тэдгээрийн харилцан хамаарал, саад бэрхшээл зэргийг харуулсан нэмэлт сүлжээ графикийг боловсруулан, Гэрээ байгуулах эрх олгох тухай албан бичгийг хүлээн авсанаас хойш 28 хоногийн дотор танилцуулна. Бүх нэмэлт сүлжээ график нь үндсэн сүлжээ графиктайгаа нягт уялдаатай байх буюу түүний үр дагавараас үүдэн гарсан байна. Сүлжээ ба дэд-сүлжээг цаг хугацааны дараалаар харуулсан график хэлбэрээр танилцуулна. Сүлжээ график, нэмэлт сүлжээ графикийн хугацааны нэгж нь 1 өдөр байна. Долоо хоногийн амралтын өдрүүд, баярын өдрүүд ба өвлийн түр зогсолтын хугацаа зэргийг шугаман графикаар үзүүлнэ. Туслах ажилчид, бусад ажиллагсдыг ажиллуулах төлөвлөгөөг сар бүрээр харуулсан хуваарь ба өссөн дүнгээр харуулсан “S” муруйн хэлбэрээр шугаман графиктаа оруулна. Гол шаардлагатай тоног төхөөрөмжийг оруулж ирэх, буцаан гаргах хуваарийг мөн шугаман графикт үзүүлэх ба энэхүү графикийн доорх хүснэгтэнд холбогдох мэдээллийг нэгтгэн харуулсан байна.Төлөвлөсөн ажлуудыг өссөн дүнгээр “S” муруй хэлбэрээр мөн графикаар үзүүлэх ба хэвтээ тэнхлэгт ажлын хэмжээг, босоо тэнхлэгт эзлэх хувийг харуулна.

Ажлын төлөвлөгөөг бэлтгэх, шаардлагатай үед шинэчилж, өөрчилж байх үүднээс Гүйцэтгэгч энэ зорилгоор ашиглах компьютер, тохиромжтой програм хангамжаар өөрийгөө хангах ба эдгээрийн сонголт, төрөл загварын талаар Инженерээс урьдчилан зөвшөөрөл авна. Гүйцэтгэгч, ажлын хөтөлбөрөө улирал бүр тогтмол эсвэл Инженерийн заасан хугацаанд шинэчилнэ. Гүйцэтгэгч, ажлын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах бүх програм хангамжуудын эх хувь ба шаардлагатай үед хөтөлбөрийг шинэчлэн өөрчлөхөд хэрэглэгдэх бүх мэдээллийг Инженерийн хэрэгцээнд зориулан хангана.

Гүйцэтгэгч, долоо хоног бүрийн нэг дэх өдөр, тухайн долоо хоногт хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн ажлуудын тоо хэмжээг ажлын төрөл тус бүрээр үзүүлсэн долоо хоногийн ажлын төлөвлөгөөгөө танилцуулна. Хэрвээ Гүйцэтгэгчийн хийж буй ажлын явц нь батлагдсан хөтөлбөрт тусгагдсан тоо хэмжээ юм уу дараалалтай тохирохгүй байна гэж Инженер тухайн үед үзвэл, Инженер ба Инженерийн төлөөлөгчийн зааврaар, Гэрээний

нөхцөлүүдийн зүйл 43-д тодорхойлсон эцсийн хугацааны дотор Ажлыг хийж дуусгахыг баталгаажуулан, ажлын хөтөлбөрөө шинэчилж, түүнийг хэрхэн шинэчилсэн тухай арга, аргачлал, нөөцийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийн хамт танилцуулна.

Гүйцэтгэгч, зөвшөөрөгдсөн программ хангамжийг ашиглан, өөрийн ажлын хөтөлбөрөө (шинэчилснийг оролцуулан) дээр өгүүлсэн сүлжээ ба нэмэлт сүлжээн графикийн хэлбэрт оруулж, түүнийг үндэслэн холбогдох шугаман графикуудыг шинэчилж өөрчлөх замаар хөтөлбөрөө шаардлага хангахаар хэмжээнд боловсруулагдсан болохыг батална. Тэдгээрийг Инженер зөвшөөрсөн тохиолдолд Гүйцэтгэгч хугацаа алдалгүй хэрэгжүүлж эхлэх ба шинэчилсэн нэмэлт төлөвлөгөө, хуваариудыг бэлтгэнэ. Хэрвээ тэдгээр шинэчилсэн төлөвлөгөөнүүдийг Инженер зөвшөөрөхгүй юм уу Гэрээний нөхцөлийн зүйл 43-т заасан эцсийн хугацаанд төслийг хэрэгжүүлж дуусгах боломжгүй гэж үзвэл, Гүйцэтгэгч төслийг эцсийн тогтоосон хугацааны дотор дуусах нөхцөлийг хангаж, Инженерийн шаардлагад нийцэх хэмжээнд төлөвлөгөөгөө шинэчлэн засварлаж танилцуулна.

Гүйцэтгэгч, ажлыг хөтөлбөрийн дагуу гүйцэтгэж, тогтоосон хугацаанд нь дуусгахаар гэрээний дэд-зүйл 14.1-ийн нөхцөлийн дагуу ажлын төлөвлөгөөгөө боловсруулахдаа бүх шаардлагатай хүчин зүйлс, бусад нөхцөл байдлын талаар сайтар судалж, тодорхой мэдлэг, мэдээллийг олж авсан байх ёстой.

Гүйцэтгэгчээс Инженерт танилцуулах мэдээлэл нь барихаар төлөвлөж буй түр ажлын байрууд болон бусад түр барилга байгууламжуудын ерөнхий зохион байгуулалтыг харуулсан зураг, нийт ажлыг гүйцэтгэхэд ашиглахаар төлөвлөж буй гүйцэтгэгчийн тоног төхөөрөмж, түр ажил ба бусад бүх нэмэлт шаардлагатай зүйлсийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан байна.

Гүйцэтгэгч, Инженер ба Инженерийн төлөөлөгчийн өгсөн зааврыг хүлээн авснаас хойш 14 (арван дөрөв) хоногийн дотор ажлын хөтөлбөрөө шинэчилж (инженерийн шаардлага хангасан хэмжээнд хийсэн өөрчлөлтийн хамт), танилцуулна.

Гүйцэтгэгч, Инженерийн зөвшөөрч баталсан хөтөлбөрийн дагуу ажлыг хийж гүйцэтгэх ба Инженерээс бичгээр зөвшөөрөл авахаас нааш тэрхүү хөтөлбөрөөс гажиж болохгүй.

## 105 АЖЛЫН ДАРААЛАЛ

Бүх зам, хоолойн ажлуудыг оролцуулан бүх ажлыг үргэлжлүүлэн хийж, замын бүрэн дуусан хэсгүүдийг бэлэн болгож гаргах байдлаар, урагшлах дараалаар гэрээнд заасан хугацаанд бүх үйл ажиллагааг явуулна. Ерөнхийдөө, гүйцэтгэгч нь замыг нэг төгсгөлөөс нь (Инженерээс зааварчилсан буюу тохиролцсон тохиолдолд замын хэсгийг) эхэлж, дунд нь тасархай хэсэг орхилгүйгээр нөгөө төгсгөл рүү чиглэсэн байдлаар үргэлжлүүлэн хийж гүйцэтгэнэ. Гүйцэтгэгчээс танилцуулж, Инженерийн баталсан ажлын төлөвлөгөөнд (шинэчилсэн ажлын төлөвлөгөөг оролцуулаад) хэсгийн урт ба ажлын бүрэлдэхүүн бүрээр (өөрөөр хэлбэл, газар шорооны ажил, хоолойны ажил, хучилтын ажил, г.м) харуулсан хийгдэх ажлын дараалыг тусгасан байна.

## 106 ИНЖЕНЕРТ ТАНИЛЦУУЛАХ ЖУРАМ

Гүйцэтгэгч, аливаа санал, асуудал, зураг, тооцоо, мэдээлэл, ном гарын авлага, материал, шинжилгээний хариу, гэрчилгээ, акт, зөвшөөрөл авах хүсэлт, тодруулга, Гэрээний хэрэгжилттэй уялдан гарч буй бусад бичиг баримтуудыг Инженерт танилцуулах шаардлагатай болбол Инженер танилцуулсан зүйлсийг судалж үзэн, тохиромжтой бол, Гэрээний нөхцөлүүдийн холбогдох заалтын дагуу Гүйцэтгэгчид хариуг өгнө. Инженерээс зөвшөөрөл авах шаардлагатай бичиг баримтуудыг, Гэрээний нөхцөлүүдийн холбогдох зүйл, техникийн шаардлагын заалтууд, эсвэл Инженертэй харилцан зөвшилцөх шаардлагатай батлагдсан ажлын хөтөлбөрийг харгалзан, тэдгээр бичиг баримт бүрийг судалж үзэх боломжийн хугацааг Инженерт олгох зэрэг шалтгаанаар, хариу өгөх өдрөөс хангалттай хугацааны өмнө Инженерт танилцуулна.

Танилцуулсан зураг ба үйлдвэрлэгчийн гарын авлага, номоос бусад бичиг баримтууд нь А4 хэмжээний, эсвэл Инженерийн зааварласан юм уу баталсан хэмжээтэй

цаасан дээр үйлдэгдсэн байна. Бүх бичиг баримт англи хэл дээр байх ба харин үйлдвэрлэгчийн танилцуулга, бичиг баримтуудыг англи хэлээр үнэн зөв хийгдсэн орчуулгын хамт, өөр хэл дээр танилцуулж болно. Аливаа товчилсон үгийн тайлбарыг оруулсан байна. BS 5775-д заасны дагуу бүх тооцоо, техникийн мэдээллүүд SI нэгжээр илэрхийлэгдэнэ.

Инженерээс өөрөөр зааварласан юм уу зөвшөөрснөөс бусад тохиолдолд бүх зургийн гадна хүрээ хүртэлх хэмжээ А3 хэмжээтэй байна. Зургийн тайлбарууд англи хэл дээр хийгдсэн байна. Бүх хэмжээснүүд нь метр юм уу миллиметрээр, бүх хүндийн жинг SI нэгжээр илэрхийлсэн байна.

Гүйцэтгэгч, зургийн хүрээ, дугаарлалт, нэр зэргийн талаар зөвшөөрөл авах зорилгоор ноорог зургийг Инженерт танилцуулна. Дараагийн бүх зургуудыг энэхүү зөвшөөрөгдсөн загварын дагуу Инженерт танилцуулна.

Бүх зургийн доод талд гэрээний нэр ба зургийн тухайлсан нэрийг бичсэн байна. Бүх зургуудыг тус тусад нь дугаарлаж, хэрэглэсэн масштаб, танилцуулсан өдөр зэргийг тэмдэглэнэ. Мөн зурагт хийсэн нэмэлт өөрчлөлтүүдийг тэмдэглэж, өдрийг нь тавьсан байна.

Аливаа танилцуулсан зүйлийг баталж, зөвшөөрөх нь Гүйцэтгэгчийг Гэрээний дагуу хүлээх үүрэг хариуцлагаас чөлөөлөхгүй.

## 107 АЖИЛ ХҮЛЭЭН АВАХ АКТ

Инженерийн саналаар, замыг нээснээр нийтийн тээврийн хөдөлгөөн тохилог бөгөөд аюулгүй байдлаар үргэлжлэн явагдах боломжтой, түүнээс гадна баталгаат засварын хугацаанд хийгдэж болох дараах ажлуудаас бусад бүх ажил уг замын хэсэгт хийгдсэн гэж үзэхээс бусад тохиолдолд замын ямар ч хэсгийн ажлыг гүйцэтгэж дууссанд тооцож ажил хүлээн авах актыг олгохгүй. Үүнд:

- шороон орд, карьеруудыг нөхөн сэргээх,
- түр замуудыг нөхөн сэргээж, урьдын байдалд оруулах,
- мэдээлэх тэмдгүүдийг угсрах,

## 108 БАРИЛГЫН АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ АРГАЧЛАЛ

Гүйцэтгэгч, гэрээ байгуулах эрх олгох тухай албан бичгийг хүлээн авсанаас хойш 28 хоногийн дотор төлөвлөж буй зохион байгуулалтын арга хэмжээ ба ажлыг хийж гүйцэтгэх аргачлаллаа Инженерт танилцуулна. Аргачлал нь дараахи зүйлсийг агуулсан байх ба гэхдээ зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй. Үүнд:

- талбайн лаборатори,
- түр байгууламжуудын зохион байгуулалт,
- гүйцэтгэгчийн тоног төхөөрөмж, төлөвлөж буй үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний хэмжээ,
- гүйцэтгэгчийн түр лагерь ба материал нөөцлөх газрууд
- карьер ашиглалт, чулуу бутлалт, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн,
- бусад чулуун материалын үйлдвэрлэл, бүтээгдэхүүн, хадгалалт, ашиглалт,
- шороон ордын ашиглалт, тэдгээрт хүрэх туслах замууд,
- замын ажлуудыг гүйцэтгэхэд шаардагдах материалын хангамж, ашиглалт, хадгалалт,
- бетон хольцны завод, тээвэрлэх, дэвсэх тоног төхөөрөмж,
- битумэн хольцны завод, тоног төхөөрөмж,
- цахилгааны хангамж, ашиглалт
- түр замууд,

- ухмал хийх аргачлал,
- усан хангамжийн зохион байгуулалт,
- ажлын ээлжийн зохион байгуулалт,
- мэргэжилтэй болон туслах ажилчид,
- гүйцэтгэгчийн үйл ажиллагааг хянах,
- чанарын хяналт, шинжилгээ хийх аргачлалууд болон ашиглах тоног төхөөрөмж.

Ажлыг гүйцэтгэх явцдаа Гүйцэтгэгч, дээр дурдсан зүйлсийн дагуу бэлтгэж танилцуулсан зохион байгуулалт, аргачлалдаа аливаа нэмэлт өөрчлөлт оруулахаар бол тэдгээрийг хэрэгжүүлэхээс өмнө Инженерт дэлгэрэнгүй байдлаар нарийвчлан танилцуулна.

Зөвлөхийн инженерүүдийн ажиллах цагийн хуваарь нь Захиалагч болон Зөвлөхийн хооронд байгуулагдсан гэрээний дагуу байна. Хэрвээ Гүйцэтгэгч, байнгын ажлын зарим хэсгийг тогтоосон ажлын цагаас бусад үед хийж гүйцэтгэх хүсэлтэй бол, тэдгээрийг хянах боломжоор хангах үүднээс, дор хаяж нэг хоногийн өмнө Инженерээс урьдчилан бичгээр зөвшөөрөл авна.

## 109 ТӨСЛИЙН ЧАНАРЫН ХЯНАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Гүйцэтгэгч нь бүх ажлын чанарын хариуцлагыг дангаараа хүлээнэ. Гүйцэтгэгч нь, төслийн чанарын хяналтын төлөвлөгөөнд тусгагдсан чанарын хяналтын арга хэмжээнд бүхэлд нь хяналт тавих, хариуцлага хүлээх чадвартай, дадлага туршлагатай, Инженерийн зөвшөөрсөн хүнийг гэрээний дагуу чанарын хяналтын менежерээр ажиллуулахаар томилж, Гүйцэтгэгчийн төслийн менежерийн шууд удирдлага, хяналтын доор ажиллуулна. Чанарын хяналтын менежер нь бүх чанарын хяналттай холбоотой үйл ажиллагаануудыг хянах ба зохицуулах эрх бүхий хүн байх ба ажлаа Гүйцэтгэгчийн төслийн менежерт шууд тайлагнана. Гүйцэтгэгч нь, зөвхөн шинжилгээ хийх ба бусад чанарын хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх чадвар бүхий техникчдийг авч ажиллуулах бөгөөд хэрвээ Инженер, тэдгээр хүмүүсийн хэн нэг нь энэхүү шаардлагыг хангахгүй байна гэж үзвэл түүнийг Инженерийн шаардлагыг хангах дадлага туршлагатай хүнээр солино.

Гүйцэтгэгч Инженертэй харилцан зөвлөлдсөний үндсэн дээр, Төслийн чанарын хяналтын төлөвлөгөөг бүхэлдээ түүний тавьсан шаардлагыг хангахуйц хэмжээнд боловсруулна. Төслийн чанарын хяналтын төлөвлөгөөг баталсан ч гэсэн Гэрээний нөхцөлүүдийн дэд-зүйл 36.1-ийн бүх заалтууд хүчин төгөлдөр үйлчлэх ба энэхүү техникийн шаардлагын дагуу ажлыг чанартай хийж гүйцэтгэхийг баталгаажуулах үүднээс Инженер шаардлагатай гэж үзвэл, Гүйцэтгэгчийг Төслийн чанарын хяналтын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт хийх талаар шаардах, зааварлах эрхтэй.

Гүйцэтгэгч, гэрээ байгуулах эрх олгох тухай албан бичгийг хүлээн авснаас хойш 28 хоногийн дотор буюу Гэрээнд гарын үсэг зурснаас хойш 14 хоногийн дотор Төслийн чанарын хяналтын төлөвлөгөөгөө Инженерт танилцуулан хянуулж батлуулна. Төслийн чанарын хяналтын төлөвлөгөөний эцсийн хувилбарыг Гүйцэтгэгч бэлтгэж боловсруулах бөгөөд үүндээ материал, тоног төхөөрөмж, ажиллах хүчний чанарын хяналтад зориулсан аргачлалуудаа тус тусад нь тайлбарлан хэсэг хэсгээр үзүүлсэн, дагаж мөрдөх гарын авлагыг оруулсан байна. Инженерээс Гэрээний нөхцөлийн дэд-зүйл 41.1-ийн дагуу ажил эхлэх зөвшөөрөл олгосноос хойш 56 хоногийн дотор Гүйцэтгэгч эцсийн байдлаар батлагдаж гарын үсэг зурагдсан 3 хувь төлөвлөгөөг Инженерт хүргүүлнэ.

Гүйцэтгэгчийн боловсруулсан Төслийн чанарын хяналтын төлөвлөгөө нь ажлын чанарыг хянах нөөц, арга ажиллагааны хувьд боломжтой байх ба дараах зүйлүүдийг багтаах боловч зөвхөн тэдгээрээр хязгаарлагдахгүй. Үүнд:

- чанарын хяналтын ерөнхий аргачлалууд,
- Ажлын талбайд авчрах бүх материалууд нь энэхүү техникийн шаардлагыг

хангаж байгаа болон гэрээний хэрэгжилтийн нийт хугацаанд уг шаардлагыг байнга хангаж байхыг илтгэх тухай бүрэн бичиг баримт, материалууд,

- шинжилгээний төрөл, давтамж, цаг хугацаа, дээж авах, туршилт шинжилгээ хийх тайлагнал, баталгаажуулалт зэргийг тусгасан иж бүрэн хуваарь,
- төлбөр хийх зорилгоор аливаа ажлыг хүлээн зөвшөөрөх шалгуур ба чанарын шаардлага хангаагүй юм уу шинжилгээний хариу оройтож гарсан тохиолдолд дагаж мөрдөх журам,
- Түр ажлыг шалгах, туршилт шинжилгээ хийх ба зөвшөөрөл олгох журам,
- Гүйцэтгэгчийн ажлын аргачлал ба тоног төхөөрөмжийн туршилт, шинжилгээ, хүлээн зөвшөөрөх, хянах,
- Гүйцэтгэгчийн талаас ажиллах хяналтын инженерүүдийн тоо, мэргэжлийн төрөл зэргийг багтаасан хяналтын түвшинтэй холбоотой технологи ба ажиллах хүчний чанарын зөвшөөрөгдөх дараалыг баталгаажуулах журам,
- Инженерт танилцуулах тайлангийн стандарт маягт.

Төслийн чанарын хяналтын төлөвлөгөөнд тусгасан туршилт, шинжилгээ хийх хуваарь нь шинжилгээнүүдийг барилгын ажлын гол үе шаттай уялдуулан бэлтгэж, хугацаа алдалгүйгээр цаг тухайд нь хийх, шаардлагатай мэдээллийг өгч байх боломжтой хийгдсэн байх ёстой. Төслийн чанарын хяналтын төлөвлөгөөний гол зорилго нь төсөл хэрэгжих хугацааны туршид Гүйцэтгэгч энэхүү техникийн шаардлагын заалтуудыг бүрэн хангаж ажиллаж байгааг Инженерт батлах мэдээ баримтаар хангах явдал юм.

Төслийн чанарын хяналтын төлөвлөгөөг бэлтгэхдээ Гүйцэтгэгч дараах зүйлүүдийг харгалзан үзэх ёстой. Үүнд:

(а) Гүйцэтгэгч, тухай тухайн ажлыг хянаж, шалгахад шаардагдах зохион байгуулалтын арга хэмжээг авах боломжийг Инженерт олгохуйц хангалттай хугацааны өмнө, түүнд бүрэн хэмжээний мэдэгдлийг урьдчилан бичгээр ирүүлэхээс нааш уг ажлыг хийхгүй,

(б) Гүйцэтгэгч, хянах ажлыг урьдчилан зохион байгуулах боломж олгох үүднээс ажлын аль нэг хэсэгт гадаслагаа хийх ба өндөр тогтоох гэж байгаа тухай хүсэлтээ 48 цагаас доошгүй хугацааны өмнө Инженерт бичгээр мэдэгдэнэ.

## 110 ХЭМЖИХ НЭГЖ, ТОВЧИЛСОН ҮГС БА НЭР ТОМЬЁО

(а) Хэмжих нэгж

Хэмжих нэгжийн тэмдэглэгээнүүд нь BS 5775 (ISO 31/1)-д өгөгдсөн SI системийн дагуу байх ба тэдгээрийн ердийн товчилсон үгсийг дор жишээ болгон үзүүллээ.

Харгалзах нэгжийн талаар бичиг баримтуудад дурдсан байвал, адил SI нэгжүүдийг орлуулна.

| | |
|---|---|
| μм | микрон = м x $10^{-6}$ |
| мм | миллиметр |
| м | метр |
| км | километр |
| $мм^2$ | квадрат миллиметр |
| $м^2$ | квадрат метр |
| $км^2$ | квадрат километр |
| га | гектар |
| $м^3$ | куб метр |
| л | литр |

| | |
|---|---|
| рад | радиан |
| с | секунд |
| °С | Цельсийн хэм |
| кг | килограм |
| г | грам = кг х $10^{-3}$ |
| мг | миллиграм = кг х $10^{-6}$ |
| мг/л | литр дэх миллиграм |
| т | тонн = кг х $10^{3}$ |
| кг/м$^3$ | нэг куб метрт оногдох килограм |
| т/м$^3$ | нэг куб метрт оногдох тонн |
| Н | Ньютон |
| Н/м$^2$ | нэг квадрат метрт оногдох Ньютон |
| Па | Паскаль = 1 Н/м$^2$ |
| МПа | мегаПаскаль = Па х $10^{6}$ |
| Ж | Жоуль |
| Вт | Ватт |
| Кв | Киловатт |
| А | Ампер |
| В | Вольт |

б) Товчилсон үгс

Дараах товчилсон үгсийг ашиглав:

| | |
|---|---|
| ЧБХ | Чулуулгийн бутрагдлын хэмжээ |
| ДХБХ | Дундаж хамгийн бага хэмжээ |
| БШЧ | Битумын шинж чанар |
| ХДҮ | Хөрсний даацын үзүүлэлт |
| БХ | Бутрагдалтын харьцаа |
| ХҮИ | Хавтгай үзүүрлэгийн индекс |
| ИГА | Иржгэр гадаргуутай арматур |
| ЧЭТ | Чулуулгийн элэгдлийг тодорхойлох |
| УХ | Урсалтын хязгаар |
| ШС | Шугаман суулт |
| ЧА | Чийгийн агуулалт |
| ХИХН | Хамгийн их хуурай нягт |
| ТЧХ | Тохиромжтой чийгийн хэмжээ |
| УХИ | Уян харимхайн итгэлцүүр |
| СХ | Суналтын (тасралтын) хязгаар |
| УХМ | Уян харимхайн модуль, УХИ х (0.425 мм-ийн шигшүүрээр нэвтрэн өнгөрөх хувь) |
| УХҮ | Уян харимхайн үзүүлэлт, УХИ х (0.075 мм-ийн |

| | |
|---|---|
| | шигшүүрээр нэвтрэн өнгөрөх хувь) |
| ЭЭ | Элсний эквиалент |
| ХЖ | Хувийн жин |
| SI | Хэмжих нэгжийн олон улсын стандарт |
| ЧХХЧ | Чулууны хүйтэнд тэсвэрлэх чадварыг тогтоох шинжилгээ, 5 эргэлтэд алдагдал тооцох |
| С | Суналт |
| ББ | Битумын барьцалдалт |
| СББ | Суналтын бат бэх |
| НТК | Нэгэн төрлийн коэффициент |
| ШББ | Шахалтын бат бэх |
| ЭДС | Эрдсийн доторх сүвшил |
| ЕПЦ | Ердийн портланд цемент |
| ш | Ширхэг (нэгж) ө.х., 6 ш. |
| ¹. | Дугаар (дараалал) ө.х., ¹. 6 |
| у/ц | ус цементийн харьцаа |
| ж | Жин |
| % | хувь |
| хам.их | хамгийн их |
| хам.бага | хамгийн бага |
| диа. | диаметр |
| ц | цаг |
| мин | минут |
| с | секунд |
| дх | долоо хоног |

## 111 СТАНДАРТ ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

Дотоодын болон дэлхий нийтэд нэр хүндтэй бусад байгууллагуудын бэлтгэсэн зарим техникийн шаардлагуудыг энэхүү техникийн шаардлагад дурдсан болно. Тэдгээр техникийн шаардлагуудыг цаашид Стандарт техникийн шаардлага гэж тодорхойлох буюу үзэх ба тендерт оролцох урилгад дурдсан тендерийн саналуудыг танилцуулах өдрөөс 28 хоногийн өмнөх бэлэн байгаа Стандарт техникийн шаардлагын хамгийн сүүлийн хэвлэлт байна.

Гадаад орноос бараа бүтээгдэхүүн оруулж ирж хангахад дотоодын техникийн шаардлагыг Стандарт техникийн шаардлага гэж тооцох тохиолдолд, Гүйцэтгэгч дотоодын өөр стандартын хувилбарыг санал болгох боломжтой бөгөөд харин тэрхүү техникийн шаардлагын үзүүлэлтүүд нь бүх талаараа Стандарт техникийн шаардлагыг хангасан байх ба Инженер түүнийг нь зөвшөөрсөн байх ёстой. Гүйцэтгэгч өөрийн санал болгож буй хувилбар техникийн шаардлагын хувийг, хэрвээ эх хувь нь өөр хэл дээр бол гэрээнд заасан хэлэнд хөрвүүлсэн орчуулгын хамт Инженерт танилцуулна.

Стандарт техникийн шаардлагуудын хувьд доорхи товчилсон үгсийг ашиглав:

AASHTO Америкийн стандарт (Америкийн мужийн зам тээврийн удирдах ажилтнуудын холбоо)

| | |
|---|---|
| ASTM | Америкийн туршилт шинжилгээ, материалын нийгэмлэг |
| BS | Британы стандарт |
| BSCP | Британы стандарт |
| ISO | Олон улсын стандартчилалын байгууллага |

Гүйцэтгэгч энэхүү техникийн шаардлагад дурдсан Стандарт техникийн шаардлагууд болон бусад бүх зөвшөөрөгдсөн техникийн шаардлагуудын нэг хувь иж бүрэн багцыг Инженерийн талбайн ажлын байранд хангаж өгнө. Мөн тэдгээр стандарт техникийн шаардлагууд болон тэдгээртэй адил төстэй бусад бүх зөвшөөрөгдсөн техникийн шаардлагуудын нэг хувь иж бүрэн багцыг Гүйцэтгэгч өөрийн хэрэгцээнд зориулан талбай дахь ажлын байрандаа хадгалж ашиглана.

## 112 БУСАД ГҮЙЦЭТГЭГЧ

Төслийн ажилтай холбоотойгоор ажлын талбайд болон ойролцоо нь Захиалагчийн ажиллуулж байгаа бусад Гүйцэтгэгчид болон Захиалагчийн ажиллагсад ажиллаж байгаа талаар гүйцэтгэгчид мэдэгдэнэ.

Захиалагчийн ба гуравдагч этгээдийн өмч мөн бишээс үл хамааран, нөгөө талаар Инженерийн зүгээс уг ажлыг Гүйцэтгэгчид хариуцуулсан, эсэхээс үл хамааран гэрээний нөхцөлийн зүйл 31-ийн дагуу Гүйцэтгэгч нь аливаа ажилд ямар нэг байдлаар хөндлөнгөөс оролцох ёсгүй. Гүйцэтгэгч нь бусдын хийсэн ажил, ханган нийлүүлсэн болон талбайд барьж суурилуулсан зүйлсийг хүндэтгэж үзэх бөгөөд Гүйцэтгэгчийн өөрийн буюу түүний ажиллагсдын, эсвэл туслан гүйцэтгэгчдийнх нь буруугаас тэдгээр зүйлс алдагдсан, эвдэрсэн тохиолдолд хариуцлагыг хүлээнэ.

## 113 АЖИЛЧДЫГ ТЭЭВЭРЛЭХ

Гүйцэтгэгч барилгын ажилтай уялдуулан өөрийн ажилтан, ажилчдыг ажлын талбай руу болон талбайгаас зөөх зардалд, гадаадын мэргэжилтэнгүүдийг оролцуулан, гэхдээ зөвхөн эдгээрээр хязгаарлахгүйгээр, тэдгээрийн аюулгүй байдлыг хангах, элсүүлэх, ажлын талбай руу болон талбайгаас нааш цааш зөөвөрлөхөд зарцуулах бүх зардлыг төсөвтөө тооцож оруулна.

## 114 ТҮР БАРИЛГА

Гэрээнд гарын үсэг зурсны дараа, ажил эхлэхээс өмнө Гүйцэтгэгч, түр барилгын талаар хийхээр төлөвлөж буй ерөнхий зохион байгуулалтыг харуулсан нарийвчилсан зургийг Инженерт танилцуулна. Гүйцэтгэгч, доор дурдсан зүйлсийг агуулсан, гэхдээ зөвхөн тэдгээрээр хязгаарлагдаагүй, бүрэн мэдээллийг гаргаж өгнө. Үүнд:

- тооцоо,
- диаграм,
- түр барилгын ажлыг хэрхэн гүйцэтгэхээр төлөвлөж буйг харуулсан танилцуулга,
- Гадаслагааны тухай мэдээлэл,
- Бусад холбогдох мэдээлэл.

Бүх түр барилгын ажлуудыг Инженерийн зөвшөөрлөөр гүйцэтгэнэ.

Гүйцэтгэгч, гэрээний нөхцөлүүдийн дэд-зүйл 14.1-ийн дагуу нийт ажлыг хийж гүйцэтгэхэд түр барилгын ажлууд нь хэрхэн түүний хөтөлбөртэй уялдаж байгаа талаар нотлон харуулна. Түр барилгуудыг барих, тэдгээрийн аюулгүй байдал, засвар арчлалт, ажил дуусаны дараа тэдгээрийг буулгах, ажлын үеэр ашигласан тоног төхөөрөмж, багаж хэрэгслүүд гэх мэт нийт түр ажилтай холбоотой зүйлсийн хариуцлагыг гүйцэтгэгч хүлээнэ. Гүйцэтгэгчийн болон түүний туслан гүйцэтгэгчийн

түр барилгын ажилтай холбоотой гаргасан саналыг Инженерээс зөвшөөрсөн аливаа зөвшөөрөл нь Гүйцэтгэгчийг гэрээний дагуу хүлээх үүрэг хариуцлагаас чөлөөлөхгүй.

**115 БАРИЛГЫН АЖИЛД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГУУД**

Барилгын ажлын үед дараах ерөнхий шаардлагууд тавигдана. Үүнд:

(а) Гүйцэтгэгч шөнийн цагаар ажил гүйцэтгэх тохиолдолд хангалттай гэрлээр хангах ба Инженерт ажлын явцыг ажиглах, хянах, материалын шинжилгээ, туршилт хийх нөхцөлөөр хангах үүднээс нэмэлт гэрэлтүүлэг суурилуулж өгнө.

(б) Ажлын талбайд байгаа буюу Захиалагчийн хангасан материалыг зөвхөн гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхэд ашиглана.

(в) Гүйцэтгэгч ажлын талбайн ойр орчмын барилга байгууламжид хүрэх замыг гэрээний нийт хугацааны туршид арчилж байна.

(г) Гүйцэтгэгч, тэсрэх, дэлбэрэх болон радио идэвхт материалыг тээвэрлэх, хадгалах, ашиглахдаа Засгийн газрын холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

(д) Гүйцэтгэгч, ажлын талбайд болон түүний ойр орчны газар шороо, зам болон бусад газруудыг бохирдуулахаас сэргийлэх ба ажлыг хэрэгжүүлж байх явцад үүсэж болзошгүй аливаа хүндрэлтэй асуудал, саад бэрхшээл зэргийг багасгахад чиглэсэн шаардлагатай бүх арга хэмжээг авна. Эдгээр урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь тэдгээр хүндрэлтэй асуудлыг нэгэнт үүссэний дараа багасгах биш, харин гарахаас нь өмнө хянаж урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн байна. Аливаа ажил ба бусад бүх холбогдох үйл ажиллагааануудыг Монгол улсад дагаж мөрдөгдөж буй бүх хууль тогтоомж, журмын (байгаль орчны холбогдолтой хууль тогтоомжийг оролцуулан) шаардлагуудын дагуу хийж гүйцэтгэнэ. Зам барилгын ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай гэж Инженер үзэж зөвшөөрснөөс бусад тохиолдолд, аливаа мод, бут, бусад өвс ургамлыг огтолж, тайрч зайлуулахгүй.

Гүйцэтгэгч барилгын ажил гүйцэтгэж буй ажилчдадаа байгалийн нөөц баялаг, ан амьтдыг хайрлан хамгаалах талаар зааварчилгаа өгсөн байна. Ан хийх болон зөвшөөрөлгүй загасчлах явдлыг хориглох ба Гүйцэтгэгч энэ талаар баталгаа гаргана.

(е) Гүйцэтгэгч дараах зүйлүүдтэй холбогдуулж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна. Үүнд:

(i) Гол горхи, усны урсац, нуур болон бусад адил төстэй зүйлсийг Инженерийн зөвшөөрөлтэйгөөр гео-нэхмэл эдлэл юм уу өөр бусад аргыг ашиглан лаг шаврын хаалт хийж, үерт автах, эрэг ёроол нь угаагдах, ус бохирдохоос сэргийлэх, тэдгээрийн чанар, харагдах байдалд сөргөөр нөлөөлөхгүй байх, хүн, амьтан, ургамлыг гэмтээх, үхэлд хүргэхгүй байхтай холбогдуулсан арга хэмжээ,

(ii) Усан хангамжийг тасалдуулахгүй байх үүднээс, мөн усны чанарт муугаар нөлөөлж, түүнийг бохирдуулахаас сэргийлэхийн тулд гүний усны нөөцтэй (шүүсэн усыг оролцуулан) холбогдуулсан арга хэмжээ.

(ё) Ажлыг гүйцэтгэх явцад гарсан хаягдал материал юм уу лаг шаврыг ойролцоох газарт зайлуулах, шаардлагатай бол Гүйцэтгэгч тэдгээрийг зөвшөөрөгдсөн хаягдал материал зайлуулах газарт зөөн хаяж, тухайн

газрыг анхны байдалд нь оруулан нөхөн сэргээх ажлыг Инженерийн тавьсан шаардлагыг хангахуйц хэмжээнд өөрийн зардлаар хийж гүйцэтгэнэ.

(ж) Гүйцэтгэгч нь карьерыг ажиллуулах, чулуу угаах, бетон зуурах, цутгах г.м болон Гүйцэтгэгчийн бусад үйл ажиллагаанаас шалтгаалан үүсэх тоос шороо, бохирдлыг (гэхдээ зөвхөн эдгээрээр хязгаарлахгүй,) багасгах үүднээс тунгаагуур болон бусад байгууламжийг барьж, ашиглах ба ажил дуусаны дараа буулгана. Үүнтэй холбогдуулан Гүйцэтгэгчийн гаргах санал нь энэхүү техникийн шаардлагын зүйл 114-ийн шаардлагыг хангаж байх ёстой. Бүх бохир ус болон бусад хаягдал шингэнийг ямар нэг бохирдол үүсгэхгүй байдлаар зайлуулна. Гүйцэтгэгч, ажлыг хэрэгжүүлэх үед гарсан аливаа хаягдал материалыг Инженерийн юм уу холбогдох байгууллагын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр усанд хаяхгүй.

(з) Гүйцэтгэгч ажилдаа тоосжилт болон агаараар тархдаг хорт хийг багасгахад чиглэгдсэн арга ажиллагааг мөрдөж ажиллана. Тоосжилт үүсэж болзошгүй тохиолдолд ус шүрших арга хэмжээг авна. Нөөц материал юм уу хаягдал материалын овоолгыг өөр тийш нь ачиж зөөхөөс өмнө норгож чийглэх тухай зааврыг Инженер өгч болно. Инженерийн зүгээс тоосжилт үүсгэж болзошгүй гэж үзсэн бүх материалыг өндөр хашлагатай тэвш бүхий машинаар тээвэрлэн зөөнө. Иймэрхүү материалыг машины тэвшний хашлаганаас илүү гаргалгүй ачиж цэвэрхэн брезентээр тэвшний талууд болон арын хаалтаас дор хаяж 300 мм илүү гарган унжуулж сайтар хучна.

(и) Гүйцэтгэгч буюу түүний туслан гүйцэтгэгчид, материал, үйлдвэр заводыг ханган нийлүүлэгчдийн машин техникийн ашиглаж буй ажлын нэг хэсэг болох бүх хуучин замууд болон адил төстэй замууд дээрх тэдгээр машин техникийн явалтаас үүссэн тоос/шавар юм уу бусад гаднынн биетийг тогтмол цэвэрлэнэ.

(й) Шатахууны агуулах ба машин техникийг цэвэрлэх газар нь ойр хавийн сайр, гол горхиноос дор хаяж 300 м-ийн зайд байрласан байна.

(к) Асфальтбетон болон бетон зуурмаг бэлтгэх завод, чулуу бутлуур, чийглэж холих үйлдвэр зэргийг суурин газар, газар тариалангийн талбай, үйлдвэр, аж ахуйн газруудаас хангалттай хол зайд суурилуулна. Боломжтой бол тэдгээрийг ойролцоох суурин газруудаас дор хаяж 1.0 км-ээс доошгүй зайнд суурилуулна.

(л) Гүйцэтгэгч ажлыг төлөвлөх ба хэрэгжүүлэхдээ, хүрээлэн буй орчинд нөлөөх дуу чимээний холбогдолтой, Монгол улсад мөрдөгдөж байгаа шаардлагуудыг судалж үзсэн байна. Гүйцэтгэгч бүх дуу чимээ намсгагч төхөөрөмжүүдийг ашиглалтын бэлэн байдалд байлгах ба ажлыг гүйцэтгэж байх явцад дуу чимээний нөлөөллийг багасгах бүх шаардлагатай арга хэмжээг авна.

(м) Гэрээний нөхцөлийн зүйл 26-д дурдсан шаардлагуудаас гадна Гүйцэтгэгч, Монгол улсад хүчин төгөлдөр хэрэгжиж буй бүх хууль, дүрэм, зарлиг, тогтоол, журам, шийдвэрүүд болон бусад хуулийн механизмуудын талаар мэдлэгтэй байх ёстой бөгөөд эдгээр нь доорх зүйлсээс бүрдэх боловч зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй. Үүнд:

- Техникийн шаардлагын нэмэлт,
- байгаль орчин,
- эрүүл мэнд, аюулгүй байдал,
- ажил олголтын байдал гадаадын мэргэжилтнүүдийг оролцуулан,

- сургалт,
- татвар, хураамж, төлбөр ба бусад,
- түр ба байнгын барилга байгууламж,
- түр лагерь,
- ариун цэврийн байгууламж ба усан хангамж.

(н) Ажлын талбай ба түр лагерьд Гүйцэтгэгчийн барьсан бүх барилгууд, тэдгээрийн орчны болон талбайн ерөнхий байдал нь Монголд мөрдөгдөж буй хууль тогтоомжууд болон ариун цэвэр, эрүүл ахуйн холбогдолтой тухайн орон нутгийн бүх дүрэм журмын шаардлагыг хангах ба гэхдээ зөвхөн тэдгээрээр хязгаарлагдахгүй.

(о)Хүмүүсийн амьдрах бүх байр суущууд нь бат бөх, цаг агаарын ямар ч нөхцөлд тэсвэртэй байгууламжууд байх ба шаардлагатай зүйлсээр тоноглон засвар арчлалтыг тогтмол хийж ашиглах цэвэрхэн нөхцөлийг бүрдүүлнэ. Оршин суугчдын ая тухтай, аюулгүй байдлыг хангах үүднээс шаардлагатай бол хангалттай халаалт, гэрэлтүүлэг, агааржуулагч, дулаалга зэргийг хангана.

(ө)Барилгын түр лагерь нь ойролцоох суурин газраас дор хаяж 200-аас 500 м-т байрлана. Ажиллагчдын амьдрах байр сууц, бусад байгууламжуудыг стандартын дагуу, Инженерийн шаардлагыг хангах хэмжээнд барьж байгуулан, арчилна.

(п) Түр лагерь байгуулах газрууд нь үерт байнга автахааргүй байх ёстой бөгөөд намаг болон бусад гадаргын ус хуримтлагддаг газруудаас дор хаяж 75 м хол зайд байрлана.

(р) Түр лагерийг түүнээс гарч буй болон түүний дундуур явсан шуудуунууд нь тэр хавийн юм уу нийтийн усан хангамжийн системд аюул учруулахааргүй газарт байгуулна.

(с) Хэрвээ өөрөөр заагаагүй бол, ажилд хэрэглэх байгалийн гаралтай болон тохиромжтой материалын эх үүсвэрүүд нь Ажлын талбайд байсан байгаагүйг үл харгалзан, тэдгээрийн байршлыг тогтоох, ашиглалтын зөвшөөрөл, карьерын лиценз ба ус ашиглах эрх гэх мэт шаардлагатай бүх зөвшөөрлийг авах ажлыг Гүйцэтгэгч хариуцна.

(т) Хэрвээ Гүйцэтгэгч, ажлын талбайн орчинд радио холбоогоор хангах тохиолдолд, тэдгээр төхөөрөмжийг ашиглах нөхцөл боломжоор Инженерийг хангана. Зөвхөн Инженерийн хэрэгцээнд хангах холбооны төхөөрөмжийн хангалтын шаардлагуудыг энэхүү техникийн шаардлагын дэд-зүйл 131 (б) (з) (Д)-д заасан болно.

(у) Гүйцэтгэгч нь, ажлын талбайн эргэн тойронд шаардлагатай хаалт, хашаа хийж, засаж хамгаалан ажил дууссаны дараа буцааж буулгах ба Захиалагч, Инженер, бусад гүйцэтгэгчид болон ажлын талбай руу орох эрх бүхий бусад хүмүүсийн аюулгүй байдлыг зохих байдлаар хангах бөгөөд өөрийн хүлээсэн бусад үүрэг хариуцлагад ямар нэг хор хохирол учруулахгүйгээр гүйцэтгэх ёстой.

(ү) Гүйцэтгэгч нь түр барилгын тохиромжтой болоод аюулгүй байдал, харуул хамгаалалтын болон шаардлагагүй болсон үед тэдгээрийг буулгах хариуцлагыг бүхэлд нь дангаараа хүлээнэ. Түр барилгын ажилд дараах зүйлс багтах боловч зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй. Үүнд:

- агуулах, бетон эдлэлийн талбай,
- тулгуур шон, гадаснууд,
- тавцан, трап, шат, угсралтын/дамжуурга шат,

- хэв хашмал, вандан шат,
- далан, усны хаалт, кессон (ус тусгаарлах хорго),
- шпунтэн тулгуур, тулаас хийх, нүх ухах,
- хашаа,
- бусад холбогдох ажлууд

орох ба үүнээс гадна Гэрээг хэрэгжүүлж, ажлыг гүйцэтгэхэд зориулагдсан буюу угсарч ажиллуулсан Гүйцэтгэгчийн өөрийн тоног төхөөрөмжтэй холбогдолтой түр барилгууд байж болно. Энэхүү заалт нь мөн ажлыг гүйцэтгэх зорилгоор юм уу түүнтэй холбогдуулан Гүйцэтгэгч/түүний туслан гүйцэтгэгчдийн хангаж, угсарсан тоног төхөөрөмжтэй холбоотой бүх түр барилгын ажлуудад хамаарна.

(ф) Гүйцэтгэгч/түүний туслан гүйцэтгэгчдийн түр барилгын ажлууд, тэдгээрийн холбогдолтой аливаа зургуудыг Инженер хянаж шалгах нь Гүйцэтгэгчийг гэрээний заалтуудын дагуу түүнд оногдсон аливаа үүрэг, хариуцлагаас чөлөөлөхгүй.

(х) Хэрвээ Гүйцэтгэгч үйл ажиллагаагаа улирлын байдлаас үүдэн юм уу бусад шалтгаанаар түр зогсоовол талбайд байгаа бүх барилга байгууламж, тоног төхөөрөмжийг бүхэл зогсолтын хугацааны турш харж хамгаалан, түүнийг үйл ажиллагаагаа дахин эхлэх үед шууд ашиглахад бэлэн байлгах үүргийг хүлээнэ. Гэрээний нөхцөлийн дэд-зүйл 20.1-ийн дагуу, зогсолтын хугацааны турш ажлыг харж хамгаалах үүрэг, хариуцлагыг гүйцэтгэгч хүлээнэ.

(ц) Хэрвээ, барилгын ажлын явцад, археологийн чанартай малтмал, зоос, олдвор олдсон тохиолдолд, гүйцэтгэгч, Монгол улсын засгийн газарт яаралтай мэдэгдэх ба тэдгээр олдворуудыг Монголын засгийн газрын өмч болгож, холбогдох хууль журмын дагуу арга хэмжээг авна. Гүйцэтгэгч нь соёлын/шашны холбогдолтой аливаа барилга байгууламжид нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах явдлыг баталгаажуулна.

## 116 ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДАЛ, АВААР ОСОЛ

Гүйцэтгэгч нь ажлын талбайд ажиллах эрхтэй бүх хүмүүсийн эрүүл мэнд, аюулгүй байдал, хөдөлмөр хамгааллыг хангахад шаардлагатай бүх урьдчилсан сэргийлэх арга хэмжээг авна. Эдгээр арга хэмжээнд Монгол улсад юм уу тухайн орон нутагт мөрдөгддөг хууль тогтоомжийн шаардлагуудаас гадна, Инженерийн бодлоор ажлын талбайд зөвшөөрөлгүй орсон гаднын хүмүүс, мөн Гүйцэтгэгчийн хяналтын дор хийгдэж буй аливаа үйл ажиллагаанаас орон нутгийн иргэдийг хамгаалах зэрэгт мөрдөх шаардлагатай гэж үзсэн бусад арга хэмжээнүүд орно. Гүйцэтгэгч дараах хариуцлагыг хүлээх ба гэхдээ зөвхөн эдгээр хязгаарлагдахгүй:

(а) Аюулгүй байдлыг хангасан тоног төхөөрөмжийг хангаж, засвар арчлалтыг хийх, ажлын талбайд ажиллаж буй хүмүүсийн эрүүл мэндэд аюул, эрсдэл учруулахааргүй ажлын арга барилыг мөрдөж ажиллах.

(б) Ажилд ашиглагдах бодис, бусад зүйлстэй харьцах, тэдгээрийг хэрэглэх, хадгалах, тээвэрлэх, хаяж зайлуулахтай холбоотойгоор аюулгүй байдлыг хангах, эрүүл мэндэд эрсдэл учруулахгүй байх тохиромжтой зохион байгуулалтыг хийх

(в) Инженерийн бодлоор, шөнийн ээлжинд хийж гүйцэтгэх ажлын аюулгүй байдлыг баталгаажуулах үүднээс хангалттай хэмжээний гэрэлтүүлэг болон цахилгаан тасарсан үед ажиллуулах нөөц/аваарын гэрэлтүүлгийн төхөөрөмжөөр хангана.

(г) Хяналтын инженерүүд, талбайн ажилтан, ажиллагсад болон ямар нэг

байдлаар ажилтай холбогдон ажлын талбайд орж ирж буй бүх хүмүүсийн ажлын талбайд ажиллах үеийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахад шаардагдах хамгаалалтын хувцас, аюулгүй ажиллагааны багаж төхөөрөмжөөр хангаж, энэ талаар мэргэшсэн хүнийг ажиллуулан, үүнтэй холбоотой мэдээлэл, зааварчилгааг өгч, сургалт зохион байгуулах, хяналт тавих ажлуудыг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу хийх.

(д) Эдгээр аюулгүй ажиллагааны багаж хэрэгсэлд дараах зүйлс багтах ба гэхдээ зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй:

- малгай, каск
- хамгаалалтын гутал,
- нүдний хамгаалалтын шил, гагнуурын нүдний шил,
- чихний хаалт,
- хамгаалалтын тоноглол,
- гэрэл ойлгогчтой хантааз,
- усан дээр ажиллахад зориулагдсан хамгаалалтын багаж,
- аврах хэрэгсэл,
- гал унтраах багаж г.м.

(е) Талбайд ажиллаж буй бүх хүмүүс хамгаалалтын малгай гутлыг өмсөнө.

(ё) Ажил гүйцэтгэх явцад бүхэлд нь Инженерийн тавьсан шаардлагыг хангах хэмжээний сайтар тоноглогдож, зохих мэргэжилтнээр хангагдсан анхны тусламж үзүүлэх цэгийг ажиллуулна. Гүйцэтгэгч нь Талбайн хамгаалалт, аюулгүй ажиллагаатай холбоотой бүх арга хэмжээ, бусад шаардагдах зүйлсийг өртөг зардалдаа оруулж тооцох ба үүнтэй холбогдон үүсэн бүх хариуцлагыг өөрөө хүлээнэ.

(ж) Гэмтэж бэртсэн хүнийг хамгийн ойрхон эмнэлэгт хүргэж өгөх тохиромжтой тээврийн хэрэгслийг хангаж байнгын бэлэн байдалд байлгана.

(з) Эрүүл мэнд, аюулгүй байдал, хөдөлмөр хамгааллын бүх асуудлуудыг хариуцан ажиллах нэг хүнийг Гүйцэтгэгчийн Төслийн удирдагч сонгож, аюулгүй ажиллагааны мэргэжилтнээр томилон, өөрийн бүрэн хяналтын дор ажиллуулна. Энэхүү хөдөлмөр хамгааллын мэргэжилтэн нь Гүйцэтгэгчийн төслийн менежерт ажлаа шууд тайлагнах гүйцэтгэгчийн мэргэжлийн багийн ахлах гишүүн байна. Тэрээр Монголд мөрдөгдөж буй хөдөлмөр хамгааллын холбогдолтой бүх хууль журмын талаар сайтар мэдлэгтэй байх ба өмнө нь ижил төстэй ажилд эрүүл мэнд хөдөлмөр хамгааллын мэргэжилтнээр ажиллаж байсан туршлагатай байна. Хөдөлмөр хамгааллын мэргэжилтэн нь ажиллах хүчний хөдөлмөр хамгаалалд нөлөөлж буй бүх зүйл болон хөдөлмөр хамгааллыг сайжруулах бүх арга хэмжээнд оролцоно. Энэ хүн нь талбайд ажиллаж буй хүмүүсийн эрүүл мэнд, хөдөлмөр хамгаалал болон ажлыг аюулгүй явуулахтай холбогдсон ямар нэг зааврыг Инженерээс юм уу Монгол улсын Засгийн газрын холбогдох байгууллагуудаас хүлээн авах, авсан даруйдаа биелүүлэх эрх бүхий этгээд байна.

(и) Талбайн бүх газрууд руу ямар нэг аюул, эрсдэл буюу бэртэл гэмтэлгүйгээр хүрч очих туслах зам барьж тогтмол засвар арчлалт хийх.

(й) Барилгын ажлын талбай дахь бүх байр сууц, ажлын байр, засварын газар, лаборатори, хяналтын байр, агуулах зэрэгт зориулан ариун цэврийн байгууламж, хог хаягдал цуглуулах болон зайлуулах тохиромжтой системийг төлөвлөн барьж, ашиглах ажлуудыг Монголд мөрдөгдөж буй хууль журам, тухайн орон нутгийн хууль тогтоолын дагуу Инженерийн шаардлагыг хангах хэмжээнд хийх ба эрүүл мэндэд хор хохирол учрах, агаар, ус, ойролцоох гол горхи бохирдох явдал гарахгүй ажиллана.

(к) Түр лагериудад хогийн савууд байрлуулж, тэдгээрийг тогтмол судалж цэвэрлэж байх, хог хаягдлыг холбогдох дүрэм журмын дагуу эрүүл ахуйн шаардлага хангах хэмжээнд зайлуулна.

(л) Гүйцэтгэгч, ажил дууссаны дараа өөрийн зардлаар Инженерийн тавьсан шаардлагын хэмжээнд бүх түр байгууламжуудыг буулган, хог хаягдлыг шатаан, бохирын сав болон нүх, жалгыг буцааж булан, сайтар хааж, гаднах талбайг бүхэлд нь цэвэр цэмцгэр үлдээнэ.

(м) Ажил явагдаж буй газарт хангалттай тооны бие засах газар ба бусад ариун цэврийн байгууламжуудыг барьж байгуулан тэдгээрийг Инженерийн болон тухайн орон нутгийн нийтийн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн газрын тавьсан шаардлагыг хангах хэмжээнд, эрүүл ахуйн нөхцөлийн дагуу тогтмол цэвэрлэж, ариутгаж байна.

(н) Олон гэр бүл нэг дор амьдардаг газар болон хуаран маягийн байгууламжтай газруудад нийтийн жорлонтой бол хүйс бүрд зориулсан тус тусдаа өрөөтэй барина. Эдгээр тасалгаануудын хаалган дээр ,,эрэгтэй,, ,,эмэгтэй,, гэж англи ба лагерьд амьдарч буй хүмүүсийн тухайн нутгийн хэл дээр тодоор тэмдэглэх юм уу амархан ойлгогдох зураг, тэмдэг наасан байна. Хэрвээ эдгээр хүйс тус бүрд зориулсан бие засах газрууд нь нэг байшинд байвал тэдгээрийг шалнаас тааз хүртэл өндөр хатуу хана юм уу хаалт хийж тусгаарлана.

(о) Олон нийтийн эрүүл мэндийн асуудал хариуцсан удирдах хүмүүстэй харилцан зөвлөлдөж, ажлын талбай, ажилчдын байр, түр лагерийн доторх шумуул, ялаа, хортон шавж, амьтан зэргийг устгах шаардлагатай арга хэмжээг авна.

(п) Хүний амь хохирсон буюу хүнд гэмтсэн, улмаар үүнээс болж эмнэлэгт хүргэгдэж гурваас дээш хоногоор хэвтсэн ямар нэг ноцтой аваар осол гарсан тохиолдолд Инженерт яаралтай мэдэгдэнэ. Эхний үед ийм мэдээллийг амаар хүргэж болох ба болсон явдлын дараа 24 цагийн дотор Гүйцэтгэгч дэлгэрэнгүй тайланг бичгээр бэлтгэж танилцуулна. Иймэрхүү ноцтой аваар ослын талаар хуулийн байгууллагад мэдэгдэхтэй холбоотой аливаа шаардлагыг Гүйцэтгэгч дагаж мөрдөнө.

(р) Эрүүл мэнд, хөдөлмөр хамгаалал юм уу эд хөрөнгийн эвдрэл гэмтэлтэй холбоотой аливаа бусад аваар осол, үйл явдлын деталиудыг Гүйцэтгэгч бүртгэх ба аваар осол гарсан даруйд зохих маягтын дагуу бэлтгэсэн мэдээллийг Инженерт болон хуулийн байгууллагуудад аль болох яаралтай хүргүүлнэ.

(с) Хэрвээ Гүйцэтгэгч үйл ажиллагаагаа улирлын байдлаас юм уу бусад шалтгаанаар түр зогсоовол ажлыг аюулгүй байдалд орхиж байгаа эсэхийг баталгаажуулна. Тэрээр өөрийн төслийн удирдлагын багаас Инженерийн хүлээн зөвшөөрөх нэг хүнийг зогсолтын үеийн хугацааны туршид хөдөлмөр хамгааллыг асуудлыг хариуцан ажиллуулахаар томилон, түүний нэр, холбоо барих утасны дугаарыг Инженерт мэдэгдэнэ.

(т) Гүйцэтгэгч болон түүний туслан гүйцэтгэгчид, мөн тэдгээрийн ажиллагсад, Гүйцэтгэгчээс талбайд байх эрх олгосон хүмүүс нь эрүүл мэнд, хөдөлмөр хамгаалалтай холбоотой хууль, дүрэм журмын заалтуудыг бүх талаар дагаж мөрдөнө.

(у) Энэ зүйлийн заалтууд нь Гүйцэтгэгчид хамаарахаас гадна, шаардлагатай өөрчлөлтүүдийг хийснээр түүний туслан гүйцэтгэгчид хамаарна. Гүйцэтгэгчийн туслан гүйцэтгэгчидтэй байгуулсан гэрээнд эдгээр заалтууд орсон эсэхийг тэрээр баталгаажуулна.

## 117 ХАШАА ХААЛГЫГ ХАМГААЛАХ, ЗАСВАРЛАХ

Гүйцэтгэгч нь талбайд ажиллаж буй хүмүүс болон эд хөрөнгийн аюулгүй байдал болон барилгын ажлын үед талбайд мал, амьтан оруулахгүй байх зэргийн хариуцлагыг хүлээнэ. Ажлыг зохистой явуулахын тулд хуучин хашаа, хаалга зэргийг буулгах, зөөж барих, хэрвээ эзэн юм уу эзэмшигч нь уг хашаа, хаалгыг зайлуулах юм уу шилжүүлэх хариуцлагыг хүлээсэн ч тэдгээрт нөхөн төлбөр олгох заалт бүхий хоёр талын гэрээ байгуулаагүй бол Гүйцэтгэгч өөрөө, мал, амьтан талбайд орохоос сэргийлж түр хашаа, хаалга барьж, шаардлагатай бол харуул, манаач ажиллуулна.

Ажлыг зохистой хэрэгжүүлэх үүднээс улмаас буулгах, зөөх шаардлагатайгаас бусад хашаа, хаалга зэргийг гэрээний хэрэгжилтийн нийт хугацааны туршид эвдлэхгүй, мал амьтан оруулахгүй байх талаар Гүйцэтгэгч өөрийн ажилчдад шаардлага тавьж ажиллана.

## 118 ИНЖЕНЕРИЙН БАЙГУУЛАМЖ, ШУГАМ СҮЛЖЭЭГ ХАМГААЛАХ

Гүйцэтгэгч, газар доор буюу дээр хийгдсэн аливаа хуучин ажил, инженерийн байгууламж, шугам сүлжээг (цаашид инженерийн байгууламж гэх) эвдэж гэмтээсэн тохиолдолд хариуцлагыг хүлээж, Захиалагчийн эсрэг гарсан аливаа зарга болон хохирлыг барагдуулна. Өртсөн бүх инженерийн байгууламжийг нөхөн сэргээх ажлыг өөрийн зардлаар хийж гүйцэтгэх хариуцлагыг хүлээнэ.

Хуучин инженерийн байгууламжийн ойр орчмын газарт ухалтын ажил эхлэхээс өмнө юм уу энэ ажил нь инженерийн байгууламжуудад нөлөөлөхүйц шинжтэй байвал, Гүйцэтгэгч, тэдгээр инженерийн байгууламжуудыг эзэмшигч юм уу тэдгээрийг ажиллуулж буй холбогдох байгууллагуудад мэдэгдэж, Инженерийн зааврaар, ажлаа үргэлжлүүлэхээс өмнө, тэдгээр байгууламжийг хэрхэн хамгаалах, сэргээн засварлахаар төлөвлөсөн өөрийн ажлын төлөвлөгөөгөө холбогдох байгууллагуудад танилцуулж зөвшөөрөл авна.

Гүйцэтгэгч, дараах бүх инженерийн байгууламжийн, гэхдээ зөвхөн тэдгээрээр хязгаарлагдахгүйгээр, байршил болон холбогдох деталиудыг нарийвчлан тогтоох үүрэгтэй. Үүнд:

- бохирын шугам,
- гадаргын ус зайлуулах байгууламж,
- цахилгаан, холбоо, гэрэлтүүлгийн кабель шугам, шилэн кабель,
- өндөр хүчдэлийн цамхгийн шон, кабелийн суваг хоолой,
- ус дамжуулах шугам,
- дулаан дамжуулах шугам.

Тэдгээр инженерийн байгууламжууд, шугам сүлжээг булж далдалсан байвал, Гүйцэтгэгч эзэмшигч байгууллагуудаас нь тэдгээрийн байршил, булсан гүн зэргийн талаарх мэдээллийг авна. Гүйцэтгэгч, цахилгаан ба цахилгаан соронзон багажийн аль тохирохыг ашиглан гараар туршилтын нүх болон шуудуу ухах зэрэг

аргаар цааш хайгуул хийнэ. Ил гарсан инженерийн байгууламж, шугам сүлжээг хэрхэх асуудлыг Инженер ба холбогдох байгууллагуудтай зөвлөлдөж, шийдвэрлэнэ.

Эрсдэлтэй байж болох инженерийн байгууламжуудыг бүрэн ил гаргах ба эдгээр ухмалыг сайтар манаж өгнө. Орчин тойронд нь барилгын ажил эхлэхээс өмнө ил гарсан шугам сүлжээг газар дээр нь сайтар хамгаална. Ажилтай залгаа суурилуулсан аливаа байгууламжийг ажлыг дуусах хүртэл газар дээр нь аюулгүй байлгах ба дараа нь аюулгүй, тогтвортой байдалд нь буцааж суурилуулна.

Барилгын ажил дууссаны дараа шугам, хоолой, утасны доорх суурийн хэсэгт дүүргэлт хийх, нягтруулах, усны тоолуур, урсгал тохируулагч хайрцаг, худгийн таг болон бусад адил төстэй зүйлсийг хийхэд онцгой анхаарал хандуулна. Ухмал, буцаан дүүргэлт, дахин суурилуулах (шаардлагатай үед) зэрэг ажлыг зохих дүрэм, журмын дагуу, эзэмшигч байгууллагуудын зааварчилгаа, хяналтын дор хийж гүйцэтгэнэ. Ажлын шаардлагын дагуу хийсэн ухалтаас шалтгаалан замын гадаргуугийн эцсийн төвшинг өөрчлөх болвол, тэдгээр хаалтын таг, худаг, үзлэгийн худгийн тагуудын төвшин ба тэдгээрийн амсрыг Инженерийн тавьсан шаардлагад нийцүүлэн тохирох байдлаар өөрчилнө.

Гүйцэтгэгч, зурагт үзүүлээгүй хэдий ч талбайгаас илрүүлсэн инженерийн байгууламж, шугам сүлжээний талаар Инженерт яаралтай мэдэгдэнэ. Хэрвээ, Инженерийн бодлоор, Гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас үүдэн инженерийн байгууламжид хохирол учирч магадгүй байвал, Инженерийн зүгээс эдгээр хохирлоос урьдчилан сэргийлэх үүднээс зааварлаж болох аливаа арга хэмжээг Гүйцэтгэгч авна.

Өндөр хүчдэлийн цахилгаан нь кран болон бусад овор ихтэй техник хэрэгслийн эд ангиар дамжин газар луу ,,богино холбоо үүсгэх,, аюултай тул Гүйцэтгэгч нь цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн шугамын ойролцоо ажиллаж буй бүх хүмүүст аюулгүй зайг баримтлан ажиллах ёстойг таниулж зааварчилгаа өгсөн байна. Хүснэгт 1-1, 1-2-т өндөр хүчдэл дамжуулах шугам ба нам хүчдэлийн түгээх шугамуудын хувьд баримтлах аюулгүй зайг санал болголоо. Эдгээр саналуудыг үл харгалзан, Гүйцэтгэгч, тэдгээрийн үйл ажиллагааг хариуцсан холбогдох мэргэжлийн байгууллагуудтай зөвлөлдөн, төрөл бүрийн хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамаас гадагш баримтлах аюулгүй зайг өөртөө зориулан тогтооно. Аливаа урьдчилан сэргийлэх арга хэмжээний болон цахилгааны шугамд ажил ойрхон байгаагаас шалтгаалан зайлшгүй хийгдэх ажлын зардлыг Гүйцэтгэгч хариуцна.

**Хүснэгт 1-1: Өндөр хүчдэл дамжуулах шугамаас дооших, санал болгож буй цэвэр зай**

| Вольт кВ | Зай |
|---|---|
| 138 | 7.8 м |
| 230 | 8.4 м |
| 345 | 9.4 м |
| 500 | 10.0 м |

**Хүснэгт 1-2: Нам хүчдэлийн түгээх шугамаас доошох, санал болгож буй зай**

| Вольт кВ | Зай |
|---|---|
| 0 - 750 | 1 м |
| 750 - 38,000 | 1 м |
| 38,000 - 86,000 | 1.5 м |

Гүйцэтгэгч нь дээрх шаардлагуудыг үл харгалзан, гэхдээ, өөрийнхөө үүрэг хариуцлагыг бууруулахгүйгээр, хэрвээ аливаа ажил, инженерийн байгууламжууд ил гарсан, тэдгээрийг илрүүлсэн юм уу гэмтээсэн тохиолдолд, Инженерт яаралтай мэдэгдэнэ.

Ажлын төлөвлөгөөг боловсруулах, зохицуулах болон хэрэгжүүлэхтэй уялдан, аливаа инженерийн байгууламжид хийгдэх өөрчлөлтийн бүх зардлуудыг Гүйцэтгэгч өөрөө хариуцна.

## 119 ИНЖЕНЕРИЙН БАЙГУУЛАМЖИЙГ ШИЛЖҮҮЛЭХ

Зураг дээр үзүүлсэн инженерийн байгууламжийн байршил, деталиудыг үл харгалзан, өгсөн мэдээллийг баталгаажуулах, нарийвчлан тогтоохын тулд Гүйцэтгэгч, нэмэлт хайгуул судалгаа хийнэ.

Гэрээний нөхцөлийн дэд-зүйл 14.1 болон энэхүү техникийн шаардлагын зүйл 104-ийн шаардлагуудын дагуу ажлын хөтөлбөрөө боловсруулж байх явцдаа, Гүйцэтгэгч техникийн шаардлагын зүйл 120-д тодорхойлсны дагуу ажлын эргэн тойронд байгаа инженерийн байгууламжийг илрүүлэх, байршлыг тогтоох, хамгаалах, шилжүүлэх болон холбогдох байгууллагуудад мэдэгдэх шаардлагатай хугацааг тооцож үзсэн байна.

Гүйцэтгэгч, аливаа инженерийн байгууламжийг шилжүүлэх юм уу өөрчлөх, шаардлага гарсан тохиолдолд холбогдох байгууллагуудтай холбоо харилцаатай ажиллах хариуцлагыг хүлээнэ. Хэрвээ гүйцэтгэгч, Захиалагчаар дамжуулан Засгийн газрын дэмжлэг туслалцаа авах болвол, энэ асуудалтай холбогдсон шаардлагуудыг Инженерт мэдэгдэнэ.

## 120 ЗАСГИЙН ГАЗАРТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ

Хөдөлгөөний хяналт болон ажлыг гүйцэтгэхтэй холбогдсон бусад асуудлуудын талаар орон нутаг, төмөр зам, цагдаагийн болон Засгийн газрын холбогдох албаны хүмүүстэй харилцан зөвшилцөж ажиллах ба тэдгээр хүмүүст дээр дурдсан чиглэлээр ажил үүргээ биелүүлэхэд нь шаардагдах бүх талын туслалцаа, нөхцөл боломжоор хангана.

## 121 ГАЗАР АВАХ

Зургийн ботид дурдаж, энэ техникийн шаардлагад нарийвчлан заасны дагуу Засгийн газар байнгын ажил явагдах газар нутгийг Гүйцэтгэгчид ямар ч үнэ төлбөргүй олгоно. Энэ нь барилгын ажилд ашиглагдах машин тоног төхөөрөмжүүд ажиллахад шаардагдах боломжийн хэмжээний зайг тооцож оруулсан барилгын ажил явагдах бодит газраар хязгаарлагдана. Энэ техникийн шаардлагын зүйл 602-т заасан шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлуулах талбай, карьер, тэдгээрт хүрэх зам, замын зурвасын гаднах түр зам, талбайн лаборатори, Инженерийн ажлын болон орон сууц, хяналтын байр, Гүйцэтгэгчийн өөрийн түр лагерь, ажлын байр, агуулах, засварын газар, орон сууц, түр барилга болон бусад зорилгод ашиглах бүх газрыг авах асуудлуудыг Гүйцэтгэгч хариуцна.

Талбайн лаборатори, Инженерийн ажлын болон сууцны байр, хяналтын

байр зэргийг барихаар Гүйцэтгэгчийн зүгээс хангах газрын байршил, тэдгээрийн схемийг харуулсан талбайн план төлөвлөгөөг Инженерт танилцуулж зөвшөөрөл авна.

Захиалагч, өөрийн үүрэг хариуцлагаа биелүүлэх үүднээс, Гэрээний хэрэгжилтийн явцад газар авах шаардлагатай бол, Гүйцэтгэгч газар эзэмшигчийг тогтоож, Инженерийн зааврааp хариуцсан холбогдох байгууллагуудын үнэлсний дагуу газрын болон түрээсийн төлбөр, ажлын шаардлагаар ямар нэг байгууламж, эд хөрөнгийг буулгах, шилжүүлэх юм уу байгаа газрыг шилжүүлэх зэрэгт олгох нөхөн төлбөрийг төлнө. Үүнтэй холбоотой Гүйцэтгэгчийн хүлээх хариуцлагыг энэ техникийн шаардлагын зүйл 603-д тодорхой тайлбарласан байгаа. Хэдийгээр, Гүйцэтгэгч, эхний үед газар худалдаж авах төлбөрийг төлж болох боловч, тэдгээр бүх газрууд нь Захиалагчийн өмч байна. Хэрвээ Гүйцэтгэгч, Захиалагчаар дамжуулан Засгийн газрын дэмжлэг туслалцаа авах болвол, дор хаяж 28 хоногийн өмнө энэ асуудалтай холбогдсон шаардлагуудыг Инженерт урьдчилан мэдэгдэнэ.

Шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлуулах талбай, карьер, тэдгээрт хүрэх зам, замын зурвасын гаднах түр зам, талбайн лаборатори, Инженерийн ажлын болон орон сууц, хяналтын байр, Гүйцэтгэгчийн өөрийн түр лагерь, ажлын байр, агуулах, засварын газар, орон сууц, түр ажил болон бусад зорилгод ашиглахад шаардагдах бүх газрын хувьд Гүйцэтгэгч холбогдох хөрөнгө эзэмшигчидтэй хамтран шаардлагатай бүх зохион байгуулалтыг хийж, орон нутгийн хууль тогтоомжийн дагуу тэдгээртэй уялдаж гарах төлбөрүүдийг төлнө. Ажлыг хэрэгжүүлж дуусгах үед болон хэрэгжсэний дараа ба Инженерийн зүгээс зааварчилгаа өгсөний дагуу, инженер бодитой бөгөөд боломжтой гэж үзсэн тохиолдолд, Гүйцэтгэгч нь инженерийн шаардлагад хангасан хэмжээнд бүх газруудыг ашиглалтын өмнөх байдалд нь эргүүлэн оруулна.

Гүйцэтгэгч ямар нэг зорилгоор газрыг худалдаж авах хүсэлт гаргаад дараа нь тэр газар ашиглагдахгүй бол нөхөн төлбөр, худалдан авах болон уг газрыг дахин эзэмшүүлэх зэрэгтэй холбоотой бүх зардлыг гүйцэтгэгч хариуцна.

## 122 УСАН ХАНГАМЖ

Гүйцэтгэгч, барилгын ажил болон бүх байшин, сууц, ажлын байр, талбайн лаборатори, хяналтын байр, агуулах, засварын газар ба ажилчдын байрны хэрэгцээнд зориулан хангалттай хэмжээний цэвэр усаар тогтмол хангана. Тэрээр усны шугам хоолой, орон нутгийн усны гол шугамд холбох, тоолуур, насос, усны цистернээр хангах, шаардлагатай газарт усыг зөөвөрлөх, ус ашигласны төлбөр, зардлыг төлөх, ажил дуусахад усан хангамжийн холбогдолтой байгууламжийг зохих байдлаар нь буулгах зэрэг бүх арга хэмжээг авна.

Гүйцэтгэгч орон нутагт хэрэгжиж буй хууль тогтоомжийн дагуу байгалийн усны нөөцийг ашиглаж болох ба энэхүү нөөцийг ашиглаж буй бусад хэрэглэгчидтэй хийсэн маргааны улмаас ямар нэг зарга үүссэн тохиолдолд Гүйцэтгэгч өөрөө зохицуулна. Гадаргын усны байгалийн нөөц байхгүй юм уу ямар нэг шалтгааны улмаас хангалтгүй байвал, Гүйцэтгэгч, орон нутгийн хууль тогтоомжийн дагуу өөрийн зардлаар газрын гүний эх үүсвэрээс худаг гаргаж ашиглах ажлыг зохион байгуулна.

Ус нь ажилд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй, ямар нэг хөвөгч хатуу биет, бодисыг агуулаагүй, цэвэр байна. Барилгын ажил болон бүх байшин, сууц, ажлын байр, талбайн лаборатори, хяналтын байр, агуулах, засварын газар ба ажилчдын байрны хэрэгцээнд зориулан барилгын талбайд хангах ус нь Инженерийн болон нийтийн эрүүл мэндийн асуудал хариуцсан холбогдох байгууллагын шаардлагыг хангасан, унданд хэрэглэх боломжтой, чанартай ус байна.

Ундны усны чанарыг Байгаль орчны яамнаас (БОЯ) боловсруулсан усны

чанарын үзүүлэлтүүдийн дагуу хянана.

Мод тарьж зурвас байгуулахтай холбогдуулан худаг гаргах, хамгаалалтын хашаа, усжуулалтын хоолой зэргийг төлөвлөж, Инженерээр батлуулна.

## 123 МАТЕРИАЛ БА ХИЙЦ ХЭСГҮҮД

Ажилд хэрэглэгдэх материалууд нь энэхүү техникийн шаардлагын нөхцөлүүдийг хангана. Хэрвээ Гүйцэтгэгч, өөр хувилбар техникийн шаардлагын дагуу ижил буюу илүү өндөр стандартын материал хангахыг илүүд үзвэл, санал болгож буй хувилбар техникийн шаардлагын хуулбар хувь болон санал болгосон материалын техникийн иж бүрэн шаардлагын хамт Инженерт хүргүүлнэ. Эдгээр материалуудыг Гүйцэтгэгч өөрийн зардлаар Инженерийн зөвшөөрсөн лабораторид шинжилж, баталгаажуулна. Гэрээнд өөрөөр заагаагүй бол, ажилд хэрэглэх бүх бараа, материал, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, үйлчилгээ зэргийг Гүйцэтгэгч хангана. Энэхүү техникийн шаардлагын дагуу ажилд хэрэглэх материалын нөөцийг тогтоох, хангах, тээвэрлэх, хадгалах зэрэг ажлыг Гүйцэтгэгч дангаараа хариуцна.

Ажилд хэрэглэх ямар нэг материал, хийц хэсгүүдийн захиалгыг өгөхөөс өмнө Гүйцэтгэгч, тэдгээр материал, хийц хэсгүүдийг авахаар төлөвлөж буй пүүс компаний нэр, тэдгээрийн эх үүсвэр, бүтээгдэхүүний талаарх үйлдвэрлэгчийн тодорхойлолт, тэдгээрийн чанар, жин, бат бэх болон бусад холбогдох мэдээллийг Инженерт танилцуулна. Гүйцэтгэгч,үйлдвэрлэгчийн тэдгээр материал болон хийц хэсгүүдийн дээжийг, мөн шаардлагатай бол адил төстэй материал, хийцийн дээжүүдэд хийсэн сүүлийн шинжилгээнүүдийн сертификатуудыг Инженерт танилцуулна.

Инженер шаардсан тохиолдолд, ажилтай холбоотойгоор бүх шаардагдах материал, хийц хэсгүүдийн үнийн санал болон захиалгын хувийг Гүйцэтгэгч түүнд танилцуулна.

Хэрвээ, Байнгын ажилд ашиглахаар төлөвлөсөн юм уу эсвэл аль хэдийн ашиглагдаж буй бараа, материал нь холбогдох техникийн шаардлагыг хангахгүй байна гэж Инженер үзвэл, тэдгээр бараа материалыг хэдийд ч хүчингүй болгох эрхтэй бөгөөд зөвшөөрөгдөх чанар бүхий бараа материалаар солих зааварчилгаа өгнө. Үүний үр дүнд гарах нэмэлт зардал болон чанаргүй хийгдсэн ажлын зардлыг, солих шаардлагатай бараа материал авах бүх зардлын хамт Гүйцэтгэгч гаргана.

## 124 ЦООНОГ БА ШИНЖИЛГЭЭНИЙ НҮХНЭЭС АВСАН МАТЕРИАЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Инженерийн бэлтгэсэн материалын тайланг оролцуулаад, Инженерийн зүгээс тендерт оролцогчдод хангасан ямар нэг мэдээллийг Гэрээний бүрдэл хэсэг гэж үзэхгүй. Ажлын талбайд Инженерийн ухсан цооног, шинжилгээний нүх болон бусад судалгааны мэдээлэлд үндэслэн өөртөө гаргасан аливаа дүгнэлтийнхээ хариуцлагыг Гүйцэтгэгч өөрөө дангаараа хүлээнэ.

Талбайд нийтлэг ухмалын ажил эхэлж, цаашид үргэлжлэх явцад тодорхой болох мэдээлэлд үндэслэн, газрын төвшнөөс доошох газар шорооны ажлын болон суурийн төвшинг Инженер тааруулан өөрчилж болно.

Гэрээний нөхцөлд нарийвчлан тодорхойлсоны дагуу Гүйцэтгэгч ажлын талбайг хянах, шалгах үүрэгтэй.

## 125 МАТЕРИАЛ, ХИЙЦ ХЭСГҮҮДИЙГ ХАДГАЛАХ

Бүх материал, хийц хэсгүүдийг Инженерийн шаардлагад нийцэх байдлаар ажлын талбайд хадгална. Гүйцэтгэгч бүх ажил, материал болон хийц хэсгүүдийг цаг агаар, үер ус болон бусад гаднын нөлөөнд өртөхөөргүй байдлаар хадгалж,

хамгаална.

## 126 ШИНЖИЛГЭЭНИЙ СЕРТИФИКАТ

Эдгээр техникийн шаардлагын дагуу юм уу эсвэл Инженерийн зааварласны дагуу, Гүйцэтгэгч нь Ажилд хэрэглэх материал ба хийц хэсгүүдийг үйлдвэрлэгчийн шинжилгээний сертификатуудыг түүнд танилцуулна. Тэдгээр шинжилгээний сертификатууд нь материал ба хийц хэсгүүд энэ техникийн шаардлагын дагуу шинжлэгдсэн гэдгийг батлах бөгөөд хийгдсэн бүх шинжилгээний хариунуудыг харуулсан байна. Гүйцэтгэгч, талбайд хүргэгдсэн материал ба хийц хэсгүүдийг ялгах хангалттай аргуудыг зохих шинжилгээний сертификатуудын хамт хангана.

## 127 ГЭРЭЛ ЗУРАГ

Энэхүү техникийн шаардлагын дэд-зүйл 131 (б)-ийн дагуу Гүйцэтгэгчийн хангасан зургийн аппаратаар Инженер барилгын ажлын явцын зургийг авна.

## 128 ЗАМЫН САМБАР

Гүйцэтгэгч, Зурагт үзүүлсэн юм уу Инженерийн зааварласан ширхэг, дизайн, өнгө, хэмжээгээр замын самбарыг хийж, суурилуулан, арчилж хамгаална. Инженерийн зааварласан цэгүүдэд замын самбаруудыг суурилуулна.

Замын самбаруудыг Гэрээ байгуулах эрх олгох тухай албан бичиг олгосноос хойш 56 хоногийн дотор суурилуулсан байна. Гүйцэтгэгч тэдгээр замын самбарыг баталгаат засварын хугацаа дуусах үед буцааж авна.

## 129 ТАЛБАЙН ЛАБОРАТОРИ

Гүйцэтгэгч нь талбайн лабораторийн барилгыг шинээр барих, засварлах замаар хангах ба лабораторийн тавилга, тоног төхөөрөмжийг хангаж, засаж арчилна.

(а) Ерөнхий

Гүйцэтгэгч нь, Гэрээний хэрэгжилтийн явцад, Гүйцэтгэгч ба Инженерийн хамтран ашиглах талбайн лабораторийг байгуулах буюу хангаж, шаардлагатай тавилга хэрэгслээр тохижуулж, засварлаж, арчилна.

Талбайн лабораторын барилгын гадуур 0,25г гектараас багагүй талбайтай, 2м өндөр хашаа барьж хамгаална. Хашааны ирмэгээр өргөстэй тор татах ба 5м өргөн хаалгатай, дотор талаас онгойлгодог цоожтой байна.

Инженерийн ажлын байр, талбайн лабораторийг бүрэн ашиглалтанд оруулж, бэлэн болгон, зохих хэмжээнд ажиллах боломжтой гэж Инженерийн зүгээс зөвшөөрөл олготол барилгын ажил эхлэхийг үл зөвшөөрнө. Гүйцэтгэгч нь талбайн лаборатори, доторхи тавилга, тоног төхөөрөмж зэргийг осол аваар, гал түймэр, хулгай дээрэм болон бусад болзошгүй эвдрэл сүйрэл, хохирлоос сэргийлэн, баталгаат засварын хугацааг оролцуулан Гэрээний хэрэгжилтийн нийт хугацааны туршид даатгалд даатгуулна.

Талбайн лабораторид шаардагдах нэмэлт тоноглолыг хангахдаа энэ техникийн шаардлагыг дагаж мөрдөхөөс гадна Монгол Улсад мөрдөгдөж буй улсын болон орон нутгийн хууль тогтоомж, Захиалагчийн зүгээс тавигдах шаардлагуудыг харгалзаж үзнэ. Гүйцэтгэгч лабораторийг байгуулахтай холбогдуулан нарийвчилсан байршлын зураг, барилгын план бүхий өөрийн төлөвлөгөөгөө энэ техникийн шаардлагад өгөгдсөн зарчмуудын дагуу бэлтгэж, Инженерт танилцуулан батлуулна.

Лаборатори нь Инженерийн шаардлага хангах хэмжээнд байх ба энэ асуудлаар Инженертэй харилцан зөвшилцөж, тохижуулахаас өмнө албан бичгээр баталгаажуулна.

Гүйцэтгэгч лабораторын барилгын эргэн тойронд түр зам, хашаа, хаалт барьж, ус, халаалт, цахилгаан хангамжид холбох, харуулын байр, гадна хамгаалалтын гэрэлтүүлэг, харилцуур утас, ариун цэврийн өрөө зэргийг хангах, хог хаягдлыг зайлуулах зохицуулах гэх мэт бүх асуудлыг Инженерийн шаардлага хангах хэмжээнд хийнэ. Борооны улирлын үед шаардлагатай бол ус тогтохоос сэргийлж ус зайлуулах шуудуунуудыг барих ба лабораторийн барилгын гадна талбайд 100мм-ээс багагүй зузаантай хатуу хучилт хийнэ.

Лабораторийг зөвшөөрөгдсөн будгаар будаж, гэрээний хэрэгжилтийн үед, мөн Инженер зааварласан тохиолдолд, баталгаат засварын хугацааны үед бүхэлд нь энэхүү будгийн ажлыг хамгаалж, арчилна.

Лабораторийн барилгад Инженерийн болон Захиалагчийн зүгээс тавьсан шаардлагын дагуу галын аюулаас хамгаалах хэрэгслүүдийг байрлуулна.

Лабораторийн барилга нь хангалттай газардуулагч бүхий 220В, 50 Гц-ийн цахилгаан хүчдэл болон ундны цэвэр усаар 24 цагийн туршид тогтмол хангагдсан байна.

Лабораторийн байрны шал, таазны хоорондох цэвэр өндөр доод тал нь Инженерийн болон Захиалагчийн шаардсаны дагуу байна.

Гүйцэтгэгч Лаборатори байрлаж буй газрыг тогтмол цэвэрлэх, арчлах үүрэгтэй. Тогтмол хугацаанд уг газрыг тойруулан барьсан хашаан доторхи өвс ургамал ногоо зэргийг зулгааж цэвэрлэх, тэдгээрийг зөөж зайлуулах ажлуудыг Инженерийн тавьсан шаардлагын хэмжээнд хийж гүйцэтгэнэ.

Гүйцэтгэгч, нийтийн жорлон, хог хаягдлын цэгийг цэвэр, элдэв үнэргүй, эрүүл ахуйн шаардлага хангасан хэмжээнд байлгахад шаардагдах бүх төрлийн ариун цэврийн үйлчилгээг хангах үүрэгтэй. Үүнээс гадна, гүйцэтгэгч, бүх хог хаягдлыг зайлуулах ажлыг хийнэ.

Энэ зүйлд заасан шаардлагуудыг биелүүлэх үүднээс, Гүйцэтгэгч, хангалттай үйлчилгээний ажилчид, багаж хэрэгсэл, шүүр сойз, шалны мод, хувин болон бусад адил төстэй зүйлс болон угаалгын хэрэгслээр хангана. Гүйцэтгэгч дээрх шаардлагыг хангахын тулд шаардлагатай зардлуудыг өөрийн үнэ өртөгтөө оруулан тооцсон гэж үзэх бөгөөд тусад нь ямар нэг төлбөр хийхгүй.

(б) Талбайн лаборатори

Гүйцэтгэгч нь Лабораторийг Инженерийн зөвшөөрсөн газарт байгуулна.

Гүйцэтгэгч нь төслийн талбайд ойр, Инженерийн зөвшөөрсөн газарт 150м2 талбай бүхий талбайн лабораторийг хангах ба Инженерийн зааварласан буюу баталсан зургийн дагуу байгуулна.

Гүйцэтгэгч, лаборатори бүрт байгаа ажлын байр болон ажиллах талбайд халаалтын ба агааржуулалтын системүүдийг хангаж байрлуулна. Эдгээр төхөөрөмжүүд нь лабораторийн байрны доторхи агаарын температурыг тогтмол 15-20 $^{0}$С-ийн хэмд байлгана.

Лабораторийн барилга бүрийн шалыг төмөр бетоноор хийж цахилгаан үүсгүүртэй U3 зүлгүүрээр тэгшилнэ. Нягтруулалт хийхэд зориулан 0.4м-ийн зузаан, 1.5 м х 1.5 м-ийн хэмжээтэй төмөр бетон хавтан шал хийнэ. Бетон бутлах, хөрсний даацын үзүүлэлтийг (CBR) шалгах машинууд ба (Marshall) аппаратыг суурилуулах төмөр бетон тавцанг хийнэ.

Лабораторийн ажлын талбайд доороо дотуур шүүгээ, дээрээ хатуу тавиур бүхий хатуу төмөр гадаргуутай вандан сандлуудыг хангаж лабораторийн агуулахад тохирсон тавиуруудыг тавих ба эдгээрийн талаар Инженерээс зөвшөөрөл авна. Цонхнуудад хаалт хөшиг хийнэ.

Үүнээс гадна, лабораторид залгаа хатаах сүүдрэвч, дээжийг усанд сойх сав зэргийг байрлуулна. Хатаах суудрэвч нь ойролцоогоор дор хаяж 25м$^2$ талбай бүхий дээш өргөгдсөн бетон шалтай, хажуу талаараа онгорхой боловч агаарын нөлөөнөөс хамгаалах дээвэртэй байна. Дээжийг усанд сойх сав нь 3 м х 1 м х 0.3 м гүн байх ба ус нэвтрэхгүй бетон юмуу инженерийн зөвшөөрсөн өөр ямар нэг материалаар хийгдсэн байна.

Лабораторийн байрыг доор дурьдсан тавилга, лабораторийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангаж, засвар үйлчилгээг байнга гүйцэтгэнэ. тоноглоно.

i) Талбайн лабораторийн тавилга

Гүйцэтгэгч нь доор дурдсан тавилгыг Талбайн лабораторийн байранд хангана. Үүнд:

(1) 3-ш 4 шургуулга бүхий цоожтой төмөр шүүгээ
(2) 3-ш 6 шургуулгатай конторын ширээ, өндөр, зөөлөн түшлэгтэй тохойвч бүхий сандлын хамт,
(3) 3-ш 2 хаалга бүхий тавиуртай, цоожтой төмөр шүүгээ,
(4) 3-ш хогийн сав
(5) 6-ш конторын сандал
(6) 7-ш лабораторийн сандал
(7) 3-ш хогийн сараалжин сав
(8) 3-ш 1,8м х 0,9м хэмжээтэй бичгийн ширээ

ii) Лабораторийн тоног төхөөрөмж, аппарат хэрэгсэл

Гүйцэтгэгч нь зам барилгын ажилд шаардагдах туршилт шинжилгээг хийхэд зориулж лабораторийн доор дурдсан тоног төхөөрөмж, аппарат хэрэгслийг лабораторид байрлуулна.

| № | Шинжилгээний нэр | Зүйл | Нэгж | Тоо хэмжээ |
|---|---|---|---|---|
| 1. | Дээж авах болон бэлтгэл ажил | Дээж хуваарилагч хайрцагнууд (хам.их шигшилтийн хэмжээ 25-75 мм) | ш | 3 |
| | | Шаазан уур, нүдүүр | ш | 3 |
| | | Проктор/CBR/Маршалын экструдер | ш | 3 |
| 2. | Чийгшлийн агуулга | Чийгийг түргэвчилсан аргаар тодорхойлох | ш | 3 |
| 3. | Хөрсний үзүүлэлтүүд | Касаграндын арга AASHTO T89 | | |
| | | Урсалтын хязгаарыг тодорхойлогч (цахилгаанаар) | ш | 3 |
| | | Урсалтын хязгаарыг тодорхойлогч (гараар) | ш | 3 |
| | | Касагранд ховил гаргагч | ш | 3 |
| | | Уян налархайн хязгаар AASHTO T90 | | |
| | | Уян налархайн хязгаарыг тогтоогч шилэн хавтан | ш | 3 |
| | | Ууршуулах сав | ш | 3 |
| | | Хутгуур | ш | 3 |
| | | Хувийн жин ба нягтыг тодорхойлох хийн сав | ш | 3 |
| | | Цахилгаан сэгсрэгч | ш | 3 |
| | | Пикнометр | ш | 3 |

| № | Шинжилгээний нэр | Зүйл | Нэгж | Тоо хэмжээ |
|---|---|---|---|---|
| 4. | Шигшилт | Хутгагч аппарат | ш | 3 |
| | | Хөрс бутлах сав | ш | 3 |
| | | Хөрсний гидрометр | ш | 3 |
| | | Суулт тодорхойлох цилиндр | ш | 3 |
| | | 450 мм-ийн диа гөрмөл төмөр торон шигшүүрүүд: 63, 50, 45, 37.5, 25, 19, 16,13.2, 9.5, 6.3, 4.75 ба таг, суурьнууд | | |
| | | 200 мм-ийн диа гөрмөл төмөр торон шигшүүрүүд: 4.75, 2.36, 2.00, 1.18мм ба 600, 425, 300, 212, 150 ба 75 мм ба таг суурьнууд | ком | 3 |
| | | Шигшүүрийн багс (жижиг ба том ширхэгтэй хоёулаа) | | |
| | | 75 мм угаах шигшүүр | ш | 6 |
| | | Шигшүүр сэгсрэгч (450 мм) | | |
| | | Шигшүүр сэгсрэгч (200 мм) | ш | 3 |
| | | Чийгтэй шигшүүрийн нэмэлтүүд | ш | 3 |
| | | Элсний эквивалентыг тодорхойлох | ш | 3 |
| | | AASHTO T176 | ш | 3 |
| | | Элсний эквивалентыг тодорхойлох аппарат | ш | 3 |
| 5. | Нягтруулалт ба хөрсний даацыг тодорхойлох (CBR) | Нягтралын хэв AASHTO T180 | ш | 9 |
| | | Дагтаршуулагч | ш | 6 |
| | | Тэгшлэгч | ш | 6 |
| | | Хутгах халбага | ш | 9 |
| | | Холигч хусуур | ш | 6 |
| | | Хутгуур | ш | 6 |
| | | Дээжний тавиур | ш | 12 |
| | | Угаагч лонх | ш | 6 |
| | | Чийгшлийн агуулгыг тодорхойлох сав | ш | 20 |
| | | CBR шинжилгээ AASHTO T193 | | |
| | | CBR шинжилгээний машин | ш | 3 |
| | | Ачаа | | |
| | | 10 кН | ш | 3 |
| | | 50 кН | ш | 3 |
| | | Хүзүүвч, нүхлэгдсэн суурь бүхий CBR-ын хэв | ш | 24 |
| | | CBR диск | ш | 3 |
| | | Филтерийн цаас | хайрц | 100 |
| | | Нэмэлт жин | ш | 10 |
| | | Нүхлэгч нэмэлт жин | ш | 24 |
| | | Хөөлтийн хэмжигч тавиур | ш | 24 |
| | | Хөөлтийн хэмжигчийн суурь | ш | 24 |
| | | Хөөлт хэмжигч | ш | 24 |
| | | Усанд сойх сав | ш | 3 |
| | | CBR таслах хүзүүвч | ш | 3 |
| | | Динамик Конусын Шигдэлтийн багаж | ш | 3 |
| 6. | Талбайн нягт | Элсний сав, нягт үзэх тавиур бүхий 152мм-тэй элсэн конус | ш | 4 |
| | | Нягт, чийгшил тодорхойлох цөмийн хэмжигч | ш | 2 |

| № | Шинжилгээний нэр | Зүйл | Нэгж | Тоо хэмжээ |
|---|---|---|---|---|
| 7. | Шинэ цутгасан ба жбэхсэн бетон | Суултын шинжилгээ хийх багаж, хэрэгслүүд | ш | 9 |
| | | Бетон зуурагч | ш | 3 |
| | | Агаар нэвтрэлтийг хэмжигч | ш | 3 |
| | | Доргиулагч ширээ | ш | 3 |
| | | 150 мм кубик хэв | ш | 120 |
| | | 150х150 мм гулзайлтын хэв | ш | 60 |
| | | Нягтруулалтын хүчин зүйлүүдийг тодорхойлох аппарат | ш | 3 |
| | | Бетоны урсалтыг тодорхойлох багаж | ш | 3 |
| | | Бетон шахах машин (1500 кН) | | |
| | | Бетоны гулзайлтын бат бэх шалгах машин | ш | 2 |
| | | Хөвөгч жин | ш | 13 |
| | | Хусуур | ш | 3 |
| | | Зүлгүүр, тэгшлэгч | ш | 3 |
| | | Хүрз | ш | 3 |
| | | Бетон чигжигч саваа | ш | 6 |
| | | Резинэн алх | ш | 6 |

| № | Шинжилгээний нэр | Зүйл | Нэгж | Тоо хэмжээ |
|---|---|---|---|---|
| 8. | Агрегат болон цементийн хувь тодорхойлох | Нимгэн үзүүрлэгийг хэмжигч багаж | ш | 3 |
| | | Урт хэмжигч | ш | 3 |
| | | Утсан сагс | ш | 3 |
| | | Чулуулгийн элэгдлийг тодорхойлох машин | ш | 3 |
| | | Чулуу бутлалтын үзүүлэлтүүдийг тодорхойлох багаж | ш | 3 |
| | | Ширхэглэлийн нягт ба ус шингээлтийг тодорхойлох жин ба дагалдах хэрэгслүүд | ш | 3 |
| | | Нийт нягтыг хэмжих багаж | ш | 3 |
| | | Нягт тодорхойлох сагс | ш | 3 |
| | | Цементийн хувь тодорхойлох шинжилгээ Т0809-2009 | | |
| | | Титр хоолой (50мл) | ш | 3 |
| | | Титр хавтан | ш | 3 |
| | | Титр хоолойн хавчаар | ш | 3 |
| | | Том гэдэстэй пипетка (10мл) | ш | 10 |
| | | (50мл) | ш | 10 |
| | | Шөвгөн хэлбэртэй шил (200мл) | ш | 20 |
| | | Химийн бодис шатаах стакан (2000мл) | ш | 3 |
| | | (300мл) | ш | 10 |
| | | Уусмалын шил (1000мл) | ш | 3 |
| | | Шаазан стакан (1200мл) | ш | 10 |
| | | Зэвэрдэггүй ган савх | ш | 10 |
| | | Хэмжих бортого (100мл) | ш | 3 |
| | | (50мл) | ш | 6 |
| | | Хүрэн өргөн амсартай шил (60мл) | ш | 2 |
| | | Цахилгаан жин 1500 гр (0.01гр нарийвчлалтай) | ш | 2 |
| | | Секундээр хэмжигч | ш | 2 |
| | | Сорьцын шилэн таваг (9см) | ш | 10 |
| | | Бодисын нухуур (12-13см) | ш | 2 |
| | | Бургуй | ш | 3 |
| | | Илрүүлэгч цаас (pH12-14) | ш | 3 |
| | | Полиэтилений хувин (20л) | ш | 3 |
| | | (5л) | ш | 10 |
| | | Том амсартай хувин | ш | 3 |
| | | Угаах шил (500мл) | | |
| | | Сойз, Угаалгын нунтаг, Усны гуурс, Хуванцар шанага, Тусгай харандаа, Миллиметровка | | |

| № | Шинжилгээний нэр | Зүйл | Нэгж | Тоо хэмжээ |
|---|---|---|---|---|
| 9. | Асфальт | Битумын хэмжээг тодорхойлох нэрэлтийн аппарат | ш | 3 |
| | | Филтерийн цаасан хайрцаг | хайрц | 50 |
| | | 5 литрийн багтаамжтай тавцан дээр суурилуулсан зуурагч | ш | 3 |
| | | Нягтруулагч хэв | ш | 36 |
| | | Нягтруулагч хавтан | ш | 3 |
| | | Нягтруулагч алх | ш | 6 |
| | | Маршалын шинжилгээний аппарат, дагалдах хэрэгслүүд (25 кН хүчин чадалтай) | ш<br>ш | 3 |
| | | Урсалт хэмжигч | ш | 3 |
| | | Вакуум пикнотетр | ш | 3 |
| | | Усны ванн | ш | 3 |
| | | Кинематик вискометр | ш | 3 |
| | | Шингэлсэн битум нэрэх аппарат | ш | 3 |
| | | Цагигаг бөмбөгт аппарат | ш | 3 |
| | | Термометр (0-оос 250 $^0$C) | ш | 6 |
| | | Ердийн шилэн термометр (-10-аас +250 $^0$C) | ш | 9 |
| | | Тоон термометр (-30-аас +200 $^0$C) | ш | 3 |
| | | Цооног өрөмдөгч машин | ш | 3 |
| 10. | Хатаах ба жинлэх | 25,000 гр талбай ба лабораторит хэрэглэх жин ба ком туухай | ш | 3 |
| | | 10,000 гр талбай ба лабораторит хэрэглэх жин ба ком туухай, 2610 гр гурван тавиур бүхий жин ба ком туухай | ш<br>ш | 3<br>3 |
| | | Цахилгаан жин 360 гр (0.0019 нарийвчлалтай) | ш | 3 |
| | | Цахилгаан жин 3000 гр хүчин чадалтай | ш<br>ш | 3<br>3 |
| | | Халуун ширэм | ш | 3 |
| | | Хатаах зуух, 750 л (термостатик хяналттай) | ш | 3 |
| 11. | Бусад нэмэлт хэрэгсэл, багаж, бодисууд | Содын сульфат | кг | 15 |
| | | Хутгах саваа | ш | 6 |
| | | Хатаагч | ш | 3 |
| | | Хэмжигч цилиндр (янз бүрийн хэмжээтэй) | ш | 9 |
| | | Угаах лонх | ш | 3 |
| | | Шилэн аяга ба тагнууд | ш | 3 |
| | | Хэмжээстэй дусаагуур | ш | 3 |
| | | Аяга (янз бүрийн хэмжээтэй) | ш | 9 |
| | | Дээжний тавиур (янз бүрийн хэмжээтэй) | ш | 18 |
| | | Дээж хадагалах сав | ш | 18 |
| | | Хайлдаггүй хавчуур | ш | 3 |
| | | Бат бөх резинэн бээлий | ш | 15 |
| | | Халуунд тэсвэртэй бээлий | хос | 15 |
| | | Цүүц | хос | 3 |
| | | Нониус штангениркуль микрометр | ш | 3 |
| | | Утсан багс | ш | 3 |

| № | Шинжилгээний нэр | Зүйл | Нэгж | Тоо хэмжээ |
|---|---|---|---|---|
| | | Тайрагч хутга | ш | 6 |
| | | Бөх гялгар уут | ш | 300 |
| | | Хуванцар хувин | ш | 9 |
| | | Секундээр хэмжигч | ш | 3 |
| | | Хүрз | ш | 6 |
| | | Агрегатны хүрз | ш | 6 |
| | | Малтуур | ш | 9 |
| | | Жижиг хүрз | ш | 6 |
| | | Угсрагч | ш | 3 |
| | | Алх | ш | 3 |
| | | Юүлүүр | | |
| | | Ердийн шилэн термометр (-30-аас +100 $^0$C) | ш | 9 |
| | | Зээтүү | ш | 9 |
| | | Хатуу үстэй бариултай шүүр | ш | 6 |
| 12 | | Пикнометр (шилэн) | ш | 18 |
| | | Шигшүүр (Ф200мм, Ф28мм, Ф20мм, ф14мм, Ф10мм, Ф6мм, Ф3мм-...) | ком | 3 |
| | | AASHTO T99 нягтруулагч | ш | 3 |
| | | Хэв | ш | 3 |
| | | Алх | ш | 3 |
| | | AASHTO T99 Хэв | ш | 3 |
| | | Алх | ш | 3 |
| | | Шмитт алх | ш | 3 |
| | | Битумын суналт хэмжигч | ш | 3 |
| | | Битумын нэвчилт хэмжигч | ш | 3 |
| | | Битумын хүйтэн тэсвэрлэлтийг хэмжих багаж (Fraass-ийн арга) болон холбогдох химийн бодисын хамт | ш | 3 |
| | | Термометр /+250С/ | ш | 15 |
| | | Хатаагч шүүгээ | ш | 3 |
| | | CBR Force Measurement 10kN, 28kN,50kN | ш | 3 |
| | | 3м-ийн рейк, тэгш хэмжигч багаж | ш | 2 |
| | | Humbolt багаж | ш | 1 |

Үүнээс гадна, Гүйцэтгэгч нь Инженерийн зарим үед шаардаж болох, дээж авахад зориулсан таар, хуванцар юмуу 4 давхар цаасан уут, будаг, багс, тосон давирхай юмуу лабораторийн бусад тоног төхөөрөмж, материалыг талбайн лабораторийн хэрэгцээнд хангана.

Лабораторийн тоног төхөөрөмжүүд нь орчин үеийн загвар дизайнаар бүтээгдсэн, төлөвлөж буй дээж авах, шинжилгээ хийх зэрэг ажлыг зохих хэмжээнд гүйцэтгэхэд шаардагдах хэмжээс, шинж чанар, нарийвчлалтай байна. Лабораторийн тоног төхөөрөмж нь энэ техникийн шаардлагад нэрлэн заасан бүх олон улсын стандартуудын шаардлагад нийцсэн олон улсад нэр хүндтэй үйлдвэрлэгч компанийх байна. Энэ техникийн шаардлагын зүйл 125-ын дагуу хэрэглэхээр төлөвлөж буй лабораторийн бүх тоног төхөөрөмжийн марк, загвар, техникийн шаардлагуудыг үйлдвэрлэгчийн бичиг баримтын хамт Инженерт танилцуулна. Талбайн лабораторит тоног төхөөрөмжүүдийг хангахаас өмнө Гүйцэтгэгч, Инженерээс урьдчилан зөвшөөрөл авна.

Талбайн лабораторыг гүйцэтгэгч ба инженер хамтран ашиглана. Энд

дурдсан лабораторийн тоног төхөөрөмжүүдийн тоо ширхэг нь, чанарын баталгааны системтэй холбогдуулан өөрийн үүрэг хариуцлагаа биелүүлэхийн тулд дээж авах, шинжилгээ хийх зэрэгт Инженерт шаардагдах хамгийн бага хэмжээг төлөөлж байгаа юм. Энэхүү техникийн шаардлагын зүйл 109-ийн дагуу, Төслийн чанарын хяналтын төлөвлөгөөгөө биелүүлэхэд нь шаардагдах бусад нэмэлт тоног төхөөрөмжийг оруулж ирэх шаардлагатай болохыг Гүйцэтгэгчид зөвлөж байна. Ялангуяа, Гүйцэтгэгч, шинжилгээ хийх, дээж авах зэрэгт Инженерийн зүгээс тавих шаардлагыг харгалзан үзэж, ажлын явцад саатал гаргалгүйгээр төслийн чанарын хяналтын төлөвлөгөөг биелүүлэхэд шаардагдах зүйлсийг (дээжний хэв, зуухны хэмжээ, нягт шалгах цөмийн багажны хэрэгцээ гэх мэт ) өөрсдөө сайтар судалж, тооцсон байх шаардлагатай.

iii) Лабораторид байрлуулах стандартууд

Үүнээс гадна, Гүйцэтгэгч энэ техниийн шаардлагын зүйл 111-ийн дагуу, доор дурдсан нийтлэлүүдийн хамгийн сүүлчийн үеийн хэвлэлтийн нэг хувийг талбайн лабораторит байршуулна. Үүнд:

1. ASTM Боть 04,01 - Цемент, Шохой, Гипс,
2. ASTM Боть 04,02 - Бетон ба эрдэс чулуу,
3. ASTM Боть 04,03 - Зам ба хучилтын материал,
4. ASM Боть 04,04 - Дээврийн хучилт, Ус тусгаарлалт, битумэн материал,
5. ASTM Боть 04,08 - Байгалийн барилгын чулуу, Хөрс ба уулын чулуулаг,
6. ASTM STP 599 - лабораторийн шинжилгээнд зориулсан хөрсний дээжийг бэлтгэх,
7. Материалыг тээвэрлэх, дээж авах ба шинжилгээ хийх аргачлалуудын тухай AASHTO стандарт техникийн шаардлагууд Бүлэг 1А & 1Б Техникийн шаардлагууд,
8. Материалыг тээвэрлэх, дээж авах ба шинжилгээ хийх аргачлалуудын тухай AASHTO стандарт техникийн шаардлагууд Бүлэг 2А & 2Б Шинжилгээнүүд,
9. Зам гүүрийн AASHTO стандарт техникийн шаардлагууд,
10. BS 812 Эрдэс чулуу, элс, нарийн ширхэгтэй дүүргэгчийн дээж авах, шинжилгээ хийх аргачлалууд,
11. BS 1882 Бетоныг шинжлэх аргачлалууд,
12. AASHTO T99, R12-85 Маршаллын болон –ийн аргачлалыг ашиглан битумен хольцын орцыг тогтоох
13. MS 2 Асфальтбетоны болон өөр төрлийн халуун хольцын орцыг тогтоох
14. ASTM D242-85 Битумэн хучилтанд хэрэглэх эрдэс AASHTO T37-91 нунтгийн шаардлагууд
15. ASTM D21664-85. Буталсан чулууг битумээр бүрэх ба

T182-84 битумтэй барьцалдах чанарыг тогтоох шинжилгээний арга

## 130 ЗАМЫН ДАГУУ МОД ТАРИХ

Зураг дээр үзүүлсэн юм уу Инженерийн зааварласан газарт замын дагуу Гүйцэтгэгч модны үрслэг тарин, өнгөн хөрсөөр буцаан дүүргэлт хийж, усалж хамгаална.

Тарих модны төрлүүдийг Инженер сонгож зааварлах ба Гүйцэтгэгчийн санал болгосон тарих аргачлалыг хянаж баталгаа. Зурагт зааснаар юм уу Инженерийн зааврын дагуу модны төрлүүдийг хамгаалах ажлыг хийнэ.

## 131 БАЙГАЛЬ ОРЧНЫ ЧАНАРЫН ХЯНАЛТ

Барилгын ажлын үед замын дагуух гол, горхи зэрэг усны эх үүсвэрүүд зарим тохиолдолд хөндөгдөж магадгүй. Баригдаж буй замын дагуу байгаа гол горхийг шаврын хаалт, налуугийн хамгаалалт хийх юм уу бусад зөвшөөрөгдсөн аргыг ашиглан хамгаалалтын арга хэмжээ авах замаар тунадас үүсэхээс хамгаална. Гүйцэтгэгч Инженерийн ба орон нутгийн удирдах байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр тогтоосон гол горхи юм уу, гүний худгуудаас ус олдворлож болно. Гүйцэтгэгч Монгол улсын гадаргын усны чанарын хяналтын стандартын дагуу шаардлагатай арга хэмжээг авах бөгөөд ингэснээр барилгын үйл ажиллагаанаас шалтгаалан усны чанарт өөрчлөлт гарахгүй байх боломжтой.

Асфальтбетон завод, чулуу бутлуур ба буталсан чулуу холих төхөөрөмжүүдийг ажиллуулахдаа байгаль орчны хяналтын талаарх Засгийн газрын хууль тогтоомжийг чанд мөрдөх бөгөөд тэдгээрийг хүн ам суурьшсан газраас дор хаяж 1.0 км-т байршуулна. Тоосжилт үүсэхээс сэргийлж газар шорооны ажил, түр овоолго, түр зам ба хучилтын үе бүрийг тогтмол усална. Агаарын чанар нь орчин тойрны агаарын чанарын тухай Монгол улсын стандартын шаардлагыг хангах ёстой.

Барилгын ажилд хэрэглэгдэж буй бүх тоног төхөөрөмж, үйлдвэр завод, техник, машин унаа нь холбогдох дуу чимээний стандартыг дагаж мөрдөнө. Барилгын ажлын тоног төхөөрөмж нь 90дБ(А)-аас бага дуу чимээ гаргана гэсэн стандартын шаардлагыг хангана. Суурин газраас 150м-ээс ойр зайд явагдаж буй дуу чимээтэй барилгын ажлыг оройны 10.00 цагаас өглөөний 6.00 цагийн хооронд зогсооно. Дуу чимээний төвшинг тогтоосон хязгаарт байлгах үүднээс бүх машин тэрэг, барилгын ажлын техникүүдийг тогтмол хянаж, дуу намсгагчийг хангаж, жолооч, операторууд чихэвч зүүсэн эсэхэд онцгойлон анхаарал тавина.

Байгаль орчны чанар, барилгын ажилчдын эрүүл мэнд, ажлын талбайн нөхцөл байдал, эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал зэргийг дараах байдлаар хянана. Үүнд:

| Бүрэлдэхүүн хэсэг | Үе шат | Зүйл |
|---|---|---|
| Агаар | Барилгын ажлын үе шат | Бохирдлын элементүүд (SPM), CO, NO2, SO2 |
| Ус | Барилгын ажлын үе шат | Физик, хими, биологийн шинж чанар |
| Дуу чимээ | Барилгын ажлын үе шат | Дуу чимээний төвшин |
| Ажилчдын эрүүл мэнд | Барилгын ажлын үе шат | Эрүүл мэндийн үзлэг |
| Ажлын талбайн нөхцөл байдал, эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал | Барилгын ажлын үе шат | Ажлын талбайн нөхцөл байдал/түр лагерийн байдлыг ажиглах |

## 132 ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР

Энэ техникийн шаардлагын зүйл бүлэг 100-ийн шаардлагуудыг биелүүлэхтэй холбогдон гарах зардалд тусад нь ямар нэг хэмжилт, төлбөр хийхгүй бөгөөд Гүйцэтгэгчийг тэдгээрийн бүх зардлыг өөрийн өртөг зардалд шингээсэн гэж тооцно.

# БҮЛЭГ 200 – МАТЕРИАЛ, МАТЕРИАЛЫН ШИНЖИЛГЭЭ

## БҮЛЭГ 200 – МАТЕРИАЛ, МАТЕРИАЛЫН ШИНЖИЛГЭЭ


| | | |
|---|---|---|
| Лавлагааны стандарт, код болон бусад бичиг баримтууд | | 2-3 |
| 201 | БҮЛГИЙН АГУУЛГА | 2-8 |
| 202 | ГҮЙЦЭТГЭГЧИЙН ХИЙХ ШИНЖИЛГЭЭ | 2-8 |
| 203 | МАТЕРИАЛЫГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ СТАНДАРТ | 2-8 |
| 204 | ЕРӨНХИЙ ШААРДЛАГА | 2-9 |
| | (а) Стандартад нийцэх | 2-9 |
| | (б) Шигшүүр | 2-9 |
| 205 | ХӨРС БА ХАЙРГА | 2-9 |
| | (а) Дээж авах, дээж бэлтгэх | 2-9 |
| | (б) Шинжилгээний стандарт аргууд | 2-9 |
| 206 | ЧУЛУУ, ЧУЛУУН МАТЕРИАЛ, ЭЛС БА ДҮҮРГЭГЧ | 2-10 |
| | (а) Дээж авах, дээж бэлтгэх | 2-10 |
| | (б) Шинжилгээний стандарт аргууд | 2-10 |
| 207 | ПОРТЛАНД ЦЕМЕНТ | 2-12 |
| 208 | БЕТОН | 2-12 |
| 209 | БИТУМЭН БАРЬЦАЛДУУЛАГЧ | 2-13 |
| | (i) Өтгөн битумын шинжилгээ | 2-13 |
| | (ii) Шингэн битумын шинжилгээ | 2-13 |
| | (а) Хучилтын доод үед тавигдах шаардлагууд | 2-14 |
| | (i) Ерөнхий зүйл | 2-14 |
| | (ii) Өтгөн битум | 2-14 |
| | (iii) Шингэн битум | 2-15 |
| 210 | БИТУМЭН ХОЛЬЦ | 2-15 |
| | (а) Дээж, дээж авалт | 2-15 |
| | (б) Шинжилгээний стандарт аргууд | 2-15 |
| 211 | АРМАТУР | 2-16 |
| 212 | БЕТОН ХООЛОЙ | 2-16 |
| 213 | ЗАМЫН ТЭМДГҮҮД | 2-16 |
| | (а) Замын тэмдгийн будаг | 2-16 |
| | (б) Бусад будгууд | 2-16 |
| 214 | ЗАМЫН ТЭМДЭГЛЭГЭЭ | 2-17 |
| 215 | ЗАМЫН ТЭМДЭГТ ХЭРЭГЛЭХ ГЭРЭЛ ОЙЛГОГЧ МАТЕРИАЛУУД | 2-17 |
| 216 | ЗАМЫН ТЭМДЭГТ ХЭРЭГЛЭХ ӨНГӨ | 2-17 |
| 217 | ЗАМЫН ХАШИЛТ | 2-18 |
| 218 | ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН АШИГЛАЛТ, БАРИЛГЫН АРГАЧЛАЛ, ТЕХНИКИЙН ШААРДЛАГЫГ БАТАЛГААЖУУЛАХ ТУРШИЛТУУД | 2-18 |
| | (а) Лабораторийн туршилтууд | 2-19 |
| | (б) Талбайн туршилтууд | 2-19 |
| 219 | ГАЗАР ШОРООНЫ АЖИЛ, ХУЧИЛТЫН ҮЕҮД БОЛОН УС ЗАЙЛУУЛАХ БАЙГУУЛАМЖ, ХИЙЦҮҮДИЙГ ДАРАХ АЖИЛД БАРИЛГЫН ХЯНАЛТЫН ТУРШИЛТ ХИЙХ | 2-19 |
| 220 | ТУРШИЛТЫН ДАВТАМЖ | 2-20 |
| | (а) Нягтрал шалгах цөмийн багажны тохируулга хийх | 2-20 |
| | (б) Туршилтын давтамжийн шаардлагууд | 2-20 |
| | (i) Ул хөрс | 2-24 |
| | (ii) Газар шорооны ажил | 2-24 |
| | (iii) Хоолой ба хийцийг буцааж дарах, дүүргэх болон ухмал гадаргуу | 2-24 |
| | (iv) Хайрган хөвөө ба хайрган гадаргуу | 2-24 |
| | (v) Суурийн доод үе | 2-25 |
| | (vi) Буталсан чулуун суурь | 2-25 |
| | (vii) Битумэн хучилтын ажлууд | 2-25 |
| 221 | ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР | 2-26 |

**Ашигласан стандарт, норм, бусад хэвлэлүүдийн жагсаалт**

Дор дурдсан стандартууд, норм болон бусад материалуудад хамгийн сүүлд оруулсан өөрчлөлт, шинэчилсэн хэвлэлүүд нь техникийн шаардлагын энэхүү хэсэгт дурдагдах ба эдгээртэй холбоотойгоор ашиглагдана. Үүнд:

| | |
|---|---|
| AASHTO-04 | Материалын тээвэрлэлт, материалаас дээж авах, шинжлэх аргуудад тавих стандартын шаардлагууд, Техникийн шаардлагууд, 1А ба 1В Хэсэг |
| AASHTO-04 | Материалын тээвэрлэлт, материалаас дээж авах, шинжлэх аргуудад тавих стандартын шаардлагууд, Техникийн шаардлагууд, 2А ба 2В Хэсэг, Шинжилгээнүүд |
| AASHTO-04 | Автозамын гүүрийн стандарт шаардлагууд |
| AASHTO M6-03 | Портланд цемент бетонд хэрэглэх жижиг чулуун материал |
| AASHTO M31M-03 | Төмөр бетонд хэрэглэх иржгэр болон гөлгөр арматур |
| AASHTO M33-99 (2003) | Бетонд (битум хэлбэрийн) хэрэглэх урьдчилан хэлбэржүүлсэн заадсыг бөглөх материал |
| AASHTO M43-88 (2003) | Зам, гүүрийн барилгад хэрэглэх чулуун материалын хэмжээнүүд |
| AASHTO M80-87 (2003) | Портланд цемент бетонд хэрэглэх том чулуун материал |
| AASHTO M81-92 (2002) | Шингэн асфальт (түргэн өтгөрдөг хэлбэр) |
| AASHTO M82-75 (2000) | Шингэн асфальт (дунд зэрэг өтгөрдөг хэлбэр) |
| AASHTO M85-04 | Портланд цемент |
| AASHTO M111-04 | Төмөр ба ган хийцүүдийг цайраар бүрэх |
| AASHTO M133-04 | Модон материалд зориулсан хамгаалах хэрэгсэл ба даралтаар боловсруулах процесс |
| AASHTO M140-03 | Эмульсжүүлсэн асфальт |
| AASHTO M145-91 (2000) | Автозамын барилгын зорилгоор хөрс ба хөрс-чулуун материалын хольцыг ангилах |
| AASHTO M148-01 | Бетон арчлахад зориулсан мембран үүсгэгч шингэн бүрэлдэхүүн |
| AASHTO M153-98 (2002) | Бетон хучилт болон хийц барихад зориулсан урьдчилан хэлбэржүүлсэн сархиат резинэн болон заадсыг бөглөх материал |
| AASHTO M154-00 | Бетонд агаар оруулагч материал |
| AASHTO M156-97 (2001) | Халуун битумэн хучилтын холимог бэлдэх холих төхөөрөмжид тавих шаардлагууд |
| AASHTO M157-97 (2001) | Бэлэн (таваарын) бетон |
| AASHTO M160-04 | Хийцэд хэрэглэх ган, хавтан төмөр, шпунтэн хана, арматурын саваа зэргийн ерөнхий шаардлагууд |
| AASHTO M168-96 (2003) | Модон бүтээгдэхүүнүүд |
| AASHTO M170M-04 | Арматуртай хоолой, ус зайлуулах шуудуу ба ариутгах татуургын хоолой (метрээр) |
| AASHTO M171-00 | Бетон арчлах ялтас материал |
| AASHTO M180-00 | Замын хашлагийн долгионт ган гулдан |
| AASHTO M194-00 | Бетонд хэрэглэх химийн хольцууд |

| | |
|---|---|
| AASHTO M208-01 | Катионы эмульсжүүлсэн асфальт |
| AASHTO M213-01 | Бетон хучилт ба хийц байгууламжид зориулсан урьдчилан хэлбэржүүлсэн заадсыг бөглөх материал (шахаагүй болон уян харимхай битумын хэлбэр) |
| AASHTO M221M-03 | Төмөр бетон арматурын ган гагнаас бүхий нугалсан утас |
| AASHTO M225M-03 | Төмөр бетон арматурын ган, нугалсан утас |
| AASHTO M226-80 (2000) | Наалданги чанартай асфальтан барьцалдуулагч |
| AASHTO M240-04 | Хольсон шингэн цемент |
| AASHTO M241-97 (2001) | Бүрдүүлэгч хэсгийн эзлэхүүнээр хольцыг тунлах, тасралтгүй холих аргаар хийсэн бетон |
| AASHTO M247-02 | Замын тэмдэглэгээнд ашиглах шилэн дэвсгэр |
| AASHTO M249-98 (2003) | Цагаан ба шар өнгийн гэрэл ойлгогч термопластик материал /хатуу хэлбэртэй/ |
| AASHTO M251-04 | Хавтгай болон үелсэн резинэн тулах хэсэг |
| AASHTO M268-03 | Замын хөдөлгөөний хяналтын гэрэл ойлгогч гадаргуу |
| AASHTO M270-04 | Нүүрстөрөгчийн ба өндөр хатуулагтай хийцийн ган профиль, хавтан, саваа, гүүрэнд хэрэглэх хатаасан хийцийн ган хавтан |
| AASHTO M280-03 | Цайрдсан ган үзүүртэй утас |
| AASHTO M295-00 | Бетонд минерал хольц болгож хэрэглэх нүүрсний үнс, түүхий болон шатаасан байгалийн пуццолан |
| AASHTO M297-98 (2002) | Гүүрэнд хэрэглэх урьдчилан хэлбэржүүлсэн полихлорпрен заадас битүүлэх материал |
| AASHTO M300-03 | Органик бус цайраар баялаг барьцалдуулагч материал |
| AASHTO M302-00 | Бетон болон зуурмагт ашиглах шатаах зуухны шаарга |
| AASHTO R5-03 | Эмульсжүүлсэн асфальтыг сонгох ашиглах |
| AASHTO T2-91 (2000) | Чулуунаас дээж авах |
| AASHTO T11-97 (2000) | 75 мм-ийн шигшүүрээр гарсан, эрдэс чулууны ширхгүүдийг угааж турших |
| AASHTO T21-00 | Бетонд ашиглах жижиг чулууны органик хольц |
| AASHTO T24-04 | Бетоны өрөмдсөн цилиндрэн дээж болон хөрөөдсөн жижиг хэсгийг турших |
| AASHTO T26-79 (2000) | Бетонд хэрэглэх усны чанар |
| AASHTO T27-99 | Жижиг болон том ширхэгтэй чулууг шигшүүрээр турших |
| AASHTO T30-93 (2003) | Ялгасан чулууны механик шинжилгээ |
| AASHTO T40-02 | Битумэн материалаас дээж авах |
| AASHTO T44-03 | Битумэн материалын уусах чанар |
| AASHTO T48-04 | Кливленд аягаар дөл авалцах, шатах хэмийг тодорхойлох |
| AASHTO T49-03 | Битумыг зүү шигдэлтээр тодорхойлох |
| AASHTO T51-00 | Битумын суналт |
| AASHTO T53-96 (2000) | Битумын уярах хэмийг тодорхойлох /цагираг ба бөмбөлгийн аппарат/ |

| | |
|---|---|
| AASHTO T55-02 | Нефть бүтээгдэхүүн ба битум дэх усны агуулгыг ширгээх аргаар тодорхойлох |
| AASHTO T71-93 (2001) | Жижиг ширхэгтэй чулуун дахь органик хольцуудын зуурмагийн бэхжилтэд нөлөөлөх нөлөө |
| AASHTO T78-96 (2000) | Шингэрүүлсэн асфальт бүтээгдэхүүнийг ширгээх |
| AASHTO T84-00 | Жижиг ширхэгтэй чулууны хувийн жин ба шингээх чадвар |
| AASHTO T85-91 (2000) | Том ширхэгтэй чулууны хувийн жин ба шингээх чадвар |
| AASHTO T87-86 (2000) | Эвдэрсэн бүтэцтэй хөрс, хөрсний чулуулгийн дээж хуурайгаар бэлтгэх, шинжлэх |
| AASHTO T88-00 | Хөрсний ширхэглэлийг шинжлэх |
| AASHTO T89-02 | Хөрсний урсамтгайн хязгаарыг тодорхойлох |
| AASHTO T90-00 | Хөрсний уян налархайн хязгаар ба уян налархайн индексийг тодорхойлох |
| AASHTO T96-02 | Жижиг чулууг Лос Анжелес машин дээр үрэлт цохилтоор турших |
| AASHTO T100-03 | Хөрсний хувийн жин |
| AASHTO T102-83 (2000) | Асфальт материалыг цэгийн /дуслын/ аргаар турших |
| AASHTO T104-99 (2003) | Чулууны бат бэхийг натрийн сульфат ба магнийн сульфат ашиглан тодорхойлох |
| AASHTO T106-04 | Шингэн цементийн зуурмагийн шахалтын бат бэхийг тодорхойлох |
| AASHTO T119-99 | Шингэн цемент бетоны суулт |
| AASHTO T121-97 (2001) | 1 куб фут /эсвэл куб метр/-т ноогдох жин, гарц, агаарын агуулгыг тодорхойлох |
| AASHTO T127-04 | Шингэн цементийн дээж авах, шинжилгээний хэмжээ |
| AASHTO T137-04 | Шингэн цементийн зуурмагийн агаарын хувь |
| AASHTO T141-01 | Шинээр зуурсан бетоноос дээж авах |
| AASHTO T146-96 (2000) | Эвдэрсэн бүтэцтэй хөрсний дээжийг нойтон аргаар бэлдэх |
| AASHTO T152-01 | Шинээр хольсон бетоныг агаарын хувийг даралтын аргаар тодорхойлох |
| AASHTO T157-00 | Бетоны агаар оруулах нэмэлт бодисууд |
| AASHTO T158-01 | Бетоны урсалт |
| AASHTO T160-97 (2001) | Хатуурсан, шингэн цемент зуурмаг ба бетоны уртыг өөрчлөх |
| AASHTO T161-00 | Бетоны хүйтнийг тэсвэрлэх чадварыг хөлдөөж гэсгээх аргаар тодорхойлох |
| AASHTO T162-04 | Шингэн цементийн зуурмаг болон уян консистенц бүхий шохойг механикаар холих |
| AASHTO T164-01 | Битумэн хучилтын холимгоос битумыг ялгаж авах |
| AASHTO T166-00 | Нягтруулсан асфальтбетон хольцын эзлэхүүний хувийн жинг хуурай гадаргатай ханасан дээж ашиглан тодорхойлох |
| AASHTO T168-03 | Асфальт бетон хольцыг дээжлэх |
| AASHTO T176-02 | Ангилсан чулуу болон хөрсний уян налархайн ширхэглэлийг элсний эквивалент шинжилгээний аргыг ашиглан тодорхойлох |

| | |
|---|---|
| AASHTO T179-04 | Асфальт материалд халуун ба агаарын үзүүлэх нөлөөлөх |
| AASHTO T180-01 | Хөрсний чийг нягтшилын харьцааг 4.54 кг алхыг 457 мм-ийн өндрөөс унагах аргыг ашиглан тодорхойлох |
| AASHTO T188-75 (1999) | Портланд цементэд агаар оруулах нэмэлт бодисуудыг хөлдөөх ба гэсгээх аргаар үнэлэх |
| AASHTO T191-02 | Хөрсний нягтыг газар дээр нь элсэн конусын аргаар тодорхойлох |
| AASHTO T193-99 (2003) | Хөрсний даацын үзүүлэлт (CBR) |
| AASHTO T196-96 | Бетон хольцын агаарын агуулгыг эзлэхүүний аргаар тодорхойлох |
| AASHTO T197-00 | Бетон хольцын хатууралтын хугацааг зүү шигдэлтийн аргаар тодорхойлох |
| AASHTO T201-03 | Асфальтын кинематик зууралдалтыг тогтоох |
| AASHTO T202-03 | Асфальтын зууралдах чанарыг вакуум капилляр вискозиметрээр тодорхойлох |
| AASHTO T209-99 (2004) | Асфальтан хольцын хамгийн их хувийн жин |
| AASHTO T218-86 (2000) | Усжуулсан шохойноос дээж авах |
| AASHTO T228-04 | Хагас хатуу битумэн материалын хувийн жин |
| AASHTO T230-68 (2000) | Битум-чулууны хольцон хучилтын нягтын зэргийг тодорхойлох |
| AASHTO T245-97 (2001) | Асфальт бетон хольцын урсалтыг эсэргүүцэх чанарыг Маршалын аппаратаар тодорхойлох |
| AASHTO T265-93 (2000) | Хөрсний чийгийн агуулгыг лабораторид тодорхойлох |
| AASHTO T269-97 (2003) | Нягтруулсан ба нягтруулаагүй асфальт бетон хольц дахь агаарын сүвшилийн эзлэх хувь |
| AASHTO T310-03 | Хөрс ба Хөрс-чулууны газар дээрх нягт ба чийгийн агуулгыг цөмийн аргаар тодорхойлох |
| ASTM C 29-97 | Чулуун материалын нэгж жин ба сүвшил |
| ASTM C 227-97 | Цемент-чулууны нэгдлийн шүлтний потенциал урвалжих чанарыг тодорхойлох |
| ASTM C 289-02 | Чулуун материалын потенциал урвалжих чанарыг химийн аргаар тодорхойлох |
| ASTM D 243-02 | Тодорхойлсон зүү шигдэлтийн үлдэгдэл |
| ASTM Боть 04.01 | Цемент шохойн гипс |
| ASTM Боть 04.02 | Бетон ба эрдэс чулуу |
| ASTM Боть 04.03 | Замын болон хучилтын материалууд |
| ASTM Боть 04.04 | Дээврийн, ус нэвтрүүлдэггүй болон битумэн материалууд |
| ASTM Боть 04.05 | Байгалийн гаралтай, барилгын чулуу, хөрс, чулуулаг |
| BS 381 | Таних, кодлох ба бусад зориулалтын өнгүүд |
| BS 812 | Чулуулгын бутралтын индекс |
| BS 812 | Суналтын индекс |
| BS 812 | Чулуулгын бутралтын индекс |
| BS 812 | Жижиг чулуулгийн хлоридын агуулга |

| | |
|---|---|
| BS 873 | Замын тэмдгүүд, гэрэлтэгч тумбүүд |
| BS 1088 | Тэнгисийн хөлөгт зориулсан фанер |
| BS 1377, 14 Шинжилгээ | Нягт-чийгийн агуулгын харьцаа, доргиут алх |
| BS 1707 | Замын гадаргууг боловсруулахад зориулсан халуун барьцалдуулагч материал тараагчийн техникийн шаардлага |
| BS 1881 хэсэг 1 | Шинэ бетоноос дээж авах арга |
| BS 1881 хэсэг 2 | Шинэ бетоныг шинжлэх арга |
| BS 1881 хэсэг 3 | Шинжилгээний дээжийг бэлтгэх, хатаах аргууд |
| BS 1881 хэсэг 4 | Бетоны бат бэхийг турших аргууд |
| BS 4449 | Төмөрбетон арматурт ашиглах хүчитгэсэн ган саваанууд |
| BS 4450 | Цементийн бат бэх |
| BS 4482 | Бетон арматурт ашиглах төмөр утас |
| BS 4483 | Бетоны арматурт ашиглах ган деталь |
| BS 5607 | Тэсрэх бодис ашиглах британий стандарт норм |
| ACI 318 | Төмөр бетонд зориулсан барилгын нормын шаардлага |
| ACI 347 | бетоны хэв хашмалын санал болгосон үйл ажиллагаа |
| NIST PSI | В-В ангиллын гадна фанерын бүтээгдэхүүний стандарт |
| AWS D1.4 | Арматурт зориулсан хийцийн гагнуурын стандарт |
| DIN 51011 | Хатуу ба шингэн битумын хугарлын хэмийг тодорхойлох шинжилгээний стандарт аргууд |

## 201 БҮЛГИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

Энэ бүлэгт материалын сонголт болон чанар, ажлын арга технологи, барилгын ажлын хяналтад хэрэглэгдэх туршилт, шинжилгээнүүд болон тэдгээрийн аргуудыг багтаасан.

## 202 ГҮЙЦЭТГЭГЧИЙН ХИЙХ ШИНЖИЛГЭЭ

Гүйцэтгэгч нь барилгын ажлыг гүйцэтгэх нийт хугацааны туршид, гэрээний дагуу нийт ажлын гүйцэтгэлийн гэрчилгээг олгох хүртэл талбайн лабораториудыг байгуулж, ашиглаж, ажиллах нөхцлийг нь хангаж байх ёстой. Талбайн лабораториуд нь инженерийн бүрэн удирдлага, хяналтын дор ажиллах ба инженер болон гүйцэтгэгч эсвэл хоёулаа хамтран, гэрээт ажилтай холбоотой шинжилгээг гүйцэтгэгчийн хангасан лабораторийн ажилтнуудыг оролцуулан шинжилгээний бүх нөөцийг ашиглан явуулахад ашиглагдана.

Гүйцэтгэгч нь энэхүү шаардлагуудын 109 зүйлийн дагуу болон гүйцэтгэгчийн ажлын чанарын хяналтын төлөвлөгөөний дагуу материалын сонголт, чанарын хяналт болон мэргэжлийн ур чадварын хяналтад шаардлагатай дээж бэлтгэх болон шинжилгээ хийх чадвар бүхий ажилтнууд (талбайн лаборатори бүрт дор хаяж 1 лабораторийн инженер, 2 техникч болон 4 туслах ажилтан) болон хангалттай тоног төхөөрөмжөөр хангах ёстой. Гүйцэтгэгчийн барилгын хяналтын шинжилгээний давтамж нь түүний төслийн чанарын хяналтын төлөвлөгөөний дагуу байх ёстой ба инженертэй өөрөөр зөвшилцөөгүй бол энэхүү шаардлагын 220 зүйлд заасан удирдамжаас багагүй байна. Гүйцэтгэгч нь ажилд хэрэглэх бүх материал болон хийгдсэн бүх ажилд туршилт шинжилгээг гүйцэтгэнэ.

Гүйцэтгэгч нь шаардлагатай бүх шинжилгээг хийж, материал болон хийгдсэн ажлыг инженерт батлуулахаар өгөхийн өмнө эдгээр шинжилгээний үр дүнгийн нэг хувийг инженерт өгнө. Боломжтой нөхцөлд болон энэхүү шаардлагад тусгагдсан бол материалын шинжилгээг үйлдвэрлэсэн газарт нь явуулж болох бөгөөд энэ тохиолдолд гүйцэтгэгч нь үйлдвэрлэгчийн шинжилгээний өгөгдлүүдийг оригинал хэлбэрээр нь өгөх ёстой. Хэрвээ инженер үйлдвэрлэгчийн гаргаж өгсөн шинжилгээний өгөгдлүүдийг зөрчилтэй буюу эсвэл найдваргүй гэж үзвэл гүйцэтгэгч нь инженерийн зааварчилсан болон баталсны дагуу шаардлагатай шинжилгээг явуулахад тохиромжтой байдлаар сайтар төхөөрөмжилсөн хараат бус шинжилгээний лабораторид эдгээр материалын шинжилгээг гүйцэтгэнэ. Шинжилгээний өгөгдлүүдийг нь инженер батлаагүй үйлдвэрийн материалуудыг ажлын талбай дээр татан авчрах ёсгүй.

Инженер нь гүйцэтгэгчийн дээжлэх ажиллагаа, шинжилгээний байр байгууламж, тоног төхөөрөмж, лабораторийн ажилтнуудын үйл ажиллагаа болон шинжилгээний үр дүнгийн бүртгэл зэргийг ямар ч үед чөлөөтэй хянаж шалгах эрхтэй.

Инженер нь бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн газарт нь хийх шинжилгээг оролцуулан, төслийн чанарын хяналтын төлөвлөгөөний нэг хэсгийг бүрдүүлж байгаа, эсвэл түүн дээр нэмэгдсэн, гүйцэтгэгчийн лабораторийн ажилтнуудын явуулах бүх шинжилгээг гэрчилж, зааварчилгаа өгөх эрхтэй.

## 203 МАТЕРИАЛЫГ БАТАЛГААЖУУЛАХ СТАНДАРТУУД

Барилгын ажилд ашиглах бүх материал нь энэхүү шаардлагуудад нийцэх ёстой ба инженерийн шаардлагыг хангаж байх ёстой. Хэрвээ энэ тухай заагдсан байвал, материал нь энэхүү шаардлагын зүйл 111-ийн дагуу нэрлэгдсэн стандарт шаардлага болон альтернатив стандарт шаардлагад нийцэж байх ёстой. Хэрвээ материал нь үйлдвэрлэгчийн худалдааны нэрээр тодорхойлогдсон бол өөр үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүнийг ашиглаж болох ба гэхдээ өөр үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүн нь чанарын хувьд нэрлэсэн бүтээгдэхүүнтэй ижил буюу илүү гэдгийг гүйцэтгэгч баталж, инженер зөвшөөрсөн тохиолдолд хүлээн зөвшөөрөх ба инженер урьдчилан зөвшөөрөл өгнө. Ажилд ашиглахаар төлөвлөсөн бүх материалын дээжийг инженерт өгөх ба төслийн чанарын хяналтын төлөвлөгөөнд тусгагдсан ба өөрөөр зааварчилсан бол шинжилж, материалыг талбайд нийтэд нь татан авчрахаас өмнө шинжилгээний дүнг инженерээр баталгаажуулахаар өгнө. Хэрвээ энэхүү шаардлагын дагуу зарим материалыг гаднын хараат бус лабораторид шинжлэх шаардлагатай бол гүйцэтгэгч нь үүнээс гарах бүх

зардлыг хариуцах ба зардалд дараах зүйлүүд багтана /гэвч эдгээрээр хязгаарлагдахгүй/. Үүнд:

- Лабораторийн шинжилгээний хөлс
- Дээжээр хангах
- Дээжийг талбайгаас лаборатори руу, шаардлагатай бол буцааж талбай руу тээвэрлэх
- Лабораторийн ажилтнуудын хөлс

Хараат бус лабораторид хийгдэх шинжилгээний төлөвлөгөөг инженерт нэг долоо хоногийн өмнө мэдээлэх ба тэрээр шинжилгээ хийх цагт, газар дээр нь байлцах эрхтэй.

**204 ЕРӨНХИЙ ШААРДЛАГУУД**

(а) Шинжилгээний стандарт шаардлагууд ба аргууд

Инженер өөрөөр зааварчлаагүй буюу энэ шаардлагуудад заагдаагүй бол ажилд хэрэглэх бүх материал нь AASHTO-гийн баталсан "Тээвэрлэлт, материал, дээжлэх ба шинжилгээний аргуудын стандарт шаардлагууд"-ад /1A ба 1B Хэсэг, 2002 он, 22-р хэвлэл/ нийцэж байх ёстой. Ажилд хэрэглэх материалын дээжлэлт ба шинжилгээний аргууд нь дээр дурдсан AASHTO-гийн хэвлэлийн 2A ба 2B-ийн /шинжилгээ/ дагуу байх ёстой.

Энэ шаардлагын дагуу хийгдэх ёстой боловч AASHTO-гийн шинжилгээний аргуудад хамрагдаагүй буюу энэ шаардлагад өөрөөр заагдаагүй шинжилгээний хувьд Британий стандарт шаардлагуудын /эсвэл инженерийн заасан буюу зөвшөөрсөн бусад олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ижил төстэй шаардлагууд/ заалт хэрэглэгдэнэ.

(б) Шигшүүр

Бүх шинжилгээнд ASTM E11 шигшүүрүүд ашиглагдана. мм болон μм-ээр (микрон) өгсөн шигшүүрийн цувралыг дор үзүүлэв.

Том 100, 75, 63, 50, 37.5, 25.0, 19.0, 16.0, 13.2, 12.5, 9.5, 6.3, 4.75, 4.00 мм

Жижиг 2.80, 2.36, 2.00, 1.70, 1.40, 1.18, 1.00 мм, 850, 600, 500, 425, 355, 300, 250, 212, 180, 150, 125, 75, 63 μм

**205 ХӨРС БА ХАЙРГА**

(а) Дээж авах ба дээж бэлтгэх

Хөрс ба хайрганы дээж авалт, тэдгээрийн дээж бэлтгэлийг дор дурдсан шаардлагын дагуу явуулна.

(i) AASHTO T87-86 (2000) - Эвдэрсэн бүтэцтэй хөрс, хөрсний чулуулгийн дээжийг хуурайгаар бэлтгэх, шинжлэх

(ii) AASHTO T146-96 (2000) - Эвдэрсэн бүтэцтэй хөрсний дээжийг нойтон аргаар эсвэл инженерийн зааврын дагуу бэлдэх

(б) Шинжилгээний стандарт аргууд

Хөрс ба хайрганы шинжилгээг хүснэгт 2-1-д өгсөн стандарт аргуудын дагуу гүйцэтгэнэ.

4.54 кг-ийн алхыг 457 мм-ийн өндрөөс унагах аргыг ашиглан хөрсний нягт-чийгийн харьцааг тодорхойлох AASHTO T180-ийн стандарт аргын дагуу хийгдэх лабораторийн нягтын шинжилгээг "AASHTO T180" гэж тодорхойлно. Энэ шаардлагын текстэд ,,MDD (AASHTO T180)(Хамгийн их хуурай нягтрал-ХИХН)-ийн х%,, гэсэн нэр томьёо байвал энэ нь нягтруулсан материалын хуурай нягтрал нь AASHTO T180-ийн нягтралын шинжилгээнээс тодорхойлогдсон хамгийн их хуурай нягтралын х% байвал нягтшилын стандартад хүрсэн болохыг тодорхойлно.

**ХҮСНЭГТ 2-1: Хөрс ба хайрганы шинжилгээний аргууд**

| Үзүүлэлтүүд | Шинжилгээний аргууд |
|---|---|
| Хөрсний ширхэглэлийн бүрэлдэхүүнийг тодорхойлох | AASHTO T88-00 |
| Хөрсний урсалтын хязгаарыг тодорхойлох | AASHTO T89-02 |
| Хөрсний уян налархайн хязгаар ба уян налархайн индекс | AASHTO T90-00 |
| Хөрсний хувийн жин | AASHTO T100-03 |
| Ангилсан чулуу ба хөрсөн дэх уян жижиг хэсгүүдийг элсний эквивалент шинжилгээгээр тодорхойлох | AASHTO T176-02 |
| Хөрсний чийгшил нягтшилын харьцааг 2.5 кг алхыг 457 мм-ийн өндрөөс унагах аргыг ашиглан тодорхойлох | AASHTO T18001 |
| Хөрсний нягтшилыг газар дээр нь элсэн конусын аргаар тодорхойлох | AASHTO T19102 |
| Хөрсний даацын үзүүлэлт (CBR) | AASHTO T193-99 (2003) |
| Хөрс, хайрга ба дайрганы нягтшилыг газар дээр нь цөмийн аргаар тодорхойлох | AASHTO T238/239 |
| Хөрс, хайрга ба дайрганы чийгийн агуулгыг газар дээр нь цөмийн аргаар тодорхойлох | AASHTO T239 |
| Хөрсний чийгийн агуулгыг лабораторид тодорхойлох | AASHTO T265-93 (2000) |
| Чийгшил-нягтшилын харьцааг доргиулагч алхаар тодорхойлох | BS 1377 Test 14 |
| Чийгийн агуулгыг тодорхойлох (лабораторид) | AASHTO T265-93 (2000) |
| Чийгийн агуулгыг тодорхойлох (талбайд) | AASHTO T217-02 |

Хэрвээ инженерийн үзэж байгаагаар гүйцэтгэгчийн санал болгосон нягтруулалтын ажиллагааны үр дүнд материалын шинж чанар нягтруулалтын явцад өөрчлөгдөхгүй бол AASHTO T180-ийн нягтруулалтын шинжилгээнд зориулсан дээжүүдийг зохих үеийн нягтруулалтын өмнө авах ёстой бөгөөд хэрвээ материалын шинж чанар нягтруулалтын явцад өөрчлөгдөж байвал шинжилгээнд зориулсан дээжийг бүх нягтруулалт дуусаны дараа авах ёстой.

Нягтруулалтын явцад бутрах магадлалтай материалд хийх нягтшилын шинжилгээнд тусдаа шинэ дээж шаардлагатай ба энэ дээжийг чийг/нягтын муруй дээрх цэг тус бүрийг тодорхойлох зорилгоор бэлтгэнэ.

Ажилд ашигласан хөрс болон зохист ширхэглэлийн бүрэлдэхүүнтэй материалын талбайн нягтрал ба чийгийн агуулгыг, хэрвээ инженерийн саналаар эдгээр нь хэрэглэх боломжтой, тохиромжтой байвал, ихэвчлэн AASHTO T310-ийн дагуу цөмийн аргуудыг ашиглан тодорхойлно. Хөрсний нягтралыг газар дээр нь элсэн конусын аргаар шинжлэх стандарт арга, AASHTO T191 нь нягтын цөмийн шинжилгээний тоног төхөөрөмжийн анхны тохируулгыг хийх, инженерийн зааврын дагуу ажлын явцад шалгалт/харьцуулалтын шинжилгээг явуулахад ашигладаг.

Доргиурт алх ашиглан явуулах лабораторийн нягтралын шинжилгээ BS 1377 шинжилгээ 14-ийг буталсан чулуун материал, жижиг ширхэггүй хайрган материал, AASHTO T180-ийн шинжилгээний дагуу нягтруулалт хийх явцад ерөнхийдөө бутарч болзошгүй зохист ширхэглэлийн бүрэлдэхүүнтэй материалд зориулсан AASHTO T180-ийн нягтруулалтын шинжилгээний альтернатив байдлаар, инженерийн зааврын дагуу ашиглаж болно. Энд тодорхойлсны дагуу хамгийн их хуурай нягтралыг зохих шинжилгээний аргаас гарган авч болно. Энэ шаардлагад AASHTO T180-г шинжилгээний

арга буюу шинжилгээний шалгуур гэж дурдсан тохиолдолд BS 1377 шинжилгээ 14-ийг хувилбар болгон оруулах ёстой.

## 206 ЧУЛУУ, ЧУЛУУН МАТЕРИАЛ, ЭЛС БА ДҮҮРГЭГЧ

(а) Дээж авах ба дээж бэлтгэх

Дээж авалт ба дээж бэлдэлтийг AASHTO T2 /Чулуун материалын дээж авалт/-ийн дагуу гүйцэтгэнэ.

(б) Шинжилгээний стандарт аргууд

Чулуу, чулуун материал, элс ба дүүргэгчийн шинжилгээнүүдийг хүснэгт 2-2-т өгсөн шинжилгээний стандарт аргуудын дагуу явуулна.

**Хүснэгт 2-2: Чулуу, хайрга, элс, дүүргэгч материалын шинжилгээний аргууд**

| Үзүүлэлтүүд | Шинжилгээний аргууд |
|---|---|
| Хайрган дахь нэгж жин ба сүвшилийг тодорхойлох | AASHTO T19M-00 |
| Хайрганы потенциал урвалжилт (Химийн арга) | ASTM C289-02 |
| Эрдэс материал дахь 75 мкм-ээс бага ширхэглэлтэй хэсгийг угаах аргаар шинжлэх | AASHTO T11-97 (2000) |
| Жижиг ширхэглэлтэй хайрга дахь органик хольц | AASHTO T21-00 |
| Жижиг болон том ширхэглэлтэй хайрганы ширхэглэлийн бүрэлдэхүүнийг тодорхойлох | AASHTO T27-99 |
| Жижиг ширхэглэлтэй хайрганы хувийн жин ба ус шингээлтийг тодорхойлох | AASHTO T84-00 |
| Том ширхэглэлтэй хайрганы хувийн жин ба ус шингээлтийг тодорхойлох | AASHTO T85-91 (2000) |
| Бага хэмжээний том ширхэглэлтэй хайрганы элэгдэл тэсвэрлэх чанарыг Лос Анжелес машинаар тодорхойлох | AASHTO T96-02 |
| Хүхэр хүчлийн натри эсвэл хүхэр хүчлийн магни ашиглаж хайрганы бат бэхийг тодорхойлох | AASHTO T104-99 (2003) |
| Хайрганы үелэлтийн индексийг тодорхойлох | BS 812 |
| Суналтын индексийг тодорхойлох | BS 812 |
| Хайрганы бутралтын хэмжээг тодорхойлох | BS 812 |
| Жижиг ширхэгтэй хайрганы хлоридын агуулгыг тодорхойлох | BS 812 |
| Чийгийн агуулгыг тодорхойлох (лабораторид) | AASHTO T265-93 (2000) |
| Чийгийн агуулгыг тодорхойлох (талбайд) | AASHTO T217-02 |

Хүснэгт 2-2-т нарийвчлан үзүүлсэн шинжилгээний стандарт аргууд дээр нэмэлт болгон дараах тестүүдийг тусгасан болно. Үүнд:

Хайрганы хамгийн бага дундаж хэмжээг дараах байдлаар тодорхойлно:

(i) Шинжлэх гэж буй материалын фракци тус бүрээс доод тал нь 200 ширхэг хайрга байхаар дээж авч, дээжийг рифлерээр хуваана. Шинжлэх гэж буй хайрганы хэвийн хэвийн хэмжээний хагастай тэнцэх хэмжээний нүхтэй шигшүүрээр дээжийг шигших ба шигшүүрээр өнгөрсөн хэсгүүдийг шинжилгээнд хэрэглэхгүй. Хэвийн хэмжээ бүхий хайргыг хамгийн бага хэмжээтэй шигшүүрээр материалын 85%-иас доошгүй хэсэг нь өнгөрсөн хувь хэмжээгээр тодорхойлно.

0.1 мм-ийн нарийвчлалтай шигшүүр дээр үлдсэн ширхэглэл тус бүрийн хамгийн бага хэмжээг доод тал нь 5 мм голчтой хавтан бүхий /эсвэл булан төмөр/ штангенциркуль ашиглан хэмжиж тодорхойлно. Шинжилгээ хийсэн ширхэглэлүүдийн тоо болон хэмжилтийг тэмдэглэж авна. Ширхэглэл тус бүрийн хамгийн бага хэмжээнүүдийн нийлбэрийг хэмжилт хийсэн ширхэглэлийн тоонд хуваж хамгийн бага дундаж хэмжээг тодорхойлж гаргана.

(ii) Хайрганы хлоридыг талбайд түргэн тодорхойлох шинжилгээ (Куантаб-Quantab шинжилгээ).

Энэхүү шинжилгээний зорилго нь хлоридыг тээвэрлэж авчирсан цэг дээр нь түргэн тодорхойлох аргаар шинжлэх явдал бөгөөд ингэснээр бохирлогдсон ачааг зайлуулах арга хэмжээг хурдан авч болно.

## 207 ПОРТЛАНД ЦЕМЕНТ

Портланд цементийг, гидравлик цементийн шинжилгээний AASHTO T127 стандартын дагуу дээжлэх ба Портланд цемент AASHTO M85-ийн шаардлагуудад нийцэж байх ёстой.

AASHTO M85-д нийцүүлэхийн тулд Портланд цементийн шинжилгээг хараат бус шинжилгээний лабораторид эсвэл инженерийн зааврын дагуу гүйцэтгэх ёстой.

Талбайн лаборатори дахь шинжилгээг хүснэгт 2-3-т өгсөн стандарт аргуудын дагуу гүйцэтгэнэ.

**Хүснэгт 2-3: Портланд цементийн шинжилгээний аргууд**

| Үзүүлэлтүүд | Шинжилгээний стандарт |
|---|---|
| Шингэн цементийн уусмалын шахалтын бат бэх | AASHTO T106-04 |
| Шингэн цементийн зуурмаг болон уян консистенц бүхий зуурмагийн механик холилт | AASHTO T162-04 |

## 208 БЕТОН

Бетоны дээжлэлт ба шинжилгээг хүснэгт 2-4-т өгсөн аргуудын дагуу явуулна. Шинжилгээний загваруудыг 27 С± 2 С-ийн температурт сойхоор тусгасан. Бетонд ашиглах усыг AASHTO T26-ийн дагуу шинжилнэ.

**Хүснэгт 2-4: Бетоны шинжилгээний аргууд**

| Үзүүлэлтүүд | Шинжилгээний аргууд |
|---|---|
| Цемент ба хайрганы хольцын шүлтлэгийн урвалжилт | ASTM C227-97 |
| Шингэн цемент бетоны суултыг тодорхойлох | AASHTO T119-99 |
| Бетоны эзлэхүүн, жин, гарц, агаарын агуулга | AASHTO T121-97 (2001) |
| Шингэн цементийн зуурмагийн агаарын агуулга | AASHTO T137-04 |
| Шинэ бетоны зуурмагаас дээж авах | AASHTO T141-01 |
| Бетонд агаар оруулах нэмэлтүүд | AASHTO T157-00 |
| Бетоны урсалт | AASHTO T158-01 |
| Бетоны хүйтэн ба гэсэлтийг тэсвэрлэх | AASHTO T161-00 |
| Портланд цементэд агаар оруулах нэмэлтүүдийг хөлдөөж гэсгээж турших | AASHTO T188-75 (1999) |
| Шинэ бетон зуурмагийн агаарын агуулгыг эзэлхүүн тодорхойлох аргаар тодорхойлох | AASHTO T196-96 (2000) |

| | |
|---|---|
| Шинэ бетоноос дээж авах аргууд | BS 1881 Хэсэг 1 |
| Шинэ бетоныг турших аргууд | BS 1881 Хэсэг 2 |
| Шинжилгээний дээжийг бэлтгэх, бэхжүүлэх аргууд | BS 1881 Хэсэг 3 |
| Бетоны бат бэхийн шинжилгээний аргууд | BS 1881 Хэсэг 4 |

## 209 БИТУМЭН БАРЬЦАЛДУУЛАГЧ

(i) Өтгөн битумын шинжилгээ

Өтгөн битумын шинжилгээг хүснэгт 2-5-д өгөгдсөн аргуудын (2002 онд хийсэн хамгийн сүүлийн үеийн залруулгыг тооцно) дагуу явуулна.

**Хүснэгт 2-5: Өтгөн битумын шинжилгээний аргууд**

| Үзүүлэлтүүд | Шинжилгээний аргууд |
|---|---|
| Битумэн материалын ууршимтгай чанар | AASHTO T44-03 |
| Кливлендын задгай сав ашиглаж дөл авалцах температурыг тодорхойлох | AASHTO T48-04 |
| Битумын зүү шигдэлтийн гүнийг тодорхойлох | AASHTO T49-03 |
| Битумын сунах чанар | AASHTO T51-00 |
| Битумын зөөлрөх температур | AASHTO T53-96 (2000) |
| Нефть бүтээгдэхүүн болон битум дэх усны агуулгыг нэрэх аргаар тодорхойлох | AASHTO T55-02 |
| Битумын цэгэн туршилт | AASHTO T102-83 (2000) |
| Битумд халууны болон агаарын үзүүлэх нөлөө | AASHTO T179-04 |
| Битумын кинематик зунгаарал | AASHTO T201-03 |
| Битумын зунгаарлыг вакууман капилляр вискометрээр тодорхойлох | AASHTO T202-03 |
| Хагас хатуу битумэн материалын хувийн жин | AASHTO T228-04 |
| Хатуу болон хагас хатуу битумын хэврэгших температурыг тодорхойлох /Фраассын арга/ | DIN 51011 |

(ii) Шингэрүүлсэн битумын шинжилгээ

Шингэрүүлсэн битумын шинжилгээг хүснэгт 2-6-д өгсөн аргуудын дагуу инженерийн шаардлагад нийцэхүйц хараат бус шинжилгээний лабораторид явуулна.

**Хүснэгт 2-6: Шингэн битумын шинжилгээний аргууд**

| Үзүүлэлтүүд | Шинжилгээний аргууд |
|---|---|
| Зүү нэвчилтийн үлдэгдэл | ASTM D 243-02 |
| Битумэн материалын ууршиx чанар | AASHTO T44-03 |
| Кливлендын задгай сав ашиглаж дөл авалцах температурыг тодорхойлох | AASHTO T48-04 |
| Битумын зүү шигдэлтийн гүнийг тодорхойлох | AASHTO T49-03 |
| Битумын сунах чанар | AASHTO T51-00 |
| Нефть бүтээгдэхүүн болон битум дэх усны агуулгыг нэрэх аргаар | AASHTO T55-02 |

| | |
|---|---|
| тодорхойлох | |
| Шингэн битумыг нэрэх | AASHTO T78-96 (2000) |
| Дөл авалцах температур нь 93.3 С-ийн градусаас бага байх материалд зориулж задгай сав бүхий аппаратаар битумын дөл авалцах температурыг тодорхойлох | AASHTO T79-96 (2000) |
| Битумын цэгэн туршилт | AASHTO T102-83 (2000) |
| Битумд халууны болон агаарын үзүүлэх нөлөө | AASHTO T179-04 |
| Битумын кинематик зунгаарал | AASHTO T201-03 |
| Битумын хувийн жинг тодорхойлох | AASHTO T228-04 |
| Хатуу болон хагас хатуу битумын хэврэгших температурыг тодорхойлох /Фраассын арга/ | DIN 51011 |

(a) Битумэн барьцалдуулагчид тавих шаардлага

(i) Ерөнхий зүйл

Битумэн барьцалдуулагчийг ажлын талбайд авчирахын өмнө гүйцэтгэгч, нийлүүлэх материал нь энэхүү стандартын шаардлагад нийцэж байгааг батлах зорилгоор үйлдвэрлэгчийн сертификат, дээж, зохих шинжилгээний тайлан зэргийг инженерт ирүүлнэ. Энэ зорилгоор 200 тонн болон түүнээс бага хэмжээгээр авчирч буй хэмжээ нь нэг хэсэг болно. Хэрвээ нэг удаагийн татан авчралт нь 200 тонноос илүү байвал тэр хэсгийн 200 тонн бүр нь тусдаа хэсэг гэж тооцогдоно.

Нүх цоорхой гарсан, эвдэрсэн контейнерт авчирсан битумэн барьцалдуулагчыг хүлээн авахгүй.

(ii) Өтгөн битум

Өтгөн битум нь хучилтын асфальт бетон хольцонд хэрэглэгдэнэ. Асфальт бетон хольцонд хэрэглэх 130/200-ийн өтгөн битумийн хувьд битум ньхХүснэгт 2-7-д өгсөн шаардлагыг хангах ёстой.

**Хүснэгт 2-7: 130/200 Өтгөн битумийн техникийн шаардлага**

| **Шинжилгээний нэр** | **Хамгийн бага** | **Хамгийн их** |
|---|---|---|
| 25 С хэм дэх зүү шигдэлт /100 гр, 5 сек/ 0.1 мм | 130 | 200 |
| Дөл авалцах температур /кливлендийн задгай аяга/ | 210 | - |
| 25 С хэм дэх сунах чадвар, 5 см/мин.,см | 100 | - |
| Трихлорэтиленд ууршиx чанар, % | 99 | - |
| Зуухны туршилтын дараа халаах үед гарах алдагдал, % | - | 0.5 |
| Үлдэгдлийн зүү нэвчилт, оригиналын хувь | 46 | - |
| Фрассын хагарлын цэг, С | -21 | - |
| Зөөлрөх цэг /цагираг ба бөмбөлөгийн аргаар/ | 35 | 45 |
| Зунгаарлын шаардлагууд | Дор заасны дагуу | |
| Стандарт нафтын уусмал ашиглах хэсэгчилсэн шинжилгээ | Сөрөг | |
| Усны агуулга | Байхгүй | |
| 25 С хэм дэх хувийн жин | 1.00-1.05 | |

130/200 маркийн өтгөн битум нь шинжилгээний дээжийн хэмжсэн зүү нэвчилтийн дагуу дор заасан зунгаарлын шаардлагыг хангах ёстой.

- Хэрвээ $25^0$C хэм дэх зүү нэвчилт нь 140-өөс бага байвал $60^0$C хэм дэх абсолют зунгаарал нь 900 пойзоос их байна.
- Хэрвээ $25^0$C хэм дэх зүү нэвчилт нь 140 ба 160-ийн хооронд байвал $60^0$C хэм дэх абсолют зунгаарал нь 800 пойзоос их байна.
- Хэрвээ $25^0$C хэм дэх зүү нэвчилт нь 160 ба 180-ийн хооронд байвал $60^0$C хэм дэх абсолют зунгаарал нь 700 пойзоос их байна.
- Хэрвээ $25^0$C хэм дэх зүү нэвчилт нь 180-аас их байвал $60^0$C хэм дэх абсолют зунгаарал нь 600 пойзоос их байна.

Түүнчлэн битум нь нэг төрлийн, усгүй байх ба $175^0$C хүртэл халаахад хөөсрөлт үүсэх ёсгүй.

Дээр тодорхойлсон 130/200 зүү нэвчилтийн маркаас бусад өтгөн битум асфальт бетон хольц буюу бусад битумны ажилд хэрэглэгдвэл, ийм битум нь зунгаарлын ангилалтай асфальт цементэд зориулсан AASHTO T226-ийн шаардлагад нийцэх ёстой.

(iii) Шингэн битум

Түргэн хатдаг шингэн битум нь AASHTO стандарт техникийн шаардлагын 81 шингэн асфальт (түргэн хатдаг төрөл)-ийн бүх шаардлагуудад нийцэх ёстой.

Дунд зэрэг хатдаг шингэн битум нь AASHTO стандарт техникийн шаардлагын 82 шингэн асфальт (дунд зэрэг хатдаг төрөл)-ийн бүх шаардлагуудад нийцэх ёстой.

## 210 БИТУМЭН ХОЛЬЦУУД

(а) Дээж ба дээж авалт

Битумэн хольцын дээж авалтыг AASHTO T168 Битумэн хучилтын хольцуудын дээж авалт-ийн дагуу гүйцэтгэнэ.

(б) Шинжилгээний стандарт аргууд

Битумэн хольцын шинжилгээг хүснэгт 2-8-д өгсөн аргуудын дагуу явуулна.

**Хүснэгт 2-8: Битумэн хольцын шинжилгээний аргууд**

| Үзүүлэлтүүд | Шинжилгээний аргын стандартууд |
|---|---|
| Ширхэглэсэн чулууны механик шинжилгээ | AASHTO T30-93 (2003) |
| Хучилтын битумэн хольцоос битумыг ялгах | AASHTO T164-01 |
| Нягтруулсан битумэн хольцын эзэлхүүний хувийн жинг ханасан хуурай гадаргуутай дээж ашиглан тодорхойлох | AASHTO T166-00 |
| Хучилтын битумэн хольцоос дээж авах | AASHTO T168-03 |
| Битумэн хольцын хамгийн их хувийн жинг тодорхойлох | AASHTO T209-99 (2004) |
| Битум-хайрга хольцын хучилтын нягтралын зэрэг | AASHTO T230-68 (2000) |
| Битумэн хольцын тогтвортой байдлын үзүүлэлтийг Маршалын аппарат ашиглан тодорхойлох | AASHTO T245-97 (2001) |
| Хучилтын битумэн хольцон дахь сүвшилтийн хэмжээг тодорхойлох | AASHTO T269-97 |

| | |
|---|---|
| | (2003) |

## 211 АРМАТУР

Бетоныг арматурлах ган нь хүснэгт 2-9-д өгсөн AASHTO стандарт техникийн шаардлагууд болон Британий стандартуудын аль нэгэнд нь нийцэж байх ёстой. Гүйцэтгэгч нь бүх арматурын цувимлын шинжилгээний тайланг ирүүлнэ. Арматур тохирох техникийн шаардлагад нийцэж байгаа эсэхийг шалгахын тулд инженерийн шаардлагад нийцэхүйц бие даасан шинжилгээний лабораторид шинжлэх ёстой.

**Хүснэгт: Арматурын шинжилгээний аргууд**

| Үзүүлэлтүүд | Стандартын дугаар |
|---|---|
| Бетоны арматурт хэрэглэх хэв гажсан ба хавтгай ган | AASHTO M 31M-03 |
| Бетоны арматурт хэрэглэх хэв гажсан ган утсан тор | AASHTO M 221M-03 |
| Бетоны арматурт хэрэглэх хэв гажсан ган утас | AASHTO M 225M-03 |
| Бетоны арматурт хэрэглэх сунгаж хүчитгэсэн ган | BS 4449 |
| Бетоны арматурт хэрэглэх ган тор | BS 4483 |

## 212 БЕТОН ХООЛОЙ

Бетон хоолой хүснэгт 2-10-т дурдсан AASHTO стандарт техникийн шаардлагуудад нийцэж байх ёстой. Гэхдээ хэмжээ ба арматурын деталиудыг зургийн ботид үзүүлнэ.

**Хүснэгт 2-10: Бетон дугуй ба дөрвөлжин хоолойн хэсэглэлд тавигдах техникийн шаардлага**.

| Үзүүлэлтүүд | Техникийн шаардлагын дугаар |
|---|---|
| Төмөр бетон хоолой, үерийн шуудуу, ариутгах татуургын хоолой (метр) | AASHTO M 170M-04 |
| Төмөрбетон дөрвөлжин хоолой, үерийн шуудуу, аритгах татуургын хоолой (метр) | AASHTO M 259M-00<br>AASHTO M 273M-00 |

Бетон хоолойны бетон нь энэхүү техникийн шаардлагын бүлэг 1300-ийн шаардлагад нийцэх ёстой.

Төмөр бетон хоолойны арматур нь AASHTO M 170M-ийн шаардлагад нийцсэн байна.

Төмөр бетон дөрвөлжин хоолойны арматур нь AASHTO M 259M, AASHTO M 273M -ийн шаардлагад нийцсэн байна.

Бүх бетоныг эргүүлэх буюу доргиох аргаар нягтруулна.

Бүх бетон хоолойг хүснэгт 2-10-т өгсөн зохих стандарт техинкийн шаардлагын дагуу хатаах ёстой. Хоолойг бэлдсэнээс хойш 21 хоногийн дараа ажилд хэрэглэх ёстой. Цутгасан өдрийг хоолойн дээр арилахгүй байдлаар бичнэ.

Бетон хоолойг хүснэгт 2-10 дахь зохих стандарт шаардлагын дагуу шинжилнэ.

## 213 ЗАМЫН ТЭМДЭГ

(а) Замын тэмдгийн будаг

Замын тэмдэг, шон ба тоноглолыг бэлтгэх, засварлах, будахдаа MC 4597:2003 стандартын шаардлагын дагуу гүйцэтгэнэ.

(б) Бусад будаг

Ажилд хэрэглэх бусад бүх будгийг инженер баталгаа.

## 214 ЗАМЫН ТЭМДЭГЛЭГЭЭ

Замын тэмдэглэгээг будах будгийг AASHTO M 248 “Цагаан ба шар өнгийн ойлгогч термопластик материал (хатуу хэлбэр)” ба AASHTO M 247 “Замын хөдөлгөөний будагт хэрэглэх шилэн дэвсгэр”-т заасан шаардлагыг хангасан шилэн дэвсгэрийг ашиглан гэрэл ойлгох чанартай болгоно.

## 215 ЗАМЫН ТЭМДЭГ ХИЙХЭД ЗОРИУЛСАН ГЭРЭЛ ОЙЛГОГЧ МАТЕРИАЛ

Гэрэл ойлгогч материал нь AASHTO M 268 – “Хөдөлгөөний хяналтад зориулсан ойлгогч самбар”-т заасан нөхцлүүдийг хангасан байх ёстой. Түүнчлэн дараахи шаардлагууд тавигдана. Үүнд:

(а) Ойлгогч материал нь ямар ч өнцгөөс харахад тасралтгүй ойлгогч гадаргуутай байна. Энэ нь гадаргуугийн дор суулгасан бөөрөнхий хэлбэрийн линз бүхий толигор нимгэн хальснаас бүрдэх ба ар тал нь хамгаалалттай, дэвсгэр үе хийсэн, наалдамтгай байна. Янз бүрийн элементийг хослуулах нь гэрлийн бус линз төрлийн оптик ойлгогч системийг бий болгоно. Гэрэл ойлгогч материалыг үйлдвэрлэгчийн гаргасан зааврын дагуу хэрэглэх ёстой.

(б) Замын тэмдгийн ойлгогч 45 градусын өнцгөөр, Улаанбаатараас баруун тийш харуулж, босоо байрлуулж хэрэглэхэд ямар нэг хагарал, цэврүү, хялгасан ан цав, хэмжээний хувьд өөрчлөлт гарахгүй байх ёстой.

(в) Ойлгогч гадаргууг үндсэн суурь материал дээр тогтоох наалт нь 20 $^{0}$C-ийн хэмд хүрзээр цохиход салахгүй, гараар зөөвөрлөхөд сэвтэж гэмтэхгүй, мөн хуурахгүй байх ёстой. 25$^{0}$C-ийн хэмд усан дотор 8 цаг байлгахад ирмэг зах нь ямар нэг байдлаар хуйларч эргэхгүй байх ёстой. Цавуу нь ойлгогч материал дээр толбо үүсгэх ёсгүй. Цавуу нь ойлгогч материалыг нааснаас хойш -20$^{0}$C хэмээс +93$^{0}$C хэмд 48 цагийн хугацаанд түүнийг найдвартай тогтоон барьж байх шаардлагатай.

(г) 20 орчим мм-ийн голчтой хүрээг тойруулан нугалахад 0.5 мм-ийн зузаантай хөнгөн цагаан дэвсгэр дээр наасан ойлгогч материалд ямар нэг хагарал үүсэхгүй байх ёстой.

(д) 20$^{0}$C хэмд замын тэмдгийн ойлгогч гадаргуу дээр 25 мм-ийн голчтой ган бөмбөлгийг 2 м-ийн өндрөөс унагаахад цохилтын цэгийн орчимд ямар нэг мэдэгдэхүйц хагарал үүсэх юмуу хуурах ёсгүй.

(е) Замын заалтын ойлгогч материалыг метилийн спирт, керосин юмуу тосон давирхайд 10 минут, эсвэл ксилол буюу толуолд 1 минут дүрэхэд хайлах буюу цэврүүтэх, эсвэл завсар үүсэх ёсгүй. Гэрэл ойлгогч материал нь ус, зөөлөн уусмал, тосон давирхай болон метанолоор угаахад арилахгүй байх ёстой.

(ё) Гэрэл ойлгогч материал нь үйлдвэрлэгчийн зааврын дагуу цэвэрлэж будахад дахин сэргээгдэж байх ёстой.

## 216 ЗАМЫН ТЭМДГҮҮДИЙН ӨНГӨ

Замын тэмдэг, шон ба бусад тоноглолд хэрэглэх стандартын өнгө нь дараахи Британий стандартуудад заасны дагуу байна. Үүнд:

| | |
|---|---|
| Улаан | BS 381 C No. 537 |
| Цэнхэр | BS 4800 No. 18 E 53 |
| Шар | BS 381 C No. 537 |
| Ногоон | BS 4800 No. 14 C 39 |
| Саарал | BS 4800 No. 10 A 11 |
| Шаргал | BS 381 C No. 352 |

| | |
|---|---|
| Цагаан | BS 873 хэсэг 1 – бүлэг 1-3.2 |
| Хар | BS 873 хэсэг 1 – бүлэг 1-3.3 |

## 217 ХАШЛАГА

Хашлага болон түүний бүрдэл хэсгүүд нь AASHTO M180 – Замын хашлаганы атираатай ган төмөр-т заасан шаардлагыг хангасан, А ангиллын, 1 дүгээр төрлийн ган байна.

## 218 ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН АШИГЛАЛТ, БАРИЛГЫН АРГАЧЛАЛ БА ТЕХНИКИЙН ШААРДЛАГЫГ БАТАЛГААЖУУЛАХ ТУРШИЛТУУД

а) Лабораторийн шинжилгээ

Газар шорооны ажил болон хайрган өнгөн үед ашиглах байгалийн гаралтай ба боловсруулсан материалын лабораторийн туршилт шинжилгээг гүйцэтгэгч байгууллага нь инженертэй зөвлөлдөж гүйцэтгэнэ. Материалын стандартад тодорхойлсон эцсийн бүтээгдэхүүнд тавих шаардлага болон барилгын ажилд хяналт тавих зорилгоор газар дээр нь хялбар тодорхойлж болох материалын шинж чанарын хооронд харилцан уялдааг бий болгохын тулд ийм туршилтуудыг хийдэг.

Хольцын хувьд стандартын тодорхой шаардлагыг хангасан ба инженерийн хүлээн зөвшөөрсөн материалуудыг энэ техинкийн шаардлагын зүйл 218 (б) дэх шаардлагыг хангаж байх газар дээр нь хийх туршилт шинжилгээнд ашиглана. Ийм туршилтаар төлөвлөсөн хольцыг ашиглан хучилтын үед тодорхой шаардлагыг хангах эсэхийг харуулах юм. Лабораторийн туршилтыг хольц ба байгалийн гаралтай материал дээр хийж гүйцэтгэх ба үүн дээр тулгуурлан гүйцэтгэгчийн урьдчилан төлөвлөсөн материалыг энэ техникийн шаардлагын зүйл 218 (б)-ийн дагуу газар дээр нь туршихаас доод тал нь хоёр долоо хоногийн өмнө урьдчилсан төлөвлөгөөгөө инженерт танилцуулна.

(б) Талбай дээрх туршилтууд

Барилгын ажилд ашиглахаар гүйцэтгэгчийн төлөвлөсөн тоног төхөөрөмж, аргачлалын дагуу бүх газар шорооны болон хайрган үед ашиглах материалын дэвсэх, нягтруулах бүрэн хэмжээний талбайн туршилтуудыг гүйцэтгэгч хийж гүйцэтгэнэ. Гүйцэтгэгч нь холих хувь хэмжээг нэгэн жигд байхыг баталгаажуулах ба материалыг нэгэн ижил төлөвт байлгахын тулд маш сайн холино.

Гүйцэтгэгч нь материалыг дэвсэж, боловсруулалт хийж, шаардагдах нягтралын түвшин хүртэл нягтруулахад түүний тоног төхөөрөмж болон барилгын аргачлал тохирч байгаа эсэх, түүнчлэн дууссан газар шорооны ажил эсвэл хучилтын үед тавигдах тодорхой шаардлагуудыг хангаж байгаа эсэхийг харуулах зорилгоор туршилтуудыг явуулна.

Туршилт хийх талбай бүр нь 100 м-ийн урттай байх ба барилгын ажил хийгдэх өргөнийг бүхэлд нь хамарна. Материалыг тодорхойлогдсон гүнд хүрэх хүртэл нь дэвсэж байрлуулна. Туршилтын талбай нь энэ техникийн шаардлагуудад нийцэж байгаа тохиолдолд барилгын ажлын нэг хэсгийг бүрдүүлэх юм. Энэ техникийн шаардлагуудад нийцэхгүй байгаа талбайг хамруулахгүй ба туршилтыг цаашид үргэлжлүүлнэ.

Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөртөө талбайн туршилт явуулах болон шаардагдах шинжилгээг төлөвлөнө. Хучилтын үе бүр дээр хийх туршилтыг гүйцэтгэгч энэ үе дээр бүрэн хэмжээний ажлыг эхлэх санал тавихаас 21 хоногийн өмнө явуулна.

Талбайн туршилт хийх бүрт нягтруулалтын түвшин бүрт дараахи өгөгдлүүдийг бүртгэж авна. Үүнд:

- Туршилтаас өмнөх материалын найрлага ба зэрэглэл
- Нягтруулалтаас хойших материалын найрлага ба зэрэглэл
- Нягтруулах үеийн чийгийн агуулга, тодорхойлсон нягтруулалтын хамгийн тохиромжтой чийгийн агуулга

- Нягтруулах техникийн төрөл, хэмжээ, дугуйны даралт, доргилтын давтамж, өнгөрөх тоо
- Талбайн туршилтыг явуулахын өмнө болон туршилт явуулах хугацааны туршид дээжинд хэмжсэн хамгийн их хуурай нягтрал эсвэл төлөвлөсөн нягтралын аль тохирох нь
- Эцсийн нягтрал
- Нягтруулсан үеийн зузаан
- Инженерийн зааварласан бусад холбогдох мэдээлэл

Гүйцэтгэгч тухайн материалыг ашиглахаар төлөвлөж байгаа газар шорооны ажил болон хучилтын үе бүрт зориулсан 100 м-ийн урттай хэсэг бүр дээр дор хаяж найман иж бүрдэл туршилтыг гүйцэтгэгч ба инженер явуулна. Үе бүрт явуулсан бүх найман иж бүрдэл шинжилгээний үр дүн нь материалын шаардлагад нийцэж байвал талбайн туршилтыг амжилттай болсон гэж үзнэ. Талбайн туршилтын үед бүртгэж авсан өгөгдлүүд нь гүйцэтгэгчийн санал болгож, инженерийн зөвшөөрсний дагуу, энэхүү техникийн шаардлагад нийцсэн тодорхой материал бүрийг нийлүүлэх, дэвсэх, боловсруулах болон барилгын техникийг сонгон авах аргачлалыг тодорхойлох үндэс болох юм. Хэрвээ инженер иж бүрдэл туршилтын аль нэгийг үр дүнд хүрээгүй гэж үзвэл гүйцэтгэгч инженерийн удирдлагын дор дахин туршилтууд явуулна.

Ажлыг гүйцэтгэх явцад, хэрвээ материалд тавигдах шаардлагууд тогтмол хангагдахгүй байгаа нь барилгын хяналтын туршилтаар харагдаж байвал гүйцэтгэгч шалтгааныг судалж, тогтоох хүртэл тухайн газар шорооны ажил буюу хучилтын үе дээр хийгдэж буй ажлыг зогсооно. Тухайн үед ашиглах бүх материалыг нийлүүлэх, дэвсэх болон боловсруулахад шаардлагатай өөрчлөлт хийсэн аргачлалыг тогтооход хэрэглэх засвар өөрчлөлт оруулсан иж бүрдэл өгөгдлүүдийг тодорхойлох зорилгоор цаашид хийх лабораторийн шинжилгээ болон талбайн туршилтууд ийм судалгаанд хамрагдана.

Барилгын ажлын санал болгосон аргачлалыг талбайд туршсан туршилтын явцад бүртгэгдсэн иж бүрдэл өгөгдлүүдийг инженер зөвшөөрөх нь энэхүү техникийн шаардлагыг хангах аливаа хариуцлагаас гүйцэтгэгчийг чөлөөлөхгүй.

## 219 ГАЗАР ШОРООНЫ АЖИЛ, ХУЧИЛТЫН ҮЕ БОЛОН УС ЗАЙЛУУЛАХ ХИЙЦ, БАЙГУУЛАМЖИЙГ БУЦААЖ ДАРАХ АЖЛЫН БАРИЛГЫН ХЯНАЛТЫН ТУРШИЛТ

Энэ техникийн шаардлагууд, техникийн шаардлагуудын зүйл 109-ийн дагуу зохиогдсон төслийн чанарын хяналтын төлөвлөгөө болон инженерийн явуулах чанарын баталгааны туршилтын дагуу, бүх газар шорооны ажил, хучилтын үе, ус зайлуулах хийц, байгууламж нь барилгын чанарын туршилтанд хамрагдана. Гүйцэтгэгч ажлынхаа дэс дараалын дагуу ийм хяналтын туршилтыг явуулах хугацааг ажлын төлөвлөгөө болон тендертээ тооцсон байх ёстой.

Дараагийн барилгын ажил эхлэхийн өмнө гүйцэтгэгч нь газар шорооны ажлын хэсэг бүрийн үе бүрт, хучилтын ажил, ус зайлуулах хийц, байгууламжийг буцааж дарах ажлуудад инженерийн зөвшөөрлийг бичгээр авна. Тухайн ажлын хэсэг энэ техникийн шаардлагуудын дагуу хийгдэж байна гэж гүйцэтгэгч үзсэн тохиолдолд л ийм хүсэлтийг гаргана. Энэ техникийн шаардлагуудын дагуу ийм хүсэлтэд гүйцэтгэгчийн шинжилгээний дүнгийн хувиудыг хавсаргана.

Үүний дараа инженер тухайн хэсэгт нүдэнд ил ус тогтсон, давхраатсан, материал овойж гарсан /тэгшилсэн хэсэгт ил үзэгдэх/ эсэх, чулууны ялгарал,, том хэмжээтэй материал байгаа эсэх, холилт ба нягтруулалт нь нэгэн жигд эсэхийг шалгана. Биечлэн шалгасан шалгалт нь хангалттай тохиолдолд инженер баталгаа гаргах замын хэсгийг шалгана. Эдгээр шалгалтын үр дүнг инженер гүйцэтгэгчид бичгээр мэдээлэх ба үүний зэрэгцээ тухайн үе болон хэсгийг хүлээн авах буюу татгалзах шийдвэрээ гаргана.

Инженер өмнөх үеийг бичгээр баталгаажуулж, хүлээн авах хүртэл дараагийн үеүдэд хийгдэх ажлыг ямар ч тохиолдолд эхлүүлэхгүй. Гүйцэтгэгч нь батлуулахаар мэдүүлсэн ажлын нөхцөл байдлыг хамгаалах, хадгалах хариуцлагыг бүрэн хүлээнэ.

Ямар нэг үеийг баталгаажуулсны дараа 24 цагаас илүү хугацаанд хамгаалалтгүй орхисон тохиолдолд гүйцэтгэгч энэ үеийг дахин батлуулахаар хүсэлт гаргана. Хэрвээ инженер шаардвал, энэ үе дээр хяналтын тэгшилгээ, барилгын хяналтын туршилт, зөвшөөрөгдөх алдааны шалгалтыг энэхүү техникийн шаардлагын дагуу явуулна.

Ямар нэг үеийг инженер баталгаажуулсан боловч, гүйцэтгэгч тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, ус нэвтрэх болон бусад шалтгаанаар үүссэн эвдрэлийг засах хариуцлагыг хүлээнэ. Үенд ямар нэгэн эвдрэл гарвал түүнийг дахин тэгшлэх, нягтруулах, барилгын хяналтын туршилт ба зөвшөөрөгдөх алдааны шалгалтыг энэхүү техникийн шаардлагын дагуу явуулна.

## 220 ТУРШИЛТЫН ДАВТАМЖ

(а) Нягтралын шинжилгээний цөмийн төхөөрөмжийн тохируулга

Талбайн хуурай нягтралыг тодорхойлох зорилгоор ерөнхийдөө цөмийн аргыг ашиглана. Анхны тохируулга, тохируулгын муруйн зохицуулалт, нягтралын шинжилгээний цөмийн төхөөрөмжийн өдөр бүрийн стандартжуулалт нь AASHTO T310 –“ Хөрс ба хөрс-хайрганы нягтрал ба чийгийн агуулгыг цөмийн арга ашиглан газар дээр нь тодорхойлох” -ийн шаардлагуудад нийцэж байх ёстой. Муруйн тохируулгыг AASHTO T191 – “Хөрсний нягтралыг элсэн конусын аргаар газар дээр нь тодорхойлох”-тай параллеллаар хийх ёстой.

(б) Давтамжийн шаардлагууд

Шинжилгээний давтамж нь энэхүү техникийн шаардлагын зүйл 109-ийн дагуу гаргасан гүйцэтгэгчийн төслийн хяналтын төлөвлөгөөний дагуу байх ёстой ба дор дурдсан наад захын шаардлагыг хангаж байх ёстой.

(i) Тохирох шинжилгээнүүд

Барилгын ажлын төрөл бүрт тохирох шинжилгээнүүд нь дор заасны дагуу байна. Үүнд:

| No. | Ажлын төрөл | AASHTO стандарт | Бусад шинжилгээ |
|---|---|---|---|
| 1. | Ул хөрсийг нягтруулах | T180-01 | |
| | | T217-02 | |
| | | T265-93 (2000) | |
| | | T310-03 | |
| 2. | Далан барих | T88-00 | |
| | | T89-02 | |
| | | T90-00 | |
| | | T180-01 | |
| | | T191-02 | |
| | | T217-02 | |
| | | T265-93 (2000) | |
| | | T310-03 | |
| 3. | Хөлдөлтийн эсрэг үе | T11-97 (2000) | |
| | | T88-00 | |
| | | T89-02 | |

| | | | |
|---|---|---|---|
| | | T90-00 | |
| | | T180-01 | |
| | | T191-02 | |
| | | T217-02 | |
| | | T193-99 (2003) | |
| | | T265-93 (2000) | |
| | | T310-03 | |
| 4. | Хайрган хөвөө ба хайрган хучилт | T11-97 (2000) | |
| | | T88-00 | |
| | | T90-00 | |
| | | T180-01 | |
| | | T191-02 | |
| | | T193-99 (2003) | |
| | | T217-02 | |
| | | T265-93 (2000) | |
| | | T310-03 | |
| 5. | Суурийн доод үе | T88-00 | (i) чийгийн тестерээр хийх түргэн арга |
| | | T89-02 | |
| | | T90-00 | |
| | | T150 | |
| | | T191-02 | |
| | | T193-99 (2003) | |
| | | T265-93 (2000) | |
| | | T310-03 | |
| 6. | Буталсан чулуун суурь | T27-99 | |
| | | T84-00 | |
| | | T85-91 (2000) | |
| | | T96-02 | |
| | | T104-99 (2003) | |
| | | T180-01 | |
| | | T191-02 | |
| | | T265-93 (2000) | |
| | | T310-03 | |
| 7. | Ухмалыг буцааж дарах болон хийцэд дүүргэлт хийх | T27-99<br>T88-00 | |
| | | T89-02 | |
| | | T90-00 | |

T180-01

T191-01

T193-99 (2003)

T217-02

T265-93 (2000)

T310-03

(ii) Шинжилгээний давтамж

Ажилд хэрэглэх материалын эх үүсвэр бүрт хийгдэх наад захын шинжилгээний давтамж дараахи байдалтай байна. Үүнд:

| 1 | Ажлын төрөл | Шинжилгээ | Давтамж (хамгийн бага) |
|---|---|---|---|
| 1. | Ул хөрсийг нягтруулах | чийг-нягтын харьцаа | 3000 м$^2$ буюу трассын дагуу 250 м-т нэг шинжилгээ |
| | | нягтруулалтын өмнөх чийгийн агуулга | 1000 м$^2$ буюу трассын дагуу 100 м-т нэг шинжилгээ |
| | | Талбайн хуурай Нягтшил | 500 м$^2$ буюу нэг хэсэгт хоёр шинжилгээ |
| 2. | Далан барих | Чийг-нягтын харьцаа | 2000 м$^3$-д нэг шинжилгээ |
| | | Ширхэгийн хэмжээний анализ | 1000 м$^3$--д нэг шинжилгээ |
| | | Уян налархайн индекс | 1000 м$^3$--д нэг шинжилгээ |
| | | Урсалтын хязгаар | 1000 м$^3$--д нэг шинжилгээ |
| | | Нягтруулалтын өмнөх чийгийн агуулга | үе бүрийн 600 м$^2$ -д нэг шинжилгээ эсвэл нэг хэсэгт 3 шинжилгээ |
| | | Талбайн хуурай нягт | үе бүрийн 600 м$^2$-д нэг шинжилгээ эсвэл хэсэг бүрт 3 шинжилгээ |
| 3. | Хөлдөлтийн эсрэг үе | Чийг-нягтын харьцаа | 1000 м$^3$--д нэг шинжилгээ |
| | | Ширхэглэлийн хэмжээний анализ | 500 м$^3$--д нэг шинжилгээ |
| | | Хувийн овойлт ба CBR (3 дээжийн иж бүрдэл) | 1000 м$^3$--д нэг шинжилгээ |
| | | Уян налархайн индекс | 500 м$^3$-д нэг шинжилгээ |
| | | Уян налархайн бүтээгдэхүүн | 500 м$^3$--д нэг шинжилгээ |
| | | Нягтруулалтын өмнөх чийгийн агуулга | үе бүрийн 300 м$^3$-д нэг шинжилгээ |
| | | талбайн хуурай нягт | 300 м$^2$-д нэг шинжилгээ эсвэл эг хэсэгт 3 шинжилгээ |
| 4. | Хайрган хөвөө ба хайрган хучилт | Чийг-нягтын харьцаа | 1000 м$^3$--д нэг шинжилгээ |
| | | Уян налархайн индекс | 500 м$^3$--д нэг шинжилгээ |
| | | Ширхэглэлийн бүрэлдэхүүн | 500 м$^3$--д нэг шинжилгээ |

| | | | |
|---|---|---|---|
| | | Хөрсний даацын үзүүлэлт (3 дээжийн бүрдэл) | 500 м$^3$-д нэг шинжилгээ |
| | | Нягтруулалтын өмнөх чийгийн агуулга | үе бүрийн 500 м$^2$ -д нэг шинжилгээ |
| | | Талбайн хуурай нягт | 250 м$^2$ -д нэг шинжилгээ буюу нэг хэсэгт 3 шинжилгээ |
| 5. | Суурийн доод үе | Чийг-нягтын харьцаа | 1000 м$^3$--д нэг шинжилгээ |
| | | Уян налархайн индекс | 250 м$^3$--д нэг шинжилгээ |
| | | Урсалтын хязгаар | 250 м$^3$--д нэг шинжилгээ |
| | | Ижил байдлын коэффициент | 250 м$^3$--д нэг шинжилгээ |
| | | Уян налархайн модуль | 250 м$^3$-д нэг шинжилгээ |
| | | Хөрсний даацын үзүүлэлт (3 дээжийн иж бүрдэл) | 250 м$^3$--д нэг шинжилгээ |
| | | Ширхэглэлийн бүрэлдэхүүн | 250 м$^3$--д нэг шинжилгээ |
| | | Нягтруулалтын өмнөх чийгийн агуулга | үе бүрийн 500 м$^2$ -д нэг шинжилгээ |
| | | Талбайн хуурай нягт | 250 м$^2$ -д нэг шинжилгээ буюу нэг хэсэгт 3 шинжилгээ |
| 6. | Буталсан чулуун суурь | Чийг-нягтын харьцаа | 500 м$^3$--д нэг шинжилгээ |
| | | Сульфат натрийн бат бэх | 500 м$^3$--д нэг шинжилгээ |
| | | Үелэлийн индекс | 500 м$^3$--д нэг шинжилгээ |
| | | Ус шингээлт | 500 м$^3$--д нэг нэг шинжилгээ |
| | | Лос Анжелесийн Элэгдэл | 500 м$^3$--д нэг шинжилгээ |
| | | Ширхэглэлийн бүрэлдэхүүн | 250 м$^3$--д нэг шинжилгээ |
| | | Нягтруулалтын өмнөх чийгийн агуулга | үе бүрийн 500 м$^2$ -д нэг шинжилгээ |
| | | Талбайн хуурай нягт | 250 м$^2$ -д нэг шинжилгээ буюу нэг хэсэгт 3 шинжилгээ |
| 7. | Ухмалыг буцааж ;арах ба хийцийн дүүргэлт | Чийг-нягтын харьцаа | 250 м$^3$--д нэг шинжилгээ |
| | | Ширхэглэлийн хэмжээний анализ | 500 м$^3$-д нэг шинжилгээ |
| | | Хувийн овойлт ба CBR (3 дээжийн иж бүрдэл) | 500 м$^3$--д нэг шинжилгээ |
| | | Уян налархайн индекс | 500 м$^3$--д нэг шинжилгээ |
| | | Урсалтын хязгаар | 500 м$^3$--д нэг шинжилгээ |
| | | Нягтруулалтын өмнөх чийгийн агуулга | 300 м$^2$ д хоёр шинжилгээ |

Талбайн хуурай нягт 300 м$^2$ -д хоёр шинжилгээ

Хэрвээ хийгдсэн шинжилгээ болон шинжилгээний иж бүрдэл нь тохирохгүй буюу тогтмол бус бол эдгээр шинжилгээг давтан явуулах буюу инженерийн зааврын дагуу шинжилгээний давтамжийг ихэсгэж болно.

Инженерийн тодорхойлсны дагуу шинэ материал бүрт дээр дурдсанаар дор хаяж, 2 иж бүрдэл шинжилгээг, материалын чанараас үл хамааран явуулна.

(i) Ул хөрс

AASHTO T180 Хамгийн их хуурай нягт ба тохиромжтой чийгийн агуулгыг шинэ материал бүрт, ул хөрсний 3,000 м$^2$ бүрт нэг удаа эсвэл трассын дагуу хамгийн их нь 250 м-ийн интервалтайгаар тодорхойлно.

Материалыг нягтруулахын өмнөх чийгийн агуулгын шинжилгээг дор хаяж 1,000 м$^2$ тутамд нэг удаа явуулна. Хатах буюу норсоноос шалтгаалж материалын чийгийн агуулга өөрчлөгдөх үед эсвэл өмнөх шинжилгээний дүн нь тодорхой бус байвал чийгийн агуулгын шинжилгээг давтан явуулна.

Талбайн хуурай нягтыг нягтруулсан материалын дор хаяж 500 м$^2$ тутамд нэг удаа тодорхойлох буюу эсвэл нэг хэсэгт дор хаяж 2 шинжилгээ явуулах хүсэлт гаргасан тохиолдолд замын 100 м тутамд дор хаяж нэг шинжилгээг явуулна.

(ii) Газар шорооны ажил

AASHTO T180 Хамгийн их хуурай нягт ба тохиромжтой чийгийн агуулгыг шинэ материал бүрт болон материалын 2,000 м$^3$ бүрт нэг удаа эсвэл материалын төрөл өөрчлөгдөх үед тодорхойлно.

Далангийн дүүргэлтийн материалын ширхэглэлийн шинжилгээ, уян налархайн индекс ба урсалтын хязгаарыг ашиглагдсан материалын 1000 м$^3$ тутамд нэг удаа эсвэл гарсан шинэ материал бүрт тодорхойлно.

Материалын үе бүрийг нягтруулахын өмнөх чийгийн агуулгын шинжилгээг нягтруулсан материалын үе бүрийн дор хаяж 600 м$^2$ тутамд нэг удаа явуулах ба эсвэл шинжилгээ хийлгэх шаардлагатай хэсэг бүрт дор хаяж гурван шинжилгээг явуулна.

Хатах буюу норсоноос шалтгаалж материалын чийгийн агуулга өөрчлөгдөх үед эсвэл өмнөх шинжилгээний дүн нь тодорхой бус байвал эсвэл нягтруулах ажил тасалдсаны дараа дахин шинээр эхэлсэн тохиолдолд чийгийн агуулгын шинжилгээг давтан явуулна.

Талбайн хуурай нягтыг нягтруулсан материалын үе бүрийн дор хаяж 600 м$^2$ тутамд нэг удаа тодорхойлох буюу эсвэл шинжилгээ хийлгэх шаардлагатай хэсэг бүрт дор хаяж гурван шинжилгээг хийнэ.

(iii) Хоолой ба хийц байгууламжийг буцааж дарах, дүүргэлт хийх, ухсан гадаргуу

Ширхэглэлийн бүрэлдэхүүний шинжилгээ, уян налархайн индекс, урсалтын хязгаар, AASHTO T180 хамгийн их хуурай нягт ба тохиромжтой чийгийн агуулгыг ашигласан материалын 500 м$^3$ тутамд буюу гарсан шинэ материал эсвэл байршил бүр дээр тодорхойлно.

Нягтруулахын өмнөх чийгийн агуулга, нягтруулсны дараахи талбайн хуурай нягтыг дэвсэж нягтруулсан материалын үе бүрийн эсвэл хэсэг бүрийн дор хаяж 300 м$^2$ тутамд хоёр удаа тодорхойлно. Баталгаажуулахаар мэдүүлсэн хэсэг бүрт хийх шинжилгээний тоо нь 3 байна.

(iv) Хайрган хөвөө ба хайрган хучилт

AASHTO T180 Хамгийн их хуурай нягт ба тохиромжтой чийгийн агуулга, хөрсний даацын үзүүлэлтийн (CBR) шинжилгээг (3 дээжийн бүрдэл) материалын шинэ эх үүсвэр нээсний дараа болон боловсруулсан материалын 1,000 м$^3$ тутамд дор хаяж нэг удаа тодорхойлно.

Ширхэглэлийн бүрэлдэхүүний шинжилгээ, уян налархайн индексийг ашигласан материалын 500 м$^2$ тутамд дор хаяж нэг удаа эсвэл гарсан шинэ материал бүр дээр тодорхойлно.

Материалын үе бүрийг нягтруулахын өмнөх чийгийн агуулгын шинжилгээг нягтруулсан материалын үе бүрийн эсвэл хэсгийн дор хаяж 500 м$^2$ тутамд нэг удаа явуулна. Хатах буюу норсоноос шалтгаалж материалын чийгийн агуулга өөрчлөгдөх үед эсвэл өмнөх шинжилгээний дүн нь тодорхой бус байвал чийгийн агуулгын шинжилгээг давтан явуулна.

Талбайн хуурай нягтыг нягтруулсан материалын үе бүрийн дор хаяж 250 м$^2$ тутамд нэг удаа тодорхойлох буюу эсвэл шинжилгээ хийлгэх шаардлагатай хэсэг бүрт дор хаяж гурван шинжилгээг явуулна.

(v) Суурийн доод үе

AASHTO T180 хамгийн их хуурай нягт ба тохиромжтой чийгийн агуулга, хөрсний даацын үзүүлэлтийн (CBR) шинжилгээг (3 дээжийн бүрдэл) суурийн доод үеийн материалын шинэ эх үүсвэр бүрийг нээсний дараа болон боловсруулсан материалын 1,000 м$^3$ тутамд дор хаяж нэг удаа явуулна. Суурийн доод үеийн материалын ширхэглэлийн бүрэлдэхүүний шинжилгээ, уян налархайн индекс, уян налархайн модуль болон ижил байдлын коэффициентийг 250 м$^3$ тутамд дор хаяж нэг удаа тодорхойлно.

Материалын үе бүрийг нягтруулахын өмнөх чийгийн агуулгын шинжилгээг нягтруулсан материалын үе бүрийн эсвэл хэсгийн дор хаяж 500 м$^2$ тутамд нэг удаа явуулна. Хатах буюу норсоноос шалтгаалж материалын чийгийн агуулга өөрчлөгдөх үед эсвэл өмнөх шинжилгээний дүн нь тодорхой бус байвал чийгийн агуулгын шинжилгээг давтан явуулна.

Талбайн хуурай нягтыг нягтруулсан материалын үе бүрийн дор хаяж 250 м$^2$ тутамд нэг удаа тодорхойлох буюу эсвэл шинжилгээ хийлгэх шаардлагатай хэсэг бүрт дор хаяж гурван шинжилгээг явуулна.

(vi) Буталсан чулуун суурь

AASHTO T180 хамгийн их хуурай нягт ба тохиромжтой чийгийн агуулга, элэгдэл, сульфат натрийн бат бэх, үелэлийн индекс ба ус шингээлтийг материалын шинэ эх үүсвэр бүрт болон үйлдвэрлэсэн материалын 500 м$^2$ тутамд дор хаяж нэг удаа тодорхойлно.

Суурьт хэрэглэсэн материалын ширхэглэлийн бүрэлдэхүүнийг 250 м$^3$-т дор хаяж нэг удаа тодорхойлно.

Материалын үе бүрийг нягтруулахын өмнөх чийгийн агуулгын шинжилгээг нягтруулсан материалын үе бүрийн эсвэл хэсгийн дор хаяж 500 м$^2$ тутамд нэг удаа явуулна. Хатах буюу норсоноос шалтгаалж материалын чийгийн агуулга өөрчлөгдөх үед эсвэл өмнөх шинжилгээний дүн нь тодорхой бус байвал чийгийн агуулгын шинжилгээг давтан явуулна.

Талбайн хуурай нягтыг нягтруулсан материалын үе бүрийн дор хаяж 250 м$^2$ тутамд нэг удаа тодорхойлох буюу эсвэл шинжилгээ хийлгэх шаардлагатай хэсэг бүрт дор хаяж гурван шинжилгээг явуулна.

(vii) Битумэн хучилтын ажлууд

(А) Барьцалдуулагч

AASHTO T144, T49 ба T202-ийн дагуу шинжилгээг ажлын өдөр бүр, талбайд татан авчирсан 20,000 литр тутамд дор хаяж нэг удаа явуулна. Зүйл 209-ийн шаардлагыг хангах шинжилгээнүүдийг талбайд татан авчирсан 20,000 литр тутамд дор хаяж нэг удаа явуулна.

(Б) Хайрга

Дор жагсаасан хайрганы шинж чанарыг хайрганы шинэ эх үүсвэр бүрийг нээсний дараа болон хайрганы шинж чанар өөрчлөгдсөн байж магадгүй гэж инженер үзсэн

тохиолдолд, түүнчлэн үйлдвэрлэсэн материалын 500 $м^3$ тутамд дор хаяж нэг удаа тодорхойлно.

- Ширхэглэлийн бүрэлдэхүүн
- Лос анжелесийн элэгдэл
- Сульфат натрийн бат бэх
- Үелэлийн индекс
- Элсний эквивалент
- Уусдаг давс ба хорт бодис
- Хольсон хайрга дахь бодит болон илэрхий хувийн жин
- Сүвшил

(В) Эрдэс нунтаг

Ширхэглэлийн бүрэлдэхүүн болон задгай үеийн нягтыг ашигласан нунтгийн 50 тонн тутамд нэг удаа болон нунтгийн эх үүсвэр өөрчлөгдөх үед тодорхойлно.

(Г) Битумэн хольц (холих төхөөрөмжөөс)

Тодорхойлогдсон орцны төрөлд тохирох битумэн хольцийн дараахи шинж чанарыг холих төхөөрөмжөөс гарсан дээжийг 4 цаг тутамд тодорхойлно.

- Битумын агуулга,
- Ширхэглэлийн бүрэлдэхүүн,
- Маршалын тогтвортой байдал,
- Хөдөлгөөн
- Шингэсэн ус
- Сүвшил

(Д) Битумэн хольц (нягтруулсан үеэс авсан цилиндрэн дээж)

Битумэн хольцын дараахи шинж чанарыг нягтруулсан үеэс тасалж авсан цилиндрэн хэлбэрийн хос дээжний хольцны 600 $м^2$ тутамд дор хаяж нэг удаа тодорхойлно. Үүнд:

- Битумын агуулга
- Ширхэглэлийн бүрэлдэхүүн
- Нягт
- Сүвшил

## 221 ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР

Материалын шинжилгээ, барилгын туршилт болон барилгын хяналтын шинжилгээнд зориулж тусдаа хэмжилт болон төлбөр хийгдэхгүй. Гүйцэтгэгч нь үнэлгээ болон үнэндээ энэхүү техникийн шаардлагын бүлэг 200-ийн бүх шаардлагыг хангах зардлыг тусгасан гэж тооцно.

# БҮЛЭГ 300 – УЛААН ШУГАМ ТАВИХ БА ХҮЛЦЭХ АЛДАА

## БҮЛЭГ 300 – УЛААН ШУГАМ БА ХҮЛЦЭХ АЛДАА


| | | |
|---|---|---|
| 301 | УЛААН ШУГАМ | 3-3 |
| | (а) Ерөнхий | 3-3 |
| | (б) Нарийвчилсан хэмжилт | 3-4 |
| 302 | ХҮЛЦЭХ АЛДАА | 3-5 |
| | (а) Замын хэвтээ элемент | 3-5 |
| | (б) Хучилтын үеүдийн зузаан | 3-5 |
| | (в) Далан ба хучилтын үеүдийн өндөржилт | 3-5 |
| | (г) Хучилтын тэгш байдал | 3-6 |
| | (д) Далан ба ухмалын налуу | 3-6 |
| | (е) Далан ба ухмалын өргөн | 3-6 |
| | (ё) Хажуугийн шуудууны гүн | 3-6 |
| | (ж) Бетон байгууламжууд | 3-6 |
| | (i) Тулгуур хэсгийн бетон элементүүд | 3-6 |
| | (ii) Тулах хэсгийн бетон элементүүд | 3-7 |
| | (з) Барилгын ажлын хяналт, шинжилгээ | 3-7 |
| 303 | ХҮЛЦЭХ АЛДААНААС ЗӨРҮҮТЭЙ АЖЛЫГ ЗАСАХ | 3-7 |
| | (а) Газар шорооны ажил | 3-7 |
| | (б) Хөлдөлтөөс хамгаалах үе /300 мм/ | 3-7 |
| | (в) Суурь болон чулуун суурь үе | 3-8 |
| | (г) Асфальт бетон хучилт | 3-8 |
| 304 | ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР | 3-8 |

## 301 УЛААН ШУГАМ ТАВИХ, ГАДАСЛАГАА ХИЙХ

(а) Ерөнхий

Инженер нь барилгын улаан шугамыг тавихад хангалттай хайгуулын мэдээллийг гүйцэтгэгчид өгөх ба гүйцэтгэгч бүх шаардлагатай хяналтын цэгүүдийн гадаслагааг хийж, тэдгээрийг арчилж хамгаалах хариуцлагыг хүлээнэ. Улаан шугам тавих, гадаслагаа хийх нь үндсэн ажлыг гүйцэтгэхэд зайлшгүй дагалдан хийгдэх ажил гэж үзэх бөгөөд үүнийг гүйцэтгэгч өөрийн зардлаар хийх ба үүнд тусад нь төлбөр шаардагдахгүй. Гүйцэтгэгч хайгуулын үндсэн мэдээлэл, гадаслагааны деталиудыг хүлээн авмагцаа анхны хяналтын цэг, шугам, төвшин ба хэмжилтүүдийн нарийвчлалыг тодруулж бодитоор шалгана.

Хэрэв гүйцэтгэгч инженерийн өгсөн хайгуулын мэдээлэлд ямар нэгэн алдаа юмуу зөрүү байгааг олвол инженерт нэн даруй мэдэгдэх ёстой. Хэрэв мэдээлсэн алдаа нь үнэн байвал засварласан зураг юмуу алдааг залруулахтай холбогдсон зааврыг инженер өгнө.

Барилгын ажил эхлэхээс өмнө гүйцэтгэгч нь анхан шатны хэмжилтийн цэгүүд болох, Монгол улсын геодезийн координатын (өндрийн) цэгүүдтэй холбогдсон, замын трассын дагууд байгаа репер болон хэвтээ хяналтын цэгүүдийн (өнцгийн орой, хэвтээ муруйн эхлэл, төгсгөлийн цэг г.м) байршил, бэхэлгээ зэргийг шалгаж, зөвлөхийн хэмжилтийн инженерээс хүлээн авна. Үндсэн реперүүд нь замын ихэнх хэсэгт хоорондоо 2 км-ээс ихгүй зайд, гол төлөв замын зурвасын гадна, өнцгийн оройны ойролцоо байрлалтай байгаа. Гүйцэтгэгч цаашид туслах реперүүдийг замын дагууд хооронд нь 200м-ээс ихгүй зайнд, замын тэнхлэгээс гадагш 50м-ээс багагүй зайнды, аль болох өндөрдүү газарт байрлуулж бэхлэнэ. Бэхэлгээг дараах байдлаар хийнэ. Үүнд: 250х250х400мм хэмжээтэй бетон блок цутгаж, түүндээ 22мм-ийн диаметртэй, 200мм урт төмөр гадсыг блокын дээд гадаргуугаас 20мм дээш цухуйлган суулгаж бэхжүүлсэний дараа уг хийцийг туслах репер байрлуулах цэгт хатуу хөрстэй газарт ухаж суулган, эргэн тойрны газрыг сайтар жигжиж булна. Блокын дээд ирмэг газрын төвшинтэй ижил байх ба дээд гадаргуу дээр тухайн реперийн дугаарыг арилдаггүй будгаар тод бичсэн байна. Газарт суулгасан блокоос хааш хааш 0,5м-т 200мм гүнтэй шуудууг эргэн тойронд нь ухаж, гарсан шороог шуудууны гадна талаар овоолж орхино. Ухсан шуудууны аль нэг өнцөгт төмөр буюу модон гадсыг 400-500мм ил цухуйж байхаар суулгана. Туслах реперүүдийг байрлуулж бэхэлсэний дараа тэдгээрийг үндсэн реперийн цэгүүдтэй холбож өндөржилтийг тогтооно.

Гэрээний нөхцөл ба энэхүү техникийн шаардлагын зүйл 107-д заасны дагуу бүх реперүүд, хэвтээ хяналтын цэгүүдийг барилга ашиглалтад хүлээлгэж өгсөн гэрчилгээг олгох хүртэл, инженерийн шаардлагыг хангах хэмжээнд арчилж хамгаалах ажлыг гүйцэтгэгч хариуцна. Гүйцэтгэгч нь бүх реперийн болон хэвтээ хяналтын цэгүүдийн өндөржилт, координат, байршилыг үзүүлсэн хүснэгтийг инженерт гарган өгч байхын дээр хэмжилтийн ажлын шинэчлэгдсэн мэдээллээр байнга хангах үүргийг хүлээнэ.

Гүйцэтгэгч нь улсын геодезийн сүлжээний өндрийн тэмдэгтүүд болон зургийн тэмдэгтийг эвдэж, гэмтээх болон зайлуулж болохгүй. Барилгын ажилд саад болох магадлалтай тэмдэгтүүдийн талаар гүйцэтгэгч инженерт мэдэгдэх ба тэдгээрийг зайлуулах буюу шилжүүлэн байршуулахад шаардагдах арга хэмжээний талаар холбогдох байгууллагатай харьцаж, шийдвэрлэх ажлыг инженер хариуцна. Хэрэв өндрийн тэмдэгтүүдийг инженерийн зөвшөөрөлгүйгээр зайлуулах болон хөндсөн тохиолдолд түүнийг дахин суурилуулах зардал болон үүнээс үүдэн гарах төлөвлөгөөний тасалдлын хариуцлагыг гүйцэтгэгч хүлээнэ.

Гүйцэтгэгчийн талаас алдаатай хэмжилт хийснээс болж ажлын явцад ямар нэгэн хэмжилтийн ажлыг нэмж хийх шаардлага гарвал буруу хийгдсэн ажлыг гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр засч гүйцэтгэнэ.

(б) Нарийвчилсан хэмжилт, гадаслагааны ажил

Репер болон хэвтээ хяналтын цэгүүдийг хүлээн авсаны дараа гүйцэтгэгч тэдгээрийн координат, өндөржилтийг нарийвчлан шалгаж, үр дүнг инженерт танилцуулж зөвшөөрөл авна. Үүний дараа замын дагууд суулгаж бэхэлсэн туслах реперүүдийн өндөржилтийг үндсэн реперийн өндөржилттэй холбож тогтоон үр дүнг инженерээр

батлуулна.

Гүйцэтгэгч нь энэхүү техникийн шаардлагын зүйл 301 /а/-д заасны дагуу замын тэнхлэгийн шугамыг зурагт үзүүлснээр (Инженерийн зааварчилсанаар тэдгээрийг дахин хянаж үзсэн аливаа зүйлийг бодолцон) 20м-ээс ихгүй буюу түүнээс богино зайтайгаар гадаслах бөгөөд техникийн шаардлагын зүйл 302-т заасан хүлцэх алдааны дотор барилгын ажлыг гүйцэтгэхийн тулд хугарлын цэгт болон зарим онцлог газарт гадаслагаа хийхэд эдгээр богино зайг ашиглах шаардлагатай болно.

Гадаслагааг хийсний дараа гүйцэтгэгч улаан шугам тавьсан замын тэнхлэгийн дагууд, пикет болон нэмэх цэгүүдийн зай хэмжээ, газрын өндөржилтийг нарийвчлан шалгаж, газрын төвшний дагуу ба хөндлөн огтлолыг замын нийт өргөнд тодорхойлох хэмжилтийг гүйцэтгэнэ. Мөн үүнтэй адилаар замын тэнхлэгийн дагуух бүх төлөвлөгдсөн хоолой ба байгууламжуудын хөндлөн, дагуу хэмжилтийг гүйцэтгэнэ. Төлөвлөгдсөн гүүр, хоолойны тэнхлэгийн дагууд газрын төвшинг тодорхойлохдоо замын тэнхлэгээс хоёр тийш инженерийн зааварчилсан хязгаар хүртэл, тодорхой зайнд хэмжилтийг гүйцэтгэнэ.

Бүх холбогдох мэдээллийг (дугаар, байршил, төвшин г.м) угаагдаж арилдаггүй будгаар, тодорхой тэмдэглэж бичсэн лавлагааны гадас, налуугийн самбарыг ухмал ба өндөрлөгөөний налуу, хучилтын үеүдийн төвшинг ямар ч үед шууд тодорхойлох боломжтойгоор, замын тэнхлэгтэй перпендикуляраар, замаас тодорхой зайнд байрлуулна. Эдгээр нь гүйцэтгэгчид барилгын ажлыг шалгах, хянах зориулалтаар ашиглагдана. Талбайн цэвэрлэгээг хийж дуусмагц гүйцэтгэгч нь лавлагааны 50х50х1200мм хэмжээтэй модон гадсыг хөрсийг нь хуулсан талбайн хоёр захаас гадагш 0,5-0,8м зайнд, 400мм гүн суулгана. Тэнхлэгийн дагууд байрлах лавлагааны гадаснуудын хоорондын зай 20м-ээс ихгүй байна. Гадасны газраас дээш ил гарсан хэсгийг цагаанаар будсан байна. 25 мм-ийн урттай хадаасыг гадсан дээр үе тус бүрийн өндрөөр зоох ба хадаасны толгой нь хэмжилт хийх цэг ба замын тэнхлэгийг зааж өгнө. Гадсан дээр пикетийн дугаар болон тэнхлэгээс хуулсан хөрсний зах хүртлэх цэвэр зайг инженерийн шаардлагад нийцүүлэн тод, арилахааргүй тэмдэглэсэн байна. Замын дагууд хийгдсэн бүх гадаслагааг гүйцэтгэгч нь шаардлагатай хугацааны туршид арчлан хамгаалж, эвдрэл гэмтэл гарсан бол нэн даруй засварлаж, тэмдэглэгээг тогтмол сэргээж байна.

Хэмжилтийн ажлыг электрон дуран (total station) багажны тусламжтайгаар гүйцэтгэх ба өгөгдлийг инженерийн зөвшөөрсөн формат ба нарийвчлалын стандартын дагуу нэгтгэн боловсруулна. Хөндлөн огтлолын зургийг тохиромжтой программ хангамж ба зураг боловсруулагчийг ашиглан 1:200 масштабтайгаар хэвлэж өгөх ба боловсруулсан өгөгдлийн төслийг зөвшөөрөлцөхөөр инженерт танилцуулна. Дагуу огтлолын зургийг хэвтээд 1:2,000 масштабтай босоод 1:200-гийн масштабтайгаар боловсруулна. Замын тэнхлэгийг хэвтээд 1:2,000 масштабтайгаар боловсруулна. Гүйцэтгэгч хөндлөн огтлолыг зөвшөөрөгдсний дараа шаардлагатай нэмэлт өөрчлөлтүүдийг хийж болно.

Инженер нь нэмж засварлан зөвшөөрөлцсөн хөндлөн огтлолын болон бусад зургийг гүйцэтгэгчээс авсанаас хойш 28 хоногийн дотор зам, хоолой, бусад байгууламжуудын байрлал ба төвшинг эцсийн байдлаар гаргаж явуулна. Гүйцэтгэгч нь нэг удаад 5 км-ээс багагүй урттай замын хөндлөн огтлолыг танилцуулна. Хөндлөн огтлолыг танилцуулах замын ердийн урт 10 км байна. Хэрэв гүйцэтгэгч 28 хоногийн хугацаанд 10 км-ээс илүү хэсгийн хөндлөн огтлолыг боловсруулж танилцуулбал инженерээс төвшингийн эцсийн зөвшөөрлийг олгох анхны 28 хоногийн хугацааг нэмэлт 10 км тутамд 28 хоногоор сунгана. Инженерийн зааварласан зам, хоолой ус зайлуулах байгууламжуудын эцсийн төвшин нь зурагт үзүүлсэнээс өөр байж болно. Гүйцэтгэгч нь тендерийн бичиг баримтыг танилцуулахдаа болон дэд зүйл 14.1-ийн дагуу ажлын хөтөлбөр, бусад дараа дараагийн хөтөлбөрүүдээ бэлтгэхдээ энэхүү зүйлийн шаардлагуудыг харгалзан үзсэн гэж тооцогдоно.

Гүйцэтгэгч эцсийн байдлаар засагдсан зам, хоолой ба бусад байгууламжуудын өгөгдлийг програмд оруулан хөндлөн огтлолын зургийг боловсруулан гаргана. Гүйцэтгэгч эцсийн байдлаар боловсруулагдан гаргасан дагуу болон хөндлөн огтлолын зургийн хэвлэмэл болон дискэнд бичигдсэн тус бүр нэг хувийг инженерт үнэ төлбөргүйгээр өгнө.

Далангийн дүүргэлтийн газар шорооны ажлыг дуусангуут, гэхдээ хүйтэнд тэсвэртэй

далангийн дээд үе болон хучилтын үеүдийн ажлыг эхлэхээс өмнө гүйцэтгэгч нь төмөр гадсуудыг өндөрлөсөн далангийн хоёр талын ирмэгт, замын тэнхлэгээс ижил хэмжээтэй тогтмол зайнд, аль болох бөх суулгана. Ухмалд болон өндөрлөгөөтэй хэсэгт талбайн нөхцлөөс шалтгаалан тэнхлэгээс гадас хүртлэх зай өөрчлөгдөж болох ба ийм тохиолдолд инженерийн зөвшөөрсөн зайнд суулгана. Далангийн гадаргуугаас дээш ил байх гадасны өндөр нь 1м-ээс багагүй байна. Төмөр гадсан дээр зорчих хэсгийн хөндлөнгийн аль ч цэгт замын тэнхлэг болон төвшинг нарийн утас ашиглан шууд тодорхойлоход шаардлагатай бүх холбогдох мэдээллийг арилахгүйгээр тэмдэглэсэн байх ёстой. Гадаснуудын хоорондох зай нь 20 м-ээс ихгүй байх ба инженер ажлыг шалгахад шаардлагатай гэж үзсэн бүхий л хугацааны туршид гүйцэтгэгч тэдгээрийг засварлан сэргээж байна. Инженерийн урьдчилсан зөвшөөрөлгүйгээр гүйцэтгэгч аль нэг гадсыг хөдөлгөж болохгүй.

## 302 ХҮЛЦЭХ АЛДААНУУД

(а) Хэвтээ чиг

Замын хэвтээ чиг нь зурагт үзүүлсэн юмуу зурагнаас тооцож гаргасан замын хучилтын тэнхлэгээс тодорхойлогдоно. Дэвссэн хучилтын тэнхлэг ба түүнтэй зэрэгцээ орших бусад чигийн нарийвчлал ± 10 мм-ийн дотор байвал зөв гэж үзнэ.

(б) Хучилтын үеүдийн зузаан

Дурын 100 метрийн дотор 5 цэгт хэмжсэн хучилтийн аль ч үеийн дундаж зузаан нь инженерийн зааварласан юмуу тогтоосон зузаанаас 100%-иас багагүй, 120%-иас ихгүй байна. Үүний дээр, хучилтын аль ч үеийг дурын цэгт хэмжсэн зузаан нь инженерийн зааварласан юмуу эсвэл техникийн шаардлагад зааснаас 95%-иас бага, 120%-иас их байх ёсгүй.

(в) Далан ба хучилтын үеүдийн гадаргуугийн төвшин

Хучилтын үеүдийн болон далангийн дээд үеийн гадаргуугийн аливаа цэгт хэмжсэн төвшин ба зурагнаас тооцсон зохих төвшингийн хоорондох зөрүү нь хүснэгт 3-1-д үзүүлсэн хүлцэх алдаанаас илүү байх ёсгүй.

Хүснэгт 3-1-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг баталгаажуулахын тулд, инженерийн сонгосон цэгүүдэд, замын тэнхлэгийн дагууд 10 м тутамд, тухайн үеийн голд болон хоёр захад гадаргуугийн төвшинийг хэмжихээс гадна гол замын суурийн болон өнгөн хучилтын гадаргуу дээр тэнхлэгээс хоёр тийш хөндлөнд 1.75м-т, салаа замын суурийн болон өнгөн гадаргуу дээр тэнхлэгээс хоёр тийш хөндлөнд 1.0м-т тус тус нэмэлт хэмжилт хийнэ. Уулзвар дээр төвшинг торон хэмжилтийн аргаар хийх бөгөөд цэгүүдийн байршлыг инженер тодорхойлно.

(г) Хучилтын тэгш байдал

Инженерийн сонгосон газарт 3 м-ийн төмөр рейкийг замын тэнхлэгт паралель буюу перпендикуляраар байрлуулж хучилтын үеүдийн болон далангийн дээд үеийн гадаргуугийн жигд байдлыг шалгана. Рейкийн доор гарах зайн хамгийн их зөвшөөрөгдөх хэмжээг хүснэгт 3-1-д үзүүлэв.

Үүнээс гадна зурагт заасан дагуугийн болон хөндлөнгийн налуу нь хүснэгт 3-1-т үзүүлснээс зөрөх ёсгүй.

**Хүснэгт 3-1: Хучилтын үеүдийн болон далангийн дээд үеийн гадаргуугийн хүлцэх алдаа**

| Үеүд | Гадаргуугийн төвшингийн хамгийн их гажилт | 3м-ийн рейкийн доорх хамгийн их зай | Хөндлөн болон налуугийн хамгийн их гажилт |
|---|---|---|---|
| Асфальт бетон хучилт | ± 5 мм | 3 мм | ±0.20% |
| Суурь | ±10 мм | 8 мм | ±0.25% |

| | | | |
|---|---|---|---|
| Суурийн доод үе ба хөвөө | ± 15 мм | 12 мм | ±0.40% |
| Далангийн дээд үе | ± 25 мм | 20 мм | ±0.50% |

(д) Далан ба ухмалын налуу

Засаж тэгшилсэн ба нягтарсан ухмал ба далангийн налуугийн хүлцэх хэмжээ +0,20 байхыг зөвшөөрнө. Өөрөөр хэлбэл, хэрэв далангийн налуу нь 1: 2 (босоо 1-д хэвтээ 2) бол огцом налуугийн зөвшөөрөгдөх хэмжээ нь 1-д 2-оос ихгүй (Б:Х), аажим налуугийн зөвшөөрөгдөх хэмжээ нь 1-д 2,2-оос илүүгүй (Б:Х) байна гэж ойлгоно.

(е) Далан ба ухмалын өргөн

Замын тэнхлэгээс ухмалын хажуу налуугийн доод зах хүртэл хэмжсэн хэвтээ зай нь ± 200 мм байх ба энэ нь ухмалын ёроолын өргөний зөвшөөрөгдөх хүлцэх алдаа болно.

Замын тэнхлэгээс дүүргэлтийн налуугийн дээд зах хүртэл хэмжсэн далангийн өргөн нь ба зурагт үзүүлснээс багагүй, эсвэл зурагт үзүүлсэнээс +100 мм-ээс ихгүй байна.

(ё) Хажуугийн шуудууны гүн

Тэгшилсэн хөвөөний ирмэг ба хажуугийн шуудууны ёроолын төвшингийн зөрүүгээр хэмжигдсэн шуудууны гүн нь зурагт үзүүлсэн гүнээс багагүй, эсвэл мөн хэмжээнээс 100 мм-ээс ихгүй байна.

(ж) Бетон байгууламжууд

(i) Тулгуур хэсгийн бетон элементүүд

Тулгуур хэсгийн бетон элементийн хүлцэх алдааг хүснэгт 3-2-т үзүүлэв.

**Хүснэгт 3-2: Тулгуур хэсгийн бетон элементүүдийн хүлцэх алдаанууд**

| Ангилал | Хүлцэх алдаа |
|---|---|
| Тогтоосон хөндлөн огтлолын хэмжээсүүдийн гажилт | + 10 мм, - 5 мм |
| Тогтоосон байршлаас шилжүүлэх зөрүү | 10 мм |
| Гадаргуугийн дээд хэсгийн тогтоосон өндрийн гажилт | ±10 мм |
| Тогтоосон тулгуур хэсгийн өндрийн зөрүү | ±5 мм |
| Нийт өндрийн эгцлүүрийн гажилт | 10 мм |
| 3м гадаргуугийн тэгш байдлыг шалгах шугамын доорхи гадаргуугийн тэгш байдлын гажилт, тулгуурын хэсэгт | 3 мм |
| 3м гадаргуугийн тэгш байдлыг шалгах шугамын доорхи гадаргуугийн тэгш байдлын гажилт, бусад бүх газарт | 5 мм |

(ii) Тулах хэсгийн бетон элементүүд

Тулах хэсгийн бетон элементийн хүлцэх алдааг хүснэгт 3-3-т үзүүлэв.

**Хүснэгт 3-3: Тулах хэсгийн бетон элементийн хүлцэх алдаанууд**

| Ангилал | Хүлцэх алдаа |
|---|---|
| Хавтан дам нуруу, хайрцган дам нуруу, Т | + 10 мм, - 5 мм |

| | |
|---|---|
| хэлбэрийн дам нурууны зузааны гажилт | |
| Торны зузааны өөрчлөлт | + 10 мм, - 5 мм |
| Нийт өргөн, гүний өөрчлөлт | ±5 мм |
| Шонгийн хоорондох нийт зай болон уртын гажилт | ±10 мм |
| 3м гадаргуугийн тэгш байдлыг шалгах шугамын доорхи гадаргуугийн тэгш байдлын гажилт | 5мм |

(з) Барилгын ажлын хяналтын шинжилгээ

Хэрэв өөрөөр заагаагүй бол, энэхүү техникийн шаардлагад тодорхойлсон хэмжээ нь хамгийн бага буюу хязгаарлагдмал хэмжээ бөгөөд төслийн чанарын хяналтын төлөвлөгөөнд тусгагдсанаар юмуу эсвэл техникийн шаардлагын бүлэг 200-д тогтоосон давтамжаар хийгдсэн бүх туршилт, шинжилгээ нь тухайн хэсгүүдэд тодорхойлсон хэмжээтэй хамгийн багаар авахад тэнцүү байх нөхцөлд ажлыг хангалттай болсон гэж үзнэ.

## 303 ХҮЛЦЭХ АЛДААНААС ЗӨРҮҮТЭЙ АЖЛЫГ ЗАСАХ

Аль нэг хүлцэх алдаа техникийн шаардлагын зүйл 302-т зааснаас зөрсөн тохиолдолд гүйцэтгэгч зөрүүтэй хийгдсэн хучилт, газар шорооны ажил, буюу далангийн дээд үеийн ажлын талбайг бүрэн хэмжээгээр тодорхойлж, дор дурдсан байдлаар дахин засч янзална. Дахин засварлах талбайн хамгийн бага хэмжээ нь өнгөн хучилтаас бусад үеүдэд 3м өргөн, 30м урттай байна. Харин асфальтбетон хучилтын засварыг нийт өргөнөөр нь хуулж авч хийх ба уртыг инженер тодорхойлно. Гүүр хоолойны хувьд:

(а) Газар шорооны ажил

Хэрэв ухмалын налуу нь заагдсан налуугаас илүү огцом, далангийн налуу нь илүү хавтгай байвал налууг заагдсан хэмжээнд хүртэл засаж тэгшилнэ. Хэрэв далангийн налуу нь заагдсан хэмжээнээс илүү огцом байвал гүйцэтгэгч налууг шатлан ухаж гарсан материалыг зайлуулаад, оронд нь ижил төрлийн дүүргэгч материалыг дэвсэж нягтруулан налууг тэгшлэх ажлыг техникийн шаардлагын бүлэг 500-д нийцүүлэн гүйцэтгэнэ. Ухмалын налуу нь заагдсанаас хавтгай болсон бол илүү ухсан газар шорооны ажилд төлбөр хийгдэхгүй бөгөөд хэрэв илүү ухсанаас хөрсний тогтворгүйжил үүсэх буюу элэгдэлд орвол гүйцэтгэгч өөрийн зардлаар зохих шаардлагын хэмжээнд засварлах ёстой.

Хэрэв ухмалын өргөн заагдсан өргөнөөс бага, эсвэл далангийн өргөн тогтоосон хэмжээнээс их байвал гүйцэтгэгч ухмал ба даланг заасан хэмжээнд хүртэл засаж тэгшилнэ. Ухмалын өргөн нь заагдсан өргөнөөс их буюу далангийн өргөн заагдсанаас бага байгаа хэсэгт гүйцэтгэгч техникийн шаардлагын бүлэг 500-гийн дагуу налууг шаталж дүүргэгч материал дэвсэж нягтруулан налууг тэгшилж засна.

Хэрэв хажуугийн шуудууны гүнийг заагдсан гүнээс бага хийсэн бол зохих хэмжээнд хүртэл нь тэгшилж янзална. Өөрийн шуудууны гүнийг заагдсан хэмжээнээс илүү гүнтэйгээр гүйцэтгэсэн хэсэгт гүйцэтгэгч тогтоосон гүнд хүртэл хөрсийг сийрэгжүүлэн, зохистой дүүргэгч материалыг дэвсэн ХИХН-ийг наад зах нь 90% (AASHTO T180) байхаар нягтруулна.

Далангийн өндөрлөгөө, хиймэл байгууламжийн ойролцоох буцаан дүүргэлтийн ажлын чанарын шинжилгээний дүн нь техникийн шаардлагад заасан хэмжээнд хүрэхгүй байгаа хэсэгт гүйцэтгэгч үеийн нийт зузаанд дахин боловсруулалт хийнэ. Дахин засварлах талбай нь зөвшөөрөл авахаар танилцуулсан нийт хэсэг бүхлээрээ байх юмуу эсвэл шинжилгээний үр дүн муу гарсан байршлаас инженерийн саналаар хоёр тийш дор хаяж 50м-ийн уртад, уг хэсгийн нийт өргөнөөр тогтоосон хэсэг байна.

(б) Шороон далангийн төвшингийн доорхи хөлдөлтөөс хамгаалах үе /300 мм/

Далангийн дээд үеийн төвшин ба өргөн нь хүлцэх алдааны хасах тал руу хэтэрсэн бол, техникийн шаардлагад нийцүүлэх үүднээс үеийг нийт гүнд нь дахин засварлаж хийнэ.

Дахин хийх хэсэг нь дор хаяж 30 м урт, 3 м-ийн өргөнтэй байх буюу эсвэл инженерийн тодорхойлсон талбай байна. Харин тухайн үеийн төвшин ба өргөн нь хүлцэх алдааны нэмэх тал руу хэтэрсэн бол техникийн шаардлагад заасан хэмжээнд хүртэл хусаж, тэгшилж янзална.

Хэрэв далангийн дээд үеийн ажлын чанарын шинжилгээний дүн нь техникийн шаардлагад заасан хэмжээнд хүрэхгүй байгаа хэсэгт гүйцэтгэгч үеийн нийт зузаанд дахин боловсруулалт хийнэ. Дахин засварлах талбай нь зөвшөөрөл авахаар танилцуулсан нийт хэсэг бүхлээрээ байх юмуу эсвэл шинжилгээний үр дүн муу гарсан байршлаас инженерийн саналаар хоёр тийш дор хаяж 50м-ийн уртад, уг хэсгийн нийт өргөнөөр тогтоосон хэсэг байна.

(в) Суурь болон буталсан чулуун суурь үе

Хэрэв суурийн төвшин ба өргөн, түүнчлэн гадаргуугийн жигл байдал нь хүлцэх алдаанаас хэтэрсэн, мөн суурийн доод үеийн төвшин ба өргөн нь хүлцэх алдаанаас хасах тал руу зөрүүтэй байвал эдгээрийг нийт гүнд нь хуулан авч, дахин шинээр дэвсэх ажлыг техникийн шаардлагад нийцүүлэн хийнэ. Харин суурийн доод үеийн төвшин ба өргөн нь хүлцэх алдаанаас нэмэх тал руу хэтэрсэн, гэхдээ энэ нь 50мм-ээс их бол техникийн шаардлагад заасан хэмжээнд хүртэл хусаж, тэгшилж болох боловч инженер зөвшөөрөөгүй тохиолдолд үеийг нийт гүнд нь хуулан авч, дахин шинээр дэвсэнэ. Дахин хийх хэсэг нь дор хаяж 30 м урт, 3 м-ийн өргөнтэй байх буюу эсвэл инженерийн тодорхойлсон талбай байна.

Хэрэв суурь болон суурийн доод үеийн барилгын ажлын чанарын шинжилгээний дүн нь техникийн шаардлагад заасан хэмжээнд хүрэхгүй байгаа хэсэгт гүйцэтгэгч үеийн нийт зузаанд дахин боловсруулалт хийнэ. Дахин засварлах талбай нь зөвшөөрөл авахаар танилцуулсан нийт хэсэг бүхлээрээ байх юмуу эсвэл шинжилгээний үр дүн муу гарсан байршлаас инженерийн саналаар хоёр тийш дор хаяж 50м-ийн уртад, уг хэсгийн нийт өргөнөөр тогтоогдсон хэсэг байна.

(г) Асфальт бетон хучилт

Хучилтын зузаан нь хэтэрхий бага буюу техникийн шаардлагын зүйл 302-т заасан хүлцэх алдаанаас хасах тал руу хэтэрсэн байвал гүйцэтгэгч тухайн үеийг нийт зузаанаар нь, инженерийн тогтоосон уртад хуулан авч, шинэ хольцлыг дэвсэн техникийн шаардлагад заасан хэмжээнд хүртэл индүүдэж нягтруулна. Дахин шинээр хийх ажлыг нэг удаагийн ажиллагаагаар, хучилтын нийт өргөнөөр гүйцэтгэнэ. Хучилт хүлцэх алдаанаас нэмэх тал руу их хэмжээгээр зөрж, хэтэрхий зузаан тавигдсан тохиолдолд гүйцэтгэгч инженерийн зөвшөөрсөн тоног төхөөрөмжөөр, баталсан аргачлалыг баримтлан илүүдэл материалыг зорж зайлуулна.

Хэрэв асфальт бетон хучилтын чанарын шинжилгээний үр дүн нь техникийн шаардлагатай нийцэхгүй байвал гүйцэтгэгч тухайн үеийг нийт зузаанаар нь инженерийн тогтоосон уртаар хуулан авч, техникийн шаардлагын дагуу дахин шинээр хийнэ.

Дахин хийх талбай нь зөвшөөрөл авахаар танилцуулсан нийт хэсэг бүхлээрээ байх юмуу эсвэл шинжилгээний үр дүн муу гарсан байршлаас инженерийн саналаар хоёр тийш дор хаяж 15м-ийн уртад, уг хэсгийн нийт өргөнөөр тогтоогдсон хэсэг байна.

## 304 ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР

Техникийн шаардлагын зүйл 301, 302, 303-т тавигдсан шаардлагуудыг хангахтай холбогдсон зардлыг гүйцэтгэгч ажлын нэгж үнэ ба өртөгтөө оруулан тооцсон гэж үзнэ.

Энэхүү техникийн шаардлагын зүйл 302, 303-т заасныг үл харгалзан, газар шорооны ажил, хучилтын үеүдийн хэмжилт ба төлбөрийг инженерийн зааварласан цэвэр хөндлөн огтлол дээр үндэслэн хийх ба тогтоосон хүлцэх алдааны дотор байх гажилтын хувьд ямар нэг нэмэгдэл төлбөр хийгдэхгүй. Хэдийгээр эдгээр хүлцэх алдааны дотор байлаа ч гэсэн хөлдөлтөөс хамгаалах үе, хөвөө болон хучилтын бүх үеүдийн баригдсан дундаж зузаан нь зурагт үзүүлснээс бага байж болохгүй.

# БҮЛЭГ 400 - ТАЛБАЙН ЦЭВЭРЛЭГЭЭ

## БҮЛЭГ 400 - ТАЛБАЙН ЦЭВЭРЛЭГЭЭ


| | | |
|---|---|---|
| 401 | ТАЛБАЙН ЦЭВЭРЛЭГЭЭ | 4-3 |
| | (а) Ерөнхий | 4-3 |
| | (б) Бусад шаардлага | 4-3 |
| 402 | ӨНГӨН ХӨРСИЙГ ХУУЛАХ | 4-3 |
| 403 | ХААЛТ, ХАШЛАГА БА БАЙГУУЛАМЖИЙГ ЗАЙЛУУЛАХ | 4-3 |
| 404 | ХАШАА, МОД, ХААЛТЫН ХАМГААЛАЛТ | 4-4 |
| 405 | ХОЛБОО БОЛОН ЦАХИЛГААНЫ ШУГАМЫГ ӨРГӨХ, ШИЛЖҮҮЛЭХ | 4-4 |
| 406 | ХУДАГ ГАРГАХ | 4-4 |
| 407 | ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР | 4-4 |
| | (а) Зүйл: Талбайн цэвэрлэгээ | 4-4 |
| | (б) Зүйл: Холбоо, цахилгааны шугамыг өргөх, шилжүүлэх | 4-4 |
| | (в) Зүйл: Худаг гаргах | 4-4 |
| | (г) Зүйл: Хуучин замын бетон хучилтыг эвдэж зайлуулах | 4-4 |

## 401 ТАЛБАЙН ЦЭВЭРЛЭГЭЭ

(а) Ерөнхий

Талбайн цэвэрлэгээ гэдэг нь хаалт, саадыг буулгаж зайлуулах, өвс ургамал, хог шороо, материалын үлдэгдэл, өнгөн хөрсийг хуулах, цэвэрлэж зайлуулах, бут сөөг, үндэс, хожуул, мод зэргийг булгалах, сугалах, тэдгээрээс үүссэн нүхнүүдийг буцаан дүүргэж, янзлах гэх мэт ажлуудыг багтаасан тодорхойлолт юм.

Талбайн цэвэрлэгээ хийх ба хог хаягдлыг зайлуулах явцад Гүйцэтгэгч нь нийтийн болон хувийн өмчийг гэмтээхгүй ба замын хөдөлгөөнд саад учруулахгүй байхад бүрэн анхаарч, шаардлагатай арга хэмжээг авч ажиллана.

Талбайн цэвэрлэгээ хийгдэх газрууд нь Зурагт үзүүлсэн буюу Инженерийн зааварчилсан газрууд байна.

Гүйцэтгэгч өөрийн түр лагерь, орд газар, карьер, материал нөөцлөх талбай ба хаягдал зайлуулах газар болон Инженерийн зааварчилсан ажлын бусад талбайн цэвэрлэгээг хийнэ. Дээр дурдсан газрууд нь төлбөрт хамаарагдахгүй.

Инженер талбайн цэвэрлэгээний явцад буулгаж, зайлуулж болохгүй мод, бут эсвэл тусгай объектүүдийн талаар заавар өгч болно. Гүйцэтгэгч талбайн цэвэрлэгээний явцад нийтийн болон хувийн өмчийг гэмтээхгүй байх шаардлагатай бүх урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах ба хэрэв ямар нэгэн гэмтэл учруулбал гүйцэтгэгч гарсан хохиролыг бүрэн засах хариуцлагыг хүлээнэ.

Геологийн дүгнэлт дурьдсан хар саарал өнгөтэй ургамлын үндэс агуулсан шаварлаг өнгөн хөрсийг 500 мм-ийн зузаанд хуулах ажил талбайн цэвэрлэгээнд багтана.

(б) Бусад шаардлага

Инжнерийн зааврааp талбайн цэвэрлэгээг хийсэн бол цэвэрлэж зайлуулсан бүх материал нь Гэрээний нөхцлийн дэд зүйл 27.1-т хамаарна.

Гүйцэтгэгч нь ашигдагдахгүй материал, хог хаягдалыг цэвэрлэх, зайлуулахдаа олон нийт болон хувь хүмүүсийн тав тухыг алдагдуулалгүй, мөн байгаль орчныг хамгаалах шаардлагыг зөрчихгүйгээр гүйцэтгэнэ. Хаягдал зайлуулах газрыг Техникийн шаардлагын бүлэг 600-д заасны дагуу зохион байгуулна.

Хэрэв Гүйцэтгэгч барилгын үндсэн ажил эхлэхээс өмнө талбайг цэвэрлэсэн боловч барилгын ажил эхлэхэд аль нэг хэсэгт нь өвс ургамал ургасан байвал талбайн нэмэлт цэвэрлэгээг өөрийн зардлаар хийж гүйцэтгэнэ.

## 402 ӨНГӨН ХӨРСИЙГ ХУУЛАХ

Инженер өөрөөр заагаагүй бол, Гүйцэтгэгч нь талбайн цэвэрлэгээ хийгдэх хэсэгт өнгөн хөрсийг 200 мм-ийн зузаантай хуулж, ачиж, тээвэрлэн тогтоосон газарт зайлуулна.

Хэрэв Гүйцэтгэгч өнгөн хөрсийг заасан хэмжээнээс илүү гүнд хуулсан бол дүүргэлтийн материалыг зохих төвшинд хүртэл дэвсэж нягтруулах ажлыг өөрийн зардлаар гүйцэтгэнэ.

## 403 ХААЛТ, ХАШЛАГА БА БАЙГУУЛАМЖИЙГ ЗАЙЛУУЛАХ

Гүйцэтгэгч нь замын трассанд буюу бусад ажлын зурваст орсон хашаа байшин, барилга байгууламж, барилгын болон бусад байгууламжийн суурь, туурь үлдэгдэл, хуучин зам, замын байгууламж, овоо болон бусад зүйлийг Зурагт үзүүлсэний дагуу, эсвэл Инженерийн зааварчилснаар бүрэн буюу хэсэгчлэн буулгаж зайлуулна.

Гүйцэтгэгч нь барилга байгууламж, хашаа болон бусад зүйлсийг болгоомжтой задалж буулгаж цэвэрлэн, тус тусад нь хураана. Инженерийн үзсэнээр дахин ашиглах боломжгүй бүх материалыг Гүйцэтгэгч талбайгаас зайлуулан энэхүү техникийн шаардлагын 401 (б)-д заасны дагуу хаягдал зайлуулах цэгт аваачиж буулгана. Инженерийн үзсэнээр хэрэглэж болох бүх материал нь Захиалагчийн өмч байх бөгөөд Захиалагч тэдгээрийг ачиж явах хүртэл, эсвэл баталгаат засварын хугацаа дуусах хүртэл Гүйцэтгэгч хадгалан хамгаална.

Барилга байгууламж, барилгын болон бусад байгууламжийн суурь,туурь үлдэгдэл, хашаа болон бусад зүйлсийг буулгаж зайлуулсанаас үүсэх нүх, хонхорыг энэхүү техникийн шаардлагын зүйл 507-д заасан шаардлагын дагуу буцаан дүүргэж нягтруулна.

## 404 ХАШАА, МОД, ХААЛТ ЗЭРГИЙГ ХАМГААЛАХ

Инженер буулгаж зайлуулахгүйгээр хэвээр нь орхихыг зааварласан хашаа, хана, хаалт, мод, бут болон бусад зүйлийг ажил гүйцэтгэж байх явцад эвдэрч гэмтэхээс хамгаалсан шаардлагатай бүх урьдчилан сэргийлэх арга хэмжээг Гүйцэтгэгч авна. Үүнээс гадна горхи булаг, төгөл зүлэг зэргийг унаган төрхөөр нь хамгаалах ёстой. Зохих арга хэмжээг аваагүйгээс болж эдгээрт ямар нэг хохирол учирвал сэргээн засварлах ажлыг Гүйцэтгэгч өөрийн зардлаар хийж буюу хохирлыг бүрэн барагдуулна.

## 405 ХОЛБООНЫ БОЛОН ЦАХИЛГААНЫ ШУГАМЫГ ӨРГӨХ, ШИЛЖҮҮЛЭХ

Зам барилгын ажлын талбайд орсон холбооны болон цахилгааны шугамыг өргөх, шилжүүлэх ажлыг Гүйцэтгэгч нь Монгол улсад мөрдөж байгаа холбогдох хууль тогтоомж, стандартын дагуу гүйцэтгэнэ.

Энэ ажилтай холбогдсон төлбөрийг зөвхөн Инженерийн баталсанаар Гүйцэтгэгчид төлнө.

## 406 ХУДАГ ГАРГАХ

Зам барилгын ажилд хэрэглэх усыг хангах зорилгоор Гүйцэтгэгч худаг гарган ашиглаж болох ба ингэхдээ Монгол улсад мөрдөж байгаа холбогдох хууль тогтоомж, стандартыг мөрдөж ажиллана.

Худаг гаргахтай холбоотой зардлыг зөвхөн Инженерийн баталсанаар Гүйцэтгэгчид төлнө.

## 407 ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР

(а) Зүйл : Талбайн цэвэрлэгээ

Нэгж : Га

Зам барилгын ажил явагдах зурвасын дагууд хийгдэх талбайн цэвэрлэгээний (хог хаягдлыг ухаж цэвэрлэх, зайлуулах, өнгөн хөрсийг хуулах, зайлуулах, нөөц талбайд овоолох г.м орно) ажлыг Га-ээр хэмжинэ. Түр лагерь, шороон орд, карьер, нөөц материал, хаягдал материалын цэг, тэдгээрт хүрэх туслах замууд, суваг, шуудууны талбайн цэвэрлэгээний зардлыг Гүйцэтгэгч нэгж үнэ болон өртөгт багтаасан гэж тооцно.

Талбайн цэвэрлгээний ажлын үнэлгээнд дараахи зүйлсүүд багтана. Үүнд:

- өвс ногоо, хог шороо, бут ширэг болон бүх төрлийн бартаа саадыг цэвэрлэх, булгалж сугалах, зайлуулах,
- өнгөн хөрсийг 500 мм зузаантай хуулах,
- ургамлын үндсийг ховхлох, сугалж зайлуулах,
- шаардлагатай тээвэрлэлт,
- ажлыг бүрэн дуусгахад шаардагдах ажилчид, материал, багаж, техник дагалдах материалуудын нөхөн төлбөр,
- энэ техникийн шаардлагын зүйл 401, 402,403 болон 404-ийн шаардлагыг хангах.

(б) Зүйл : Холбоо, цахилгааны шугамыг өргөх, шилжүүлэх
Нэгж : P.S (Provisional Sum)

(в) Зүйл : Худаг гаргах
Нэгж : P.S (Provisional Sum)

(г) Зүйл : Хуучин замын бетон хучилтыг эвдэж зайлуулах
Нэгж : м3

# БҮЛЭГ 500- ГАЗАР ШОРООНЫ АЖИЛ

## БҮЛЭГ 500 - ГАЗАР ШОРООНЫ АЖИЛ


| | | |
|---|---|---|
| 501 | БҮЛГИЙН АГУУЛГА | 5-3 |
| 502 | ЕРӨНХИЙ | 5-3 |
| 503 | УХМАЛ МАТЕРИАЛЫН АНГИЛАЛ | 5-4 |
| | (а) Ердийн ухалт | 5-4 |
| | (б) Хучилтыг хуулах | 5-4 |
| | (в) Чулуу ухах | 5-4 |
| 504 | ДАЛАНГИЙН БЭЛТГЭЛ АЖИЛ | 5-4 |
| 505 | ДАЛАН БА ХҮЙТЭНД ТЭСВЭРТЭЙ ҮЕИЙГ БАРИХ | 5-4 |
| | (а) Далан барих | 5-4 |
| | (б) Хиймэл байгууламжийн буцаан дүүргэлтийн иатериал | 5-5 |
| | (в) Хүйтэнд тэсвэртэй үеийн ажил | 5-5 |
| 506 | НАМАГТАЙ БОЛОН БАМБАЛЗУУР ХӨРСИЙГ ЧУЛУУГААР ДҮҮРГЭХ | 5-6 |
| 507 | ГАЗАР ШОРООНЫ АЖЛЫН НЯГТРУУЛАЛТ | 5-6 |
| 508 | ХАЯГДАЛ МАТЕРИАЛ | 5-8 |
| 509 | НӨӨЦ ОРДУУД | 5-8 |
| 510 | НАЛУУГ ТЭГШИЛЖ ЗАСАХ | 5-9 |
| 511 | ХАЖУУГИЙН ШУУДУУ | 5-9 |
| 512 | УХМАЛЫН ХАЖУУ НАЛУУ ДАХЬ ТОГТВОРГҮЙ МАТЕРИАЛ | 5-9 |
| 513 | ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР | 5-9 |
| | (а) Зүйл: Шороон ордоос болон замын ухмалаас гарсан материалыг даланд хэрэглэх | 5-11 |
| | (б) Зүйл: Материалыг ухаж зайлуулах (ердийн ухалт) | 5-11 |
| | (в) Зүйл: Хатуу матераилыг ухаж зайлуулах | 5-11 |
| | (г) Зүйл: Ухмал дахь газрын хөрсийг ХИХН 95% хүртэл нягтруулах (AASHTO T199) | 5-12 |
| | (д) Зүйл: Хүйтэнд тэсвэртэй үе | 5-12 |
| | (е) Зүйл: Намагтай газрыг чулуугаар дүүргэх | 5-12 |
| | (ё) Зүйл: Хажуугын шуудуу | 5-12 |

## 501 БҮЛГИЙН АГУУЛГА

Энэ бүлэгт бүх ухмалын (хажуугийн шуудуу ба шаталсан ухалтыг оролцуулаад) ажил ба даланд дүүргэгч материалыг дэвсэх, нягтруулах, ул хөрсний нягтруулалт, хөлдөлтөөс хамгаалах үеийг хэлбэршүүлэх, шаардлага хангахгүй хөрсийг солих ажлууд багтана.

## 502 ЕРӨНХИЙ

Гүйцэтгэгч нь газар шорооны ажил эхлэхээс өмнө, Инженерийн зааврын дагуу талбайн цэвэрлэгээ болон өнгөн хөрсийг хуулах зэрэг ажлыг хийнэ. Газар шорооны бүх ажлыг зургийн дагуу юмуу Инженерийн зааврааp тогтоосон налуу, төвшин, гүн, өргөн, хүлцэх алдаа, өндрийг баримтлан хийнэ. Шаардлага хангаагүй газар шорооны ажлыг Гүйцэтгэгч өөрийн зардлаар сайжруулан хийнэ.

Ухмалаас гарсан зөвхөн тохиромжтой материалыг даланд хэрэглэж болно. Инженерийн саналаар тохирохгүй гэж үзсэн материалыг далангийн дүүргэлтэд хэрэглэхгүй. Тохиромжгүй материалд дараахи зүйлс багтах бөгөөд зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй. Үүнд:

- өнгөн хөрс, намгархаг болон хүлэр агуулсан хөрс, 2%-иас их органик бодис агуулсан материал юмуу амархан илжирдэг материал,
- шатамхай материал,
- хөөлт нь 2.5%-иас их материал,
- Урсалтын хязгаар нь 45%-иас их болон уян харимхайн модуль нь 20%-иас ихтэй материал,
- Бул чулуу, хад болон 75 мм-ээс том хэмжээтэй чулуу, өгөршсөн чулуу, галт уулын гаралтай материал,

Илүүдэл болон тохиромжгүй материалыг энэхүү техникийн шаардлагын бүлэг 600 заасан шаардлагын дагуу заасан газарт зөөж хаяна.

Хэрэв дүүргэлтийн материалыг ухмалаас авах боломжтой бол Гүйцэтгэгч нь шороон ордоос материал авахыг урьтал болголгүй ухмалын материалыг эхэлж ашиглах бөгөөд ингэхдээ Инженерээс өөрөөр зааварчлаагүй бол ухмалаас гарах тохиромжтой материалыг овоолж бэлтгэнэ. Ухмалаас гарсан тохиромжгүй материал, мөн хэрэгцээнээс илүү гарсан тохиромжтой материалыг заасан талбайд зөөж асгана.

Даланд шаардлагатай материалын эзлэхүүн нь ухмалаас гарсан материалаас илүү байвал гүйцэтгэгч Инженерийн зааврааp ухмалыг өргөтгөх юмуу эсвэл шинээр орд газар нээж болно.

Цаг агаарын нөхцлөөс юмуу замын хөдөлгөөнөөс шалтгаалан газар шорооны ажилд ямар нэгэн эвдрэл гэмтэл учруулахгүй байхад Гүйцэтгэгч цаг ямагт анхаарч ажиллана. Хэрэв ямар нэгэн эвдрэл гарвал Гүйцэтгэгч тухайн хэсгүүдэд техникийн шаардлагын нөхцлүүдийг хангасан засварыг хийх хүртэл Инженер ажлын зөвшөөрлийг буцаан авч болно. Энэ төрлийн засварын ажил болон нэмэлт шинжилгээ хийсэн ажлын зардлыг Гүйцэтгэгч хариуцна.

Гүйцэтгэгч далангийн дүүргэлтэд зөвхөн тохиромжтой материалыг ашиглана. Хэрэв ямар нэг тохиромжгүй материал ашиглагдсан бол түүнийг зайлуулан оронд нь тохиромжтой материал дэвсэх ажлыг Гүйцэтгэгч өөрийн зардлаар гүйцэтгэх болно.

Бүх ухмал, далан, хажуугийн шуудуу, хөвөө зэргийг тогтоосон налууд хүртэл тэгшилж засах ажлуудыг газар шорооны ажил явагдаж буй байршил, төвшинд нэг зэрэг хийнэ.

## 503 УХМАЛ МАТЕРИАЛЫН АНГИЛАЛ

Замын ухмалаас гарсан материалыг дараахи байдлаар ангилна:

(a) Ердийн ухалт

Ердийн ухалтын ажилд хатуу чулууг ухахаас бусад бүх ухалтын ажлууд орно.

Ердийн ухалтанд намагжсан хөрс, бусад тохиромжгүй материал мөн багтана.

**(б)** Хатуу материалын ухалт

Хатуу материалын ухалтанд Инженерийн шийдвэрээр тэсэлгээ хийж суллах юмуу ухахаас өмнө шингэн буюу хийн шахуургат төхөөрөмж ашиглан боловсруулалт хийх шаардлагатай хатуу хад чулуу багтана.

Хатуу материалын ухалтын үнэлгээнд тухайн нөхцөл байдалд шаардагдах бүх аргаар хийх ухалтын ажлууд орсон гэж тооцно.

0.75м$^3$-ээс том хэмжээтэй чулуунуудыг агуулсан зөөлөн хөрсийг ухаж зайлуулах ажил нь хатуу материалын ухалтын төрөлд орно. 0.75 м$^3$-ээс бага эзэлхүүнтэй бат бөх хатуу чулууг ухах ажил нь ердийн ухалтанд орно.

Хатуу чулуун материалыг далангийн гадаргуугаас доош 900 мм-ийн дотор дэвсэхгүй ба харин ухмалд зурагт үзүүлсэн төвшингөөс доош 300 мм-ийн гүнд эсвэл Инженерийн зааварчилсан гүнээр ухаж зайлуулна.

Ажил үргэлжлэн хийгдэх явцад материалын ангилалыг Инженерийн төлөөлөгч ба Гүйцэтгэгч хоорондоо зөвшөөрөлцсөн байна. Инженерийн үзсэнээр материалын ухалтыг дөхөмтэй болгоход тэсэлгээ зайлшгүй шаардлагатай нь тодорхой байлаа ч ухалтанд тэсрэх бодис ашиглаж байгааг чулууны хатуулгийн зэргийг өндөрсгөх шалтгаан болгож авч үзэхгүй. Материалын ангиллын талаар маргаан гарах тохиолдолд Инженерийн шийдвэр эцсийн бөгөөд дагаж мөрдөх шийдвэр байна.

## 504 ДАЛАНГИЙН БЭЛТГЭЛ АЖИЛ

Гадаргуугийн хөндлөн налуу нь 20%-иас ихтэй газарт өнгөн хөрсийг хуулсаны дараа Гүйцэтгэгч нь ул хөрсийг зурагт үзүүлсэнээр буюу Инженерийн зааварчилсаны дагуу шатлан ухна. Дэвсэх ба нягтруулах тоног төхөөрөмжийг ажиллах боломж олгох үүднээс дүүргэлтийн доод захын эхний шатлалыг хангалттай өргөнөөр ухна. Дүүргэлт хийж нягтруулсаны дараагаар дараагийн шатлалыг ухна. Шаталж ухсан ухмалаас гарсан материалыг зайлуулах буюу эсвэл Инженер ашиглахад тохиромжтой гэж үзсэн тохиолдолд дүүргэлтэнд ашиглана Шатлалын өндөр нь 200-300 мм юмуу эсвэл Инженерийн зааварчилснаар байна.

Далангийн доорхи болон ухмалын төвшингөөс 300мм-ийн доор байгаа ул хөрс, мөн шаталсан хөрсний нягтыг AASHTO T191-93 стандартын дагуу газар дээр нь шалгах ёстой ба хэрвээ ХИХН нь (AASHTO T99-94)-д тодорхойлсноор 95% бага байвал Инженерийн зааварласны дагуу баригдаж буй нийт өргөнд 150 мм буюу түүнээс илүү гүнд сэндийлж ХИХН 95% хүртэл нягтруулна. Нягтруулах үеийн чийгийн хэмжээ тохиромжтой чийгээс (AASHTO T99-94) нэмэх, хасах 2% -ын дотор байхаар хөрсийг жигд услах буюу материалыг хатаах замаар, нягтруулалт хийхээс өмнө далангийн доорхи ул хөрсний чийгийг тохируулна. Шатлалын ажилд тусад нь хэмжилт, төлбөр хийгдэхгүй. Далангийн бусад ажлын үнэлгээнд орсон гэж үзнэ.

Хэрэв далангийн доорхи ул хөрс нь дүүргэлтийг хүлээн авах суурь болж чадахгүй гэж Инженер үзсэн нөхцөлд Гүйцэтгэгч инженерийн заасан гүнд хүртэл ухаж, материалыг хаягдал зайлуулах газарт зөөж зайлуулах ба оронд нь тохиромжтой материалыг дэвсэж зохих хэмжээнд хүртэл нягтруулна. Солих материалд хатуу дүүргэгчийг оролцуулж болно.

## 505 ДАЛАН БА ХҮЙТЭНД ТЭСВЭРТЭЙ ҮЕИЙГ БАРИХ

(а) Далангийн дүүргэгч материал

Шороон орд болон замын ухмалаас гарсан, тохиромжгүй гэж үзсэнээс бусад хөрс, хайрга, элс буюу тэдгээр материалын холимгийг даланд хэрэглэнэ. Ухмалаас гарах материалын эзлэхүүн нь далангийн дүүргэлтийн ажилд хангалтгүй гэж Гүйцэтгэгчийн нотолж, Инженерийн зөвшөөрсөн тохиолдолд шороон ордоос материалыг авч хэрэглэнэ.

Материалыг зөвхөн чийг ихтэйгээс нь болоод тохиромжгүй материал гэж үзэхгүй.

Чийгтэй материалыг техникийн шаардлагад заасан чийгийн хэмжээнд нийцэх хүртэл нь борнойдох буюу бусад тохиромжтой аргаар сийрүүлж хатаана.

Шороон орд болон замын ухмалаас гарсан материалыг далангийн ажилд тохиромжтой, тохиромжгүй гэж ангилна.

Далангийн дүүргэгч материал нь энэхүү техникийн шаардлагын зүйл 502-т зааснаас гадна:

- ХИХН нь 1.75 т/м$^3$-ээс бага (AASHTO T180)
- 0,075мм-ийн шигшүүрээр өнгөрч байгаа нарийн ширхэглэлтэй хэсэг нь хуурай үеийн жингийн 45%-иас их байгаа тохиолдолд даланд хэрэглэхгүй.

Энэхүү техникийн шаардлагад өөрөөр заагаагүй бол материалын ширхэглэл нь 75 мм-ээс илүү байвал далангийн дүүргэлтэнд хэрэглэхгүй.

(б) Хиймэл байгууламжийн буцаан дүүргэлтийн материал

Хиймэл байгууламжийн ойролцоох орон зайг буцаан дүүргэж нягтруулахад дараах шаарплагыг хангасан зохист ширхэглэлтэй дүүргэлтийн материал хэрэглэнэ. Үүнд:

- Уян харимхайн индекс нь 7%-иас бага,
- Урсалтын хязгаар нь 30%-иас бага,
- 0,075мм-ийн шигшүүрээр өнгөрч байгаа нарийн ширхэглэлтэй хэсэг нь хуурай үеийн жингийн 8%-иас бага

(в) Хүйтэнд тэсвэртэй үеийн материал

Хүйтэнд тэсвэртэй үе нь сонгосон зохист ширхэглэлтэй дүүргэлтийн материал ашиглан хучилтын үеүдийн ёроолоос доош 300 мм-ийн зузаантай хийгдэх хэсэг болно.

Хүйтэнд тэсвэртэй үеийн материал нь дараахи шинж чанарыг агуулна:

- Хөрсний даацын үзүүлэлт (CBR) нь 4 өдөр сойсны дараа ХИХН нь 98% (AASHTO T180) хүртлэх нягтруулалтанд шалгаж үзэхэд 20%-иас их,
- Хөөлт (CBR-ийн туршилтын сойлтын үед) 1 %-иас бага,
- Уян харимхайн индекс нь 9%-иас бага,
- Урсалтын хязгаар нь 25%-иас бага,
- Уян харимхайн үзүүлэлт нь 90-ээс бага,
- ХИХН (AASHTO T180) 1.85 т/м$^3$-аас багагүй,
- 75 μm шигшүүрээр нийт жингийн 10-аас доош хувь нь өнгөрөх,
- ширхэглэлийн хамгийн том хэмжээ нь 60 мм-ээс бага байна.

Ухмал дахь ул хөрсний шинж чанар нь дээрхтэй тохирч байгаа эсэхийг тогтоох үүднээс хүйтэнд тэсвэрлэх үетэй адил төвшинд ул хөрсөн дээр (400 м$^2$ тутамд хоёр цэгт, хэрэв ухмалын урт 100м-ээс бага бол цэгийн тоог Инженерийн тодорхойлсоноор авна) туршилт шинжилгээ хийнэ. Хэрэв бүх үзүүлэлтүүд нь тохирч байвал ухмалын ул суурийг хүйтэнд тэсвэртэй үе гэж үзэж болно. Хэрэв бусад бүх үзүүлэлт нь шаардлага хангаж харин зөвхөн ХИХН нь 98% (AASHTO T180)-аас бага байвал ул хөрсийг 300 мм-ийн гүнд сайтар сийрэгжүүлж ХИХН 98% (AASHTO T180) болох хүртэл нь дахин нягтруулна. Хэрэв уг шалгууруудын алийг ч хангахгүй бол 300 мм-ийн гүнд ухмалын ул хөрсийг ухаж зайлуулан оронд нь шаардлага хангасан, зохистой найрлага бүхий хүйтэнд тэсвэртэй материалыг дэвсэнэ. Дэвсэж нягтруулсан үеийн зузаан 150мм-ээс ихгүй байна.

Туршилт хийх үед сийрэгжилт, тогтворгүй байдал үүсэх юмуу нягтруулалт хийх үед ямар нэг хүндрэл учрахгүй байхаар дүүргэлтийн материалыг ширхэглэлийн бүрэлдэхүүнээр нь маш сайн шилж сонгоно.

Дүүргэлтийн материал нь зүйл 502-т тодорхойлсон тохиромжгүй материал биш боловч ширхэглэлийн хэмжээ нь 75мм-ээс том, гэхдээ 250мм-ээс бага байвал дүүргэлтийн

хатуу материал гэж тодорхойлох бөгөөд Инженерээс зөвшөөрсөн тохиолдолд, өндөр далантай хэсгийн хөлдөлтөөс хамгаалах үеийн гадаргуугаас доош 1,5м хүртэлх буюу түүнээс доошхи дүүргэлтэнд, зүйл 506-д заасны дагуу ашиглаж болно. Энэ ажилд Инженер зөвшөөрөл өгөхдөө ашиглагдах материалын шинж чанар, талбайн туршилтын явцад үзүүлсэн Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийн хүчин чадал, ажлын горим зэргийг харгалзан үзнэ.

Гүйцэтгэгч нь газар шорооны ажлыг тасралтгүй үргэлжлүүлэн хийж, дэс дараалалтайгаар дуусгаж байхаар ажлыг зохион байгуулна. Гүйцэтгэгч нь далан болон хучилтын аливаа үеийн ажлыг хийж дуусмагц дараагийн үеийн ажлыг эхлэхээс өмнө, зөвшөөрөл авах хүсэлтээ дор хаяж 48 цагийн өмнө Инженерт бичгээр илгээх ба Инженерт чанарын баталгаа гаргах үүрэг хариуцлагаа биелүүлэхэд нь шаардагдах хангалттай хугацааг өгнө. Инженерээс албан бичгээр зөвшөөрөл авах хүртэл Гүйцэтгэгч ямар нэг нягтруулсан үеэн дээр дараагийн үеийн ажлыг эхлүүлэх ёсгүй. Өмнөх үеийн зөвшөөрлийг авсан даруйд дараагийн үеийн материалыг дэвсэнэ.

Инженерээс зөвшөөрөл авсаны дараа 24 цагийн дотор аль нэг үеийг хамгаалалтгүй орхих болвол Инженерээс дахин уг үеийн зөвшөөрлийг авах бөгөөд Гүйцэтгэгч зөвшөөрөл авах хүсэлтээ дахин танилцуулна. Далангийн дүүргэлтийн материалын нягтруулсан зузаан нь 150 мм-ээс илүү байж болохгүй. Гүйцэтгэгч ажлын ондоо аргачилал болон техник хэрэгслийг ашиглан туршилт хийсний үндсэн дээр дүүргэлтийн материалыг энд зааснаас илүү зузаан үеээр дэвсэж, шаардлагатай хэмжээнд хүртэл нягтруулах боломжтойг харуулсан нөхцөлд Инженер зөвшөөрч болох юм. Гэхдээ нягтруулсан зузааны зөвшөөрөгдөх хамгийн их хэмжээ 250 мм байж болно. Далангийн үе бүрийг хангалттай өргөнд дэвсэх ба энэ техникийн шаардлагын зүйл 507-ын дагуу нягтруулна.

Даланг барихдаа Гүйцэтгэгч нь далангийн доорхи ул хөрсний нягтруулалт, шорооны суулт, нягтралт, агшилт зэргийг харгалзан өндөр болон өргөний зөвшөөрөгдөх хэмжээг хангана. Даланг барьж байх явцад, доод талын үед дэвссэн материалд хатууралт, суулт, овойлт нөлөөлөх, агшилт үүсэх тохиолдолд Гүйцэтгэгч үе тус бүр дээр, зааварласан төвшин ба өргөнд зөвшөөрөгдсөн дүүргэлтийн материалыг дэвсэн нягтруулах ажлыг өөрийн зардлаар хийж гүйцэтгэнэ.

Далангийн барилгын ажлын явцад, нягтруулсан шороон үеийн хамгаалалтгүй гадаргуу дээгүүр ямар нэгэн тээврийн хэрэгслийг явуулахгүй байхад анхаарах ястой. Хэрэв Гүйцэтгэгч өөрийн ажиллаж байгаа машин, механизмуудыг далан дээгүүр явуулах шаардлагатай болвол тэдгээрийг нэг мөрөөр биш, харин нийт өргөнд нь жигд тархсан байдлаар явж байхаар зохион байгуулж, шаардагдах бүх алхмуудыг хийнэ. Нягтруулсан газар шорооны ажлын ямар нэг үеэнд хэв гажилт үүсэх юмуу дээрх хөдөлгөөний улмаас гэмтсэн бол дараагийн үеийг дэвсэхээс өмнө Гүйцэтгэгч уг үеийг техникийн шаардлагын нөхцлүүд ба Инженерийн тавьсан шаардлагуудыг хангах хэмжээнд сийрэгжүүлж дахин нягтруулна. Инженерийн зүгээс тусгай зөвшөөрөл өгөхөөс бусад тохиолдолд дүүргэгч материалыг далан дээр овоолоостой байлгаж болохгүй.

Даланг гүүр хоолойнуудын төвшинд хүртэл эсвэл хоолойны дээгүүр барихдаа байгууламжийн хоёр талаар ижил түвшинд даланг өндөрсгөнө. Инженер өөрөөр зааварлаагүй бол энэ ажлыг байгууламжид дүүргэлт хийх ажилтай хамт нэг зэрэг хийнэ. Даланг нягтруулах тоног төхөөрөмжийг тухайн байгууламжид аль болох ойр ажиллуулах ба ингэхдээ тэдгээрт ямар нэгэн эвдрэл, гэмтэл учруулахгүй байх хэрэгтэй. Хэрэв байгууламжинд ямар нэгэн эвдрэл учруулбал Гүйцэтгэгч өөрийн зардлаар засна.

## 506 НАМАГТАЙ ГАЗАР БОЛОН БАМБАЛЗУУР ХӨРСИЙГ ЧУЛУУГААР ДҮҮРГЭХ

Инженерийн зааварласан тохиолдолд Гүйцэтгэгч нь намагтай газар болон бамбалзуур хөрстэй газрыг ухан авч, хаягдал зайлуулах газарт зөөж зайлуулах ба дараахи байдлаар чулуун дүүргэлтийг хийнэ.

Намагтай буюу бамбалзуур хөрстэй газарт Гүйцэтгэгч зөвшөөрөгдсөн чулуун дүүргэлтийг Инженерийн зааврааp дэвсэнэ. Чулуун дүүргэлтийг зааварласан газарт нийтэд нь сайтар шигдэж суух хүртэл нь жигд үеэр дэвсэж, хөдөлгөөн явуулан индүүдэнэ.

Тогтворгүй ул хөрсөн дээр чулуун дүүргэлтийг хийх бол материалыг ажлын талбайд ойрхон буулгаад, далангийн өндөр нь барилгын хүнд машин механизмын ачааллыг даах боломжтой болох хүртэл нь бульдозероор түрж тараах замаар даланг барина.

Өндөр далантай хэсгийн дүүргэлтэнд ашиглах хатуу материалын хамгийн их хэмжээ нь 250 мм байна. Хатуу материалыг далангийн нийт өргөнөөр, нягтраагүй үеийн зузаан нь 400 мм-ээс ихгүй байхаар үечлэн дэвсэх ба материал нь боломжийн хэмжээний зохист ширхэглэлтэй байна. Материалыг 15 тонноос багагүй жинтэй гинжит тракторaар тараан тэгшлэнэ. Далангийн хажуу налууд чулуун материал буулгахыг үл зөвшөөрнө. Хажуу налуу нь материалын чөлөөт уналтын өнцгөөр аяндаа үүсэх юм.

Дараагийн үеийг дэвсэхээс өмнө үе бүрийг нарийн ширхэглэлтэй чулуу, хайргаар хөндий зайг боломжийн хирээр дүүргэж чигжинэ. Үе бүрийг энэ техникийн шаардлагын зүйл 507-ын дагуу нягтруулна. Хатуу материалын дүүргэлтийн явцад тухайн үеийн нөхцөл байдалтай уялдуулан тавигдах шаардлагуудыг Инженер өөрчилж болно.

## 507 ГАЗАР ШОРООНЫ АЖЛЫН НЯГТРУУЛАЛТ

Газар шорооны дүүргэлтэнд болон хөлдөлтөөс хамгаалах үеэнд хэрэглэж байгаа материалыг нягтруулалтын өмнө услах буюу хатаах замаар, нягтруулалтын үеийн чийг нь зохистой чийгийн агуулгаас 1%-иар их, эсвэл 2%-иар бага байхаар тохируулна. (AASHTO T180). Нягтруулалт дуустал чийгшилтийг энэ хязгаарт байлгана.

Материалын үе бүрийг дээрх чийгшилийн хязгаар дотор дор тодорхойлсонтой ижил буюу илүү хэмжээний хуурай нягтралтай болтол индүүднэ. Үүнд:

- Хөлдөлтөөс хамгаалах үеэс бусад бүх дүүргэлтийн материалыг ХИХН нь 95%-аас багагүй байхаар (AASHTO T180),
- Далангийн дээд үе болох 300 мм зузаантай хөлдөлтөөс хамгаалах үеийг ХИХН нь 98%-аас багагүй байхаар (AASHTO T180),
- Ухмалд хийсэн шинжилгээний үр дүнгээр, хөлдөлтөөс хамгаалах үеэнд тохирохоор гарсан хөрсийг ХИХН нь 98%-аас багагүй байхаар (AASHTO T180) тус тус нягтруулна.

Энэхүү техникийн шаардлагын зүйл 218-д заасны дагуу талбайн туршилтыг үндэслэн Гүйцэтгэгчийн санал болгож, Инженер зөвшөөрсөн аргачлалаар ул хөрс, далан болон ухмалын нягтруулалтыг хийнэ. Далан болон ухмалын аль алинд нь 300 мм-ийн зузаантай хөлдөлтөөс хамгаалах үеийг 150 мм-ийн хоёр үеэр дэвсэж нягтруулна.

Өндөр далантай хэсгийн дүүргэлтэнд дэвсэж тараасан хатуу материалыг 18-20тн жинтэй хийн дугуйт индүү, скрепер, эсвэл 15тн-оос багагүй даацын ачаатай самосвал зэрэг техникийг ашиглан дарж нягтруулна.

Гүйцэтгэгч, Техникийн шаардлагын бүлэг 200-д заасны дагуу даланд ашиглагдах гол нэр төрлийн материалуудыг нягтруулах саналаа Инженерт танилцуулна. Үе тус бүрийн нягтраагүй зузаан, нягтруулах машин техникийн төрөл, жин, тэдгээрийн нэг мөрөөр явах явалтын тоо зэргийг уг төлөвлөгөөнд тусгасан байна. Гүйцэтгэгч нь газар шорооны ажилд тохируулан хэрэглэхээр санал болгосон аргачлалаа ашиглан, шаардлагатай лабораторийн шинжилгээнүүдийг оролцуулан нягтруулалтын талбайн туршилтуудыг Инженертэй зөвлөлдсөний үндсэн дээр явуулна. Гүйцэтгэгч санал болгосон аргачлалаа ашиглан, нягтруулалтын талаар тотоосон бүх шаардлагыг хангаж чадна гэдгээ Инженерт батлан үзүүлэх ёстой. Барилгын гол ажлыг эхлэхээс өмнө гол нэр төрлийн материал бүр дээр хийгдэх нягтруулалтын талбайн туршилтууд дууссан байна.

Органик болон хорт бодис агуулаагүй, элдэв хольцгүй, цэвэр усыг Инженерийн зөвшөөрсөн эх үүсвэрээс авч газар шорооны ажилд хэрэглэнэ. Инженер шаардсан тохиолдолд, ус нь техникийн шаардлагад тохирч байгаа эсэхийг батлахын тулд Гүйцэтгэгч усны шинжилгээг хийлгэнэ.

Инженерийн баталсан төрлийн усны машиныг ашиглах ба эдгээр нь гадаргууд усыг урьдчилан тогтоосон тогтмол нормоор, жигд шүрших чадвартай байх ёстой.

## 508 ХАЯГДАЛ МАТЕРИАЛ

Замын ухмалаас гарсан далангийн дүүргэлтэнд ашиглахад тохиромжгүй буюу дүүргэлтийн болон хөлдөлтөөс хамгаалах үед хэрэглэх шаардлагагүй гэж Инженер тодорхойлсон бөгөөд хаягдал зайлуулах талбайд зөөж буулгах заавар өгсөн материалыг хаягдал материал гэнэ. Инженер тусгай зөвшөөрөл өгөхөөс бусад тохиолдолд ухмалын материалыг хаягдал зайлуулах талбайд зайлуулахгүй.

Ухмалаас гарсан материал эхлээд хаягдал материал гэж ангилагдсан байлаа ч дараа нь Гүйцэтгэгч түүнийг Инженерийн зааврaар далангийн дүүргэлт, хүйтэнд тэсвэртэй үе, суурийн доод үе, хөвөөнд буюу зам барилгын аль нэг хэсэгт ямар нэгэн байдлаар хэрэглэж болно.

Гүйцэтгэгч байршлыг нь тогтоож, Инженер урьдчилан баталсан хаягдал материал зайлуулах талбайд гүйцэтгэгч хаягдал материалыг зөөвөрлөж хаяна. Энэхүү техникийн шаардлагын бүлэг 600-д заасны дагуу хаягдал материалын талбайг олж тогтооно. Гүйцэтгэгч хаягдал материалыг зайлуулах үйл ажиллагааг эхлэх тухай мэдэгдлийг дор хаяж 24 цагийн өмнө Инженерт өгнө.

## 509 ШОРООН ОРДУУД

Ухмалыг ухах буюу өргөтгөхөд гарсан материал дээр нэмж шаардагдах дүүргэлтийн материалыг авна. Техникийн шаардлагын бүлэг 600-д заасны дагуу шороон ордыг тогтооно. Шороон ордын байршлыг Гүйцэтгэгч тогтоож, Инженер батална.

Инженер барилгын аль нэг онцлог хэсэгт ашиглахаар шороон ордоос тодорхой материалыг сонгох зааврыг өгч болно. Ийм сонголт хийхээр зааварласан тохиолдолд шороон ордын тодорхой хэсэгт материалыг ухах, дахин шилжүүлэн зөөвөрлөх, овоолох ажил хийгдэж болох юм.

Гүйцэтгэгч нь шороон ордод хүрэх туслах замыг барьж, шороон ордоос овор хэмжээ ихтэй том чулуу, үл тохирох материал, бүх төрлийн ургамлыг цэвэрлэж зайлуулна.

Техникийн шаардлагын бүлэг 600-д заасны дагуу шороон ордыг нөхөн сэргээх үед ашиглах зорилгоор өнгөн хөрсийг хуулж, овоолон хадгална.

Гүйцэтгэгч нь шороон ордод буй тохиромжтой материал нь үл тохирох материалтай холилдохгүй байх арга хэмжээг авна. Тохиромжгүй материалыг техникийн шаардлагын зүйл 508-д заасны дагуу зайлуулна.

Шороон ордыг тогтоосон өргөн ба хэлбэрээр ухах ба ажил дуусаны дараа цэвэрлэж, нөхөн сэргээнэ. Нөхөн сэргээсэн газрын хажуу налуу нь хамгийн ихдээ хэвтээд 1, босоод 6 гэсэн харьцаатай байна. Техникийн шаардлагын бүлэг 600-д заасны дагуу ойр орчмын газар нь цэвэрхэн үзэмжтэй засагдсан байна.

Шороон ордыг нөхөн сэргээсний дараа Инженерээс баталгаа авах ёстой.

## 510 НАЛУУГ ТЭГШИЛЖ ЗАСАХ

Зурагт тусгасан буюу Инженериийн зааврын дагуу ухмал ба далангийн хажуу налууг гараар болон механик аргаар засна. Далангийн хажуу налуугийн гадаргуу нь Техникийн шаардлагын зүйл 507-д заасны дагуу зохих ёсоор нягтарсан байх ёстой ба яман нэгэн сул буюу дутуу нягтарсан, эсвэл том хэмжээтэй материалыг тэгшлэн хусаж, далангийн хажуу налуугаас зайлуулна. Ийм төрлийн материалыг хаягдал материал зайлуулах талбай руу зөөж зайлуулах буюу эсвэл Инженер тохиромжтой гэж үзвэл өөр ажилд хэрэглэнэ. Ухмал болон далангийн хажуу налуугийн тэгшилгээ, засварыг далангийн дээд үе хүртлэх газар шорооны ажил дуусанаас хойш, гэхдээ хучилтын үеүүдийн ажил эхлэхээс өмнө гүйцэтгэнэ.

Ухмал болон далангийн налууд ямар нэгэн хад, чулуу мөн асфальтан хольцны үлдэгдэл байвал тэдгээрийг зайлуулж, зөвшөөрөх хэмжээнд хүртэл тэгшилнэ. Хэрэв ухмалын налууд том хад чулуу сул байдалтай, ил үлдсэн байвал түүнийг зайлуулан оронд нь тохиромжтой материалаар дүүргэн, Инженерийн зөвшөөрөх хэмжээнд хүртэл нягтруулна.

Далан ба ухмалын налууг тэгшилж засах ажил нь ухмалын болон хажуугийн шуудууны ухалт, мөн далан барих ажлын нэг хэсэг гэж тооцогдох тул эдгээр ажилд Гүйцэтгэгч ямар нэгэн төлбөрийг тусад нь нэхэмжлэх ёсгүй.

## 511 ХАЖУУГИЙН ШУУДУУ

Техникийн шаардлагын зүйл 501, 502, 503-т заасны дагуу хажуугийн шуудууг замын ухмал гэж тооцох ба газар шорооны ажил гэж ангилагдана. Барилгын ажлын явцад хажуугийн шуудууны хэмжээ, налуу, гүн зэргийг өөрчлөх зааварчилгааг Инженер өгч болох ба үүний дагуу ажлыг гүйцэтгэнэ.

Шаардлагатай газруудад хажуугийн шуудууг чулуугаар Зурагт үзүүлсэний дагуу буюу Инженерийн зааварчилсанаар бэхлэнэ.

## 512 УХМАЛЫН ХАЖУУ НАЛУУ ДАХЬ ТОГТВОРГҮЙ МАТЕРИАЛ

Ухмалын хажуу налууд нурамтгай, тогтворгүй материал илэрвэл Гүйцэтгэгч Инженерт мэдэгдэх ба Инженер заавар өгвөл нурамтгай материалыг ухан зайлуулж оронд нь тохирох материалаар дүүргэнэ. Үл тохирох хөрсийг ухаж зайлуулах ажил нь замын ухмалын нэг хэсэг гэж тооцогдох ба тохирох материалаар дүүргэх ажил нь далангийн ажлын нэг хэсэг гэж тооцогдоно.

## 513 ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР

Техникийн шаардлагын бүлэг 300-д заасны дагуу 20 м тутамд авсан хөндлөн огтлолыг ашиглан газар шорооны ажлын хэмжээг тодорхойлно. Инженерийн зааварчилгааны дагуу жигд бус хөрстэй болон огцом эргэлттэй, мөн уулархаг газарт хөндлөн огтлолыг илүү ойрхон зайтайгаар авна.

Газар шорооны дүүргэлтийн ажил нь бүрэн дууссан даланг нягтруулсан материалын куб.метрээр хэмжинэ. Далан барих зорилгоор хийсэн материалын ухмалын ажилд тусдаа хэмжилт буюу төлбөр хийгдэхгүй.

Ухмал хийх, ухмалыг өргөтгөхөд гарсан материал дээр нэмэлт дүүргэлтийн материал шаардагдах болон Инженер шороон ордыг шинээр нээх заавар өгсөн тохиолдолд дор дурдсан зүйлд тусдаа хэмжилт буюу төлбөр хийгдэхгүй.

- Газрын зөвшөөрөл
- Туслах замын зөвшөөрөл
- Эзэмшигчид болон засаг захиргаатай хийх гэрээ хэлцэл
- Олзворлож авсан материалын татвар, хураамж
- Техникийн шаардлагын бүлэг 400-д заасны дагуу шороон ордын талбайн цэвэрлэгээ
- Техникийн шаардлагын бүлэг 400-д заасны дагуу шороон ордын өнгөн хөрсийг хуулан өөр газарт хэрэглэх
- Техникийн шаардлагын бүлэг 500-д заасны дагуу өнгөн хөрсийг хуулж, түр зуур овоолон хадгалж, шороон ордыг сэргээн засварлахад хэрэглэх
- тээвэрлэлт
- Техникийн шаардлагад нийцүүлэх зорилгоор овор ихтэй материал, илүү жижиг ширхэгтэй болон бусад фракцийн чулууг зайлуулахын тулд материалыг бутлах буюу шигших
- шороон ордын тохиромжтой материалыг дахин шилжүүлэн зөөвөрлөх буюу түр зуурын овоолго хийх

Инженер заавар өгсөн тохиолдолд, Гүйцэтгэгч ухмалын ажлыг гүйцэтгэж, заагдсан хөндлөн огтлолыг хэлбэр, хэмжээнд хүргэж ухах явцдаа өнгөн хөрсний төвшинг аль болохоор нарийн тодорхой үзүүлэх боломжтой байрлалд гүнийг заагч тэмдгийг тавина. Гүйцэтгэгч гүн заагчийг сүүлчийн хэмжилт хийх хүртэл хэвээр байлгана. Техникийн

шаардлагын зүйл 508, 512-д заасны дагуу тохиромжгүй болон тогтворгүй материалыг ухан зайлуулах ажлын хэмжээг ухмалын эзлэхүүнтэй адилаар хэмжинэ.

Ухаж зайлуулах материалыг тооцоо хийхэд тохирох компьютерийн программ ашиглан хэмжих ба хэмжилтийг хийхдээ ухмалаас зайлуулсан материалын нийт эзэлхүүнээс дээр дурдсан байдлаар хэмжсэн ухаж зайлуулах тохиромжгүй материалын эзэлхүүнийг хасч, үүнээс далангийн нягтруулсан дүүргэлийн эзэлхүүнийг хасаад гарсан эзэлхүүнээр хэмжинэ.

Техникийн шаардлагын зүйл 505-д заасны дагуу материалын хаягдал болон шорооны бэхжилт, суулт зэргээс үүдэн гарсан илүү эзлэхүүнд нөхөн төлбөр олгогдохгүй.

(а) Зүйл : Замын ухмал болон шороон ордоос авсан материалыг ашиглан даланг барих

Нэгж : $м^3$

Далангийн ажлын үнэлгээнд дор дурдсан ажлын зардлууд багтана.Үүнд:

- Замын ухмал, шатлал болон шороон ордоос материалыг ухаж авах.
- Материалыг ачих, тээвэрлэх, далан болон дүүргэлт шаардлагатай бусад газарт дэвсэх
- Бусад шаардлагатай зөөвөр, тээврийн ажлууд
- Материалыг засах, хэлбэржүүлэх, услах болон нягтруулах
- Энэ техникийн шаардлагын бүлэг 100, 200, 300 болон 600-д заасныг мөрдөх
- Энэхүү техникийн шаардлагын зүйл 501, 502, 503, 504, 505, 507, 509, 510, 511 болон 513-д заасныг мөрдөх

Инженерийн зааврын дагуу барилгын ажил эхлэхээс өмнө, мөн түүнээс хойш 20 м-ийн зайтайгаар авсан хөндлөн огтлолыг үндэслэн далангийн ажлын эзэлхүүнийг хэмжинэ.

(б) Зүйл : Материалыг ухаж, зайлуулах (ердийн ухалт)

Нэгж : $м^3$

Ердийн ухмалын ажлын үнэлгээнд дор дурдсан ажлын зардлууд багтана. Үүнд:

- Материалыг ухах,
- материалыг ачих, тээвэрлэх ба тогтоосон хаягдал материал зайлуулах цэгт хаях,
- Бусад шаардлагатай зөөвөр, тээврийн ажлууд,
- өнгөн хөрсний ажлууд,
- хаягдал материалын цэгт өнгөн хөрсийг тарааж тэгшлэх,
- энэхүү техникийн шаардлагын бүлэг 600-д заасны дагуу хаягдал материалын талайг бэлдэх, хэлбэрт оруулах, засах сэргээх
- энэ техникийн шаардлагын зүйл 502, 503, 504, 505, 506, 508, 509, 510 болон 513-т заасныг мөрдөх.

Техникийн шаардлагын зүйл 506-д заасны дагуу далангийн доорхи намагтай хөрсний ухалтанд ямар нэгэн тусдаа болон нэмэлт төлбөр хийгдэхгүй.

-

(в) Зүйл : Хатуу материалыг ухаж зайлуулах

Нэгж : $м^3$

Хатуу хадан хөрсийг ухах ажлын үнэлгээнд дор дурдсан ажлын зардлууд

багтана. Үүнд:

- Материалыг ухах,
- материалыг ачих, тээвэрлэх ба тогтоосон хаягдал материалын цэгт хаях,
- Бусад шаардлагатай зөөвөр, тээврийн ажлууд,
- өнгөн хөрсний ажлууд,
- хаягдал материалын цэгт өнгөн хөрсийг зайлуулах,
- энэхүү техникийн шаардлагын бүлэг 600-д заасны дагуу хаягдал материалын талайг бэлдэх, хэлбэрт оруулах, засах сэргээх
- энэхүү техникийн шаардлагын зүйл 502, 503, 504, 505, 506, 508, 509, 510 болон 513-д заасан шаардлагыг хангах.

Төлбөр хийх зорилгоор ухмалаас гарч буй эзэлхүүнээрээ 0.5 $м^3$-аас том хэмжээтэй чулууны эзэлхүүнийг тээвэрлэж буй машины тэвшин дэх тэдгээрийн сул эзэлхүүний 50%-иар тооцож авна.

(г) Зүйл : ухмал дахь ул хөрсийг ХИХН 95% хүртэл нягтруулах (AASHTO T199)

Нэгж : $м^3$

Ул хөрсийг ХИХН 95% хүртэл нягтруулах (AASHTO T199) ажлын хэмжилтийн нэгж нь куб метр байна. Нягтруулсан ул хөрсний эзэлхүүнийг зааварласан, нягтруулсан талбай ба нягтруулсан зузааны үржвэрээр хэмжинэ.

Нягтруулалтын ажлын үнэлгээнд дор дурдсан ажлын зардлууд багтана. Үүнд:

- газрын хөрсийг сийрэгжүүлэх,
- материалыг тээвэрлэх, зөөх, зайлуулах,
- овор ихтэй материалыг шигших, зайлуулах
- чийгийн агуулгыг нь тохируулахын тулд материалыг хатаах болон услах,
- зохих хөндлөн огтлолыг гаргаж тэгшлэх,
- засах ба нягтруулах,
- Энэхүү техникийн шаардлагын зүйл 505, 507, 510, мөн 513-д заасан шаардлагуудыг хангах.

(д) Зүйл : Хүйтэнд тэсвэртэй үе

Нэгж : $м^3$

Хүйтэнд тэсвэртэй үеийн ажлыг метр кубээр хэмжинэ. Хэрэв ухмалаас гаргасан хөрс нь ямар нэгэн нэмэлт боловсруулалт хийлгүйгээр хүйтэнд тэсвэрлэх үед хэрэглэхэд боломжтой гэж Инженер тодорхойлвол тухайн хэсэгт хүйтэнд тэсвэртэй үеийг хэмжих шаардлагагүй. Заагдсан, нягтруулсан талбай ба уртын үржвэрээр эзэлхүүнийг тооцоолно.

Хүйтэнд тэсвэртэй үеийн үнэлгээнд дор дурдсан ажлын зардлууд багтана. Үүнд:

- Хэрэглэхэд тохиромжтой материалыг чулуун болон шороон орд, замын ухмалаас ухаж гаргах ажлууд
- материалын сонголт,
- материалыг ачих, тээвэрлэх ба хөлдөлтийн эсрэг үе дээр тавих
- Бусад шаардлагатай зөөвөр, тээврийн ажлууд,
- овор хэмжээ томтой материалыг шигшиж, зайлуулах,
- шороон даланг зохих түвшин болон хөндлөн налуутай бэлдэх, тэгшлэх, индүүдэх

- хүйтэнд тэсвэртэй үеийн материалыг 150 мм-ийн зузаан үеэр нягтруулах
- Материалыг хатаах, услах замаар чийгшлийг тохируулах,
- зохих хөндлөн огтлолоор тэгшлэх,
- дэвсэх болон нягтруулах,
- энэ техникийн шаардлагын бүлэг 100, 200, 300, 600-д заасан шаарлагыг хангах,
- энэ техникийн шаардлагын зүйл 502, 504, 505, 507, 508, 509, 510, 512 ба 513-д заасан шаардлагуудыг биелүүлэх

(е) Зүйл : Намагтай газруудыг чулуугаар дүүргэх

Нэгж : $м^3$

Намгийг чулуугаар дүүргэх ажлын хэмжих нэгж нь куб метр байна. Хэмжээг төлөвлөсөн дээд, доод суурийн талбайн дундажыг, чулуун дүүргэлтийн зузаанаар үржиж гаргана.

Намган хөрсийг чулуугаар дүүргэх ажлын үнэлгээнд дор дурдсан ажлын зардлууд багтана. Үүнд:

- материалыг ухаж авах,
- материалыг ачих,тээвэрлэх, дэвсэх,
- Бусад шаардлагатай зөөвөр, тээврийн ажлууд ,
- чулуун дүүргэлтийг хийх,дарж суулгах,
- Энэ техникийн шаардлагын зүйл 505, 506, 507, 508, болон 513-ын шаардлагыг хангах.

(ё) Зүйл : Хажуугийн шуудуу

Нэгж : м2

Хажуугийн шуудууг чулуугаар бэхлэх ажлыг м2-аар хэмжинэ. Төлбөр хийгдэх талбайг газар дээр нь хийгдсэн бэхэлгээний цэвэр талбайгаар авна.

Хажуугийн шуудууг чулуугаар бэхлэх ажлын үнэлгээнд дараах ажлын зардлууд багтана. Үүнд:

- чулууг бэлтгэх
- чулууг ачиж тээвэрлэх, дэвсэх, өрөх, шигтгэх, зуурмагаар гагнах
- ажил гүйцэтгэхэд шаардлагатай ажиллах хүч, багаж хэрэгслэл, тоног төхөөрөмж ба эдгээртэй холбогдох жижиг зардлуудын бүрэн төлбөр
- Энэ техникийн шаардлагын зүйл 501,502,503, 508, 510, 511, болон 513-ын шаардлагыг хангах.

# БҮЛЭГ 600- КАРЬЕР, ШОРООН ОРД, МАТЕРИАЛ НӨӨЦЛӨХ БА ХАЯГДАЛ МАТЕРИАЛ ЗАЙЛУУЛАХ ГАЗАР

## БҮЛЭГ 600- КАРЬЕР, ШОРООН ОРД, МАТЕРИАЛ НӨӨЦЛӨХ БА ХАЯГДАЛ МАТЕРИАЛ ЗАЙЛУУЛАХ ГАЗАР


| | | |
|---|---|---|
| 601 | ЕРӨНХИЙ ЗҮЙЛ | 6-3 |
| 602 | ТОДОРХОЙЛОЛТУУД | 6-3 |
| 603 | ГАЗАР ОЛГОХ | 6-3 |
| 604 | ГАЗАР ДЭЭР АЖИЛ ЭХЛҮҮЛЭХ | 6-5 |
| 605 | АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОЛОН ЭРҮҮЛ АХУЙН ШААРДЛАГУУД | 6-5 |
| 606 | ТУСЛАХ ШОРООН ЗАМУУД | 6-6 |
| 607 | ТАЛБАЙГ ЦЭВЭРЛЭХ, ӨНГӨН ХӨРС ХУУЛАХ БА ХӨРСНИЙ ДЭЭД ҮЕИЙГ УХАЖ ЗАЙЛУУЛАХ | 6-6 |
| 608 | МАТЕРИАЛЫГ СОНГОХ, ХОЛИХ, НӨӨЦЛӨХ | 6-6 |
| 609 | МАТЕРИАЛЫГ АШИГЛАХ | 6-7 |
| 610 | ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР | 6-7 |

## 601 ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Бетоны ажил, битумэн хучилтын ажил, буталсан чулуун суурь, чулуун өрлөг, чулуун асгаас, намаг, шавартай газрыг чулуугаар дүүргэх зэрэгт ашиглах чулуун материалуудын эх үүсвэрийг Гүйцэтгэгч сонгоно. Энэхүү техникийн шаарлагын бүлэг 602 (а)-д зааснаар эдгээр эх үүсвэрийг карьераар тогтооно.

Замын далан барихад дүүргэлтэд ашиглах орон нутгийн материал болон суурийн доод үе, хөвөөнд ашиглах хайрганы эх үүсвэрийг Гүйцэтгэгч сонгоно. Энэхүү техникийн шаарлагын бүлэг 602 (б)-д зааснаар эдгээр эх үүсвэрийг шороон ордоор тогтооно.

Инженерийн материалын тайланд дурдсан ямар ч карьер, шороон ордын аль ч материалын чанар болон тэдгээрийн тохиромжтой эсэх талаар Захиалагч ямар нэгэн хариуцлага хүлээхгүй. Тендерийн хугацаанд Захиалагч нь эдгээр бичиг баримтыг тендерт оролцогчдод чөлөөтэй үзэж танилцах боломж олгосон байлаа ч тэдгээр нь тендерийн бичиг баримтын хэсэг болохгүй. Инженерийн материалын тайлангаас хийсэн дүгнэлтэндээ Гүйцэтгэгч дангаар хариуцлага хүлээнэ.

## 602 ТОДОРХОЙЛОЛТУУД

(а) Карьер гэдэг нь зам барилгын ажилд ашиглах чулууг хөрснөөс өрөмдөж тэслэх буюу ондоо арга хэрэгслүүдийг ашиглан ухах замаар олборлох газрыг хэлнэ.

(б) Шороон орд гэдэг нь зам барихад ашиглах чулуунаас бусад материалуудыг авч буй талбай юм.

(в) Материал нөөцлөх газар гэдэг нь дүүргэлтийн материал, хайрга, дайрга өнгөн хөрс зэргийг зам барилгын ажилд ашиглахын өмнө түр хугацаагаар нөөцлөн овоолох талбайг хэлнэ.

(г) Хаягдал материал зайлуулах газар гэдэг нь зам барилгын ажлаас гарсан илүүдэл болон шаардлага хангахгүй материалуудыг тараан асгадаг талбайг хэлнэ. Инженерийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр илүүдэл болон шаардлага хангахгүй материалыг замын зурвас газарт асгаж болохгүй.

## 603 ГАЗАР ОЛГОХ

Захиалагч нь энэхүү техникийн шаардлагын бүлэг 100-д заасны дагуу барилгын ажилд шаардагдах замын зурвас болон бусад зориулалтын газрыгүнэ төлбөргүй ашиглах боломжийг Гүйцэтгэгчид бүрдүүлж өгнө. Үүнд:

- Шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлуулах газар ба карьер,
- тэдгээр лүү хүрэх туслах замууд,
- замын зурвасын гаднах түр замууд,
- Талбайн лаборатори байгуулах газар,
- Инженерийн орон сууц болон ажлын байрны газар,
- Гүйцэтгэгчийн түр лагерь, контор, агуулахууд, засвар үйлчилгээний болон амьдрах байрны газар,
- түр барилгын ажилд шаардлагатай газар,

Бусад зорилгоор ашиглахад шаардлагатай газар авах асуудлыг Гүйцэтгэгч хариуцна.

Карьер болон шороон ордын газрыг тогтоох, ашиглахдаа гүйцэтгэгч нь Улсын болон орон нутгийн холбогдох хууль журмуудыг баримтлан ажиллана.

Гүйцэтгэгчийн сонгож тогтоосон карьер, шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлуулах газруудын байршил болон хэмжээг Инженер хянаж батална.

Хэрвээ Инженерийн дүгнэлтээр карьер, шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлуулах газруудын болон тэдгээр лүү хүрэх туслах замуудын байршил нь дор дурдсан нөхцөлтэй байвал зөвшөөрөл олголгүй байж болно. Үүнд:

- Хүрээлэн буй орчинд хор нөлөө учруулахаар бол,
- Хот суурингийн дотор буюу түүнтэй хэтэрхий ойрхон байх,
- Хэтэрхий урт туслах зам шаардахаар бол,
- Дэндүү өргөн талбайг хамарсан байвал,
- Олон нийтийн аюулгүй байдалд эрсдэл учруулахаар бол,
- Ашиглаж болохуйц тохиромжтой материал болон газруудаас илүү хол байвал,
- Усны эх үүсвэр болон усан хангамжийг таслах, түүнд саад тотгор учруулахаар байвал.

Гүйцэтгэгч нь тухайн карьер, шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлуулах талбайд ямарваа нэгэн ажил эхлэхээс дор хаяж 28 хоногийн өмнө энэ талаар Инженерт бичгээр мэдэгдэнэ.

Дээрх мэдэгдлийг хийхээс өмнө хайгуулын ажил хийгдсэн байх ёстой бөгөөд гүйцэтгэгч нь хайгуулын ажил эхлэхээс дор хаяж 7 хоногийн өмнө орон нутгийн холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдэгдэж тэдний зөвшөөрлийг авсан байх ёстой. Гүйцэтгэгч нь карьер, шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлуулах газруудыг сонгохын тулд тухайн орон нутагтай гэрээ хэлцэл хийж, холбогдох хууль журмын дагуу газар ашиглалтын ба түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласаны төлбөр, болон бусад шаардлагатай төлбөрийг хийсэн байх ёстой.

Гүйцэтгэгч нь газар ашигласны болон ус гаргах, барилгын материал олборлохтой холбогдсон бүхий л татвар, хураамжийг хуулинд заасны дагуу төлж барагдуулах хариуцлага хүлээнэ.

Инженерт бичгээр мэдэгдэл өгөхийн өмнө Гүйцэтгэгч карьер, шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлуулах газар тус бүрд бетон тэмдгүүд тавьж, ажил явагдах, материал нөөцлөх талбай, тэсэлгээний ажлын аюулгүй бүс, туслах зам г.м-ээр тэдгээрийн хил хязгаарыг зааглан тогтоож тэмдэглэсэн байна. Дээрх газруудын талаар Гүйцэтгэгчээс ирүүлэх мэдэгдэл нь дараахи мэдээллийг агуулсан байна. Үүнд:

(а) Төлөвлөж буй туслах замын чиглэлийг харуулсан дэлгэрэнгүй зураг,

(б) доорх зүйлсийг тусгасан 1:500 масштабтай дэвсгэр зураг:

- тухайн газрын зах,хил, урт өргөн, нийт талбайн хэмжээ,
- газар эзэмшигчийн нэр, хаяг,
- тухайн газарт буй барилга, хашаа, булш, тариалангийн талбай, бусад зүйлсийн талаар газар эзэмшигчтэй зөвшөөрөлцсөн тухай дэлгэрэнгүй мэдээлэлэл
- ажлын талбай, материал нөөцлөх талбай, тэсэлгээний ажлын аюулгүй бүс зэргийг зурж тэмдэглэсэн байна.

(в) Газар эзэмших, ашиглах Улсын ба орон нутгийн эрх бүхий байгууллага буюу үндсэн эзэмшигчийн албан ёсны зөвшөөрөл

Хэрвээ сонгосон газарт шаардлагатай материалын нөөц хүрэлцээгүй байх юмуу эсвэл талбай нь бага байвал Гүйцэтгэгч нь одоогийн ашиглаж байгаа карьер, шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлуулах газрыг өргөтгөх юмуу эсвэл тэдгээрийг шинэ олж тогтоох, ашиглах хүсэлтээ бичгээр өгнө.

Өргөтгөх буюу шинээр нээх газрын зөвшөөрлийг энэхүү техникийн шаардлагын 603-р бүлэгт заасны дагуу авна.

### 604 ГАЗАР ДЭЭР АЖИЛ ЭХЛҮҮЛЭХ

Захиалагчаас зохион байгуулж, улмаар тухайн орон нутгаас газрын зөвшөөрөл олгосон даруйд ямар нэгэн ажил эхлэхийн өмнө Гүйцэтгэгч нь тухайн газарт хүрээлэн буй орчныг хамгаалахаас эхлүүлээд бусад бүх ажлыг эхлэх хууль эрх зүйн бүхий л нөхцөл

бүрэлдсэн эсэхийг хянаж баталгаажуулсан байх ёстой.

Инженерээс бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр Гүйцэтгэгч ямар ч газарт ажил эхэлж болохгүй.

**605 АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОЛОН ЭРҮҮЛ АХУЙН ШААРДЛАГУУД**

Гүйцэтгэгч нь карьер, шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлуулах газарт үйл ажиллагаа явуулахдаа эрүүл мэнд, ахуйн болон аюулгүй байдлын талаархи орон нутгийн засаг захиргааны дүрэм журмыг мөрдөж ажиллана. Тийм дүрэм журам байхгүй тохиолдолд, эсвэл тэдгээр дүрэм журмаас гадна дараахи нөхцлийг хангаж ажиллана:

(а) Ажил явагдаж байгаа бүх газрын усыг байнга зайлуулж хуурай байлгана. Хэрэв карьер юмуу шороон ордын ухагдсан газарт, ус гарч тэр нь өөрөө хатахааргүй байгаа бол ажил явагдаж байх хугацаанд усыг байнга соруулж зайлуулж байна. Тиймэрхүү хонхор газрыг ажил дуусаны дараа Инженерийн зааврааp мал услах усан сан болгон үлдээж болно. Энэ тохиолдолд эргийн налууг 1:6-аас илүү намхан болгон засч мал ороход тохиромжтой болгоно.

(б) Зам барилгын ажилд шаардагдах дээрх газрууд нь усны эх бүхий газар, хот, суурингийн дотор юмуу тэдэнтэй ойр зэргэлдээ оршиж болохгүй.

(в) Газрууд нь доор дурдсан хил хязгаарын дотор байж болохгүй:

- Тусгай хамгаалалттай Газрууд,
- Дархан цаазтай газрууд,
- Хилийн бүсүүд,
- Байгалийн нөөц газрууд
- Дурсгалт газрууд,
- Хамгаалалттай ойн бүс,
- Усны бүсүүд.

Хаягдал зайлуулах газар нь гол горхи, суваг шуудуу, усны урсац, усны эх, нуур зэрэг усны нөөцийг боож, бохирдуулахгүй байх ёстой.

Гүйцэтгэгч нь олгосон газарт ажлын талбарынхаа хил хязгаарыг тогтоож, Инженерийн зааврын дагуу түр болон удаан хугацааны хашаа хамгаалалт барьж тусгаарлан, үйл ажиллагаагаа зөвхөн тэр хил хязгаарынхаа дотор бие даан явуулна.

(г) Мөргөцөгийн өндөр 1м-ээс илүү болсон газарт, зөвшөөрөлгүйгээр мөргөцөг өөд гарахаас сэргийлсэн хаалга, мал орохоос хамгаалсан түр зуурын хашилтыг Гүйцэтгэгч өөрийн зардлаар хийж тавина.

(д) Ажил дуусахад бүх мөргөцөгүүдийг нурааж, 1:6-аас багагүй налуу болгож сайтар тэгшлэн засна.

(е) Ажил дуусахад бүх хашилт болон түр хугацааны бусад байгууламжуудыг буулгаж, зөөн, бүх жорлонгийн нүхийг булж, өнгөн хөрсийг тарааж тэгшлэн усалж, талбайг цэвэрхэн болгож үлдээнэ.

(ё) Гүйцэтгэгч нь байгаль орчныг бохирдуулахгүй байх бүхий л арга хэмжээг авч ажиллана. Үүнд хөрсний болон гадаргын усанд тос, эрдэсжсэн ус оруулахгүй байх ба гэхдээ энэ чиглэлийн арга хэмжээ нь зөвхөн эдгээрээр хязгаарлагдах ёсгүй.

(ж) Ажил дуусахад бүх карьер, шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлуулах газруудыг нөхөн сэргээж ландшафтын харагдах байдлыг сайжруулаад зогсохгүй хүн, малд саад болохооргүй байдлаар хуучин төрхийг сэргээнэ. Налуу жигд байх бөгөөд түүнийг өнгөн хөрсөөр хучиж ургамалжилтыг

тэтгэх зорилгоор байнга усалж байна. Газрыг нөхөн сэргээхэд шаардлагатай бүхий л зүйлийг хийж хуучин хэвэнд нь оруулна.

### 606 ТУСЛАХ ШОРООН ЗАМУУД

Карьер, шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлуулах газруудад хүрэх туслах замууд болон одоогийн байгаа замуудыг Гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр барьж, засварлана.

### 607 ТАЛБАЙГ ЦЭВЭРЛЭХ, ӨНГӨН ХӨРС ХУУЛАХ БА ХӨРСНИЙ ДЭЭД ҮЕИЙГ УХАЖ ЗАЙЛУУЛАХ

Инженер өөрөөр зааварчлаагүй бол Гүйцэтгэгч энэхүү техникийн шаардлагын бүлэг 400-д заасны дагуу одоогийн байгаа карьер, шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлуулах газрууд болон тэдэнд хүрэх туслах замуудыг цэвэрлэнэ.

Инженерийн зааврааp зайлуулж буюу хөдөлгөж үл болох хашилт, мод, малын хашаа болон бусад зүйлсийг энэхүү техникийн шаардлагын бүлэг 400-д заасан нөхцлийн дагуу хамгаална.

Инженер өөрөөр зааварчлаагүй бол Гүйцэтгэгч карьер, шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлуулах газруудын болон тэдэнд хүрэх туслах замуудын өнгөн хөрсийг хуулах ба шаардлагатай үед карьер болон шороон ордод тохиромжтой материалын үе гарч ирэх хүртэл хөрсний дээд хэсгийг ухаж авч зайлуулна. Өнгөн хөрсийг дангаар нь хуулж зайлуулах уу, эсвэл тохиромжтой материалын үе хүртлэх давхрагатай хамт хуулах уу гэдгийг Инженер зааварчилна. Түүнчлэн Инженер өнгөн хөрс болон тохиромжтой материалын үе хүртлэх давхрага нь шаардлага хангана гэж үзсэн бол зам барилгын ажилд ашиглах талаар зөвлөж болно.

Хуулсан өнгөн хөрсийг 1м-ээс өндөргүйгээр талбайд буулгана. Борооны усыг шингээн барих, гадаргын ус урсахаас хамгаалах зорилгоор өнгөн хөрсийг шатлан овоолно. Гүйцэтгэгч, салхинд өнгөн хөрсийг хийсгэж алдахгүйн тулд болон ургамалжилтыг сэргээх зорилгоор өнгөн хөрсний овоолгыг тогтмол усалж байна.

Карьер, шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлуулах газар тус бүрт ажил дуусаны дараа ашиглагдаагүй үлдсэн өнгөн хөрс ба тохиромжтой материалын үе хүртлэх давхрага үеийг тухайн газруудад нь тарааж хаялгүй, ойролцоох хонхор хотгор газруудад зөөж аваачин тэгшилнэ. Өнгөн хөрсийг дангаар нь овоолсон тохиолдолд түүнийг нөөцөлж байгаад газраа зассаныхаа дараа тараана.

### 608 МАТЕРИАЛЫГ СОНГОХ, ХОЛИХ, НӨӨЦЛӨХ

Инженер нь олборлох материалын төрөл, талбай, гүн зэргийг Гүйцэтгэгчид зааварчилна.

Зохистой ширхэглэлийг хангахын тулд Гүйцэтгэгч байгалиас олборлосон материалуудыг бульдозор, грейдер, ачигчийн шанага, ротор зэрэг тохиромжтой машин техникийг ашиглан холих шаардлага гарч болно. Эдгээр материалыг сайн хольж нэгэн жигд хольц болгоод ажилд ашиглахаас дор хаяж 21 хоногийн өмнө нөөц материал хадгалах талбайд овоолон хадгална.

Гүйцэтгэгч нь том хэмжээтэй юмуу шавар, хар шороон хөрс болон бусад чанар муутай, барилгын ажилд хор нөлөөтэй, тохиромжгүй материалуудыг ажилд ашиглах тохиромжтой материалуудаас тусгаарласан байх ёстой. Дээрх тохиромжгүй материалуудыг хаягдал зайлуулах газар луу зөөж буулгана. Шороон орд бүрт материалыг төрөл, ширхэглэл тус бүрээр нь ялгаж нөөцөлнө.

Материал нөөцлөх газраас материалыг авахдаа уланд нь байгаа материалтай хольж болохгүй бөгөөд ёроолын үеийг 100мм орчим зузаантай үлдээнэ.

Хэрэв нөөц материал нь шаардлагатай хэмжээнээс илүү гарсан бол Инженер өөрөөр зааварчлаагүй тохиолдолд гүйцэтгэгч түүнийг карьер болон шороон ордын дотор талбайд тараана.

Бутлах ба шигших ажил нь энэхүү техникийн шаардлагын бүлэг 500 ба дэд бүлэг 1303 (в)-д заасны дагуу хийгдэнэ.

**609 МАТЕРИАЛЫГ АШИГЛАХ**

Зам барилгын байнгын ажилд хэрэглэгдэх, шороон ордоос олборлосон материалд тавигдах шаардлага нь Гүйцэтгэгчийн бусад ажлуудад хамааралтай шаардлагаас давуу байдлаар ашиглагдана. Шороон ордоос олборлосон материалыг туслах зам, түр зам, бусад түр барилга г.м үндсэн ажлаас бусад ямар нэг ажилд Инженерийн зөвшөөрөлгүйгээр ашиглаж болохгүй.

**610 ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР**

Техникийн шаардлагын бүлэг 600-д хамааруулан ямар ч хэмжилт ба төлбөр хийгдэхгүй.

Гүйцэтгэгч нь техникийн шаардлагын бүлэг 600-д заасан шаардлагуудыг хангахтай холбогдсон зардлыг бусад ажлын нэгж үнэ ба өртөгт тооцож гэж үзнэ.

Хэрэв Инженер карьер ба шороон ордоос, тохиромжтой материалын үе хүртэл ухаж гаргасан давхрага үеийг зам барилгын үндсэн ажилд ашиглахаар зааварчилсан тохиолдолд хэмжилт ба төлбөрийг Техникийн шаардлагын тохирох бүлэгт заасны дагуу хийнэ.

# БҮЛЭГ 700 - УС ЗАЙЛУУЛАХ БАЙГУУЛАМЖИЙН УХМАЛ, ДҮҮРГЭЛТИЙН АЖИЛ, УС ЗАЛАХ ДАЛАН, ГҮҮРИЙН ХАМГААЛАЛТЫН АЖИЛ

## БҮЛЭГ 700 - УС ЗАЙЛУУЛАХ БАЙГУУЛАМЖИЙН УХМАЛ, ДҮҮРГЭЛТИЙН АЖИЛ, УС ЗАЛАХ ДАЛАН, ГҮҮРИЙН ХАМГААЛАЛТЫН АЖИЛ


| | | |
|---|---|---|
| 701 | БҮЛГИЙН ХАМРАХ ХҮРЭЭ | 7-3 |
| 702 | УХМАЛЫН АНГИЛАЛ | 7-3 |
| 703 | БАЙГУУЛАМЖИЙН СУУРИЙГ УХАХ | 7-3 |
| 704 | УХМАЛЫГ ХУУРАЙ БАЙЛГАХ | 7-3 |
| 705 | УХСАН ГАДАРГУУД ЦУТГАСАН СУУРЬ БА ЗАХЫН ТУЛГУУР | 7-4 |
| 706 | ИЛҮҮДЭЛ УХМАЛ БА ДҮҮРГЭЛТИЙН МАТЕРИАЛ | 7-4 |
| 707 | УХМАЛЫГ БУЦААН ДҮҮРГЭХ | 7-4 |
| 708 | БАЙГУУЛАМЖУУДЫГ ХАМГААЛАХ | 7-4 |
| 709 | УС ЗАЛАХ ДАЛАН БА ШИНЭ УРСГАЛ ЧИГЛҮҮЛЭХ УХМАЛЫН АЖИЛ | 7-5 |
| 710 | ЧУЛУУН БЭХЭЛГЭЭ | 7-5 |
| 711 | ЧУЛУУН АСГААС | 7-6 |
| 712 | ТҮШИЦ (АР) ХАНА | 7-6 |
| 713 | ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР | 7-7 |
| | (а) Зүйл: Зөөлөн материалд байгууламж барих ухалт хийх | 7-7 |
| | (б) Зүйл: зөөлөн материалд ус далах далан гаргах ухалт хийх | 7-7 |
| | (г) Зүйл: хатуу материалын ухалт хийхэд дэд-зүйл 713 (а)-ын дагуу гарах нэмэлтүүд | 7-7 |
| | (д) Зүйл: Шүүрүүлэх материал | 7-8 |
| | (е) Зүйл: Зохистой ширхэгтэй дүүргэгч материал | 7-8 |
| | (ё) Зүйл: Цементэн зуурмагаар бэхжүүлсэн чулуун бэхэлгээ | 7-8 |
| | (ж) Зүйл: Чулуун асгаас | 7-9 |
| | (з) Зүйл: Чулуун рисберм | 7-9 |
| | (и) Зүйл: Чулуун даланд ашиглах М12 маркийн арматургүй бетон | 7-9 |

## 701 БҮЛГИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү бүлэгт гүүр, хайрцган хоолой, түшиц хана болон бусад байгууламжийн ухмал, дүүргэлтийн ажлуудыг оруулсан. Үүнээс гадна, ус залах далан болон гүүрийн хамгаалалтын ажлуудыг хамруулна. Харин замын ухмал болон далангийг ажил энэ бүлэгт хамаарахгүй.

## 702 УХМАЛЫН АНГИЛАЛ

Материалыг доор тодорхойлогдсоны дагуу хатуу, зөөлөн гэж ангилна. Үүнд:

Хатуу материалд зөвхөн тэсрэх, дэлбэрэх бодис ашиглан тэсэлгээ хийж ил гаргасны дараа эсвэл хийн юмуу гидравлик механик ховхлогч царилыг ашиглан ухаж гаргах материал багтана. Зөөлөн материалаас гарсан тусдаа буй чулуу юмуу 0.75м$^3$-ээс том хэмжээтэй материалыг хатуу материал гэж ангилна.

Зөөлөн материал гэдэг нь дахин хэрэглэхэд тохиромжтой юмуу тохиромжгүй, хатуу материалаас бусад бүх материал болно.

## 703 БАЙГУУЛАМЖИЙН СУУРИЙГ УХАХ

Байгууламжууд болон бусад дагалдах шуудууны суурийг аль болох бага ухна. Ухмалын хажуу талуудыг босоо байдлаар ухах ба эргэн тойрны сул хөрсөнд суулт үүсэх/нурах юмуу эвдрэх зэргээс сэргийлэх үүднээс мод эсвэл шпунтан бэхэлгээ (чулуун бэхэлгээ), тулгуур, тулаас зэргийг хийж өгнө.

Хатуу материалаас бусад материалд хийсэн байгууламжийн суурийг тавих бүх ухмалын гадаргуун суурийг барих ажил дуусангуут 95% хүртэл хамгийн их хуурай нягт(ХИХН)-аар (AASHTO T180) нягтруулна.

Хатуу материалын ухмалын гадаргуу дээр дор хаяж 50мм зузаан даац багатай (тэгшилгээний) бетон дэвсэнэ.

Ухмалын гадаргууд хатуу зөөлөн холимог материал байвал, байгаа материалын пропорцоос хамааран гүйцэтгэгч инженерийн өгсөн зааврын дагуу суурийн доод төвшингөөс доош 300мм-ээс багагүй зузаан зөөлөн материалыг зайлуулж оронд нь тэгшилгээний үеийн дээд хэсэг хүртэл бүтээцийн бус бетон хийх эсвэл суурийн доод төвшингөөс доош 300мм-ээс багагүй зузаан хатуу материалыг зайлуулж оронд нь зөөлөн материал дэвсэн 95% хүртэл ХИХН-аар (AASHTO T180) нягтруулна.

Газрын байдлаас үүдэн тогтоосон суурийн үенд шаардлага хангасан суурийг хийх боломжгүй байвал гүйцэтгэгч, инженерийн зааврын дагуу, тохиромжтой суурийн материалын үе гарах хүртэл нь эсвэл инженерийн зааварласан гүн ба өргөнд зохисгүй материалыг ухаж зайлуулна. Гүйцэтгэгч, нэмж ухалт хийсэн газруудад даац багатай (тэгшилгээний) бетоны доод үеийн тогтоосон төвшин хүртэл зөвшөөрөгдсөн материалаар буцаан дүүргэлт хийж 95% хүртэл ХИХН-аар (AASHTO T180) нягтруулна.

Ухмал хийсэн хэсгүүдэд барилгын ажил эхлэхээс өмнө инженерийн зөвшөөрлийг авна.

## 704 УХМАЛЫГ ХУУРАЙ БАЙЛГАХ

Бүх ухмалыг хуурай байлгах ба тэдгээрийг усанд автагдах, цас мөсөнд дарагдахаас сэргийлэх шаардлагатай бүх арга хэмжээг гүйцэтгэгч авна.

Инженерийн шаардсан тохиолдолд, суурийн үеийн гадна талд усгүйжүүлэх насос бүхий худаг барина. Суулт, эвдрэл үүсгэх юмуу эргэн тойрны газраас жижиг ширхэгтэй бүрэлдэхүүн хэсгүүдийг угааж арилгах талтай тул ухмалын усыг хэт их шахуургадахыг үл зөвшөөрнө.

Инженерийн бодлоор, суурь нь зөөлөрсөн юмуу тогтворгүй болсон бөгөөд зөвхөн гүйцэтгэгчийн өөрийн мөрдсөн ажлын арга барилаас үүдэн нэмэлт ухмалын ажил хийх шаардлагатай болсон гэж үзвэл инженерийн зааварласнаар зөвшөөрөгдсөн материалаар дүүргэлтийг хийн 95% хүртэл ХИХН-аар (AASHTO T180) нягтруулах юмуу эсвэл бетоноор дүүргэлтийг хийнэ. Бүх ухмал болон буцаан дүүргэлтийн ажлыг гүйцэтгэгч өөрийн

зардлаар хийж гүйцэтгэнэ.

### 705 УХСАН ГАДАРГУУД СУУРЬ БА ЗАХЫН ТУЛГУУР ЦУТГАХ

Суурь ба захын тулгуурыг зургийн дагуу юмуу инженерийн зааварчилсанаар ухсан гадаргуу дээр цутгана. Суурь ба захын тулгуурын ухмалыг маш нямбай ухаж шаардлагатай хэлбэрээр засаж тэгшилнэ. Илүү ухсан тохиолдолд суурь ба захын тулгуурын ухсан гадаргуугийн хоорондох зайг тэгшилгээний үед хэрэглэхээр заасан бетонтой адил зэргийн бетоноор буцаан дүүргэнэ. Энэ бетон дүүргэлтийг суурь ба захын тулгуурыг цутгахаас өмнө дэвсэх ба гүйцэтгэгч өөрийн зардлаар хийж гүйцэтгэнэ.

### 706 ИЛҮҮДЭЛ УХМАЛ БА ДҮҮРГЭЛТИЙН МАТЕРИАЛ

Ухмалын илүүдэл материалыг энэхүү техникийн шаардлагын бүлэг 500 ба 600-д заасны дагуу хаягдал материал зайлуулах тогтоосон газарт хаях ба эсвэл инженерийн зүгээс ашиглах боломжтой гэж үзсэн тохиолдолд газар шорооны ажилд ашиглаж болно.

Байгууламжийн ар хэсэг эсвэл эргэн тойронд буцаан дүүргэлт, чигжээс зэргийг хийхдээ зөвхөн инженерийн зөвшөөрсөн материалыг ашиглана.

### 707 УХМАЛЫГ БУЦААН ДҮҮРГЭХ

Гүйцэтгэгч, байгууламжийн эргэн тойронд дүүргэлт хийх юмуу нүх, ухмалыг буцаан дүүргэх, аливаа байгууламжид ачаалал өгөхөөс өмнө инженерийн зөвшөөрлийг авна.

Байгууламжийн ард тал ба эргэн тойронд, дүүргэлтийн тогтоосон өндөр хүртэл тэдгээрийн төвшний хооронд дүүргэлт эсвэл буцаан дүүргэлт хийх ажлын төлөвлөсөн дараалыг гүйцэтгэгч инженерт танилцуулж батлуулна.

Гүйцэтгэгч, инженерийн зөвшөөрсөн сонгосон материалыг ашиглан дүүргэлт, буцаан дүүргэлтийн ажлыг хийж гүйцэтгэх ба 150мм-ээс хэтрэхгүй зузаан хэвтээ үеэр дэвсэж нягтруулна. Үе бүрийг сайтар хольж, услан шаардлагатай бол хатаах бөгөөд дор хаяж 95% хүртэл ХИХН-аар (AASHTO T180) нягтруулна.

Ухмалын хажуу талыг хамгаалах зорилгоор хийсэн модон тулц, шпунтан бэхэлгээг 150мм-ийн шатлалаар нягтруулалт хийсний дараа үечлэн дээшлүүлж сугална. Инженерийн зааварласан газруудад модон тулц юмуу шпунтан бэхэлгээг уг газарт тогтмол байлгана.

Зурагт үзүүлсэн юмуу инженерийн зааварласан газарт гүйцэтгэгч инженерийн зөвшөөрсөн ширхэглэлийн бүрэлдэхүүн нь шигшүүрийн ¹89 (9.5-1.18мм) байх AASHTO M6/AASHTO M43-ын шаардлагыг хангасан зохистой ширхэгтэй дүүргэгч материал ба шигшүүрийн ¹467 (37.5-4.75мм)-д тохирох AASHTO M43-т нийцэх ширхэглэл бүхий шүүрүүлэх материалыг дэвсэнэ. Гүйцэтгэгч хөдөлгөөнт хашлага юмуу инженерийн зөвшөөрсөн өөр бусад аргыг буцаан дүүргэлтийн үед ашиглаж зохистой ширхэгтэй дүүргэгч материалыг дэвсэхээс өмнө уг үеийг дэвсэн дор хаяж 150мм хүртэл нягтруулан, дараа нь хажуу хэсгийн газар шорооны дүүргэлтийг хийхээс өмнө тэрхүү зохистой ширхэгтэй дүүргэгч материалын үеийг дэвсэн дор хаяж 150 мм хүртэл нягтруулна. Энэ техникийн шаардлагын бүлэг 700-ийн дагуу хийгдэх зохистой ширхэгтэй дүүргэгч материал ба энэхүү техникийн шаардлагын бүлэг 500-ын дагуу хийгдэх хажуугийн газар шорооны ажлын хоорондын зааг нь зурагт үзүүлсэний дагуу юмуу инженерийн зааварчилсанаар хийгдэнэ. Газрын төвшнөөс дээшхи хэсэгт даланд хэрэглэж буй материалыг хэрэглэнэ.

### 708 БАЙГУУЛАМЖУУДЫГ ХАМГААЛАХ

Гүйцэтгэгч шаардлагатай усны хаалт, кессон, заамал тулгуур, суваг, судаг, бусад түр зам, хамгаалалтын ажлуудыг хийх, барих, засвар арчлалтыг хангах зэрэг ажлыг хийж, ажлын талбайн хэсгүүдэд тогтсон усыг зайлуулахад шаардлагатай насос болон бусад тоног төхөөрөмжийг сурилуулж, ажиллуулан, засвар арчлалтыг хийнэ.

Усны хаалт болон бусад түр суурилуулах байгууламжуудын зураг төслийг энэхүү техникийн шаардлагын зүйл 114-ийн дагуу түр ажил эхлэхээс өмнө инженерт танилцуулж батлуулна. Гүйцэтгэгч тэдгээр байгууламжуудыг суурилуулахдаа ажлын талбайн дээд

болон доод хэсэгт үер ус болох, хүн амьтан, эд хөрөнгөнд аюул учруулах зүйлээс зайлсхийнэ.

Инженерийн зүгээс өөрөөр заагаагүй бол тэдгээр бүх байгууламжуудыг ажил дуусахад буулгаж зайлуулна.

## 709 УС ЗАЛАХ ДАЛАН БА ШИНЭ ГОЛЬДРОЛ ГАРГАХ УХМАЛ

Гол горхины хажуугаар түр зам барих, өргөсгөх, гүнзгийлэх юмуу тэгшлэн шулуутгах эсвэл шинэ гольдрол гаргахад зориулан ухмал хийх ажлыг зурагт заасны дагуу юмуу инженерийн зааврааp хийж гүйцэтгэнэ. Энэ ухмалын ажилд талбайн цэвэрлэгээ, налууг засаж тэгшлэх, шороон даланг хусах, ухмалаас гарсан материалыг зайлуулах гэх мэт ажил багтана.

Усны гольдролыг шилжүүлэх шаардлага гарах эсвэл инженер зааварчилгаа өгсөн тохиолдолд, анхны сувгийн өвс ургамал, зөөлөн хаягдал зэргийг цэвэрлэн зайлуулж, зөвшөрөөгдсөн материалаар буцаан дүүргэж 95% хүртэл ХИХН-аар (AASHTO T180) нягтруулна. Нөөц ордууд нь сувагнуудаас нэлээн зайтай байх шаардлагатай. Гүүрийг барих явцад хуучин сувгийг буцаан дүүргэх ажлыг хамтад нь хийнэ. Буцаан дүүргэх ажлыг нэг улирлын дотор хийж гүйцэтгэхийн тулд бүх хүчээ дайчилж ажиллана. Хэрвээ бүх дүүргэлтийн ажлыг нэг ажлын улирлын дотор хийж гүйцэтгэхэд эргэлзээтэй гэж үзвэл гүйцэтгэгч хийгдэж дуусан ажлыг хамгаалах тохиромжтой арга хэмжээг авна.

Ус залах далан ба хамгаалалт бэхэлгээний ажилд чулуун бэхэлгээ ба асгаасны ажлууд багтах ба эдгээр нь үерийн ус, мөсний улмаас үүсч болох эвдрэлээс гүүрийн байгууламж ба замуудыг аюулгүй байлгах явдлыг баталгаажуулахад шаардагдана.

## 710 ЧУЛУУН БЭХЭЛГЭЭ

Зурагт үзүүлсэн юмуу инженерийн зааварласан газарт гүйцэтгэгч ухаж, засаж тэгшлэн, чулуун бэхэлгээ хийнэ.

Чулуун бэхэлгээг хатуу, бат бөх, ердийн хэлбэртэй чулуугаар хийнэ. Карьерын чулууг ашиглана. Бөөрөнхий хэлбэртэй чулуу ашиглахыг хориглоно. Ус юмуу цаг агаарын нөлөөгөөр элэгдэж өгөршдөг чулууг ашиглахгүй. Хамгийн том хэмжээтэй чулуунуудыг ашиглах бөгөөд Инженер өөрөөр зөвшөөрөөгүй тохиолдолд 35 кг-аас бага жин татах аливаа фрагментыг хэрэглэхгүй. Чулууны хэлтэрхийнүүдийн хамгийн бага зөвшөөрөгдөх хэмжээ 25мм байх ба бэхэлгээний нүх сүвийг бөглөхөд тохирсон байна. Бэхэлгээний чулууны бэхэлгээний хувийн жин нь дор хаяж 2.40 байна.

Чулуун бэхэлгээ хийх хэсгийг ухаж, хэлбэржүүлэн тэгшилж чулуунуудыг тавихад бэлэн болгон 95% хүртэл ХИХН-аар (AASHTO T180) нягтруулна. Бэхэлгээ хийх хажуу налуугийн хормойгийн дагуу юмуу голын гольдролын ёроолын дэвсэгт хийгдсэн бэхэлгээний устай харьцах хэсгийн дагуу шуудуу татна. Шуудууны ёроолоос эхлэн чулуунуудыг байрлуулан хажуу налуу дээр чулуунуудыг хооронд нь сайтар чигжиж суулгаж өгнө. Чулуун бэхэлгээний тогтоосон зузаанаас чулууны хамгийн өргөн тэгш өнцөгтэй тал нь илүү гараагүй л бол тэдгээрийг хажуу налууны ирмэг дээр шигтгэн суулгана. Чулуунуудыг хамгаалалт хийх гадаргуу дээр сайтар чигжиж дагтаршуулж хооронд нь зайгүй болтол нь тааруулан байрлуулах замаар маш бага завсар үлдээх ба тэдгээрийг тохирох байдлаар нь зорж хэлбэр гарган шаантагласан үртэс чулуугаар чигжиж дүүргэнэ. Бэхэлгээний дээд хэсгийг залгаа үетэй хамт тэгшилнэ.

Цементэн зуурмаг хийхээр заагдсан газруудад чулууны гадаргууг сайтар цэвэрлэж, наалдсан хог, шавраас нь салгана. Ус зайлуулах нүх болгон 20%-ийн босоо заадас үлдээнэ гэж инженер зааварласан гэж тооцон бүх нүх сүвийг нийтэд нь бөглөх үүднээс 1:3 цемент, элсний харьцаагаар бэлтгэгдсэн цементэн зуурмагийг чулуунуудын хоорондох зай завсраар чигжиж шавна. Цементэн зуурмагийг бэхэлгээ хийсэн гадаргуутай хамт тэгшилж багсаар сайтар шүүрдэж цэвэрлэн дээд талын хэсгийг ил гаргана. Цементэн бэхэлгээг нойтон шуудайгаар хучиж юмуу эсвэл зөвшөөрөгдсөн аргаар бэхжүүлэх замаар цементэн зуурмагаар бэхэлгээ хийсний дараа долоогоос багагүй хоногийн турш цаг агаарын нөлөөнд автахаас хамгаалах арга хэмжээ авна.

Бэлэн болсон налуу юмуу чулуун бэхэлгээг хийхийн өмнөх гадаргуу дээр чулуун бэхэлгээний нүх сүвээр дамжин далангийн шүлтгүйжилт үүсэхээс сэргийлэх, бэхэлгээн дээр хөрсний овойлт үүсгэлгүйгээр усыг чөлөөтэй урсгах боломжийг хангах үүднээс *шүүрүүлэх үеийг* тавина. Чулуун бэхэлгээний дор тогтоосон зузаан бүхий нэг үе тэгшилсэн шүүрүүлэх үеийг хангана. Шүүрүүлэх орчинд орох агрегат нь AASHTO Авто зам барих удирдамж техникийн шаардлагын бүлэг 700-ын шаардлагуудыг хангах ёстой.

*Чулуун рисберм*: Рисбермд ашигласан чулуу нь хатуу, бат бөх, ердийн хэлбэртэй чулуу байна. Ус, цаг агаарын нөлөөгөөр элэгдэж өгөршдөг чулууг ашиглахгүй. Бөөрөнхий хэлбэртэй чулуунаас илүү өнцөг хэлбэртэй чулууг ашиглана. Чулууны хэмжээ нь зурагт заагдсан юмуу инженерийн зөвшөөрсөний дагуу байна. Рисбермийг дэвсэх гадаргууг зурагт заасан өргөн уртад тэгшилж бэлтгэнэ.

### 711 ЧУЛУУН АСГААС

Чулуун асгаас нь хатуу, бат бөх, буталсан, карьераас олзворлосон юмуу байгалийн чулуун агрегатаас бүрдэнэ. Дор хаяж 75мм зузаан, хамгийн бага нь 23 кг-ын жинтэй байх чулууны дор хаяж 60 хувь нь 35 кг-аас илүү масстай байх ба чулуун асгаасны жигд тархалтыг хангах үүднээс чулуунуудын хооронд шаантаглаж чигжихэд тохирох хэмжээтэй фрагмент юмуу хэлтэрхийнүүдийг агуулсан байна. Чулуун асгаасны хувийн жин нь дор хаяж 2.40 байна.

Чулуун асгаас дэвсэх гадаргууг хэлбэржүүлэн тэгшилж 95% хүртэл ХИХН-аар (AASHTO T180) нягтруулна. Чулуун асгаасыг 600мм гүнд чулуун асгаасны тогтоосон өндөртэй шуудуунд баригдсан 1м өргөн хуурай чулуун өрлөг ханаар бэхэлнэ.

Инженерийн зааварласан, зураг дээр үзүүлсэн хэсэгт нэг эсвэл хоёр үе ширхэглэлийн бүрэлдэхүүнээр сонгосон нэвчүүлэх материалуудаас бүрдсэн шүүрүүлэгч материалыг бэлтгэсэн гадаргуу дээр шаардагдах зузаантайгаар дэвсэж дэвссэн үе бүрийг тэгшилж засна. Уг ширхэглэл бүхий шүүрүүлэх материалыг ширхэглэлийн бүрэлдэхүүнээр сонгох шаардлага нь техникийн шаардлагын зүйл 707-ийн шаардлагад нийцсэн юмуу инженерийн зааварласны дагуу байна.

Чулуунуудыг далангийн налуугийн ёроолоос эсвэл газрын хөрснөөс дээш том чулуунуудыг доод хэсэгт нь тавих байдлаар хооронд нь маш ойрхон чигжиж байрлуулна. Тэгш, дагтаршуулсан гадаргуу барих үүднээс сайтар чихэн дүүргэж тохиромжтой үртэс чулуунуудаар шаантаглан чигжинэ.

### 712 ТҮШИЦ/АР ХАНА

Гүйцэтгэгч, зурагт заасан юмуу инженерийн зааварласан шулуун, налуу, хэмжээсүүдийн деталийн дагуу байгууламжийн бетоныг байрлуулж, дагалдах түшиц ханыг барина.

Бүх материал нь энэ техникийн шаардлагын ,,Бетоны ажил,, буюу бүлэг 1300-д тавигдсан шаардлагыг хангасан байна.

Газар дээр цутгах бетоны ажил нь ,,Бетоны ажил,, буюу бүлэг 1300-ийн шаардлагыг хангана. Бетоны марк нь М12 байна.

Шүүрүүлэх үе/ширхэглэл бүхий шүүрүүлэх материал нь энэ техникийн шаардлагын зүйл 707-ын дагуу байна.

Ус зайлуулах нүх нь 50мм-ийн диаметртэй, хананы нийт уртад хийгдэх ба шүүрүүлэгчийн амсарын тал руу чиглэсэн босоо 1 хэвтээ 20-ын налуутай байна. Ус зайлуулах нүхний хоорондын зай нь аль ч чиглэлд 1.0м-ээс хэтрэхгүй бөгөөд сөөлжүүлэх юмуу инженерийн зааварласны дагуу байрлуулагдсан байна.

### 713 ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР

а/ Зүйл: Зөөлөн материалд байгууламж барих ухалт хийх

Нэгж: : $м^3$

Байгууламжийн зөөлөн материалын ухмалыг куб метрээр хэмжинэ. Ухмалын

эзэлхүүнийг тооцохдоо, даац багатай (тэгшилгээний) бетоны зааварчлагдсан зузааныг хамруулаад, суурь буюу байгууламж газраас дээш босоо чиглэлд өргөгдөх үед үүсэх онолын хоосон зай хөндийгөөр тооцоолно. Эдгээр хязгаараас хэтэрсэн ажлын талбайд төлбөр хийгдэхгүй. Энэ онолын хоосон зайг тооцоолохдоо инженер ба гүйцэтгэгчийн тохиролцсон далангийн доорхи ул суурийн төвшин буюу шороон далангийн төвшингийн аль илүү намханд нь болон ухмалын ёроолын зааварласан төвшин хоёрын хоорондох зөрүү дээр үндэслэн тооцоолно.

Байгууламжийн зөөлөн материалын ухмалын үнэлгээнд дараахи ажлуудын зардал багтана. Үүнд:

- Инженерийн зааварласан буюу зурагт үзүүлсэн гүн хүртэл ухах
- Ухмалын бетон цутгах гадаргууг хэлбэржүүлж, тэгшлэх
- Ухмалын суурь тавигдах гадаргууг нягтруулах
- Ухмалаас гарсан буюу сонгон авсан материалаар буцааж дүүргэх
- Ашиглахад тохиромжгүй буюу илүү гарсан ухмалын материалыг хаягдал материалын талбай руу зөөх
- Энэ техникийн шаардлагын зүйл 701, 702, 703, 704, 705, 706, 707 ба 708-г хангахтай холбоотой зардлууд

Байгууламжуудтай залгаа газрын төвшнээс дээш өндөрлөгөө хийхэд зориулж далан барих үнэлгээ ба үнээс тусдаа төлбөр хийгдэхгүй.

б/ Зүйл : зөөлөн материалд ус залах далан гаргах ухалт хийх

Нэгж : $м^3$

Зөөлөн материалд голын урсгалыг залах ухалт хийх ажлын хэмжих нэгж нь куб метр байна. Эзэлхүүн нь ухмал хийх талбайн тэнхлэгийн дагуу 10 м-ээс хэтрэхгүй зайд хэмжсэн талбайн дундажийг ухмалын уртад үржүүлсэн үржвэртэй тэнцүү байна. Талбайн хэмжээг ухмалыг эхлэхээс өмнө хэмжсэн газрын төвшин буюу одоо байгаа голын эсвэл усны урсгалын огтлолоос ба зурагт үзүүлсэн буюу инженерийн зааварласнаар тооцон гаргана.

Зөөлөн материалд голын урсгалыг залах ухмалын ажил хийх үнэлгээнд дор дурдсан ажлын зардлыг тооцон оруулна. Үүнд:

- Аливаа гүн ба гольдролын өргөн хүртэл хийх ухмал
- Ухмалын хажуу талууд ба суурийг хэлбэржүүлж тэгшлэх
- Ухмалын материалыг ашиглагдахгүй материалын талбайд зөөвөрлөх
- Энэ техникийн шаардлагын зүйл 701, 702, 704, 708 ба 709-г хангахтай холбоотой зардлууд

г/ Зүйл: хатуу материалын ухалт хийхэд дэд-зүйл 713 (а)-ын дагуу гарах нэмэлтүүд

Нэгж: $м^3$

Энэ техникийн шаардлагын дэд зүйл 713 /а/-д хамаарах хатуу материалын ухмалын ажлын хэмжих нэгж нь куб метр байна. Хатуу материалын ухмалын эзэлхүүн нь ухмалын дагуу инженертэй зөвшилцсөн зайд хэмжсэн дундаж хөндлөн огтлолын талбайг хатуу материал гаргаж авах ухмалын уртад үржүүлсэн үржвэртэй тэнцүү байна. Хөндлөн огтлолын талбайг ухмал хийхээс өмнө хатуу материалын орой хэмжсэн төвшин ба хатуу материал гаргаж авсаны дараахи төвшин буюу тодорхойлсон төвшинд хүртэл хэмжсэн түвшнээс тооцоолно.

Эзэлхүүнээрээ 0.75 $м^3$-ээс том хэмжээтэй чулуу бүхий ухмалаас гарах хатуу

материалын эзэлхүүнийг түүнийг зөөх тээврийн хэрэгслийн сул эзэлхүүний 50%-иар бодож төлбөр хийнэ.

Хатуу материалын ухмалын дэд зүйл 713 (а) дахь нэмэлт ухмалын үнэлгээнд аливаа гүнд хийсэн ухмалын зардал ба энэ техникийн шаардлагын зүйл 701, 702, 703, 704, 705, 706, 707 ба 708-ийг хангахтай холбоотой зардлыг тооцож оруулна.

д/ Зүйл : Шүүрүүлэх материал

Нэгж: $м^3$

Шүүрүүлэх материалыг хэмжих нэгж нь куб метр байна. Материалын эзэлхүүнийг шүүрүүлэх материалаар буцааж дүүргэхээр зааварласан талбайг уг материалыг тавих дундаж гүний хэмжээгээр үржүүлсэн үржвэрээр тооцоолж гаргана.

Шүүрүүлэх материалын үнэлгээнд дор дурдсан ажлуудын зардлыг тооцоолж оруулна.

- Материалыг олборлох
- Тодорхой гүнд буцаан дүүргэлт хийх
- Бүх шаардлагатай тээвэрлэлт
- Энэ техникийн шаардлагын зүйл 701, 704, 707, 708 ба 711-г хангахтай холбоотой зардлууд

е/ Зүйл : Зохистой ширхэгтэй дүүргэгч материал

Нэгж: $м^3$

Зохистой ширхэгтэй дүүргэгч материалыг хэмжих нэгж нь куб метр байна. Материалын эзэлхүүнийг зохистой ширхэгтэй дүүргэгч материалаар буцааж дүүргэхээр зааварласан талбайг уг материалыг тавих дундаж гүний хэмжээгээр үржүүлсэн үржвэрээр тооцоолж гаргана.

Зохистой ширхэгтэй дүүргэгч материалын үнэлгээнд дор дурдсан ажлуудын зардлыг тооцоолж оруулна.

- Материалыг олборлох
- Тодорхой гзнд хүртэл буцааж дүүргэх
- Бүх шаардлагатай тээвэрлэлт
- Энэ техникийн шаардлагын зүйл 701, 704, 707 ба 708-г хангахтай холбоотой зардлууд

ё/ Зүйл: Цементэн зуурмагаар бэхжүүлсэн чулуун бэхэлгээ

Нэгж: $м^2$

Цементэн зуурмагаар бэхжүүлсэн чулуун бэхэлгээг хэмжих нэгж нь квадрат метр байна. Талбайг чулуун өрлөг хийхээр инженерийн зааварласан налууд хэмжсэн талбайгаар тооцоолно.

Цементэн зуурмагаар бэхжүүлсэн чулуун бэхэлгээний үнэлгээнд дор дурдсан зардлыг оруулж тооцно. Үүнд:

- ухмал хийх
- ухмалын материалыг хаягдал материалын талбайд зөөвөрлөх
- нэг шугам ба төвшинд тэгшлэх
- ухмалын хажуу талууд ба суурийг нягтруулах
- чулуун бэхэлгээнд ашиглах материалыг олборлох ба өрлөг хийх
- Бүх шаардлагатай тээвэрлэлтүүд

- Энэ техникийн шаардлагын зүйл 701, 709 ба 710-г хангахтай холбоотой зардлууд

ж/ Зүйл: Чулуун асгаас

Нэгж: $м^3$

Чулуун асгаасыг хэмжих нэгж нь куб метр байна. Хийхээр заварласан чулуун асгаасын эзэлхүүнийг зурагт үзүүлсэн буюу инженерийн заварласан хэмжээгээр тооцоолно.

Чулуун асгаасын үнэлгээнд дор дурдсан ажлуудын зардлыг оруулан тооцно. Үүнд:

- хуурай чулуун өрлөгтэй хананы ухмал
- ухмалын материалыг тогтоосон хаягдал материал зайлуулах талбайд зөөвөрлөх
- чулуун асгаасын материалыг олборлох, дэвсэх, чулуун асгаасыг хийх
- бүх шаардлагатай тээвэрлэлтүүд
- Энэ техникийн шаардлагын зүйл 701, 709 ба 710-г хангахтай холбоотой зардлууд

з/ Зүйл: Чулуун рисберм

Нэгж: $м^3$

Рисбермийг хэмжих нэгж нь куб метр байна. Хийхээр заварласан рисбермийн эзэлхүүнийг зурагт үзүүлсэн буюу инженерийн заварласан хэмжээгээр тооцоолно.

Рисбермийн үнэлгээнд дор дурдсан ажлуудын зардлыг оруулан тооцно. Үүнд:

- ухмал
- хуурай чулуун өрлөгтэй хананы ухмал
- ухмалын материалыг тогтоосон хаягдал зайлуулах талбайд зөөвөрлөх
- нэг шугам, төвшинд тэгшлэх
- ухмалын хажуу талууд ба суурийг нягтруулах
- Рисбермийн материалыг олборлох, дэвсэх, чулуун асгаасыг хийх
- Бүх шаардлагатай тээвэрлэлтүүд
- Энэ техникийн шаардлагын зүйл 801, 802, 815 ба 817-ыг хангахтай холбоотой зардлууд

и/ Зүйл: Чулуун далан

Нэгж: $м^3$

Чулуун даланд ашиглах чулууг зурагт үзүүлж, инженерийн заварласан газарт куб метрээр хэмжинэ.

# БҮЛЭГ 800 - ХООЛОЙ БА УС ЗАЙЛУУЛАХ БАЙГУУЛАМЖ

## БҮЛЭГ 800 - ХООЛОЙ БА УС ЗАЙЛУУЛАХ БАЙГУУЛАМЖ


801 БҮЛЭГТ ХАМРАГДАХ ЗҮЙЛ 8-3
802 АЖЛЫН ДАРААЛАЛ 8-3
803 УХМАЛЫН АНГИЛАЛ 8-4
804 ХООЛОЙН БА УС ЗАЙЛУУЛАХ БАЙГУУЛАМЖИЙН УХМАЛ 8-4
805 ХАТУУ МАТЕРИАЛЫН УХМАЛ 8-5
806 УХМАЛ ДАХЬ УС 8-5
807 УГСАРМАЛ БЕТОН ДУГУЙ БА ХАЙРЦГАН ХООЛОЙН ХЭСЭГЛЭЛ 8-5
808 ХООЛОЙН СУУРЬ ТАВИХ БА ХООЛОЙГ СУУЛГАХ 8-5
а/ газар дээрх эсвэл сонгож авсан материалаар хоолойн суурь тавих ба хоолойг суулгах 8-6
б/ Бетоноор хоолойн суурь тавих болон хоолойг суулгах 8-6
809 БЕТОН ХООЛОЙГ ХОЛБОХ 8-6
а/ Хатуу холбоос 8-6
б/ Уян холбоос 8-7
в/ Хоолойн төгсгөл 8-7
810 БЕТОН СУУРЬ, ЧИГЖЭЭС БА ЗУЗААЛАХ ХЭСЭГ 8-7
811 БУЦААЖ ДҮҮРГЭХ 8-7
812 ШҮҮРҮҮЛЭХ ҮЕ 8-8
813 ХАМГААЛАЛТЫН АЖЛУУД 8-9
814 УС ЗАЙЛУУЛАХ БАЙГУУЛАМЖИЙН ЖИЖИГ ХИЙЦҮҮД 8-9
815 ШУУДУУ, ЧУЛУУН БЭХЭЛГЭЭ, РИСБЕРМ 8-10
816 ЧУЛУУН ӨНГӨЛГӨӨ 8-10
817 ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР 8-11

**801 БҮЛЭГТ ХАМРАГДАХ ЗҮЙЛ**

Энэ бүлэг дор дурдсан зүйлсийг хамрана. Үүнд:

а/ бетон хоолойнуудыг угсарч суулгах

б/ хоолойны орох, гарах амсарын хийцүүд, ус цуглуулах худаг, каскад болон эдгээртэй төстэй байгууламжуудыг барих,

в/ угаагдлаас хамгаалах рисбермийг хангаж, угсрах

г/ дор дурдсан шуудууны ухмал, өндөрлөгөө ба бусад ажлууд

(i) хоолой байрлуулах суваг

(ii) орох амсрын шуудуу

(iii) гарах амсрын шуудуу

(iv) тахир шуудуу

(v) тусгаарлах шуудуу

(vi) шүүрүүлэх үе

(vii) уулын шуудуу

(viii) жижиг хийцүүд

Хажуугийн шуудууны барилгын ажилд тавигдах шаардлагыг энэ техникийн шаардлагын бүлэг 500-д оруулсан болно.

Ус зайлуулах байгууламжийн барилгын ажил, чулуун бэхэлгээтэй хажуу налуугийн хамгаалалтын ажлуудад тавигдах шаардлагыг энэ техникийн шаардлагын бүлэг 700-д оруулсан.

**802 АЖЛЫН ДЭС ДАРААЛАЛ**

Ажлын зургуудад хоолой бүрийн байршил, хэмжээний талаар анхан шатны удирдамжийг өгсөн болно. Урт, жишүү болон ёроолын түвшний нарийвчлалыг барилгын ажлын явцад гүйцэтгэгчид үе үе өгч байна. Энэхүү техникийн шаардлагын бүлэг 300-д нийцүүлэн дагуу огтлол, хөндлөн огтлол болон бусад мэдээлийг ирүүлнэ. Гүйцэтгэгч нь гэрээний нөхцлийн дэд зүйл 14.1-ийн заалтын дагуу танилцуулах ажлын хөтөлбөртөө энэхүү техникийн шаардлагын бүлэг 300-ийн дагуу дээр дурдсан мэдээллийг ирүүлэх болон хоолойн нарийвчилсан мэдээллийг гаргахын хоорондох хугацааг тооцсон байна.

Бүх хоолой ба ус зайлуулах байгууламжийн барилгын ажлыг сайтар төлөвлөсөн байна. Гүйцэтгэгч нь, хэрвээ инженер өөрөөр заагаагүй бол гэрээний нөхцлийн дэд зүйл 14.1-ийн заалтын дагуу, эдгээр байгууламжийн дээр буюу дэргэд далан барихаас өмнө бүх хоолой ба ус зайлуулах байгууламжийн ажлыг дуусгахаар ажлынхаа хөтөлбөрт тусгасан байх ёстой.

Хэрвээ гүйцэтгэгч, далан барихын өмнө хоолой барих шаардлагагүй ус нэвтрүүлэх нөхцөл байдал байна гэж үзвэл ажлын ердийн дараалыг өөрчлөх хүсэлтийг бичгээр инженерт гаргана. Дор дурдсан нөхцөлд инженер энэ хүсэлтийг зөвшөөрч болно. Үүнд:

а/ Гүйцэтгэгч хоолой болон даланд эвдрэл гарах эсвэл эдгээрийг барих ажил хойшлогдвол хариуцлага хүлээнэ.

б/ Далан барих ажил бүрэн дуусаны дараа хоолойн барилгын ажлыг яаралтай эхлэнэ.

Ухмал дахь замын далан доор хоолой барих газарт ухмал ба буцааж дүүргэх ажлыг газар шорооны ажлын ихэнх хэсэг дуусаны дараа гэхдээ ухмал дахь далангийн төвшнээс доош 300 мм үеийг боловсруулахын өмнө гүйцэтгэнэ. Хэрвээ гүйцэтгэгч ажлын энэ дараалыг өөрчлөхийг хүсвэл инженерт энэ тухай хүсэлтийг бичгээр гаргана. Газар шорооны ажлыг дуусахаас өмнө эдгээр хоолойн ухмалыг хийнэ гэсэн гүйцэтгэгчийн хүсэлтийг, хоолойн ухмалын төлбөрийг далангийн төвшнээс доош ухсан хэмжээгээр хийх

нөхцөлд инженер зөвшөөрч болно.

**803 УХМАЛЫН АНГИЛАЛ**

Хоолой ба ус зайлуулах байгууламжийн ухмалыг дараахи байдлаар ангилна. Үүнд:

а/ зөөлөн материалын ухмал

б/ энэхүү техникийн шаардлагын зүйл 703-д тодорхойлсон хатуу материалын ухмал

Зөөлөн материалд барилгын ажилд тохирох материал, тохирохгүй материал, усанд дэвтсэн материал багтах боловч үүгээр хязгаарлагдахгүй.

Ухмалаас гарсан материал нь эзэлхүүнээрээ тус бүр нь 0.75 $м^3$-аас том хатуу бул чулууг агуулж байвал ийм чулуулгийг хатуу материал гэж ангилна. Ухмалд тааралдаж байгаа, эзэлхүүнээрээ 0.75$м^3$-аас бага цул чулуулгийг хатуу материал гэж тооцохгүй.

Барилгын ажлын явцад илэрч байгаа материалын ангиллыг инженерийн төлөөлөгч ба гүйцэтгэгч нар зөвшилцөх ёстой. Материалын ангиллын талаар маргаан үүссэн тохиолдолд инженерийн шийдвэр эцсийн бөгөөд албан ёсны байна.

**804 ХООЛОЙН БА УС ЗАЙЛУУЛАХ БАЙГУУЛАМЖИЙН УХМАЛ**

Гүйцэтгэгч нь хоолой ба ус зайлуулах байгууламжийн бүх ухмалыг ажлын зурагт үзүүлсэн буюу инженерийн зааварласан шугам, түвшин, налуу болон хэмжээгээр хийж гүйцэтгэнэ.

Хэрэв гүйцэтгэгч нь тодорхойлсон хэмжээнээс илүү гүн буюу өргөнд ухмал гаргах бол илүү ухмалыг батлагдсан материалаар өөрийн зардлаар буцааж дарах ба зэргэлдээ газрын нягтын хэмжээнд, инженерийн баталсан төвшин ба хэмжээний дагуу, нягтруулна.

Гүйцэтгэгч нь илэрсэн, янз бүрийн тохирох материалыг буцааж дүүргэхэд ашиглах зорилгоор тус тусад нь сайтар хадгална. Хэрвээ инженерийн саналаар, ухсан материал нь буцааж дүүргэхэд тохирохгүй байвал гүйцэтгэгч ийм материалыг инженерийн зааврын дагуу ашиглагдахгүй материалын талбайд зайлуулна.

Бүх ухмалыг ус, цас нэвтрүүлэхгүй, цэвэр байлгах ба гүйцэтгэгч ус зайлуулах суваг ухах, усны хаалт далан барих болон бусад аргаар ухмалыг усгүй байлгах ёстой.

Инженерийн саналаар, хэрвээ гүйцэтгэгчийн ажлын аргачлалын улмаас ухмалын гадаргуу нь зөөлөн буюу тохиромжгүй бол гүйцэтгэгч энэхүү техникийн шаардлагын бүлэг 1300-д тодорхойлсоны дагуу тохиромжгүй материалыг өөрийн зардлаар зайлуулж, бүтцийн бус бетоноор болон инженерийн зааварласан бусад батлагдсан материалаар солино.

Энэхүү техникийн шаардлагын бүлэг 801-д тодорхойлсон хоолой ба бусад бүх байгууламжийг суурилуулахад бэлэн болсон зөөлөн материалын ухмалын гадаргууг 150 мм-ийн гүн хүртэл, хамгийн их хуурай нягтрал нь дор хаяж 95% хүртэл нягтруулна. 20 мм-ээс дээш бүх жижиг хэсгүүдийг нягтруулахын өмнө зайлуулна.

Өнгөн хөрсийг зайлуулсны дараа ойролцоогоор газрын төвшинд баригдах хоолойн хувьд гүйцэтгэгч нь газрын хөрсийг үе үеэр ухах ба өндөрлөж тэгшилнэ.

Хоолойн суурь нь хоолойн нийт уртад үнэн зөв төвшинтэй, нэг ижил нягтралтай байхуйцаар хоолойн суурийн материалаас доош нь 150 мм хүртэлх хөрсийг хуурай нягтшил нь дор хаяж 95% (AASHTO T180) хүртэл нягтруулна.

Хоолойг суурилуулах буюу хийц байгууламжуудыг барихаас өмнө бэлэн болсон ухмалын гадаргууг инженерээр батлуулна.

Худаг, суваг болон бусад ухмалын хажуу ханыг зохих ёсоор бэхэлж тулна. Хоолой ба бетоныг зохих нарийвчлалтай суулгах, буцааж дүүргэх болон нягтруулах ажлыг зохих ёсоор нь гүйцэтгэх боломжийг хангахын тулд эдгээр бүх ухмалыг хангалттай хэмжээтэй хийнэ.

Инженерийн зааварласан газарт, суваг ба бусад ухмал дахь бэхэлгээ, модон

тулгуурыг хэвээр нь орхино. Гүйцэтгэгчийн буруугаас бус харин хөрсний нөхцөл байдлын улмаас суурийг хангалттай тавих боломжгүй бол гүйцэтгэгч нь инженерийн зааврын дагуу тохиромжтой материал гарч ирэх хүртэл буюу инженерийн заавaрласан гүн ба өргөн хүртэл ухаж, тохиромжгүй материалыг зайлуулна. Үүний үр дүнд гарсан ухмалыг гүйцэтгэгч батлагдсан материалаар хамгийн их хуурай нягтралын (ХИХН) 95% (AASHTO T180) хүртэл буцааж дүүргэнэ. Зөвшөөрөгдсөн материал нь энэхүү техникийн шаардлагын бүлэг 506-д тодорхойлсоны дагуу чулуулаг ба/эсвэл энэ техникийн шаардлагын бүлэг 811-д тодорхойлсоны дагуу зохист ширхэглэлийн бүрэлдэхүүнтэй материал байж болно.

**805 ХАТУУ МАТЕРИАЛЫН УХМАЛ**

а/ Бетон хоолой

Хатуу материал гарах бетон хоолойн сувагт дугуй ба дөрвөлжин хоолойн ёроолоос доош 50 мм-ийн дотор хатуу материал гарч ирэхээргүйгээр ухмалыг хийнэ. Хамгийн бага нь 50 мм-ийн зузаантай хийцийн бус бетоны тогтворжуулагч үеийг орой нь хоолойн их биений доод хэсгийн түвшинд байх ухсан хатуу материалын гадаргуу дээр дэвсэж, нягтруулна. Тогтворжуулагч үеийн хамгийн их зузаан нь 150 мм байна. Сувагт зөөлөн болон хатуу материал тохиолдвол нэг бол зөөлөн материалыг 300 мм-ийн гүн хүртэл, эсвэл инженерийн заавaрласан гүн хүртэл ухан зайлуулж, хийцийн бус бетоноор солих эсвэл инженерийн үзэмжээр хатуу материалыг 300 мм-ийн гүн хүртэл эсвэл инженерийн заавaрласан гүн хүртэл ухан зайлуулж, сувгийн ёроолын үлдсэн хэсэгт байгаа материалтай ижил төстэй материалаар буцаан дүүргээд ХИХН 95% (AASHTO T180) хүртэл нягтруулна.

б/ Жижиг хийцүүд

Жижиг хийцүүдийн ухмалд хатуу материал тохиолдвол үүнийг энэ техникийн шаардлагын бүлэг 703-ийн зохих хэсгүүдийн дагуу шийдвэрлэнэ.

**806 УХМАЛ ДАХЬ УС**

Гүйцэтгэгч нь үргэлжилсэн ба/буюу илүүдэл соруулалтын улмаас ухмалд учирсан эвдрэлийг өөрийн зардлаар засах ба ухмал нээлттэй байх бүх хугацааны туршид бэхэлгээ ба бусад аргаар, залгаа байгаа хийц болон барилгын аюулгүй байдалд шаардлагатай бүх урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна.

**807 УГСАРМАЛ ТӨМӨР БЕТОН ДУГУЙ ХООЛОЙ БА ХАЙРЦГАН ХЭСЭГЛЭЛ**

Бетон хоолойг энэхүү техникийн шаардлагын бүлэг 212-ийн дагуу үйлдвэрлэн, туршина.

**808 ХООЛОЙН СУУРЬ ТАВИХ, ХООЛОЙГ СУУЛГАХ**

Дугуй хоолойг ерөнхийдөө газар дээрх зөөлөн материалаар суурь бэлдэж шууд суурилуулдаг. Газар дээрх материал нь тохиромжгүй байвал сувгийг ухаж, энэ техникийн шаардлагын бүлэг 804 ба 805-д тодорхойлсны дагуу буцааж дүүргэнэ. Углуургын төгсгөлийг урсгалын дагуу харуулж байрлуулна.

а/ Газар дээрх буюу зохист ширхэглэлийн бүрэлдэхүүнтэй дүүргэгч материалаар суурь хийж, хоолойг суулгах

зохист ширхэглэлийн бүрэлдэхүүнтэй дүүргэгч материал нь энэ техникийн шаардлагын бүлэг 811-ийн дагуу байх ёстой.

Ухмалын ёроолыг ХИХН нь дор хаяж 98% хүртэл нягтруулах (AASHTO T180) ба хоолойн нийт уртад хоолойн их бие ухмалын өргөний доод тал нь дөрөвний нэгд сууж байхаар хоолойн ёроол суух хамгийн доод цэг хүртэл ухмалыг хэлбэржүүлнэ.

Хоолойн хэсэглэлүүдийг холбоход зориулж хоолойн холбоос ба углуурган доогуур зохих хэмжээний зай үлдээнэ. Хэсэглэлүүдийг холбосны дараа доторхи зайг нь суурийн материалаар сайн чигжиж дүүргэнэ. Хоолойн их биеийн доод хэсгийг тохиромжтой чийгийн агуулга нь 1%-2%-ийн хооронд байх дүүргэлтийн материалаар нягт чигжин дарж,

нягтруулна.

б/ Бетон дугуй хоолой ба хайрцган хэсэглэлийг бетон суурь дээр байрлуулах

Бетон хайрцган хэсэглэлийг зураг төсөлд үзүүлсэн нарийвчлалын дагуу суурь засаж холбоно.

Хоолойн суурийг хоолойн их биеийн нийт уртын хэмжээгээр, доод тал нь 150 мм өргөн, 50 мм зузаан, 1:3-ийн цемент-элсний зуурмагаар цутгаж бэлдэнэ. Хэсэглэлүүдийг холбосны дараа энэ техникийн шаардлагын бүлэг 1300-д нийцэх М 20 маркийн бетоноор хоолойн их бие, холбоосны доогуур, хоолойн хоёр талаар дээш нь чиглэсэн байдлаар, ажлын зурагт үзүүлсэн өндөр хүртэл битүү чигжиж, цутгана.

Олон хоолойг хоолойн бетон суурийн дагуу, параллель тэнхлэгээр, дагуу хөдөлгөөнт холбоосоор холбож, суулгана. Зэргэлдээ байрлах хоолойнуудын их биеийн хоорондох үзэгдэх зайг ажлын зурагт үзүүлсний дагуу эсвэл инженерийн зааварласнаар авна.

## 809 БЕТОН ХООЛОЙН ДУГУЙ БОЛОН ХАЙРЦГАН ХЭСЭГЛЭЛҮҮДИЙГ ХОЛБОХ

а/ Хөшүүн холбоос

Хөшүүн холбоосоор холбосон, үл салах хоногтой бетон хоолойг суулгахдаа, гүйцэтгэгч нь хоолойны углуургыг хоногт нь суулгахын өмнө углуурга ба хоногийг шавар, тос болон бусад хорт бодисоос цэвэрлэнэ. Хоолойн хамгийн дээд хэсэг дээр холбоос үүсгэхэд тохиромжтой уртаар тайрсан давирхайтай олсон жийргийг углуургыг тойруулан ороож, дараа нь углуургыг хоногт бүрэн оруулан суулгах ба холбоосыг жийргээр битүү бөглөнө. Дараа нь 1:2-ийн харьцаатай цемент-элсний зуурмагаар холбоосыг битүү дүүргэж, $45^0$-ийн өнцгөөр зуурмагаар шавна..

Хоёр углуургыг холбоход ашигласан хөшүүн холбоосоор холбосон бугуйвчуудыг үл салах хоногийг холбосонтой ижил байдлаар холбоно.

Хэрвээ S хэлбэрийн хоногоор холбогдсон хоолойнуудыг зуурмагаар холбохоор зурганд заагдсан бол гүйцэтгэгч нь тэдгээрийг суулгах үедээ гүйцэтгэнэ. 1:2-ийн харьцаатай цемент-элсний зуурмагийг хоногийн доод талын хагас тойрог дээр, углуургын дээд хагас тойрог дээр шавж, хоолойг хоногт сайн суулгана.

Холбоосын эргэн тойрон 75 мм-ийн өргөн, 25 мм-ийн зузаантай нэг ижил зуурмагаар шавна.

Бүх хоолойг холбохын өмнө хоолойнд ус шингээж, хусч цэвэрлэх ба 1:2-ийн цемент-элсний зуурмагаар холбоосыг шавна.

Бүх холбоосыг инженерийн баталсан хучилтаар хучиж, салхи, нар болон хүйтнээс хамгаалах ба дор хаяж 3 хоногийн туршид тасралтгүй чийгтэй байлгана.

Холбосны дараа хоолойнуудыг дор хаяж 48 цагийн туршид хөдөлгөхгүй байх ёстой.

б/ Уян холбоос

Үл салах хоногтой бетонон хоолойнуудын уян холбоосыг хоног дотор суулгасан резинэн жийрэг болон хоолойн углуурга дээр байрлуулсан дугуй жийргийн тусламжтайгаар гүйцэтгэнэ. Уян холбоосын энэ төрлийг инженер баталгаажуулах ёстой.

Аливаа холбоосыг хийхийн өмнө холбоосын бүх хэсгийг шавар, тос болон бусад хорт бодисоос цэвэрлэх ёстой.

Гүйцэтгэгч нь суулгасан жийргүүдийг үйлдвэрлэгчийн зөвлөмжийг нарийн баримтлан тослох шаардлагатай. Дугуй жийргүүдийг тослохгүй. Өөр өөр үйлдвэрлэгчийн үйлдвэрлэсэн уян холбоосын эд ангиудыг хамт хэрэглэж болохгүй.

Суулгах хоолойны углуургыг өмнөх хоолойны хоногт оруулж, хоёр хоолойг нэг шугаманд байрлуулна. Суулгаж буй хоолойны төгсгөл дээр тогтмол даралт ирж байх ёстой. Шаардлагатай тохиолдолд өмнөх хоолойны бүслүүрийг тойруулж бэхэлсэн өргөгч

хэрэгслийг ашиглан дараагийн хоолойг татан оруулна. Углуургыг хоногт нь сайн шахаж оруулан суулгах ба дараа нь холбоосын уян налархай байдлыг хангахын тулд үйлдвэрлэгчийн зөвлөсөн зай хэмжээгээр буцаан суллана.

Холбоосыг хийсний дараа гүйцэтгэгч дугуй жийргүүдийг зөв байрласан эсэхийг мэдрэгч багажаар туршина. Хэрвээ дугуй жийргүүд нь хоолойны тойргийн дагуух шугамнаас нэлээд их зайнд холдсон байвал холбоосыг задалж, шинэ дугуй жийргээр дахин хийнэ.

Гөлгөр хоолойнуудыг уян холбоосыг агуулсан бугуйвчаар холбох үед холбоос нь үл салах хоногтой хоолойныхтой адил байдлаар хийгдэнэ. Эхний хоолой ба бугуйвч хоёрын хоорондох холбоосыг хоёрдох хоолойг бугуйвчинд суулгахын өмнө хийж дуусгана.

Гүйцэтгэгч хоолойн хоног буюу бугуйвч бүрийн доторх зай болон жийргийн гадна талыг чулуу орохоос сэргийлж шавар, олс болон инженерийн баталсан бусад тохиромжтой материалаар дүүргэнэ.

в/ Хоолойны төгсгөл

Өөрөөр заагаагүй бол хоолойны төгсгөлийг тэгш босоо байдлаар үлдээнэ.

**810 БЕТОН СУУРЬ, ЧИГЖЭЭС БА ЗУЗААЛАХ ХЭСЭГ**

Гүйцэтгэгч нь бетоны ажлыг эхлүүлэхээс өмнө аливаа суурь, чигжээс ба зузаалах хэсгийн гадаргууг инженерийн шаардлагыг хангахуйцаар сайн тэгшилж, нягтруулж цэвэрлэнэ.

Инженерийн зааварласан буюу зурагт үзүүлсэн хэсэгт гүйцэтгэгч нь бетон хоолойд 150 мм-ийн зузаан бетон чигжээс хийнэ. Бетон суурь, чигжээс ба зузаалах хэсэгт энэ техникийн шаардлагын бүлэг 1300-г хангах М 20 маркийн бетоныг ашиглах ба зураг төсөлд буюу инженерийн зааварласан хэмжээгээр хэлбэржүүлнэ.

**811 БУЦААН ДҮҮРГЭХ**

Буцааж дүүргэх хэсгийн газрын хөрсийг 150 мм гүн хүртэл ХИХН нь 95% /AASHTO T180/ хүртэл нягтруулна.

Бетон хоолой ба ус зайлуулах жижиг бүтээцийг буцааж дүүргэхэд ашиглах материал нь ухмалаас гарсан материал байна. Хэрвээ зурагт үзүүлсэн байршил дээр буюу хоолойг газрын хөрсөн дээр суулгах байвал гүйцэтгэгч нь инженерийн баталсан нөөц газраас материал сонгон авна. Зохист ширхэглэлийн бүрэлдэхүүнтэй дүүргэгч материал нь ХИХН нь 95% /AASHTO T180/ хүртэл нягтруулсан лабораторийн хольцыг 4 өдөр дэвтээсний дараа хэмжихэд хөрсний даацын үзүүлэлт (CBR) нь 15%-иас их, хөөлт нь 1%-иас бага, уян налархайн индекс нь 9%-иас бага, урсалтын хязгаар нь 25%-иас бага, ХИХН нь /AASHTO T180/ 2.0 т/м$^2$-иас бага, 75 мкм-ийн шигшүүрээр өнгөрөх хувь нь 8%-иас бага, ширхэглэлийн хамгийн их хэмжээ нь 12.5 мм-ээс бага байх ёстой.

Ухмалаас авсан зохистой материалаас бүрдсэн, хоолойд зориулсан буцаан дүүргэлтийн материалыг 150 мм-ээс хэтрэхгүй сул зузаантайгаар үе үеэр нь тавина. Материалын чийгийн агуулгыг, нягтруулах үеийн чийгийн агуулга нь хамгийн тохиромжтой чийгийн агуулгын 1%-иас их, 2%-иас бага байх хязгаарын дотор байхаар устай нэгэн жигд холих буюу хатааж тохируулна. Хоолойн их биеийн доод хэсэг болон холбоосны доорхи хөндийг материалаар буцаан дүүргэж сайн нягтруулна. Үүний дараа гүйцэтгэгч ижил төстэй материалыг 150 мм-ээс ихгүй сул зузаантайгаар үе үеэр нь, шаардлагатай бол хольж, хатааж, усалж дэвсээд ХИХН нь 95% /AASHTO T180/ хүртэл нягтруулна. Гүйцэтгэгч энэ үеийг хоолойн хоёр талаар нэгэн зэрэг тэнхлэгийн өндрөөс дээш 300 мм-ээс багагүй өндөрт хүртэл тэнцүү хэмжээгээр дэвсэнэ.

Сувгийн үлдсэн хэсгийг байгаа тохиромжтой материал ашиглан 150 мм-ээс хэтрэхгүй сул зузаантай үеэр, шаардлагатай бол хольж, услах буюу хатааж дэвсэж дүүргээд нягтруулна.

Ухмалын хананд хийсэн түр зуурын тулгуур болон бэхэлгээг, буцааж дүүргэх үетэй нэгэн зэрэг 150 мм хүртэл суллах ба эдгээр тулгуур болон бэхэлгээний доор болон ар

талд буцааж дүүргэсэн материалыг нягтруулна.

Бүх буцааж дүүргэсэн материалыг ХИХН нь дор хаяж 95% /AASHTO T180/ хүртэл нягтруулна.

Газрын төвшинд ойр эсвэл түүнээс дээш гарсан хоолойны хувьд хоолойны дагуу хийгдэх өндөрлөгөөний өргөн нь хоолойн хоёр талд дор хаяж (2+1.5 h) м байна. (h нь нягтруулж байгаа үеийн ёроолоос хоолойн тэнхлэгийн орой хүртэлх метрээр илэрхийлсэн өндөр).

Газрын хөрснөөс дээш байрлах хоолойны дагуу хийх өндөрлөгөөнд ашиглах материал нь залгаа далангийн материалтай ижил материал байна. Хоолойны дагуу хийх өндөрлөгөөг залгаа далангийн өндөрлөгөөтэй хамт хийх ба энэ техникийн шаардлагын бүлэг 500-д заасан далангийн барилгын ажлаас бусад тохиолдолд нэмэлт төлбөр хийгдэхгүй. Хоолойн сувгийг буцааж дүүргэх болон өндөрлөх ажлыг хоолойн байршил гажих, мөн хажуугийн даралт тэнцүү бус оногдохоос зайлсхийх зорилгоор хоолойн хоёр талаас нэгэн зэрэг, тэнцүү хэмжээгээр хийж гүйцэтгэнэ.

Инженерийн баталсан хамгаалалтын бусад арга хэмжээг аваагүй бол, ямар ч тохиолдолд хоолой дээгүүр барилгын машин механизмыг явуулахаас өмнө хоолойн тэнхлэгийн орой дээрх хучилтын зузаан нь дор хаяж 600 мм байна.

### 812 ХАМГААЛАЛТЫН БАЙГУУЛАМЖУУД

Зурагт үзүүлсэн буюу инженер зааварласан тохиолдолд гүйцэтгэгч хамгаалалтын хийц байгууламжуудыг барина. Ус зайлуулах суваг, хоолойн орох ба гарах амсарын шуудуу ба голын урсгалыг зайлуулахтай холбогдсон хамгаалалтын байгууламжуудад ерөнхийдөө энэхүү техникийн шаардлагын бүлэг 700-ийн дагуу чулуу дүүргэсэн торон бэхэлгээ, чулуун асгаас зэрэг багтана.

Инженер өөрөөр заагаагүй бол гүйцэтгэгч чулуун өнгөлгөө ба бусад ажлыг хийх зорилгоор голын ёроол дахь бул чулуунуудыг зайлуулахгүй.

### 813 УС ЗАЙЛУУЛАХ БАЙГУУЛАМЖИЙН ЖИЖИГ ХИЙЦҮҮД

Ус зайлуулах байгууламжийн жижиг хийцэд хоолойн орох ба гарах амсрын бүтээцүүд, ус цуглуулах худаг, каскад, ус хаялгын байгууламж болон тэдгээртэй ижил төстэй байгууламжууд орно. Нэг маягийн нарийвчиллыг зургуудад үзүүлсэн боловч гэрээт ажлын явцад инженер ажлын нарийвчлалыг гүйцэтгэгчид үе үе гаргаж өгч байна.

Зурагт өөрөөр заагаагүй бол ус зайлуулах байгууламжийн жижиг хийцүүдэд энэхүү техникийн шаардлагын бүлэг 1300-д нийцэх М20 (цилиндр бат бэхээр) маркийн бетоныг ашиглана. Хийцийн гадаргууг U1 ангиллаар засах ба хэлбэржүүлсэн хийцийн гадаргууг ердийн байдлаар засна.

Зурагт өөрөөр заагаагүй бол бетоныг ар болон урд талаас нь, бүх хавтангуудын орой болон ёроолыг нь 10 мм-ийн голчтой, 200 мм-ын алхамтай арзгар торон арматураар хүчитгэнэ. Арматур нь энэ техникийн шаардлагын бүлэг 1300-д нийцэж байх ёстой.

### 814 ШУУДУУ, ЧУЛУУН БЭХЭЛГЭЭ БА РИСБЕРМ

а/ Шуудуу, чулуун бэхэлгээ болон рисберм зэргийг зурагт үзүүлсэн буюу инженерийн зааварчилсан байршил, чиг, төвшинд байгуулна.

б/ Зурагт үзүүлсэн буюу инженерийн зааварчилсан газарт гүйцэтгэгч нь ус зайлуулах байгууламжид усны урсацыг чиглүүлэх зорилгоор уулын шуудуу, жишүү шуудуу, ус зайлуулах шуудуу болон гаргах шуудууг байгуулна. Энэ ажилд бүх материалыг ухах, зайлуулах ажил багтана. Талбайг цэвэрлэсний дараа ухмалын хязгаарыг зурагт үзүүлсэн болон инженерийн зааварласан чиг, налуу, төвшин болон огтлолын дагуу тэмдэглэж тогтооно. Гүйцэтгэгч нь хажуу налуугаас гадагшаа буюу тогтоосон төвшнээс доош ухах ёсгүй ба мөн ухмалын хязгаараас гадагш аливаа материалыг суллахгүй. Тогтоосон төвшнээс доош илүү гүнд ухсан тохиолдолд гүйцэтгэгч өөрийн зардлаар буцааж дүүргэнэ. Тогтоосон овор хэмжээ, түвшин ба хажуу налууд хүргэх зорилгоор ухсан шуудууны ёроол болон хажуу талыг тэгшилж, сайтар нягтруулна.

в/ Зурагт үзүүлсэн буюу инженерийн зааварчилсан чиг, түвшин, хажуу налуу, овор хэмжээ ба огтлолын дагуу уулын шуудууны нэг хэсэг болгож, дүүргэлтийн материалаар шороон далан босгох ба нягтруулагчаар нягтруулна.

г/ Зааварчилгаа өгсөн тохиолдолд тохирох заалтуудын дагуу шуудуунуудад чулуун өнгөлгөө хийх буюу ширэгжүүлнэ.

д/ Зурагт үзүүлсэн буюу инженер зааварчилсан тохиолдолд гүйцэтгэгч энэ техникийн шаардлагын бүлэг 700-ийн дагуу тогтоосон зузаан ба хэлбэртэй чулуун бэхэлгээг хийнэ.

е/ Гүйцэтгэгч нь зурагт үзүүлсэн буюу инженерийн зааварчилсан чиг, төвшин ба овор хэмжээний дагуу рисбермийг байгуулна.

Чулуу нь хатуу бат бэх, хэмжээгээр ижил байх ёстой. Ус болон цаг агаарын нөлөөгөөр эвдэрч муудсан чулуулгийг ашиглахгүй. Чулууны хувийн жин нь дор хаяж 2.40 байх ёстой. Рисбермд ашиглах чулууны хэмжээ нь аль болох том байх ёстой. Чулууны ямар ч ширхэг нь 40 кг-аас бага байх ёсгүй. Чулууны шаардагдах тоо хэмжээг эмх цэгцтэй, зөв байрлуулахын тулд 600 мм гүнзгий периметр 1м өргөн суваг дотор хуурай өрлөгтэй ханаар бэхлэх ба хана нь рисбермийн тогтоосон өргөнөөр бүрэн өндөр хүртэл үргэлжлэх ёстой. Рисбермийг өрөх гадаргууг зурагт үзүүлсэн буюу инженерийн зааварчилсан урт ба өргөний дагуу тэгшилж, нягтруулна.

### 815 ЧУЛУУН ӨНГӨЛГӨӨ

Гүйцэтгэгч нь зургийн дагуу болон инженерийн зааварчилгааны дагуу шуудуунд зориулан 200 мм-ийн зузаан чулуун өнгөлгөөг хийнэ. Чулуун өнгөлгөө нь элс-цементийн зуурмагаар тогтоож, шуудууны хажуу тал болон ёроолд тавьсан чулуунаас бүрдэнэ.

Чулуун өнгөлгөөнд ашиглах чулуу нь хатуу, бат бэх, элэгдээгүй байх ёстой бөгөөд ан цав, хагарал, нүх сүв, үе давхраа болон ямар нэг эвдрэл гэмтэлгүй байх ёстой. Чулууны ширхэг бүр нь параллелепипед хэлбэртэй, 180 мм-220 мм зузаан, 220 мм-280 мм өргөн, 300 мм-450 мм урт байх ёстой. Дугуй болон гурвалжин гадаргуутай буюу үелэлтэй чулуунууд ашиглагдах ёсгүй. Ил гарсан гадаргуу дээр бага зэргийн /барзгардуу/ боловсруулалттай чулууг тавих ба эдгээр нь хажуу бэхэлгээний шугамнаас 12 мм-ээс илүү гарах ёсгүй. Бусад бүх гадаргуу дээр нарийн боловсруулсан чулууг тавих ба эдгээр нь хажуу бэхэлгээний шугамнаас 6 мм-ээс хэтрэхгүй байна. Чулууг ажлын талбайд авчрахын өмнө гүйцэтгэгч ашиглагдах чулууны 5 (таван) төлөөлсөн дээжийг баталгаажуулахаар инженерт ирүүлэх ба үүний хамтаар чулууг гарган авах карьерийн геологийн болон байршлын нарийвчилсан мэдээллийг ирүүлнэ. Зөвхөн инженерийн баталсан чанар ба гарал үүсэлтэй чулууг ажилд ашиглана. Чулууг тавихын өмнө хэмжээгээр нь бүрэн ангилж, засаж өөлөх ба зуурмагийг хөдөлгөхгүй байлгах зорилгоор тавьж байх явцад хэмжээгээр нь ангилах ажлыг хийхгүй.

Чулууг өрөхөд ашиглах зуурмаг нь дараах найрлагатай байх ёстой. Үүнд:

Энэхүү шаардлагын бүлэг 1300-д нийцэх портланд цемент ба ус.

Нойтон шохой (ASTM C207)

Элсэн чулуу (AASHTO M45)

Зуурмагт хэрэглэх цементэн барьцалдуулагч нь нэг хувийн портланд цемент, $^1/_4$ - $^1/_2$ -ийн нойтон шохойноос бүрэлдэнэ. Элс-цементэн барьцалдуулагчийн харьцааг чийгтэй, сул байдалд байгаа элсний хэмжээ цементэн барьцалдуулагчийн хэмжээнээс 3 дахин их байхаар тогтооно. Эдгээр харьцааг хангаж байгаа урьдчилан хольсон материалыг ашиглана. Ашиглагдах ус нь хольцыг ашиглах боломжтой хэмжээнд байх ёстой ба бэлтгэсэн зуурмагаас ус дуслах ёсгүй. Устай хольсны дараа зуурмагийг 1.5 цагийн дотор ашиглах ба ингээгүй тохиолдолд зуурмагийг хаяна.

Зуурмагаас гарсан усыг нэвчүүлэхгүй байх зорилгоор тавихын өмнө чулуунуудыг хангалттай чийглэж, гадаргууг нь хатаасан байна. Чулууг тавих суурийг цэвэрлэж, чийглэн, шинэ бэлдсэн зуурмагаар шавна, Хэрвээ суурийн хөрс сул байвал зуурмаг

тавихын өмнө чийглэж, нягтруулна. Хэрвээ суурь хөрсөнд сул, зууралдамтгай бус материал байвал нягтруулж, зууралдамтгай болгосон хайргархаг хөрсөөр солино.

Чулууг суурь болон холбоосон дээр зуурмагаар бэхлэн тавих ба тавьсны дараа даруйхан модон алхаар болгоомжтой цохин суулгах ба зуурмагийг бэхжихээс өмнө сайтар суулгана. Чулуун өнгөлгөөнд хуурай болон хоосон зай гарах ёсгүй ба чулууны суулгасан бүх хэсгийг зуурмагаар шавна. Холбоосон дээрх илүүдэл зуурмагийг цэвэрлэн арилгаж холбоосийг мэдэгдэхүйц болгоно. Чулууны босоо холбоосны хоорондох зай нь дор хаяж 150 мм байх ба чулууг нэг шугаманд тавьж бага зэрэг тэгшилнэ. Агаарын болон хөрсний температур $5^0$С-ээс бага үед чулуун өнгөлгөөг хийхгүй. Чулуун өнгөлгөөг тавьсны дараа зуурмагийг бэхжүүлэхийн тулд 2 /хоёр/ өдрийн турш усаар хөнгөн шүршиж чийгтэй байлгана.

Дээр заагдсан материал болон ажлын технологийг үл баримтлан барьсан чулуун өнгөлгөөг хүлээн авахгүй ба инженерийн зааварчилгааны дагуу дахин барина.

**816 ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР**

а/ Зүйл: Хоолой, шүүрүүлэх үе болон ус зайлуулах байгууламжийн жижиг хийцүүд, орох гарах амсрын шуудуу, жишүү шуудуу болон ус зайлуулах шуудууны сул хөрсний ухмал

Нэгж: $м^3$

Хоолой, шүүрүүлэх үе болон ус зайлуулах байгууламжийн жижиг хийцүүд, орох гарах амсрын шуудуу, жишүү шуудуу болон ус зайлуулах шуудууны сул хөрсний ухмалын хэмжих нэгж нь куб метр байна.

Хоолой ба шүүрүүлэх үеийн ухмалын эзэлхүүнийг ухмалын тогтоосон өргөн ба уртын дагуу хэмжсэн ухмалын хөндлөн огтлолын талбайн үржвэрээр тодорхойлно.

Ус зайлуулах байгууламжийн жижиг хийцүүдийн ухмалын эзэлхүүнийг хавтгайн талбай болон ухмалын дундаж гүний үржвэрээр тодорхойлно.

Хоолойн орох ба гарах амсар, жишүү шуудууны ухмалын эзэлхүүнийг шуудууны тэнхлэгийн дагуу 10 м-ээс хэтрэхгүй зайд хэмжсэн ухмалын дундаж талбайг шуудууны уртад үржүүлсэн үржвэрээр тодорхойлогдоно.

Ус зайлуулах шуудууны ухмалын эзэлхүүнийг шуудууны тэнхлэгийн дагуу 10 м-ээс хэтрэхгүй зайд хэмжсэн ухмалын дундаж талбайг шуудууны уртад үржсэн үржвэрээр тодорхойлогдоно.

Ажлын талбайг эдгээр хязгаараас илүү гарган тооцох ёсгүй.

Сул хөрсний ухмалын ажлын үнэлгээнд дор дурдсан ажлын зардлыг тооцож оруулна. Үүнд:

- Аливаа гүн хүртэл хийсэн ухмал
- Орох ба гарах амсарын шуудуу, жишүү шуудууны суурь ба ханыг нэг шугам ба түвшинд тэгшлэх
- Ухмалын суурь ба ханыг нягтруулах
- Ухмалаас гарсан илүүдэл болон шаардлага хангахгүй материалыг зайлуулж ашиглагдахгүй материалын талбайд зөөж овоолох
- Ус зайлуулах шуудууны нам талд нь далан босгож, нягтруулах
- Бүх шаардлагатай тээвэрлэлт
- Энэ техникийн шаардлагын бүлэг 801, 802, 803, 804, 806, 808, 811, 812, 814, 815 ба 817-д нийцэх зардлууд

б/ Зүйл: Сувгийн сул хөрсний ухмал

Нэгж: $м^3$

Шуудууны орох ба гарах амсар буюу жишүү шуудууны суурийн зааварласан өргөн нь 2.5 м-ээс илүү байвал үүнийг сувгийн ухмал гэж ангилах ба энэ техникийн шаардлагын бүлэг 820 (а)-д заасантай адилаар тооцож, куб метрээр хэмжинэ.

Сувгийн сул материалын ухмалд дор дурдсан ажлын зардлууд орно. Үүнд:

- Аливаа гүн хүртэл хийсэн ухмал
- Суурь ба ханыг нэг шугам ба түвшинд тэгшлэх
- Ухмалын суурь ба ханыг нягтруулах
- Ухмалаас гарсан илүүдэл материалыг зайлуулж ашиглагдахгүй материалын талбайд зөөж овоолох
- Бүх шаардлагатай тээвэрлэлт
- Энэ техникийн шаардлагын бүлэг 801, 802, 803, 804, 806, 815 ба 817-д нийцэх зардлууд

в/ Зүйл: Хатуу материалын ухмалд зориулсан дэд зүйл 818 (а) ба (б)-ийн нэмэлт

Нэгж: $м^3$

Дэд зүйл 818 (а) ба (б)-д дурдсан ухмалд тохиолдох хатуу материалыг куб метрээр хэмжих ба ухмалын тэнхлэгийн дагуу инженертэй зөвшилцөж тохиролцсон зайд хэмжсэн ухмалын дундаж талбайг хатуу материал олборлосон хэсгийн нийт уртад үржүүлсэн үржвэрээр эзэлхүүнийг тодорхойлно. Дундаж талбайг ухмал хийгдэхээс өмнөх хатуу материалын гадаргуугийн өндөржилт, ухмалын дараах суурийн өндөржилт буюу зааварласан суурийн төвшний аль өндрөөр нь тодорхойлно. Төлбөр хийх үүднээс 0.5 $м^3$–ээс том хэмжээний чулуулгийн ухмалаас гарах хатуу материалын эзэлхүүнийг машины тэвшний сул эзэлхүүний 50%-иар авна.

Хатуу материалын ухмалын 818 /а/ ба /б/ дэд зүйлүүдийн үнэлгээг сул хөрсний ухмалын үнэлгээнд нэмэлт болгон оруулах ба аливаа гүний ухмал ба энэ техникийн шаардлагын бүлэг 801, 802, 803, 804, 805, 806, 815 ба 817-тэй холбоотой зардлуудыг тооцож оруулна.

г/ Зүйл: Уулын шуудуу

Нэгж: м

Уулын шуудууг барихад ашиглах хэмжилтийн нэгж нь тууш метр байна. Уулын шуудууны уртыг зурагт үзүүлсний дагуу буюу шуудууны тэнхлэгийн дагуу хэмжсэн зааврласан уртаар тооцно.

Уулын шуудууг барих үнэлгээнд дор дурдсан ажлуудын зардал орно. Үүнд:

- Аливаа гүн хүртэл хийсэн ухмал
- Суурь ба ханыг нэг шугам ба төвшинд тэгшлэх
- Ухмалын суурь ба ханыг нягтруулах
- Зурагт үзүүлсний дагуу буюу инженерийн зааварласны дагуу ухсан шуудуунд залгаж шороон далан барьж, нягтруулах
- Бүх шаардлагатай тээвэрлэлт
- Энэ техникийн шаардлагын бүлэг 801, 802, 803, 804, 806, 811, 815 ба 817-д нийцэх зардлууд

д/ Зүйл: Зохист ширхэглэлийн бүрэлдэхүүнтэй дүүргэгч материал

Нэгж: $м^3$

Буцааж дүүргэхэд ашиглах зохист ширхэглэлийн бүрэлдэхүүнтэй дүүргэгч материал хэмжих нэгж нь куб метр байна. Хоолойг буцааж дүүргэх эзэлхүүнийг хөндлөн

огтлолын дундаж талбайг буцааж дүүргэх хэсгийн уртад үржүүлсэн үржвэрээс хоолой ба аливаа бетон суурь ба хийцүүдийн эзлэх эзэлхүүнийг хасаж тодорхойлно.

Буцааж дүүргэхэд ашиглах зохист ширхэглэлийн бүрэлдэхүүнтэй дүүргэгч материалын үнэлгээнд дор дурдсан зардлууд багтана. Үүнд:

- Материалын хангалт
- Аливаа гүнд буцааж дүүргэх
- Бүх шаардлагатай тээвэрлэлт
- Энэ техникийн шаардлагын бүлэг 801, 802, 811, 815 ба 817-д нийцэх зардлууд

е/ Зүйл: Шүүрүүлэх үед ашиглах том ширхэглэлтэй материал

Нэгж: $м^3$

Шүүрүүлэх үед ашиглах том ширхэглэлтэй материалын хэмжих нэгж нь куб метр байна. Өндөрлөгөөний эзэлхүүнийг хөндлөн огтлолын дундаж талбайг шүүрүүлэх үеийн уртаар үржүүлсэн үржвэрээр тодорхойлно. Хөндлөн огтлолын талбай нь том ширхэглэлтэй материалын өндөрлөгөөний гүнийг энэ стандартын 818 /а/-ийн дагуу тооцоолсон ухмалын өргөнөөр үржүүлж, аливаа хоолойн хөндлөн огтлолын талбайг хассантай тэнцүү байна.

Шүүрүүлэх үеийн өндөрлөгөөний том ширхэглэлтэй материалын үнэлгээнд дор дурдсан зардлуудыг тооцож оруулна. Үүнд:

- Материалын хангалт
- Аливаа гүнд буцааж дүүргэх
- Бүх шаардлагатай тээвэрлэлт
- Энэ техникийн шаардлагын бүлэг 801, 802, 804, 806, 811, 812 ба 817-д нийцэх зардлууд

ё/ Зүйл: Бетон хоолойн дугуй болон хайрцган хэсэглэлүүдийг холбох

Нэгж: м

Бетонон дугуй хоолойн хэсэглэлүүдийн хангамж, тэдгээрийг байрлуулж холбох ажлыг шугаман метрээр хэмжинэ. Дугуй хоолойн уртыг хоолой буюу шүүрүүлэх үеийн тэнхлэгийн шугамын дагуу хэмжсэн уртаар тодорхойлно.

Бетонон дугуй хоолойн хэсэглэлүүдийн хангамж, тэдгээрийг байрлуулж холбох ажлын үнэлгээнд хангамж байрлуулах, мөн энэ стандартын шаардлагыг хангахтай холбоотой зардлуудыг оруулна.

ж/ Зүйл: Суурь, чигжээс ба зузаалах хэсэгт ашиглах М 20 маркийн бетон

Нэгж: $м^3$

Суурь, чигжээс ба зузаалах хэсэгт ашиглах М 20 маркийн бетоныг хэмжих нэгж нь куб метр байна. Бетоны эзэлхүүнийг хөндлөн огтлолын талбайг суурь, чигжээс ба зузаалах хэсгийн уртад үржүүлсэн үржвэрээр тодорхойлно. Хөндлөн огтлолын талбайг зураг төсөлд үзүүлсэн буюу инженерийн зааварласан хэмжээгээр авах ба эндээс хоолойн эзлэх талбайг хасна.

Суурь, чигжээс ба зузаалах хэсэгт ашиглах М 20 маркийн бетоны үнэлгээнд до дурдсан зардлуудыг багтаана. Үүнд:

- Бетоны хангалт, суулгах
- Арматур
- Хэв хашлага ба тулгуур

- Гадаргууг ердийн байдлаар засах
- Энэ техникийн шаардлагын бүлэг 801, 802, 804, 805, 806, 808, 810 ба 817-д нийцэх зардлууд

Бетон цутгамал хийх ухмалын гадаргууг бэлдэж засахтай холбоотой

ухмалын үнэлгээнээс давсан зардлуудад нэмэлт төлбөр хийгдэхгүй.

з/ Зүйл: Ус зайлуулах байгууламжийн жижиг хийцүүдэд ашиглах М 20 маркийн бетон

Нэгж: м

Ус зайлуулах байгууламжийн жижиг хийцүүдэд ашиглах М 20 маркийн бетоныг хэмжих нэгж нь куб метр байна. Бетоны эзэлхүүнийг зураг төсөлд үзүүлсэн буюу инженерийн зааварласан хэмжээгээр тооцно.

Ус зайлуулах байгууламжийн жижиг хийцүүдэд ашиглах М 20 маркийн бетоны үнэлгээнд дор дурдсан зардлуудыг багтаана. Үүнд:

- Арматур
- Хэв хашлага ба тулгуур
- Гадаргууг ердийн байдлаар засах
- Энэ техникийн шаардлагын бүлэг 801, 802, 804, 805, 806, 814 ба 817-д нийцэх зардлууд

Бетон цутгамал хийх ухмалын гадаргууг бэлдэж засахтай холбоотой ухмалын үнэлгээнээс давсан зардлуудад нэмэлт төлбөр хийгдэхгүй.

и/ Чулуун бэхэлгээ

Нэгж: $м^2$

Чулуун бэхэлгээний хэмжих нэгж нь квадрат метр байна. Талбайг бэхэлгээ хийхээр инженерийн зааварласан налуу дээр хэмжсэн цэвэр талбай гэж тооцоолно.

Чулуун бэхэлгээний үнэлгээнд дор дурдсан ажлууд орно.Үүнд:

- Ухах
- Ухмалын материалыг тогтоосон талбайд зайлуулах
- Нэг шугам, төвшинд тэгшлэх
- Ухмалын хана ба суурийг нягтруулах
- Чулуун бэхэлгээг хангаж, тавих
- Бүх шаардлагатай тээвэрлэлт
- Энэ техникийн шаардлагын бүлэг 801, 802, 804, 805, 806, 814 ба 817-д нийцэх зардлууд

к/ Зүйл: Рисберм

Нэгж: $м^3$

Рисбермийг хэмжих нэгж нь куб метр байна. Тавихаар зааварласан рисбермийн эзэлхүүнийг зурагт үзүүлсэн буюу инженерийн зааварчилсан хэмжээгээр тооцоолж гаргана.

Рисбермийн үнэлгээнд дор дурдсан ажлын зардлууд багтана. Үүнд:

- Ухах

- Хуурай өрлөгийн периметр хананд зориулсан ухмал
- Ухсан материалыг тогтоосон хаягдал материалын талбайд зайлуулах
- Нэг шугам ба төвшинд тэгшлэх
- Ухмалын хана ба суурийг нягтруулах
- Рисбермийг хангах, тавих ба засаж өөлөх
- бүх шаардлагатай тээвэрлэлт
- Энэ техникийн шаардлагын бүлэг 801, 802, 815 ба 817-д нийцэх зардлууд

л/ Зүйл: Шуудууны чулуун өнгөлгөө

Нэгж: $м^2$

Шуудууны чулуун өнгөлгөөний хэмжих нэгж нь квадрат метр байна. Талбайг зурагт үзүүлсэн буюу инженерийн зааварласан хэмжээнээс тооцоолно.

Шуудууны чулуун өнгөлгөөний үнэлгээнд дор дурдсан ажлын зардал орно. Үүнд:

- Ажлыг дуусгахад шаардлагатай бүх ажиллах хүч, материал, багаж, тоног төхөөрөмж ба жижиг зардлуудын бүрэн төлбөр
- Тунлах, холих, чулууг өрөх, өнгөлөх ба бэхжүүлэх
- Бүх шаардлагатай тээвэрлэлт
- Энэ техникийн шаардлагын бүлэг 801, 816 ба 817-д нийцэх зардлууд

# БҮЛЭГ 900 -ХӨДӨЛГӨӨНИЙГ НЭВТРҮҮЛЭХ

## БҮЛЭГ 900 - ХӨДӨЛГӨӨНИЙГ НЭВТРҮҮЛЭХ


901 ЕРӨНХИЙ ЗҮЙЛ 9-3
902 ХУУЧИН ЗАМ / ШОРООН ЗАМУУДЫГ ЗАСАХ 9-3
903 ТҮР ЗАМ БАРИХ БОЛОН ТЭДГЭЭРИЙН ЗАСВАР АРЧЛАЛТ 9-4
(а) Ерөнхий зүйл 9-4
(б) Геометр 9-5
(в) Барилгын ажил 9-5
(г) Ус зайлуулах шуудуу ба овоолго 9-5
(д)Түр зам барьсан газруудыг нөхөн сэргээх 9-5
(е) Түр замын засвар, арчлалт 9-6
904 АЖЛЫН ТАЛБАРААР ХӨДӨЛГӨӨНИЙГ НЭВТРҮҮЛЭХ 9-6
905 ЗАМЫН ТЭМДЭГ, ХААЛТ, ГЭРЭЛТҮҮЛЭГ 9-7
906 ЗАМЫГ ХААХ, ТҮР ЗАМ БАРИХ 9-7
907 ЗОРЧИГЧДОД ТУСЛАХ 9-7
908 ТУСЛАХ ЗАМ 9-7
(а) Талбайд хүрэх зам 9-7
(б) Шинэ туслах замууд 9-7
(в) Туслах зам барьсан газруудыг нөхөн сэргээх 9-8
(г) Зардал 9-8
909 ГҮЙЦЭТГЭГЧИЙН БАРИЛГЫН АЖЛЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ 9-8
(а) баригдаж буй шинэ замыг ашиглах 9-8
910 ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР 9-8
(а) Зүйл : түр замыг барих, засаж арчлах 9-8

## 901 ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Төслийн замын трасс нь ч ихэнхдээ замгүй газраар тавигдсан боловч зарим газарт одоогийн хөдөлгөөн явж буй хэлбэржээгүй шороон замын чиглэлтэй давхцах юмуу зэрэгцээ байдалтай байгаа болно. Иймд шинээр баригдаж байгаа замын ажилд ямар нэгэн байдлаар нөлөөлөхөхөөр нөхцөлтэй, мөн төслийн замд ойр оршдог, хөдөлгөөн явж буй шороон замуудыг (үүнд салаалсан замууд бас хамаарч болно) тээврийн хэрэгсэлүүд тэгш тал газарт дор хаяж 50 км/цаг, харин уулархаг газарт дор хаяж 30 км/цаг хурдтай явах бололцоогоор хангаж, нийт барилгын ажлын үргэлжлэх явцад (барилгын ажил хүйтний улиралд зогсох үед ч) байнга засварлаж арчилж байна. Зурагт одоогийн байгаа замуудын байршлыг үзүүлсэн болно.

Гэрээнд заасны дагуу Гүйцэтгэгч нь гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн замыг хүлээлгэн өгөх гэрчилгээг олгох өдөр хүртэлх бүхий л ажлын туршид төслийн замын дагууд, зорчигчид болон тээврийн хэрэгслүүдийг чөлөөтэй нэвтрүүлэх явдлыг зохицуулах хариуцлагыг хүлээнэ.

Шинэ замын барилгын ажлын явцад ажлаас үүдэн хуучин шороон замаар явж буй хөдөлгөөнд ямар нэг таагүй байдал, саад учирч болзошгүй тохиолдолд Гүйцэтгэгч саад бэрхшээл, хүндрэлийн байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр тохиромжтой арга хэмжээг авч зорчих тав тухыг хангана.

Зам барилгын ажлын явцад тухайн газар орны онцлогоос (өндөр уул, усаар хашигдсан, барилга байгууламж ойрхон гэх мэт) шалтгааланаас хөдөлгөөнийг түр замаар өнгөрүүлэх боломжгүй тохиолдолд зайлшгүй байдлыг харгалзан, ажилд эвдрэл, хохирол учруулахгүй байх нөхцлийг хангасан тохиолдолд барилгын ажил явагдаж буй талбай дундуур буюу дээгүүр замын хөдөлгөөнийг нэвтрүүлэн өнгөрүүлэхийг Инженерээс Гүйцэтгэгчид зөвшөөрч болно.

Гэрээний хугацаанд Гүйцэтгэгч барилгын ажил явагдаж буй газруудтай ойр байгаа замуудын дагуу түр тэмдэг, хаалт байрлуулан, засвар арчлалт хийж, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажиллана.

Гүйцэтгэгч нь барьж буй замаа болон зэргэлдээх замуудыг өөрийн тээврийн хэрэгслүүд болон хүнд механизмын хөдөлгөөний нөлөөллөөс хамгаална.

## 902 ШОРООН ЗАМУУДЫГ ЗАСАЖ АРЧЛАХ

Гүйцэтгэгч нь, шинэ барилгын ажлыг явуулахад ямар нэгэн байдлаар нөлөөлөх, Талбайд ойрхон буюу зэрэгцээ оршиж байгаа шороон замуудыг Гэрээ хүчин төгөлдөр болсон үеэс эхлэн барилга ашилалтанд орох хүртэл, Гэрээнд хүлээсэн үүргийнхээ дагуу хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлэх, аюулгүй байх нөхцлийг хангах байдлаар засаж арчилна. Энэ нь шинэ замын ажлыг хамгаалах давхар ач холбогдолтой юм.

Засвар арчлалтанд дараахи ажлууд багтах бөгөөд зөвхөн тэдгээрээр хязгаарлагдахгүй. Үүнд:

- шороон замын хонхорыг дүүргэж тэгшлэх, дэржигнүүрийг зохих өргөнөөр хусах,
- шаардлагатай үед услах,
- төслийн замтай огтлолцох тохиолдолд гарц хийж өгөх
- шаардлагатай хэсэгт ус зайлуулах хажуугийн болон жишүү шуудууг татаж төслийн замаас гадаргуугийн усыг холдуулах, зарим үед шуудууг гүнзгийлэх,
- ус зайлуулах шуудуу, сувгаар ус чөлөөтэй урсах нөхцлийг хангах,
- замын түр тэмдэг, хаалт тавих засаж арчлах,
- хөдөлгөөнийг нэвтрүүлэхэд шаардлагатай туслалцаа үзүүлэх.

## 903 ТҮР ЗАМ БАРИХ БА ТҮҮНИЙ ЗАСВАР,АРЧЛАЛТ

(a) Ерөнхий зүйл

Гүйцэтгэгч нь ажлын зурагт өгөгдсөн юмуу Инженерийн зааварчилснаар түр замыг барих, ашиглах, засварлах арчлах ажлыг энэхүү техникийн шаардлагын дагуу хийнэ.

Гүйцэтгэгч нь нийтийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохицуулан явуулах боломжгүй хэсэгт  түр зам барина.  Зам барилгын ажил дууссан хэсгийн түр замыг даруй нөхөн сэргээнэ.

Түр замыг газрын хэвгий, саадыг харгалзан хамгийн боломжит богино чиглэлд сонгон барих бөгөөд сонгосон трассыг Инженерээр батлуулна.

Техникийн шаардлагын зүйл 114-т заасны дагуу Гүйцэтгэгч барилгын ажлын талбай дээгүүр болон хажуугаар тээврийн хэрэгслийг хэрхэн өнгөрүүлэх ба түр замыг барих төлөвлөгөө бүхий ажлын зургийг Инженерт танилцуулж зөвшөөрөл авна.  Ажлын зурагт дараах мэдээлэл багтах ба гэхдээ зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй:

- түр замын урт ба чиг,
- барилгын талбайг хөндлөн огтлох, эсэх
- хоёр урсгалтай хөдөлгөөн,
- замын өргөний хязгаар,
- ус зайлуулах шуудуу,
- элс, цасны хунгарлалтаас хамгаалах,
- хоолой,
- 7% - иас илүү налуу
- газар шорооны ажил,
- хучилт,
- тоос багасгах арга хэмжээнүүд,
- тэмдэг, хаалт хашилт,

Гүйцэтгэгч, ажлын талбар дээгүүр болон ойр орчмоор тээврийн хэрэгслийг өнгөрүүлэх болон замын аль хэсэгт түр зам барих саналаа энэ ажил эхлэхээс дор хаяж 28 хоногийн өмнө Инженерт бичгээр мэдэгдэнэ.  Тур зам барих ажлыг Инженертэй харилцан зөвшилцсөний дагуу гүйцэтгэнэ.

Инженерээс бичгээр зөвшөөрөл авсаны дараа л гүйцэтгэгч түр зам барих ажлаа эхлүүлнэ.

Гүйцэтгэгч уг хэсэгт барилгын ажил явагдах хугацааны туршид түр замаар хөдөлгөөнийг саадгүй өнгөрүүлэх болон бусад холбогдох засвар арчлалт хийх үүрэг хариуцлагыг өөртөө хүлээнэ.

Түр зам барих ажилтай холбогдон Гүйцэтгэгч нь дараахи хариуцлагыг хүлээх ба холбогдож гарах зардлыг хариуцна:

- замын зурвасаас гадагш ашиглах газрын (хэрвээ шаардлагатай бол) зөвшөөрлийг авах, төлбөрийг хийх.
- холбооны болон цахилгааны шугам, ус дамжуулах хоолой болон бусад шугам сүлжээг шилжүүлэх,

Гүйцэтгэгч нь түр зам барихад хөндөгдөж болзошгүй холбооны ба цахилгааны шугам болон шонг хамгаалах үүрэгтэй.  Гүйцэтгэгч кабель утас, шонгууд болон бусад шаардлагатай зүйлсийг хамгаалах хэлбэр, шилжүүлэх, солих арга зэрэг асуудлыг энэхүү техникийн шаардлагын зүйл 120 ба холбогдох эрх бүхий байгууллагаас тавьсан шаардлага, мөрдөгдөж байгаа стандартын дагуу шийдвэрлэнэ.

Эдгээр шугам сүлжээ нь түр замыг хөндлөн огтолж буй тохиолдолд Гүйцэтгэгч тэдгээрийг хамгаалах үүрэгтэй бөгөөд техникийн шаардлагын зүйл 120-ын  заасан

шаардлагуудад нийцүүлэн, эрх бүхий байгууллагын зөвлөсний дагуу хамгаалах арга хэлбэрийг сонгоно. Тэдгээрийг шилжүүлэх шаардлагатай бол техникийн шаардлагын зүйл 121-т зааснаар хийж гүйцэтгэнэ.

(б) Геометр хэмжээ

Түр замыг зурагт үзүүлсэний дагуу юмуу Инженерийн зааварчилсан хөндлөн огтлолоор барина. Инженер өөрөөр зааварлаагүй бол түр замын зорчих хэсгийн өргөн нь 7м, хоёр урсгалтай байна.

Түр дагуугийн хамгийн их замын налуу 7%-иас хэтрэхгүй, түүнээс илүү байхаар бол инженерийн зөвшөөрлийг авсан байх ёстой. Замын налуугийн аливаа өөрчлөлтийг 60м-ээс багагүй урт зайд, жигд босоо муруй гарган хэлбэржүүлэх байдлаар хийнэ.

(в) Барилгын ажил

Талбайг цэвэрлэх болон шаардлагатай бусад газар шорооны ажлыг энэхүү техникийн шаардлагын Бүлэг 400 ба 500-д заасны дагуу хийнэ. Ерөнхийдөө түр зам нь газар шорооны ажил багатай, тэгшилсэн шороон зам байх бөгөөд Инженерээс зааварлалсан тохиолдолд хайрган хучилт хийнэ. Замын түр тэмдэг, хаалт хашилт, зэргийг суурилуулна.

(г) Ус зайлуулах байгууламж

Гүйцэтгэгч түр зам барьж ашиглах явцдаа түүнийг хөндлөн дайрч өнгөрөх усны гольдрол нь ус зайлуулах байгууламжаар чөлөөтэй урсаж байх нөхцлийг хангасан байна.

Инженерийн зүгээс шаардлагатай гэж үзсэн газруудад зохих хэмжээ, нэвтрүүлэх хүчин чадал бүхий ус зайлуулах түр суваг шуудуу, хоолой, уулын шуудуу болон гүүр зэргийг барина.

Уулын шуудууны уртын хэмжээг Инженертэй зөвшөлцсөний үндсэн дээр тухайн үед нь тогтоох ба гэхдээ шуудуугаар гадагшилсан ус шинэ болон түр замын аль нэг хэсгийг гэмтээхгүйгээр алсад зайлуулагдахаар барих хэрэгтэй. Уулын шуудууны гүн нь 0,6м-ээс багагүй байх ба шуудуунаас гарсан шороог зам талын ирмэгт овоолж өгнө. Хэрэв ашиглалтын явцад үерийн буюу уулын ус овоолго шорооноос давж байвал шуудууг гүнзгийлж, овоолгоны өндрийг нэмэгдүүлнэ.

(д) Түр зам барьсан газруудыг нөхөн сэргээх

Түр замын барилгын ажлыг эхлүүлэхийн өмнө буюу товлосон газрыг ашиглаж эхлэхийн өмнө гүйцэтгэгч түр зам барих газрын дагууд, дээд тал нь 500м тутамд авсан 90мм х 125 мм хэмжээтэй өнгөт зургийн цомгийг Инженерт өгнө. Эдгээр зургууд нь тухайн газрын барилгын ажил эхлэхээс өмнөх нөхцөл байдал, онцлогийг бодитоор харуулсан байх шаардлагатай. Зургууд шаардлага хангасан гэж үзвэл Инженер түр замын ажил эхлэх зөвшөөрлийг олгоно. Гүйцэтгэгч түр зам барихад ашигласан газрыг, барилгын ажил эхлэхээс өмнө байсан байдалтай нь адил нөхөн сэргээнэ. Инженер нөхөн сэргээх ажил шаардлага хангахуйц болсон эсэхийг тодорхойлохдоо гэрэл зургуудыг ашиглана.

(е) Түр замын засвар, арчлалт

Гүйцэтгэгч нь баригдсан түр замын засвар арчлалтыг техникийн шаардлагын дэд-зүйл 903-ын (а)-(д) заалтуудыг мөрдлөг болгон замын хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлэх нөхцлийг бүрэн хангахуйц хэмжээнд хийнэ. Түр замыг ашиглалтад өгсөн цагаас эхлэн зэргэлдээх шинэ зам ашиглалтад орох хүртэл хугацаанд засвар арчлалтыг хийж гүйцэтгэнэ.

Түр замын засварт дараахи ажлууд хамрагдах ба гэхдээ зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй. Үүнд:

- услах,
- замыг нийт өргөнөөр нь хусаж тэгшлэх,
- хонхор хотгорыг дүүргэж, дахин хэлбэржүүлэх ба нягтруулах,

- ус зайлуулах шуудуу, усны гольдрол ба хоолойгоор усны урсгал чөлөөтэй нэвтрэх боломжийг хангах, уулын шуудууг сэргээх,

овоолгыг өндөрлөх

- хоолой болон гүүрний жижиг засвар,
- замын тэмдэг, хаалт хашилт,
- замын хөдөлгөөнийг нэвтрүүлэхэд туслалцаа үзүүлэх

## 904 АЖЛЫН ТАЛБАРААР ХӨДӨЛГӨӨНИЙГ НЭВТРҮҮЛЭХ

Ердийн нөхцөлд ажлын талбар дундуур хяналтын ажилтнуудын машин, Гүйцэтгэгчийн технологийн машин техникээс бусад нийтийн тээврийн хэрэгсэл явуулахыг зөвшөөрөхгүй.

Барилгын ажлын талбар дундуур, өөрөөр хэлбэл, аль нэг хийгдэж байгаа үеэн дээгүүр болон түүний хөндлөн чиглэлд нийтийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг нэвтрүүлэх асуудлыг зөвхөн Гүйцэтгэгчийн санал болгосон тохиолдолд Инженер шийднэ.

Ийм газруудад хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахын тулд Гүйцэтгэгч ажлаа замын өргөний хагаст юмуу тодорхой хэмжээний богино зайд хийж гүйцэтгэнэ.

Ажлын талбар дундуур нэвтрэх хөдөлгөөнийг саатуулах давтамж ба үргэлжлэх хугацааг аль болох бага байлгахаар Гүйцэтгэгч ажлаа зохион байгуулна. Инженерийн зөвшөөрөлгүйгээр хөдөлгөөнийг 30 минутаас илүү саатуулж болохгүй бөгөөд энэ хугацаа дунджаар 5 минутаас бага байна. Хэрвээ Гүйцэтгэгчийн санал болгосон ажлын аргачлалаас шалтгаалан хөдөлгөөнийг 30 минутаас илүү хугацаагаар саатуулахаар болвол, энэ тухайгаа Инженерт 48 цагийн өмнө бичгээр мэдэгдэнэ. Ийм мэдэгдэл өгөөгүй нөхцөлд Инженер хөдөлгөөнийг хаахаас татгалзах юмуу эсвэл саатуулах хуваарийг өөрчлөхийг шаардаж болно.

Барилгын ажлын талбар дундуур нийтийн тээврийн хэрэгсэл нэвтэрч буй газруудад Гүйцэтгэгч ухсан нүх болон бусад аюултай саадыг хаалт хашилтаар хамгаалж шөнийн цагт тод гэрэлтүүлсэн байна.

Барилгын ажлын талбар дундуур нийтийн тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөнийг нэвтрүүлэхтэй холбогдон ажилд учирсан аливаа эвдрэл гэмтлийг Гүйцэтгэгч өөрийн зардлаар, чанарын зохих хэмжээнд засварлана.

## 905 ЗАМЫН ТЭМДЭГ, ХААЛТ

Гүйцэтгэгч нь Инженерийн зааварчилсанаар шороон замын дагууд болон баригдаж байгаа замаар тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг нэвтрүүлэхдээ энэхүү техникийн шаардлагын зүйл 902, 903-т зааснаар түр тэмдэг, хаалт хашилтыг тавина.

Түр тэмдэгжүүлэлтэд ашиглах замын бүх тэмдгүүд нь Монгол улсын МС 4597-98 стандартын шаардлагад нийцсэн, хаалт хашилт нь Гүйцэтгэгчээс санал болгож, Инженер баталсан хэлбэр, хэмжээтэй байна.

Байрлуулах замын түр тэмдгүүдийн төрлийг Инженер батална. Тэмдгүүдийг цэвэр, бүрэн бүтэн байлгана.

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний чиглэл, зохицуулалтыг хангахын тулд Гүйцэтгэгч тохирсон масштаб бүхий хөдөлгөөн зохицуулах төлөвлөгөө гаргана. Уг төлөвлөгөөг хөдөлгөөнд нөлөөлөхүйц ямарваа нэг барилгын ажил эхлэхээс дор хаяж 14 хоногийн өмнө Инженерт танилцуулж зөвшөөрөл авна. Ажлын явцаас шалтгаалан хөдөлгөөн зохицуулах арга хэмжээнд орж болзошгүй өөрчлөлтийг энэхүү төлөвлөгөөнд харгалзан тусгасан байна .

Хаалт, хашилтуудыг цэвэр, бүрэн бүтэн байлгах ёстой. Хаалтуудыг улаан цагаан

өнгийн ойлгодог будгаар будах буюу эсвэл гэрэл ойлгогч нааж өгнө.

### 906 ЗАМЫГ ХААХ

Ажлын шаардлагаар шороон замуудыг бүр хаах, түр хугацаагаар чиглэлийг нь өөрчлөх эсвэл буцааж замын хөдөлгөөнд нээх тухай мэдэгдлийг Гүйцэтгэгч дор хаяж 28 хоногийн өмнө Инженерт бичгээр өгнө. Инженер холбогдох байгууллагатай ажлыг гүйцэтгэх арга хэлбэр, дэс даралал, хугацааны талаар тохиролцсоны үндсэн дээр Гүйцэтгэгчид зохих зааварчилгааг өгнө. Ажлын хэмжээ бага тохиолдолд Инженер нь зохих байгууллагатай тохиролцох ажлыг Гүйцэтгэгчид даалгаж болно. Ямар ч тохиолдолд Гүйцэтгэгч Инженерийн зааварчилгааг авах бөгөөд эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр ямар ч замыг ямар нэг байдлаар хааж болохгүй.

### 907 ЗОРЧИГЧДОД ТУСЛАХ

Гүйцэтгэгч нь зорчигчдын тав тух, аюулгүй байдлыг хангахад шаардлагатай туслалцааг бүх хугацааны туршид үзүүлнэ.

### 908 ТУСЛАХ ЗАМ

(а) Талбайд хүрэх зам

Гүйцэтгэгч нь өөр зам байхгүй газарт өөрийн тоног төхөөрөмж, ажиллах хүчин, материалыг тээвэрлэх болон нийтийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд зориулан ажлын талбайн бүх хэсэгт хүрэх туслах зам барих, засварлаж арчлах ажлуудыг өөрийн хөрөнгөөр хийж гүйцэтгэнэ. Шинэ трасст хүрэх болон түүний дагуу ямар нэг туслах зам байхгүй тохиолдолд гүйцэтгэгч өөрийн хэрэгцээнд зориулан туслах болон материал тээвэрлэх замуудыг өарийн зардлаар барьж арчилна. Тэдгээр бүх туслах замуудыг Захиалагч болон Инженерүүд ашиглах боломжтой байна.

(б) Шинэ туслах замууд

Карьер, материал нөөцлөх газар, шороон орд ба хаягдал материал зайлуулах газрууд руу хүрэх туслах замуудыг тэдгээрийн хоорондох хамгийн боломжтой богино чиглэлээр, шинэ трассын дагуух хамгийн ойр цэгийг дайрч өнгөрөхөөр сонгоно. Туслах замуудыг байнга арчилж, материал тээвэрлэлтээс шалтгаалан барилгын ажил саатахгүй байх нөхцлийг хангасан байна.

(в) Туслах зам барьсан газруудыг нөхөн сэргээх

Гүйцтгэгч энэхүү техникийн шаардлагын зүйл 904 (д)-д заасны дагуу түр замуудыг нөхөн сэргээх талаар заасантай адил байдлаар бүх туслах замуудыг нөхөн сэргээнэ.

(г) Зардал

Гүйцэтгэгч туслах замуудыг барихтай холбоотой санхүүгийн бүх хариуцлагыг хүлээх бөгөөд тэдгээрээс үүдэн гарч байгаа дараахи зардлуудыг төлөх ба гэхдээ зөвхөн тэдгээрээр хязгаарлагдахгүй. Үүнд:

- газар авахтай холбоотой бүх арга хэмжээ,
- газрын төлбөр,
- газар эзэмшигч, тэнд оршин суугчид болон холбогдох байгууллагуудтай хийх хэлэлцээр,
- холбооны болон цахилгааны шугам, ус дамжуулах хоолой болон бусал шугам сүлжээний бүх ажлууд,
- нөхөн олговор,
- байгалаас ашигласан хайрга, бусад матеиалын төлбөр,

## 909 ГҮЙЦЭТГЭГЧИЙН БАРИЛГЫН АЖЛЫН ТЭЭВЭР

(а) баригдаж буй шинэ замыг ашиглах

Гүйцэтгэгчийн барилгын материал тээвэрлэж буй тоног төхөөрөмж, хүнд даацын ачааны машинууд нь баригдаж буй хүйтэнд тэсвэртэй үе ба хучилтын үеүд дээгүүр явах ёсгүй. Энэ зорилгоор хүйтэнд тэсвэртэй үе ба хучилтын үеүдийг, асфальтбетон болон гадаргуун давхар өнгө боловсруулалт хийж дуусах хүртэл сайтар хамгаалах ёстой. Хучилт нь бүрэн дууссан хэсэгт дээр Гүйцэтгэгчийн барилгын буй тоног төхөөрөмж болон тэнхлэг дээрээ 10 тонноос илүү ачаалал бүхий машинуудыг явуулахгүй. Инженерээс хиймэл байгууламж, далангийн хүйтэнд тэсвэртэй үе, хучилтын үе юмуу гадаргууд эвдрэл үүсэж болзошгүй гэж үзсэн тохиолдолд замын дууссан хэсгүүдийг юмуу дууссан хучилтын үеүдийг Гүйцэтгэгч тээвэрлэлтийн ажилд гүйцэтгэгхдээ ашиглахыг хориглоно.

Бүрэн дууссан далангийн хүйтэнд тэсвэртэй үе, хучилтын үе юмуу өнгөн үе дээр, машины тэнхлэгийн ачааллаас үл хамааран, Гүйцэтгэгчийн машинуудын аль нэгний буруутай үйлдлээс шалтгаалж ямар нэг эвдрэл үүссэн тохиолдолд Гүйцэтгэгч өөрийн зардлаар Инженерийн зааврын дагуу засварлана.

Нийтийн замаар зорчиж буй Гүйцэтгэгчийн машинууд нь энэ талаарх Монгол улсын холбогдох хууль, тогтоомжийг дагаж мөрдөнө.

## 910 ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР

Энэхүү техникийн шаардлагын зүйл 901, 902, 904, 905, 906, 907, 908 ба 909-ийн шаардлагуудыг хангах үүднээс зарцуулах аливаа зардалд тусад нь хэмжилт, төлбөр хийгдэхгүй бөгөөд Гүйцэтгэгчийг аль нэг ажлынхаа өртөг зардалд оруулан тооцсон гэж үзнэ.

(а) Зүйл : түр замыг барих, засаж арчлах

Нэгж : км

Энэхүү зүйлийн төлбөрийн нэгж нь километр байна. Инженерийн зааварчилж, түүний шаардлагыг хангах хэмжээнд баригдаж, засвар арчлалт нь хийгдсэн замын хэсгүүдэд хэмжилт, төлбөр хийгдэнэ.

Энэхүү зүйлийн өртөг нь техникийн шаардлагын зүйл 903 ба Бүлэг 100-ийн шаардлагуудыг хангахад зориулагдан, барилгын ажлын явцад бүхэлд нь гаргах зардлуудыг хамрах ба үүнд энэхүү техникийн шаардлагын Бүлэг 1000-ын дагуу тусдаа хэмжилт ба төлбөр нь хийгдэх түр замын хайрган хучилтын ажил орохгүй.

Дараахи нөхцлүүдийн дагуу түр замын засвар арчлалтын ажлын төлбөрийг хийнэ. Үүнд:

Дэд-зүйл 910 (а)-д заасан нийт үнийн дүнгийн 80%-ийг Гэрээ хүчин төгөлдөр болсоноос хойш ажил хэрэгжиж дуусах хүртэлх хугацаагаар тооцож, сар бүр адил хэмжээгээр төлнө. Гэхдээ Гэрээний нөхцлийн дэд-зүйл 43.1 ба Тендерийн хавсралтад дурьсаны дагуу, барилгын дуусах хугацааг сунгасан байдлыг харгалзан үзнэ.

Зүйл 901-ээс 903-ын шаардлагын дагуу хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлэх үүднээс хийгдэх ёстой ажлууд нь Гүйцэтгэгчийн буруугаас хийгдээгүй хэмээн Инженер тодорхойлсон бол сар бүрийн төлбөрийн зохих хэсгүүдийг саатуулан барина. Үүнтэй холбогдуулан, Гүйцэтгэгчийн гаргасан зөрчлийг арилгах үүднээс Инженер түр замын шаардлагатай засвар арчлалтыг өөр байгууллагаар хийлгэх эрхтэй бөгөөд үүнд зарцуулсан зардлыг Гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс нөхөн олгоно.

Гүйцэтгэгч нь нийт барилгын ажлын явцад зүйл 901-ээс 903-д заасан шаардлагын дагуу хуучин шороон зам, түр замыг засаж арчилсан гэж Инженер шийдвэрлэсэн бол энэ ажлын нийт үнийн дүнгийн үлдсэн 20%-ийг барилгыг хүлээн авсан гэрчилгээг олгосны дараа гүйцэтгэгчид төлнө.

# ХЭСЭГ 1000 – ХАЙРГАН ХӨВӨӨ

## ХЭСЭГ 1000 – ХАЙРГАН ХӨВӨӨ


| | | |
|---|---|---|
| 1001 | ЕРӨНХИЙ ЗҮЙЛ | 10-3 |
| | (a) Тодорхойлолт | 10-3 |
| 1002 | МАТЕРИАЛЫН ШААРДЛАГА | 10-3 |
| 1003 | ХАЙРГАН ХӨВӨӨНИЙ АЖИЛ | 10-4 |
| 1004 | ХҮЛЦЭХ АЛДАА | 10-5 |
| 1005 | ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР | 10-5 |
| | (a) Ажлын нэр: Хайрган хөвөө | 10-5 |

## 1001 ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

(а) Тодорхойлолт

Хайрга гэдэг нь байгалд бэлнээр тохиолддог зохист ширхэглэлтэй материалыг хэлэх ба үүнд ердийн хайрга, буталсан хайрга эсвэл буталсан чулуу багтана.

Хайрган хөвөө гэдэг нь дээрх материалыг дангаар нь буюу тэдгээрийн хольцыг хэрэглэн, зөвшөөрөгдсөн суурийн доод үе дээр, хучилтын өнгөн үе болон суурийн хоёр захыг хамгаалах зориулалтаар, зурагт үзүүлсний дагуу хийсэн зохист ширхэглэлтэй өнгөн үе юм.

Хайрган материал нь байгалаас шууд олборлосон, эсвэл буталсан буюу шигшиж, угааж тодорхой харьцаагаар дахин хольсон материалууд байж болно.

Гүйцэтгэгч нь хайрганы орд газар, мөн материалыг зайлуулж хаях буюу нөөцөлж овоолох газар зэргийг нээх, ашиглах буцааж дарах, нөхөн сэргээх болон тэдгээр лүү хүрэх түр замтай холбоотой ажлыг гүйцэтгэхдээ Монгол улсын холбогдох хууль тогтоомж болон энэхүү Техникийн шаардлагын 600-р Бүлэгт заасан шаардлагыг дагаж мөрдөнө.

## 1002 МАТЕРИАЛЫН ШААРДЛАГА

Дэвсэж нягтруулсан материалын ширхэглэлийн харьцаа нь **Хүснэгт** 10-1-д үзүүлсэн ширхэглэлийн хязгаарт ойролцоо буюу зэрэгцэн явах аажим муруйн хэлбэртэй байна. “Б” зэрэглэлийн ширхэглэлтэй хайргыг хайрган хөвөөний дээд хэсгийн 100мм зузаанд дэвсэж хэрэглэх ба “А” зэрэглэлийг үлдсэн доод хэсэгт ашиглана. Дээд ба доод хэсгийн зузааныг Инженер тодорхойлно. Гэхдээ хайрган хөвөөний зузаан нь 200 мм буюу түүнээс бага тохиолдолд Инженер нь “А” зэрэглэлийг ашиглахгүй байхаар шийдэж болно.

**Хүснэгт 10 - 1 Хайрган хөвөөний материалын ширхэглэлийн шаардлага**

| Шигшүүрийн хэмжээ | Шигшүүрээр өнгөрсөн материалын жингийн | |
|---|---|---|
| | Зэрэглэл | |
| | А | Б |
| 37.5 мм | 100 | - |
| 19.0 мм | 95-100 | 100 |
| 9.5 мм | 60 – 90 | 80 - 100 |
| 4.75 мм | 40 – 70 | 60 - 75 |
| 2.36 мм | 25 - 50 | 35 - 55 |
| 0.425 мм | 15 - 35 | 18 - 27 |
| 0.075 мм | 5 - 20 | 10 - 15 |

Хайрган хөвөөнд хэрэглэх материалын хуурай үеийн хамгийн их нягтшил (MDD) 98% ба 4 хоног усанд сойсоны дараах CBR үзүүлэлт 20% -с их байх ёстой.

Материалын уян налархайн индекс 3 – 7%-ийн хооронд байна.

## 1003 ХАЙРГАН ХӨВӨӨНИЙ АЖИЛ

### (а) ТОДОРХОЙЛОЛТ

“Хөвөө” гэдэг нь суурийн доод үе дээр, хучилтын захаас гадагш Зурагт заасан өргөнөөр тавигдах барилгын ажлын нэг хэсэг юм.

### (б) МАТЕРИАЛ

Хөвөөнд ашиглахаар барилгын талбайд авчирсан материал нь 1002-д дурьдсан ширхэглэл, CBR болон уян налархайн үзүүлэлтүүдийг бүрэн хангасан, хар шороо болон элдэв гадны материал холилдоогүй байх ёстой. Түүнээс гадна хөвөөнд хэрэглэх материалыг авчирч талбай дээр холихыг хориглоно.

(в) ХӨВӨӨНИЙ АЖИЛ

Хайрган хөвөөний ажилд ашиглах тоног төхөөрөмж, тэдгээрийн ажлын аргачлалыг Инженерийн зааварчилсаны дагуу талбайд туршилт хийж сонгох ба тогтооно.

Гүйцэтгэгч нь хайрган хөвөөг хучилтын зэрэгцээ орших үетэй нэгэн зэрэг хийх ба ингэхдээ аливаа үеийн гадаргуугийн усыг байнга гадагшлуулж байх нөхцлийг хангасан тийм аргачлалыг сонгож, баримтдан ажиллах ёстой.

Иймээс энэхүү Гэрээнд тусгагдсан гол замын асфальтан хучилт, буталсан чулуун суурийн болон салаа замын хучилтын хөвөөг зэрэгцээ орших үеийг барихаас өмнө буюу барьснаас хойно хийхийг зөвшөөрөхгүй.

Хайрган материалыг хөвөөний нийт өргөнөөр, хангалттай хэмжээгээр жигд тарааж, нягтруулсаны дараах зузаан нь зурагт заасан буюу Инженерийн зааварчилснаас багагүй байхаар дэвсэнэ. Дэвссэн материалд том чулуу орсон байвал түүж зайлуулах ба хэрэв тэр нь их хэмжээтэй байх юмуу шаарлага хангахгүй материал ихээр холилдсон бол хайрган материалыг нийт нь талбайгаас гаргаж зайлуулна. Хайрган материалыг ачих, тээвэрлэх, буулгах, тарааж дэвсэх, нягтруулах явцад хайрга ширхэглэлээрээ ялгарахаас урьдчилан сэргийлсэн бүхий л бололцоотой арга хэмжээг авах хэрэгтэй.

Нэг удаагийн ажиллагаагаар дэвсэж, нягтруулсан аливаа үеийн зузаан нь 200мм-ээс илүүгүй байна. Нягтруулсан үеийн зузаан үүнээс их байх шаардлагатай хэсэгт материалыг хоёр буюу түүнээс дээш үеэр дэвсэж боловсруулна. Нягтруулсан үеийн хамгийн бага зузаан нь 100мм байна.

Хайрганы чийгийн агууламж нь Тохиромжтой чийгийн агууламжаас (AASHTO T180-93) 1%-иар их буюу 2%-иар бага байж болно. Үүний тулд материалыг нэгэн жигд усалж холих буюу эсвэл хатаах замаар чийгийг тохируулах хэрэгтэй. Хайрган материалыг заасан өргөнд хүргэж, хөндлөнгийн налууг гаргаж тэгшилсэний дараа дурандлага хийж төвшинг эцсийн байдлаар тааруулах ба 3м-ийн рейк, эсвэл ондоо зөвшөөрөгдсөн багажийг ашиглан гадаргуугийн тэгш байдлыг шалгаж, шаардлагатай газруудыг тэгшилж янзлана. Эцсийн нягтруулалтыг хийхээс өмнө хөнгөн нягтруулалт хийж болно. Хэрэв гадаргуу нь нийт авах нягтруулалтын 25%-ийг нэгэнт авсан бол Гүйцэтгэгч хусах буюу гадаргууд тэгшилгээний ажил хийж болохгүй. Хөвөөний ажлыг гүйцэтгэхдээ орчны температур 0-оос доош орсон үед хөвөөг ямар нэг хэмжээгээр усалж, чийглэхийг хориглоно.

Эцсийн хэлбэржүүлэлт хийж хуссаны дараа MDD (хуурай үеийн хамгийн их нягтшил) нь 98% -с доошгүй (AASHTO T180-93) байхаар материалыг нягтруулна. Гүйцэтгэгч материалыг тараах, тэгшлэх, нягтруулах үед шаардлагатай чийгшилтэй байлгах үүднээс ус шүрших буюу бусад зөвшөөрөгдсөн аргаар тогтоосон чийгшлийн агууламжийг хангалттай хэмжээнд барина.

Нягтруулалт хийж дууссаны дараа гадаргуу нь сайн нягтарсан, элдэв ан цав, хагаралгүй, индүүдлэгийн улмаас гулсалт, долгион үүсэгүй, чулууны ялгарал гараагүй байх ёстой. Хэрвээ гадаргуу нь энд дурвдсан шаардлагыг хангахгүй байвал Гүйцэтгэгч энэхүү Техникийн шаардлагын 300-р Хэсэгт заасан суурийн доод үеийнхтэй ижил арга хэмжээ авах буюу Инженерийн шаардсан буюу зөвшөөрсөн аливаа бусад арга хэмжээг авна. Шаардлагатай тохиолдолд тухайн хэсэгт хийсэн хучилтыг хуулж зайлуулан дахин

шинээр хийхийг Инженер зааварчилж болох ба энэхүү ажлын зардлыг бүхэлд нь Гүйцэтгэгч хариуцна.

Түүнчлэн энэхүү Техникийн шаардлагын 100, 200-р Бүлгийн шаардлагад нийцүүлэн гүйцэтгэнэ.

1004 ХҮЛЦЭХ АЛДАА

Хайрган хөвөөний хүлцэх алдаа нь энэхүү Техникийн шаардлагын 300-р хэсэгт заасан суурийн доод үеийн хүлцэх алдаатай адил буюу хучилтын зэргэлдээх үеүдийнхтэй уялдуулан авна.

**1005 ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР**

(a) Ажлын нэр : Хайрган хөвөө

Хэмжих нэгж : $м^3$

Хайрган хөвөөний ажлыг суурийн доод үе дээр дэвсэж нягтруулсан шоо метрээр хэмжинэ. Ажлын тоо хэмжээг гаргахдаа хөвөөний өргөнийг Инженерийн зааварчилсан, нягтруулсан зузаан ба уртаар үржүүлнэ.

Засварын ажлын хувьд тусад нь хэмжилт , төлбөр хийхгүй.

Хайрган хөвөөний нэгж үнэлгээнд дараах ажлууд багтана. Үүнд:

- Хайрган материалын орд газар болон түр замын талбайн цэвэрлэгээ,
- Орд газар болон түр замаас хуулсан өнгө хөрс бусад хаягдлыг зайлуулах ба хэрэв шаардлагатай бол тусад нь овоолох,
- Орд газрыг тойруулж хайс барих,хамгаададт хийх
- Түр зам барих ба тэдгээрийг арчлах, түр замаар хөдөлгөөн явах нөхцлийг бүрдүүлэх,
- Орд газар болон түр замыг уснаас хамгаалахь барилгын ажил дуусаны дараа тэдгээрийг буцааж булах, зүлэгжүүлэх ба нөхөн сэргээх,
- Тээврийн хөдөлгөөний хяналт, аюулгүй байдал ба олон нийтийн эрүүл ахуйн шаардлагыг хангах,
- Материалыг сонгох, ухаж авах,
- Материал бутлах, шигших, угаах ба холих, том хэмжээтэй материалыг зайлуулах,
- Материалыг ачих, тээвэрлэх, буулгах,
- Талбай дээрх шаардлагатай түрэлт,шилжүүлэлт ,тараах,тэгшлэх
- Ус авчирч материалыг услах буюу хатаах,
- Нягтруулах
- Шаардлагатай гэж үзвэл нарийн ширхэглэлтэй материал авчирч нэмж холих,
- Шүүрдэх, доголдолтой хэсгүүдийг засч сайжруулах, гадаргууг арчлах,
- Энэхүү Техникийн шаардлагын 100, 200, 300, 600, 900 ба 1000-р хэсгүүдийн заалтуудтай нийцүүлэх.

# БҮЛЭГ 1100 – БУТАЛСАН ЧУЛУУН СУУРЬ БА СУУРИЙН ДООД ҮЕ

## БҮЛЭГ 1100 – БУТАЛСАН ЧУЛУУН СУУРЬ БА СУУРИЙН ДООД ҮЕ


1101 ЕРӨНХИЙ 11-3

(а) Тодорхойлолт 11-3

(б) Материалын эх үүсвэр 11-3

(в) Ажлын талбайн шалгалт 11-3

(г) Чулууны карьер ба шороон орд газрууд 11-3

1102 МАТЕРИАЛЫН АНГИЛАЛ 11-3

1103 МАТЕРИАЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА 11-4

(а) Ерөнхий 11-4

(б) Суурийн доод үе 11-4

(в) Зохист ширхэглэл бүхий суурь 11-4

1104 МАТЕРИАЛЫГ БУТЛАХ, ШИГШИХ БА ХОЛИХ 11-5

1105 ДЭВСЭХ БА НЯГТРУУЛАХ 11-6

1106 СОРИЛТЫН НЯГТРУУЛАЛТ 11-7

1107 УЛААН ШУГАМ ТАВИХ БА ХҮЛЦЭХ АЛДАА 11-7

1108 ДАЛАНГИЙН ДЭЭД, СУУРИЙН ДООД ҮЕ БА СУУРИЙН ГАДАРГУУГААС УСЫГ ЗАЙЛУУЛАХ 11-7

1109 ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР 11-7

(а) Ажлын нэр: Суурийн доод үе

(б) Ажлын нэр: Зохист ширхэглэлт суурь

## 1101 ЕРӨНХИЙ

(а) Тодорхойлолт

Байгалийн материал гэдэг нь хайрга, элс хайрганы хольц, уулын чулуулаг, элс, элсэрхэг хөрс буюу эдгээрийн холимог зэрэг (гэвч зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй) байгалаас шууд олборлосон, бутлалгүйгээр хэрэглэх материалыг хэлнэ. Байгалийн хайрган материалыг “хайрга” гэсэн ерөнхий нэр томъёогоор нэрлэнэ.

Суурийн доод үеийн материалыг шууд байгалаас авах буюу эсвэл буталж, шигшин тодорхой харьцаагаар дахин хольж гаргаж авна.
“Зохистой найрлага бүхий буталсан чулуу” гэдэг нь байгалийн том чулууг буталж, тодорхой харьцаагаар хольсон, ширхэглэлийн тогтоосон хязгаар дотор орших аажим муруй бүхий хольцыг хэлнэ.

Суурийн материалд зохистой найрлага бүхий буталсан чулууг ашиглана.

(б) Материалын эх үүсвэр

Суурь болон суурийн доод үеийн материалыг дараах эх үүсвэрээс гаргаж авч болно. Үүнд:

(i) чулууны орд газар,
(ii) шороон орд газар
(iii) ухмал

Материалын эх үүсвэрийг сонгож тогтоох ажлыг Гүйцэтгэгч бүрэн хариуцаж, өөрийн зардлаар гүйцэтгэнэ. Аль ч тохиолдолд хэрэглэгдэх материалын эх үүсвэрийг Инженер -ээр батлуулна.

(в) Ажлын талбайг үзэж судлах

Тендерийн явцад Гүйцэтгэгч нь ажлын талбайтай танилцах үедээ байгалаас олборлон ашиглаж болох материалуудын талаар сайтар судалж, олдоцтой бөгөөд зохих нөөцтэй гэж үзсэн материалын хувьд дараах зүйлүүдийг тодорхойлж шийдвэр гаргах ба гэхдээ эдгээрээр хязгаарлахгүй. Үүнд:

- зайлуулах хөрс хуулалтын хэмжээ,
- зайлуулах ажиллагааны хүндрэлтэй эсэх,
- материалын чанар ба хатуулаг,
- материалын физик болон химийн үзүүлэлтүүд,
- эх үүсвэрийн шаардлагатай сонголтын зэрэглэл,
- том хэмжээтэй материалын харьцаа,
- гаргаж авах арга,
- боловсруулах арга,
- эх үүсвэрт хүрэх зам.

(г) Чулуун ба шороон орд газрууд

Гүйцэтгэгч нь чулуун ба шороон орд, мөн материалыг зайлуулж хаях буюу нөөцөлж овоолох газар зэргийг нээх, ашиглах, буцааж дарах, нөхөн сэргээх болон тэдгээр лүү хүрэх түр замтай холбоотой ажлыг гүйцэтгэхдээ Монгол улсын холбогдох хууль тогтоомж болон энэхүү Техникийн шаардлагын 600-р бүлэгт заасан шаардлагыг дагаж мөрдөнө.

## 1102 МАТЕРИАЛЫН АНГИЛАЛ

Суурийн доод үед хэрэглэх байгалийн материал нь чулуун болон шороон орд газраас ухаж авч болох буюу замын ухмалаас тэсэлгээгүйгээр ухаж авсан материал байна.

Зохистой ширхэглэл бүхий буталсан чулуу нь чулуун орд газраас гарган авч хоёроос доошгүй үе шаттайгаар буталж боловсруулсан материал байна. Чулууны төрлийг Инженерийн тодорхойлсон буюу зааварчилсаны дагуу сонгох бөгөөд бутлах материал нь

100 мм-ээс доошгүй хэмжээтэй ширхэг бүхий байгалийн хад буюу бул чулуу байна.

## 1103 МАТЕРИАЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

а. Ерөнхий

Суурь болон суурийн доод үеийн материал нь доор дурьдсан зүйлсийг агуулаагүй байна. Үүнд:

i. органик бодис,
ii. өгөршсөн буюу хэврэгшсэн материал,
iii. хоёрдогч (шавар) эрдэс бодис,
iv. хавтгай буюу хайрслаг материал (миканит),
v. зөөлөн чулуу,
vi. тэлэх чадвартай эрдэс бодис,
vii. химийн нөлөөнд хялбар өртдөг материал,
viii. уусдаг давс,

(б) **Суурийн доод үе**

Суурийн доод үеийн материалын дэвсэж нягтруулсаны дараах ширхэглэлийн харьцаа нь **Хүснэгт 11-1-д** үзүүлсэн ширхэглэлийн хязгаарт ойролцоо буюу зэрэгцэн явах аажим муруйн өөрчлөлтийн хэлбэртэй байна.

**Хүснэгт 11-1: Суурийн доод үеийн материалд тавигдах ширхэглэлийн шаардлага**

| Шигшүүрийн хэмжээ | Шигшүүрээр өнгөрсөн материалын жингийн эзлэх хувь |
|---|---|
| 63 мм | 100 |
| 37.5 мм | 90-100 |
| 19.0мм | 60-90 |
| 4.75 мм | 30 - 60 |
| 0.075 мм | 0 – 15 |

Суурийн доод үеийн материалын физик шинж чанар нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Урсалтын хязгаар ≤ 25,
- Уян налархайн индекс ≤ 6,
- Уян налархайн модуль ≤ 60,
- (AASHTO T180-93)-аар тодорхойлсон MDD - 98 % байх үеийн усанд 4 хоног сойсны дараах CBR≥ 30

(в) **Буталсан чулуун суурь**

Ширхэглэлт буталсан чулуун материал нь өгөршсөн, хавтгай буюу хайрслаг ширхэглэлтэй материал (миканит), шавар, шавранцар, органик материал болон бусад хортой бодис агуулаагүй буталсан үзүүрлэг чулуунаас бүрдэнэ. Газар дээрээ амархан бутарч буюу хагарч байгаа мөн хагарахдаа хавтгай хайрс мэт салдаг эсвэл хагарсан судлын дагуудаа гөлгөр гадаргуутай зэрэг чулууг буталсан чулуун материалд ашиглаж болохгүй.

Бутлах чулууны хамгийн бага хэмжээ нь нарийн ширхэглэлтэй буталсан чулууны хэмжээнээс 4 дахин их буюу түүнээс том байх ёстой. Хүрмэн чулуу зэрэг сүвэрхэг хад буюу бул чулууг ашиглахгүй. Буталсан чулууны нийт жингийн 75-аас дээш хувь нь бутлалтын явцад хоёр буюу түүнээс дээш талаараа хагарсан байх ёстой. 0.075мм шигшүүрээр өнгөрөх чулууны хэмжээ жингээрээ 0.5%-иас хэтрэхгүй байна. Зохист ширхэглэлт буталсан

чулуун суурийн дэвсэж нягтруулсаны дараах ширхэглэлийн харьцаа нь **Хүснэгт 11-2-д** үзүүлсэн ширхэглэлийн хязгаарт ойролцоо буюу зэрэгцэн явах аажим муруйн өөрчлөлтийн хэлбэртэй байна.

**Хүснэгт 11-2: Буталсан чулуун суурийн материалын ширхэглэлийн хязгаар**

| Шигшүүрийн хэмжээ | Шигшүүрээр өнгөрсөн материалын жингийн эзлэх хувь |
|---|---|
| 50 мм | 100 |
| 37.5 мм | 90 – 100 |
| 25.0 мм | 80 – 95 |
| 19.0 мм | 60 – 80 |
| 9.5 мм | 40 – 60 |
| 4.75 мм | 25 – 40 |
| 2.36 мм | 15 – 30 |
| 0.425 мм | 7 – 19 |
| 0.075 мм | 0--5 |

Хэрэв чулууг бутлах явцад нарийн ширхэглэлтэй хэсгийн хэмжээ хүрэлцэхээргүй байвал Инженерийн баталсан орд газраас шавар агуулаагүй, элс авчирч хольж болно.

Зохист найрлагатай буталсан чулуун материалын физик шинж чанар нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Содын сульфатыг ашиглан тодорхойлсон буталсан чулууны бат бэх (AASHTO T104) ≤ 12%,
- Лос Анжелесын машинаар тодорхойлсон чулууны элэгдлийн бат бэх (AASHTO T96) ≤ 30,
- Үзүүрлэг шовх ба хавтгай хэсгийн индекс (BS 812) ≤ 25,
- Ус шингээлт ≤ 2%.
- Бутрагдалтын харьцаа 100%
- (AASHTO T180-93)-аар тодорхойлсон MDD - 98 % байх үеийн усанд 4 хоног сойсны дараах CBR≥ 80
- Уян наархайгүй байна. NP

## 1104 МАТЕРИАЛЫГ БУТЛАХ, ШИГШИХ БА ХОЛИХ

Материалыг бутлах, шигших болон тогтоосон орц хэмжээгээр тэдгээрийг холихдоо эцсийн бүтээгдэхүүний чанарыг хангахуйц ажлын аргачлалын дагуу, сайн тохиргоотой, механик ажиллагаатай төхөөрөмжийг ашиглан гүйцэтгэнэ.

Төрөл бүрийн хэмжээтэй, өөр өөр эх үүсвэрүүдээс авсан материалыг материал хураан нөөцөлдөг талбайд механик ажиллагаатай төхөөрөмжийг ашиглан Гүйцэтгэгчийн

туршиж, Инженерийн хүлээн зөвшөөрсөн аргачлалын дагуу холино.

Материал ялгарахаас сэргийлж буталсан чулууг хольж боловсруулах, тээвэрлэх явцад чийглэж байх ба өндрөөрөө 5м-ээс илүүгүй байхаар 25 см-ээс ихгүйгээр үелж, овоолго хийж хураана. Тодорхойлсон ширхэглэлийн хэмжээнд хүрэхийн тулд Гүйцэтгэгч зөвшөөрөгдсөн эх үүсвэрээс өөр материал авч холихоор бол дараах нөхцлүүдийг хангана. Үүнд:

А. Материал бэлдэх олборлох, холихтой холбоотой бүх зардлыг Гүйцэтгэгч бүрэн хариуцна.

Б. Суурийн тогтвортой байдлыг хангах үүднээс /нягтралтыг сайжруулахаар/ уян наархайгүй, органик нэгдэл агуулаагүй элсийг хольцонд нэмж болно.

В. Нэмэлт элсийн хувь хэмжээг лабораторийн дүгнэлтийг үндэслэн Инженертэй зөвшилцөж тогтоох ба хольцын жингийн 15%-иас илүүгүй байна.

## 1105 ДЭВСЭХ БА НЯГТРУУЛАХ

(а) Гол замын суурийн дэвсэлт

Нэг удаагийн ажиллагаагаар дэвсэж, нягтруулсан аливаа үеийн зузаан нь 200мм-ээс илүүгүй байна. Нягтруулсан үеийн зузаан үүнээс их байх шаардлагатай хэсэгт материалыг хоёр буюу түүнээс дээш үеэр дэвсэж боловсруулна. Нягтруулсан үеийн хамгийн бага зузаан нь 100 мм байна.

(б) Салаа замын суурийн дэвсэлт

Нэг удаагийн ажиллагаагаар дэвсэж, нягтруулсан аливаа үеийн зузаан нь 150мм-ээс илүүгүй байна. Нягтруулсан үеийн зузаан үүнээс их байх шаардлагатай хэсэгт материалыг хоёр буюу түүнээс дээш үеэр дэвсэж боловсруулна. Нягтруулсан үеийн хамгийн бага зузаан нь 75мм байна. Салаа замын суурийг Инженерээс өөрөөр зааварчлаагүй бол 4,5м-ийн өргөнтэй дэвсэнэ.

Материалын ширхэглэлийн хэмжээ 903-р зүйлд заасны дагуу байна. Аливаа бутлагдаагүй, заасан хэмжээнээс том чулууг түүж зайлуулна.

Дэвсэх, нягтруулах, мөн түүнчлэн тоног төхөөрөмжийг сонгох зэрэг ажлын аргачлалыг Гүйцэтгэгч, Инженерийн зааварчилсаны дагуу урьдчилсан туршилтаар тодорхойлсон байна. Барилгын ажлын эхэнд материалын эх үүсвэр болон тоног төхөөрөмж солигдсон, эсвэл ажлын чанарыг хангах зорилгоор Инженер ингэх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд дээрх туршилтуудыг дахин хийх ёстой.

Материалыг зурагт заасан буюу Инженерийн тогтоосон нийт өргөнд, хангалттай хэмжээгээр жигд тарааж нягтруулсаны дараах зузаан нь зурагт заасан буюу Инженерийн зааварчилснаас багагүй байхаар дэвсэнэ. Материалыг ачих, тээвэрлэх, буулгах, тарааж дэвсэх, нягтруулах явцад хайрга ширхэглэлээрээ ялгарахаас урьдчилан сэргийлсэн бүхий л бололцоотой арга хэмжээг авах хэрэгтэй. Материалыг нэгэн жигд зузаантайгаар материалын ялгаралгүйгээр тараах төхөөрөмжийг ашиглан дэвсэнэ.

Ямар ч тохиолдолд, суурийн доод үеийн нягтарсан зузаан нь хэрэглэж байгаа материалын хамгийн том хэмжээнээс 2 дахин, суурийн нягтарсан зузаан нь хэрэглэж байгаа материалын хамгийн том хэмжээнээс 3 дахин их байх ёстой.

Гүйцэтгэгч материалыг дэвсэхээс өмнө тохиромжтой чийгийн агуулгыг тохируулах ба материалыг дэвсэж нягтруулах үед чийгийн агуулгыг шаардлагатай хэмжээнд байлгах зорилгоор чийгийн хэмжээг тохируулна. Хэрэв Инженерээс өөрөөр зааварчлаагүй бол нягтруулалтын үед материалын чийг нь тохиромжтой чийгийн агууламжаас (AASHTO T180-93) 0.5%-иар их буюу 1%-иас бага байна. Суурь ба суурийн доод үеийг дэвссэний дараа дурандлага хийж төвшинг эцсийн байдлаар тааруулах ба 3м-ийн рейк, эсвэл бусад зөвшөөрөгдсөн багажийг ашиглан гадаргуугийн тэгш байдлыг шалгаж, шаардлагатай газруудыг тэгшилж янзлах ёстой.

Эцсийн нягтруулалтыг хийхээс өмнө хөнгөн нягтруулалт хийж болох боловч хэрэв гадаргуу нь нийт авах нягтруулалтын 25%-ийг нэгэнт авсан бол Гүйцэтгэгч хусах буюу гадаргууд тэгшилгээний ажил хийж болохгүй.

Эцсийн хэлбэржүүлэлт хийж нягтруулсны дараа суурийн доод үеийн MDD (хуурай

үеийн хамгийн их нягтшил) нь 98%-с доошгүй (AASHTO T180-93) байх хүртэл, суурийн материалыг MDD нь 98%-с доошгүй байхаар нягтруулна.

Гүйцэтгэгч үе тус бүрийг дэвссэн даруйдаа шууд нягтруулна.

Эргэц бүхий тойруугаас бусад бүх хэсэгт нягтруулалтыг хучлагын гадаад ирмэгээс төв рүү чиглэсэн байдлаар, тэнхлэгийн дагуу явж нягтруулна. Эргэцтэй хэсэгт мөн тэнхлэгийн дагуу, гэхдээ нам ирмэгээс өргөгдсөн ирмэг рүү чиглэсэн байдлаар гүйцэтгэнэ.

Гүйцэтгэгч материалыг тараах, тэгшлэх, нягтруулах үедээ гадаргуу болон материалыг хатахаас сэргийлж ус шүрших буюу бусад зөвшөөрөгдсөн аргыг хэрэглэн тогтоосон чийгшлийн агууламжийг зохих хэмжээнд барина.

Нягтруулалт хийж дууссаны дараа гадаргуу нь сайн нягтарсан, элдэв ан цав, хагаралгүй, индүүдлэгийн улмаас гулсалт, долгион үүсээгүй, чулууны ялгарал гараагүй байх ёстой. Хэрвээ гадаргуу нь энд дурьдсан шаардлагыг хангахгүй байвал Гүйцэтгэгч энэхүү Техникийн шаардлагыг 300-р бүлэгт заасан арга хэмжээг авах буюу дахин шинээр хийх зэргээр Инженерийн шаардсан аливаа бусад арга хэмжээг авна. Засварын болон дахин хийх ажлын зардлыг Гүйцэтгэгч хариуцна.

## 1106 СОРИЛТЫН НЯГТРУУЛАЛТ

Гүйцэтгэгч суурь болон суурийн доод үеийг Инженерийн зөвшөөрсөн индүүгээр индүүдэж сорино. Сорилтын нягтруулалт хийх явцад үеүд ил харагдах хөдөлгөөнгүй байх ёстой. Сорилтын нягтруулалт хангалттай болсон гэж үзвэл зөвшөөрөл олгоно. Сорилтын нягтруулалт хийх болон сорилтын дараа гарсан шаардлагатай аливаа засварыг Гүйцэтгэгч өөрийн зардлаар гүйцэтгэнэ.

## 1107 УЛААН ШУГАМ ТАВИХ БА ХҮЛЦЭХ АЛДАА

Суурь болон суурийн доод үеийн улаан шугам тавих ба барилгын ажлыг энэхүү Техникийн шаардлагын 300-р бүлэгт заасан хүлцэх алдааг харгалзан гүйцэтгэнэ.

## 1108 ДАЛАНГИЙН ДЭЭД ҮЕ, СУУРИЙН ДООД ҮЕ БА СУУРИЙН ГАДАРГУУГААС УСЫГ ЗАЙЛУУЛАХ

Гүйцэтгэгч далангийн дээд үе, суурийн доод үе ба суурийн гадаргуугаас усыг байнга зайлуулж хамгаалах арга хэмжээ авах бөгөөд гадаргуу дээр ус тогтсон буюу урссанаас гарсан аливаа эвдрэл гэмтлийг Гүйцэтгэгч өөрийн зардлаар засварлана. Тухайлбал, энэ Техникийн шаардлагын 100 ба 1100-р бүлгүүдэд заасан ус зайлуулах шаардлагыг мөрдөнө.

Хэрэв далангийн дээд үе, суурийн доод үе ба суурийн үеийн аливаа хэсэгт ус тогтсоноос болж материал усанд нэвчсэн буюу үүний улмаас материал нь шаардлагатай нягтыг авч чадахгүй болсон бол Гүйцэтгэгч өөрийн зардлаар эдгээр материалыг зайлуулан хаяж энэхүү Техникийн шаардлагад нийцсэн материалаар солино.

## 1109 ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР

а.Зүйл : Суурийн доод үе

Нэгж :м$^3$

Суурийн доод үеийн ажлыг зурагт үзүүлсэн буюу Инженерийн зааварчилсны дагуу замын далан дээр дэвсэж нягтруулсан шоо метрээр хэмжинэ. Ажлын тоо хэмжээг тооцохдоо нягтруулсан үеийн хөндлөн огтлолын талбайг заасан уртаар үржүүлж гаргана.

Засварын ажилд тусад нь хэмжилт буюу төлбөр хийхгүй. Суурийн доод үеийн нэгж үнэлгээнд дараах ажлууд багтана. Үүнд:

i. Шороон орд, материал хураах талбай, боловсруулалт хийх талбай болон тэдгээрт хүрэх түр замын цэвэрлэгээ,

ii. Дээрх газрууд болон түр замаас хуулсан өнгөн хөрс бусад хаягдлыг зайлуулах ба хэрэв шаардлагатай бол тусад нь овоолох,
iii. Дээрх газрууд болон түр замаас ус зайлуулах, ажил дууссаны дараа тэдгээрийг буцааж булах, зүлэгжүүлэх, нөхөн сэргээх,
iv. Орд газрыг тойруулж хамгаалалт хийх, хайс барих,

- Түр зам барих ба тэдгээрийг арчлах, түр замаар хөдөлгөөн бүрдүүлэх,
- Тээврийн хөдөлгөөний хяналт, аюулгүй байдал ба олон нийтийн эрүүл ахуйн шаардлагыг хангах,
- Материалыг сонгох, ухаж авах,
- Техникийн шаардлагын дагуу болон уян налархай чанарыг өөрчлөх нэмэлтүүдтэй уялдуулан байгалийн хайргыг боловсруулах ба өөрчлөх,
- Хэрэв заасан хэмжээнээс том ширхэглэлтэй материал байвал тэдгээрийг зайлуулах,
- Хуучин хучилтын үеүдийг ухаж авах, тэдгээрийг түр хураах,
- Материалыг давхар боловсруулах ба хураах,
- Материалыг ачих, тээвэрлэх, буулгах,
- Бүхий л шаардлагатай тээвэрлэлт,
- Ус авчирч материалыг услах, хатаах,
- Материалыг холих, боловсруулах, тараах, нягтруулах,
- Шаардлагатай гэж үзвэл нарийн ширхэглэлтэй материал авчирч нэмж холих,
- Шүүрдэх, доголдолтой хэсгүүдийг засч сайжруулах, гадаргууг арчлах,
- Энэхүү Техникийн шаардлагын 100, 200, 300, 600 ба 1100-р бүлгүүдийн заалтуудтай нийцүүлэх.

(б) Зүйл : Зохист ширхэглэлтэй буталсан чулуун суурь

Хэмжих нэгж : $м^3$

Зохист ширхэглэлтэй буталсан чулуун суурийн үеийн ажлыг зурагт үзүүлсэн буюу Инженерийн зааварчилсны дагуу замын далан дээр буюу суурийн доод үе дээр дэвсэж, нягтруулсан шоо метрээр хэмжинэ. Ажлын тоо хэмжээг тооцохдоо нягтруулсан үеийн хөндлөн огтлолын талбайг заасан уртаар үржүүлж гаргана.

Засварын ажилд тусад нь хэмжилт буюу төлбөр хийхгүй.

Зохист ширхэглэлтэй буталсан чулуун суурийн нэгж үнэлгээнд дараах ажлууд багтана.

Үүнд:

- Материалын орд газар, материал хураах талбай, боловсруулалт хийх талбай болон тэдгээрт хүрэх түр замын талбайн цэвэрлэгээ,
- Дээрх газрууд болон түр замаас хуулсан өнгөн хөрс бусад хаягдлыг зайлуулах ба хэрэв шаардлагатай бол тусад нь хураах,
- Дээрх газрууд болон түр замаас ус зайлуулах ажил дууссаны дараа тэдгээрийг буцааж булах, зүлэгжүүлэх, нөхөн сэргээх,
- Чулуун ордыг тойруулан хамгаалалт хийх, хайс барих,
- Тэсэлгээний ажлын аюулгүй байдлыг хангахтай холбогдсон бүхий л арга хэмжээ авах,
- Түр зам барих ба тэдгээрийг арчлах, түр замаар хөдөлгөөнявах нөхцлийг бүрдүүлэх,
- Тээврийн хөдөлгөөний хяналт, аюулгүй байдал ба олон нийтийн эрүүл ахуйн шаардлагыг хангах,
- Материалыг сонгох, ухаж авах,
- Материалыг хоёроос доошгүй үе шаттайгаар бутлах, шигших, угаах ба холих,

- Хэрэв шаардлагатай бол нарийн ширхэглэлтэй материалыг нэмж холих, тэдгээрийг туслах орд газраас гаргаж авах, тээвэрлэлт, орд газар ашигласны төлбөр, нөхөн сэргээлт
- Уян налархай чанарыг өөрчлөх нэмэлтүүдийг авчрах, боловсруулах,
- Заасан хэмжээнээс том ширхэглэлтэй материалыг зайлуулж заасан газарт хаях,
- Материалыг давхар боловсруулах ба 5м-с дээшгүй өндөртөйгөөр овоолон хураах,
- Материалыг ачих, тээвэрлэх, буулгах,
- Бүхий л шаардлагатай тээвэрлэлт,
- Ус авчирч материалыг услах буюу хатаах,
- Материалыг холих, боловсруулах, тараах, нягтруулах,
- Шүүрдэх, доголдолтой хэсгүүдийг засч сайжруулах, гадаргууг арчлах,
- Энэхүү Техникийн шаардлагын 100, 200, 300, 600 ба 1100-р бүлгүүдийн заалтуудтай нийцүүлэх.

# БҮЛЭГ 1200 : АСФАЛЬТБЕТОН БОЛОН ЧУЛУУН ХУЧЛАГА

## БҮЛЭГ 1200 – АСФАЛЬТАН ХУЧЛАГЫН АЖЛУУД


| | | |
|---|---|---|
| 1201 | БҮЛГИЙН АГУУЛГА | 12-4 |
| 1202 | “А” ДЭД БҮЛГИЙН АГУУЛГА | 12-5 |
| 1203 | БИТҮМЭН БАРЬЦАЛДУУЛАГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА | 12-5 |
| 1204 | БИТҮМЭН БАРЬЦАЛДУУЛАГЧИЙН ХАДГАЛАЛТ, АРЧЛАЛТ | 12-5 |
| 1205 | БИТҮМЭН БАРЬЦАЛДУУЛАГЧИЙГ ХАЛААХ | 12-5 |
| 1206 | НЭМЭЛТ БОДИС | 12-6 |
| 1207 | БАРИЛГЫН АЖИЛД ТАВИГДАХ ХЯЗГААРЛАЛТ | 12-6 |
| 1208 | АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ | 12-6 |
| 1209 | АЖЛЫН ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР – “А” ДЭД БҮЛЭГ | 12-6 |
| 1210 | ТОДОРХОЙЛОЛТ | 12-7 |
| 1211 | БИТҮМЭН ЦАЦЛАГА БА БИТҮМЭН ТҮРХЛЭГТ АШИГЛАХ МАТЕРИАЛ | 12-7 |
| 1212 | ГАДАРГУУГ БЭЛДЭХ | 12-7 |
| 1213 | БИТУМЭН ЦАЦЛАГА БА ТҮРХЛЭГ ХИЙХ | 12-8 |
| 1214 | ЦАЦАХ ҮЕИЙН ТЕМПЕРАТУР | 12-9 |
| 1215 | БИТУМЭН ЦАЦЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ, ҮЙРМЭГ ЧУЛУУ ЦАЦАХ | 12-9 |
| 1216 | ХҮЛЦЭХ АЛДАА | 12-9 |
| 1217 | АЖЛЫН ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР – “Б” ДЭД БҮЛЭГ | 12-9 |
| | (а) Ажлын нэр: Битүмэн цацлага ба битүмэн түрхлэг | 12-9 |
| 1218 | ТОДОРХОЙЛОЛТ | 12-11 |
| 1219 | ГАДАРГУУН ӨНГӨ БОЛОВСРУУЛАЛТАД АШИГЛАХ МАТЕРИАЛ | 12-11 |
| | (а) Барьцалдуулагч | 12-11 |
| | (б) Буталсан чулуу | 12-11 |
| 1220 | ТУРШИЛТЫН ХЭСГҮҮД | 12-13 |
| 1221 | БАРЬЦАЛДУУЛАГЧ БА ЧУЛУУН ҮЙРМЭГИЙГ ЦАЦАХ ХЭМЖЭЭ | 12-13 |
| 1222 | ЧУЛУУГ БУТЛАХ, ШИГШИХ, БУТАЛСАН ЧУЛУУГ УГААХ БА НӨӨЦЛӨХ | 12-13 |
| 1223 | БУТАЛСАН ЧУЛУУНЫ ГАДАРГУУГ УРЬДЧИЛАН БҮРЭХ | 12-13 |
| 1224 | ГАДАРГУУГИЙН ӨНГӨ БОЛОВСРУУЛАЛТАД АШИГЛАХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ | 12-14 |
| | (а) Битум цацагч | 12-14 |
| | (б) Чулуу тараагч | 12-14 |
| | (в) Индүү | 12-15 |
| | (г) Бусад машин техникүүд | 12-15 |
| 1225 | ГАДАРГУУГ БЭЛДЭХ | 12-15 |
| 1226 | ГАДАРГУУГИЙН ӨНГӨ БОЛОВСРУУЛАЛТ ХИЙХ | 12-16 |
| 1227 | АРЧЛАЛТ БА ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ХӨДӨЛГӨӨНИЙГ ХЯНАХ | 12-17 |
| 1228 | ХҮЛЦЭХ АЛДАА | 12-17 |
| 1229 | АЖЛЫН ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР – “В” ДЭД БҮЛЭГ | 12-18 |
| | (а) Ажлын нэр: Гадаргуун давхар өнгө боловсруулалт | 12-18 |
| | АСФАЛЬТБЕТОН ХУЧЛАГА | 12-19 |
| 1230 | ТОДОРХОЙЛОЛТ | 12-19 |
| 1231 | МАТЕРИАЛ | |
| | (а) Зунгалаг чанартай битум | 12-19 |
| | (б) Буталсан чулуу | 12-19 |
| | (в) Эрдэс нунтаг | 12-19 |
| 1232 | ФИЗИК ШИНЖ ЧАНАР БА ШИРХЭГЛЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА | 12-20 |

| | | |
|---|---|---|
| 1233 | ГҮЙЦЭТГЭГЧИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ | 12-21 |
| | (а) Ерөнхий | 12-21 |
| | (б) Холих тоног төхөөрөмж | 12-21 |
| | (в) Дэвсэх тоног төхөөрөмж | 12-21 |
| | (г) Нягтруулах тоног төхөөрөмж | 12-21 |
| 1234 | ГАДАРГУУГ БЭЛДЭХ | 12-22 |
| 1235 | АСФАЛЬТАН ХОЛЬЦНЫ ОРЦЫН НОРМЫГ ТОГТООХ | 12-22 |
| 1236 | ТАЛБАЙН ТУРШИЛТ | 12-23 |
| 1237 | АСФАЛЬТБЕТОН ХОЛЬЦЫГ ХОЛИХ | 12-24 |
| 1238 | ХОЛЬЦЫГ ДЭВСЭХ | 12-25 |
| 1239 | ХОЛЬЦЫГ НЯГТРУУЛАХ | 12-25 |
| 1240 | ӨНГӨЛГӨӨ, ИРМЭГ БА ЗААДАС | 12-27 |
| 1241 | АСФАЛЬТБЕТОН ХОЛЬЦООС ДЭЭЖ АВАХ БА ШИНЖИЛГЭЭ | 12-27 |
| 1242 | ЧАНАРЫН  ХЯНАЛТЫН ШИНЖИЛГЭЭ | 12-27 |
| 1243 | ХҮЛЦЭХ АЛДАА | 12-27 |
| 1244 | АЖЛЫН ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР – “Г” ДЭД БҮЛЭГ | 12-28 |
| | (а) Ажлын нэр : Асфальт бетон хучлага | 12-28 |
| | (б) Ажлын нэр: Барьцалдуулагчийн орцын өөрчлөлт | 12-29 |
| 1245 | ЧУЛУУН ХУЧЛАГА | 12-30 |
| 1246 | БҮЛГИЙН ХАМРАХ ХҮРЭЭ | 12-30 |
| 1247 | ТОДОРХОЙЛОЛТ | 12-30 |
| 1248 | ЕРӨНХИЙ ЗҮЙЛ | 12-30 |
| 1249 | МАТЕРИАЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА | 12-30 |
| | (а) Байгалийн чулуун материалын бүлэг | 12-30 |
| | (б) Чулууны хэлбэр дүрс | 12-30 |
| | (в) Чулууны төрөл | 12-31 |
| | (г)  Чулууны үндсэн хэмжээс | 12-31 |
| | (д) Хүлцэх алдаа | 12-31 |
| | (е) Чулууны физик-механик шинж чанар | 12-32 |
| | (ё) Шалгалт ба туршилтын аргууд | 12-32 |
| | (з) Чулууг тээвэрлэх хадгалах | 12-33 |
| 1250 | ЧУЛУУН ХУЧЛАГЫГ БАРИХ | 12-33 |
| | (а) Бэлтгэл ажил | 12-33 |
| | (б) Чулууг өрж суулгах | 12-34 |
| | (в) Чулууг нягтруулах ба заадсыг чигжих | 12-35 |
| | (г) Ашиглалтын үед гадаргууд тавигдах шаардлага | 12-35 |
| 1251 | ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР | 12-36 |

## 1201 БҮЛГИЙН АГУУЛГА

Энэ бүлэгт янз бүрийн битүмэн барьцалдуулагч болон буталсан чулууг гадаргуун боловсруулалт болон асфальтбетон хучлаганд хэрэглэх талаар зааварчилсан болно. Бүлэг дотроо таван дэд хэсэгт хуваагдана. Үүнд:

Дэд бүлэг “А” Ерөнхий

Дэд бүлэг “Б” Битүмэн цацлага ба битүмэн түрхлэг

Дэд бүлэг “В” Гадаргуугийн өнгө боловсруулалт

Дэд бүлэг “Г” Асфальтбетон хучлага

ДЭД БҮЛЭГ “**А” – ЕРӨНХИЙ**

## 1202 “А” ДЭД БҮЛГИЙН АГУУЛГА

“А” Дэд бүлэгт битүмэн барьцалдуулагч болон буталсан чулуунд тавигдах бүх шаардлагыг тайлбарласан болно.

## 1203 БИТҮМЭН БАРЬЦАЛДУУЛАГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Бүх битүмэн барьцалдуулагч нь энэхүү Техникийн шаардлагын 200-р Хэсэгт заасан шаардлагад нийцсэн байх ёстой.

## 1204 БИТҮМЭН БАРЬЦАЛДУУЛАГЧИЙН ХАДГАЛАЛТ, АРЧЛАЛТ

Гүйцэтгэгч нь барьцалдуулагч материалыг их хэмжээгээр зөөвөрлөх бол тухай бүрд нь барьцалдуулагчийн температур, болон тоо хэмжээний талаар Инженерийн зөвшөөрсөн байдлаар тэмдэглэл хөтөлнө. Энэхүү техникийн шаардлагын 1205-р Зүйлд тавигдсан шаардлагыг хангаагүй аливаа барьцалдуулагч материалыг Инженер барилгын ажилд ашиглахыг зөвшөөрөхгүй.

Гүйцэтгэгч нь битумын агуулах, халаах станцыг байнга цэвэр байлгах ба эдгээрийн ойр орчмын өвс ургамлыг хадаж цэвэрлэсэн байна. Галын аюул гарахаас урьдчилан сэргийлэх үүднээс торхуудыг хооронд нь хангалттай зайнд байрлуулна.

Битум зөөгч болон битумын тогоог бүхий л хугацаанд цэвэр байлгана. Битумын марк өөрчлөгдөх тохиолдолд өөр төрлийн битумуудыг хольж хадгалах, хэрэглэхийг зөвшөөрөхгүй. Шинэ маркийн битумыг хүлээж авахын тулд ондоо торхнуудыг бэлтгэсэн байх ба бүх ажлын тогоо болон битум зөөгчийг зөвшөөрөгдсөн уусмалаар сайтар угааж цэвэрлэнэ. Битумын тогоо болон битум зөөгчийг цэвэрлэхэд гарсан хаягдлыг зориулалтын бохир усны худагт зайлуулж хаяна. Ингэхдээ Гүйцэтгэгч газрын гадаргуу болон урсгал усны урсац, хөрсний усны судлыг бохирдуулахгүй байх бүх талын арга хэмжээг авсан байна. Гүйцэтгэгч бохир усны худгийг Инженерийн зөвшөөрсөн байдлаар тодорхой хугацаанд султгаж, бохир усыг зайлуулж байна. Барилгын ажил дууссаны дараа Гүйцэтгэгч эдгээр бохир усны худаг ба сувгийг зайлуулж, Инженерийн шаардлагын хэмжээнд хүртэл тухайн орчны талбайг нөхөн сэргээнэ.

Гүйцэтгэгч бүх тогоо, урьдчилан халаах худгууд, багаж, тоног төхөөрөмжийг туйлын цэвэр байлгах ёстой.

Битумийг тогоо буюу агуулахаас битум зөөгч рүү юүлэхдээ нарийн утсаар хийсэн торон шүүлтүүрээр шүүж хийнэ.

Битумыг төмөр замын тээврээр авч байгаа тохиолдолд замын рельс, дэр болон бусад тоноглолыг бохирдуулахгүй, байнга цэвэр байлгаж, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авч байна.

## 1205 БИТҮМЭН БАРЬЦАЛДУУЛАГЧИЙГ ХАЛААХ

Хадгалалтын явцад битумэн барьцалдуулагчийн температурыг аль болох бага, гэхдээ барьцалдуулагчийг шахуургаар шахах боломжтой хэмжээнд байлгана.

Гүйцэтгэгч нь битумэн барьцалдуулагчийг зөвхөн зохих шахуурга болон нарийвчилсан заалт бүхий термометрээр тоноглогдсон тогоо буюу хүрэлцэх хэмжээний багтаамж бүхий агуулахад халаана. Термометр нь эвдэрсэн буюу нарийн заадаггүй саванд барьцалдуулагчийг халаахыг зөвшөөрөхгүй.

Цойлох шахалттай шүршигчийг ашиглахаар бол цацах үеийн зунгалаг чанар нь 70-аас 100 центисток байх ба шүрших шахалттай шүршигчид 35 –аас 65 сентисток хүртэл байна.

Барилгын ажилд ашиглах аль ч маркийн битумыг $170^0$С-аас дээш хэмд халааж болохгүй. Хэт халаасан битумыг Гүйцэтгэгч ажлын талбайгаас зайлуулж хаяна.

Барьцалдуулагчийн эзэлхүүнийг 15.° С-т хэмжих буюу эсвэл Нефтийн Стандарт Хэмжилтийн тохиргооны хүснэгтийг (ASTM D 1250) ашиглан 15.° С-тай байхад шилжүүлж тохируулсан хэмжээг үндэслэн, Инженерийн зааварласан буюу тодорхойлсон орцоор барьцалдуулагчийн хэрэглэнэ.

## 1206 НЭМЭЛТ БОДИС

Гадаргуун боловсруулалтад хэрэглэх битумийн барьцалдуулах чанарыг нэмэгдүүлэхийн тулд Инженерийн зөвшөөрсөн зохих нэмэлт бодисыг хэрэглэнэ. Нэмэлт бодисыг Инженерийн зааварласан орцоор, үйлдвэрлэгчийн ашиглах зааврын дагуу хэрэглэнэ.

## 1207 БАРИЛГЫН АЖИЛД ТАВИГДАХ ХЯЗГААРЛАЛТ

Гүйцэтгэгч битумтэй холбоотой барилгын ажлыг цаг агаарын тааламжгүй нөхцөлд буюу Инженерээс урьдчилан анхааруулсан нөхцөлд гүйцэтгэхгүй.

Битумэн материалыг чийгтэй буюу хөлдүү гадаргууд, эсвэл хольцыг дэвсэж нягтруулахад тааламжгүй цаг агаарын нөхцөлд, мөн Инженерийн баталсан ажлын аргачилалд дурьдсан хүн хүч, машин техник, багаж хэрэгслийн иж бүрдэл хангагдаагүй бол дэвсэхгүй. Битумэн эмульс болон зарим төрлийн шингэн цацлага хийхээс өмнө гадаргууг чийглэх зааврыг Инженер өгч болно.

Гүйцэтгэгч агаарын ба замын гадаргуугийн температур +10$^0$С буюу түүнээс дээш, салхины хурд 36км/цагаас бага нөхцөлд битумэн хольцыг гадаргууд дэвсэнэ.

## 1208 АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

Гүйцэтгэгч галын аюулаас сэргийлж бүхий л шаардлагатай арга хэмжээг авсан байна. Гүйцэтгэгчийн битумтэй ажиллах арга ажиллагаа нь ард иргэдийн буюу өөрийн ажиллагсадын эрүүл мэнд, аюулгүй байдалд хор хөнөөл учруулахгүй байх нөхцлийг хангасан байна. Нэн ялангуяа Гүйцэтгэгч нь:

а) битумыг зөвхөн тухайн ажиллагаанд шаардагдах хэмжээнд хүртэл халаах,
б) халуун битумд ус хүргэхгүй байлгах,
в) халуун битумтэй ажиллахад зохих хамгаалалтын хувцас, гутал ба бээлийгээр хангах,
г) тоосжилтийг хамгийн бага төвшинд бууруулах,

д) ажлын тогоо, битум хадгалах торхнуудын амсрыг битүү байлгах, хэрэв задгай агуулахтай бол хаалт тор татаж мал, амьтан орохоос сэргийлэх зэрэг арга хэмжээг авсан байна.

## 1209 АЖЛЫН ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР – “А” ДЭД БҮЛЭГ

Энэхүү Техникийн шаардлагын 1201 – 1208 Заалтуудыг биелүүлэхэд аливаа хэмжилт буюу төлбөр тусад нь хийгдэхгүй. 1200-р Бүлгийн “А” дэд бүлгийн шаардлагыг биелүүлэхтэй холбогдон гарсан зардлыг Гүйцэтгэгч 1200-р Бүлгийн Б, В, Г дэд хэсгүүдийн нэгж үнэлгээнд оруулсан гэж тооцно.

## ДЭД БҮЛЭГ "Б" – БИТУМЭН ЦАЦЛАГА БА БИТУМЭН ТҮРХЛЭГ

### 1210 ТОДОРХОЙЛОЛТ

Битумэн цацлага гэдэг нь зунгалаг чанар багатай битумэн барьцалдуулагчийг шингээлт сайтай, хучлагагүй гадаргууд цацаж хэрэглэхийг хэлнэ.

Битумэн түрхлэг гэдэг нь битумэн барьцалдуулагчийг асфальтбетон буюу бетон гадаргууд нимгэн үеэр цацахыг хэлнэ.

### 1211 БИТУМЭН ЦАЦЛАГА БА БИТУМЭН ТҮРХЛЭГТ АШИГЛАХ МАТЕРИАЛ

Битумэн цацлагад ашиглах барьцалдуулагч нь AASHTO M82 шаардлагад нийцсэн MC-30 ба MC-70 маркийн шингэрүүлсэн битум байна. Инженерээс өөрөөр заагаагүй бол шингэрүүлсэн битумыг 0.8-1.4 л/м$^2$ –ийн хэмжээгээр цацна.

Битумэн эмульсыг шингэн цацлагад ашиглаж болохгүй. Битумэн цацлага хийсний дараа гадаргуу нь 24 цагийн дотор хатсан байх ба цацлагын гадаргууд нэвчих гүн 3-10мм байх ёстой. Хэрэв Гүйцэтгэгч цацлага хийсэн гадаргуугаар өөрийн машин техник, эсвэл нийтийн тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхээр бол тухайн хэсэгт шигшсэн материал цацаж хамгаалж өгнө.

Битумэн цацлагатай гадаргуунд цацах шигшсэн материал нь органик бодис, шавар болон бусад тохиромжгүй бодис агуулаагүй байх шаардлагатай ба нарийн ширхэгтэй буталсан чулуу, элс, бутлуураас гарсан чулуун тоос зэргийг ашиглана. Шигшсэн материалын ширхэглэлийн үзүүлэлтүүд нь Инженерийн зааварчилсаны дагуу байна.

Битумэн түрхлэгт ашиглах барьцалдуулагч нь :

(i) асфальтбетон үеийг дэвсэхийн өмнөхөн халуунаар нь 0.3 л/м$^2$ –ийн хэмжээтэй цацах, нэвчилт сайтай битум;

(ii) асфальтбетон үеийг дэвсэхийн урд, шингэрүүлэгч ууршихад хүрэлцэхүйц хугацааны өмнө 0.2л/м$^2$-ийн хэмжээтэй цацагдах дунд зэргийн хурдтай өтгөрдөг шингэрүүлсэн битум;

Инженерээс өөрөөр зааварчлаагүй бол шингэрүүлэгч материалд дизелийн түлшийг ашиглаж болно.

Битумэн цацлага ба түрхлэгт хэрэглэх барьцалдуулагчийн болон шингэрүүлэгчийн зохистой харьцааг Гүйцэтгэгч лабораторит урьдчилан тогтоож Инженерээр хянуулах ба үүний дараа талбайд тодорхой тооны туршилт хийж Инженерээс зөвшөөрөл авсаны дараа ажлыг гүйцэтгэнэ.

Гүйцэтгэгч нь битумэн цацлага ба түрхлэгийг хийх бүрдээ хэрэглэх барьцалдуулагчийн температур, бүрэлдэхүүн материалуудын харьцаа, хийгдэх газрын байршил зэргийг харуулсан хүснэгтийг тогтмол хөтлөх ба Гүйцэтгэгчийн болон Инженерийн холбогдох хүмүүс гарын үсэг зурж байна.

### 1212 ГАДАРГУУГ БЭЛДЭХ

Гүйцэтгэгч цацлага ба түрхлэг хийх гадаргууг механик шүүрээр шүүрдэх, хийн шахуургаар /компрессор/ үлээлгэх, усаар шүршиж угаах, эсвэл бусад тохиромжтой аргаар сайтар цэвэрлэх ба суларсан хөрс болон бусад гадны материалыг зайлуулна.

Битумэн цацлага ба түрхлэг хийгдэх гадаргуу нийт өргөндөө бүрэн цэвэрлэгдсэн байна.

Цацлага, түрхлэг хийгдэх гадаргуугийн чиг, хөндлөн хэвгий ба төвшинг шалгаж,

ажлыг эхлэхээс өмнө Инженерийн зөвшөөрөх хэмжээнд хүртэл гадаргууг засаж тэгшилнэ. Гүйцэтгэгч битумэн цацлагын ажлыг эхлүүлэхийн өмнөхөн Инженерт цацлага хийх зөвшөөрөл авах хүсэлт гаргана.

Инженерээс ажлыг эхлүүлэх зөвшөөрөл авмагцаа Гүйцэтгэгч цацлага хийхийн өмнө гадаргуун нийт өргөнд нь нэгэн жигд бага зэрэг ус цацаж өгөх ба ингэхдээ ус тогтох буюу үеийг усанд дэвтэж норохоос зайлсхийх ёстой. Тохиромжтой нөхцлийг хангахын тулд усны хэмжээг бага багаар нэмж цацна. Гадаргууд ус тогтсон бол цацлага хийхээс өмнө усыг гадагшлуулж, зохих хэмжээнд хүртэл хатаах арга хэмжээ авна.

### 1213 БИТУМЭН ЦАЦЛАГА БА БИТУМЭН ТҮРХЛЭГ ХИЙХ

Гадаргууг Техникийн шаардлагын 1212-р Зүйлд заасны дагуу Инженерийн зөвшөөрөх хэмжээнд бэлтгэсэний дараа шингэн цацлага буюу түрхлэгийг зохих орц, нормыг баримтлан хийнэ. Инженер гадаргуун бэлтгэлийг зөвшөөрсөнөөс хойш 4 цагийн дотор цацлага болон түрхлэгийг гүйцэтгэсэн байна.

Барьцалдуулагчийг гадаргуугийн нийт өргөнөөс бага зэрэг илүү гаргаж цацна. Цацалт, түрхлэгийн норм буруу байвал Гүйцэтгэгч ажлыг нэн даруй зогсоож энэ тухай Инженерт мэдэгдэх ба ингэснээр Инженер норм хэмжээг өөрчлөх заавар өгнө.

Цацлага, түрхлэг хийх талбайн ирмэгийг замын шулуун хэсэгт 15м, эргэлтэд 7.5м-ээс илүүгүй зайтайгаар гадаслаж утас буюу төмөр утас татаж тэмдэглэнэ.

Барьцалдуулагчийг энэхүү техникийн шаардлагын 1224 (а) Дэд-Зүйл–д заасан шаардлагад нийцүүлэн хамгийн багаар 7000 литрийн багтаамжтай жигд даралтат цацагчаар цацна. Бага талбайд буюу цацагчийн хошуу бөглөрсний улмаас муу цацагдсан газруудыг засварлах зорилгоор Инженерийн зөвшөөрөлтэйгээр гар аргаар цацаж болно.

Цацлага ба түрхлэг жигд хийгдэхээр цацагчийн хошууг тохируулах ба ажлыг эхлэхээс өмнө тохиромжтой материал (хар цаас, лист төмөр зэрэг) дээр буюу зориулалтын хавтгай тэвшинд цацаж туршина. Туршилтыг замын гадаргуу дээр хийж болохгүй ба газар асгарсан аливаа битумыг зайлуулж цэвэрлэнэ.

Цацах явцад цацагчийн хошуу бөглөрөх буюу эвдэрвэл цацлагыг нэн даруй зогсооно. Дутуу цацсан хэсгийг гараар цацаж гүйцээнэ. Дараагийн цацлагыг эхлүүлэхээс өмнө цацагч машиныг зассан байна.

Цацлага, түрхлэгийг эхлүүлэх, зогсоох үед талбайн эхлэл, төгсгөлийн ирмэгийг тод, цэвэрхэн гаргах зорилгоор 2м-с доошгүй өргөнтэй хар цаас буюу гөлмөн төмрийг цацлага хийж буй талбайн нийт өргөнд хөндлөн дэвсэж өгсөн байна.

Ажилбар бүрийн дараа гөлмөн төмрийг сайтар цэвэрлэх хэрэгтэй ба туршилтад ашигласан тэвшийг өдөр бүрийн ажлын дараа цэвэрлэнэ.

Цацалтын үед замын хашлага, замын тоноглол, хоолойн толгой, далавч, мод, бут зэрэг бохирдож болох зүйлсийг хамгаалах ба санамсаргүй байдлаар битум цацарч тэдгээрийг бохирдуулсан бол Инженерээс зөвшөөрсөн тохиромжтой аргаар сайтар цэвэрлэнэ.

## 1214 ЦАЦАХ ҮЕИЙН ТЕМПЕРАТУР

Даралтаар шахах үеийн хамгийн бага температур, цацах үеийн температурын хязгаар болон шингэрүүлсэн битумыг халаах температурын хязгаарыг Хүснэгт 12-1-д үзүүлэв.

**Хүснэгт 12-1 Дунд зэргийн хурдтай өтгөрдөг шингэрүүлсэн битумыг шахах, цацах ба халаах температур**

| Барьцал-дуулагч | Температур (°C )* | | | |
|---|---|---|---|---|
| | Шахах үеийн хамгийн бага температур | Цацах | | Халаах хязгаар |
| | | Цойлох шахалт | Шүрших шахалт | |
| MC30 | 10 | 40 - 50 | 50 – 60 | 65 |
| MC70 | 25 | 55 - 70 | 65 – 80 | 85 |

** Эдгээр нь зөвхөн чиг баримжаа болгох зорилгоор өгөгдөж байгаа үзүүлэлтүүд болно. Харин тухайн үеийн тохиромжтой температурыг, цаг агаарын болон замын нөхцөл байдал, битумын температур ба зуурамтгай чанарын харьцаа зэргээс хамааруулан Гүйцэтгэгч тодорхойлж, Инженер зөвшөөрсөн байх шаардлагатай.*

## 1215 БИТУМЭН ЦАЦЛАГЫГ АРЧЛАХ, ҮЙРМЭГ ЧУЛУУ ЦАЦАХ

Битумэн цацлага хийсний дараа энэхүү Техникийн шаардлагын 1211-р Зүйлд тодорхойлсон хугацаанд барьцалдуулагч нь нэвчээгүй буюу эсвэл энэ хэсэгт тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг нэвтрүүлэх шаардлагатай болсон бол битумын илүүдлийг шингээж, цацлага хийсэн гадаргууг хамгаалах зорилгоор үйрмэг чулуун материалыг шаардлагатай хэмжээгээр цацаж өгнө. Машины дугуй хамгаалаагүй гадаргуу дээгүүр явахаргүй байхаар үйрмэг чулуун материал нийт талбайд жигд тараагдсан байна.

Цацлага хийсэн гадаргуу дахь үйрмэг чулуу болон бүх сул материалыг дараагийн барьцалдуулагчийг цацахаас өмнө зайлуулна.

## 1216 ХҮЛЦЭХ АЛДАА

Нийт өргөнд нэг удаад цацах барьцалдуулагчийн хэмжээ нь тогтоосон нормоос ± 10% -ээс илүүгээр зөрж болохгүй. Битум цацагч нэг удаагийн явалтаараа цацах барьцалдуулагчийн дундаж хэмжээ нь дор хаяж тогтоосон нормтой тэнцүү байна. Битум цацагчийн даацыг үндэслэн тодорхойлсон тооцооны зөв эсэхийг шалгах зорилгоор битумэн цацлагын үед өдөрт нэгээс доошгүй удаа машины торхны багтаамжийг шалгаж үзнэ.

Битум болон шингэрүүлэгчийн харьцааг цацлага хийгдэх тухай бүрт нь нэг удаа шалгаж байна.

## 1217 АЖЛЫН ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР – “Б” ДЭД БҮЛЭГ

(a) Зүйл: Битүмэн цацлага ба битүмэн түрхлэг

Хэмжих нэгж : м2

Битумэн цацлага ба түрхлэгийг энэхүү Техникийн шаардлагын 1210-1216-р зүйлүүдийг ханган хийгдсэн хавтгай дөрвөлжин метрээр хэмжинэ. Ажлын хэмжээг бодохдоо цацлага ба түрхлэг хийгдсэн цэвэр өргөнийг замын тэнхлэгийн дагуу заагдсан уртаар үржүүлж гаргана. Цацлага ба түрхлэг хийгдсэн талбайн өргөнийг 20-25м тутамд хэмжиж, тэдгээрийн дунджаар цэвэр өргөнийг тодорхойлно. Заагдсан хэмжээнээс илүү гарсан талбайд төлбөр хийгдэхгүй.

Битумэн цацлага ба түрхлэгийн нэгж үнэлгээнд дараах ажлууд багтана. Үүнд:

- Барьцалдуулагчийг бэлтгэх, тээвэрлэх ба тогтоосон орцоор цацах,

- Битумэн цацлага ба түрхлэгийг зорчих хэсгийн захаас хоёр тийш тус бүр 150мм илүү гарган гүйцэтгэх,
- огцом налуу газар ажиллах,
- үйрмэг чулуу цацах,
- энэхүү Техникийн шаардлагын 200 ба 300-р Бүлгүүдийн шаардлагад нийцүүлэх.

## ДЭД БҮЛЭГ “B” – ГАДАРГУУН ДАВХАР ӨНГӨ БОЛОВСРУУЛАЛТ

### 1218 ТОДОРХОЙЛОЛТ

Гадаргуун давхар өнгө боловсруулалт (DBST) гэдэг нь урьдчилан бэлдсэн гадаргууд битумэн барьцалдуулагчийн эхний цацалтыг хийж дээр нь жигд ширхэглэлтэй буталсан чулууг дэвсэж нягтруулан, улмаар 2-р үеийг түрүүчийнхтэй ижил аргачлалаар давхарлан хийх ажиллагааг хэлнэ.

### 1219 ГАДАРГУУН ӨНГӨ БОЛОВСРУУЛАЛТАД АШИГЛАХ МАТЕРИАЛ

(а) Барьцалдуулагч

Барьцалдуулагч нь Техникийн шаардлагын 209-р Зүйлд заасан шаардлагад нийцсэн 130/200 маркийн зунгалаг чанартай өтгөн битум байна.

Зунгалаг чанартай битумын шахах үеийн хамгийн бага температур, цацалтын температурын хэлбэлзэл, болон халаалтын хамгийн өндөр темпе артурыг **Хүснэгт 12-2-**т үзүүлэв.

**Хүснэгт 12-2 : Өтгөн битумыг шахах, цацах ба халаах температур**

| Барьцал-дуулагч | Температур (°C )* | | | |
|---|---|---|---|---|
| | Шахах үеийн хамгийн өндөр температур | Цацах | | Халаах хязгаар |
| | | Цойлох шахалт | Шүрших шахалт | |
| 130/200 | 115 | 155-165 | 170-190 | 200 |

* *Эдгээр нь зөвхөн чиг баримжаа болгох зорилгоор өгөгдөж байгаа үзүүлэлтүүд болно. Харин тухайн үеийн тохиромжтой температурыг, цаг агаарын болон замын нөхцөл байдал, битумын температур ба зууранмгай чанарын харьцаа зэргээс хамааруулан Гүйцэтгэгч тодорхойлж, Инженер зөвшөөрсөн байх шаардлагатай.*

Инженер өөрөөр заагаагүй бол битум цацах орц болон буталсан чулууны ширхэглэлийн хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

i) Нэгдүгээр цацалт

*19 мм-ийн дундаж хэмжээтэй буталсан чулуу :*

1,5л/м$^2$

ii) Хоёрдугаар цацалт

*9,5 мм-ийн дундаж хэмжээтэй буталсан чулуу :*

1,1л/м$^2$

Чулууны хамгийн бага дундаж хэмжээг (ALD) буталсан чулууны нөөц бүрт Техникийн шаардлагын 200-р Зүйлд заасны дагуу тодорхойлно. Буталсан чулууны хэлбэр болон тухайн үеийн цаг агаарын байдлаас хамааруулан битумын цацах хэмжээг Инженер өөрчилж болно.

(б) Жижиг ширэглэлтэй буталсан чулуу

i) Хатуулаг, бат бэх, хэлбэр ба цэвэр байдал

Буталсан чулуу нь нэгэн ижил хэмжээгээр бутлагдсан, шоо хэлбэртэй, хатуу, бат бэх байх ба чулууны тоос, шавар, давс, органик бодис буюу эвдрэлд хүргэж болох аливаа

зүйлүүдийг агуулаагүй байна. Буталсан чулууны жингийн 90-с доошгүй хувь нь бутлах явцад нэг буюу түүнээс дээш талаараа хагарсан байна. 0.075мм-ийн шигшүүрээр өнгөрөх чулууны жин нийт жингийн 0.5%-иас ихгүй байна.

Буталсан чулуу нь дараахи шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Лос Анжелесын элэгдлийн бат бэх ≤ 30%
- Содын сульфатын бат бэх ≤ 12%
- Ус шингээлт ≤ 2%
- Үзүүрлэг, шовх хэсгийн индекс ≤ 25%
- Бутрагдалтын харьцаа 90%-аас багагүй

ii) Бутлах чулууны хэмжээ

Бутлуурт оруулах чулууны хамгийн бага хэмжээ нь хэрэглэх буталсан чулууны тогтоосон хэмжээнээс 4 ба түүнээс дээш дахин их байх шаардлагатай.

iii) Урьдчилан бүрэх

Гадаргуун боловсруулалтад хэрэглэх буталсан чулууг энэхүү техникийн шаардлагын 1223-р Зүйлд заасны дагуу битумээр урьдчилан бүрсэн байна.

iv) Ширхэглэл

Бутлах чулууны ширхэглэл нь Хүснэгт 12-3-д үзүүлсэн хязгаартай ижил буюу ойролцоо байна.

**Хүснэгт 12-3: Гадаргуун өнгө боловсруулалтад ашиглах буталсан чулууны ширхэглэлийн хэмжээ**

| Шигшүүрийн хэмжээ (мм) | Шигшүүрээр өнгөрсөн жингийн хувь | |
|---|---|---|
| | Чулууны хэмжээ | |
| | 19 мм (1-р үеэнд) | 9,5 мм (2-р үеэнд) |
| | | |
| 19,0 | 100 | |
| 12,5 | 85 – 100 | |
| 9.5 | 0 –40 | 100 |
| 4.75 | - | 85 – 100 |
| 2.36 | 0-2 | 0 – 10 |
| 1.18 | 0-0,5 | 0 – 2 |
| 0.075 | 0 – 0.5 | 0 – 0.5 |

v) Буталсан чулууг дэвсэх орц

Буталсан чулууг доорх орцоор дэвсэнэ. Үүнд:

- Буталсан чулууны хэмжээ 19 мм 25 кг/м$^2$
- Буталсан чулууны хэмжээ 9,5 мм 12,5 кг/м$^2$

Битум цацалтын болон чулуу дэвсэлтийн нарийвчилсан орцыг талбайд шаардлагатай тооны туршилт хийж тодорхойлох бөгөөд ингэхдээ нягтруулсны дараа буталсан чулуу нь нэг нягт үе болон барьцалдсан ба бага зэрэг илүү гарсан байхаар тооцоолж тохируулна. Эдгээр туршилтын үр дүн нь Инженерийн шаардлагад нийцсэн гэж үзвэл гадаргуун боловсруулалтад ашиглах материалуудын бодит орцыг тэрээр батална.

## 1220 ТУРШИЛТЫН ХЭСГҮҮД

Гүйцэтгэгч, Гэрээний нөхцлийн 14.1-р Зүйлийн дагуу танилцуулах ажлын хөтөлбөртөө, Инженерийн зааварласаны дагуу гүйцэтгэх туршилтын хэсгүүдийн барилгын болон судалгаа туршилтын ажлыг тооцож оруулсан байна. Туршилтын ажлын үр дүн Инженерийн шаардлагыг хангаагүй бол энэ нь Ажил дуусгах хугацааг сунгах үндэслэл болохгүй. Инженер нь туршилт хийсэн хэсэгт лабораторийн шинжилгээ хийлгэж үнэлгээ гаргахад шаардлагатай хугацааг авах эрхтэй. Гадаргуун өнгө боловсруулалттай холбоотой аливаа ажлыг туршилтын хэсэгт зөвшөөрөл өгөх хүртэл эхлүүлэхгүй. Инженерийн урьдчилсан зөвшөөрөлгүйгээр цацах, дэвсэх орц, материалын төрөл, хэмжээ, эх үүсвэрийг өөрчилж болохгүй ба хэрэв ийм өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагатай бол Инженерийн зааврааp туршилтын хэсгийг хийнэ.

## 1221 БАРЬЦАЛДУУЛАГЧ БА БУТАЛСАН ЧУЛУУГ ЦАЦАХ, ДЭВСЭХ ОРЦ

Барьцалдуулагчийн болон буталсан чулууны орц, хэмжээг Техникийн шаардлагын 1219-р Зүйлд заасны дагуу буюу Инженерийн зааснаар тогтооно.

Хэрэв Инженер нь барьцалдуулагч болон буталсан чулууны орцыг өөрчилбөл Ажлын тоо хэмжээнд орсон нэгж үнэлгээ болон орцонд өөрчлөлт орохгүй бөгөөд аливаа нэмэлт төлбөр хийгдэхгүй.

Битум цацагчийн багтаамж болон буталсан чулуу тараагч машины хүчин чадлыг үндэслэн тооцоолсон цацах ба дэвсэх орц хэмжээг шалгах зорилгоор гадаргуугийн өнгө боловсруулалт хийх явцад өдөрт нэгээс доошгүй удаа туршилтын цацалт буюу дэвсэлт хийсэн байх шаардлагатай. Хэд хэдэн богино хэсгүүдэд өнгө боловсруулалт хийх үед Инженерийн удирдамжаар туршилтыг олон дахин давтан хийх шаардлагатай болно. Ингэхдээ цацалт хийсэн хэсэг тус бүрт цацагч машины торхны багтаамж болон хайрга тараагчийн дэвсэх хүчин чадлыг ажлын явцад өдөр тутам шалгаж байна.

## 1222 ЧУЛУУГ БУТЛАХ, ШИГШИХ, УГААХ БА НӨӨЦЛӨХ

Гүйцэтгэгч, Техникийн шаардлагын 1219-р Зүйлийн (б)-д заасан шаардлагыг хангахуйц буталсан чулууг үйлдвэрлэх хүчин чадал бүхий тоног төхөөрөмжтэй байна. Шороо тоосгүй, цэвэр байлгах үүднээс буталсан чулууг угаах шаардлага гарч болно.

Гүйцэтгэгч буталсан чулууг энэхүү Техникийн шаардлагын 600-р Бүлэгт заасан шаардлагад нийцүүлэн нөөцөлж хадгална. Хэрэв Инженер шаардлагатай гэж үзвэл материал хадгалах талбайн гадаргууг 100мм зузаан хайргаар буюу Инженерийн зөвшөөрсөн бусад материалаар нэг үе хучиж өгнө.

Бохирдсон чулууг барилгын ажилд ашиглахгүй. Овоолсон материал ширхэглэлээрээ ялгарахгүй байх талаар Гүйцэтгэгч шаардлагатай арга хэмжээг авсан байна. Материалыг хэвтээ үеэр 1.5м-ээс илүүгүй өндөр овоолж нөөцлөнө. Материалыг ашиглаж дуусаны дараа нөөцийн талбайг Инженерийн шаардлагын хэмжээнд хүртэл сайтар цэвэрлэж зүлэгжүүлэх ба нөхөн сэргээнэ.

## 1223 БУТАЛСАН ЧУЛУУНЫ ГАДАРГУУГ УРЬДЧИЛАН БҮРЭХ

Гадаргуун өнгө боловсруулалтад ашиглах буталсан чулууны гадаргууг Инженерийн зааварласанаар урьдчилан бүрнэ.

Буталсан чулууг урьдчилан бүрэхэд ашиглах барьцалдуулагч нь Инженерээс өөрөөр заагаагүй бол зунгалаг чанартай өтгөн битум байна. Гүйцэтгэгч буталсан чулууг бүрэх ажлыг бага оврын асфальт заводод гүйцэтгэнэ. Буталсан чулууны бүрэлтийн хатуулаг чанарыг хянахдаа бүрсэн чулууг хөргөсний дараа хоорондоо наалдахгүй, чөлөөтэй урсаж байхаар бүрэх үеийн температур ба холих хугацааг тохируулан хянана.

Урьдчилан бүрэхэд шаардлагатай барьцалдуулагчийн хэмжээг Инженерийн зааварчилснаар буюу дараах харьцаагаар тогтооно:

- 19 мм-ийн хэмжэээтэй чулууг жингийн 0.6 – 0.8%-иар
- 9,5 мм-ийн хэмжэээтэй чулууг жингийн 0.9 - 1.1%-иар

Урьдчилж бүрсэн чулууг тоос шороо буюу бусад шаардлага хангахгүй зүйлүүдээр бохирдохоос хамгаална.

## 1224 ГАДАРГУУН ӨНГӨ БОЛОВСРУУЛАЛТАД АШИГЛАХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

(а) Битум цацагч

Битум цацагч нь BS 1707 стандартад дурьдсан гадаргуун өнгө боловсруулалтад ашиглах халуун барцалдуулагч цацагчид тавигдах шаардлагад нийцсэн, ачааны машин дээр суурилуулсан, тогтмол даралтат битум цацагч байна. Шүршигч хоолойн нэгэн жигд цацалтын үзүүлэлт нь BS 1707 стандартад тайлбарласан “Цацалтын туршилтын” шаардлагыг хангасан байх ба Гүйцэтгэгч энэ төхөөрөмжийг жилд нэг удаа шалгаж байна.

Битум цацагч нь жигд хурдтай явж, барьцалдуулагчийг тогтоосон орцоор цацах бүрэн хүчин чадалтай машин байна. Машин нь цацалтын урт, өргөн, барьцалдуулагчийн орц, хэмжээ, температурыг жолоочид нарийвчлан харуулах компьютержсэн хяналтын самбартай байхын дээр жолоочид сайн харагдахаар машинд холбосон чиглүүлэгч төмөр ба гинж буюу аливаа бусад зөвшөөрсөн захын чиг баригчаар тоноглогдсон байна. Түүнчлэн битум цацагдаагүй буюу муу цацагдсан жижиг талбайд дахин цацалт хийх зориулалт бүхий гар шахуургатай байна.

Цацагчийн ачаалах сав нь 7000-с доошгүй литрийн багтаамжтай байх ба ямар ч үед саван дахь битумын хэмжээг заадаг төхөөрөмжтэй байна. Мөн битумийг байнга $200^0$C-тэй байлгах халаагуур ба нарийвчлал сайтай термометрээр тоноглогдсон байна. Цацалтын даралт хэмжигч ба температур хэмжигчийг шүршигч хоолойд байрлуулсан байна.

Битум цацагч нь халуун барьцалдуулагчийг цацалгүйгээр цистерн ба шүршигчийн дотор циркуляц хийж байх хүчин чадалтай шахуургаар тоноглогдсон байна. Шүршигч хоолойг бөглөрөхөөс сэргийлж шүүлтүүр хийж өгсөн байна. Цацаж эхлэхээс өмнө халуун барьцалдуулагчийг шахаж эргэлдүүлэн, шүршигч хоолой ба түүний хушууг урьдчилан халааж өгнө. Шүршигч хоолой нь 7.3м-ээс доошгүй өргөнд шүрших, хөндлөн ба босоо чиглэлд тохируулах боломжтой байна. Ингэснээр жолооч өөрөө шаардлагатай ирмэгийг гаргах бололцоотой болно. Шүршигч хошуу нь хурдан салгагч ба дусахаас хамгаалсан төхөөрөмжөөр тоноглогдсон, мөн барьцалдуулагчийг нэгэн жигд шүршиж цацахад хүрэлцэхүйц даралттай байна.

Зэрэгцээ 3 хушуунаас цацагдсан битум давхарлах үедээ тогтоосон орцыг зурвасын нийт өргөнд жигд хангахуйцаар шүрших хоолойн өндөр болон цацах хушууны өнцгийг тохируулсан байх шаардлагатай.

Цацагч нь битумэн барьцалдуулагчийг заасан хэмжээнээс ± 10% -ийн хязгаарт цацах хүчин чадалтай байна.

Ажил эхлэхээс өмнө буюу Инженерийн шаардсан тохиолдолд цацагчийг шалгаж тохиргоо хийсэн байна. Үүнд бүх хэмжигч багаж төхөөрөмжүүдийн тохиргоо болон хөндлөн цацалтын жигд байдлыг шалгах ажлууд багтана. Ялангуяа шүршигч хоолойны өндөр нь үйлдвэрлэгчийн зааврын дагуу тохирсон эсэх, мөн шүрших хушуунуудын цэвэрлэгээ, гэмтэл, өнцгийн тохиргоо, битумын температур зэргийг сайн шалгах шаардлагатай.

Битум цацагч бүр “цацалтын орц хэмжээ/машин хурд” гэсэн тохиргооны графикаар хангагдсан байна.

(б) Буталсан чулуу тараагч

Буталсан чулуу тараагч нь чулууг заасан орц хэмжээгээр, 7м хүртэл өргөнөөр, нэгэн жигд тараах чадалтай өөрөө явагч буюу Инженерийн зөвшөөрсөн төхөөрөмж байна.

Буталсан чулуу тараагчийн тоо болон хүчин чадал нь битумэн барьцалдуулагчийг цацсаны дараа нэн даруй буталсан чулууг шууд дэвсэхэд хүрэлцээтэй байх ёстой.

Аливаа ажлыг эхлүүлэхээс өмнө буюу Инженерийн шаардлагаар буталсан чулуу тараагчийг шалгаж тохиргоо хийнэ.

(в) Индүү

6-8тн жинтэй, резинээр бүрсэн төмөр бултай, доргиурт индүүгээр нягтруулна. Инженер зөвшөөрсөн тохиолдолд 8-12тн жинтэй хийн дугуйт индүүг ашиглаж болох юм. Хийн дугуйт индүүг ашиглах тохиолдолд дугуйн гадаргуу нь толигор, даралт нь 0.4MPa-аас дээш байна.

Ган дугуйт индүүг ашиглахыг хориглоно.

Индүүний тоо ба хүчин чадал нь буталсан чулуу тараагчийн араас хоцролгүй индүүдэхэд хүрэлцээтэй байх ёстой. Чулуу тараагч тус бүрийг хоёр ширхэг индүү дагаж индүүднэ.

(г) Бусад төхөөрөмж

Буталсан чулууг цаг хугацаанд нь тасралтгүй хангахад хүрэлцэхүйц тооны ачааны машин, ачих техникийг ажиллуулна.

Резинэн дугуйтай машинд угсарсан буюу түүнээс чирсэн резинэн дугуйтай эргэлддэг механик шүүрийг хэрэглэнэ.

Битумтэй ажиллаж байгаа бүх ажилчдыг хамгаалалтын хувцас ба гутлаар хангана.

Агуулах буюу ажлын тогоо нь барьцалдуулагчийг талбайд цацах техпературт хүртэл халаагууруудтай байна. Эдгээр халаагуурууд нь барьцалдуулагчийг гадаргуугийн өнгө боловсруулалтын ажиллагаанд шаардлагатай хэмжээгээр зохих хэмд халааж битум цацагчид өгөх хүчин чадалтай байх шаардлагатай. Битум цацагч дахь халаагчийг барьцалдуулагчийг харьцангуй бага халаахад л хэрэглэнэ. Битум цацагч дахь халаагчийг энэхүү Техникийн шаардлагын 1219-р Зүйлийн Хүснэгт 12-2–д тодорхойлсон барьцалдуулагчийн шахах үеийн температураас цацах үеийн температур хүртэл халаах зорилгоор ашиглаж болохгүй.

**1225 ГАДАРГУУГ БЭЛДЭХ**

Барьцалдуулагчийг цацахын өмнө гадаргуу дахь бүх сул болон илүүдэл материалыг механик шүүрээр шүүрдэх, Инженер шаардсан тохиолдолд угааж эсвэл өөр бусад зөвшөөрөгдсөн аргаар цэвэрлэж зайлуулна. Бүх хатуурсан шавар буюу бусад гадны зүйлийг шүүрдэж зайлуулахаас өмнө хусаж сулласан байна. Цацалт хийх гадаргуугаас хог хаягдлыг сайн цэвэрлэж зайлуулсан байна. Гадаргуун боловсруулалтын ажлын үед битум доош нэвчихээргүйгээр гадаргууг сайтар нягтруулсан байна. Хэрэв гадаргууд нүх, хонхор үүссэн байвал Инженерийн зааварчилсан хэмжээгээр, тухайн үеийн нийт зузаанаар ухаж авч, оронд нь ижил төрлийн тохирох материалаар эргүүлж дүүргэн нягтруулна. Ингэхдээ чийгийн агуулгыг тохиромжтой хэмжээнд байлгах ёстой.

Гадаргуун боловсруулалтын тэгш байдал нь доод суурiас шууд хамаарах учраас боловсруулалтын ажил эхлэхийн өмнө суурийн тэгш байдлыг зохих багажаар шалгаж, үзүүлэлтийг Инженерт танилцуулна.

Гадаргуун боловсруулалтын бүх ажиллагааг эхлүүлэхийн өмнө Гүйцэтгэгч бэлтгэсэн гадаргууд Инженерийн зөвшөөрөл авсан байна.

Гадаргууд илэрсэн аливаа дутагдлыг Инженерийн зааварласаны дагуу засаж залруулах ба Инженерээс зөвшөөрөл авах хүртэл барьцалдуулагчийг цацахгүй.

## 1226 ГАДАРГУУН ӨНГӨ БОЛОВСРУУЛАЛТ ХИЙХ

Инженер гадаргуун бэлтгэлийг зөвшөөрснөөс хойш 4 цагийн дотор барьцалдуулагчийг зохих орц хэмжээгээр жигд цацна.

Битумыг Инженерийн боломжтой гэж үзсэн цаг агаарын нөхцөлд цацна. Инженерээс өөрөөр заагаагүй бол, Гүйцэтгэгч битумыг агаарын ба замын гадаргуугийн температур $15^0$С буюу түүнээс дээш, салхины хурд 30км/цаг –аас бага нөхцөлд цацна.

Битумыг хучилтын нийт өргөнөөр цацаж гадаргуун боловсруулалтыг хийнэ. Гэхдээ зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд нэг зурваст цацаж, нөгөө зурвасаар барилгын машин механизмыг явуулах байдлаар ажлыг зохион байгуулж болох бөгөөд үүнд Инженерээс зөвшөөрөл авсан байна. Битум цацах ажлыг замын тэнхлэгтэй параллелээр, зорчих хэсгийн захаас гадагш 75мм-ээр давуулан гаргаж буюу эсвэл Инженерийн зааварласны дагуу хийнэ. Харин буталсан чулууг зөвхөн зорчих хэсгийн заагдсан өргөний хэмжээгээр тараана.

Цацагчийн хошууг цацлагыг жигд хийхээр тохируулах ба цацлагыг эхлэхээс өмнө тохиромжтой материал (хар цаас, лист төмөр зэрэг)-ын гадаргуу дээр буюу зориулалтын хавтгай тэвшинд цацаж туршина. Туршилтыг замын гадаргуу дээр хийж болохгүй ба газар асгарсан аливаа битумыг зайлуулж цэвэрлэнэ.

Цацах явцад цацагчийн хошуу бөглөрөх буюу эвдэрвэл цацлагыг нэн даруй зогсооно. Дутуу цацсан хэсгийг гараар цацаж гүйцээнэ. Дараагийн цацлагыг эхлүүлэхээс өмнө цацагч машиныг зассан байна.

Цацалтыг эхлүүлэх үед хөндлөн залгаасыг цэвэрхэн гаргах зорилгоор 2м-с доошгүй өргөнтэй хар цаас буюу гөлмөн төмрийг цацалт хийж буй талбайн нийт өргөнд хөндлөн дэвсэж өгсөн байна. Харин ажлын явц дунд ажил зогсохоор болвол түрүүчийн хэсгийн цацсан тосны төгсгөлд 0,5м-ээс багагүй зайнд чулуу дэвсэлгүй орхино. Саатлыг арилгасаны дараа ажлыг үргэлжлүүлэхдээ энэ хэсэг дээр тосыг давхарлан цацна. Тэхдээ урьд хийсэн гадаргуун боловсруулалтыг мөн л цаас буюу гөлмөн төмөр дэвсэж хамгаална. Эдгээр ажилбарууд нь гадаргуун боловсруулалтын ажил 3 минутаас илүү хугацаагаар зогсох тохиолдол бүрт давтагдан хийгдэнэ.

Хэрэв битумын цацалтыг хучилтын нэг зурвасаар хийж байгаа тохиолдолд дагуу залгаасыг сайн гаргахын тулд замын тэнхлэг талд 200-300мм өргөн хэсгийг чулуу дэвсэлгүй орхиж, дараагийн зурвасыг хийхдээ энэ хэсэгт дахин битум цацаж, дараа нь буталсан чулууг дэвсэнэ.

Ажилбар бүрийн дараа гөлмөн төмрийг сайтар цэвэрлэх хэрэгтэй ба туршилтад ашигласан тэвшийг өдөр бүрийн ажлын дараа цэвэрлэнэ.

Цацалтын үед замын хашлага, замын тоноглол, хоолойн толгой, далавч, мод, бут зэрэг бохирдож болох зүйлсийг хамгаалах ба санамсаргүй байдлаар битум цацарч тэдгээрийг бохирдуулсан бол Инженерээс зөвшөөрсөн тохиромжтой аргаар сайтар цэвэрлэнэ.

Барьцалдуулагчийг цацсан даруйд цэвэр, хуурай бүрхмэл буталсан чулууг заагдсан орцоор нэгэн жигд дэвсэнэ. Барьцалдуулагч ба буталсан чулуу цацах ажиллагааны хоорондох хугацаа ямар ч тохиолдолд 30 секундээс хэтэрч болохгүй.

Боловсруулалтын 2-р үеийг хийхийн өмнө анхны үеийн гадаргууг сайтар шүүрдэж, суларсан чулуу, хог, тоосыг бүрэн цэвэрлэсэн байна. Хэрэв гадаргууд ямар нэгэн эвдрэл гарсан бол Инженерийн шаардлагад нийцүүлэн засварласан байна. 1-р үеийн дэвсэлт, нягтруулалт зохих хэмжээнд хийгдэж, гадаргуу бэлэн болсон гэж үзвэл Инженерт шалгуулж дараагийн үеийг хийх зөвшөөрөл авна. Ер нь 1-р үеийн чулуу битумтай сайтар барьцалдаж, бэхжилтийг бүрэн авсаны дараа 2-р үеийг хийнэ.

Боловсруулалт хийгдсэн гадаргууг хэт их халуунд механик шүүрээр шүүрдэхийг хориглоно.

Буталсан чулууг цаг хугацаанд нь нийлүүлэх боломжгүй болсон тохиолдолд барьцалдуулагч цацах ажлыг нэн даруй зогсоож буталсан чулууны зохих нөөцтөй болтол ажлыг дахин эхлэхгүй.

Чулууны дэвсэлт тохиромжтой хэмжээгээр хийгдсэн эсэхийг нүдэн баримжаагаар үнэлнэ. Ингэхэд барьцалдуулагч нь дэвссэн чулуунуудыг нэгэн жигд бүрхсэн байдалтайгаар нийт гадаргуудаа харагдаж байх ёстой. Дэвссэн үенд аливаа дутагдал илэрвэл Гүйцэтгэгч энэ тухай Инженерт нэн даруй мэдэгдэх ба тэрээр цацалтын хэмжээг өөрчлөх заавар өгнө. Илүүдэл чулууг гараар зайлуулах ба дутуу дэвссэн талбайд гараар буталсан чулуу дэвсэж өгнө. Материалыг шүүрдэж тараах замаар буталсан чулууны дэвсэлтийг жигд бус болгохыг хориглоно.

Гүйцэтгэгч чулуу дэвсэгчийг өндөр хурдтай ажиллуулж болохгүй. Эсрэг тохиолдолд 1-р үеийн гадаргууд дэвссэн буталсан чулуу сулрахад хүрнэ. Буталсан чулууг дэвсэж дуусангуут индүүдлэгийг эхэлж чулууг барьцалдуулагчид наалдаж сайтар суутал индүүднэ.

Индүүний явалтын тохиромжтой тоог туршилт хийсний дараа тогтоох ба Инженертэй зөвшилцөж тохиролцсон байна. Гэхдээ гадаргуун давхар боловсруулалтын 1-р үеийг дор хаяж нэг мөрөөр 3-аас доошгүй удаа, 2-р үеийг нэг мөрөөр 4-өөс доошгүй удаа явж нягтруулна.

Үеийг хэтрүүлэн индүүдэж чулууг хагалж бутлахаас зайлсхийх хэрэгтэй.

Инженерээс өөрөөр зааварлаагүй бол индүүний хурдыг 8км/цаг-аас хэтрүүлэхгүй.

Инженерээс өөрөөр заагаагүй бол өмнө дуусгасан хэсгийг нэмж индүүдэхээр бол 1-р үеийг резинээр бүрсэн төмөр бултай, доргиурт индүүгээр, 2-р үеийг хийн дугуйт индүүгээр өдрийн халуунд гүйцэтгэнэ.

Хэрэв шинээр хийсэн гадаргууд битумын нэвчилт илэрвэл тухайн хэсэгт ижил төрлийн, гэхдээ арай жижиг ширхэглэлтэй (5-8мм) чулууг нэмж цацна.

## 1227 АРЧЛАЛТ БА ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ХӨДӨЛГӨӨНИЙГ ХЯНАХ

Дэвсэлт хийснээс хойш 48 цагийн дотор тээврийн хөдөлгөөн нээхгүй буюу барьцалдуулагч, буталсан чулуу хоёр хоорондоо сайн барьцалдаж чулуу сулрахаргүй болсон гэж Инженер үзсэн нөхцөлд замын хэсгийг хөдөлгөөнд нээж болно.

Шинэ дэвссэн гадаргуу дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг нэвтрүүлэхээс сэргийлж түр хориглох тэмдэг, хаалт хамгаалалтыг Инженерийн зааварласанаар тавьж өгнө.

Өнгө боловсруулалт хийсэн зам дээр хөдөлгөөн явж эхэлсэнээс хойш 2 хоногийн туршид бүх суларсан материалыг зорчих хэсгээс шүүрдэж цэвэрлэнэ. Суларсан чулуун үйрмэгийг замын хажууд цуглуулж хуримтлуулахыг зөвшөөрөхгүй ба замын зурвасаас зайлуулсан байна.

## 1228 ХҮЛЦЭХ АЛДАА

Гадаргуун өнгө боловсруулалтын 100м-т хоорондоо ижил зайтай зургаан цэгт хэмжсэн дундаж өргөн нь зурагт заасан өргөнтөй ижил байна. Замын тэнхлэгийн шугамаас гадаргуун өнгө боловсруулалтын зах хүртлэх зай нь аль ч цэгт зурагт заасан хэмжээнээс 20мм-ээс илүү нарийссан байхыг зөвшөөрөхгүй.

Зурвасын өргөнөөр цацах барьцалдуулагчийн орц заагдсан хэмжээнээс ±10% -иас

илүүгээр зөрж болохгүй ба зурвасын уртад нэг удаагийн явалтаар дэвсэх барьцалдуулагчийн дундаж орц хэмжээ нь зааварласан хэмжээнээс багагүй байна.

Чулуу дэвсэгчийн явалтын дагууд ба хөндлөнгөөр нэг удаад дэвсэх чулууны дундаж орц хэмжээ заагдсан орц хэмжээгээс ±10% -иас илүүгээр зөрж болохгүй.

### 1229 АЖЛЫН ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР – "В" ДЭД БҮЛЭГ

Ажлын нэр : Гадаргуун давхар өнгө боловсруулалт

Хэмжих нэгж : $м^2$

Гадаргуун давхар өнгө боловсруулалтын ажлыг хавтгай дөрвөлжин метрээр хэмжинэ. Талбайг хэмжихдээ боловсруулалт хийгдсэн цэвэр өргөнийг замын тэнхлэгийн дагуух заагдсан уртаар үржүүлж гаргана. Гадаргуун боловсруулалт хийгдсэн талбайн өргөнийг 20-25м тутамд хэмжиж, тэдгээрийн дунджаар цэвэр өргөнийг тодорхойлно. Заагдсан хэмжээнээс илүү гарсан талбайд төлбөр хийгдэхгүй.

Гадаргуугийн өнгө боловсруулалтын ажлын нэгж үнэлгээнд дараах ажлууд багтана. Үүнд:

- Гадаргууг барьцалдуулагч цацахад бэлдэх,
- огцом налуу газар ажиллах,
- барьцалдуулагчийг бэлтгэх, тээвэрлэх ба зааварласан хэмжээгээр цацах,
- барьцалдуулагчийг зорчих хэсгийн заагсдсан өргөнөөс гадагш 150мм илүү гарган цацах,
- нөөц газрыг ашиглах, түр зам, талбайн цэвэрлэгээ ба нөхөн сэргээлттэй холбоотой үйл ажиллагаа,
- урьдчилан бүрсэн буталсан чулууг бэлтгэх, тээвэрлэх, тараах ба индүүдэх,
- тоос болон бусад хог шороог зайлуулах,
- цагаан шугам ба ирмэгүүдийн тэмдэглэгээ хийх,
- бүхий л нэмэлтүүдийг бэлтгэх, нэмж холих,
- нэмэлтүүдийн хэмжээнд гарах өөрчлөлтүүд,
- барьцалдуулагч ба буталсан чулууны хэмжээнд гарах өөрчлөлтүүд
- энэхүү Техникийн шаардлагын 200 ба 300-р Бүлгүүдийн шаардлагад нийцүүлэх,
- энэхүү Техникийн шаардлагын 1200-р Бүлгийн "А" болон "В" Дэд Бүлгийн шаардлагад нийцүүлэх.

## ДЭД БҮЛЭГ “Г” - АСФАЛЬТ БЕТОН ХУЧЛАГА

### 1230 ТОДОРХОЙЛОЛТ

“Асфальтбетон” гэдэг нь ширхэглэлийн зохистой найрлага бүхий хуурай чулуун материал, эрдэс нунтаг ба битумыг тусгай төхөөрөмжид халуунаар нь хольж, зурагт заасан хэмжээ, налууг баримтлан Техникийн шаардлагын дагуу халуунаар нь дэвсэж нягтруулсан хийцийг хэлнэ.

### 1231 МАТЕРИАЛ

(а) Зунгалаг чанартай битум

Барьцалдуулагч нь Техникийн шаардлагын 209-р Зүйлд нийцсэн 130/200 маркийн өтгөн битум байна.

(б) Буталсан чулуу

Том ширхэглэлийн чулуу нь (4.75 мм-ийн шигшүүр дээр үлдсэн) буталсан үзүүрлэг чулуу байх ба өгөршсөн, хавтгай буюу хайрслаг ширхэглэлтэй материал (миканит), шавар, шавранцар, органик материал болон бусад хортой бодис агуулаагүй байна. Газар дээрээ амархан бутарч буюу хагарч байгаа мөн хагарахдаа хавтгай хайрс мэт салдаг эсвэл хагарсан судлын дагуудаа гөлгөр гадаргуутай зэрэг чулууг буталсан чулуун материалд ашиглаж болохгүй. Бутлах чулууны хамгийн бага хэмжээ нь нарийн ширхэглэлтэй буталсан чулууны хэмжээнээс 4 дахин их буюу түүнээс том байх ёстой. Буталсан чулууны нийт жингийн 75-аас дээш хувь нь хоёр буюу түүнээс дээш талаараа бутлалтын явцад хагарсан байх ёстой. 0.075мм шигшүүрээр өнгөрөх чулууны хэмжээ жингээрээ 0.5%-иас хэтрэхгүй байна. Материалын физик шинж чанар нь дараах шаардлагыг хангасан байна.

- Лос Анжелесын үрэлтийн бат бэх ≤ 30%
- Содын сульфатын бат бэх ≤ 12%
- Ус шингээлт ≤ 2%
- Хэврэгшлийн индекс ≤ 30%

Нарийн ширхэглэлийн чулуу нь (4.75 мм-ийн шигшүүрээр өнгөрсөн) том ширхэгтэй элс, буталсан чулуу буюу буталсан хайрганаас бүрдэнэ. Чулуу нь бат бэх, барзгар ширхэгтэй, шавар, шавранцар, миканит болон бусад хортой бодис агуулаагүй байна. Нарийн ширхэглэлийн чулууны элстэй адилтгах (AASHTO T176) хэмжээ 50-аас доошгүй, 0.425мм шигшүүрээр өнгөрөх чулууны хэврэгшлийн индекс 4-с ихгүй ба AASHTO T104 стандартын дагуу содын сульфатын бат бэхийн 5 удаагийн туршилтаар орсны дараах жингийн алдагдал 15% ихгүй байна.

Гүйцэтгэгч чулууг овоолон хураахдаа материал ширхэглэлээрээ ялгарахаас сэргийлсэн арга хэмжээ авна. Чулууг хэвтээ үеээр, овоолсон чулууны өндөр 1.5 м илүүгүй байхаар хураана.

(в) Эрдэс нунтаг

Эрдэс нунтаг нь чулууны тоос, зуурч болгосон шохой, Портланд цемент болон Инженерийн баталсан бусад эрдсээс бүтнэ.

Эрдэс нутгийг хэрэглэх үед нунтаг нь хуурай, хялбар урсах аливаа бөөгнөрөлгүй байна.

Эрдэс нутгийн ширхэглэлийн найрлага дараах хязгаарт байна. Үүнд:

| Шигшүүрийн хэмжээ | Шигшүүрээр өнгөрөх жингийн хувь |
|---|---|
| 600 µm | 100 |
| 300 µm | 95 - 100 |
| 75 µm | 70 - 100 |

Чулууны тоос болон ижил төстөй материалаас гаргаж авсан эрдэс нунтаг нь миканит, органик материал болон бусад бохир бодис агуулаагүй байх ба уян налархайн индекс нь 4%-с дээшгүй байна.

### 1232 ФИЗИК ШИНЖ ЧАНАР БА ШИРХЭГЛЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Хэрэв Инженер өөрөөр заагаагүй бол том болон нарийн ширхэгтэй чулуу, эрдэс нунтгийг жишиг орцны нормын дагуу хольсны дараа ширхэглэлийн хуваарь Хүснэгт 12-4-д өгсөн хязгаартай ижил буюу ойролцоо байна.

Лабораторийн шинжилгээний дүн болон талбайн туршилтыг үндэслэн Инженер зөвшөөрвөл ширхэглэлийн хязгаарыг өөрчилж болно.

**Хүснэгт 12-4: Асфальт бетонд орох чулууны** ширхэглэлийн хязгаар

| Шигшүүрийн хэмжээ | Шигшүүрээр өнгөрөх жингийн хувь |
|---|---|
| 19 мм | 100 |
| 16 мм | 73 - 87 |
| 9.5 мм | 56 - 71 |
| 4.75 мм | 40 - 55 |
| 2 мм | 25 - 40 |
| 0,425мм | 10-25 |
| 0,075 мм | 3 - 8 |

Асфальт бетон хольц нь Хүснэгт 12-5-д заасан шаардлагыг хангах ёстой.

**Хүснэгт 12-5: Асфальт бетоны физик шинж чанар**

| | **Зохих ширхэглэлийн чулуу бүхий асфальт бетон :** |
|---|---|
| Маршалын тогтворжилт (N) | 5,000 - 12,000 |
| Хэв гажилт (мм) | 3 – 5 |
| Нягтралын түвшин (цохилтын тоо) | Дээжний хоёр тал тус бүр дээр 75 цохилт |
| Хольцны Сүвшил (%) | 3 – 5 |
| Чулууны сүвшил (%) | 14 – 16 |
| 60 °C температурт усанд живэлтийн үеийн тогтворжилтын алдагдал (ASTM D1075) | 75% -ас доошгүй |

Гүйцэтгэгчийн анх санал болгосон жишиг орцын норм дахь барьцалдуулагчийн агууламжийг лабораторийн шинжилгээний дүн болон талбайн туршилтыг үндэслэн Инженер зөвшөөрвөл өөрчилж болно.

## 1233 ГҮЙЦЭТГЭГЧИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

(а) Ерөнхий

Энэхүү Техникийн шаардлагын 100-р Бүлгийн дагуу Гүйцэтгэгч нь барилгын ажлыг гүйцэтгэхэд ашиглах тоног төхөөрөмж болон ажлын аргачлалыг тодорхой боловсруулж Инженерт танилцуулна.

Инженер ямар ч үед Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийг үзэж шалгах эрхтэй. Гүйцэтгэгч нь Инженерийг байлцуулан тоног төхөөөрөмжийн тохиргоог тогтмол хийж эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд засч залруулна.

Асфальтбетон хольцийг холих, дэвсэх болон нягтруулахад ашиглах бүх тоног төхөөрөмж нь зохих хүчин чадалтай, ашиглалтын үзүүлэлт сайтай байх ёстой бөгөөд тэдгээрийг ашиглаж болохыг Инженер зөвшөөрсөн байна. Хуучирсан буюу элэгдсэн тоног төхөөрөмжийг ажиллуулахгүй.

(б) Асфальт холих төхөөрөмж

Битумэн материалыг AASHTO M156 стандартад тохирох асфальт заводод холих бөгөөд заводыг талбайд байрлуулсан байна. АБЗавод нь халаасан чулуулаг материал хадгалах 3-аас доошгүй сав, эрдэс нунтгийг хадгалах 1 сав, шаардлагатай тооны битумын агуулах, ажлын тогоотой байна. Бүх савнууд нь чийг орохоос хамгаалсан тагтай байна.

Асфальт завод нь давтамжит ажиллагаатай, автомат удирдлагатай, барилгын ажлыг тасралтгүй явуулахад хангалттай хүчин чадалтай, эрчим хүчний найдвартай эх үүсвэрт холбогдсон, хольцны найрлагыг энэхүү шаардлагын 1242-р Зүйлд тодорхойлсон хүлцэх алдааны дотор байлгахаар тохируулга хийх бололцоотой, Инженерээс шаардсан үед асфальтбетоны орц нормын талаарх мэдээллийг хувилан гаргах программтай, шинэ төхөөрөмж байх ёстой. Мөн бэлэн болсон халуун хольцыг хадгалах 100 тн-оос доошгүй багтаамжтай халуун бункерээр тоноглогдсон байна.

Битум хадгалах сав нь битумын ажлын температурыг тогтоосон хэмжээнээс ± 5 градусын хэлбэлзэлтэйгээр байлгах боломжтой, мөн битумын температурыг 170°C-аас дээш гаргахгүйгээр барьж байх термостатаар тоноглогдсон байх бөгөөд термостатыг гадна талаас нь харахад хялбар байхаар суурилуулсан байна. 170°C-аас дээш халсан буюу эсвэл удаан халаасны улмаас шатсан битумыг гаргаж зайлуулах хэрэгтэй.

(в) Асфальт дэвсэх төхөөрөмж

Асфальт дэвсэгч нь бункер, халаагч бүхий доргиурт брусс, дамжуулагч шнекээр тоноглогдсон өөрөө явагч дэвсэгч байна. Асфальт дэвсэгч нь асфальт хольцыг төвшин, хүлцэх алдааны тогтоосон хэмжээнд гадаргууд ямар нэгэн өө, согог, материалын ялгарал ба бөөгнөрөл гаргахгүйээр дэвсэх чадвартай байх ёстой. Дэвсэлтийн явцад гадаргуугийн тэгш байдлыг хангах зориулалтын төхөөрөмжөөр (Averaging Beam) тоноглогдсон, бүрэн автомат ажиллагаатай, 7м-ээс доошгүй өргөнөөр дэвсэх хүчин чадалтай байна. Дэвсэгч нь гадаргуун дагуу налуу болон хөндлөн хэвгийг мэдэрч бруссыг тохируулдаг нарийн хяналтын системээр тоноглогдсон байх ёстой. Хяналтын систем нь бруссыг заасан хөндлөн хэвгийгээр ±1%-ийн нарийвчлалтайгаар ажиллуулах чадвартай байна. Дэвсэгч нь автомат хянах системийн зэрэгцээ гар хяналтын системтэй байх ёстой.

(г) Нягтруулах тоног төхөөрөмж

Гүйцэтгэгч асфальт хольцыг шаардлагын хэмжээнд нягтруулж чадахуйц тооны, зөвшөөрөгдсөн төрөл, жинтэй индүүгээр хангаж өгнө. Индүү нь төмөр, хийн дугуйтай болон доргиурт эсвэл эдгээрийн аль нэг нь хосолсон хэлбэрийн өөрөө явагч төхөөрөмж байх бөгөөд буцаж ухрахдаа дэвссэн хольцийг сэндийлж эвддэггүй байна. Асфальт хольцийг дэвсэх ажлыг эхлүүлэхийн өмнө Гүйцэтгэгч тухайн тоног төхөөрөмж нь ажлын шаардлагыг хангаж чадахыг энэхүү Техникийн шаардлагын 200-р Хэсэгт заасны дагуу талбайн туршилтаар үзүүлж, индүүний ажлын дараалал, явалтын тоо болон ажиллагааны хамгийн тохиромжтой аргачлалыг тодорхойлсон байна.

## 1234 ГАДАРГУУГ БЭЛДЭХ

Битумэн хольцыг дэвсэхийн өмнө гадаргуу дахь бүх сул болон илүүдэл материалыг механик шүүрээр буюу өндөр даралттай хийн цоргиураар эсвэл өөр бусад зөвшөөрөгдсөн аргаар цэвэрлэж зайлуулна.

Гадаргууд илэрсэн аливаа дутагдлыг засаж залруулах ба Инженерээс зөвшөөрөх авах хүртэл битумэн хольцыг дэвсэхгүй.

Хэрэв Инженер өөрөөр заагаагүй бол Гүйцэтгэгч битумэн хольцыг дэвсэхээс өмнө битумэн бус суурийн гадаргуу буюу хуучин гадаргууд Техникийн шаардлагын 1200-р Бүлгийн “Б” Дэд бүлэгт заасны дагуу битумэн цацлага, эсвэл түрхлэг хийж өгнө.

Битумэн цацлага, эсвэл түрхлэг хийсэн гадаргуу нь хольц дэвсэхээс өмнө шингэж хатсан байх шаардлагатай. Харин битумэн түрхлэгийг арчлах хугацааг аль болох бага байлгах үүднээс түүнийг асфальт хольц дэвсэхийн өмнөхөн хийх хэрэгтэй.

Битумэн хольц дэвсэхээс өмнө Гүйцэтгэгч битум цацлага буюу түрхлэг хийсэн гадаргуугийн өө сэвийг засч янзлах бөгөөд хэрэв битумэн хольцтой харьцах замын бусад хийцүүд байвал тэдгээрийн гадаргууд битумэн түрхлэг хийж өгнө. Хуучин хучилт буюу суурийн тэгш бус байдлыг засч янзална. Суурийн үед гарсан нүх, хонхойсон буюу овойсон болон бусад гэмтэлтэй хэсгүүдийг цэвэрхэн ухаж авч, шинэ материалаар дүүргэж янзална.

Хуучин гадаргууд битумэн хольц дэвсэхээс өмнө Гүйцэтгэгч гадаргуугийн хөндлөн болон дагуу заадсуудыг зөвшөөрөгдсөн материалаар чигжинэ. Аль ч тохиолдолд дэвсэх ажиллагаагаа эхлэхээс өмнө Гүйцэтгэгч Инженерээс ажил эхлэх зөвшөөрөл авна.

Хэрэв Гүйцэтгэгчийн ажлын арга барилаас шалтгаалан ажил удааширч, үүний улмаас битумэн хольц дэвсэхээс өмнө урьд хийсэн битумэн цацлага дээр буюу эсвэл хоёр үеийн завсар битумэн түрхлэг хийх шаардлагатай гэж Инженер үзэн зааварчилсан бол уг битумэн түрхлэгийн зардлыг Гүйцэтгэгч хариуцна.

## 1235 АСФАЛЬТАН ХОЛЬЦНЫ ОРЦЫН НОРМЫГ ТОГТООХ

Асфальтбетон нь буталсан чулуу, битум болон эрдэс нунтгийг заасан орцоор хольсон хольцоос бүрдэнэ. Гүйцэтгэгч асфальтбетон хольцны жишиг орцын нормыг тодорхойлж Инженерээр батлуулна. Буталсан чулууг орцын нормын ширхэглэлийн найрлагад тавигдах шаардлагыг хангасан харьцаагаар ангилж холино.

Жишиг орцын норм нь дараах орц хэмжээг тодорхойлно. Үүнд:

(а) шигшүүрийн хэмжээ тус бүрээр өнгөрөх чулууны хувь,

(б) хольцонд хийх битум, эрдэс нунтгийн хувь,

(в) хольцыг холих үеийн температурын дээд ба доод хязгаар,

(г) хольцыг дэвсэх үеийн температурын дээд ба доод хязгаар.

Асфальтбетон хольцыг үйлдвэрлэж эхлэхээс 56-с доошгүй хоногийн өмнө Гүйцэтгэгч жишиг орцын норм болон лабораторийн шинжилгээний дүн, дээж, материал тус бүрийн эх үүсвэр болон барьцалдуулагчийн зунгалаг чанар ба температурын харьцаа зэргийг хавсарган Инженерт албан тоотоор хүргүүлнэ. Инженер орцын нормыг шалгаж батлахад шаардлагатай шинжилгээг нэмж хийхийг Гүйцэтгэгчээс шаардах эрхтэй. Гүйцэтгэгч битумэн хольц үйлдвэрлэхдээ Зөвхөн Инженерээр батлагдсан жишиг орцын нормыг мөрдлөг болгоно. Хэрэв Гүйцэтгэгч жишиг орцын нормд өөрчлөлт оруулах буюу материалын төрөл буюу эх үүсвэрийг өөрчлөх саналтай бол энэ тухайгаа Инженерт урьдчилан мэдэгдэж өөрийн саналаа нарийн тайлбарлан холбогдох баримт мэдээллийг хавсарган Инженерт бичгээр танилцуулна. Инженерийн зөвшөөрөл гарахаас нааш Гүйцэтгэгч дээрх өөрчлөлтийг хийж болохгүй.

Хэрэв Инженер Гүйцэтгэгчийн ирүүлсэн жишиг орцын нормыг хангалтгүй гэж үзвэл Гүйцэтгэгч хольц үйлдвэрлэхээсээ өмнө жишиг орцын нормыг дахин тогтоож холбогдох бичиг баримтын хамт Инженерт танилцуулж батлуулна.

Инженер асфальт заводын дэргэд нөөцөлсөн буталсан чулуун материал болон Асфальт заводаас гарсан хольцыг түр хугацаагаар зөвшөөрөх буюу эс зөвшөөрөх эрхтэй.

Асфальт бетоныг талбайд дэвссэний дараа нягтруулахын өмнө хольцноос дээж авч шинжилгээнд оруулан жишиг орцын нормтой нийцэж байгаа эсэхийг шалгана.

Хэрэв жишиг орцын нормын дагуу хольцонд нэмэлт бодис хийхээр бол нэмэлт бодисын эх үүсвэрийг Инженерээр батлуулна. Нэмэлтийн орц хэмжээг Гүйцэтгэгч тодорхойлж Инженер лабораторийн дүн шинжилгээ болон орцын норм тогтоох лабораторийн журмыг үндэслэн батлана. Мөн нэмэлтийн орц хэмжээг үйлдвэрлэлийн явцад талбайн лабораторид шалгаж баталгаажуулна. Нэмэлтийг хольц үйлдвэрлэх явцад нэмэх буюу бусад зөвшөөрөгдсөн аргаар нэмж холино.

Дээр дурьдсан журмыг жишиг орцын нормыг шинэчлэх бүрт мөрдлөгө болгоно.

## 1236 ТАЛБАЙН ТУРШИЛТУУД

Гүйцэтгэгч төлөвлөсөн машин тоног төхөөрөмжийг ашиглан хучлагын материалыг дэвсэж нягтруулах ба туршилтыг өөрийн төлөвлөсөн аргачлалын дагуу гүйцэтгэнэ. Туршилтыг Инженертэй зөвшилцөж, түүнийг байлцуулан, Инженерийн тодорхойлсон байршилд хийнэ.

Гүйцэтгэгч нь асфальт бетон хучлагын ажилд өөрийн төлөвлөсөн ажлын аргачлал, ажлын дараалал, машин техник, завод, боловсон хүчний үйл ажиллагаа, асфальт бетон хучлагыг шаардлагын хэмжээнд хүртэл дэвсэж нягтруулах болон бусад шаардлагуудыг хангаж буйг үзүүлэх зорилгоор туршилтыг хийнэ.

Туршилтыг 100м-с доошгүй уртад, замын нийт өргөнд, материалын зохих зузаанаар хийнэ. Туршилтын хэсэг Техникийн шаардлага хангаж Инженер баталсан бол байнгын бүтээц хэсэг гэж үзэн хэвээр үлдээх ба харин шаардлага хангаагүй бол хусаж зайлуулна.

Гүйцэтгэгч гэрээний нөхцлийн 14.1-р Дэд зүйлийн дагуу өөрийн ажлын график төлөвлөгөөндөө талбайн туршилтыг хийх болон зохих шинжилгээ хийх хугацааг харгалзан үзэж тооцоолж оруулсан байна. Гүйцэтгэгч нь туршилтыг тухайн хэсгийн хучлагын үндсэн ажил эхлэхээс 14 хоногийн өмнө хийсэн байна.

Гүйцэтгэгч туршилтын хэсэг бүрт үе нэг бүрийг шаардлагын хэмжээнд хүртэл нягтруулж, дараахи мэдээллийг бичиж тэмдэглэнэ. Үүнд:

а) материалын бүрэлдэхүүн ба ширхэглэлийн зэрэглэл, битумын агууламж, битумын төрөл ба марк;
б) асфальт заводын халуун бункер дахь чулууны чийгийн агууламж,
в) Холигчид орохоос өмнөх чулуу ба битумын температур, , холигчоос гарах үеийн, дэвсэж эхлэх үеийн, нягтруулж эхлэх үеийн, нягтруулж дуусах үеийн хольцны температур
Г) Индүүний төрөл тус бүрээр булны өргөн, жин, төрөл, дугуйны тоо, дугуйны ачаалал, дугуйны даралт, доргиулалтын давтамж, явалтын тоо
Д) Төлөвлөсөн сүвшил ба хольцны бусад төлөвлөсөн үзүүлэлтүүд лавораторийн туршилтын дүнгийн хамт
е) Нягт ба сүвшил
Ё) Үеийн хүлцэх алдааг тооцсон бүрэн нягтарсан зузаан
Ж) Инженерийн шаардсан аливаа бусад холбогдох мэдээлэл;

Гүйцэтгэгч нь Инженерийг байлцуулан туршилтын хэсэгт нягтруулалтын төрөл тус бүрт, 100м тутамд 8-с доошгүй цэгт дээж авч шинжилж үзнэ. Хэрэв 8 дээж бүгдээрээ шаардлага хангасан гарвал туршилтын хэсгийг амжилттай хийгдлээ гэж үзнэ. Туршилтын явцад тэмдэглэгдсэн дээрх мэдээлэл нь цаашид нарийвчилсан шаардлагуудыг боловсруулахад ашиглагдах үндсэн материал болж өгнө.

Хэрэв Барилгын ажлын явцад чанарын хяналтын шинжилгээгээр материал нь шаардлага хангаагүй гэдэг нь тогтоогдвол Гүйцэтгэгч ажлыг зогсоож шалтгааныг тогтооно.

Үүнд, материалын шинж чанарын иж бүрэн үзүүлэлтүүдийг тогтоох зорилгоор лабораторын шинжилгээ болон талбайн туршилт хийнэ.

Талбайн туршилтаар тэмдэглэгдсэн өгөгдлүүдийг Инженерээс зөвшөөрөх нь Гүйцэтгэгчийг энэхүү техникийн шаардлагыг хангах аливаа хариуцлагаас нь чөлөөлөхгүй.

## 1237 АСФАЛЬТБЕТОН ХОЛЬЦЫГ ХОЛИХ

Асфальт завод нь AASHTO M156 стандартын дагуу дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

(а) Хамгийн бага хүчин чадал 120 т/цаг

(б) буталсан чулууг энэхүү Техникийн шаардлагад заасан температурт халаах чадвартай цилиндр хэлбэрийн хатаагчтай,

(в) битумыг Инженерээс зөвшөөрөгдсөн саванд зохих температур хүртэл халааж дулааны алдагдлыг хамгийн бага болтол бууруулсан дулаалга бүхий хоолойгоор дамжуулан холигч төхөрөмжид хүргэх,

(г) заводын хуурай холилт 10-аас доошгүй секунд, битумтай холилт 30-аас доошгүй секунд үргэлжлэх,

(д) ердийн нөхөлд битумтай холилтын хугацааг 60 секундээс дээш гаргахгүй байх,

(е) дүүргэгч материалын орцлолт, холилтын хугацаа болон холигчийг суллах үйл ажиллагааг хянах автомат хяналтын системтэй байх естой.

Гүйцэтгэгч битумыг жигд урсах болтол халаах ба хэт халаахаас сэргийлнэ. Халаасан битумын температур 170 °C-аас хэтэрч болохгүй. Битумыг 24 цагаас дээш хугацаагаар халуунаар нь хадгалахаар бол битумын температур 125 °C –аас хэтэрч болохгүй.

Чулуулаг материалын холилтын үеийн температур нь 125-165ºC байхаар халааж хатаана. Чулуулаг материалтай хольж байх үеийн битумын температур 140 °C - 160 °C хооронд байна. Барьцалдуулагч ба чулууны температурын ялгаа хэзээ ч 14ºC-аас хэтрэх ёсгүй.

Гүйцэтгэгч хатаасан чулууг ширхэглэл тус бүрээр тогтоосон орц хэмжээгээр холигчид өгч дараа нь битумыг тогтоосон хэмжээгээр өгнө. Чулуулаг материалыг битумээр жигд бүрэгдтэл нь хольцыг зуурна.

Гүйцэтгэгч нь асфальт дэвсэлтийн ажлыг төлөвлөсөн хугацаанд тасралтгүй явуулахад хүрэлцэх тооны тээврийн хэрэгслээр хангах ба асфальтын ажил явагдах цаг агаарын болон бусад тохиромжтой хугацааны туршид хуваарилагдсан машинуудыг ондоо зориулалтаар ашиглахгүй.

Тээвэрлэх явцад асфальт хольцийг бохирдох, ширхэглэлийн ялгаралт гарахаас сэргийлэх ёстой. Ачаа бүрийг сайтар бэхэлсэн зотон даавуун буюу ижил төстэй бүтээлгээр бүтээж тээвэрлэх ба бүтээлэг нь тэвшний тал бүр лүү давж унжиж байхаар хэмжээтэй байна. Бүтээлгийг тээвэрлэлтийн явцад дэрвэж хийсэх, салж унахааргүйгээр сайтар бэхэлсэн байх ёстой. Хэрэв бүтээлэг урагдсан, цоорсон байвал нэн даруй солих шаардлагатай. Бүтээлэг нь хольцыг цаг агаарын нөлөөллөөс хамгаалж, тээвэрлэх үед болон хольцыг дэвсэгч рүү буулгаж байх үед тоос, шороо, хог орохоос сэргийлэх зориулалтай байна. Зохих ёсоор бүтээгээгүй хольцыг хэрэглэж болохгүй. Мөн асфальт хольц тээвэрлэх машинуудын тэвшний ёроол цэвэрхэн, гөлгөр байхаас гадна газрын тос, уусгагч болон хольцод муугаар нөлөөлөх бусад материалаар бохирдоогүй байна. Хольцыг тэвшний ёроолд наалдахаас сэргийлэх үүднээс Инженерийн баталсан тусгай бодис түрхэж болно.

Гүйцэтгэгч жишиг орцын нормд нийцсэн халуун хольц нийлүүлэх хариуцлага хүлээнэ.

### 1238 ХОЛЬЦЫГ ДЭВСЭХ

Гадаргууг бэлдэж дуусан зөвшөөрөл авмагц хольцыг тогтоосон чиг, төвшинд материалын ялгарал, бөөгнөрөл гаргалгүйгээр дэвсэгч тоног төхөөрөмжөөр дэвсэнэ. Хучлага тавих чиг, хольцны дэвсэлтийн төвшинг зориулалтын дуран ашиглан замын тэнхлэгээс 2 тийш хэмжиж тавина. Харин дэвсэлтийн төвшинг тааруулан тавьж, утас татахдаа энгийн шугам г.м гар багаж буюу нарийвчлал багатай багаж ашиглахыг хориглоно.

Инженер өөрөөр зааварчлаагүй бол хольцийг явах ангийн өргөнөөр дэвсэнэ. Асфальт бетоны нягтрсан үеийн зузаан нь Техникийн шаардлагын 300- Бүлэгт заасан шаардлагыг хангасан байна. Гэхдээ хучлагын нягтарсан зузаан нь чулуулгийн хамгийн том хэмжээнээс наад зах нь 2,5 дахин их байна. Хучлагын хамгийн бага зузаан нь 50мм байна.

Өөрөө явагч асфальт дэвсэгчээр хольцыг дэвсэнэ. Дэвсэгч нь асфальт хольцыг Зурагт заасан буюу Инженерийн зааварчилсан зузаан, төвшин, налуутайгаар дэвсэнэ. Дэвсэлтийн ажил эхлэхээс өмнө дэвсэгчийн бруссыг халааж, бункер болон хольц дамжуулах хусуурыг цэвэрлэсэн, доргиулагчийн ажиллагааг шалгаж бэлтгэсэн байна. Брусс нь зохих хэмжээнд халаагүй, мөн доргиулагч нь ажиллахгүй байгаа дэвсэгчийг ашиглахыг хоиглоно.

Хольцыг жигд хурдаар явж, тасралтгүй дэвсэнэ. Хэрэв дэвсэлтийн явцад аль нэг хэсэгт зузаан, налуу алдагдах, нүх хонхор үүсэх, дэвссэн гадаргуу арзгар болох, брусс сайн халаагүйгээс мөр үүсэх зэрэг дутагдал гарвал дэвсэлтийг нэн даруй зогсоож, гарсан алдааг Инженерийн шаардлагад нийцэхээр бүрэн засварлана. Инженер зөвшөөрсөний дараа дэвсэлтийг үргэлжлүүлнэ. Гүйцэтгэгч асфальтбетоны ажлыг бүхэлд нь хариуцсан чадварлаг мэргэжилтэнг томилон ажиллуулах бөгөөд тэр нь дэвсэлт, нягтруулалтын болон заводын үйл ажиллагааг хооронд нь нягт уялдуулан зохион байгуулах ёстой. Дэвсэлтийг хийхдээ дэвсэгчийг ойр ойрхон зогсоохгүйгээр жигд явуулах ба хучлагын хөндлөн залгаасыг аль болох цөөн гаргахаар ажлыг зохион байгуулах хэрэгтэй.

Хэрэв дэвсэгчийн автомат хянах систем эвдрэх эсвэл буруу ажиллах тохиолдолд ажлын эрдийн өдрийн үлдсэн хугацаанд гараар удирдаж ажиллуулж болно.

Хэрэв Гүйцэтгэч гадаргуун тэгш байдал болон налууг шаардлагын хэмжээнд хүртэл гаргаж чадаагүй бол Инженерийн зөвшөөрөх хэмжээнд хүртэл гадаргууг дахин засварлаж, тоног төхөөрөмжийг засварлах буюу өөр тоног төхөөрөмжөөр солих арга хэмжээ автал хучлагын ажлыг түр зогсооно.

Хольцыг дэвсэх явцад чанарын шаардлага хангаагүй (шатсан, битум ихэдсэн, дутуу холигдсон, бага температуртай г.м) хольц ирвэл дэвсэгчид хүлээн авахгүйгээр талбайгаас шууд зайлуулж хаяна.

Дэвсэгчийг ашиглах боломжгүй жижиг талбайд хольцыг гараар дэвсэхийг зөвшөөнө. Гэхдээ гараар хийсэн дэвсэлтийн чанарыг Гүйцэтгэгч бүрэн хариуцах ба хэрэв ямар нэгэн ажил шаардлагад нийцэхгүй бол түүнийг зайлуулж, оронд нь шинээр хийхийг Инженер зааварчилж болно. Дахин хийсэн ажлын зардлыг Гүйцэтгэгч хариуцна.

Өгсүүр хэсэгт дэвсэлт хийх үед хучлагын доогуур ус орохоос хамгаалсан арга хэмжээ авна.

### 1239 ХОЛЬЦЫГ НЯГТРУУЛАХ

Асфальт хольцыг дэвссэний дараа нэн даруй сайтар жигд индүүдэж нягтруулна.

Хольцыг индүүдэж эхлэх үеийн хольцны хамгийн доод температур 125°C, нягтруулж дуусах үеийн хольцны хамгийн доод температур 90-110°C байна.

Хольцыг индүүдэхэд түрэгдэх буюу нүүхээр хэт зөөлөн биш, эсвэл шаардлагатай нягт авахгүй болтлоо хэт хатуурч царцаагүй тийм үед Гүйцэтгэгч нягтруулалтыг хийнэ.

Индүүний төрөл, жин, тоо ширхэг нь хольцыг тохиромжтой температуртай үед нь нягтруулахад шаардлагатай нягт авахад бүрэн хангалттай байх ёстой. Ашиглах тоног төхөөрөмж болон нягтруулах ажилбарын дараалал болон явалтын тоог Гүйцэтгэгч талбайн туршилтаар баталж үзүүлэн, Инженерээр зөвшөөрүүлсэн байх ёстой.

Дор дурьдсан ерөнхий зарчимд заасанчлан үеийг шаардлагатай нягт авах хүртэл индүүднэ.

Нягтруулах ажил эхлэхээс өмнө ажиллах индүүнүүдийн түлшний системийг сайтар шалгаж, хэрэв түлш дусах юмуу гоожиж байвал засаж янзалсан байна. Мөн булны услалтын системийг шалгаж тохируулсан байх хэрэгтэй.

Эхний нягтруулалтыг 6-8тн жинтэй, ган бултай доргиурт индүүгээр дэвсэгч машины араас аль болох ойр зайд дагаж хийнэ. Дэвсэлтийн чиглэлд эхлээд хийх явалт бүрт доргиулагчийг ажиллуулахгүй, харин буцах явалт бүрийг доргиулагчтай хийнэ.

Дараагийн шатанд 12-16тн жинтэй хийн дугуйт индүүгээр нягтруулалтыг хийж сүүлчийн нягтруулалтыг хүнд жинтэй 3 булт индүүгээр индүүдэж түрүүчийн индүүний мөрийг дарна. Бүх индүү нь араараа ухарч ажиллах бөгөөд (өөрөөр хэлбэл индүүний хөтлөгч дугуй буюу бул нь дэвсэгчийн талд байрлалтай байна) цагт 5 км-ээс илүүгүй жигд хурдаар ажиллана.

Нягтруулалтыг хучлагын гадаад ирмэгээс эхэлж тэнхлэгийн шугам руу чиглэсэн байдлаар, индүүний явалт бүр урьд явсан мөрний хагасыг дарах маягаар хийнэ. Эргэцтэй хэсэгт хэвгийн нам талаас өндөр тал руу чиглэсэн байдлаар гүйцэтгэнэ. Индүүний хөдөлгөөний чиглэл нь замын тэнхлэгтэй аль болох паралель байхаар нягтруулалтыг хийх ба ялангуяа нэг, хоёрдугаар индүүдлэгийн үед огцом эргэж хажуу тийш шилжих, ташуу байдлаар явахыг хоиглоно.

Хучлагын захыг индүүдэх явцад индүүний дугуй дэвсэлтийн ирмэгээс 50-100 мм илүү гарч байх ёстой.

Нягтралаа бүрэн аваагүй хучлага дээр индүү болон бусад техник зогсоож болохгүй, хэрэв ажлын явцад индүү эвдрэх буюу өөр шалтгаанаар зогсох бол түүнийг нягтарсан хэсэгт эсвэл талбайн гадна яаралтай гаргах арга хэмжээ авна. Нягтруулалт хийж буй индүүнүүд түр зогсохоор бол урьд нь нягтарсан хэсэгт шилжиж зогсоно.

Асфальт бетон үеийн нягтыг Төслийн Чанарын хяналтын төлөвлөгөөнд заасан давтамжаар, үеийн нийт зузаанаар авсан хос дээжийн дундаж нягтаас тооцон гаргана. Ингэхдээ асфальт бетоны ажил хийгдсэн өдөр тутамд 1-ээс доошгүй хос дээж авна.

Асфальт бетон үеийн нягт нь заасан нягттай ижил буюу түүнээс их байх ба дараалсан 10 туршилтаас 1-с илүүгүй тохиолдолд нягт нь заасан нягтаас 2-оос дээш хувиар доогуур байж болно.

Нягтруулсан үеийн хамгийн бага, шаардагдах нягтрал нь батлагдсан орцын нормын дагуу нягтруулсан Маршаллын загварын нягтралын 98%-тай тэнцэх ёстой. Нягтралын хэмжээ нь тогтоосон стандартад хэмжээнд хүрээгүй гадаргууг дахин нягтруулж нягтралыг нь дараачийн өрөмдлөгөөр тодорхойлно.

Нягтруулсан үеийн дундаж нягт нь хамгийн бага шаардагдах нягтаас 1%-иар бага байгаа гадаргуугын хучлагыг Гүйцэтгэгч хуулж шаардлага хангасан асфальт бетон дахин дэвсэж нягтруулна.

Асфальтбетон хучлагын аль ч хэсэг дээр машин тоног төхөөрөмжийг түлшээр цэнэглэхийг хориглоно. Индүүдэлтийн бүх нөхцөлд огцом эргэж болохгүй.

Хольц наалдахаас сэргийлж индүүний дугуй болон булыг усаар бага зэрэг норгож өгнө. Харин усанд элдэв химийн бодис холих, усны оронд дизелийн түлш хэрэглэхийг хориглоно.

Индүү ажиллах боломжгүй хэт бага талбайд доргилтот нягтруулагч ашиглаж болно.

### 1240 ӨНГӨЛГӨӨ, ИРМЭГ БА ЗААДАС

Аливаа хольц хагарах, хог шороотой холилдож суларч гарах тохиолдолд түүнийг ухан авч шинэ халуун хольцоор дүүргэн эргэн тойрны гадаргуутай ижил хэмжээнд нягтруулна.

Өмнө нь хийгдсэн хучлагатай залгаж дараагийн хэсгийг дэвсэхдээ урьд дэвссэн үеийг нийт өргөн ба гүнд нь шулуун шугамаар зүсэгч машин ашиглан хөндлөн зүснэ. Гар багаж (лоом, сүх г.м) ашиглаж болохгүй. Зүсэлт хийсэн босоо нүүрийг хийн халаагуураар халааж 130/200 маркийн халуун битум түрхэх ба үүний дараа нэн даруй шинэ хольцоо залгаж дэвсэнэ. Дэвсэлтийг эхлэхдээ дэвсэгчийн өнгөлөх хавтан нь зүсэлтийн шугамнаас хойш 20-30см илүү гарсан байхаар дэвсэгчийг байрлуулна.

Дэвсэгчийг явуулж эхлэхээс өмнө шнекээр татагдаж ирсэн халуун хольцыг залгаасны хэсгийн хуучин хучлага дээр 5-10минут орчим байлгаад үүний дараа дэвсэгчийг ажиллуулна. Залгаасны хэсэгт дэвсэгч явж өнгөрмөгц овон товон дэвсэгдсэн хольцыг малтуураар жигд хусч аваад залгаасан дээрээ нарийн ширхэглэлтэй хольц цацаж гараа маш нямбай тэгшлэнэ. Тэгшилгээ сайн болсон гэж үзвэл индүүдлэгийг шууд эхлэнэ.

Залгаасны өнгөлгөөг гадаргууд тавигдах шаардлагын дагуу хучлагын бусад хэсэг дэх нягтрал, бүтэц, өнгөлгөө зэрэгтэй ижил байхаар хийж гүйцэтгэнэ.

Хэрэв дэвсэлтийн явцад гадаргууд чулууны ялгарал үүсч барзгар болсон бол халуун хольцноос авч нарийн нүхтэй шүүрээр тухайн хэсэг дээр шигшээд дараа нь модон малтуураар хөнгөн гүйлгэж сайтар тэгшлээд индүүднэ.

### 1241 АСФАЛЬТАН ХОЛЬЦООС ДЭЭЖ АВАХ БА ШИНЖЛЭХ

Гүйцэтгэгч AASHTO T168 стандартын дагуу дээж авна.

### 1242 ЧАНАРЫН ХЯНАЛТЫН ШИНЖИЛГЭЭНҮҮД

Асфальтбетоныг холих ба дэвсэх үед Гүйцтгэгч түүний Төслийн чанарыг хянах төлөвлөгөө болон Техникийн шаардлагын Хэсэг 200, Зүйл 1239-ын дагуу хольц болон түүний бүрэлдэхүүн материалуудаас дээж авч шинжилж байх ёстой.

Хэрвээ шинжилгээний үр дүн материалын Шаардлагыг хангахгүй байгаа тохиолдолд Гүйцэтгэгч материал болон ажлын журамд оруулах шаардлагатай өөрчлөлтийг хийхээс өмнө Инженерийн зөвшөөрлийг авсан байх ёстой.

Хэрвээ хольц болон материалын 10 амжилттай шинжилгээ тутамд нэгээс дээш тооны шинжилгээний хариу нь Шаардлагыг хангахгүй байгаа тохиолдолд Гүйцэтгэгч шалтгааныг нь олж тогтоож залруултал хольц дэвсэхийг даруй зогсооно. Гүйцэтгэгч шаардлага хангахгүй байгаа бүх материалыг өөрийн зардлаар буцаан авч шаардлага хангах материалаар солино.

### 1243 ХҮЛЦЭХ АЛДАА

Гүйцэтгэгч хучлагыг Техникийн шаардлагын 300-р Бүлэгт заасан геометр хүлцэх алдааны хүрээнд барина.

Гүйцэтгэгч хольцын найрлагыг жишиг орцын норм болон талбайн туршилтуудаар тодорхойлсоны дагуу Хүснэгт 12-6-д үзүүлсэн хүлцэх алдааны хүрээнд байлгана.

**Хүснэгт 12-6: Асфальтбетон хольцны хүлцэх алдаа**

| Бүрэлдэхүүн хэсэг | Хүлцэх алдаа |
|---|---|
| Битумын агуулга | Хольцны нийт жингийн ± 0.3% |
| 4.75 мм ба түүнээс том шигшүүрээр өнгөрөх хувь | Эрдэс нунтгийг оролцуулан хуурай чулуулаг материалын нийт жингийн ± 6% |
| 2.36 - 0.15 мм-ийн шигшүүрээр өнгөрөх хувь | Эрдэс нунтгийг оролцуулан хуурай чулуулаг материалын нийт жингийн ± 4% |
| 0,075 мм-ийн шигшүүрээр өнгөрөх хувь | Эрдэс нунтгийг оролцуулан хуурай чулуулаг материалын нийт жингийн ± 2% |
| Хольцны температур | ± 10 °C |

Нэг удаагийн шинжилгээгээр гарсан битумын агууламжийг хольцийн нийт жингээр үржүүлж тооцсон, аливаа үеийн нийт уртад орох битумын дундаж хэмжээ нь заасан хэмжээнээс багагүй байх ёстой.

Хольцийн жинг шалгаж тодорхойлсон өдөр тутам үйлдвэрлэсэн хольцны битумын дундаж хэмжээ нь заасан хэмжээнээс багагүй байх ёстой.

100 м урт хэсэгт хоорондоо ижил зайтай 6 цэгт хэмжсэн асфльтбетон хучлагын гадаргуугийн өргөн заасан өргөнөөс бага байж болохгүй. Аль ч цэгт замын тэнхлэгээс хучлагын гадаргуугийн ирмэг хүртэл зай заасан зайнаас 10мм-ээс илүү нарийссан байж болохгүй.

## 1244 ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР – ДЭД БҮЛЭГ “Г”

(а) Ажлын нэр : асфальт бетон хучлага

Хэмжих нэгж : $м^3$

Асфальт бетон хучлагыг нягтруулсан үеийн шоо метр байна. Асфальт бетон хучлагын ажлын эзэлхүүнийг Зурагт заасан буюу Инженерийн зааварчилсаны дагуу нягтруулсан үеийн хөндлөн огтлолын талбайг замын тэнхлэгийн дагуу Инженерийн зааварчилсаны дагуу хэмжсэн уртаар үржүүлж гаргана.

Асфальт бетон хучлагын ажлын нэгж үнэлгээнд дараах ажлууд багтана. Үүнд:

- барьцалдуулагч болон буталсан чулууг бэлдэх, халаах, холих,
- эрдэс нунтаг бэлдэх, холих,
- шаардлагатай бол нэмэлт бодис бэлдэх, холих,
- чулуу болон эрдэс нунтагийн хэмжээг өөрчлөх,
- нэмэлт бодисын хэмжээг өөрчлөх,
- гадаргууг бэлдэх,
- эгц налуу газар ажиллах,
- тээвэрлэх,
- халаасан хольцыг нягтруулсан үеийн зузааныг хангахаар дэвсэх,
- индүүдэх,
- гадаргууг шаардагдах хэмжээнд хүртэл засах,
- энэхүү Техникийн шаардлагын 1200-р Бүлгийн “А”, “Г” Дэд Бүлгийн

шаардлагад нийцүүлэх.

Асфальт бетон хучлагын ажлын нэгж үнэлгээнд мөн дараах ажлууд багтана. Үүнд:

- Чулуу бутлах ба шигших тоног төхөөрөмжийг суурилуулах, ажиллуулах,
- нөөц газрыг ашиглах,
- газрын зөвшөөрөл авах, холбогдох татвар төлбөрийг хийх,
- ажил дуусаны дараа нөхөн сэргээлт хийх,
- энэхүү Техникийн шаардлагын 100, 200, 300 ба 600-р Бүлгүүдийн шаардлагад нийцүүлэх,

б) Ажлын нэр : Барьцалдуулагчийн орцыг өөрчлөх

Хэмжих нэгж: л

Асфальт бетон хольцонд орох барьцалдуулагчийн хэмжээг Техникийн шаардлагын 1231-р Зүйлд заасны дагуу тодорхойлно. Ажлын үнэлгээг тогтоох зорилгоор Гүйцэтгэгч асфальт бетон хольцны нэгж үнэлгээнд барьцалдуулагчийн тооцоот агууламжийг 5.5%-иар тооцож оруулсан гэж үзнэ.

Барьцалдуулагчийн орцыг өөрчлөх ажлыг литрээр хэмжинэ. Барьцалдуулагчийн орцыг өөрчлөх ажлыг дараах аргаар тооцно. Үүнд:

(i) 5.5%-ийн барьцалдуулагчийн тооцоот агууламж ба жишиг орцын нормын барьцалдуулагчийн агууламж хоёрын зөрүүг гаргах,

(ii) Техникийн шаардлагын 1243-н (а) Дэд Зүйлд заасны дагуу Асфальт бетоны эзэлхүүнийг бодож олох,

(iii) дээр дурьдсан (ii) болон 1231-р Зүйлд заасан хамгийн бага нягтыг ашиглан асфальт бетоны хувийн жинг тооцох,

(iv) дээр дурьдсан (i) ба (iii) дүнг үржүүлж барьцалдуулагчийн өөрчлөлтийн хувийн жинг тодорхойлох,

(v) үйлдвэрлэгчийн гэрчилгээнд заасан нягтыг ашиглан барьцалдуулагчийн хувийн жинг (iv) литрт шилжүүлэх,

(vi) литрт өгөгдсөн энэ эзэлхүүнийг Нефтийн бүтээгдхүүний Хэмжилтийн Жишиг Хүснэгт (ASTM D 1250)-ийг ашиглан 15.6 °C-д засах.

Гүйцэтгэгчид хийх төлбөрийг дараах аргуудын алийг нь ч хэрэглэн тохируулж болно. Үүнд:

- жишиг орцын нормын барьцалдуулагчийн агууламж 5.5%-ийн тооцоот агууламжаас их бол Гүйцэтгэгчид төлбөр хийх,
- жишиг орцын нормын барьцалдуулагчийн агууламж 5.5%-ийн тооцоот агууламжаас бага бол Захиалагчид нөхөн төлбөр хийх.

## 1245 ЧУЛУУН ХУЧЛАГА

## 1246 БҮЛГИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

Энэ бүлэгт уулын хатуу оргимол хатуу чулуулгаас зүсэж бэлтгэсэн болон зассан чулуугаар хотын гудамж, зам, талбайн хучлага барих ажлыг тусгав.

## 1247 ТОДОРХОЙЛОЛТ

Урьдчилан бэлтгэсэн, геометрийн зөв хэлбэр дүрстэй, зассан чулуу, байгалийн зөв хэлбэртэй чулуу, төрөл бүрийн хавтан (өнгөт, хээтэй, хээгүй г.м.), блок зэргийг зориулалтын суурь ба тэгшилгээний дэвсгэр үеэн дээр хооронд нь нягт шахаж суулгах аргаар барьсан хучлагыг өрмөл хучлага гэнэ.

## 1248 ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Замын гадаргууд дэвсэж, суурийн үеүдийг хучихад зориулсан экологийн хамгийн цэвэр, бат бэх бөгөөд урт эдэлгээтэй материал бол байгаль дээр орших төрөл бүрийн цэвэр чулуу юм. Учир нь тэдгээр нь температурын эрс өөрчлөлтөөс ямар ч эвдрэлд ордоггүйн дээр дотор нь ус орж бүтцийг эвдэж болох ан цавгүй байдаг.

Байгалийн чулуунаас бүтээгдэхүүн үйлдвэрлэх орчин үеийн технологи нь төрлийн бүрийн хэлбэр, загвартай бөгөөд зүсмэл, хагалмал, хагас боловсруулсан болон зүлгэж өнгөлсөн гадаргуутай г.м олон янзын чулууг бэлтгэх бололцоог олгож байна.

Минералын шинж чанар ба экологийн аюулгүй байдлаараа байгалийн чулуу нь цэцэрлэгт хүрээлэнгийн доторх зам, авто зам, гүүр, явган хүний зам ба зогсоолын талбай зэргийг өнгөлж хучихад өргөн хэрэглэгдэнэ.

Өрмөл чулуун хучлага нь замын бусад бүх төрлийн хучлагаас чанар ба өртгийн хувьд хамаагүй илүү бөгөөд удаан эдэлгээтэй байдаг.

Нөгөө талаас чулууг зөв өрж, дэвссэн (энэ бол дэвсмэл чулуун хучлага барих ажлын хамгийн чухал нөхцөл буюу Т.Ш юм) нөхцөлд суулгасан чулууг солих шаардлага огт гардаггүй онцлогтой.

Зөв аргачлалын дагуу, сайн хийгдсэн өрмөл чулуун хучлага нь тэр болгон онцгой арчлалт шаардаад байдаггүйн дээр олон арван жилийн туршид өнгө хэлбэрээ алдалгүй, өө сэвгүй байдлаа хадгалсаар байдаг.

Харин ашиглалтын явцад хучлага аль нэг хэсэгтээ ямар нэгэн хэв гажилтад орж, суулт үүссэн тохиолдолд цөөн тооны чулууг сугалан авч, эвдрэлийг засаад дахин өрж дэвсэх замаар байнга нөхөн сэргээх боломжтой.

## 1249 МАТЕРИАЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

а) Байгалийн чулуун материалын бүлэг

Зам барилгад ашиглах байгалийн гаралтай бүх чулуун материалыг дараах 2 бүлэгт хуваана. Үүнд:

1. Байгаль дээр байгаа хэвээр нь (боловсруулалтгүй) ашигладаг материал.
2. Зөвхөн зохих боловсруулалтыг хийсний дараа л барилгын ажилд тохиромжтой болдог материал.

б) Чулууны хэлбэр дүрс

Зүсэж бэлтгэсэн чулуу нь ихэнхдээ түүний тэнхлэгт перпиндикуляраар орших дээд ба доод зөв тэгш өнцөгт суурьтай огтолсон пирамид, мөн шоо дөрвөлжин хэлбэртэй байна.

в) Чулууны төрөл

Хучлагаанд хэрэглэх зүсэж бэлтгэсэн буюу зассан огтолсон пирамид хэлбэртэй чулуу нь хэмжээсээсээ хамааран доорх 3 төрөл байна. Үүнд:

- Өндөр чулуу-ӨЧ
- Дунд зэргийн өндөртэй-ДЧ
- Намхан чулуу-НЧ

г) Чулууны үндсэн хэмжээс

Хучлагад хэрэглэх чулууны үндсэн хэмжээс нь Хүснэгт 16-14-д үзүүлсэнтэй тохирч байх ёстой.

**Хүснэгт 12-7. Зүсэж бэлтгэсэн (зассан) чулууны хэмжээ (мм)**

| Чулууны төрөл | Дээд ирмэгийн урт | Дээд ирмэгийн өргөн | Өндөр |
|---|---|---|---|
| ӨЧ | 250 | 125 | 160 |
| ДЧ | 250 | 125 | 130 |
| НЧ | 200 | 100 | 100 |
| Шоо хэлбэртэй | 70-110 | 70-110 | 70-110 |

Огтолсон пирамид хэлбэртэй чулууны доод суурийн ирмэгийн проекц дээд суурийн хүрээн дотор бүтэн багтаж байх ёстой.

Нөгөө талаас доод ирмэгийн урт ба өргөн нь дээд ирмэгийнхээс НЧ-д аль ч талдаа 3-5мм-ээр, ӨЧ ба ДЧ-д 7-10мм-ээр бага байна.

Түүнээс гадна чулуунуудыг бие биенд нь шахаж нягт суулгахад саад болохуйц овон товон хажуугийн гадаргууд байх ёсгүй.

Харин чулууны дээд тал нь машины дугуй ба өнгө хучлагын хоорондын барьцалдалгааг хангах зорилгоор 2-3мм гүн ба өндөртэй хотгор, гүдгэр бүхий арзгар гадаргуутай байна.

д) Хүлцэх алдаа

Чулууны хэмжээс ба гаднах байдал нь Хүснэгт 12.8-д үзүүлсэн хүлцэх алдааны дотор байна.

**Хүснэгт 12.8 Чулууны хэмжээс ба гадна байдлын хүлцэх алдаа.**

| Чулууны хэмжээс ба гадна байдал тогтоосон | Хүлцэх алдаа |
|---|---|
| Огтолсон пирамад хэлбэртэй бүх төрлийн чулууны урт, | ± 15 |
| Огтолсон пирамад хэлбэртэй бүх төрлийн чулууны | ± 10 |
| Шоо дөрвөлжин чулууны бүх талууд, мм | ± 10 |
| Дээд суурийн ирмэг эмтэрсэн ба мөлийсөн | Зөвшөөрөхгүй |
| Доод суурийн ирмэг эмтэрсэн ба мөлийсөн | Зөвшөөрөхгүй |
| Босоо ирмэгийн эмтэрсэн өнцгийн урт, мм | Зөвшөөрөхгүй |
| Дээд талын зэргэлдээ (хамарлаж) орших | <4 |
| Дээд талын гадаргын тэгш бус байдал, мм, | <10 |

е) Чулууны физик-механик шинж чанар

Хучлагад хэрэглэх чулууны физик-механик шинж чанар нь Хүснэгт 12-9-д үзүүлсэн шаардлагыг хангаж байх ёстой.

**Хүснэгт 12-9. Чулууны физик-механик шинж чанар**

| Үзүүлэлтүүд | Хангах шаардлага |
|---|---|
| Шахалтын бат бэх кгс/см$^2$ | >1000 |
| Хүйтэнд тэсвэрлэлт (жингийн алдагдлаар) ХТ | > 100 |
| Усанд ханасан үе дэх шахалтын бат бэхийн бууралт % | <20 |
| Элэгдэл г/см$^2$ | <0.5 |

ё) Чулууг хүлээн авах

Замын хучлагад хэрэглэх чулууг багцаар хангах ба хүлээн авна. Нийтдээ 200м$^2$ талбай бүхий чулууг нэг багц гэж үзнэ. Чулууны хэлбэр ба хэмжээсийг шалгахын тулд буулгасан буюу хураасан 10 хэсэг байрлал тус бүрээс 5ш буюу бүгд 50ш-ийг нэг багцаас түүвэрлэж авна. Шалгалтын үр дүн хангалтгүй гарвал тухайн багцаас дээр дурдсан дээжийн хэмжээг 2 дахин өсгөн авч, дахин шалгана. Хэрэв давтан шалгалтаар нэг л чулууны үзүүлэлт тохирохгүй гарвал энэ багцын бүх чулууг ширхэгчлэн шалгана.

Чулууны физик-механик шинж чанарыг жилд нэгээс доошгүй удаа шалгах ба харин чулууны төрөл өөрчлөгдвөл түүнийг хэрэглэхийн өмнө эдгээр үзүүлэлтийг шалгана.

Ажлын явцад хяналтын байгууллагаас гэнэтийн шалгалт хийж болно.

ж) Шалгалт ба туршилтын аргууд

Замын хучлагад хэрэглэх чулууны хэмжээс болон гаднах байдлыг шалгахдаа дараах аргаар гүйцэтгэнэ. Үүнд:

- Тусгай зориулалтын шаблон, шулуун ба гурвалжин шугам ашиглан урт, өргөн, өндрийг хэмжих замаар чулууны хэмжээсийг тодорхойлно.

- Чулууны хажуу гадаргуун налуу (дээд ирмэгийн проекцийн доод ирмэгээс зөрсөн хэмжээ)-г шулуун ба гурвалжин шугам ашиглан тодорхойлно.

- Чулууны дээд гадаргуун өнгөлгөөг зөв хийсэн эсэх, мөн түүний чанар, ирмэгүүдийн тэгш байдал, өнцгүүдийн хэмжээг хэвтээ (банзан) шаблон болон хэмжилтийн төмөр багажаар тодорхойлно.

- Чулууг (засах) зүсэж бэлтгэхэд хэрэглэх уулын чулуулгийн физик-механик шинж чанарыг уг чулуулгийг бэлтгэн нийлүүлэгч эсвэл үйлдвэрлэгчээс олгосон паспорт, мөн геологийн тайлангаар тодорхойлно.

- Уулын чулуулгийн шахалтын бат бэх, хүйтэнд тэсвэрлэлт, шахалтын бат бэхийн бууралт ба элэгдлийг энэхүү ТШ-ын бүлэг 400-ийн холбогдох зүйл ба стандартыг баримтлан тодорхойлно.

- Гадаргуугийн үрэлийн итгэлцүүрийг AASHTO T 242-96 (2009), ASTM E 247-97, AASHTO T 278-90 (2007), ASTM E 303-93 (2003)-ын дагуу тодорхойлно.

з) Чулууг тээвэрлэх ба хадгалах

Үйлдвэрлэгч нь доорх мэдээллийг агуулсан дагалдах баримт бичгийг ТИ-ийн зөвшөөрсөн маягтын дагуу бүрдүүлж, нийлүүлж буй чулууны багц бүрт хавсарган өгч байна. Үүнд:

- Байгууллагын нэр, хаяг
- Паспортыг бэлтгэсэн өдөр, дугаар
- Хучлагын чулууг үйлдвэрлэхэд хэрэглэсэн уулын чулуулгийн төрөл
- Чулууны төрөл (ӨЧ, ДЧ, НЧ),
- Хэмжээс
- Багц дахь чулууны тоо (ш)
- Ачуулсан өдөр

Замын хучлагад хэрэглэх засч бэлтгэсэн чулууг тусгай чингэлэгээр юмуу задгай байдлаар нь ямар ч төрлийн тээврийн хэрэгслээр тээвэрлэж болно.

Чулууг ачих ба задгайгаар нь буулгах үедээ аюулгүй ажиллагааг сайтар хангах шаардлагатай.

Чулууг төрөл тус бүрээр нь, хэвтээ байдлаар эгнүүлэн хураана.

**1250 ЧУЛУУН ХУЧЛАГЫГ БАРИХ**

а) Бэлтгэл ажил

Хучлагын чулууг өрж суулгахын өмнө хийх бэлтгэл ажил нь шинээр хийх зам, талбайн захыг гадаслахаас эхлэнэ. Гадаслагааг хийхдээ тухайн газрын өнцөг, налуу зэргийг сайтар харгалзаж үзэх шаардлагатай. Үүний дараа даацын үе, шүүрүүлэх үе зэргийг багтаасан суурийг бэлтгэнэ.

Зам, талбайн захын цэгүүдийг гадаслаж, өндөржилтийг тавьсаны дараа өнгөн хөрсийг хуулна. Түүнийг зохих хэмжээнд тэгшилж нягтруулах ажлыг энэхүү ТШ-ын бүлэг 300-ын дагуу гүйцэтгэнэ.

Дараа нь хайрга ба буталсан чулуугаар суурийг энэхүү ТШ-ын бүлэг 1200 ба 1400-ын дагуу хийнэ.

Чулуунуудыг бие биед нь сайн тулгаж суулгадагаас хоорондох заадас нь хэдийгээр шигүү байдаг боловч гадаргуугаас урссан ус тэдгээрээр дамжин суурьт нэвчиж, энэ нь өрж суулгасан хучлагын бүтцийг эвдэхэд хүргэдэг. Ийм учраас сууринд ус үл нэвтрэх, шүүрүүлэх даацын үе шаардлагатай байдаг юм. Ийм нөхцөлд гадаргуугийн ус нь өрмөл чулуу ба даацын үеэр дамжин шууд гадагш зайлуулагдана.

Шүүрүүлэх үеийг хийхэд ширхэглэлийн бүрэлдэхүүний хувьд нэг ижил төрлийн бөгөөд хүйтэнд тэсвэртэй материалыг ашиглах ба түүнийг жигд зузаантайгаар, усыг зайлуулахад тохиромжтой налууг гарган дэвсэнэ. Энэ нь хучлагын өрмөл чулууны дор ус хуримтлуулахгүй байх зориулалттай юм.

Явган хүний ердийн замыг хучихад 15-20см, нарийн гудамж, орц, гарц, зогсоолын талбай зэрэгт 20-30см үеийг тус тус хэрэглэнэ. Харин их хэмжээний ачаалалд хийсэн тооцоогоор гарсан даацын үеийг хэд хэдэн үеэр дэвсэж нягтруулна.

Дэвсгэр үеийг хийхийн өмнө чиглүүлэгч модон шугам буюу рейкийг бүх налууд тохируулан байрлуулж, элсээр манаж тогтооно. Үүний дараа нягтруулсан даацын үе буюу суурь дээр тэгшилгээний дэвсгэр үеийг цэвэр элсээр 3-5см зузаантай

дэвсэж хийнэ.

Хучлагын чулууг нягтруулахаас өмнө зураг төслийн түвшингээс 1см дээр байхаар суулгана. Дараа нь чиглүүлэгчийг болгоомжтойгоор сугалж аваад гарсан зайг элсээр нямбай дүүргэнэ. Өрсөн чулуу тарж хөдлөхөөс хамгаалахын тулд талбайн захаар тулц хашлагыг байгалийн чулуугаар хучлагын талд хүртэл хийж өгөх ба дараа нь түүнийг байгалийн хөрсөөр хучна.

б) Чулууг өрж суулгах

ӨЧ ба ДЧ төрлийн чулууг ихэвчлэн элсэн суурин дээр, харин НЧ-г бетон болон бусад төрлийн бат бэх суурин дээр суулгана.

Зассан чулууг тээвэрлэн авчирч замын хөвөөн дээр эсвэл шинээр барьсан хучлагын захад багцалж өрнө. Тэдгээрээс модон шаблоны тусламжтайгаар ижил өргөнтэй чулуунуудыг сонгож нэг эгнээнд суулгана.

Чулууг замын тэнхлэгийн хөндлөн чигт буюу тэнхлэгтэй $45^0$-ын өнцөг үүсгэсэн байрлалтай эгнээгээр өрж суулгана.

Эгнээ бүрийг суулгахдаа залгаасуудын холболтыг сайн анхаарах бөгөөд түрүүчийн эгнээнд суулгасан чулуунуудын заадастай давхардал үүсгэхгүй, заадас бүр сөөлжилсөн байхаар суулгана. Зэрэгцээ эгнээ бүрийн ойр байрших заадсуудын хоорондын зай нь засмал чулууны уртын хагасаас бага байж болохгүй.

Дээрхээс гадна өрмөл чулуун хучлагыг шоо дөрвөлжин хэлбэртэй чулуугаар шигтгэн хийж болно. Дөрвөлжин чулуу нь тэгш өнцөгт чулууг бодвол овор хэмжээ бага тул шигтгэж суулгахад илүү хялбар, ажлын явцад болон дараа нь ямар нэгэн засал хийхэд амар байдаг. Ийм төрлийн хучлагыг бетон суурин дээр хийдэг бөгөөд энэ нь суурийн бат бэхийг тухайн хучлагын зузаантай уялдуулан нийт хучилтын даацыг хангах зорилготой юм.

Суурин дээр өрмөл чулуун хучлагын нэгэн адил элсээр болон цементтэй элсэн хольцоор тэгшилгээний дэвсгэр үеийг байгуулна.

Өрмөл чулуун хучлагыг нум хэлбэртэйгээр өрж суулгах тохиолдолд нумын гүдгэр талыг замын хөдөлгөөний чиглэл рүү харуулна. Нум хэлбэрээр суулгах хэд хэдэн арга байдаг бөгөөд тэдгээрээс илүү энгийн, түгээмэл арга нь зэрэгцээ орших хоёр нумыг нэг ерөнхий чулуугаар холбох арга юм. Ингэхдээ зэрэгцээ тавигдаж байгаа хоёр нумын төгсгөлийн ерөнхий чулуунууд нь хучлагын тэнхлэгт параллель орших нэгэн шулуун дээр байрлахаар өрлөгийг хийнэ. Чулууг нуман хэлбэрээр суулгахдаа зориулалтын хэв ашиглана. Нумын төгсгөлийн чулуунуудын байршлыг тогтоох зорилгоор хучлагын тэнхлэгтэй параллелээр чиглүүлэгч утас татна. Нум бүр дэх эгнээний зах, үзүүр хэсэг буюу нумын төгсгөлд хамгийн бага хэмжээс бүхий, харин нумын гол хэсэг рүүгээ ойртох тусам чулууны хэмжээг өргөсгөн голд нь хамгийн том хэмжээс бүхий чулууг байрлуулна. Зэрэгцээ хоёр нумыг ерөнхий чулуугаар холбох аргаас гадна хоёр, гурав буюу дөрвөн эгнээ бүхий нумыг мөн тооны зэрэгцээ орших эгнээ бүхий нумаар холбох аргыг хэрэглэж болно. Нумаар холбох аргын давуу тал нь механик аргаар зөв хэлбэрт оруулж бэлтгэсэн чулуу бүрийг хаягдалгүйгээр хучлагад хэрэглэх боломжийг олгодогт оршино.

Энд нягтруулах ба заадас бөглөх арга нь дээр дурдсантай адил байна. Замын хучлагад чулууг өрж суулгах ажлыг гүйцэтгэхдээ чулуунуудын хоорондох зай буюу заадсыг ижил хэмжээнд нарийн баримтлахын тулд талбайн нийт урт, өргөнөөр утас татаж, уг утсыг дагуулан суулгаж эхлэнэ. 3 үе тутамд заадасны өргөнийг шалгаж байх хэрэгтэй. Чулууг өрж суулгахдаа резин алхыг ашиглана.

Хэвтээ гадаргуун тэгш байдлыг өрж суулгасан, гэхдээ нягтруулаагүй чулууны 5м2 тутамд шалгана. Зөвшөөрөгдөх хүлцэх алдаа нь 2м-т 0.5-1см байна. Цэцэрлэгт хүрээлэнгийн жижиг зам, барилгын гадна талбай зэргийг хийхдээ байшингийн гол хаалга, үүдний довжоо зэрэг тодорхой бөгөөд чухал цэгээс эхлэнэ.

в) Чулууг нягтруулах ба заадсыг чигжих

Зассан чулууг зөв аргачлалаар, сайн өрж дэвссэний дараагаар хучлагын дууссан хэсгийг гар механик чигжигч буюу өөрөө явагч индүүгээр нягтруулна. Улмаар голын шигшсэн, цэвэр бөгөөд хуурай элсээр чулуунуудын хоорондох завсрыг бүрэн дүүртэл нь чигжиж нягтруулна. Элсийг жигдхэн байдлаар олон дахин шүүрдэх замаар бүх завсар зайг битүү дүүргэсэнээр нийт гадаргуу найдвартай бөгөөд бат бэх нягтарна. Үүний дараа цэвэр бөгөөд хуурай гадаргууг дээр шигшсэн, хуурай элсийг дахин нэг үе дэвсэж нягтруулах ба үүнийг хэсэг хугацааны туршид хөндөлгүй байлгаад эцэст нь үлдэгдлийг шүүрдэж гаргана.

Авто замын хучлагын хувьд автомашины дугуйн ачааллаар үүсэх шилжилтийн хүч нэг чулуунаас нөгөө чулуунд тогтвортой дамжуулагдах нөхцлийг бүрэн хангасан, зохих хэмжээний тортвортой, бат бэх ба сайн дүүргэлт бүхий заадсыг бий болгох нь чухал. Эсрэг тохиолдолд чулуунууд нь нааш цааш хөдлөхөд хүрнэ.

Заадсыг бөглөхөд хэрэглэх материалыг сонгохдоо цаг агаарын болон ашиглалтын нөхцлүүдийг сайтар тооцож үзэх шаардлагатай. Заадсанд дан цэвэр элснээс гадна цементийн нэмэлттэй элс, эсвэл битум ба эрдэс нунтаг бүхий битумын хольцыг хэрэглэж болно. Битум болон түүнтэй төсөөтэй материалыг хэрэглэхэд замын хучлагын уян хатан байдал нь тодорхой хэмжээнд хадгалагддаг. Шатахуун түгээгүүрийн болон авто угаалгын талбайд бат бэх сайтай заадсыг ашиглана.

Чулууны дэвсэлтийн заадасны өргөн 8 мм-ээс багагүй байх ёстой.

г) Ашиглалтын үед гадаргууд тавигдах шаардлага

Янз бүрийн материалын нөлөөллөөс шалтгаалан чулуун хучлагын гадаргуу дээр төрөл бүрийн бохирдол үүсч, энэ нь дэвсэлтийн гаднах өнгө төрхийг үндсээр нь өөрчилдөг. Жишээ нь, машины дугуй хар зураас үлдээх, замын тоос, шавар шавхай нь чулууны өнгийг бор саарал болгох гм. Иймд тусгай зориулалтын бодис болон цэвэрлэгээний хэрэгслийг ашиглан чулууг хуучин өнгөнд нь оруулах арга хэмжээг авч байх шаардлагатай.

Өвлийн улиралд чулууны гадаргуу дээр мөстөлт үүсэхээс сэргийлж, модон хүрз болон шүүрийн тусламжтайгаар байнгын цэвэрлэгээ хийж байх ёстой. Хальтаргаа, гулгаа багасгахын тулд гадаргууд элс цацаж болно.

Харин цас, мөсийг цэвэрлэхдээ ямар ч нөхцөлд төмөр багаж хэрэглэхийг хориглоно.

## 1251 ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР

Зүйл : Чулуун хучлага Нэгж : м2

Чулуун хучлагын ажлыг ажлын зурагт үзүүлсэн буюу ТИ-ийн зааварчилсны дагуу өрж суулгасан метр квадратаар хэмжинэ. Ажлын тоо хэмжээг тооцохдоо заадсыг бүрэн чигжиж, нягтруулсан чулуун үеийн өргөнийг зөвшөөрсөн уртаар үржүүлж гаргана. 2 талын хашлагын өргөнийг нийт өргөнд оруулж тооцохгүй.

Аливаа засварын ажилд тусад нь хэмжилт буюу төлбөр хийхгүй.

Чулуун хучлагын ажлын нэгж үнэлгээнд дараах ажлууд багтсан гэж үзнэ. Үүнд:

- Шороон орд, материал нөөцлөх талбай, боловсруулалт хийх талбай, хаягдал материал зайлуулах газар болон тэдгээрт хүрэх түр замын цэвэрлэгээ,
- Дээрх газрууд болон түр замаас хуулсан өнгөн хөрс бусад хаягдлыг зайлуулах ба хэрэв шаардлагатай бол тусад нь хураах,
- Дээрх газрууд болон түр замаас ус зайлуулах, ажил дуусаны дараа тэдгээрийг буцааж булах, зүлэгжүүлэх, нөхөн сэргээх,
- Орд газрыг тойруулж хамгаалалт хийх, хайс барих,
- Түр зам барих ба тэдгээрийг арчлах, түр замаар хөдөлгөөн явах нөхцлийг бүрдүүлэх,
- Тээврийн хөдөлгөөний хяналт, аюулгүй байдал ба олон нийтийн эрүүл ахуйн шаардлагыг хангах,
- Суурийн материалыг сонгох, ухаж авах,
- Тэгшилгээний дэвсгэр үеийн материалыг сонгох, ухаж авах,
- Заадасны материалыг сонгох, ухаж авах,
- Шаардлагатай нэмэлтүүдийг хангах,
- Хуучин хучилтын үеүүдийг ухаж авах, тэдгээрийг түр хураах, эсвэл зайлуулах,
- Хучлагын чулууг тээвэрлэх, хүлээн авах ба буулгах, хураах,
- Талбайн бүхий л шаардлагатай тээвэрлэлт,
- Чулуун хучлагыг өрж суулгах,
- Заадсыг бөглөх, хучлаг ба заадсыг нягтруулах,
- Шүүрдэх, гологдолтой хэсгүүдийг засч янзлах, гадаргууг арчлах,
- Тухайн ажилтай холбогдолтой байгаль орчны нөхөн сэргээлт хийх,

# БҮЛЭГ 1300 – БЕТОНЫ АЖИЛ

## БҮЛЭГ 1300 – БЕТОНЫ АЖИЛ


| | | |
|---|---|---|
| 1301 | БҮЛГИЙН АГУУЛГА | 13-6 |
| 1302 | ТОДОРХОЙЛОЛТ | 13-6 |
| 1303 | МАТЕРИАЛ | 13-6 |
| | (а) Ерөнхий | 13-6 |
| | (б) Цемент | 13-6 |
| | (в) Чулуулаг материалд тавигдах ерөнхий шаардлага | 13-7 |
| | (г) Жижиг ширхэглэлтэй чулуулаг материал | 13-8 |
| | (д) Том ширхэглэлтэй чулуулаг материал | 13-9 |
| | (е) Чулуулаг материалын шинжилгээ | 13-10 |
| | (i) Зөвшөөрөл авахад шаардлагатай шинжилгээ | 13-10 |
| | (ii) Байнга хийгдэх шинжилгээ | 13-10 |
| | (ё) Бетон болон зуурмагт хийх ус | 13-11 |
| | (ж) Нэмэлтүүд | 13-12 |
| 1304 | БЕТОН ЗУУРМАГИЙН ОРЦЫГ ТОГТООХ | 13-13 |
| | (а) Барилгын ажилд хэрэглэх бетоны анги | 13-13 |
| | (б) Ус цементийн харьцаа | 13-13 |
| | (в) Орцын норм тогтоох | 13-14 |
| 1305 | ТАЛБАЙН ТУРШИЛТУУД | 13-15 |
| 1306 | БЕТОНЫ ЧАНАРЫН ХЯНАЛТ | 13-16 |
| | (а) Дээж авах | 13-16 |
| | (б) Туршилт хийх | 13-16 |
| | (i) Өтгөрөл | 13-16 |
| | (ii) Ус цементийн харьцаа | 13-17 |
| | (iii) Агаарын агууламж | 13-17 |
| | (iv) Үзүүрлэг хавтгайлагийн индекс | 13-17 |
| | (v) Бетон шоог шахалт болон гулзайлтанд турших | 13-17 |
| | (в) Шооны туршилт хүчинтэй байх | 13-17 |
| | (г) Бетоны бат бэхийн шалгуур үзүүлэлтүүд | 13-18 |
| | (д) Шаардлага хангаагүй туршилтууд | 13-18 |
| 1307 | БЕТОНЫГ ХОЛИХ | 13-18 |
| 1308 | БЕТОН ЗУУРМАГИЙГ ТЭЭВЭРЛЭХ | 13-20 |
| 1309 | БЕТОНЫГ ЦУТГАХ | 13-20 |
| | (а) Цутгах зөвшөөрөл | 13-20 |
| | (б) Гадаргууг бэлдэх | 13-21 |
| | (в) Цутгах ажиллагаа | 13-21 |
| | (г) Усан дотор бетон цутгах | 13-22 |
| | (д) Цутгалтыг зогсоох | 13-24 |

(е) Цутгах хэмжээ 13-24
(ё) Цутгах дараалал 13-24
1310 БЕТОНЫГ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛӨӨС ХАМГААЛАХ 13-24
(а) Ерөнхий 13-24
(б) Бороноос хамгаалах 13-25
(в) Цаг агаарын халуун нөхцлөөс хамгаалах 13-25
(г) Цаг агаарын хүйтэн нөхцлөөс хамгаалах 13-25
(i) Зуурах ба цутгах 13-25
(ii) Эхний арчлалт 13-26
(iii) Усан дотор бетон цутгах 13-26
(д) Сульфатын агууламж ихтэй ус ба хөрснөөс хамгаалах 13-27
1311 БЕТОНЫГ НЯГТРУУЛАХ 13-27
1312 БЕТОНЫГ АРЧЛАХ 13-28
(а) Ерөнхий 13-28
(б) Материал 13-29
(i) Ус 13-29
(ii) Шингэн мембран 13-29
(iii) Ус нэвтэрдэггүй хучлага 13-29
(в) Бетоныг арчлах аргууд 13-29
(i) Хэв хашмалын арга 13-29
(ii) Усаар арчлах 13-29
(iii) Шингэн мембранаар арчлах 13-29
(iv) Ус нэвтэрдэггүй материалаар хучих 13-30
(v) Халаалттай байранд арчлах 13-30
(vi) Уур ба туяагаар халааж арчлах 13-30
(г) Шинэ цутгасан бетоны дулааны өөрчлөлтийг хязгаарлах 13-31
1313 АЖЛЫН ЗАЛГААС 13-32
1314 ХЭВ ГАЖИЛТЫН ЗААДАС 13-33
1315 УС ТОГТООГЧ 13-33
1316 ХЭВЛЭМЭЛ БУС ГАДАРГУУН ӨНГӨЛГӨӨ 13-34
(а) UF 1 өнгөлгөө 13-34
(б) UF 2 өнгөлгөө 13-34
(в) UF 3 өнгөлгөө 13-34
(г) Зорчих хэсгийн гадаргуун өнгөлгөө 13-34
1317 ХЭВЛЭМЭЛ ГАДАРГУУН ӨНГӨЛГӨӨ 13-36
(а) Ердийн өнгөлгөө 13-36
(б) Зүлгэх өнгөлгөө 13-37
1318 ТҮР БАЙГУУЛАМЖ БА ХЭВ ХАШМАЛ 13-37
(а) Түр байгууламж 13-37

(i) Ачаалал 13-38
(ii) Суурь 13-38
(iii) Хазайлт 13-38
(iv) Чөлөөт зай 13-38
(v) Түр байгууламж барих 13-39
(б) Хэв хашмал 13-39
(i) Ерөнхий 13-39
(ii) Хэв хашмалыг төсөллөх 13-40
(iii) Хэв хашмал барих 13-40
(iv) Хэв хашмалыг бетон цутгахад бэлдэх 13-41
(в) Хэв хашмал ба түр байгууламж буулгах 13-41
(i) Ерөнхий 13-41
(ii) Буулгах хугацаа 13-42
(iii) Хязгаарлалт 13-43
1319 ӨТГӨН БА ШИНГЭН ЗУУРМАГ 13-43
(а) Ерөнхий 13-43
(б) Нийтлэг зориулалтаар хэрэглэх зуурмаг 13-43
(в) Хонхор ба нүхийг чигжих 13-43
(г) Суурийн хавтангуудын доорх чигжээс 13-44
1320 БЕТОНЫ ДАЛД АЖЛЫН АКТ 13-44
1321 СОГОГТОЙ БЕТОНЫГ ЗАСВАРЛАХ 13-44
1322 БЕТОНЫ АРМАТУР 13-45
(а) Ерөнхий 13-45
(б) Арматурт хийх шинжилгээ, туршилтууд 13-45
(в) Арматурыг тээвэрлэх ба хадгалах 13-45
(г) Арматурыг нугалах схем 13-46
(д) Арматурыг бэлтгэх 13-46
(i) Таслах ба нугалах 13-46
(ii) Хаяглах 13-46
(е) Арматурын гадаргууг арчлах 13-46
(ё) Арматурыг байрлуулах ба бэхлэх 13-47
(i) Ерөнхий 13-47
(ii) Тулах систем 13-47
(iii) Цементэн блок 13-47
(iv) Тулгуур бэхэлгээ 13-47
(v) Арматурыг гагнах 13-47
(vi) Арматурыг залгах 13-47
1323 ӨӨР ХЭМЖЭЭТЭЙ АРМАТУРААР ОРЛУУЛАХ 13-48
1324 УГСАРМАЛ ТӨМӨР БЕТОН 13-48

(а) Ерөнхий 13-48
(б) Угсармал хийцийн хэв 13-48
(в) Угсармал хийцийн арматур 13-48
(г) Угсармал хийцийг цутгах 13-49
(д) Угсармал хийцийг бэхжүүлэх 13-49
(е) Угсармал хийцийн гадаргуугийн өнгөлгөө 13-49
(ё) Угсармал хийцийг зөөх, хадгалах 13-49
(ж) Угсармал хийцийг шалгаж турших 13-50

## 1301 БҮЛГИЙН АГУУЛГА

Энэ бүлэгт бетоны ажилд шаардагдах материал, орцын норм, холилт, тээвэрлэлт, дэвсэлт, нягтруулалт болон арчлалтын тухай заасан болно. Мөн бетоны хэв хашмал, арматурчлал болон угсармал хийцийн тухай заалтууд орсон байгаа.

## 1302 ТОДОРХОЙЛОЛТ

Хийцийн бетон гэдэг нь аль ч ангиллын, урьдчилан хүчитгэсэн болон хүчитгээгүй даацын бетоныг хэлнэ.

Хийцийн бус бетон гэдэг нь энэхүү техникийн шаардлагад нийцэх материалаас бүтсэн, зөвхөн нүх, зай завсрыг бөглөх, ул бетон болон бусад ачаалал ирдэггүй эд ангиудад хэрэглэх даацын бус бетоныг хэлнэ.

Хэвлэмэл гадаргуу гэдэг нь цутгамал бетоны хэвтэй харьцсан гадаргууг хэлнэ.

Хэвлэмэл бус гадаргуу гэдэг нь хэвтээ буюу бараг хэвтээ байрлалтай, тараах тэгшлэх аргаар үүссэн гадаргууг хэлнэ. Иймд гадаргуунд өнгөлгөө хийх шаардлагатай.

Цутгалт гэдэг нь аливаа хэв хашлага, тэвш гэх мэт эзлэхүүнд бетоныг шаардлагатай хэмжээнд хүртэл дүүргэхийг хэлнэ.

Тулах түр байгууламж гэдэг нь хэв хашмал болон цутгасан бетоныг бэхжиж дуустал нь тулах даацын элементүүдээс бүтсэн байгууламж юм.

Хэв хашмал гэдэг нь цутгасан бетоныг бэхжтэл нь шаардлагатай хэлбэрт барих түр буюу байнгын бүтэц юм.

Тогтворжилт гэдэг нь бетон зуурмагийн урсах эсэргүүцлийг буюу өтгөрөлтийг хэлэх бөгөөд ихэнхдээ конусын суултын аргаар тодорхойлогддог.

Тогтворжилтыг хэмжих өөр аргуудад нягтралын хүчин зүйл ба Вебе тогтворжилт хэмжигч ордог.

## 1303 МАТЕРИАЛ

(а) Ерөнхий

Гүйцэтгэгч бетонд ашиглахаар төлөвлөж байгаа материалын тухай бүрэн мэдээллийг инженерт танилцуулна. Инженер тохирох материалыг зөвшөөрөх хүртэл уг материалуудыг зам барилгын ажлын талбайд байрлуулахыг хориглоно. Нэгэнт инженерийн зөвшөөрсөн материалыг солих буюу өөр материалаар орлуулж болохгүй. Хэрвээ материалын эх үүсвэрийг солих шаардлага гарсан тохиолдолд инженерийн зөвшөөрлийг авах шаардлагатай.

(б) Цемент

Цемент нь AASHTO M85, Төрөл II стандартын портланд цементийн шаардлагыг хангасан байна.

Цемент нь хялбар урсдаггүй ба бөөгнөрөлгүй байх ба үйлдвэрлэгчээс нийлүүлсэн урагдаагүй уутанд савласан буюу задгай байдлаар нийлүүлэгдэх ёстой. Ууттай цементийг тээврийн хэрэгслээр тээвэрлэхдээ цаг агаарын нөлөөнөөс сайтар хамгаалж тээвэрлэнэ.

Задгай цементийг тусгай зориулалтаар тоноглогдсон тээврийн хэрэгсэл эсвэл зориулалтын контейнэрээр тээвэрлэнэ.

Ууттай цементийг цаг агаарын нөлөөнөөс хамгаалагдсан хуурай, байнгын агааржуулалттай байр саванд хадгална. Шал нь чийг орохоос хамгаалагдсан ба орчин тойрны газрын түвшнээс өндөр байна.

Тээвэрлэлт бүрээр ирсэн ууттай цементүүдийг нэг газарт овоолон хурааж тавина. Ууттай цементийг агаарын солилцоо явагдах боломжийг нь багасгах зорилгоор нийлүүлж хураах ба харин хадгалж буй байрны гадна хананд ойр хурааж болохгүй. Хэрвээ тавиур дээр хурааж байгаа бол ууттай цементийг хураах зөөх үед уутнуудыг урж гэмтээхээргүйгээр тавиурыг барьсан байх ёстой. Ууттай цементийг

3 метрээс өндөргүйгээр, өөр өөр маркийн цементийг тэмдэглэгээ хийж, тус тусад нь хураана.

Урагдсан ууттай цементийг ажилд хэрэглэхгүй.

Ууттай цементийг авчирсан дараалаар нь хэрэглэнэ.

Задгай цементийг цаг агаарын нөлөөнөөс хамгаалагдсан силост хадгалах бөгөөд цементийн төрлийг зааж тэмдэглэсэн байна. Өөр өөр төрлийн цементийг өөр өөр силост хадгална.

Гүйцэтгэгч барилгын ажид цемент дутагдсанаас шалтгаалан зогсохоос сэргийлэн тээвэрлэлт, цаг агаарын нөхцөл, баяр амралтын өдрүүд зэрэг хүчин зүйлүүдийг тооцон талбай дээр хүрэлцэхүйц хэмжээгээр хадгалсан байна.

Гүйцэтгэгч хатуурсан, бөөгнөрсөн эсвэл энэ техникийн шаардлагыг хангаагүй цементийг талбайгаас зайлуулна.

Нэг бүтээцэд ашиглах цементийг нэг эх үүсвэрээс авчирсан байна.

Үйлдвэрлэгч буюу гүйцэтгэгч ажилд хэрэглэх бүх цементийг инженерийн зөвшөөрсөн лабораторид шинжилсэн байна. Шинжилгээг техникийн шаардлагын бүлэг 200-д заасны дагуу хийнэ. Гүйцэтгэгч шинжилгээ хийсэн гэрчилгээг 2 хувь үйлдэж инженерт ирүүлнэ. Инженер шинжилгээний дүнг батлахаас нааш гүйцэтгэгч талбайд цемент авчирч болохгүй.

Үйлдвэрлэгч буюу гүйцэтгэгч нь үйлдвэрээс үйлдвэрлэгдэж гараад нэгээс олон хоногүй, шууд талбайд ирсэн цементний дээжид шинжилгээ хийнэ. Үүний адил, дээжийг инженерийн зөвшөөрсний дагуу үйлдвэрээс талбайд ирсэн цементний 200 т бүрээс авна.

Гүйцэтгэгч ажилд хэрэглэхээр талбайд хүргэгдсэн цементийн үйлдвэрлэгч, ирсэн өдөр, шинжилгээ болон юунд хэрэглэсэн тухай мэдээллийг байнга бүртгэж инженерт 2% ирүүлнэ.

Талбайд 42 хоногоос удаан хадгалсан цементийг инженерийн зааврaар зөвшөөрөгдсөн лабораторид дахин шинжилгээнд оруулна.

Энэхүү техникийн шаардлагад нийцээгүй цементийг ажилд хэрэглэж болохгүй ба ийм цементийг гүйцэтгэгч талбайгаас зайлуулна.

(в) Чулуулаг материалд тавигдах ерөнхий шаардлага

Материалын эх үүсвэрийг инженерээр батлуулсан байна.

Инженерийн ажилд хэрэглэж болохгүй гэж үзсэн чулуулаг материалыг гүйцэтгэгч талбайгаас нэн даруй зайлуулна.

Чулуулаг материалыг талбайд цэвэр бөгөөд тохиромжтой машинаар тээвэрлэж авчирна. Өөр төрлийн болон өөр өөр ширхэглэлтэй чулуун материалыг нэг машинаар авчирч болохгүй.

Чулуулаг материалыг инженерийн зөвшөөрсөн эх үүсвэрээс авсан усаар угааж цэвэрлэнэ. Усны хангалт, хадгалалтыг гүйцэтгэгч өөрөө хариуцна. Чулуу угаасан усыг гол ба гадаргуун бусад усны эх үүсвэр лүү шууд хийж болохгүй.

Ашигласан шавартай усыг инженерийн зөвшөөрсний дагуу дараах аргаар зайлуулна. Үүнд:

- хээр газар тараан асгах
- шүүрүүлэгч ухаж, шахах
- муу усны хоолой руу хийх
- тогтонги ус руу шахах
- шүүлтүүрээр шүүх

Чулууг хэмжээ болон ширхэглэл бүрээр ангилан бага зэрэг налуу бетон шалтай

тасалгаануудад тус тусад нь хадгална. Тасалгаануудын хоорондох тусгаарлагч хана нь өөр өөр төрлийн хэмжээтэй чулуу хоорондоо холилдохгүй байхаар үргэлжилсэн хангалттай хэмжээтэй байна. Овоолсон чулуу ширхэглэлээр ялгарахгүй байх талаар гүйцэтгэгч арга хэмжээ авна. Чулууг хэвтээ үеэр хураах ба овоолгоны өндөр 1.5м өндөргүй байна.

Зуурах үед чийгийн агуулга нь гэнэт өөрчлөгдөхөөс сэргийлэхийн тулд чулуун овоолгыг нь ус тогтохооргүй овоолсон байна. Нойтон чулуулаг материалыг инженер сайн хатсан гэж тодорхойлохоос нааш гүйцэтгэгч ажилд хэрэглэж болохгүй. Гүйцэтгэгч жижиг ширхэглэлт чулуулаг материалын чийгийн агууламжийг тогтмол хэмжиж, зууралт бүрт чулуулаг материал болон усны хэмжээг чулуулаг материалын чийгийн агууламжаас хамааруулан тохируулна. Гүйцэтгэгч чулуулаг материалыг цаг агаарын нөлөөнөөс хамгаална.

(г) Жижиг ширхэглэлт чулуулаг материал

Жижиг ширхэглэлт чулуулаг материалд AASHTO M6 стандартын шаардлага хангасан цэвэр, хатуу бат бөх байгалийн гаралтай элс, буталсан хайрган элс, буталсан чулуун элс орно. Бүх чулуулаг материал нь 9,5 мм шигшүүрээр өнгөрөх ёстой бөгөөд хүснэгт 13-1-т үзүүлсэн ширхэглэлийн хязгаарын дотор аажим зэрэгцэн явахаар ширхэглэлд тохирсон байна. Материалын шаардлагатай ширхэглэлийг гаргаж авахын тулд материалыг нэгээс дээш эх үүсвэрээс хольж авч болно.

Жижиг ширхэглэлт чулуулаг материал нь төмрийн хольцгүй эсвэл төмрийн исэлд ороогүй байна. Мөн шаврын гялтгануур, нарийн ширхэглэлт чулуу, нүүрс эс бөгөөс бусад ялтаслаг бодис, зөөлөн эсвэл сийрэг ба органик материалуудыг агуулаагүй байхаас гадна нэгэн төрлийн, хольцгүй чулуулаг байна.

**Хүснэгт 13-1: Портланд цемент бүхий бетоны жижиг ширхэглэлт чулууны ширхэглэлийн хязгаар**

| Шигшүүрийн хэмжээ | Шигшүүрээр өнгөрсөн жингийн хувь | |
|---|---|---|
| | Даац багатай бетон | Даацын бетон |
| 9.5 мм | 100 | 100 |
| 4.75 мм | 95 – 100 | 95 - 100 |
| 1.18 мм | 45 – 80 | 45 - 80 |
| 300 µм | 10 – 30 | 5 – 30 |
| 150 µм | 2 – 10 | 0 – 10 |

Инженер өөрөөр заагаагүй бол жижиг ширхэглэлт чулууны ширхэглэлийн хязгаар Хүснэгт 13-1 дагуу байна.

Аливаа 2 шигшүүрийн дунд тунаж үлдсэн жижиг ширхэглэлийн чулууны хэмжээ 45 %-иас хэтрэхгүй.

Жижиг ширхэглэлт чулуулаг материалын бусад шинж чанарыг дурьдвал:

(i) Жижиг ширхэглэлийн модуль нь 2,3-аас багагүй эсвэл 3,1-аас ихгүй байна,

(ii) 0,075 мм-ийн шигшүүрээр өнгөрөх жижиг ширхэглэлт чулуулаг материалын хэмжээ нь байгалийн буюу эсвэл буталсан хайрган элсэнд 3%, буталсан чулуун элсэнд 15%-аас хэтрэхээргүй байна

(iii) Хлорын агууламж жингийн 0.03 % илүүгүй байна

(iv) AASHTO T104 стандартын дагуу содын сульфатыг ашиглан туршилтыг 5 удаа хийсний дараа жингийн алдагдал 10%-иас бага байна,

(v) ASTM C 289 дагуу цахиурын шүлтийн урвалаар шалгахад чулуулаг

материал нь урвалд орохгүй байх ёстой,

(д) Том ширхэглэлт чулуулаг материал

Том ширхэглэлт чулуулаг материал нь AASHTO M 80 стандартыг хангасан буталсан чулуу, буталсан хайрга буюу тэдгээрийн холимог байна. Материал нь нэгэн төрлийн хольцгүй чулуулаг байх бөгөөд , төмрийн шүлт, төмрийн гялтганууР, нүүрс, ялтаслаг бодис, зөөлөн буюу сийрэг ба органик материалуудыг бетоны шинж чанарт нөлөөлөхүйц хэмжээгээр агуулаагүй байна. Том ширхэглэлт чулуулаг материал нь бөөрөнхий эсвэл хурц өнцөг бүхий хэлбэртэй, үзүүрлэг, хавтгайн индекс нь 30%-аас хэтрэхгүй байна.

Инженер өөрөөр заагаагүй бол том ширхэглэлт чулуулаг материалын ширхэглэлийн хязгаар хүснэгт 13-2-т үзүүлсэн ширхэглэлийн хязгаарын дотор аажим зэрэгцэн явахаар ширхэглэлд тохирсон байна.

**Хүснэгт 13-2: Том ширхэглэлт чулуулаг материалын ширхэглэлийн хязгааР**

| Шигшүүрийн хэмжээ | Шигшүүрээр өнгөрөх жингийн хувь | | |
|---|---|---|---|
| | Чулууны хэмжээ | | |
| | 10 мм | 20 мм | 40 мм |
| 50 мм | - | - | 100 |
| 37.5 мм | - | - | 90 -100 |
| 25.0 мм | - | 100 | 20 - 55 |
| 19.0 мм | - | 90 - 100 | 0 -15 |
| 12.5 мм | 100 | 20-55 | - |
| 9.5 мм | 85-100 | 0-15 | 0 - 5 |
| 4.75 мм | 10-30 | 0 - 5 | - |
| 2.36 мм | 0-10 | - | - |
| 1.18 мм | 0-5 | - | - |

Аливаа 2 шигшүүрийн дунд тунаж үлдсэн ширхэглэлийн чулууны хэмжээ 45 %-иас хэтрэхгүй.

Том ширхэглэлт чулуулаг материалын бусад шинж чанарыг дурьдвал:

(i) 75 μм шигшүүрээр өнгөрөх шавар, шавранцар болон бусад бохир бодис жингийн 1%-иас хэтрэхгүй,

(ii) Буталсан чулууны нийт хайрсны агуулга нь дараахи хэмжээнүүдээс хэтрэхгүй байна:

- 40 мм ба түүнээс дээш хэмжээтэй хуурай жингийн 2%
- 20 мм ба түүнээс доош хэмжээтэй хуурай жингийн 5%

(iii) Хлорын агууламж жингийн 0.05%-иас хэтрэхгүй,

(iv) Натрийн сульфат ашиглан AASHTO T104 туршилтыг 5 удаа хийсний дараа жингийн алдагдал нь 10%-иас хэтрэх ёсгүй,

(v) ASTM C 289-ын дагуу шинжлэхэд чулуу нь шүлт цахиурын урвалд ордоггүй,

(vi) Материалыг AASHTO T85 дагуу туршихад ус шингээлт 2.5%-иас бага,

(vii) BS 812-ын дагуу буталсан чулууны бутралтын индекс (ACV) 30%-аас бага,

(viii) Лос-Анжелесийн элэгдлийн үзүүлэлт (AASHTO T96) 35%-иас бага байна

(е) Чулуулаг материалын шинжилгээ

(i) Зөвшөөрөл авахад шаардлагатай шинжилгээ

Аливаа бетоны ажил эхлэхээс өмнө гүйцэтгэгч чулууны дээжийг инженерт өгнө. Гүйцэтгэгч дээжүүдийг AASHTO T2 стандартын дагуу бэлдэж жижиг ширхэглэлт чулуунаас 50кг-ас доошгүй, том ширхэглэлт чудуунаас 100кг доошгүй байхаар бэлдэж инженерийн шаардсан бусад дээжүүдийн хамт инженерт ирүүлнэ. Дээж бүрт эх үүсвэрийг тодорхой заасан хаяг нааж AASHTO T2 стандартад тодорхойлсон бусад мэдээллийг хавсаргана.

Гүйцэтгэгч материалыг техникийн шаардлагын 1303 (в)-(д) дэд зүйлүүдтэй нийцэж байгаа эсэхийг шалгах шинжилгээг инженерийн зөвшөөрсөн лабораторид гүйцэтгэнэ.

Хэрэв урьд нь зөвшөөрөгдсөн материал шаардлага хангахгүй байгаа нь илэрвэл уг материалыг хэрэглэхийг түр зогсоож гүйцэтгэгч ба инженерийг байлцуулан дахин шинжилгээ хийнэ. Шинжилгээний дүнг үндэслэн материалыг зөвшөөрөх эсэхийг шийднэ.

Хэрэв 3-аас доошгүй дараалан хийсэн шинжилгээний дүн шаардлагад нийцвэл материалыг зөвшөөрнө.

(ii) Байнга хийгдэх шинжилгээнүүд

Гүйцэтгэгч барилгын ажлын явцад чулуулаг материал нь техникийн шаардлага болон төслийн чанарын хяналтын төлөвлөгөөтэй нийцэж байгаа эсэхэд өдөр тутмын шинжилгээ хийж байх ёстой. Өдөр бүр талбайд ирж байгаа чулуунаас эх үүсвэр тус бүрээр дээж авч иж бүрэн шинжилгээ хийнэ. Ингэхдээ чулууны дээж тус бүр нь 250 т-оос багагүй жижиг ширхэглэлт чулуу, 500т-оос багагүй том ширхэглэлт чулууг төлөөлсөн байх ба чулуу нь нэг жигд чанарын үзүүлэлттэй байх ёстой. Хэрэв чулууны шинж чанар өөр өөр байгаа бол шинжилгээний давтамжийг инженер тодорхойлно.

- Ширхэглэл AASHTO T27
- Хэврэгшлийн индекс BS 812
- Уян налархай хэсгүүд AASHTO T176
- Чийгийн агууламж Түргэн тодорхойлогч аппарат ("Speedy")
- Органик бодисын агууламж AASHTO T21

Дээр дурьдсан өдөр тутмын шинжилгээнүүдээс гадна гүйцэтгэгч дор дурьдсан шинжилгээнүүдийг хийнэ. Үүнд:

- Чийгийн агууламж: бетоны усны агууламжийг техникийн шаардлагад заасны дагуу хянахад шаардагдах давтамжаар,
- Хлорын агууламж: чулуулаг материал дахь хлорын харьцааг техникийн шаардлагын 1303-р дэд зүйлийн (г) ба (д)-д заасан хязгаар дотор барихад шаардлагатай давтамжаар.

Хэрэв хлорын агууламж өөр өөр гарч байвал гүйцэтгэгч бетоныг бохирдуулдаг хлорын хэмжээг хэтрүүлэхгүйн үүднээс талбайд авчирсан чулууны ачаа бүрийг шинжилж үзэх шаардлагатай байж магадгүй. Ийм зориулалтаар гүйцэтгэгч шууд хариу нь гардаг Куантаб (Quantab)-ын түргэвчилсэн аргыг хэрэглэж болох юм. Хэрэв энэ аргаар гаргасан дүнгийн талаар маргаан гарвал материалын хлорын агууламжийг BS 812 (Volhard-ын арга)-ын дагуу лабораторид тодорхойлно.

(ё) Бетон зуурмагт орох ус

Бетон зуурмаг болон бэхжилтэд хэрэглэх ус нь тос, хүчил, шүлт, сахар, давс, оргагик бодис болон бусад сөрөг нөлөөтэй бодис агуулахгүй. Ус нь AASHTO T26 стандартын шаардлагад нийцэж байгаа эсэхийг нь шинжилж хэрэв инженер

зөвшөөрвөл усны pH үзүүлэлт 6.0 – 8.5 хэлбэлзэнэ.

Дараахи шинж чанар бүхий усыг бетон зуурмагт хэрэглэж болохгүй. Үүнд:

- давстай буюу давсархаг,
- 500 мг/л-ээс дээш хлорын ион агуулсан,
- 1000 мг/л-ээс дээш сульфатын ион агуулсан,
- 1000 мг/л-ээс дээш нүүрс буюу нүүрсний шүлт агуулсан,
- 2000 мг/л-ээс дээш нийт тэнцвэртэй бодис агуулсан.

Хэрэв бетоны бат бэхийг хангахад усны чанар тохиромжтой эсэх нь эргэлзээтэй байгаа бол усыг AASHTO M157 стандартын 1–р хүснэгтэд заасан бат бэхийн туршилтыг хийх хэрэгтэй.

pH нь 8.5-аас ихтэй боловч дээр дурдсан болон дараах нэмэлт шаардлагыг хангасан усыг хэрэглэхийг инженер зөвшөөрч болно.

Нэгдүгээрт, шүлтний гаралыг өөрөөр хэлбэл кальци болон магнийн карбонатаас уу эсвэл натри ба калийн оксидоос уу гэдгийг тогтоох хэрэгтэй. (Na2O ба K2O).

1. Шүлтлэг орчин натри ба калийн оксидоос ($Na_2O$ ба $K_2O$) үүссэн тохиолдолд усыг дараах нөхцөлийг хангасан байвал зуурмаг ба арчилгаанд хэрэглэж болно. Үүнд:
   - Шинэхэн зуурсан зуурмаг дахь шүлтний нийт хэмжээ 3 кг/м$^3$ –аас ихгүй байх,
   - Том болон жижиг ширхэглэлт чулуулаг материалын аль аль нь урвалд ордоггүй байх.
2. Шүлтлэг орчин кальци болон магнийн карбонатаас үүссэн тохиолдолд чулуулаг материал нь урвалд ордог байсан ч шинэхэн зуурсан зуурмаг дахь шүлтний нийт хэмжээ 3 кг/м$^3$ –аас ихгүй байвал усыг хэрэглэж болно.

(ж) Нэмэлт бодисууд

Техникийн шаардлагатай нийцүүлэх буюу бетон зуурмаг цутгахад нэмэлт бодис ашиглахыг гүйцэтгэгч санал болгож болно. Нэмэлт бодисыг ашиглахаас өмнө инженерээр батлуулсан байна. Инженер өөрөөр заагаагүй бол агааржуулагч бодисыг бетоны хүйтэнд тэсвэрлэх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор хэрэглэнэ.

Гүйцэтгэгч бетон зуурмагт хэрэглэх гэж буй нэмэлт бодисын тухай дэлгэрэнгүй мэдээлэл, мөн яаж хэрэглэх тухай ажлын аргачлалаа инженерт танилцуулна. Мэдээлэл нь доор дурдсан мэдээллүүдийг багтаах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.

(i) Нэг удаагийн тун, тугнах арга, илүү тунгаар ашигласан тохиолдолд гарах сөрөг үр дагавар,

(ii) Нэмэлтэд орох гол элементүүдийн химийн нэр томьёо,

(iii) Жингийн хувиар илэрхийлэгдсэн хлорын агууламж,

(iv) үйлдвэрлэгч гаргасан зааврын дагуу хэрэглэхэд агааржуулах үйлчилгээ үзүүлэх хэмжээ

(v) нэмэлтийг урьд өмнө Монголд хэрэглэж байсан туршлага

Бетонд хэрэглэх химийн нэмэлт бодис нь AASHTO M194, агааржуулагч бодис нь AASHTO M154 стандартыг хангасан байна. Гүйцэтгэгч нь бүх нэмэлт бодисуудыг инженерийн зөвшөөрсөн лабораторид AASHTO T157 стандартын дагуу шинжилнэ.

Дээрх ерөнхий шаардлагуудаас гадна агааржуулагч бодис нь удааширсан холилтын үед илүүдэл агаар үүсгэлгүйгээр техникийн шаардлагын дагуу буюу зурагт заасан хязгаарт агаарын агууламжийг нэмэгдүүлдэг байх ёстой.

Агааржуулагч бодисын үйлчилгээг гүйцэтгэгч байнгын барилгын ажилд ашиглах

үйлдвэртээ туршилтын зуурмаг дээр туршиж үзнэ.

Нэмэлт бодисууд нь бетоны шинж чанарт ямар ч сөрөг нөлөө үзүүлэх ёсгүй.

Хлоридын ионы агууламж нэмэлтийн жингийн 2% болон бетонд орох цементны жингийн 0.03%-иас хэтрэх ёсгүй.

Кальцийн хлоридыг буюу кальцийн хлорид агуулсан нэмэлтийг хэрэглэж болохгүй.

Инженерийн зөвшөөрөлгүй нэмэлт бодисуудыг хольж болохгүй.

Пуццолан нэмэлтүүдийг тусад нь буюу талбайд авчрахаас өмнө цементэнд хольж хэрэглэхдээ инженерийн зөвшөөрлийг урьдчилан авсан байх шаардлагатай.

Зөвхөн төмөрлөгийн зуухны үнс (шлакнаас) бусад холихоос бусад тохиолдолд пуццолан материалын холих тохиолдолд инженерийн зөвшөөрөл авах ба хольцон дахь цементийн жингийн 50%-иас хэтрэхгүй байна.

Төмөрлөгийн зуухны үнсийг (шлакийг) зуурмаг холих үед хийж байгаа бол хольц нь AASHTO M302 стандартын шаардлагыг хангасан байх ёстой. Харин цементтэй хольж байгаа бол хольц нь AASHTO M240 стандартын шаардлагыг хангасан байх ёстой.

Үнсэн дэх нүүрсний агууламж жингийн 7%-иас хэтрэх ёсгүй. Сульфатын ($SO_3$) хамгийн их агууламж жингийн 2.0% байна. Нарийн ширхэглэлийн хязгаарыг AASHTO M295 стандартын 2-р хүснэгтэд үзүүлсний дагуу байна. Үнсийг зөвхөн ASTM C150 шаардлагыг хангасан цементтэй хольж хэрэглэх ба аль ч эх үүсвэрээс авсан хольцны нийт сульфатын ($SO_3$) агууламж цементийн жингийн 4% хувиас хэтрэх ёсгүй.

## 1304 БЕТОН ЗУУРМАГИЙН ОРЦЫН НОРМЫГ ТОГТООХ

(а) Барилгын ажилд хэрэглэгдэх бетоны анги.

Бетоны анги нь шоон (150x150x150) дээжний 28 хоногийн бэхжилттэй сорьцоор тодорхойлсон шахалтын нормчилсон бат бэх юм. Инженер өөрөөр заагаагүй бол талбайгаас авсан шооны 28 хоногийн дундаж бат бэх хүснэгт 13.3-т үзүүлсэнтэй тэнцүү буюу илүү байна. Харин бетон зуурмагийн орц тогтооход Хүснэгт 13-4-д заасан бат бэхийг хангах ёстой.

**Хүснэгт 13-3: Шоон дээжний 28 дахь өдрийн бат бэхээр илэрхийлсэн бетоны анги**

| Бетоны анги | Шоон дээжний 28 дахь өдрийн бат бэхийн жишиг үзүүлэлт |
|---|---|
| C 15 | 15 МПа |
| C 25 | 25 МПа |
| C 30 | 30 МПа |
| C 37 | 37 МПа |
| C 40 | 40 МПа |

(б) Ус/цементийн хамгийн их харьцаа

Барилгын ажилд хэрэглэх бетоны анги болон ус цементийн харьцааг чулууны ширхэглэлийн хэмжээнээс хамааран хүснэгт 13.4-д үзүүлсэний дагуу тогтооно. Энэ хүснэгтийн А , Б багана нь гадаргуу нь ил гарсан бетон хийцүүдэд (жишээ нь нимгэн хийцүүд, хүчитгэсэн багана, гүүрийн хавтан гэх мэт) хамаарна.

**Хүснэгт 13-4: Бетоны анги, бетоны бат бэх, ус цементийн харьцаа**

| Бетоны анги | Чулууны хамгийн их төлөвлөгөөт хэмжээ /мм/ | Хамгийн их ус цементийн харьцаа | | 150 мм-ийн шоон дээжний 28 дахь өдрийн дундаж бат бэх /МПа/ |
|---|---|---|---|---|
| | | А | В | |
| С 15 | 40 | 0.48 | 0.45 | 19.6 |
| | 20 | 0.48 | 0.45 | 19.6 |
| С 25 | 40 | 0.46 | 0.42 | 32.7 |
| | 20 | 0.46 | 0.42 | 32.7 |
| С 30 | 20 | 0.45 | 0.43 | 39.3 |
| | 10 | 0.45 | 0.43 | 39.3 |
| С 37 | 20 | 0.41 | 0.40 | 48.5 |
| | 10 | 0.41 | 0.40 | 48.5 |
| С 40 | 40 | 0.40 | 0.40 | 52.5 |
| | 20 | 0.40 | 0.40 | 52.5 |

(в) Зуурмагийн орцын нормыг төсөллөх

Гүйцэтгэгч нь энэхүү Техникийн шаарлагад нийцүүлэн бетон зуурмагийн орцын нормыг тогтоохдоо зөвхөн инженерийн зөвшөөрсөн бүрэлдэхүүн материалаар дараах шаардлагад нийцүүлэн тодорхойлно. Үүнд:

(i) чулуулаг материалын ширхэглэлийн нарийн хуваарь нь хамгийн том тооцоот хэмжээнээс 150 μм хүртэл байна,

(ii) цементийн агууламж хүснэгт 13.4-д өгөгдсөн бетоны бат бэхийг хангахуйц хэмжээтэй байна,

(iii) бетоны бат бэхийг хангахад шаардлагатай цементийн хамгийн бага агуулга хүснэгт 13-5-д үзүүлсний дагуу байна.

**Хүснэгт 13-5: Цементийн хамгийн бага агууламж**

| **Хийцийн төрөл** | **Цементийн хамгийн бага агууламж (нягтруулсан бетоны 1м$^3$ ногдох кг-р)** |
|---|---|
| Энгийн бетон | 360 |
| Хүчитгэсэн бетон | 400 |

(iv) бетон зуурмаг нь арматур болон бусад саад бэрхшээлийг үл харгалзан цутгах болон нягтруулахад хялбар байхаар өтгөн байна,

(v) Инженер өөрөөр заагаагүй бол агааржуулагчийг хүснэгт 13-6-д үзүүлсэн агаарын агууламжийг хангах хэмжээгээр бетонд нэмж холино.

**Хүснэгт 13-6: Хүйтэнд тэсвэртэй чанарыг хангах агаарын агууламж**

| **Чулууны заагдсан хамгийн их хэмжээ** | **Агаарын хэмжээ** |
|---|---|
| 40 мм | 2-4 % |

| | |
|---|---|
| 20 мм | 3-5 % |
| 10 мм | 3-5 % |

(i) ус цементийн харьцаа нь зуурмагтай ажиллахад хялбар байх нөхцөлийг хангахад шаардлагатай хамгийн бага хэмжээтэй, гэхдээ чулуулаг материал мөн ус агуулдгийг харгалзан хүснэгт 13-4-д үзүүлсэн хэмжээнээс ихгүй байна,

(ii) AASHTO T160 стандартын дагуу тодорхойлсон бэхжсэн бетоны уртын өөрчлөлт 0.05%-аас илүүгүй байна,

(iii) цемент, ус ба нэмэлт бүхий хольцны хлорын ионоор илэрхийлэгдсэн хлорын нийт агууламж нь хольц дахь цементийн жингийн хувиар илэрхийлэгдсэн дараах хязгаараас хэтэрч болохгүй.

- Уураар бэхжүүлсэн бетон буюу сульфатанд тэсвэртэй цемент агуулсан бетонд: жингийн 0.05 %,
- Бусад хүчитгэсэн бетонд: бүх туршилтын 95%-д 0.3 % (0.5%-ээс дээш дүн гараагүй бол)

(iv) цемент, ус ба нэмэлт бүхий хольцны $SO_3$–р илэрхийлэгдсэн сульфатын нийт агууламж чулууны жингийн 0.4%-иас ихгүй, ба цементны жингийн 4.0%-иас хэтрэхгүй байна.

(v) C40 ангийн бетоны гулзайлтын (3 шооны 28 хоногийн дараах дундаж) бат бэх нь орц норм тогтоолтын үед 5МПа буюу түүнээс дээш байна.

Байнгын барилгын ажлын бетон цутгах ажлыг талбайд эхлэхээс 56 хоногийн өмнө гүйцэтгэгч бетоны марк болон өтгөрөлийн түвшин тус бүрээр орцын норм боловсруулж инженерт танилцуулна.

Орцын нормын төлөвлөгөө нь дараах мэдээллийг агуулсан байна. Үүнд:

- цементний төрөл,
- цементний хэмжээ, кг/ м$^3$,
- чулууны ширхэглэлийн хэмжээ ба ширхэглэлийн хуваарь,
- норгоод хатаасан чулууны жин, кг/м$^3$,
- зуурмаг дахь нийт усны хэмжээ, кг/м,$^3$ үүний дотор зуурах ус, нэмэлтэн дэх ус, чулуун материал дахь ус (норгоод хатаасан чулууны ус орохгүй),
- AASHTO T119-ийн дагуу хэмжсэн бетоны тооцоот суулт,
- агааржуулагч бодисны үйлдвэрлэгчийн нэр, 1 м$^3$–д орох тун,
- агаарын агууламжийн хязгаар,
- зөөлрүүлэгч, тусгаарлагч бодис болон бусад нэмэлт бодисуудыг үйлдвэрлэгч ба, тэдгээрийн 1 м$^3$–д орох тун.

## 1305 ТАЛБАЙН ТУРШИЛТ

Бетон зуурмагийн орц нормыг инженер баталсны дараа бетоны зэрэглэл тус бүрээр шаардлага хангаж байгаа эсэхийг тогтоохоор туршилтын зуурмагийг хийхээр бэлдэнэ.

Гүйцэтгэгч талбайн туршилтыг барилгын ажилд ашиглахаар төлөвлөж байгаа завод дээр гурван удаа зууралт хийхээр зөвшөөрөгдсөн материалаа бэлдэнэ. Нэг удаагийн зууралтад орох материалын хэмжээ нь заводын бүрэн хүчин чадлаар ажиллуулахад орох хэмжээтэй ижил байна.

Зууралт тус бүрээс дээж авч дараах тур шинжилгээнүүдийг хийнэ. Үүнд:

(а) AASHTO T119 стандартын дагуу бетоны суултыг шалгах,

(б) зууралт бүрээс дээж авч BS 1881 дагуу туршилт хийнэ,

(в) зууралт бүрээс 12 ширхэг шоон дээж авч 7 болон 28 хоног лаборатори ба талбайд бэхжүүлэн бетоны бат бэхийн туршилт хийнэ,

(г) бат бэхийн туршилт хийхээс өмнө бүх шоон дээжний нягтыг тодорхойлно,

(д) AASHTO T160 стандартын дагуу тодорхойлсон бетон бэхжсэний дараах уртын өөрчлөлт 0.05 %-иас ихгүй байна.

Инженер зөвшөөрвөл бетоны суултыг тодорхойлогч конусны оронд бетоны хатуурлыг тодорхойлдог төхөөрөмжийг ашиглаж болно. Энэ тохиолдолд бетоны суулт ба хатуурлын итгэлцүүрийн хоорондох харьцааг талбайн туршилт хийх явцад тодорхойлж өгнө.

9 шооны 28 дахь өдрийн дундаж бат бэх хүснэгт 13-3-д үзүүлсэн дундаж бат бэхээс багагүй байх ба нэг ч шооны бат бэх хүснэгт 13-3-д үзүүлсэн дундаж бат бэхээс 3 МПа-аас доогуур байж болохгүй.

Талбайн туршилтууд техникийн шаардлагын заалтуудыг бүрэн хангасан тохиолдолд туршилтын зууралтын орцыг тухайн ангилал болон өтгөрөлийн зэрэгтэй бетоны орцын нормоор батална. Бетоны тусгай зэрэглэл дэх шаардлагыг хангаж байгаа төлөвлөсөн зуурмагийг зөвшөөрөгдсөн зуурмаг гэх бөгөөд бетоны зэрэглэлийг тодорхойлсон үед гүйцэтгэгч зөвхөн зөвшөөрөгдсөн зуурмагийг хэрэглэх ба инженер бичгээр зөвшөөрөл өгөөгүй тохиолдолд өөр зуурмаг хэрэглэхгүй. Хэрвээ гүйцэтгэгч материал, материалын эх үүсвэр болон материалын харьцаанд өөрчлөлт оруулахаар төлөвлөж байгаа бол инженерээс урьдчилсан зөвшөөрөл авч талбайн туршилт болон бүх холбогдох туршилтыг хийж инженерт танилцуулж зөвшөөрөл авна.

Гэрээний нөхцөлийн дагуу гүйцэтгэгч ажлын хөтөлбөртөө туршилтын зуурмагийг бэлтгэх, талбайн туршилт хийх ба туршилт хийх дээжийг бэлтгэх зэрэг ажлуудыг оруулж өгнө.

## 1306 БЕТОН ХИЙЦИЙН ЧАНАРЫН ХЯНАЛТ

(а) Дээж авах

Цаашид энэхүү техникийн шаардлагын болон BS 1881-д дурдсан аргачлалын дагуу барилгын ажилд ашиглагдах бетоны ангилал болон өтгөрөлтийн түвшин бүрээр хольж байх үед буюу төслийн чанарын хяналтын төлөвлөгөөнд заагдсан буюу инженерийн зааварчилсан үед дээж авна.

Хэрэв инженер өөрөөр заагаагүй бол дээж бүрээс 150мм-ын 6 ширхэг шоо авч талбайд цутгасан бетоны адил арчилж бэхжүүлээд 3 шоонд 7 хоног дахь, 3 шоонд 28 хоног дахь бетоны бат бэхийн туршилтыг BS 1881 Хэсэг 3-ын дагуу хийж хийцийн бат бэхийг хянана . Мөн зэрэгцээ 6 ширхэг дээж авч лабораторийн нөхцөлд бэхжүүлэн, дээрх стандартын дагуу туршилт хийж орцын бат бэхийг хянана.

Дээж бүрийг сонгож авсан нэг зууралтаас тохиолдлын журмаар дээж авах ба дээж бүр нь 50 $м^3$-аас ихгүй бетоныг төлөөлнө.

Бетон хучилтын гулзайлтын бат бэхийг 7 блон 28 хоног бэхжүүлсэн 3 шооны дундаж үр дүнгээр хянана. Инженер өөрөөр заагаагүй бол бетон хучлагын тухайн өдрийн дэвсэлт 500 метрээс бага байвал 1 багц, 500-1000 метр байвал 2 багц, 1000-1500 метр дэвсвэл 3 багц дээж авна. (1 багц нь 150x150 мм-н 6 ширхэг дээж байна.)

Инженер өөрөөр заагаагүй бол бетон зуурмаг нь техникийн шаардлагатай нийцэж буй эсэхийг тогтоотол нэг дээж 20 т-оос илүүгүй бетон зуурмагийг төлөөлж байхаар шинжилгээг явуулна.

Гүйцэтгэгч дээж авах, шоо цутгах, арчлах, бэхжүүлэхэд инженерийг байлцуулах ба хэрэв байлцуулаагүй бол тухайн шоо нь чанарын хяналтын туршилтад тэнцэхгүй гэж үзнэ.

(б) Туршилт хийх

(i) Өтгөрөл

Бетоны суулт ба нягтрууалтын итгэлцүүрийг инженерийн зааварчилсан давтамжаар зууралт бүрт тодорхойлно.

Ямар ч зууралтын бетоны суулт нь талбайн туршилтаар тогтоогдсон хэмжээнээс 20мм-ээс буюу аль их байгаа хэмжээний гуравны нэгээс илүүгээр зөрж болохгүй.

Бетоны суултын оронд хатуурлын итгэлцүүрийг ашигласан бол хатуурлын итгэлцүүр нь дараах хязгаарт хэлбэлзэнэ:

- 0.9 түүнээс дээш ±0.03
- 0.8 - 0.9 ±0.04
- 0.8 ба түүнээс доош ±0.05

(ii) Ус/цементийн харьцаа

Аливаа зууралтаас авсан дээжний (i)-д гарсан дүнгээс тооцсон ус/цементийн харьцаа нь талбайн туршилтаар тогтоосон хэмжээнээс 5-аас илүү хувиар өөрчлөгдөх ёсгүй.

(iii) Агаарын агууламж

Агааржуулах бодис хийсэн аливаа бетон зуурмагийн агаарын агууламж нь дэд зүйл 1304 (в) (v) -ийн 13-6-р хүснэгтэд үзүүлсэн хэмжээнд байна. (шинэхэн зуурсан зуурмагийн эзлэхүүний хувиар илэрхийлэгдэнэ). Туршилтыг AASHTO T196 дагуу явуулна.

(iv) Үзүүрлэг хавтгайлагийн индекс

Хэрэв том ширхэглэлтэй буталсан чулууны үзүүрлэг хавтгайлгийн индекс нь батлагдсан зуурмагийн чулуулгийн дундаж үзүүлэлтээс 5-аас илүү нэгжээр зөрж, улмаар зуурмагийн хөдөлгөөнт чанарт сөргөөр нөлөөлбөл талбайн туршилтуудыг эхнээс нь дахин хийнэ.

(v) Бетон шоог шахалт болон гулзайлтад турших

Шооны шахалтын болон гулзайлтын бат бэхийг BS 1881 -ийн дагуу тогтооно.

Шооны шинжилгээний дүнг зөвшөөрөгдсөн маягт дээр үзүүлэх ба дараах мэдээллийг агуулсан байна:

- шооны дугаар,
- шооны хэмжээ ба жин,
- шоог хийсэн өдөр,
- шоог хийсэн бетоны ширхэглэл,
- бетоны дээжийг авсан бүтэц дэх байршил,
- бетоны суулт,
- шоог туршсан өдөр,
- туршилтын явцад хагаралтын үеийн нийт ачаалал,
- туршилтын явцад хагаралтын үеийн нийт даралт, МПа.

Дээр дурдсан мэдээллийг агуулсан гэрчилгээний 2 хувийг инженерт явуулж, 1 хувийг лабораторид үлдээнэ.

(в) Шооны туршилт хүчинтэй байх

Бетоны нэг зуурмагаас авсан гурван шоог 28 дахь хоногт шахахад гарсан шахалтын бат бэхийг дунджаар тооцно. Хэрвээ гурван шоог туршиж үзэхэд шахалтын бат бэх нь тэдний дундаж шахалтын бат бэхийн 15%-аас бага байгаа

тохиолдолд л туршилтыг хүчинтэйд тооцно.

Дээр дурдсан туршилтын үр дүн хүчинтэй гартал техникийн шаардлагын дэд зүйл 1306 (г)-д тодорхойлсон хяналтын аргыг хэрэглэхдээ 28 дахь хоногийн бетоны бат бэхийг авч үзэх ба ийм тохиолдолд туршилтын бүх дүн бат бэхийн жишиг үзүүлэлтээс 3 МПа-аас бага байж болохгүй ба дараалсан гурван туршилтын дундаж бат бэх бат бэхийн жишиг үзүүлэлтээс 2 МПа-аар их буюу түүнээс дээш байх ёстой.

Хэрэв дараалсан гурван туршилтын дундаж бат бэх нь бат бэхийн жишиг үзүүлэлтээс 2 МПа-аар их байж чадахгүй хэдий ч бат бэхийн жишиг үзүүлэлттэй ядаж тэнцүү байвал ийм бетоныг зөвшөөрч болох боловч гүйцэтгэгч орцын норм болон хяналтын стандартад тохируулга хийх хэрэгтэй.

Инженер зөвшөөрвөл 7 хоног дахь бат бэхийг бат бэхийн эхний үзүүлэлт гэж үзэж болох юм.

(г) Бетоны бат бэхийг зөвшөөрөх шалгуур үзүүлэлтүүд

Ямар ч зэрэглэлийн гэхдээ ижил өтгөрөлттөй бетоноор аливаа нэг зуурагчид зуурсан 30-аас доошгүй дараалсан зууралтын туршилтын дүн бүгд хүчинтэй гарвал даралтын дундаж бат бэх нь [бат бэхийн жишиг үзүүлэлт + 1.7х тэдгээрийн нормын хэлбэлзэл]-тэй тэнцүү байх ба шоо бүрийн бат бэх нь бат бэхийн жишиг үзүүлэлтийн 85%-иас их байна.

(д) Шаардлага хангаагүй туршилтууд

Хэрэв дараалсан гурван туршилтын аль нэгийн бат бэх нь бат бэхийн жишиг үзүүлэлтийн 85%-иас бага байгаа боловч энэ гурван туршилтын дундаж бат бэх техникийн шаардлагын дэд зүйл 1306 (в) буюу (г)-д заасан шаардлагад нийцэж буй бол зөвхөн нормд хүрээгүй шоо авсан зууралтыг шаардлага хангаагүйд тооцно.

Хэрэв дараалсан гурван туршилтын хоёрынх нь дүн бат бэхийн жишиг үзүүлэлтийн 85%-иас бага байгаа буюу дундаж бат бэх нь бат бэхийн шаардлага хангаагүй бол гурван зууралтыг бүгдийг шаардлага хангаагүйд тооцож гүйцэтгэгч нэн даруй инженерийн зөвшөөрөлтэйгөөр орцын нормыг өөрчлөх арга хэмжээ авч техникийн шаардлагын зүйл 1305-д нийцүүлнэ.

Гүйцэтгэгч шаардлага хангахгүй байгаа бетоныг сайжруулах талаар зохих арга хэмжээг авна. Үүний дотор:

- хяналтын туршилт дахин амжилттай болтол туршилтын давтамжийг нэмэгдүүлэх,
- бетоноос өрөмдлөгөөр дээж AASHTO T24 дагуу турших,
- бетоныг бэхжүүлэх болон бусад сайжруулах арга хэмжээ авах,
- ачаалалд дам нуруу эвдрэхгүй байх туршилт хийх,
- бетоныг солих буюу авч хаях

Хэрэв бетоноос авсан гурван дээжний дундаж даралтын бат бэх бат бэхийн жишиг үзүүлэлтийн 85%-иас их байгаа боловч дээж тус бүрийн бат бэх 75 %-иас бага байвал инженер өөрийн эрх мэдлийн дагуу уг бетоныг хэвээр үлдээж болно.

## 1307 БЕТОНЫГ ХОЛИХ

Гүйцэтгэгч хэрэглэх гэж байгаа тоног төхөөрөмжөө захиалах буюу талбайд авчрахаас өмнө өөрийн хэрэглэхээр төлөвлөсөн бетоныг зуурах, холих, тээвэрлэх, хийх, нягтруулах ба тэгшилж засах зэрэг ажлууд болон авах арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг зургийн хамтаар инженерт танилцуулна.

Бетоныг гараар зуурч болохгүй. Хэрвээ инженер өөрөөр заагаагүй бол ажилд хэрэглэгдэх бетоныг нэг буюу түүнээс дээш төв заводуудад зуурч, холино. Хэрвээ гүйцэтгэгч бэлэн хольсон бетон хэрэглэхийг хүсвэл уг бетон хольцны талаарх бүх мэдээлэл болон хийсэн шинжилгээний дүнгийн хамт инженерт танилцуулна. Бетоны хольц дараах шаардлагыг хангасан тохиолдолд инженер бэлэн зуурмаг хэрэглэхийг зөвшөөрнө. Үүнд:

(а) тухайн зуурмаг, ашиглах материал, болон хадгалах ба зуурах аргачлал нь энэүү техникийн шаардлагатай нийцэж байгаа,

(б) зуурах үед зохих хяналт тавьдаг,

(в) бэлэн зуурмаг нь AASHTO M157 стандартын шаардлагыг хангасан эсэх

Хэрэв инженер зуурмагт хэрэглэж буй материал болон зууралтад тавьж байгаа хяналт хангалтгүй байна гэж үзвэл бэлэн зуурмаг хэрэглэхийг зогсоож болно.

Зуурах ба холих завод нь орчин үеийн AASHTO M241-ийн жигдрэлийн шаардлагыг хангасан, нэгэн жигд өтгөрөлттөй бетоныг үйлдвэрлэж гаргах чадалтай байна. Бетон зуурмагийн машин нь нь BS 4251-ын шаардлагыг хангасан байх ба Инженерээс урьдчилсан зөвшөөрөл авсан тохиолдолд л хэрэглэнэ.

Бүх холих, зуурах ажиллагааг туршлага бүхий хяналтын хүнээр хянуулна.

Чулуу хадгалах бункерүүд нь ус гадагшлуулах тоноглолтой байх ба гадагшлах ус нь жигнэх тасалгаа руу орохгүй байх арга хэмжээ авсан байна. Бункер бүрийг долоо хоногт нэгээс доошгүй удаа суллаж тэнд хуримтлагдсан шавар шавхайг зайлуулна.

Цемент ба чулууг жигнэж хэмжинэ. Усыг жингээр буюу эзлэхүүнээр хэмжиж болно. Шингэн нэмэлтийг цахилгаан хяналттай шингэн хэмжигчээр хэмжин хийнэ.

Жигнэх төхөөрөмжүүдийг байнга арчилж байх хэрэгтэй. Тэдгээрийн нарийвчлалыг AASHTO M241-т өгөгдсөн зөвшөөрөгдөх хэмжээнд байлгах ба инженер шаардсан үед жин ба эзлэхүүний нарийвчлалыг шалгаж байна.

Цемент, ус, нэмэлт ба чулуулаг материалын ширхэглэл бүрийн жин нь хүснэгт 13-8-т өгөгдсөн зөвшөөрөгдөх зөрүүгийн хэмжээнд байна.

**Хүснэгт 13-8: Бетон хольцны орцын зөвшөөрөгдөх зөрүү**

| Орцын зөвшөөрөгдөх зөрүү | Жингийн хувь |
|---|---|
| Цементийн жин | 0-ээс + 4 |
| Жижиг чулууны жин | -2-оос + 2 |
| Том чулууны жин | -2-оос + 2 |
| Нэмэлтүүд | -2-оос + 3 |
| Ус | -1-ээс + 1 |

Гүйцэтгэгч жин болон бусад хэмжилтийн туслах хэрэгслүүдийн найдвартай ажиллагааг шалгахдаа стандартын хамгийн хүнд ачаалал авдаг жин дээр хамгийн их ажлын ачааллаар жигнэж шалгана.

Шалгалтын долоо хоногт нэгээс доошгүй удаа буюу инженерийн зааварчилсан давтамжаар инженерийг байлцуулан гүйцэтгэнэ. Энэ зорилгоор ажилтнууд жигнэх бункерт хялбар хүрэх бололцоотой байх ёстой. Гүйцэтгэгч дээрх шалгалтын дүнг хоёр хувь үйлдэж инженерт хүргүүлнэ.

Цаашид техникийн шаардлагын дагуу найдвартай ажиллах нөхцөлийн хангах зорилгоор гүйцэтгэгч жигнэх болон ус хэмжих төхөөрөмжийн шаардлагатай тохиргоо болон засвар үйлчилгээг хийнэ.

Жигнэж хэмжсэн материалыг холигч руу оруулах явцад салхи буюу бусад нөлөөллөөр жингийн алдагдал гаргахгүй байх аргаар холигчид хийнэ. Гүйцэтгэгч жигд өтгөн зуурмаг үйлдвэрлэхэд шаардлагатай материалыг зуурагчид хийх хамгийн тохиромжтой арга

болон дараалыг талбайн туршилтаар тогтооно.

Холигчийг бункер болон тогооны тооцоот хүчин чадлаас хэтрүүлж ачааллаж болохгүй. Эргэлтийн хурд ба зуурах хугацааг үйлдвэрлэгчийн зааврын дагуу тохируулах боловч хэрэв усыг хамгийн сүлд хийж байгаа бол ус хийсний дараа 1-ээс доошгүй минут хутгана. Материал сайн тарж зуурмаг нэгэн жигд өнгө өтгөрөлттөй болтол зуурна.

Холигчийн тогооны хутгануудыг үйлдвэрлэгчийн заасан зөвшөөрөгдөх хүлцэх алдааны дотор засварлаж, арчилж байх шаардлагатай бөгөөд хүлцэх алдааны дотор тохируулга хийх боломжгүй болсон тохиолдолд хутгануудыг сольж байна.

Зуурагч нь хэдэн зууралт хийснийг харуулдаг автомат тоолуураар тоноглогдсон байх ёстой.

Хольцонд нэмэх усыг том ба жижиг ширхэглэлтэй чулуунд агуулагдсан усны хэмжээгээр хасна. Энэ хэмжээг гүйцэтгэгч инженерийн зөвшөөрсөн аргаар өдөр бүр хольцыг зуурч эхлэхийн өмнө, зуурч байх явцад цагт нэг удаа мөн зууралтын явцад чулуулаг материал авчирч буулгах бүрт тодорхойлно. Техникийн шаардлагын дагуу тодорхойлсон хэмжээний усыг хольцод нэмж хийсний дараа холих үед болон хольсны дараа ус нэмэхгүй.

Гүйцэтгэгч бетоны суулт техникийн шаардлагын 1306 (б) (i) дэд зүйлд заасан хүлцэх алдааны хүрээнд байхаар бүх шаардлагатай чийгийн тохиргоог хийнэ.

Зууралт дуусаны дараа холигчийг дараагийн зууралтын материалыг хийхээс өмнө сайтар суллана.

30-аас илүү минут сул зогссон холигчийг шинэ материал хийхээс өмнө сайтар цэвэрлэж дуусаны дараагаар эхний зууралтад том ширхэгтэй чулуулаг материалыг ердийн зууралтынхаас 2 дахин бага хэмжээгээр хийж зуурна. Зууралтыг ердийнхөөс 1 минут илүү гүйцэтгэнэ.

Цементийн маркийг өөрчилж байгаа бол холигчийг шинэ материал хийхээс өмнө сайтар цэвэрлэнэ.

Холигч угаасан усыг гол ба гадаргуун бусад усны эх үүсвэр лүү шууд хийж болохгүй. Ашигласан усыг техникийн шаардлагын 1303 (в) дэд зүйлд заасны дагуу инженерийн зөвшөөрсөн аргачлалаар зайлуулна.

## 1308 БЕТОН ЗУУРМАГИЙГ ТЭЭВЭРЛЭХ

Гүйцэтгэгч бетон зуурмагийг зуурч байгаа газраас цутгах газарт нь хүргэж, тээвэрлэхдээ бетон бохирдох, хатах, материалаар ялгарах буюу урсахаас сэргийлэх бөгөөд хэвэнд бетоныг цутгаж эхлэхэд зуурмаг хөдөлгөөнт чанараа алдаагүй байна. Холигчоос цутгах газар луу тээвэрлэх явцад бетоны суултын хэмжээ 25 мм-ээс илүүгээр багасч болохгүй.

Холигчоос цутгах газар луу тээвэрлэх хугацаа аль болох богино байх ёстой ба эхний бетоны цутгалт ба нягтруулалт дуусахаас өмнө очсон байх ёстой. Хоцорч ирсэн бетоныг барилгын ажилд хэрэглэхийг зөвшөөрөхгүй.

Зуурмаг ирэх хоорондын хугацаа 20 минутаас хэтрэхгүй байх ба цутгаж буй бетон нь нэгэн жигд цутгамал байж, хийцийн дотор аливаа заадас гарахаас сэргийлнэ.Тээврлэлтийн явцад бетоныг нар, салхи, борооны сөрөг нөлөөллөөс хамгаалсан байх ёстой. Бетон зуурмагийг саяхан цутгасан шинэ бетоны бэхжилт дуустал нь хажуугаар ойр буюу дээгүүр тээвэрлэж болохгүй.

## 1309 БЕТОН ЗУУРМАГИЙГ ЦУТГАХ

(а) Цутгах зөвшөөрөл

Инженер бичгээр зөвшөөрөл өгтөл ямар ч бетоны ажлыг эхэлж болохгүй. Гүйцэтгэгч бетон цутгах гэж байгаа тухайгаа 24 цагийн өмнө инженерт бичгээр мэдэгдэнэ.

Бетон цутгаж эхлэхээс өмнө хэв хашмалаас өмнөх цутгалтаас үлдсэн зуурмаг болон бусад гадны материал хогийг гаргаж хаяна.

Инженер зөвшөөрөл өгсөнөөс хойш 24 цагийн дотор бетон цутгах ажлыг эхлүүлнэ. Хэрэв гүйцэтгэгч энэ хугацаанд цутгалтыг эхэлж чадахгүй бол инженерийн зөвшөөрлийг хүчингүйд тооцож гүйцэтгэгч дахин зөвшөөрөл авна.

(б) Бетон дэвсэх гадаргууг бэлдэх

Бетон цутгах ухмалыг энэ техникийн шаардлагын бүлэг 700-д заасны дагуу бэлдэнэ.

Ухмалд тогтсон усыг шуудуу татах буюу бусад тохирох аргаар зайлуулна. Гүйцэтгэгч шинээр цутгасан бетон болон түүний бүрэлдэхүүн хэсгүүдийг угаагдахаас хамгаална. Ухмалын ёроолоос доош хийгдсэн аливаа ус зайлуулах хоолой буюу нүхийг шаардлагагүй болмогц инженерийн зөвшөөрсөн аргаар бөглөж шавардсан байна.

Хуучин бетон гадаргууд шинэ бетон цутгахаас өмнө дараах арчлалтыг хийнэ :

- Хуучин бетон гадаргууг чулуулаг материалыг ил гартал нугардаггүй хялгасан шүүрээр угаана,
- Хуурай, чулуулаг материал нь ил гарсан гадаргуу дээр шинэ бетон цутгана,
- Гадаргуу нь цэвэр, хатуу, хуурай ба бат бэх байна.

Хэрэв угаах явцад гадаргуун хагаралууд цэвэрлэгдэж ил гарвал тэдгээрийг шавар буюу бетон зуурмагаар дүүргэж бөглөнө. Нэг удаад дүүргэх зуурмагийн хэмжээ нь уг гадаргууд бетон дэвсэх үед дүүргэсэн зуурмаг хатаагүй байхаар тохируулна..

(в) Дэвсэх ажиллагаа

Бетон дэвсэх төлөвлөгөө батлагдмагц дэвсэх дараалыг уг төлөвлөгөөтөй уялдуулна.

Бетон дэвсэхэд ашиглах бүх тоног төхөөрөмж нь сайн чанарын хийц, хүчин чадал бүхий байх ба хольц ба зуурмаганд материалын ялгарал үүсгэхээргүй ажиллана. Эдгээр тоног төхөөрөмж нь шинэ тавьсан бетоныг доргиож гэмтээхээргүй байна. Мөн эдгээр нь бетонтой урвалд орох хөнгөн цагаан материалаар хийсэн эд ангитай байж болохгүй. Дэвсэх төхөөрөмжид наалдсан аливаа зуурмагийн үлдэгдлийг дараагийн цутгалт хийхээс өмнө цэвэрлэж хаясан байна.

Бетон зуурмагийн шахуургууд нь үргэлжилсэн горимоор бетоныг нэгэн жигд урсгалаар, дундаа агаарын зай гаргалгүй шахаж ажиллана. Бетон зуурмагийн шахалтын ажил дуусаны дараа насосны хоолойд үлдсэн зуурмагийг шинэхэн дэвссэн гадаргууг бохирдуулалгүйгээр шахан гаргах хэрэгтэй.

Гүйцэтгэгч бетоныг 1,5м-ээс дээш гүнд чөлөөт уналтаар цутгаж болохгүй. Чөлөөт уналтын өндрийг 1,5м-ээс доош болгох үүднээс уян хошуу хэрэглэнэ. Бетон зуурмагийн машинд үйлдвэрлэгчээс суурилуулсан хоолойноос өөр хоолойг хэрэглэхийг зөвшөөрөхгүй.

Хана, багана ба бусад нимгэн мөртлөө нилээд өндөр хэсгүүдийг цутгахдаа бетоны түвшинээс дээш гарсан хэв хашмал ба арматур дээр хатуурсан бетон хуримтлагдах болон бетоны ялгарал үүсэхээс сэргийлж хэв хашмалд нээлхий гаргаж өгнө.

Хамгийн эхэнд цутгах бетоны чулуулаг материалын хэмжээ ердийнхөөс 2 дахин бага байна.

Бетоныг хольцонд цемент хольсноос хойш 2-оос хэтрэхгүй цагийн дараа цутгаж бэхжүүлнэ. Гүйцэтгэгч хольцонд ус нэмж бетоныг зөөлрүүлж болохгүй.

Тээвэрлэх явцад хагас хатуурсан бетоныг ажилд хэрэглэхгүй. Бетон зуурагчаас бетон дэвсэх газар хүртэлх зуурмаг тээвэрлэх ажлын аргачлал нь энэ шаардлагыг хангасан байна.

Бетоныг түүнийг цутгах газартай аль болох ойр буулгана. Бетоныг цутгахдаа

материалын ялгарал үүсгэхгүй, хэв, арматур болон бусад суулгаж тогтоосон зүйлсийн байрлалыг өөрчлөлгүйгээр гүйцэтгэнэ.

Гүйцэтгэгч хэвэнд цутгасан бетоныг хүрзээр шилжүүлэх ба доргиураар шилжүүлэхийг хориглоно. Гүйцэтгэгч тусгай баг бүрдүүлэн бетон цутгах болон нятруулах ажлыг гүйцэтгэх ажилчдыг ажиллуулна.

Инженер өөрөөр заагаагүй бол бетоныг үе үеэр, бүтээцийн залгаасын хавтгайтай паралелаар, нягтруулсан үеийн 500мм-ээс илүүгүй зузаантай дэвсэнэ. Эдгээр үеүд нь буталсан чулууны хамгийн том ширхэгийн хэмжээг 4 дахин авсан хэмжээнээс нимгэн байж болохгүй.

Үеүдийн ирмэгийг тэгш гаргаж өгнө. Гүйцэтгэгч хийцийн хэсэг бүрийн бетоныг цутгахдаа зурагт үзүүлсэн хийц болон хэв гажилтын заадсын хооронд зогсолтгүйгээр үргэлжлүүлэн цутгана. Хүргэлтийн хугацаа, дэвсэх дараалал ба аргачлал нь хүйтэн залгаас үүсэхээс сэргийлсэн байх ба ямар ч тохиолдолд бэхжиж эхэлсэн материал дээр шинэ бетон хийхгүй.

Бетоныг ямар ч залгаасгүй нэгэн жигд цутгамал үүсгэн тасралтгүй ажилбараар цутгана. Бетоныг суурь дахь аливаа саад, гадаргуун гэмтлийг тойруулан бүх хэсгүүд нь ижил нягтрал авч чадахаар нямбай цутгана. Мөн угсарсан арматур болон ган төмрүүд болон бусад бетон цутгасны дараа бетоны гадаргуугаас дээш гарах хийцүүдийг тойруулан нямбайлан цутгах хэрэгтэй.

Зууралт бүрийн бетоны бүх ажлыг бетон бэхжиж эхлэхээс өмнө дуусгасан байх ёстой.

Бетоныг цутгах үед ба цутгаж дуусаны дараа бетоныг гэмтээхгүй байх, арматур төмрийг зангилааг хугалахгүй байх талаар анхаарах хэрэгтэй. Ажилчид шинэ тавьсан бетон дээр гишгэж болохгүй ба ажилчид болон тоног төхөөрөмжид зориулсан тавцанг арматур төмөртөй хамт бэхэлж болохгүй. Бетоныг бэхжиж эхэлснээс хойш ба бетоныг гүйцэд сайн хатууртал бетоноос цухуйж гарах хэв болон арматур төмрийг хөдөлгөхийг хориглоно.

(г) Усан дор бетон цутгах

Усан дор буюу эрдэс шаврын дор бетон цутгах шаардлагатай бол Гүйцэтгэгч цутгах аргачлал болон ашиглах тоног төхөөрөмжийн талаарх саналаа инженерт танилцуулна. Бетон зуурмагийг гарах амсартаа таглаа бүхий юүлүүр хэлбэртэй хоолойгоор эсвэл бетоноор дүүргэх үед ус орохоос хамгаалсан тоноглол бүхий хоолойтой бетон шахагчаар цутгана.

Бетон дамжуулах хоолой нь хэд хэдэн хэсгээс залгагдаж бүтсэн ус нэвтэрдэггүй хоолой, ус нэвтэрдэггүй, оройдоо юүлүүртэй 250мм-ээс доошгүй голчтой, резинэн цагираг зэргээс бүрдэнэ. Хоолойн гарах үзүүрийг нийт цутгах талбайд чөлөөтөй хөдөлгөх боломжтой ба зуурмагийн хурдыг огцом багасгах буюу зогсоох тоногололтой байна. Хоолойг бетоноор дүүргэхээс өмнө ус орохоос сэргийлж гарах амсрыг хаалттай байлгана. Хоолойг юүлүүрийн ёроолын түвшин хүртэл байнга бетон зуурмагаар дүүргэсэн байх ба бетоны устай харьцах талбайг аль болох багасгах үүднээс үзүүрийг бетон зуурмаганд дүрсэн байна. Хэрэв бетон дэвсэж эхэлсэний дараа хоолой руу ус орвол хоолойг гарган авч суллаад гарах амсарыг дахин бөглөнө. Үүний дараа хоолойг шинэ зуурмагаар дүүргэж ус руу хийнэ. Цутгаж дуустал зуурмагийн урсгалыг тасалж болохгүй.

Бетон шахаж байх үед дамжуулах хоолойн гарах амсар үргэлж зуурмагаар дүүрсэн байх ба цутгалт дуустал хоолойн гарах амсрыг цутгаж буй бетонд дүрээстэй байлгана.

Аль ч нөхцөлд бетонд ялгарал үүсгэхгүй байх талаар анхаарах ёстой.

Усан дор цутгах бетоны цементийн хэмжээ нь усанд угаагдсан алдагдлыг нөхөх үүднээс тухайн марк ба өтгөрөлттөй ердийн бетоноос 10 хувиар илүү байна.

Усан дор буюу эрдэс шаврын дор дэвссэн бетоныг дараах аргаар нягтруулна. Үүнд:

(i) Бетон дамжуулах хоолойг зуурмагаар дүүргэхийн өмнө хоолойны ёроолд шилээгүүр доргиурыг оруулна,

(ii) Хоолойн амсрыг хаана,

(iii) Бетон зуурмагийг юүлүүр лүү хийж хоолойг дүүргэх явцад доргиурыг хоолой дахь бетоны бүх агаарыг хөөж гаргахаар удаан гаргаж авна,

(iv) Доргиурыг, юүлүүрээс хоолой руу шинэ зуурмаг өгөхөд дамжуулах хоолойн хана руу доргилт өгөлгүйгээр зуурмагаас агаарыг гаргах боломжтой тийм байрлалд байрлуулна,

(v) Цутгалт үргэлжлэх явцад зууралт хооронд хэт их доргилт өгөхгүйн тулд доргиурыг асааж унтраан зохицуулна.

Бетоныг насосоор шахаж цутгах үед насос руу орсон хоолой дахь бетоныг ижил аргаар нягтруулна.

Усан дор буюу эрдэс шаврын дор бетон дэвсэхдээ тасралтгүй үргэлжилсэн ажиллабараар гүйцэтгэх ба цутгаж буй гадаргууг аль болох хэвтээ хэлбэрээр гаргана. Насос болон хоолойнуудын гарах амсрын орчин тойрны усыг хөдөлгөөнгүй, тогтонги байлгана.

Бетоны үеүдийг хооронд нь сайн барьцалдуулах үүднээс эхний үе бэхжиж эхлэхээс өмнө дараагийн үеийг цутгах хэрэгтэй. Гүйцэтгэгч их хэмжээний зуурмагийг цутгахад энэ шаардлагыг хангахад хүрэлцэхүйц тооны машин тоног төхөөрөмжтэй байх ёстой.

Хэрэв усан дор бетон цутгах үед буюу цутгаж дууссаны дараа цутгасан газрыг хүрээлсэн усыг шавхаж гаргах нь шинэ цутгасан бетоны гадаргууд сөргөөр нөлөөлөх бол ус шавхаж болохгүй.

Бетон цутгах ба бэхжүүлэх явцад гидростатик даралтыг тэнцвэржүүлж бетон руу ус орохоос хамгаалах зорилгоор ус нэвтэрдэггүй, дотроо хуурай бөгөөд хөндий камер оруулна.

Техникийн шаардлагын зүйл 1306-д заасан туршилтад тавигдах шаардлагаас гадна гүйцэтгэгч цутгаж дуусаад 7 хоносны дараа бетон тус бүрээс инженерийн заасан цэгт хоёр дараалсан дээж өрөмдөж авна. Дээжийг бетоны нийт зузаанаар өрөмдөж авах ба өрөмдлөгөөс гарсан нүхийг сайтар бөглөх арга хэмжээ авна. Дээж 50мм-ээс доошгүй голчтой байна.

Багана буюу тулгуур бүрийг хэт авианы багажаар шалгана. Хэрэв бетоны бат бэх шаардлага хангахааргүй байвал инженер дахин өрөмдлөгөөр дээж авч нийт цутгалтын чанарыг шалгахыг шаардаж болно. Гүйцэтгэгч нийт хийцийг даралтат зуурмагаар засах, хэврэг бетоныг зайлуулах буюу инженерийн баталсан бусад аргаар засварлана. Дээж авах, туршилт шинжилгээ хийх, бат бэхийн шаардлага хангаагүй бетоныг засварлах, дээж авсан нүхийг бөглөх зэрэг ажлыг гүйцэтгэгч өөрийн зардлаар гүйцэтгэнэ.

(д) Цутгалтыг зогсоох

Хэрвээ бетоны ажил ямар нэг шалтгаанаас болж зогссон ба хир зэрэг удаан зогсох нь тодорхойгүй буюу удаан зогсохоор бол гүйцэтгэгч аль болох тэгш бус гадаргуу болон өнцөг үүсгэхгүй тулд ажлын залгаасыг яаралтай хийх арга хэмжээ авна. Дэвссэн бетоныг техникийн шаардлагын зүйл 1311-ийн дагуу сайтар нягтруулна. Бүх бетоны ажлыг бетоныг налархай байхад нь амжиж хийж дуусгах ба дараа нь түүнийг ямар нэг эвдрэлийг эсэргүүцэх чадвартай болж хангалттай хатуурах хүртэл нь гар хүрэхгүй орхино. Ийм тохиолдолд ашиглах машин тоног төхөөрөмж байнга бэлэн байх ёстой.

Ийм зогсолтын дараа бетоны ажлыг дахин эхлэхэд гүйцэтгэгч бүх эвдэрсэн буюу нягтруулагдаагүй бетон, барзгар ирмэг, эсвэл бусад тохиромжгүй зүйлсийг хуулж авч зайлуулаад шинэ бетон хийх цэвэр, бат бэх гадаргууг техникийн шаардлагын 1309 (б) дэд зүйлийн дагуу бэлдэнэ.

Бүх бетоны ажлын турш туршлага бүхий хэвний болон арматурын ажилчдыг ажиллуулна. Эдгээр хүмүүс нь хэв хашмалыг техникийн шаардлагад нийцүүлэх, түр ажлын залгаасуудыг зөв гаргах, арматур төмрүүд ба бэхэлгээнүүдийг зөв байрлуулах зэргийг хариуцна.

Инженерийн зөвшөөрөлтэйгөөр техникийн шаардлагад нийцүүлэн бетоны ажлыг дахин эхлүүлэх боломжтой болбол ямарваа хүйтэн залгаас гаргалгүйгээр шинэ бетоныг хуучин бетон дээр дэвсэж нягтруулна.

(е) Цутгах хэмжээ

Инженерээс өөрөөр заагаагүй бол цутгалтын өндөр 2м-ээс илүүгүй байна. Бетоныг цутгах нийт талбайд жигд зузаантайгаар цутгалтын нийт өндрөөр цутгана.

Гүйцэтгэгч цутгалтын хэмжээ болон дараалыг дулааны өөрчлөлт буюу агшилтын улмаас хагарал үүсэхгүй байхаар төлөвлөх хэрэгтэй.

(ё) Цутгах дараалал

Гүйцэтгэгч бүтээцийн нэг хэсэг дэх босоо элементүүдийн цутгалтын хоорондох хугацааг ижил байлгах арга хэмжээ авна. Энэ хугацаа нь инженер өөрөөр заагаагүй бол цаг агаарын таатай нөхцөлд 3-7 хоног байна.

Хэрэв инженер бетоны агшилтын улмаас ажлын залгаасыг багасгахыг шаардвал шинэ бетон зуурмагийг 21 хоног болоогүй гадаргууд дэвсэхгүй. Хэрэв зурагт ажлын залгаас хийхээр үзүүлсэн бол тэдгээрийн өргөн ба урт нь зурагт үзүүлсний дагуу байх ба зурагт заасан хугацааг өнгөртөл тэдгээрийг дүүргэж болохгүй.

## 1310 БЕТОНЫГ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛӨӨС ХАМГААЛАХ

(а) Ерөнхий

Гүйцэтгэгч бетоныг хийх, арчлах явцад цаг агаарын ба орчин тойрны нөлөөллөөр эвдрэл үүсэхээс хамгаалж урьдчилсан сэргийлсэн арга хэмжээ авна.

Цаг агаарын нөлөөллийн улмаас бетон хөлдсөн буюу эвдэрсэн тохиолдолд инженерийн зөвшөөрөх хэмжээнд хүртэл засах буюу хуулан авч шинээр цутгана.

Бетоныг дэвсэж эхлэхийн өмнөх температур нь техникийн шаардлагад өөрөөр заагаагүй бол 10°C-32°C-ын хооронд байна. Гүүрийн хавтангийн бетоныг дэвсэх үеийн температур нь 27°C байна.

(б) Бороноос хамгаалах

Хэрэв инженерийн үзэж байгаагаар ширүүн буюу удаан орох бороо нь шинэ бетоны ил гарсан гадаргуугийн том ширхэгтэй чулуулгийн зуурмагийг угаан урсгаж болзошгүй байвал гүйцэтгэгч, хэрвээ дэвссэн бетоны гадаргуу дээрх усыг зайлуулах буюу ус цугларахаас хамгаалж чадахааргүй бол бетон дэвсэх ажлыг зогсооно. Бетоны ажлыг ус тогтсон хэсгүүдэд хийхгүй.

(в) Халуун агаараас хамгаалах

Хэрвээ орчны температур 32°C-ээс дээш байвал хэв хашмал, арматур төмөр, төмөр дам нуруу ба бусад шинэ бетонтой шууд харьцах гадаргууг 32°C-ээс доош температуртай болтол нь ус шүрших юм уу бусад зөвшөөрөгдсөн аргаар хөргөнө.

Бетоныг дэвсэх үеийн температурыг тогтоосон температурын хэлбэлзэлд барихад доорх аргуудыг хослуулан хэрэглэнэ. Үүнд:

- материал хадгалах газрыг сүүдэрлэх,
- үйлдвэрлэгч төхөөрөмжийг сүүдэрлэх,
- чулуун материалыг ус шүршиж хөргөх,
- чулуун материалыг ба усыг хөргөгчид хийж хөргөх, эсвэл хольцонд хийх усны заримыг буюу бүгдийг нь жижиглэж буталсан мөсөөр орлуулах,
- шингэн нитроген цацах.

Хуурайшил ихтэй нөхцөлд болон инженерийн зааварчилсан үед шинэ бетон гадаргуугийн чийг ууршихаас сэргийлж доорх аргуудыг хослуулан хэрэглэнэ. Үүнд:

- тохирох материалаар бүтээх,
- нарны хаалт хэрэглэх
- салхинаас хамгаалах
- эсвэл ус цацаж гадаргууг чийгтэй байлгана.

Инженер бетон дэвсэхийг хойшлуулж өдрийн арай сэрүүн үед хийхийг шаардаж болно.

(г) Хүйтэн нөхцөлөөс хамгаалах

(i) Холих ба дэвсэх

Инженер шаардсан үед гүйцэтгэгч талбайд халуун хүйтэн хэмжигч 2 термометрийг суурилуулна.

Бетоныг доорх нөхцөлд халаахгүй болон хөлдөлтөөс хамгаалахгүйгээр цутгаж болохгүй:

- агаарын температур буурч байгаа үед 7°C-аас доош байвал
- агаарын температур өсч байгаа үед 3°C-доош байвал

Агаарын температур 5°C-аас доош байвал 300мм зузаан бетоны дэвсэх үеийн температур 15°C-аас доош байж болохгүй. Агаарын температур ямар байгааг үл харгалзан мөстэй буюу хөлдсөн хэсгүүдтэй чулууг зууралтанд оруулж болохгүй ба 0°C буюу түүнээс доош температуртай аливаа гадаргуу дээр бетон дэвсэхгүй.

Хэрвээ бетон дэвсэх үеийн орчны температур хасах хэмтэй байна гэж инженер үзэж байвал, гүйцэтгэгч ус ба чулуун материалыг халаах арга хэмжээ авна. Бетоныг цутгаж дууссаны дараа бүтэн 8 өдрийн турш хөлдөхөөс сэргийлж хамгаална.

Дүүргэгчийг 20°C ба 65°C-ийн хооронд, усыг 55°C ба 65°C-ийн хооронд халаана. Бетоны зуурмагны температур нь хэвэнд цутгах үед 15°C ба 25°C-ийн хооронд байна. Халаагч төхөөрөмж нь чулууг хэт халуун цэгүүд үүсгэлгүй нэгэн жигд халаана.

Халаагч төхөөрөмж ба байр нь цутгалт дууссанаас хойш бүтэн 5 өдрийн турш шинэ бетоны орчны температурыг 20°C - 30°C-ийн хооронд барих чадвартай байх ёстой. Дараачийн гурван өдөрт бетоны температурыг 5°C хүртэл хөргөнө. Халаагч төхөөрөмжийг хэв хашмал ба бетон гадаргууг шууд халаахгүй байхаар байрлуулна.

Агаарын температур -10°C-ээс доош байвал бетоныг гадаа цутгаж болохгүй бөгөөд түр байр дотор холигчоо оруулж цутгалт хийнэ. Хэрэв холигч байрны гадна байх шаардлагатай бол зуурмагийг түр байрны бүтээлгийг цоолж суулгасан бункерээр дамжуулан цутгах байр луу өгнө.

Агаарын температур -10°C-ээс дээш байвал гүйцэтгэгч түр байрны жижиг хэсгийг богино хугацаанд онгойлгож цутгалтын ажлыг гүйцэтгэж болно.

Орчны хасах хэмийн температурт бетон дэвсэхээс өмнө гүйцэтгэгч, халаах төхөөрөмжийн ажиллагааг шалгах зорилгоор 20°C хүртэл халааж бетоны ажил эхлэхээс өмнө 24 цагийн турш энэ дулааныг хадгална.

Гүйцэтгэгч халаах төхөөрөмж болон бүх шаардлагатай түлшээр хангана.

(ii) Эхний арчлалт

Гүйцэтгэгч цутгасан бетоноо хуурайгаар арчлахаар төлөвлөж байгаа бол байран доторх чийгшлийг хангах ба бетоныг хуурайшлаас хамгаалах арга

хэмжээ төлөвлөж инженерээр батлуулна. Хэрэв халаах төхөөрөмж нь утаа буюу хий ялгаруулдаг бол байрыг байнга агааржуулж байна.

Байрны хэмжээ нь бетон зуурмаг цутгах болон хэв хашмалыг салгаж авахад хүндрэл учруулахгүй байх ёстой. Хэв хашмалыг салгаж авсны дараа бетоны зүлгэх өнгөлгөөг халаалт зогсоохоос 3 хоногийн өмнө дуусгасан байна.

Гүйцэтгэгч халаах ажиллагааг байнгын хяналт ба удирдлагаар хангана.

Агаарын температур гэнэт унах буюу халаах төхөөрөмж эвдэрсэн үед хэрэглэх нөөц халаах төхөөрөмж болон түлшийг хангалттай хэмжээгээр нөөцөлсөн байна.

(iii) Усан дор цутгах

Орчны хасах хэмийн температурт усан дор бетон дэвсэхээс өмнө гүйцэтгэгч коффердам дахь усны температурыг 5°C-аас доошгүй халаана. Бетон цутгаж дуусаад усыг шавхахаас өмнө гүйцэтгэгч коффердам дахь усны температурыг 5°C-аас дээш хэмд барина.

(д) Сульфат ихээр агуулсан хөрс буюу уснаас хамгаалах

Сульфат ихээр агуулсан хөрс буюу уснаас хамгаалах талаар гүйцэтгэгч анхаарах ёстой. Гүүрийн тулгуур, тулгуурын бусад хэсгийг AASHTO M85 II-р ангиллын шаардлага хангасан портланд цементээр хийнэ. Ийм газраас авсан усыг бетон арчлахад хэрэглэж болохгүй.

Зуурмагт хийх усыг сайтар шалгаж бетоны нэвчимхий чанарыг аль болох бага байлгах ёстой. Бетоныг хамгийн их нягт автал нь нягтруулна. Бетоны гадаргуугаас арматур хүртэлх хамгийн бага зай 50мм байна. Бетон цутгасны дараа 7-оос дээш хоносны дараа хэв хашмалыг салгаж болно. Гадаргуун нүх хонхорхойг шавах, хэвний бэхэлгээг авах зэргээс бусад тохиолдолд гадаргууд хүрч болохгүй. Урьдчилан цутгасан бетон хийцтэй ажиллахад аливаа хэв гажилтын хагарал гаргахгүйн тулд тусгай тоноглол хийж өгнө.

## 1311 БЕТОНЫГ НЯГТРУУЛАХ

Бетоныг дэвссэн үеийн нийт хэмжээнд сайтар нягтруулна. Хэв хашмал, арматур ба бусад суурилуулсан зүйлсийг хөндөлгүйгээр тэдгээрийн эргэн тойронд нь сайтар нягтруулж өгнө. Нарийхан болон бусад хязгаарлагдмал хэсгүүдэд болгоомжтой ажиллах хэрэгтэй. Нэг цутгалтаас дараалан гарсан үеүдийг хамтад нь нягтруулна.

Бетоныг механик гүний доргиулагчийн тусламжтайгаар нягтруулна. Гүйцэтгэгч гүүрийн хавтанг цутгахдаа гадаргуун өнгөлгөөг хийхэд дан ганц доргиулагч хангалтгүй тохиолдолд хос хөндлөвчтөй доргиур нэмж ашиглаж болно.

Гүний доргиурыг минутанд 7,000-10,000 цохилттойгоор ажиллуулна. Сайн нягтруулахын тулд доргиурыг үйлдвэрлэгчийн зааварласан бүрэн даралт ба хүчдэлээр ажиллуулална. Хүснэгт 13-9-д гүний доргиулагчийн хэмжээ, ашиглалт болон хүчин чадлыг харуулсан болно.

**Хүснэгт 13-9: Гүний доргиулагчийн хэмжээ ба ашиглалт**

| Гүний доргиулагчийн голч, мм | Үйлчлэх радиус, мм | Нягтруулах хурд, $м^3$/цаг | Ашиглалт |
|---|---|---|---|
| 20 – 30 | 80 – 150 | 0.8 – 2 | 50мм ба түүнээс дээш суултууд болон маш нимгэн ба маш нарийн ба хязгаарлагдмал хэсгүүдэд |

| | | | |
|---|---|---|---|
| 35 – 40 | 130 – 250 | 2 – 4 | 50мм ба түүнээс дээш суултууд болон нимгэн хана, багана болон дунд зэрэг хязгаарлагдмал |
| 50 – 75 | 180 – 350 | 3 – 8 | 50мм ба түүнээс дээш суултууд болон хийцийн их биеээс дээш хэсэгт |

Хүснэгт 13-9-ийн дагуу нийт бетон зуурмагийг зохих хугацаанд нь нягтруулахын тулд гүйцэтгэгч доргиулагчийг хангалттай тоогоор бэлдэх шаардлагатай. Бетон дэвсэж буй газар бүрт хэзээ ч хэрэглэхэд бэлэн нөөц доргиулагчийг байлгана.

75мм-ийн болон үүнээс том чулуулаг агуулсан бетонд 100 буюу түүнээс дээш мм-ийн голчтой доргиулагч хэрэглэнэ.

Нягтруулалтыг бетон дэвссэн цэгт хийнэ. Зуурмагийг хэвтээ чиглэлд доргиулагчаар шилжүүлж болохгүй. Доргиулагчийг босоогоор өөрийн жингийн даралтаар зуурмагт оруулна. Үелсэн байдал үүсгэхгүйн тулд гүний доргиулагчийг урьд нь дэвссэн бетоны гүн рүү хийж нягтруулна. Бетон зуурмагийн нягтралт зогсож гадаргуу дээр зуурмагийн шингэн үе гарч ирэх ба агаар ялгарахаа болитол нягтруулна. Доргиулагчийг зуурмагаас гаргахдаа араас нь үүссэн зай нь бөглөрөхөөр удаан гарган авна.

Нягтруулалт сайн хийгдтэл доргилтыг үргэлжлүүлэх ба материалын ялгарал үүстэл удаан доргиулж болохгүй. Мөн доргилтыг нэг цэг дээр шингэн зуурмаг ялгартал удаан үргэлжлүүж болохгүй. Доргиулагчийг нийт зуурмагийн талбайд жигд ажиллуулж доргиулагч хийх цэгүүдийн хоорондох зай доргиурын ил харагдах үйлчлэх радиусаас 1.5 дахинаас илүү хол байж болохгүй.

Доргиулалтыг шууд арматур дээр эсвэл арматураар дамжуулан хийхгүй бөгөөд доргиулагчийг арматур, хэв ба бусад суулгасан зүйлд хүргэхгүй.

Бага голчтой доргиулагчийг гадаргуун болон өнцөг булангийн нягт, гөлгөр байдлыг хангах зорилгоор дагтаршуулагч хэрэгслээр нэмж тоноглож өгнө.

Багана, доод бүтээц, хоолойн хана болон бусад босоо элементүүдийг цутгаад хэсэг байлгах ба 1-2 цагийн дараа нягтруулалт хийнэ. Энэ нь хэвтээ элементийг цутгахын өмнө суултын хагарал үүсэхээс сэргийлэх зорилготой юм.

Инженер доргиулагчаар үүссэн нүхийг багасгаж бетоны гадаргууг сайжруулах буюу агшилтаас үүсэх хагарлаас сэргийлэх зорилгоор ийм бетоныг дахин нягтруулахыг шаардаж болно. Гэхдээ бетон хатуураагүй, доргиулагч доорх үеийн бетон руу өөрийн жингээр шигдэж байвал мөн доргиулагчийг гаргаж авсны дараах нүх нь өөрөө дүүрч байгаа нөхцөлд дахин нягтруулалт хийж болно. Гүйцэтгэгч бетоны марк, өтгөрөлтийн түвшин бүрээр хамгийн оновчтой хүлээх хугацааг талбайн туршилтаар тогтооно.

## 1312 БЕТОНЫГ АРЧЛАХ

(a) Ерөнхий

Бетоныг бэхжих явцад бетон чийгшлээ алдаж хатуурах ба бетоны доторх температурын өөрчлөлтөөс болж дулааны хагарал үүсэх зэргээс хамгаална.

Бетоныг арчлах арга нь бетоныг гэмтээхээргүй байна. Бэхжилт нь дээрх шаардлагыг хангатал үргэлжлэх боловч аль ч тохиолдолд 7 хоногоос багагүй байх ба дээр нь дараагийн бүтээц иртэл үргэлжилнэ.

Бетоны арчлалтыг арчлах ажиллагааг даах чадвартай болтол хатуурсан нөхцөлд эхлэх бөгөөд тасралтгүй буюу нилээд том талбайд цутгаж байгаа бол түрүүчийн цутгалт нь дуусан газраас эхэлж хийнэ.

Шинээр дэвссэн бетон бүрийг энд дурдсан аргуудыг аль нэгээр бетон хуурайшихаас сэргийлж арчилна. Арчлалт хийхээр сонгосон аргаа хэрэглэж амжаагүй байхад бетон хуурайшиж эхэлбэл бетоны гадаргууг гэмтээлгүйгээр ус

цацаж чийгтэй байлгана.

Уураар болон туяагаар халаахаас бусад аргаар хүснэгт 13-10-т өгөгдсөн хугацаанд зогсолтгүй үргэлжлүүлэн арчилна.

**Хүснэгт 13-10: Арчлалтын хамгийн бага хугацаа**

| Цементийн төрөл | Орчны дундаж температур 15° С -ээс их | Орчны дундаж температур 5° С-15° С | Орчны дундаж температур 5° С -ээс бага |
|---|---|---|---|
| 10%-аас бага пуццоллан нэмсэн портланд цемент | 7 өдөр | 10 өдөр | 14 өдөр |
| 10%-аас их пуццоллан нэмсэн портланд цемент | 10 өдөр | 15 өдөр | 20 өдөр |

Цаг агаарын халуун нөхцөлд, инженер шаардлагатай гэж үзвэл, шингэн мембран буюу газар дээр нь хэвлэх аргуудаар арчлалт хийгдэж байгаа бетонон гадаргууд ус цацаж өгнө. Усыг, инженер гадаргууг хөргөх шаардлагагүй болсон гэж үзэх хүртэл цацна.

Инженер зааварласан бол гүйцэтгэгч, дор дурдсан арчлалтын зарчмаас гадна нарны хурц туяа буюу салхи бетон гадаргууд хүрэхээс сэргийлж нар ба салхины хаалт зэргээр хангана.

(б) Материал

(i) Ус

Ус нь 1303 (ё) дэд зүйлийн шаардлагыг хангасан байх ёстой.

(ii) Шингэн мембран

Бетоныг арчлах шингэн мембраны хольц нь AASHTO M148-ын шаардлагыг хангасан байна.

(iii) Ус нэвтэрдэггүй материалаар хучих арга

Ус нэвтэрдэггүй цаас, полиэтилен хальсан материал,цагаан өнгийн тааран полиэтилен хулдаас нь AASHTO M171-ын шаардлагыг хангасан байна.

(в) Бетоныг арчлах аргууд

(i) Хэв хашлага ашиглах

Бетоны хэв хашмалыг нь авалгүйгээр шаардлагатай хугацааны туршид бэхжилтээ автал нь байлгаж арчилна.

(ii) Ус ашиглах арга

Бетоны гадаргуу дээр ус тогтоох, усаар шүрших, эсвэл байнга нойтон материалаар хучих замаар гадаргууг үргэлж чийгтэй байлгана. Эдгээр материалуудыг хөвөн, зулхай, олон давхар таар юм уу бусад зөвшөөрөгдсөн материалаар хийсэн байх ба будаг гардаггүй, бетонд ямар нэгэн байдлаар нөлөөлдөггүй байх ёстой.

(iii) Шингэн мембранаар арчлах холимог арга

Гадаргууг зүлгэж өнгөлөх шаардлагатай үед болон ажлын залгаасны гадаргууд шингэн мембраны аргыг хэрэглэж болохгүй. Гэхдээ залгаасан дээр бетон тавихаас өмнө элсэн шүршигчээр мембраныг арилгавал энэ аргыг хэрэглэж болно. Хоёрдугаарт зэрэглэлийн цагаан пигментыг зөвхөн гүүрний хавтангийн гадаргуу, ажил дуусаны дараа ил харагддаггүй буюу инженерийн зөвшөөрсөн бусад гадаргуу дээр хэрэглэнэ.

Шингэн мембраны аргыг хэрэглэх үед сул ус гадаргуугаас ууршмагц ил бетоныг мембраны уусмалаар богино хугацаанд бүрнэ. Хэвлэмэл гадаргуугийн хэв хашлагыг авч шаардлагатай өнгөлгөө хийж дуусмагц нэн даруй мембраны уусмалаар бүрнэ. Уусмалыг цахилгаан үүсгүүрээр ажилладаг шүршигчээр нэг юм уу хоёр удаагийн ажиллабараар шүршинэ. Гар ажиллагаат шүршигчийг багахан хэмжээний газарт инженерийн зөвшөөрөлтэйгөөр хэрэглэж болно.

Пигмент агуулсан мембраны уусмалыг хэрэглэхийн өмнө сайтар хольж хутгах ба хэрэглэх явцад хөдөлгөж сэгсэрнэ. Хэрвээ уусмалыг хоёр хувааж шүрших шаардлагатай гэж үзвэл эхний шүршилтийг хийсний дараа 30 минутын дотор хоёр дахь шүршилтийг хийнэ. Шүрших төхөөрөмжийг инженерээр батлуулсан байна. Гөлгөр гадаргуу дээр 1 литр бэхжүүлэх уусмалыг 0.2 хавтгай дөрвөлжин метр талбайд, барзгар гадаргууд 1 литр бэхжүүлэх уусмалыг 0.5 хавтгай дөрвөлжин метр талбайд тус тус ноогдохоор буюу инженерийн зааварчилсан хэмжээгээр нэгэн жигд бүрхүүл үүсгэж шүршинэ.

Хэрвээ шинэхэн шүршсэн мембраны хальс хангалттай хатаж гүйцээгүй байхад бороо орох юм уу арчлалтын явцад хальс ямар нэгэн байдлаар гэмтвэл тухайн газарт дээр дурдсантай ижил хэмжээгээр шинээр уусмалыг шүршинэ.

(iv) Ус нэвтэрдэггүй материалаар хучих арга

Энэ нь бетоны гадаргуугаас чийг алдагдахаас сэргийлж ус үл нэвтрэх материалаар хучих арга юм. Энэ арга нь чийгийн алдагдлаас сэргийлж чадна гэж инженер үзсэн тохиолдолд л энэ аргыг хэрэглэнэ.

Гадаргууг хучих үед бетон гадаргуу нойтон байх ёстой. Уг материал нь хангалттай хэмжээний өргөнтэй байх ба материалын зэрэгцээ эгнээнүүдийг 300-аас доошгүй мм-ээр зөрүүлж залгааг цавуутай лент, мастик цавуу юмуу бусад зөвшөөрөгдсөн аргаар сайтар битүүлж наагаад гадаргууг нийтэд нь хучина.

Хучлагыг салхинд хийсэхгүй байхаар бэхэлж өгнө. Бетоны бэхжилтийн хугацаа дуусахаас өмнө хучлагын аль нэг хэсэг урагдвал нэн даруй нөхөж засварлана. Уус үл нэвтрүүлэх чанар нь алдагдсан материалыг хучлаганд хэрэглэхгүй.

(v) Халаалттай байранд арчлах арга

Цаг агаарын хүйтэн нөхцөлд цутгасан бетоныг техникийн шаардлагын 1310 (г) дэд зүйлд заасны дагуу арчилна.

(vi) Уур болон туяагаар халаах арга

Энэ аргыг зөвхөн үйлдвэрт цутгасан бетон элементүүдэд хэрэглэж болно.

Уур болон цацрагт туяаны дулаанаар арчлах ажиллагаа нь тохиромжтой камерт хийгдэнэ. Зөвхөн бага даралттай, нойтон уурыг хэрэглэнэ. Температур заагч багаж нь камер дахь температур тогтоосон хязгаарт жигд тархсан эсэхийг зааж байх ёстой.

Бетоныг цутгаж дуусаны дараа бетоны эхний бэхжилтийг эхлүүлэхийн тулд бетоныг 3-5 цаг байлгасны дараа ууraар болон дулаанаар бэхжүүлнэ. Хэрвээ удаашруулагч бодис хэрэглэсэн бол уур болон дулаанаар арчлах арга хэрэглэх хүртэл хүлээх хугацааг инженерийн заасан хугацаагаар хойшлуулна. Эхний бэхжилтийн хугацааг AASHTO T197 стандартын дагуу тодорхойлсон бол хүлээх хугацааг ч үүнтэй уялдуулан тохируулна.

Хүлээх хугацаанд хатаах камерийн температурыг $10^0$C-аас доошгүй байлгах ба үүнийг уур болон дулааны температураар тохируулж болно. Энэ хугацаанд бетоны гадаргууг чийгтэй байлгах шаардлагатай.

Хэсэг газарт хэт халаалт үүсч болзошгүй учраас уурыг шууд бетон болон хэв рүү чиглүүлж болохгүй. Уур болон дулааныг нэмэгдүүлж өгөх үед камерт байх орчны температурыг цагт дунджаар 20-оос илүүгүй хэмээр өсгөж байх ёстой. Камерийн хамгийн их температур нь 71$^0$С-аас хэтрэх ёсгүй.

Төлөвлөсөн бат бэхийн хэмжээндээ хүртэл бетоныг хамгийн өндөр температурт байлгах ба туршилтын шоог урьдчилан хүчитгэсэн бетоны хамт ижил нөхцөлд арчилна.

Инженерийн баталсан агаарын температур хэмжигчийг бетон цутгаж дууссаны дараа хийцийн орой дээр байрлуулна. Нэмэгдүүлсэн дулаанаар бэхжүүлж дуустал дулаан хэмжигчийг хөдөлгөж болохгүй. Орчны температур болон цаг хугацаа заасан графикийг хийц бүрээр хийж бэхжилт хийж дууссаны дараа инженерт өгнө. Графикт дараах зүйлийг үзүүлсэн байна. Үүнд:

- хийцийн дэс дугаар №,
- цаг, өдөр, сар, жил,
- бетон цутгаж дууссан үе,
- Халааж эхэлсэн үе,
- Халааж дууссан үе
- бэхжилт дуусах үе.

Бэхжилт дууссаны дараа агаарын температурыг цагт 20-оос дээшгүй хэмээр аажмаар буулгах ба бетоныг камераас гаргахад гаднах температураас 6°С-аар их байх хүртэл бууруулна.

Бетон хийцүүдийг шаардагдах бат бэхийг автал хөлдөх температур хүртэл хөргөж болохгүй.

Дулаанаар арчлах аргад, уур, халуун ус, тос, усыг хоолойгоор дамжуулан эсвэл цахилгаан дулааны элемент ашиглан хэрэглэж болно. Дулаанаар арчлах аргыг дулаанаа хадгалж чадах камерт явуулах ба чийгийн алдагдлыг багасгах зорилгоор бетоны бүх ил харагдах гадаргууг полиэтилен хулдаас буюу зөвшөөрөгдсөн шингэн мембранаар бүрнэ.

Бетон элементүүдийн өөр бетон хийц болон материалтай шууд харьцах гадаргууг барьцалтын төлөвлөсөн хязгаарт бариулах үүднээс мембраны үлдэгдлээс цэвэрлэнэ.

Бетон цутгах аливаа ажлыг эхлэхээс өмнө гүйцэтгэгч бэхжүүлэх ажлын дэлгэрэнгүй төлөвлөгөөг инженерт танилцуулж батлуулна.

(г) Шинээр цутгасан бетоны температурын өөрчлөлтийг хязгаарлах

Гүйцэтгэгч бетон цутгасны дараа бетоны температурын өөрчлөлтийг хязгаарлах дараах арга хэмжээг нөхцөл байдалд тохируулан авна. Үүнд:

- Дэд зүйл 1310 (с)-ийн дагуу бетоны дэвсэх үеийн температурыг хязгаарлах,
- Инженер зөвшөөрсний үндсэн дээр бага дулаантай цемент ашиглах,
- Ил гарсан гадаргууг дулаан тусгаарлагчаар бүтээх,
- Салгаж аваагүй хэв хашмалыг дулаан тусгаарлагчаар хангах,
- Гадаргуу дулаанаа огцом алдахаас сэргийлж салхины хаалт хийх,
- Гадаргуу дээр ус тогтоох буюу ус шүрших нь гадаргууг огцом хөргөж байгаа бол эдгээр аргуудыг хэрэглэхгүй байх.

## 1313 АЖЛЫН ЗАЛГААС

Өмнө нь дэвссэн нэгэнт хатуурсан бетонд бетон залгаж дэвсэхэд тэдгээрийн хоорондох харьцах гадаргууг ажлын залгаас гэнэ.

Гүйцэтгэгч ажлын залгаасыг зурагт үзүүлсэн байрлалд хэвлэнэ. Ажлын залгаасын байрлалыг инженерээс урьдчилан зөвшөөрөл авсан байна. Налуу хавтан болон зурагт өөрөөр заасанаас бусад тохиолдолд ажлын залгаас нь хэвтээ буюу босоо хавтгайд байна.

Бүх төрлийн бетоны ажлын залгаасыг углуурга хэлбэрээр хийж сайн нягтруулж өгнө. Жижиг алгасалтай дам нуруу болон хавтангийн хүчитгэсэн бетон ба бэлэн цутгасан элементийн алинд ч залгаас байх ёсгүй.

Ажлын залгаасыг бетоныг дэвссэний дараах агшилтын нөлөөг аль болох багасгахуйц хэлбэрээр, хийцэнд ирэх ачаалал болон хөдөлгөөнт заадастай зохицох байдлыг харгалзан хамгийн тохиромжтой байрлалд хийнэ.

Ажлын залгаасны ирмэгийг арзгар гаргаж болохгүй ба залгаасаар цухуйн гарч ирсэн арматуртай хэсгийн залгаас арзгар байвал төмөр бетон хийцийг бүрэн бэхжсэний дараагаар арзгар ирмэгийг тайрч авна. .

Хэрэв тухайн нөхцөлд хэв хашмалыг салгаж авах боломжтой бол хэвийг салгаж авсаны дараа хэвтээ буюу хэвтээ залгаасуудын гадаргууг ижил аргаар арчилна. Хэв хашмалыг 72 цагийн дотор салгаж аваад бетоны гадаргууг чулуулаг материалыг ил гартал угааж шүүрдсэн тохиолдолд босоо залгаасын хэвлэмэл гадаргуунд удаашруулагч бодис түрхэж болно.

Ажлын залгаасыг дараах хэлбэрээр арчилна. Үүнд:

- хуучин бетон гадаргууг чулуулаг материалыг ил гартал угааж нугардаггүй хялгасан шүүрээр шүүрдэнэ,
- чулуулаг материал нь ил гарсан хуурай гадаргуу дээр шинэ бетон цутгана.
- гадаргуу нь цэвэр, хатуу, хуурай ба бэт бэх байна.

Дээрх арчилгааг хийх үед бетон хэтэрхий хатуурсан байвал, хэвлэмэл буюу сул гадаргууг механик аргаар, эсвэл чийгтэй элсээр буюу агаарын шахалттай зүүн буугаар шүршиж боловсруулна. Ийм арга хэрэглэсний улмаас гадаргуу дээр үүсэх нүхнүүдийн гүн нь 10мму–ээс их ба өнгөлсөн гадаргууд 40мм-ээс илүү ойр байж болохгүй. Ийнхүү хэвлэсэн гадаргууг бетоны ажил эхлэхээс өмнө сайтар угааж, хатаан орчин тойронд байгаа хайрга ба бусад сул материалуудыг зайлуулна.

Гүйцэтгэгч хуучин бетон гадаргуугаас цухуйсан бэхэлгээ болон арматурын төмөрт наалдаж үлдсэн бетон ба бусад материалыг тэдгээрийн бетон дахь барьцалтыг алдагдуулалгүйгээр цэвэрлэж зайлуулна.

Дэвсэх төхөөрөмж, залгаас, арматур болон хэв хашмалтай харьцахад тэдгээр наалдаж алдагдах шингэн зуурмагийн алдагдлыг нөхөх зорилгоор хатуурсан бетон гадаргуу дээр дэвсэх эхний үеийн бетонд байх ёстой чулуулаг материалын зөвхөн 50%-ийг хийнэ.

Инженер ажлын залгаас болон байрлалыг шалгаж үзээд зөвшөөрөл өгөхөөс нааш гадаргууд бетон дэвсэхгүй.

Инженерийн зааварласан газруудад хуучин ба шинэ бетонуудыг хооронд нь сайн барьцалдуулах үүднээс ажлын залгаасанд эпокси резин хэрэглэнэ. Эпокси резин хэрэглэх болон гадаргууг бэлдэхдээ инженерийн зааварчилгаа болон үйлдвэрлэгчийн зааврыг удирдамж болгоно. Эпокси резины төрөл болон үйлдвэрлэгчийг инженер зөвшөөрсөн байх ёстой.

Ажлын залгаас нь хоёр даацын элементүүдийг хооронд нь барьцалдуулалгүй залгах шаардлагатай бол гүйцэтгэгч тэдгээрийн дунд хоёр үе ус нэвтэрдэггүй барилгын цаас хийж өгнө. Цаасыг нугалж үрчийлгэлгүй тааруулж хийнэ. Илүү гарсан ирмэгийг цавуутай туузаар нааж бэхэлнэ. Хоёр үе барилгын хар цаасыг залгаасны нийт талбайд дэвсэнэ. Гүйцэтгэгч бетоны ажил хийх явцад цаасыг гэмтээхгүй байх талаар анхаарах ёстой.

## 1314 ХЭВ ГАЖИЛТЫН ЗААДАС

Гүүрний хэв гажилтын заадсын тухай энэхүү техникийн шаардлагын бүлэг 1400-д

заасан болно.

Хэв гажилтын заадас нь бетоны доторх дулааны болон бусад хөдөлгөөнийг хангахад зориулагдсан заадас юм.

Хэв гажилтын заадас гэдэг нь бетоны агшилт болон тэлэлтийг зохицуулах зориулалтаар бетоны дунд гаргасан зай юм. Хэв гажилтын заадас нь бетоны агшилт болон тэлэлтийг хангах ба тусгай дүүргэгчээр дүүргэгдэнэ. Хэв гажилтын заадсын байршлыг ажлын зураг буюу техникийн шаардлагад заасны дагуу тодорхойлно.

Хэв гажилтын заадсыг бетонд аливаа хагарал үүсэхээс өмнө, бетоны ирмэгийг үйрэх буюу бутралгүйгээр хөрөөдөх боломжтой болмогц хийнэ.

## 1315 УС ТОГТООГЧ

Ус тогтоогчийн тухай заалтууд нь шингэн зуурмаг тогтоогчид адил хамаарна.

Ус тогтоогчийг ажлын зурагт үзүүлсэн материалаар хийнэ. Гүйцэтгэгч ус тогтоогчийн материалын тухай дэлгэрэнгүй мэдээлэл болон дээжийг инженерт танилцуулж батлуулахаас нааш ус тогтоогчийн материалыг талбайд авчирч болохгүй. Дээжийн урт нь туршилт хийхэд хүрэлцэхүйц байна.

Ус тогтоогч нь хлорид, сульфат болон барилгын ажлын орчин тойронд байж болох бусад хортой бодисын нөлөөнд ордоггүй материалаар хийгдсэн байна. Резинэн ус тогтоогч нь байгалийн болон хиймэл резинээр хийгдсэн байх ба 25 °C-ын дулаанд хийсэн туршилтаар 500%-аар сунах чадвартай ба залгаасын 50мм-ээс доошгүй хөдөлгөөнийг даах чадвартай байна.

Поливинилхлорид (PVC)-р хийсэн ус тогтоогч нь PVC–ийн өөдөс агуулаагүй PVC–н полимерээс гаргаж авсан материалтай байна. Ийм ус тогтоогч 25°C-ын дулаанд хийсэн туршилтаар 225%-аар сунах чадвартай ба залгаасын 10мм-ээс доошгүй хөдөлгөөнийг даана.

Бага модулийн ус тогтоогчийг 25°C-ын дулаанд хийсэн 6 N/мм$^2$ хүчээр татах туршилтаар 200%-аар сунах чадвартай ба залгаасын 50мм-ээс доошгүй хөдөлгөөнийг даах ёстой.

Ус тогтоогч нь барилгын ажлын шаардлагын дагуу ажиллахад хялбар байхаар хангалттай урт байна. Амлуулах залгааснаас бусад резинэн ба хуванцар материалтай залгаасыг үйлдвэрлэгчээс нь бэлэн хийснээр авчирна. Амлуулах залгаасыг талбай дээр үйлдвэрлэгчээс хангасан тоног төхөөрөмж болон зааврааp хийнэ.

Ус тогтоогчийн материалыг тос болон бусад бодисоор бохирдуулж гэмтээхээс болгоомжлон талбайд хадгална. Резинэн болон хуванцар ус тогтоогчийг сэрүүн, агааржуулалт сайтай, нарны гэрэл шууд тусахааргүй газарт хадгална. Резинэн болон хуванцар ус тогтоогчийг залгаасны нэг талд нөгөө талын бетон дэвсэхээс 1 сар ба түүнээс дээш хугацааны өмнө бэхэлсэн бол ус тогтоогчийг нарнаас хамгаалж өгнө.

Ус тогтоогчийг бетон цутгах үед хөдлөхгүй байхаар хэв хашмалд бэхлэн өгч бетон цутгахаас өмнө тэдгээрийг аливаа хог, шавар, тосноос цэвэрлэж өгнө. Арматурын төмөрт сайтар уяж тогтоосон төмөр гогцоонд ус тогтоогчийг бэхлэх ба ямар ч тохиолдолд ус тогтоогчийг хадаасаар буюу бусад зүйлээр цоолж тогтоож болохгүй.

Бетон дэвсэх үед ус тогтоогчийг хөдөлгөлгүй тойруулан нямбай цутгаж сайтар нягтруулна. Ус тогтоогчийг хэвтээ буюу бараг хэвтээ байрлалд бэхэлж байгаа бол түүний дор хоосон зай үлдээхгүй байх хэрэгтэй.

Ус тогтоогчтой зэрэгцсэн хэв хашмалыг ус тогтоогчийг гэмтээлгүйгээр нямбай салгаж авна. Хэрэв талбайн нөхцөлд засварлах боломжгүйгээр эвдэрвэл инженер ус тогтоогч бэхэлсэн бетоны хэсгийг зайлуулан шинээр хийхийг шаардаж болно.

## 1316 ХЭВЛЭМЭЛ БУС ГАДАРГУУН ӨНГӨЛГӨӨ

Хэв хашмалтай харьцаагүй, хэвтээ буюу бараг хэвтээ гадаргууг зурагт заасан ангиллын дагуу дор тодорхойлсон аргаар өнгөлнө. Үүнд:

(a) UF 1 өнгөлгөө

Зурагт заасан буюу инженерийн зааварчилсан өнгөлгөөний ангиллаас дор ангиллын өнгөлгөө шаардах бүх гадаргууд UF 1 өнгөлгөөг хийнэ. Бетоныг нягтруулсны дараа нэн даруй тэгшлэгч рейкээр илүүдэл бетоныг хусан авч гадаргууг нэгэн жигд болтол тэгшилж засна.

(б) UF 2 Өнгөлгөө

Энэ өнгөлгөөг дээвэр, шалны хавтан болон бусад хатуу өнгөлгөө шаарддаггүй гадаргууд хэрэглэнэ.

Гадаргууг эхлээд UF 1 өнгөлгөөгөөр янзалж бетоныг нэлээд хатуурсны дараа модон буюу үйсэн хөвөгчөөр гадаргууг зөвхөн тэгшлэгч рейкийн мөрийг арилгах хэмжээнд тэгшилнэ.

(в) UF 3 Өнгөлгөө

Энэ нь түргэн урсгалтай усны үйлчлэлд өртдөг хэсгүүд буюу цаг агаарын үйлчлэлийг эсэргүүцэх чадвар болон гадаад үзэмж чухал байдаг даацын хэсгүүдийн гадаргууг нийвийгээр хатуу өнгөлгөө хийхийг хэлнэ. Эхлээд гадаргууг UF 2–ийн дагуу хөвөгчөөр дор дурдсан хүлцэх алдааны хязгаарт өнгөлнө. Гадаргуугаас чийгний давхарга алга болж бетон хангалтай хатуурсны дараа цахилгаан үүсгүүрт хөвөгчөөр нийвийний мөргүй, нягт, гөлгөр, жигд гадаргуу үүстэл өнгөлнө.

(г) Зорчих хэсгийн гадаргуун өнгөлгөө

Гүүрний хавтан болон дамжих хавтангийн гадаргууг төмөр замаар явдаг тараах төхөөрөмжөөр тэгшилнэ. Уг төхөөрөмж нь хавтангийн нийт өргөнд бэхлэгдсэн байна. Төмөр зам нь нэлээд бат бэх байх ба тараах ажилбарын явцад хотойхгүй байхаар ойр ойрхон зайнд бэхлэгдсэн байна. Төхөөрөмж болон төмөр замыг тэгшилгээний дараах бетон гадаргуу нь шаардлагатай дагуу болон хөндлөн хэвгийг хангасан байхаар тохируулдаг байх ёстой.

Бетон цутгаж эхлэхээс өмнө төмөр замыг газар дээр нь авчирч тэгшилгээ хийхээр төлөвлөсөн нийт уртын дагууд сайтар бэхэлж өгсөн байна. Төмөр замын урт нь тэгшилгээ хийхээр төлөвлөсөн уртын 2 үзүүрээс тараах төхөөрөмжийг бетоноо султгахад хангалттай зайгаар илүү гарсан байна. Шаардлагатай бол хэв хашмалын суулт, хотойлт, овойлт зэргийг харгалзан төмөр замын өндрийн төвшинг тохируулж болдог байх ёстой. Тараах төхөөрөмж нь талбайн нийт уртад тасралтгүй ажиллах хүчин чадалтай байх ёстой. Мөн урьд нь төлөвлөөгүй, тараах төхөөрөмжийн ажиллагааны үед үүссэн суулт буюу хотойлтыг засахад төмөр замыг тохируулж болдог байх хэрэгтэй.

Бетон цутгах талбайд байрлаж байгаа төмөр замын тулгууруудыг хэрэггүй болмогц бетоны түвшингээс доош 50–аас доошгүй мм байхаар тайрч зайлуулаад тулгуурын ороор гарсан зайг шинэ бетон зуурмагаар бөглөнө.

Гүйцэтгэгч бетон гадаргууг шалгах, засварын ажил хийх , тулгууraас үлдсэн нүхийг бөглөх, цахилгаан хөвөгч явуулах, арчлалт хийх зэрэг ажлуудыг гүйцэтгэх зорилгоор замын тэнхлэгийн дагуу хөдөлгөөнт гүүр хийж өгнө. Гадаргууг тэгшилсний дараах бүх ажлыг энэ ажлын гүүрэн дээрээс гүйцэтгэнэ. Гүйцэтгэгч ажлын гүүрэнд хүрэх бололцоотой болгохын тулд аль аль талдаа аюулгүйн хашлага бүхий, бат бөх явган зам барина.

Гүйцэтгэгч бетон зуурмагийг авчрахаас өмнө тараах төхөөрөмжийг бетон цутгах нийт талбайгаар ажиллуулж төмөр замын муруйлт, хавтангийн зузаан, арматурын төмөр ба гадаргуун түвшин хоёрын хоорондын зай зэргийг шалгаж бүх тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг баталгаажуулна. Шаардлагатай тохиргоог бетон дэвсэхээс өмнө хийж дуусгасан байна. Гүйцэтгэгч гүүрийн хавтан болон дамжих хавтны шинэхэн цутгасан хэсгээр бетон цутгаж дууссанаас хойш 48 цаг өнгөртөл хөнгөн даацын тоног төхөөрөмж явуулж болохгүй. Хэрэв инженер хавтан хангалттай бат бэхээ авч чадаагүй гэж үзвэл дээрх хугацааг сунгана.

Бетон 80% бэхжтэл ямар ч хүнд механизм гүүр болон дамжих хавтангаар явахгүй.

Тэгшлэх төхөөрөмж нь шаардлагатай дагуу болон хөндлөн хэвгийг гаргатал гадаргуу дээгүүр явна. Тэгшлэх төхөөрөмжийн урд талд бага зэргийн илүүдэл бетон байнга явж байх ёстой. Энэ илүүдэл бетоныг дэвсэж буй бетон руу хийж болохгүй бөгөөд цутгалтын зах руу аваачиж хаяна.

Өнгөлгөө хийх явцад илүү гарсан ус, шавар болон гадны материалуудыг буцааж хавтан руу хийж болохгүй ба тэгшлэгч рейкээр хавтангийн төвөөс захруу чиглүүлсэн хөдөлгөөнөөр гаргаж хаяна.

Бетоныг өнгөлөх зориулалтаар гадаргуу руу ус хийж болохгүй.

Гадаргууг тэгшилсний дараа 1316 (в) дэд зүйлд дурдсан UF 3 өнгөлгөө буюу цахилгаанаар ажилладаг хөвөгчөөр өнгөлгөө хийнэ.

Талбайд өнгөлгөө хийсний дараа гүйцэтгэгч 3 метрийн төмөр рейк гүүрийн тэнхлэгийн дагуу тавьж нийт гадаргууг шалгана. Захуудын шугам, тэнхлэгийн шугам болон тэнхлэг ба захуудын дундах цэгүүдийг мөн шалгах хэрэгтэй. 25 мм ба түүнээс зузаан материал нэмж дэвсэх шаардлагатай гадаргуун зөрүү рейкний хэмжилтээс 10 мм ээс илүү байж болохгүй.

Энэ хязгаараас илүү гарсан өөрчлөлтийг бетоныг бэхжихээс өмнө засаж залруулна.

Талбайг урьд шалгасан талбайн талыг давхардуулан шалгаж явна. Бусад бүх хэвлэмэл бус гадаргуу нь ажлын зурагт заасны дагуу байх ба хүснэгт 13-11-т тодорхойлсон хүлцэх алдааны хязгаар дотор хэлбэлзэх ба гадаргуун түвшин огцом өөрчлөгдөж болохгүй. Хэрвээ ажлын зурагт хүлцэх алдаа өгөгдсөн бол тэдгээрийг хүснэгт 13-11-т үзүүлсэн хүлцэх алдаанаас илүү хүчинтэйд тооцно.

**Хүснэгт 13-11: Хэвлэмэл бус гадаргуун тэгш байдлын хүлцэх алдаа**

| Өнгөлгөөний ангилал | Гадаргуу ба тэгш устай 3 метрийн рейк 2 хоорондох зөвшөөрөгдөх хамгийн их зай | Тогтоосон түвшин буюу байрлал ба 3 метрийн тэгш устай рейкийн хоорондох түвшин ба байршлын хамгийн их зөрүү |
|---|---|---|
| UF1 | 5 мм | + 10 мм буюу - 10 мм |
| UF2 | 5 мм | + 10 мм буюу - 10 мм |
| UF3 | 3 мм | + 5 мм буюу - 5 мм |

## 1317 ХЭВЛЭМЭЛ ГАДАРГУУН ӨНГӨЛГӨӨ

Бетон гадаргууг ажлын зураг дээр үзүүлсний дагуу дор заасан аргаар өнгөлж засна. Үүнд:

(а) Гадаргуун ердийн өнгөлгөө

Ажлын зураг дээр өөрөөр өгөгдөөгүй буюу инженер өөрөөр заагаагүй бол бетоны ил гарсан бүх гадаргууд ердийн заслыг хийнэ. Энэ заслаар сийрэгжиж арзайсан, цухуйсан зүйлс, овойлт, элдэв өнгө хувиралт, зураас юм уу бусад гадаргуугийн элдэв өө сэвийг арилгаж гөлгөр тэгш гадаргуу бий болгоно.

Стандартчилал, технологийн институтаас гаргасан PCI стандартын B-B дотор заслын 1 ангиллын наамал банз буюу усан онгоцонд хэрэглэдэг BS 1088 стандартын наамал банз аль эсвэл том хавтгайгаар үйлдвэрлэгддэг ижил төстэй материалаар хэв хашмалыг доторлоно. Наамал банз нь нэгэн жигд батлагдсан ширхэгтэй байна. Бололцоотой бол хавтангуудыг хооронд нь уран барилгын элементээр холбох буюу гадаргуун чиглэлийн залгаасыг тааруулж өөрчилнө. Хавтан буюу банзнуудын зузаан нь бетон цутгасны дараа бетоны даралтаар ямарваа нэг хэв мөр гаргахааргүй байна. Өөрөөр заагаагүй байвал хавтангуудыг

хооронд нь хэвтээ буюу босоо байдлаар залгана.

Шаардлага хангасан гадаргуун ердийн өнгөлгөө гэдэг нь төмөр зангилааг салгаж авсны улмаас гарсан нүхнээс бусад нүхийг бөглөх гэх мэт засвар хийх шаардлагагүй гэж инженер үзсэн гадаргууг хэлнэ. Сийрэгжиж арзайсан, цухуйсан зүйлс, овойлт, элдэв өнгө хувиралт, зураас юм уу бусад гадаргуугийн элдэв өө сэвийг инженерийн зөвшөөрсөн аргаар арилгана. Цементээр угаах юм уу гипсийг хэрэглэж болохгүй.

Хэвийг авсан даруй бетон гадаргуугийн согогийг инженерт мэдэгдэнэ. Гадаргуун согогийг техникийн шаардлагын дагуу инженерийн заасны дагуу засварлана. Хөндий газар буюу нүхийг тэр орчин тойронд хийсэн бетонтой адил чанар, хольц бүхий гэхдээ 2,36 мм шигшүүр дээр үлдсэн чулуу агуулсан цемент элсний зуурмагаар чигжиж нийт гүнд нь хүртэл дүүргэнэ. Нүх цоорхойг шавахад хэрэглэх шавар зуурмаг нь зууraад 1-ээс илүү цаг болсон чигжээс байж болохгүй. Цементэн зуурмаг хатсаны дараа нөхөөс хийсэн хэсгийг бусад гадаргуугийн хамт засч тэгшилнэ.

Суларч хөндийрсөн бетон ба муу барьцалдсан чулууг гарган авч хаяж техникийн шаардлагын зүйл 1321-ийн дагуу бат бөх бетон буюу шавар зуурмагаар бөглөн тэгшилж өгнө.

Хэрэв инженерийн үзэж байгаагаар бетоны гадаргуу ердийн өнгөлгөөний шаардлагад нийцэхгүй байгаа бол гүйцэтгэгч зүлгэх өнгөлгөөг техникийн шаардлагын зүйл 1317 (б)-ийн дагуу өөрийн зардлаар гүйцэтгэнэ.

(б) Зүлгэх өнгөлгөө

Зураг дээр өөрөөр өгөгдөөгүй бол энэ ажлыг засварын ажил гэж үзэх ба гүйцэтгэгчийн өөрийн зардлаар гүйцэтгэнэ.

Хэвийг салгаж авсны дараа зүлгэх өнгөлгөөг аль болох хурдан эхлүүлэх хэрэгтэй. Гадаргууг эхлээд техникийн шаардлагын 1317 (а) дэд зүйлд заасан ердийн өнгөлгөө хийнэ. Шавар зуурмаг бэлэн болмогц бетон гадаргууг цэвэр усаар сойздож норгоно. Үүний дараа цахилгаанаар ажилладаг чулуун өнгөлөгчөөр гадаргууг зүлгэж гадаргууг нялцгай болгоно. Гадаргуу дахь хэв хашмалын мөр, хонхойж буюу овойж илүү гарсан хэсэг болон бусад согогууд арилж гөлгөр гадаргуу үүстэл зүлгэнэ.

Зүлгэх явцад нунтаглагдаж гадаргууд үлдсэн нялцгай материалыг нийт гадаргууд жигд тарааж хатаана. Эцсийн өнгөлгөөг цахиурын карбид чулуугаар гадаргууг толигор, тэгш, жигд өнгөтэй болтол нь үрж хийнэ.

Эцсийн өнгөлгөөг хийж дуусаад гадаргууг хатсаны дараа сул шаврыг тааран материалаар үрж зайлуулна. Гадаргууд чанаргүй нөхөөс, шаваас, нунтаг ба элдэв ул мөр байх ёсгүй. Ямар ч тохиолдолд гадаргууг цементээр угаах юм уу гипсийг хэрэглэж болохгүй.

## 1318 ТУЛАХ ТҮР БАЙГУУЛАМЖ БА ХЭВ ХАШМАЛ

(а) Тулах түр байгууламж

Тулах түр байгууламжийн зураг төслийг инженерийн хүлээн зөвшөөрсөн, тулах түр байгууламж болон хэв хашмалын зураг төсөл хийх туршлага бүхий байгууллагаар хийлгэнэ. Гүйцэтгэгч бетоны ажил эхлүүлэхээс өмнө 21 хоногийн дотор, түр байгууламжийн нарийвчилсан ажлын зураг ба тооцоог инженерт танилцуулна. Ажлын зураг болон тооцоог мэргэжлийн зураг төслийн байгууллагаар баталгаажуулсан байх ёстой. Тооцоог хийхдээ бетоныг дэвсэх, нягтруулах, тэгшлэх, засварлахад шаардагдах тоног төхөөрөмж, дэвсэх дараалал ба хурдыг харгалзан үзсэн байх ёстой.

Гүйцэтгэгчээс ирүүлсэн түр байгууламж болон хэв хашмалын ажлын зураг болон тооцоог инженер баталсан ба үүний дагуу гүйцэтгэгч хэв хашмал болон түр байгууламжийг барьсан байсан хэдий ч хэв хашмал болон түр байгууламжийн

шаардлага хангасан эсэх болон аюулгүй байдлыг гүйцэтгэгч дангаар хариуцна. Гүйцэтгэгч хэв хашмал болон түр байгууламжийн зураг төсөл, барилга болон арчлалттай холбоотойгоор хүн буюу эд хөрөнгөнд гарч болзошгүй аливаа хохирлоос захиалагч ба инженерийг сэргийлнэ.

Тулах түр байгууламж болон хэв хашмал нь тухайн дэвсэх хурд болон аргачлалаар бетоныг дэвсэх болон нягтруулахад бетон хатуурч бэхжсэний дараа бетоны хэвлэмэл гадаргуу нь техникийн шаардлагын зүйл 1321-т заасан хүлцэх алдааны хязгаарт хэлбэлзэж, зурагт үзүүлсэн байрлалд байхаар, мөн ийнхүү тавьсан бетоны ачааллыг даах чадвартай байхаар тооцож баригдсан байна.

Инженер зургийг зөвшөөрсний дараа гүйцэтгэгч зургийн дагуу тулах түр байгууламжийг барина. Ажлын зурагт үзүүлсэн тулах түр байгууламжид өөрчлөлт хийхээр бол зураг төслийг боловсруулсан этгээдээр батлуулж инженерт танилцуулахаас нааш өөрчилж болохгүй.

(i) Ачаалал

Хэв хашмалд ирэх тооцоот ачаалал нь босоо чиглэлийн тогтмол ба хөдөлгөөнт бүх ачаалал ба хэвтээ чиглэлийн ачааллын нийлбэрээс бүрдэнэ.

Тогтмол ачаалалд барилгын ажилд хэрэглэж байгаа бүх материал болон хэв хашмалын нийт жин багтана. Бетон, арматур төмөр болон хэв хашмалын нийт жин нь ердийн бетоны жингийн 2.60 тн/м$^3$-ээс багагүй байна.

Хөдөлгөөнт ачаалал нь аливаа тоног төхөөрөмжийн гадаргуутай харьцаж байгаа цэгүүдэд төвлөрч ирэх ажиллагааны жин ба нийт талбайд ирэх 98 кг/м$^2$ -аас доошгүй жигд ачаа болон хавтангийн гадаад ирмэгт ирэх 112 кг/м ачаанаас бүрдэнэ.

Түр байгууламжийн холболтын системийг төсөллөхөд шаардлагатай хэвтээ ачаалал нь тоног төхөөрөмж, ажлын дараалал, шингэн бетоны тэнцвэргүй гидростатик хүч, урсалт, салхины хүч зэргээс үүдсэн хэвтээ ачааллын нийлбэрээс бүрдэнэ. Ямар ч чиглэлд ирж байгаа хамгийн бага хэвтээ ачаалал нь нийт тогтмол ачааллын 2 хувьтай тэнцүү байна.

Хуучин, шинэ эсвэл хэсэгчлэн бэлэн болсон хийцэд тулах түр байгууламжаас ирэх ачаалал нь авто замын гүүрний AASHTO, II Бүлгийн “Ачааллын тухай 8.15-р зүйлд зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрэхгүй байна.

(ii) Суурь

Түр байгууламжийг суулт өгдөггүй, ирж байгаа ачааллыг даах чадвартай материалаар хийгдсэн бат бэх суурин дээр суурилуулсан байна. Хэрэв суурь норох магадлалтай бол суурийн материалд үзүүлэх усны нөлөөг бодолцох хэрэгтэй. Хэрэв инженер шаардвал гүйцэтгэгч ачааллын туршилт хийж түр байгууламжийн суурийг төсөллөхөд тооцсон хөрсний даах чадвар нь тухайн хөрсний даах чадвараас илүүгүй гэдгийг нотолно.

Хэрвээ тулах түр байгууламжийг шаардлага хангасан суурь дээр суурилуулах боломжгүй бол түр байгууламжийг инженерийн шаардлагад нийцсэн бат бэх, туршигдсан тулгууруудаар тулж өгнө.

(iii) Хазайлт

Түр байгууламжийг, хэрэв инженер шаардсан бол, бэлэн болсон гадаргууд зохих хэвгий ба налуу гаргахын тулд түр байгууламжийн дам нуруу болон софит хэвний хооронд янз бүрийн хотойлттой гүдгэр хавтанцаруудыг бэхэлж барина. Гүйцэтгэгч тогтмол ачааллын улмаас үүсэх хазайлт ба бетоны дэвссэнээр үүсэж болох бусад хэв гажилтыг тооцсон байна.

Газар дээр нь цутгасан бетон хийцүүдийн хувьд, гулзайлтыг зохих гүдгэр хавтанцаруудаар зохицуулсан байсан хэдий ч түр байгууламжийн эд ангиудын гулзайлтын тооцоолсон хэмжээ нь тэдний уртын 1/240-өөс хэтрэх ёсгүй.

(iv) Чөлөөт зай

Инженер өөрөөр заагаагүй бол барилгын ажлын үеэр тээврийн хэрэгслийн хөдөлгөөн явж байгаа үед түр байгууламжийн доторх чөлөөт зайны өргөн нь түр байгууламжтай нийлэх замын өргөнөөс 1.5 метрээр их харин өндөр нь 4.5 м байна.

(v) Түр байгууламжийг барих

Тулах түр байгууламжийг даацын ган материалаар барина. Даацын ган хоолой нь 4мм-ээс доош нимгэн байж болохгүй.

Түр байгууламжийг зохих түвшинд угсрах, бетон цутгах үед бага зэргийн зохицуулалт хийх ба түр байгууламжийг бага багаар буулгах боломжтой болгох зорилгоор шон бүрт эрэг боолт, хос шаантаг болон бусад зөвшөөрөгдсөн тоноглолыг бэхэлж өгнө.

Үүнээс гадна гүйцэтгэгч хэв хашмалд тоолуур суулгах, түвшин ба чиг заах хатуу цэгт уртасгал холбох зэрэг зөвшөөрөгдсөн аргаар бетон цутгалтын үед түр байгууламжийн суултыг нарийн хэмжих хэрэгслээр хангана.

(б) Хэв хашмал

(i) Ерөнхий

Хэв хашмалыг мод ба төмөр болон бусад зөвшөөрөгдсөн материалаар доторлож хийсэн хийц байна.

Хэв хашмалыг түүнд ирэх аливаа даралтыг гажилтанд оролгүйгээр даахуйц, бат бөх байхаар хийнэ.

Хэв хашмал нь бетоны нүүрэн талд эвдрэл үүсгэлгүйгээр амархан салахаар хийгдсэн байх ба, хэрэв шаардлагатай бол, бетоны нүүр талуудын зөв байрлалыг хангах үүднээс бетоны байрлалыг бага зэрэг өөрчлөх зориулалттай хэрэгслээр тоноглогдсон байна. Хэв хашмалыг угсрахдаа шинэхэн бетоны жингийн үйлчлэлээр бий болох аливаа хөдөлгөөн, хазайлт буюу суулт зэргийг харгалзан үзэх ёстой.

Бетоны нүүрэн талыг инженерийн хүлээн зөвшөөрөх хэмжээнд нэгэн жигд бүтэц ба өнгө бүхий гөлгөр гадаргуутай байлгах зорилгоор хэв хашмалыг инженерийн стандартчилал, технологийн институтаас гаргасан PCI стандартын B-B дотор заслын 1 ангилалын наамал банз буюу усан онгоцонд хэрэглэдэг BS 1088 стандартын наамал банзаар доторлоно.

Бетоны ил гарах гадаргуугийн хэвийн залгаасууд нь, хэрэв өөрөөр заагаагүй бол, хэвтээ ба босоо байдлаар тэгш байрлуулагдсан, үргэлжилсэн байх юм уу эсвэл нэгэн жигд хээтэй байна. Хийцийн нийт хэсэг бүрт хэвний доторлогооны ижил төрлийн материал хэрэглэнэ.

Хэрвээ хэв хашмал цухуйсан байвал агаарыг гаргаж тэр хэсгийг сайтар нягтруулагдсан бетоноор дүүргэнэ.

30°-ийн налуутай буюу түүнээс эгц байдлаар бетон гадаргуу цутгахаар бол хэв хашмал ашиглана. Харин 20°-ээс бага налуутай хийвэл гадаргууг тэгшлэх аргаар налуу гаргана. 20°- 30° хоорондох налууг гүйцэтгэгч, хэрвээ бетоныг нягтруулах үед бетоныг байранд нь байлгаж чадах тусгай тэгшлэгч хавтан хэрэглэн гадаргууг тэгшилж чадахаа инженерт баталж чадахгүй бол хэв хашмал хэрэглэнэ.

Бетоны гадаргуу дээр хэвтээ ба налуу байдлаар хийгдсэн хэв хашмалыг шинэ бетоны хийн даралтын улмаас дээшээ өргөгдөхгүй байхаар сайтар бэхэлнэ. Бетоны их бие доторх нүхний хэв хашмалыг хөвөхөөс сэргийлж арга хэмжээ авна.

Эвдэрсэн хэв хашмалыг салгасны дараа энэ нь бетон гадаргууг гэмтээж

болзошгүй бол дахин хэрэглэж болохгүй.

Бэлэн бетон хийцийг барилгын ажилд байнгын хэв хашмалын зориулалтаар ашиглахаар гүйцэтгэгч санал болгож инженер зөвшөөрсөн бол техникийн шаардлагыг бүрэн хангасан байна. Эдгээр хийцүүдийг 1321 хэсэгт заасан хүлцэх алдааны хязгаарт зөв түвшин ба чигт суулгаж бетон цутгах үед хөдлөхгүй байхаар бэхлэгдсэн байна.

Бетонтой харьцах хэв хашмалын бүх гадаргууг арматур байрлуулахаас өмнө сайтар цэвэрлэж, хэвийг бетоноос салгахад хялбар болгох зориулалттай зөвшөөрөгдсөн химийн юмуу бусад эмүүлсээр түрхэж өгнө. Цэвэр эрдэс тос ба усанд уусдаг эмүүлсийг хэрэглэхгүй. Гүйцэтгэгч төлөвлөсөн шингэн нэмэлтүүдийг тохирох эсэхийг батлах туршилтын хавтан цутгана. Дараах шинж чанар бүхий эмүүльсийг хэрэглэж болохгүй:

- хэвлэмэл гадаргуу дээр тавигдах аливаа материалын барьцалдах чанарыг бууруулдаг,
- хэвлэмэл гадаргуун бэхжилтийг удаашруулдаг,
- гадаргууг хэврэг болгодог,
- агаарын зай үүсгэдэг,
- толбо үүсгэдэг,
- гандуулдаг,
- өнгө өөрчилдөг.

(ii) хэв хашмалыг төсөллөх

Хэв хашмал нь ACI стандарт, “Бетоны хэвийн практик зөвлөмж,” (ACI 347) эсхүл инженерийн зөвшөөрсөн олон улсад түгээмэл стандартыг хангасан байна. Хэв хашмалыг төсөллөхөд гидростатик даралтыг сонгохдоо доорх зүйлүүдийг анхаарна. Үүнд:

- бетон дэвсэх үеийн тооцоолж буй хамгийн их хэмжээ,
- төлөвлөсөн хольцны өтгөрөлт ба хөдөлгөөнт чанар,
- доргилтын нөлөө,
- бетоны температур
- орчны температур
- бетон хольц дахь удаашруулагч буюу зөөлрүүлэх бодисууд

(iii) хэв хашмалыг барих

Хэв хашмалыг дахин хэрэглэхээс өмнө цахилгаан хөдөлгүүрт механик багажаар цэвэрлэж эвдрэл, гэмтлийг шалгаж, шаардлагатай засварыг хийнэ. Хэрвээ бетон цутгах үеэр буюу цутгахаас өмнө ямар нэгэн согог илэрвэл инженер согогийг залруултал ажлыг зогсоож болно.

Гүйцэтгэгч хэв хашмалыг угсрахдаа хэвний хажуугийн талуудыг буулгах үед доод хэсгийн хэвийг хөндөхөөргүй хийнэ. Хэрэв тулгууруудыг үлдээж доод хэсгийн хэвийг салгах шаардлагатай бол цохилтын үед тулгууруудыг хөндөж болохгүй. Гүйцэтгэгч хэв хашмалыг задлах зорилгоор тулгууруудыг түр зуур зайлуулаад дараа нь буцааж тавих ёсгүй.

Хэвэн доторх метал холбоос ба бэхэлгээнүүдийг бетоныг гэмтээлгүйгээр бетоны нүүрнээс дор хаяж 60мм-ийн зайнд салгаж болохоор хийнэ. Төмөр холбогчийг авсаны дараа бетонд үлдэх хонхор зай нь аль болох бага байхаар бэхэлгээг суулгаж өгнө. Хонхор зайг техникийн шаардлагын 1317 (а) дэд зүйлийн дагуу цементэн зуурмагаар шавж гадаргууг янзална.

Хэвний тулгууруудыг өмнөх тавьсан бетонтой нь инженерийн хэрэглэхийг

зөвшөөрсөн эрэг чагтаар холбож боож болно. Хэрвээ бетоны метал холбогч нь эрэг чагттай холбоотой бол байранд нь салгалгүй үлдээх төмөр нь бетоны нүүрэн талд 60мм-ээс илүү ойр байж болохгүй.

Хэв хашмалын дотор талыг нь цэвэрлэхэд түвэгтэй бол энэ зориулалтаар хэвэнд түр нээлхий гаргаж өгнө.

Бетоны дотор ба гадна өнцгүүдэд 20мм х 20мм-ийн шинэ хатуу банзны тусламжтайгаар ховил гаргаж өгнө. Инженер өөр заавар өгөөгүй бол, ил харагдах бетон гадаргууд цэвэр, тэгш, хэвтээ залгаас үүсгэхийн тулд хэвэнд шинэ 25мм$^2$-ийн дөрвөлжин хатуу банз суулгаж өгнө.

Хэвийг хийхдээ бетоны овор хэмжээ болон чиглэл нь бүх талаараа ажлын зурагт заасан бүх өгөгдлүүдийг нарийн баримталсан байхаар зуурмагтай нягт суух байдлаар хийнэ. Арматурын хэвнээс цухуйсан хэсгүүдээр цементийн сүүг гоожуулахгүйн тулд хэвийг арматуруудын эргэн тойронд маш нягт хийнэ.

(iv) Бетоныг дэвсэхээс өмнө хэвийг бэлдэх

Түр байгууламж ба хэвийг угсарсаны дараа төмөр арматурыг байрлуулахаас өмнө гүйцэтгэгч, түр байгууламж ба хэвийг сайтар шалгаж үзнэ. Хэмжээсүүдийг шалгаж, овон товонтой гадаргууг тэгшилж, ялангуяа эрэг чагт, холбоос чанга хийгдсэн эсэх ба суурийн бат бэх байдал зэргийг сайтар анхаарч үзэх ёстой.

Хэв хашмалд арматур суурилуулахаас өмнө хэв хашмалын дотор талыг сайтар цэвэрлэж, техникийн шаардлагын 1318(б) (i) зүйлд заасны дагуу зөвшөөрөгдсөн эмульсээр түрхлэг хийнэ. Зэрэгцээ бетон гадаргуунуудын өнгө өөр өөр болохоос зайлсхийж нэг барилгын ажлын хэв хашмалд зөвхөн нэг төрлийн эмульс, шингэнийг хэрэглэнэ.

Хэв хашмалыг суулгахаас өмнө арматурыг байрлуулах шаардлага гарвал хэв хашмалын гадаргууг бэлдэх бүх ажлуудыг түүнийг эцсийн байршилд байрлуулахаас өмнө хийж гүйцэтгэнэ. Арматурыг эмульс шингэнээр бохирдуулж болохгүй.

Бетон цутгахаас өмнө хэв хашмалаас бүх хог, шороо, барилгын хаягдал болон бусад гадны материалыг гарган хаяна.

Гүйцэтгэгч бетон дэвсэж эхлэхээс өмнө бүх шаантаг ба тохиргооны хэрэгслүүдийг бетон дэвсэх үед хөдлөхөөс хамгаалж бетоныг дэвсэх үед тэдгээрийг хөдөлгөөнгүй байлгах талаар байнга хяналт тавьж байна.

Гүйцэтгэгч, хэв хашмал, тулах түр байгууламж болон арматур төмрийг байрлуулсны дараа бетон дэвсэх гэж байгаагаа бетоны ажил эхлэхээс өмнө дор хаяж 24 цагийн өмнө инженерт бичгээр мэдэгдэнэ. Гүйцэтгэгч инженерт ийнхүү мэдэгдэхээс өмнө өөрөө ажил нь энэхүү техникийн шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгаж баталгаажуулсан байна. Гүйцэтгэгч, инженерт түүнд ажил эхлэх зөвшөөрөл бичгээр өгөхөөс нааш бетон дэвсэх ажлыг эхлэхгүй.

(в) Түр байгууламж ба хэвийг задалж буулгах

(i) Ерөнхий

Гүйцэтгэгч, инженерийн зөвшөөрлийг бичгээр урьдчилан авахаас нааш түр байгууламж ба хэвийг буулгахгүй. Түр байгууламж болон хэвийг буулгах хугацааг тухайн хийцийн байршил ба төрөл, цаг агаарын нөхцөл, бетон хольцонд орсон материал болон бетоны бат бэхэд нөлөөлж болох бусад хүчин зүйлүүдийг харгалзан тогтооно.

Бетоныг цохиж хөндөлгүйгээр хэвийг болгоомжтой буулгана. Бетон нь түр байгууламж болон хэвийг буулгах үед бетонд ирж болох аливаа ачааллыг даах хэмжээний хангалттай бат бэхтэй болтол хэвийг салгахгүй. Бетонд хэт

их ачаалал өгөх эсвэл гадаргууг гэмтээж болох аргаар хэвийг буулгаж болохгүй. Хийц жигд, аажмаар өөрийн жингийн ачааллаа авах боломжтой байдлаар тулгуруудыг буулгана.

Инженер өөрөөр заагаагүй бол гүүрийн хашлага, хаалт зэргийг барихаас өмнө хэв хашлагыг буулгана.

(ii) Салгах хугацаа

Бетоныг дэвсэж дуусах ба хэв хашмал, түр байгууламжийг буулгах хоёрын хооронд өнгөрөх хамгийн бага хугацаа 0°C - 25°C хэмийн орчны температурт ямар байхыг хүснэгт 13-12-т өгөв. Дээрхээс бага температурт буюу энгийн буюу сульфатад тэсвэртэй портланд цементээс бусад төрлийн цемент хэрэглэж байгаа бол, инженер өөр хугацаа өгч болно.

**Хүснэгт 13 - 12 Хэвтэй нь байлгах хамгийн бага хугацаа**
(энгийн болон сульфатад тэсвэртэй портланд цемент бетон)

| **Хэвийн төрөл** | **Орчны дундаж температур** | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | **Хэвтэй нь байлгах хамгийн бага хугацаа** | | | | | |
| | **25° C** | **20° C** | **15° C** | **10° C** | **5° C** | **0° C** |
| Багана, хана ба том дам нурууны босоо хэв хашмал | 9 цаг | 10 цаг | 12 цаг | 15 цаг | 20 цаг | 30 цаг |
| Хавтангийн хэвтээ хавтгай хэв | 3 өдөр | 3 өдөр | 4 өдөр | 5 өдөр | 7 өдөр | 10 өдөр |
| Дам нуруу болон дам нуурууны тулгуурын хэвтээ хавтгай хэв | 7 өдөр | 8 өдөр | 10 өдөр | 13 өдөр | 17 өдөр | 25 өдөр |
| дам нуурууны тулгуур | 10 өдөр | 12 өдөр | 14 өдөр | 18 өдөр | 24 өдөр | 36 өдөр |

Мөн, бетоноос авсан шоог эх бетонтой ижил арчилж бэхжүүлсэний дараа шооны бат бэх хүснэгт 13-13-т өгөгдсөн бат бэхтэй болсон хойно хэв ба түр байгууламжийг буулгаж болно.

**Хүснэгт 13-13: Хэв хашмалыг салгахаас өмнөх бетон шооны бат бэх**
(энгийн болон сульфатад тэсвэртэй портланд цемент бетон)

| **Түр байгууламж ба хэв хашмалын төрөл** | **Хэвийг буулгахаас өмнөх шооны 28 хоногийн бат бэх %** |
|---|---|
| Багана, хана ба том дам нурууны босоо хэв хашмал | 30 |
| Хавтангийн хэвтээ хавтгай хэв | 35 |
| Дам нуруу болон дам нуурууны тулгуурын хэвтээ хавтгай хэв | 40 |
| дам нуурууны тулгуур | 50 |

Эдгээр шаардлагыг биелүүлэх нь гүйцэтгэгчийг бетоныг гэмтээлгүйгээр хэв хашмалыг хугацаанд нь салгах хариуцлагаас чөлөөлөхгүй.

Хэвийг буулгасны дараа дараагийн ажилд хэрэглэгдэхгүй бетоны нүүрэнд байгаа эрэг чагтны нүхнүүдийг зуурмагаар сайтар бөглөж техникийн шаардлагын 1317 (а) дэд зүйлийн дагуу өнгөлнө.

(iii) Хязгаарлалт

Дор дурьдсанаас бусад бүх түр байгууламж болон хэв хашмалыг буулгана.

Үүнд:

- замын далангийн хөлдөлтөөс хамгаалах үеэс доош 0.3м-ээс илүү явсан эсвэл замын далангаас гадна ул хөрсний түвшнөөс 0.6м доош, эсвэл урсгал залах сувагаас 0.6м доош явсан түр байгууламжийн тулгуурын хэсэг,
- хэв хашмалыг нь салгавал коффердам болон бусад хэсгийн аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй суурийн хэв хашмалууд,
- хүрч болохооргүй хаалттай хэсгүүдийн хашлага,
- зурагт үзүүлсэн бусад байгууламжийг нэмж угсрахад тэдэнтэй харьцдаггүй дөрвөлжин дам нуруут гүүрнүүдийн хэв хашмал.

## 1319 ӨТГӨН БА ШИНГЭН ЗУУРМАГ (ЗУУРМАГ БА ЦЕМЕНТИЙН УУСМАЛ)

(а) Ерөнхий

Энэ хэсэгт бетон хийцэнд ашиглах зуурмагийн тухай заасан байгаа. Тухайлбал чулуун бэхэлгээнд орох, гадаргуун нүх болон бусад гологдлыг засах, бэхэлгээний болтын хөндийг дүүргэх гэх мэт ажлуудад хэрэглэгдэнэ.

Зуурмаг түрхэх гадаргуу дахь бүх сул ба гадны материалыг цэвэрлэнэ. Дараа нь зуурмаг хийхээс өмнөхөн тэдгээрийг усаар урсган гадаргууг хатаана.

Бага хэмжээний зуурмагийг гараар зуурч болох боловч 0.5 $м^3$-ээс их зуурмагийг зуурагчаар зуурна. Зуурсны дараа зуурмагийг усаар шингэлж болохгүй ба нэг цагийн дотор дэвсэх хэрэгтэй.

Зуурмагийг дэвссэний дараа техникийн шаардлагын дэд зүйл 1312 (в) (ii)-ийн дагуу 5-аас доошгүй хоног усаар бэхжүүлнэ.

(б) Нийтлэг зорилгоор ашиглах зуурмаг

Зуурмаг нь техникийн шаардлагын дэд зүйл 1303 (г)-д заасан шаардлагыг хангасан нарийн чулуулаг материал болон AASHTO M85 стандартыг хангасан IA ангилалын портланд цементээс бүрдэнэ. Зуурмагийн орцыг зурагт болон техникийн шаардлагад заасны дагуу орцлох ба хэрэв алинд нь ч заагаагүй бол цемент чулууны жингийн харьцаа 1:2 байна.

Зуурмаг дахь усны агуулга нь аль болох бага байх ба ямар ч тохиолдолд ус цементийн харьцаа нь 0,5-аас ихгүй байна.

“Хуурай чигжээс” гэх зуурмаг нь хольцыг барьцалдуулахад хангалттай хэмжээний устай боловч гарт базах үед уян биш байна. Хуурай чигжээсийг хөндий рүү гар чигжигчээр дүүргэж, гүйцэд нягтралтай болгох үүднээс сайтар гар алхаар чигжинэ.

(в) Хонхор ба нүхийг чигжих

Хонхор ба нүхнүүдийг өндөр даралтын агаар ба ус шүршигчээр сайтар цэвэрлэнэ. Алмаазан хошуутай өрмөөр өрөмдсөн нүхнүүдийг барзгар болгоно. Цэвэр ус болон цементийг жингийн 1:2 харьцаагаар хольсон шингэн зуурмагаар хонхор ба нүхнүүдийг дүүргэнэ. Бүх нүхийг дүүрэнгүүт шингэн зуурмагаа хийхээ зогсоож бетон суурь дээр гоожсон зуурмагийг сайтар цэвэрлэн дараагийн ажил хийгдэхээс өмнө гадаргууг хатаана.

(г) Суурийн хавтангуудын доорх чигжээс

Суурийн хавтангууд болон бетон дэвсгэр үеийн завсраар портланд цемент болон нарийн ширхэгтэй чулууг 1:1 харьцаагаар хольсон тусгай зуурмагаар дүүргэнэ. ASTM C845-ийн шаардлагад нийцсэн, инженерийн зөвшөөрсөн агшилтын эсрэг үйлчилгээтэй нэмэлт бодисыг үйлдвэрлэгчийг зааврын дагуу орцлон нэмж холино. Тусгай зуурмагийн ус цементийн харьцаа нь зуурмагийг хамгийн их нягт авахаар нягтруулж чигжихэд хангалттай боловч аль болох бага байна.

Тусгай зуурмагийг суурийн хавтангийн доогуур хэвтээ чиглэлд дүүргэх ба нөгөө гурван талаар зуурмаг гарч иртэл алхаар чигжинэ. Зуурмагийг ямар ч агаарын

зайгүй нягтруулах үүднээс шахагдан гарч ирсэн зуурмагийн алхаар буцааж чигжинэ.

## 1320 БЕТОН ЦУТГАЛТЫН ДАЛД АЖЛЫН АКТ

Гүйцэтгэгч инженерийн зөвшөөрсөн маягт дээр бетоны цутгалт бүрийн тухай бүртгэл хөтөлнө. Энэ бүртгэлд дараах зүйлүүд багтана. Үүнд:

- бетоны төрөл,
- бетоны суулт,
- цутгасан байршил,
- цутгасан огноо,
- дэвсэх үеийн орчны ба бетоны температур,
- агрегатын чийгийн агуулга,
- хольцны найрлага,
- зууралтын дугаар,
- цементийн дугаар (нийлүүлтийн),
- бэхжих үеийн орчны температур,
- туршилт, шинжилгээнүүдийн хариу,
- туршилтын шоо авсан байршил ба шооны өгөгдлүүд
- өрөмдлөг хийсэн тухай тодорхойлолт.

Гүйцэтгэгч 7 хоног бүр өнгөрсөн долоо хоногт гүйцэтгэсэн ажлыг тусгасан эдгээр бүртгэлийн 4 хувийг инженерт өгнө. Үүнээс гадна, 28 хоног дахь шооны бат бэх, нормоос зөрсөн хэлбэлзлийг сар тутмаар болон өссөн байдлаар болон инженерийн шаардсан бетоны ажилтай холбоотой бусад мэдээллийг инженерт гаргаж өгнө.

## 1321 СОГОГТОЙ БЕТОНЫГ ЗАСАХ

Хэвийг салгасны дараа бетон элдэв согогтой байвал гадаргууг инженерт үзүүлж заавар авахаас нааш гүйцэтгэгч гадаргууг засварлах ёсгүй.

Согогтой гадаргууг шаваасаар засч болохгүй. Гадаргуун засварын ажлыг техникийн шаардлагын 1317 (б) дэд зүйлийн дагуу гүйцэтгэнэ.

Инженер засварлахыг зөвшөөрсөн сийрэгжиж арзайсан гадаргууг бат бэх бетон гарч иртэл буюу 75мм гүн ухаж авна. Хэрвээ төмөр бетон байгаа бол арматураас цааш дор хаяж 25мм буюу 75мм гүн ухаж авна. Гарсан нүхний тал бүрийг тэгш өнцөгт болгож янзална. Хөндийг даралтат ус шүршигч буюу агаараар үлээлгэж цэвэрлэсний дараа зөвшөөрөгдсөн эпокси резин түрхсэний дараа нэн даруй их биед хийсэн бетонтой адил ангилалын гэхдээ 10мм-ийн хэмжээтэй чулууг нь авсан бетоноор дүүргэнэ. Хэвийг хөндийн дээд ирмэгийн дээрх цэг хүртэл дүүргэж өгнө.

Долоо хоногийн дараа бетоны ирмэгийг тайрч аваад гадаргууг тэгшилнэ.

Техникийн шаардлагын 302 (к) дэд зүйлд тодорхойлсон хүлцэх алдааны хязгаараас давсан гадаргуун тэгш бус хэсгүүдийг зэрэгцээ гадаргуунуудын шилжих налуу 1:50-аас бага байхаар инженерийн зааварчилсаны дагуу тэгшилж засна.

Дээр зааснаас бусад согогийг инженерийн зааварчилсаны дагуу засна.

## 1322 БЕТОНД ХИЙХ АРМАТУР

(а) Ерөнхий

Энэ зүйл нь цутгамал бетонд орох үечилсэн арматур ба ган хийцийн тухай болно.

Бүх арматур нь догшин налархайшилттай, иржгэр арматур байх бөгөөд дараах Британий буюу AASHTO стандартыг хангасан байна. Үүнд:

| | |
|---|---|
| BS 4449 | карбон ган төмөр арматур |
| BS 4482 | Бетоны арматурт хэрэглэх төмөр утас |
| BS 4483 | Бетоны арматурт хэрэглэх ган хийц |
| AASHTO M 31 M | Үечилсан ба цулгуй ган арматур |
| AASHTO M 221 M | Бетоны арматурт хэрэглэх төмрөөр гагнасан, барзгар утсан материал, |
| AASHTO M 225 M | Бетоны арматурт хэрэглэх барзгар төмөр утас |

(б) Арматурт хийх шинжилгээ, туршилтууд

Гүйцэтгэгч инженерийн баталсан үйлдвэрлэгчээс арматур нийлүүлэх ба үйлдвэрлэгчийн шинжилгээний гэрчилгээг инженерт танилцуулна.

Гүйцэтгэгч барилгын ажилд ашиглахаар төлөвлөж буй бүх арматур төмрийг инженерийн зөвшөөрсөн лабораторид AASHTO стандартын дагуу туршиж туршилт бүрийн 2 хувь гэрчилгээг инженерт танилцуулна. Шинжилгээ, туршилтын давтамжийг тухайн AASHTO стандартын дагуу тогтооно.

Дээрх туршилтуудаас гадна гүйцэтгэгч инженерээс шаардаж болзошгүй нэмэлт туршилтуудыг гүйцэтгэнэ.

Гүйцэтгэгч техникийн шаардлагад нийцээгүй аливаа арматур төмрийг ажлын талбайгаас зайлуулна.

(в) Арматурыг тээвэрлэх ба хадгалах

Арматурыг урт чигээр нь, тайрч эсвэл гэрээний шаардлагын дагуу нугалж авчирна. Тээвэрлэхэд хялбар болгох үүднээс уртаар нь нугалж авчирсан арматурыг хэрэглэж болохгүй.

Арматурын төмрийг чигээрээ нугарахгүй, аливаа гэмтэл авахааргүй мөн бохирдохгүй байхаар хатуу суурь дээр байрлуулсан тавиур дээр хурааж хадгална. Удаан хугацаагаар хадгалж болзошгүй төмрийг зэврүүлэхгүй байх үүднээс цаг агаарын нөлөөллөөс хамгаалж өгнө. Зэвэрсэн төмөр нь инженерийн үзэж байгаагаар чанараа алдсан бол талбайгаас зайлуулах буюу техникийн шаардлагын 1322 (б) дэд зүйлийн дагуу AASHTO стандартад нийцсэн аргаар гүйцэтгэгчийн зардлаар туршина.

(г) Арматурыг нугалах схем

Ажлын зураг дээр заагаагүй бол гүйцэтгэгч арматурыг нугалах схемийг инженерт танилцуулж шалгуулан зөвшөөрөл авна. Арматурыг нугалах схем нь дараахи мэдээллийг агуулсан байна. Үүнд:

- арматурын байршил ба байрлуулах аргачлал
- холбогдох тэмдэглэгээ
- гангийн марк
- хэмжээний заалт
- арматурын тоо
- арматурын урт
- арматурын хэлбэр
- тайлбар

Дээрх жагсаалтыг инженер батлахаас нааш арматурын ажлыг эхэлж болохгүй. Нугалах схемийг инженер батлах нь гүйцэтгэгчийг арматурыг нарийвчлалтай матах хариуцлагаас чөлөөлөхгүй. Ажлын зурагт нийцүүлэн нугалах схемийн дагуу

материалыг шалгах ажил гүйцэтгэгчийн зардлаар хийгдэнэ.

д) Арматурыг бэлтгэх

(i) Таслах ба нугалах

Зураг дээр өөрөөр заагаагүй бол, таслах ба нугалах ажлуудыг төмөр бетоны ACI 318 барилгын нормын дагуу гүйцэтгэнэ.

Гүйцэтгэгч арматурыг нугалах схемийг нарийвчлан мөрдөх ба арматурыг зургийн дагуу таслах, нугалах хариуцлага хүлээнэ. Хэрэв нугалах схем болон ажлын зургийн хооронд аливаа зөрүү гарвал гүйцэтгэгч инженерт даруй мэдэгдэнэ.

Арматуруудыг удаан тогтмол даралтаар нугална. 5°C-аас доош температурт нугалах төмрийг хугарахаас хамгаалах шаардлагатай бол нугалах хугацааг удаашруулна. Үйлдвэрлэлтийн хүлцэх алдаа ACI 315-ын дагуу байна.

Арматурыг нугалсаны дараа багцлан боож ACI 318-т заасны дагуу тод шошго, тэмдэг тавина.

Өндөр налархайшилтай арматурыг халаах ба нугалахыг зөвшөөрөхгүй.

(ii) Хаяглах

Арматурын төмрийг стандартын багцаар боож “Бетоны арматур төмрийн институтын гарын авлага”-д заасны дагуу хаяглаж тээвэрлэнэ.

(е) Арматурын гадаргууг арчлах

Арматурыг байрлуулах үед түүн дээрх сул зэв, өнгөр, зуурмаг, будаг, тос болон бусад барьцалдалтыг багасгаж болох зүйлээс цэвэрлэсэн байна. Арматур нь ан цав, үе хагарал гэх мэт согоггүй байна. Хэрэв төмрийн гадаргуу дээр тогтсон зэв, гадаргуун барзгар, нунтаг хагийг сайтар цэвэрлэсэн бол арматурыг ажилд хэрэглэж болно. Гэхдээ ийнхүү төмөр утсан сойзоор цэвэрлэсэн арматурын хэмжээ, хөндлөн огтлол болон сунах шинж чанар нь заагдсан арматурын марк хэмжээнд тавигдах шаардлагыг хангаж байх ёстой.

(ё) Арматурыг байрлуулах ба бэхлэх (боох)

(i) Ерөнхий

Төмөр арматурыг ажлын зурагт заасны дагуу бетон цутгахын өмнө ба цутгах үед тогтвортой байхаар байрлуулна. Арматурыг бетон цутгалтын үеэр хөдөлгөөнгүй байхаар сайтар бэхэлж өгнө. Инженер өөрөөр зааварлаагүй бол огтлолцох арматуруудыг 1,25 мм-ээс багагүй диаметртэй шатааж цайрдсан төмөр утсаар холбож утасны үзүүрүүдийг бетоны их бие рүү хийнэ.

Гүйцэтгэгч ил гарсан арматуруудыг муруйх, хөдлөх буюу эвдэрч гэмтэхээс сэргийлнэ. Гүйцэтгэгч бетоноос ил цухуйн гарсан арматуруудыг түр нугалах шаардлагатай болбол нугалах радиус нь зөөлөн төмөр арматурын диаметрийн дөрөвний нэгээс их байх буюу догшин налархайшилтай арматурын диаметрээс зургааны нэгээс их байна. Эдгээр нугалсан арматуруудыг бетон цутгалт эхлэхээс өмнө ямар нэг долгион үлдээлгүйгээр эсвэл арматурын орчмын бетоныг эвдэлгүйгээр тэгшилнэ.

(ii) Тулах систем

Арматурын төмрийг байх ёстой байршилд цементэн блок, төмөр арматуран тулгуурууд, нэмэлт арматурууд, эсвэл бусад зөвшөөрөгдсөн хэрэгслүүдийг ашиглан байрлуулна. Эдгээр тулгуруудыг арматур болон хэвлэмэл гадаргуугийн хоорондох зохистой зайг барих ба арматураас бетон хавтангийн дээд гадаргуу хүртэлх зайг зурагт заасан хэмжээнээс 5 мм-ийн хязгаарт байхаар байрлуулна.

Бетон цутгах үед хүмүүс ба тоног төхөөрөмж ажиллуулах ажлын тавцанг арматур дээр тавьж болохгүй.

(iii) Цементэн блок

Цементэн блокийн шахалтын бат бэх нь суурилуулах бетоныхоос бага байж болохгүй. Хэв хашмалтай харьцаж байгаа блокийн тал нь 50мм х 50мм-ээс хэтрэхгүй хэмжээтэй байх ба бетонон гадаргуутай ижил өнгө хээтэй байна. Цементэн блок нь 1,25 мм-ийн диаметртэй шатааж, цайрдсан төмөр утсаар арматурт бэхлэгдэнэ. Инженер зөвшөөрвөл зай баригч блокийн тохирох төрлийг хэрэглэж болно.

(iv) Тулгуур бэхэлгээ

Тулгуур болгож хэрэглэх төмөр нь “Төмөр бетоны институтын стандартын гарын авлага”- ын шаардлагыг хангаж байх ёстой. Ил гарах гадаргуугийн хэв хашмалд тулах эдгээр тулгуур нь ASTM A493, Ангилал 430 стандартын зэвэрдэггүй ган бүхий “хамгийн их хамгаалалттай” - Ангилал 1 эсвэл, “дунд зэргийн хамгаалалтай” - Ангилал 2-ын төмөр байна.

(v) Арматурыг гагнах

Бетон хийцийн арматурыг инженер бичгээр зөвшөөрөл өгсөн тохиолдолд гагнана. Гагнуур хийхдээ америкийн гагнуурын нийгэмлэгийн “Барилгын гагнуурын журам, арматур төмөр, AWS D1.4”-ийг буюу зохих тусгай заалтуудыг дагаж мөрдөнө.

(vi) Арматурыг залгах

Өөрөөр хийх зөвшөөрөл өгөөгүй бол бүх арматуруудыг зурагт заасны дагуу нийт уртаар байрлуулна. Зурагт зааснаас бусад тохиолдолд арматуруудыг холбоход инженерийн зөвшөөрлийг бичгээр авсан байна. Холбоосууд нь хоорондоо аль болох хол зайтай байна.

Арматурын үзүүрүүдийг зурагт үзүүлсэн уртаар зөрүүлж холбоно. Зурагт заагаагүй бол зөрүүлэх уртыг зам гүүрний ажилд тавигдах AASHTO стандартын 8.32-р зүйлийн 1-р хэсэгт дурдсан уртаар эсхүл инженерийн зааварчилсны дагуу тогтооно.

Зөрүүлсэн холбоосуудыг ажлын зурагт буюу техникийн шаардлагын 1310 (д) дэд зүйлд заасан бетоны гадаргуу ба арматурын хоорондох зайг баримтлан төмөр утсаар ороож booно.

Инженер зөвшөөрсөн тохиолдолд холбоосыг техникийн шаардлагын 1322 (ё) (v) дэд зүйлийн дагуу гагнаж болно.

Гүйцэтгэгч инженерээс урьдчилсан зөвшөөрөл авалгүйгээр арматурыг механик холбогч буюу муфтээр холбож болохгүй. Механик муфтын таталт болон шахалтын бат бэх нь догшин налархайшилттай арматурынхаас 125% -р илүү байх ёстой.

Арматурыг холбосон механик холбогчоос тус бүр 100мм-ийн урттай 2 холбогчийг инженер сонгон авч гүйцэтгэгч 125%-ийн бат бэхийг шалгана.

Сараалж торон арматурыг хооронд нь холбохдоо бүх үзүүрүүдийг сараалжийн төмөр хоорондын зайгаас 1.5 дахин илүү уртаар зөрүүлж сайтар booно.

## 1323 ӨӨР ХЭМЖЭЭНИЙ АРМАТУРААР ОРЛУУЛАХ

Зурагт өгөгдсөн арматурыг өөр хэмжээ буюу налархайшлын эсэргүүцэлтэй арматураар зөвхөн инженерийн бичгээр өгсөн зөвшөөрлөөр сольж болно. Орлуулах арматурын хөндлөн огтлолын талбай ба налархайшлын эсэргүүцлийн бат бэх нь зурагт заасан арматуруудынхаас багагүй байх ба “Зам гүүрийн AASHTO” стандартын хэсэг 1, зүйл 8.16.8.4-ын дагуу байна.

## 1324 УГСАРМАЛ ТӨМӨР БЕТОН

(а) Ерөнхий

Гэрээнд заагдсан юм уу гүйцэтгэгчийн хэрэглэхээр төлөвлөж буй бүх төрлийн угсармал бетоныг энд хамруулж үзнэ.

(б) Угсармал хийцийн хэв

Угсармал хийцийн хэв нь энэхүү техникийн шаардлагын 1318 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаж байх ёстой. Хэвийг хэрэглэх явцад хэв маягийн болон хэмжээний өөрчлөлтөд орохооргүй, бетоны хольц дахь жижиг ширхэглэлтэй хэсгүүд болон цементийн уусмал асгарч гоожихооргүйгээр барьж угсарсан байна.

Хэвийг шинэ бетон зуурмагийн жингийн үйлчлэлд сууж хөдлөхгүй байхаар хатуу суурин дээр байрлуулна.

Цутгагдсан хийцийг авах явцад түүнд ямар нэг эвдрэл үүсэхээргүй хэвийг барьж угсарна.

Гүйцэтгэгч нь зөвхөн 1318-р зүйлийн (б)-ийн (і)-д заасан шаардлагыг хангаж байх салгах бодисуудыг хэрэглэнэ.

(в) Угсармал хийцийн арматур

Угсармал хийцэд хэрэглэх арматур нь энэхүү техникийн шаардлагын 1322, 1323–р зүйлд заасан шаардлагуудыг хангаж байх ёстой. Бэлэн хэв хэрэглэх гэж байгаа тохиолдолд хэмжээсийн нарийвчлалыг хангах зорилгоор түүнийг арматур байрлуулах кондуктор дээр суулгаж, бетон цутгах явцад хөдлөхгүй байхуйцаар хэвээр хашиж тулж өгнө.

Гол арматуруудыг бүрэх байдал нь ажлын зурагт заасны дагуу байх ба хэрэв ажлын зурагт хэмжээ өгөгдөөгүй бол 50 мм-ээс буюу шилбэний диаметрээс багагүй байна.

Шилбүүдийг тэдгээрийн хоорондох цэвэр зай нь чулуулгийн хамгийн их номиналь хэмжээн дээр 5мм-ийг нэмсэнтэй тэнцүү юм уу ямар ч тохиолдолд шилбэний диаметрээс багагүй байхаар байрлуулна.

(г) Угсармал хийцийг цутгах

Угсармал хийцэд хэрэглэх бетон нь ажлын зурагт өгсөн маркийн бетон байх ба энэхүү техникийн шаардлагын 1303-аас 1310-р зүйлүүдэд заасан шаардлагуудыг хангаж байх ёстой. Хөнгөн дүүргэгчүүд нь AASHTO M 195 стандартын шаардлагад нийцсэн байна.

Хийцийг цутгах гэж буй талбай нь ус, бороо, нар, салхинаас зохих байдлаар хамгаалагдсан байх ёстой.

Хийцүүдийг ажлын зурагт заасан хэмжээ болон хүлцэх алдааны дагуу цутгаж хэлбэржүүлнэ.

(д) Угсармал хийцийг арчлах

Арчлах ажил нь энэхүү техникийн шаардлагын 1312-р зүйлд заасан шаардлагыг хангаж байх ёстой.

Гүйцэтгэгч нь арчлах явцад уг хийцийг цутгаснаас хойш доод тал нь 4 хоногт температурын огцом өөрчлөлтөд орох юм уу чийг нь алдагдахаас сэргийлэх хэрэгтэй. Арчлах явцад усаар шүршиж норгох шаардлагатай бол хэрэглэх ус нь уг хийцийн температураас $5^0$С хэм дотор байна.

Хэрэв гүйцэтгэгч өндөрсгөсөн температурт арчлахаар төлөвлөж байгаа бол хяналтын инженерээс зөвшөөрөл авах ба уг аргадаа хийцийг халааж, температурын огцом өөрчлөлтгүйгээр хөргөх хэрэгслийг ашиглана.

(е) Угсармал хийцийн гадаргуугийн өнгөлгөө

Ажлын зурагт өөр гадаргууг заагаагүй бол угсармал хийцийн хэлбэржүүлээгүй

гадаргууг энэхүү техникийн шаардлагын 1317-р зүйлийн (а)-д заасны дагуу ердийн гадаргуу болгож өнгөлнө.

Ажлын зурагт өөр гадаргууг тусгайлан заагаагүй бол угсармал хийцийн хэлбэржүүлээгүй гадаргууг энэхүү техникийн шаардлагын 1316-р зүйлийн (в)-д заасны дагуу 3-р ангиллын гадаргуу болгож өнгөлнө.

Тусгай гадаргуу шаардлагатай тохиолдолд гүйцэтгэгч туршилтын хавтан хийх ба түүнийг хяналтын инженер зөвшөөрсний дараагаар цутгасан газарт нь шалгах зорилгоор хадгална. Цаашид үйлдвэрлэх угсармал хийцүүд нь туршилтын хавтантай ижил байх ёстой.

Өөр бусад хийцүүдтэй юм уу газар дээр нь цутгах бетонтой хүрэлцэж нийлэх хэсгийг бетон бүрэн хатуурч эхлэхээс өмнө төмөр шүдтэй сойзоор зүлгэж, усаар угаана. Хэрэв бетоныг хатууруулах шаардлагатай бол уг хэсгийн гадаргууг элс цементийн холимгоор өнгөлнө.

(ё) Угсармал хийцийг зөөх, хадгалах

Угсармал хийцүүдийг ямарваа эвдрэлээс сэргийлсэн байдлаар зөөх ба хатуу, ус үл нэвтрэх суурин дээр хадгална. Угсармал хийц болон ердийн байдлаар арматурласан том хэмжээтэй цутгамал хийцүүдийг хадгалахдаа тэдгээрийн ажилд тавигдах эцсийн байрлал дээр ирэхээс өөр нэмэлт ачаалал өгөгдөхгүй байхаар байрлуулна.

Ажлын зурагт заасан байрлалын дагуу хийцүүдэд зохих дэгээ гогцоо, нүх хийж өгөх ба зөвхөн тэдгээрийг ашиглаж хийцийг өргөж буулгана. Дэгээ юмуу нүх хийх боломжгүй бол татлага хийхэд тохиромжтой газрыг хийц дээр тосон будгаар тэмдэглэж өгнө.

Угсармал хийцүүд дээр тэдгээрийн дугаар, цутгасан огноог арилахааргүй тэмдэглэнэ. Хийцүүдийг бетонд ямар нэг эвдрэл үүсэхээргүй буюу гадаргуугийн өнгө алдагдахгүй байхаар, тохирох хавтан буюу түшлэг дээр хураана. Хийц бүрийн дор байх хавтан нь хоёроос ихгүй байх бөгөөд тэдгээрийг хөдөлгөөнгүй тулж өгөх юм ууу хийц дээр ирэх ачаалал хамгийн бага байх байрлалд тавина.

(ж) Угсармал хийцийг шалгаж, турших

Угсармал хийцүүд нь тооцоолсон ачааллыг дааж чадахуйц байх ёстой. Гүйцэтгэгч нь хяналтын инженерийн сонгосон хийцүүд дээр хийцийн ажиллах нөхцөлтэй ижил загварын ачаалал өгч туршина. Туршилтаар гүйцэтгэх зүйлсийг гүйцэтгэгч хяналтын инженер хоёр зөвшилцөж тохирсон байна.

Туршилтад хэрэглэх угсармал хийцийг нийт алгасалынх нь дагуу дороос нь тулах ба хийцийн тооцоонд авч үзсэн үл хөдлөх ба хөдөлгөөнт ачаануудыг нийлбэрийг 1.25 дахин авсантай тэнцэх хэмжээний ачааллыг өгч нэг цагийн туршид барина. Энэ үед эвдрэлийн ямар нэг шинж тэмдэг гарахгүй байх ёстой. Ачааг авсны дараа нэг цагийн дотор буцаж хэвдээ орох байдал нь бүрэн ачааллын үеийн хотойлтын 75 хувиас багаггүй байх ёстой.

Хэрэв туршсан угсармал хийц нь дээрх шаардлагуудыг хангаж чадахгүй бол дахин хоёр хийц дээр туршилт хийх ба эдгээр нь мөн л шаардлага хангаж чадахгүй бол бүх хийцүүдийг гологдол болгоно.

Хяналтын инженер шаардсан тохиолдолд хийцүүд дээр эвдлэх туршилт хийнэ. Хийцийг нийт алгасалын дагууд нь тулах ба ачааг хяналтын инженерийн зааварчилсан нэмэлтийн дагуу тооцоот хамгийн их ачааны 95 хувьд хүртэл өгнө. Уг ачааг 15 минутын туршид барина. Энэ хугацааны төгсгөлд байх хотойлт нь алгасалын 2.5 хувиас ихгүй байх ёстой. Ачааг цааш уг хийц эвдэртэл нэмж өгнө.

**Хэрэв хийц нь тогтоосон хугацаанд шаардлагатай ачааг тэсвэрлэж чадахгүй юмуу хотойлт нь тогтоосон хэмжээнээс хэтэрвэл хяналтын инженер дахин хоёр туршилт хийлгэх ба эдгээр нь мөн шаардлага хангахгүй бол тухайн хэсгийн бүх хийцийг гологдол болгоно.**

# БҮЛЭГ 1400 – ЗАМЫН ТОНОГЛОЛ

## БҮЛЭГ 1400 – ЗАМЫН ТОНОГЛОЛ


| | | |
|---|---|---|
| 1401 | ШОНГУУД | 14-3 |
| | (а) Дохионы шон | 14-3 |
| | (б) Гэрэл ойлгогч бүхий дохионы шон | 14-3 |
| | (в) Километрийн шон | 14-3 |
| | (г) Хоолойн тэмдэглэгээ | |
| 1402 | ХАШАА | 14-3 |
| 1403 | ЗАМЫН БАЙНГЫН ТЭМДГҮҮД | 14-3 |
| 1404 | ХАМГААЛАЛТЫН ХАШИЛТ | 14-4 |
| | (а) Материал | 14-4 |
| | (i) Дам нуруу | 14-4 |
| | (ii) Шон | 14-4 |
| | (iii) Зай баригч | 14-4 |
| | (iv) Хашилтыг угсрах | 14-4 |
| | (v) Хүлцэх алдаа | 14-4 |
| 1405 | ГУДАМЖНЫ ГЭРЭЛТҮҮЛЭГ | 14-5 |
| 1406 | ЦАС, ЭЛСНЭЭС ХАМГААЛАХ ДАЛАН | 14-6 |
| 1407 | ТӨМӨР БЕТОН ХАШЛАГА | 14-6 |
| 1408 | ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР | 14-6 |
| | (а) Дохионы ба КМ-ийн шон | 14-6 |
| | (б) Хашаа | 14-6 |
| | (В) Замын байнгын тэмдгүүд | 14-7 |
| | (i) Анхааруулах тэмдэг | 14-7 |
| | (ii) Зохицуулах, хориглох ба заах тэмдгүүд | 14-7 |
| | (iii) Мэдээллийн самбар | 14-7 |
| | (iv) Чиглэлийн самбар | 14-7 |
| | (г) Хамгаалалтын хашилт | 14-7 |
| | (д) Гудамжны гэрэлтүүлэг | 14-8 |
| | (е) Цасны хаалт | 14-8 |
| | | 14-9 |

## 1401 ЗАМЫН ШОН

(а) Дохионы шон

Зурагт заасан буюу Инженерийн зааварчилсан хэсгүүдэд дохионы шонгуудыг, одоо мөрдөж буй стандарт ба зурагт заасан зай хэмжээний дагуу байрлуулна. Дохионы шонг замын хөвөөн дээр дохионы шонгийн орой зорчих хэсгийн түвшингээс жигд өндөр байхаар байрлуулна.

Дохионы шон Инженерийн зөвшөөрсөн цагаан ба улаан өнгийн эпокси цавуутай будгаар хоёр давхарлаж, Зургийн дагуу будаж, Ажил хүлээж авсан тухай гэрчилгээг гарах хүртэл хугацаанд цэвэрлэж арчилна. Хугарсан, гэмтсэн тохиолдолд шонг ижил шонгоор сольж байна.

(б) Гэрэл ойлгогч бүхий дохионы шон

Гол зам орон нутгийн болон салаа замуудтай огтлолцож байгаа уулзвар дээрх арлуудын төгсгөлд гэрэл ойлгогч бүхий дохионы шонг зурагт заасны дагуу байрлуулна.

(в) Километрийн шон

Гүйцэтгэгч нь километрийн шонг Зургийн дагуу хийж байрлуулна. Километрийн шонг замын тэнхлэгийн шугамаас Зурагт үзүүлсэн буюу Инженерийн зааварласан зай, чиглэлд байрлуулна.

Километрийн шонг Инженерийн зөвшөөрсөн цагаан өнгийн эпокси цавуутай будгаар хоёр давхар будсан байна. Замын зайг гэрэл ойлгогч будагаар бичсэн заалт бүхий Км-ийн тэмдгийг шонгийн толгойн хэсгийн урд нүүрэнд Инженерийн зааснаар байрлуулна. Километрийн шонгууд болон тэдгээрийн заалтыг Ажил хүлээж авсан тухай гэрчилгээг гарах хүртэл хугацаанд цэвэрлэж арчилна. Хугарсан, гэмтсэн тохиолдолд шон болон тэмдгийг сольж байна.

(г) Хоолойны тэмдэглэгээ

Хоолойны ус гарах талын толгойн нүүрэн хэсэгт, дээд ирмэгээс доош 150мм-т, нүхний тэнхлэгийн тушаа замын пикет болон хоолойны дэс дугаар, нүхний тоо болон хэмжээг улаан өнгийн, угаагддагүй будгаар будаж тэмдэглэнэ. Хоолойны тэмдэглэгээг Ажил хүлээж авсан тухай гэрчилгээг гарах хүртэл хугацаанд цэвэр байлгана.

## 1402 ХАШАА

Гүйцэтгэгч Зурагт заасан буюу Инженерийн зааварчилсан газрыг тойруулан Зурагт заасан буюу Инженерийн зааварчилсаны дагуу хашаа барина.

Хашааг 5 м тутамд суулгах 110 мм голчтой хашааны шон, 200 метрээс ихгүй зайнд болон хашааны эхлэл, төгсгөлд буюу чиглэл өөрчлөгдөх цэгүүдэд байрлуулах 150мм голчтой татах шонгууд, шон тус бүрээс 2.5м зайд байх дундын гадаснууд, AASHTO M280 стандартыг хангасан 12½ SWG маркийн өргөстэй зэвэрдэггүй ган утас 5, шаардлагатай хадаас, хавчаар, зангидах утас болон бусад материалаар хийнэ.

Хашаа барих мод нь Инженерээр зөвшөөрөгдсөн сайн хатаасан хатуу мод байна. Гүйцэтгэгч материалаа талбайд авчрахаас эмнө материалын дээжийг Инженерээр шалгуулж зөвшөөрөл авна.

## 1403 ЗАМЫН БАЙНГЫН ТЭМДГҮҮД

Гүйцэтгэгч энэ зүйл ажлыг Гэрээний нөхцлийн Зүйл 42,3-тай холбон авч үзнэ.

Хэрэв Инженерээс өөрөөр зааварчлааγй бол замын бүх тэмдгүүд нь MNS 4597: 2003 стандартын дагуу үйлдвэрлэгдэж, тавигдсан байна.

Гүйцэтгэгч нь Инженерийн зөвшөөрсөн үйлдвэрлэгчээс замын тэмдгийг авах ба замын тэмдгийг үйлдвэрлэгчид аливаа захиалга өгөхөөс өмнө дараахи мэдээлэл бүхий бичиг баримтыг хоёр хувь Инженерт өгч танилцуулсан байна. Үүнд:

а) үйлдвэрлэгчийн нэр, хаяг;

b) нийлүүлэх бүтээгдэхүүний тодорхойлолт,

c) бүтээгдэхүүний чанар, зэрэглэл, жин ба бат бөхийн үзүүлэлтүүд бүхий үйлдвэрлэгчийн гэрчилгээ, тодорхойлолт;

d) үйлдвэрлэгчийн Инженерийн зөвшөөрсөн байгууллага буюу лабораторт хийлгэсан шинжилгээний гэрчилгээ буюу ижил төстэй зүйл төрөл дээр хамгийн сүүлд хийсэн туршилтын дүн;

e) Инженерийн зөвшөөрөл авахад үзүүлэх зорилгоор талбайд хураасан тэмдэг, шон ба бэхэлгээний дээж;

Гүйцэтгэгч нь үйлдвэрлэгч буюу ханган нийлүүлэгчээс дараахи мэдээллийг гаргуулан авч Инженерт өгнө. Үүнд:

- замын тэмдгийг угсрах заавар,
- байршил буюу ашиглалтад тавигдах хязгаарлалтууд,
- тэмдгийн ашиглалтын ба засвар арчлалтын заавар.

Үйлдвэрлэгч нь бараандаа 1 жилийн баталгааг Инженерийн зөвшөөрсөн маягтаар гаргаж өгнө.

Замын байнгын тэмдгийг гэрэл ойлгодог будгаар будсан байна. Гэрэл ойлгодог будаг нь Хэсэг 200-д заасан шаардлагыг хангасан байх ба Инженерийн зөвшөөрлөөр механик вакууман халаах аргаар будна. Гэрэл ойлгогч материал үйлдвэрлэгчийн зөвлөмжийн дагуу, тэмдгийн самбарыг тунгалаг лакаар өнгөлсөн байна.

Замын байнгын тэмдгийн хүрээ рам, шон ба бэхэлгээний урьдчилсан будалт болон хамгаалалтын будгийн чанар нь BS 873 стандартын Хэсэг 2, 6 ба 7-д заасан чанарын шаардлагыг хангасан байна. Өөрөөр зааварчлаагүй бол шон, рам, бэхэлгээ болон тэмдгийн арыг саарал өнгөөр будаж өнгөлсөн байна. Тэмдгийг угсарсаны дараа боолт болон гайкийг хулгайлагдахаас сэргийлж цэгэн гагнуураар гагнаж бэхлэх ба гагнаасыг саарал өнгийн эпокси цавуутай будгаар будсан байна.

Гүйцэтгэгч замын тэмдгийн нүхийг ухаж М 20 маркийн бетоныг нүхний ёроол рүү цутгах ба шонг тойруулан цутгана. Ухалтаас гарсан үлдэгдэл материалыг буцааж булна. Эдгээр ажлыг Зурагт заасны дагуу буюу Инженерийн зааснаар гүйцэтгэнэ. Тэмдгийн суурийн 5m$^2$-аас дээш талбайтай нүхийг Инженерт үзүүлж зөвшөөрөл авахаас нааш буцааж булахгүй.

Гүйцэтгэгч замын тэмдгийн үзэгдэх орчинг хангахын тулд ойр хавийн бут, ургамлыг тайрахаас гадна тэмдгийн орчимд материал овоолж буулгахыг зөвшөөрөхгүй.

Гүйцэтгэгч бүх тэмдгүүдийг Инженер Баталгаат засварын гэрчилгээг гаргах хүртэл арчилж цэвэр байлгах ба хугарсан, гэмтсэн тохиолдолд шон болон тэмдгийг сольж байна.

## 1404 ХАМГААЛАЛТЫН ХАШИЛТ

Гүйцэтгэгч Зурагт үзүүлсэн буюу Инженерээс зааварчилсан байршилд зохих хэмжээ болон өгөдлүүдийн дагуу хашилт барина.

(a) Материал

(i) Нуруу төмөр

Нуруу төмөр нь AASHTO M180 стандартын дагуу А ангилалын 1 зэргийн өнгөлгөөтэй байх ба Инженерийн баталсан үйлдвэрлэгчээс авна.

(ii) Шон

Модон шонгууд нь AASHTO M168 стандартын шаардлагад нийцсэн байх ба Зурагт үзүүлсэн буюу Инженерийн зааварчилсан урттай, оройн хэсгийн голч нь 200мм-ээс доошгүй байна. AASHTO M133 стандартын дагуу хамгаалах бодис түрхэхийн өмнө

шонгуудыг Зурагт үзүүлсэн буюу Инженерийн зааварчилсаны дагуу цоолж хэлбэрт оруулах бөгөөд нурууг тогтооход шаардлагатай боолт гайк, хөндлөвч модыг бэлтгэсэн байна. Хамгаалах бодис түрхсэний дараа шонг тайрах буюу хэлбэржүүлэхийг хориглоно.

Хашилтыг төмөр буюу бетон шонд угсрах зааврыг Инженер өгч болно.

(iii) Хөндлөвч мод

Хөндлөвчийг яргүй, ан цав багатай, сайтар хатаасан хатуу модоор хийнэ. Хэрэв модны цав нь 3мм-ээс гүн байвал тийм модыг ашиглаж болохгүй.

(iv) Хашилтыг угсрах

Хашилтыг үйлдвэрлэгчээс гаргасан зураг, зааврын дагуу, эсвэл Инженерийн зааварчилсанаар угсарна.

Хашилтын байршлыг замын зурагт ойролцоогоор тусгасан байж болох боловч, нарийвчилсан мэдээллийг Инженер Гүйцэтгэгчид тухайн үед нь өгнө. Ер нь, явах ангийн захаас хашилтын дотор тал хүртэл, хөвөөний нийт өргөнийг зурагт заасан хэмжээнд байлгах үүднээс хашилт барих шаардлагатай газруудад далан ба хөвөөг Инженерээс зааварчилсан өргөнөөр хийнэ.

Гүйцэтгэгч хашилтын шон суулгах нүхийг ухаж, шонг зохих журмын дагуу суулгаж хөндлөвч болон хайсыг шонд бэхэлнэ. Хашилт угсрах үед гэмтсэн зэврэлтээс хамгаалах будгийг сэргээх ба шонгийн нүхийг буцааж булан сайтар жигжиж, илүүдэл материалыг зайлуулна.

Хашилтыг угсарч дуусаад Инженерээр батлуулсны дараа гайкуудыг хөдөлгөөнгүй болгох зорилгоор боолтонд буюу хайсны төмөрт гагнаж өгнө.

Гагнуур хийсний буюу тайрсны улмаас гэмтсэн зэврэлтээс хамгаалах будгийг бага температурт хайлдаг цайрын хайлшаар эсвэл тусгай зориулалтын нунтагаар буюу AASHTO M300 шаардлагыг хангасан сайн чанарын органик бус, цайраар баялаг түрхлэгээр хоёр үе будаж засварлана.

(v) Хүлцэх алдаа

Хашилтыг замын тэнхлэгээс заагдсан зай буюу түвшинд ± 20мм-ийн нарийвчлалтайгаар угсарна. Зэрэгцээ залгагдах нуруу төмрийн хоорондох хэвтээ ба босоо түвшин 5мм-ээс илүүгээр зөрж болохгүй.

**1405 ГУДАМЖНЫ ГЭРЭЛТҮҮЛЭГ**

Гүйцэтгэгч Зурагт тусгагдсан буюу Инженерээс зааварчилсан тохиолдолд гудамжны гэрэлтүүлгийг бэлтгэж угсарна. Гүйцэтгэгч гэрэлтүүлгийг суурилуулахын өмнө түүний бүтцийн эд ангиуд, хэмжээ, суурилуулах өндөр болон байршил, гэрлийн төрөл ба хүчин чадал, суурь, цахилгааны утас, угсрах аргачлал гэх мэтийн нарийвчилсан төлөвлөгөөг Инженерт танилцуулж батлуулна. Ялгаруулах гэрэл нь гялбадаг байж болохгүй.

**1406 ЦАС, ЭЛСНЭЭС ХАМГААЛАХ ДАЛАН**

Гүйцэтгэгч нь цас, элснээс хамгаалах даланг Зурагт үзүүлсэний дагуу барина.

**Хамгаалалтын даланд** хэрэглэгдэх материал, далан барих аргачлал зэргийг Инженерт танилцуулж зөвшөөрүүлсэн байна.

**1407 ТӨМӨР БЕТОН ХАШЛАГА**

(i) Хашлага тавих

Замын тодорхой хэсгүүд болон уулзварын орчимд төмөр бетон хашлагыг Зурагт үзүүлсэний дагуу тавина. Ул хөрсний нягтралт 98%-иас багагүй байна. Хашлаганы доод ул болон арын манаасанд 14/20 маркийн бетон хэрэглэнэ. Манаасны бетон бэхжилтээ бүрэн авсаны дараа арын шороон дүүргэлтийг хийж Инженерийн зөвшөөрөх хэмжээнд хүртэл

нягтруулна.

(ii) Хүлцэх алдаа

Хашлаганы хоорондын зай зурагт зааснаас± 2 мм-ээс илүү байж болохгүй. Зэрэгцээ тавигдсан хоёр хашлаганы нүүрэн талын гадаргуу болон дээд талд хэмжсэн төвшин нь 1 мм-ээс илүү зөрүүтэй байж болохгүй.

**1408 ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР**

(а) Ажлын нэр: Дохионы ба километрийн шон

Хэмжих нэгж : ширхэг

Дохионы ба километрийн шонг заасан төрөл тус бүрийн ширхэгээр хэмжинэ.

Дохионы ба километрийн шонгийн ажлын үнэлгээнд дараах ажлууд орно. Үүнд:

- ажиллах хүч ба материал,
- улаан шугам тавих,
- аливаа материалыг тодорхой гүнд ухах,
- дохионы ба тэмдгийн шонг үйлддвэрлэх, дагалдах хэрэгслийг бэлдэх, тэдгээрийг хадгалах ба тээвэрлэх,
- шаардлагын дагуу будах,
- шонгийн сууринд цутгах М 20 маркийн бетон бэлдэх, цутгах, нягтруулах ба арчлах,
- үлдсэн ухмалыг буцааж булах ба нягтруулах,
- ухмалаас гарсан илүүдэл материалыг зөвшөөрөгдсөн газарт аваачиж хаях,
- энэхүү Техникийн Шаардлагын 1401-р Зүйлийн шаардлагатай нийцүүлэх.

Хоолойны тэмдэглэгээнд тусад нь хэмжилт ба төлбөр хийгдэхгүй.

(б) Зүйл : Хашаа

Хэмжих нэгж : м

Хашааг метрээр хэмжинэ. Хашааны уртыг Инженерийн зааварчилсан уртаар буюу гүйцэтгэлийн уртаар тооцно. Техникийн шаардлагын 100, 400, 600 Бүдгүүдэд заасан Гүйцэтгэгчийн үүргийн дагуу буюу Түр ажилтай холбогдуулан барьсан түр хашаанд төлбөр хийгдэхгүй.

Хашааны ажлын үнэлгээнд дараах ажлууд орно. Үүнд:

- ажиллах хүч, материал ба бэхэлгээг бэлдэх,
- хашааг үйлдвэрлэх, тээвэрлэх ба хураах,
- аливаа материалыг аливаа гүнд ухах,
- сууринд цутгах М 20 маркийн бетон бэлдэх, цутгах, нягтруулах ба арчлах,
- үлдсэн ухмалыг буцааж булах ба нягтруулах,
- ухмалаас гарсан илүүдэл материалыг зөвшөөрөгдсөн газарт аваачиж хаях,
- энэхүү Техникийн Шаардлагын 1402-р Зүйлийн шаардлагатай нийцүүлэх.

(в) Замын байнгын тэмдгүүд

Замын байнгын тэмдгүүдийн ажлын үнэлгээнд дараах ажлууд орно. Үүнд:

- ажиллах хүч, шон ба бусад материал, бэхэлгээг бэлдэх,
- тэмдгийг үйлдвэрлэх, тээвэрлэх ба хураах,

- аливаа материалыг аливаа гүнд ухах,
- түр тулгууруудыг бэлдэх, угсарч суулгах,
- М 20 маркийн бетон бэлдэх, цутгах, нягтруулах ба арчлах,
- үлдсэн ухмалыг буцааж булах ба нягтруулах,
- ухмалаас гарсан илүүдэл материалыг зөвшөөрөгдсөн газарт аваачиж хаях,
- энэхүү Техникийн Шаардлагын 200-р Бүлэгт шаардлагатай нийцүүлэх,
- энэхүү Техникийн Шаардлагын 1403-р Зүйлийн шаардлагатай нийцүүлэх.

(i) Ажлын нэр : анхааруулах тэмдэг

Хэмжих нэгж : ширхэг

Анхааруулах тэмдгийг Инженерийн зааварчилсан тэмдгийн төрөл бүрийн ширхэгээр хэмжинэ.

(ii) Ажлын нэр : Зохицуулах, хориглох ба заах тэмдэг

Хэмжих нэгж : ширхэг

Зохицуулах, хориглох ба заах тэмдгийг Инженерийн зааварчилсан тэмдгийн хэмжээ тус бүрийн ширхэгээр хэмжинэ.

(iii) Ажлын нэр : Мэдээллийн самбар

Хэмжих нэгж : ширхэг

Мэдээллийн самбарыг Инженерийн зааварчилсан самбарын хэмжээ тус бүрийн ширхэгээр хэмжинэ.

(iv) Ажлын нэр : Чиглэлийн самбар

Хэмжих нэгж : $м^2$

Чиглэлийн самбарыг Зурагт үзүүлсэн буюу Инженерийн зааварчилсан самбар тус бүрийн талбайн хэмжээгээр хэмжинэ.

(г) Ажлын нэр : Хамгаалалтын хашилт

Хэмжих нэгж : м

Хашилтыг урт метрээр хэмжинэ. Инженерийн зааварчилсан уртаар төлбөр хийнэ.

Хашилтын ажлын нэгж үнэлгээнд дараах ажлууд багтана. Үүнд:

- шон ба бусад материал, бэхэлгээг бэлдэх,
- ажиллах хүч,
- аливаа материалыг зохих гүнд ухах,
- түр тулгууруудыг бэлдэх, угсарч суулгах,
- М 20 маркийн бетон бэлдэх, цутгах, нягтруулах ба арчлах,
- үлдсэн ухмалыг буцааж булах ба нягтруулах,
- ухмалаас гарсан илүүдэл материалыг зөвшөөрөгдсөн газарт аваачиж хаях,
- ажлын тавцан барих,
- энэхүү Техникийн Шаардлагын 200-р Бүлгийн шаардлагатай нийцүүлэх,
- энэхүү Техникийн Шаардлагын 1404-р Зүйлийн шаардлагатай нийцүүлэх.

(д) Ажлын нэр : Гудамжны гэрэлтүүлэг

Хэмжих нэгж : ширхэг

Гудамжны гэрэлтүүлгийг Инженерийн зааварчилсан гэрэлтүүлгийн ширхэгээр хэмжинэ.

Гудамжны гэрэлтүүлгийн ажлын нэгж үнэлгээнд дараах ажлууд багтана. Үүнд:

- ажиллах хүч, шон ба бусад материал, бэхэлгээг бэлдэх,
- аливаа материалыг аливаа гүнд ухах,
- шаардлагатай хэсэгт тулгууруудыг бэлдэх, угсарч суулгах,
- будах,
- М 20 маркийн бетон бэлдэх, шонгийн дор болон шонг тойруулан цутгах, нягтруулах ба арчлах,
- үлдсэн ухмалыг буцааж булах ба нягтруулах,
- ухмалаас гарсан илүүдэл материалыг зөвшөөрөгдсөн газарт аваачиж хаях,
- энэхүү Техникийн Шаардлагын 1405-р Зүйлийн шаардлагатай нийцүүлэх.

(е) Ажлын нэр : Цас, элсний хамгаалалтын далан

Хэмжих нэгж : м

Цас, элсний хамгаалалтын даланг урт метрээр хэмжинэ. Тэдгээрийн уртыг Инженерийн зааварчилсан уртаар авна. Түр ажилтай холбогдуулан барьсан аливаа түр цасны хаалт, элсний хамгаалалтанд төлбөр хийгдэхгүй.

Цас, элсний хамгаалалтын далангийн ажлын нэгж үнэлгээнд дараах ажлууд багтана. Үүнд:

- аливаа материалыг тодорхой гүнд ухаж ачих, тээвэрлэх
- далангийн материалыг тарааж тэгшлэх, шаардлагатай бол услаж нягтруулах
- шаардлагатай бол талбайг цэвэрлэх, материал авах болон далан барих газрын өнгөн хөрсийг хуулж зайлуулах,
- материал авсан газрыг зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл эргүүлж булах, тэгшлэх
- ажил гүйцэтгэхэд шаардлагатай ажиллах хүч, багаж хэрэгслэл, тоног төхөөрөмж ба эдгээртэй холбогдох жижиг зардлуудын бүрэн төлбөр
- энэхүү Техникийн Шаардлагын 1406-р Зүйлийн шаардлагатай нийцүүлэх.

(ё) Ажлын нэр : Төмөр бетон хашлага

Хэмжих нэгж : м

Ажлыг Инженерийн тодорхойлсон уртаар хэмжинэ.

Төмөр бетон хашлага тавих ажлын нэгж үнэлгээнд дараах ажлууд багтана. Үүнд:

- ул хөрсийг нягтруулах
- хашлага болон бетоныг ачих, тээвэрлэх, суурилуулж тавих, заадсыг чигжих
- арын манаас, чигсээсийг хийх, нягтруулах
- тавьсан хашлагыг арчлах
- ажил гүйцэтгэхэд шаардлагатай ажиллах хүч, багаж хэрэгслэл, тоног төхөөрөмж ба эдгээртэй холбогдох жижиг зардлуудын бүрэн төлбөр
- энэхүү Техникийн Шаардлагын 1407-р Зүйлийн шаардлагатай нийцүүлэх.

# БҮЛЭГ 1500 - ЗАМЫН ТЭМДЭГЛЭГЭЭ

## БҮЛЭГ 1500 - ЗАМЫН ТЭМДЭГЛЭГЭЭ


| | | |
|---|---|---|
| 1501 | ЕРӨНХИЙ ЗҮЙЛ | 15-3 |
| 1502 | ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ | 15-3 |
| 1503 | ГАДАРГУУН БЭЛТГЭЛ | 15-3 |
| 1504 | УЛААН ШУГАМ ТАВИХ | 15-3 |
| 1505 | БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯЗГААРЛАЛТ | 15-3 |
| 1506 | ЗАМЫН ТЭМДЭГЛЭЛИЙН АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ | 15-4 |
| 1507 | ТУНГАЛАГ ЛАКААР БУДАХ | 15-4 |
| 1508 | ХҮЛЦЭХ АЛДАА | 15-4 |
| | (а) Өргөн | 15-4 |
| | (б) Байршил | 15-4 |
| | (в) Чиглэл | 15-4 |
| | (г) Тасархай цагаан шугам | 15-4 |
| | (b) Эргэлт дээрх шугам | 15-5 |
| 1509 | ТЭЭВРИЙН ХӨДӨЛГӨӨНӨӨС ХАМГААЛАХ | 15-5 |
| 1510 | ЧАНАРГҮЙ АЖИЛ БА МАТЕРИАЛ | 15-5 |
| 1511 | ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР | 15-5 |
| | (а) Замын тэмдэглэлийн гэрэл ойлгогч материал | 15-5 |
| | (i) : Цагаан шугам, үргэлжилсэн, 150 мм өргөн | 15-5 |
| | (ii) : Цагаан шугам, тасархай, 150 мм өргөн | 15-5 |
| | (iii) : Цагаан шугам, үргэлжилсэн, 100 мм өргөн | 15-5 |
| | (iv) : Цагаан үсэг, цифр, тэмдэг | 15-5 |

## 1501 ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Замын тэмдэглэгээ нь Инженерээс өөрөөр зааварчлаагүй бол MNS 4759 : 2003 стандартын дагуу хийгдэнэ. Замын тэмдэглэлийн хэмжээ, хэлбэр дүрс нь Зурагт үзүүлсэний дагуу эсвэл Инженерийн зааврын дагуу байна. Замын тэмдэглэл бүрийн байршлыг Инженерийн зааврааp тотооно. Тэмдэглэгээний өнгө нь тод цагаан, зарим хэсэгт шар байна.

Замын тэмдэглэгээний халуунаар дэвсэх гэрэл ойлгогч пласик материал нь AASHTO M249 стандартын шаардлагын дагуу байна.

Будганд ашигладаг тунгалаг лак нь AASHTO M247 стандартын шаардлагын дагуу байна.

## 1502 ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

Дараах тоног төхөөрөмжийг хэрэглэнэ:

- Замын гадаргууг цэвэрлэх механик ажиллагаатай шүүр,
- механиксан тунгалаг лак шүршигч бүхий замын тэмдэглэлгээ хийх механик төхөөрөмж.

Замын тэмдэглэгээ болон тунгалаг лакийг зөвхөн механик аргаар тавина.

Замын тэмдэглэгээний төхөөрөмж нь нэгэн жигд хэмжээгээр ба жигд зузаантайгаар дэвсэх чадвартай байна. Эдгээр машинууд нь гадаргуу дээр тогтоосон хүлцэх алдааны хязгаарт тэгш ирмэгтэй, урсалт, барзгар болон үсэргээгүй жигд өргөнтэй шугам тавих чадвартай байна.

Замын тэмдэглэгээ хийх төхөөрөмжийн цагаан шугам тавих өргөнийг тохируулах боломжтой байх ба 5км/цагаас багагүй хурдаар ажилладаг байх ёстой.

Халуун пластик материалыг 3.2-4.8мм-ийн зузаантайгаар механик аргаар тавина. Гүйцэтгэгч нь тоног төхөөрөмжийн шаардлага хангаж байгаа эсэхийг талбайн туршилт хийх замаар Инженерт нотолно.

Үсэг, цифр, тэмдэгүүдийг хэв шаблон ашиглан зам дээр тэмдэглэнэ.

## 1503 ГАДАРГУУН БЭЛТГЭЛ

Битумэн гадаргуу дээр замын тэмдэглэгээг битумын дэгдэмтгий бодис ууршихад хангалттай хугацаа өнгөрсний дараа тавина.

Тэмдэглэгээ тавих гадаргууг усалж, шүүрдэж, хийн даралтаар шаардлагатай хэмжээнд хүртэл нийтэд нь цэвэрлэнэ. Тэмдэглэгээ тавьж эхлэхээс өмнө замын гадаргуу нь цэвэрхэн, хуурай ба шороо, тоос, тос, бензин болон бусад хортой бодисоор бохирдоогүй байна.

## 1504 ЗАМЫН ТЭМДЭГЛЭГЭЭНИЙ УЛААН ШУГАМ ТАВИХ

Үсэг, цифр, тэмдэг, шугам тавих байршилыг урьдчилан тогтоохдоо замын тэмдэглэгээтэй ижил өнгийн будгаар 10мм-ийн голчтой цэгүүд тавьж тэмдэглэнэ. Энэ цэгүүдийн хоорондох зай нь замын тэмдэглэгээг нягт нямбай хийхэд хангалттай, гэхдээ ямар ч тохиолдолд 1.5м-ээс илүү байж болохгүй.

Өөр төрлийн шугамын эхлэл болон төгсгөлийг зам дээр тэмдэглэсэн байна. Бусад тэмдэглэгээний байршил болон хэлбэр дүрсийг замын гадаргуу дээр шохойгоор тавина. Замын тэмдэглэгээний тавигдсан улаан шугамыг Инженерээр шалгуулж зөвшөөрөл авсаны дараа тэмдэглээний ажлыг эхэлнэ.

## 1505 БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯЗГААРЛАЛТ

Дараах нөхцлүүдэд Гүйцэтгэгч замын тэмдэглэгээний ажлаа зогсооно. Үүнд:

- Замын гадаргуу чийгтэй,

- агаарын харьцангуй чийгшэл 80%-иас их,
- агаарын температур 10 °C-аас доош,
- салхины хурд нь замын тэмдэглэлийн ажилд сөргөөр нөлөөлнө гэж Инженер үзвэл

**1506 ЗАМЫН ТЭМДЭГЛЭГЭЭНИЙ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ**

Халуун пластик материалаар үсэг, цифр, тэмдэг, үргэлжилсэн ба тасархай шугамыг Зурагт үзүүлсэний дагуу эсвэл Инженерийн зааварчилгааны дагуу тавина.

Пластик материалыг хайлуулж тунгалаг лактай хамт гадаргуу дээр механик аргаар нэг үеээр тавина. Байнгын ажилд замын тэмдэглэгээний машиныг хэрэглэхээс өмнө Гүйцэтгэгч нь тухайн машин нь Техникийн шаардлагын дагуу ажиллах хүчин чадалтайг, Байнгын ажилд харьяалагдахгүй талбайд талбайн туршилт хийж нотолно. Хэрэв ямар нэгэн тохиргоо хийх шаардлагатай болвол Гүйцэтгэгч машинд зохих тохиргоог хийж, эцсийн үр дүн батлагдах хүртэл талбайн туршилтыг дахин хийж гүйцэтгэнэ.

Талбайн туршилтууд хийгдэж дуусаны дараа дадлага, туршлагатай хүнээр ажиллуулсан, Инженерийн зөвшөөрөл бүхий машиныг байнгын ажилд замын тэмдэглэгээ тавихад ашиглана.

Шаардлагатай гэж үзвэл өдөр бүр замын тэмдэглэгээ дэвсэх орц хэмжээг шалгаж, тохируулна.

Пластик материалыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу хадгалж, бэлтгэнэ.

Замын тэмдэглэгээний будгийг дэвсэх орц хэмжээ нь будах талбайг 3.2мм-ээс багагүй зузаантайгаар зогсолтгүй будахад хангалттай байх ёстой. Дэвсэх орц хэмжээ нь замын гадаргуугийн бүтцээс хамааран өөрчлөгдөж болох ба үүнийг Инженер Талбайн туршилт хийх үеэр тогтооно.

**1507 ТУНГАЛАГ ЛАКААР БУДАХ**

Гүйцэтгэгч нь замын тэмдэглэгээний материалыг тавьсан даруйдаа тэмдэглэгээний машины нэг хэсэг болох шүршигчээр тунгалаг лакыг үргэлжилсэн ажиллагаагаар шүршинэ. Тунгалаг лакийг өөрийн жингийн хүчээр шүршдэг машиныг ашиглаж болохгүй.

Тунгалаг лакийг пластик материалд 0.35кг/м$^2$ ногдох хэмжээгээр буюу Инженерийн зааварчилсан хэмжээгээр тавина.

**1508 ХҮЛЦЭХ АЛДАА**

Замын хөдөлгөөний тэмдэглэгээг дараах хүлцэх алдааны хэмжээнд нягт нарийн тохируулан хийж гүйцэтгэнэ.

(a) Өргөн

Цагаан шугам ба бусад тэмдэглэгээний өргөн нь заасан өргөнөөс 5%-аас илүү хэлбэлзэж болохгүй.

(b) Байршил

Үсэг, цифр, тэмдэг, шугамуудын байршил нь Зурагт үзүүлсэнээс эсвэл Инженерийн зааварчилснаас 20мм-ээс илүү зөрж болохгүй.

(c) Чиглэл

Замын тэнхлэгтэй параллель явах аливаа шугамын ирмэг нь Зурагт үзүүлсэнээс эсвэл Инженерийн зааварчилснаас 15м тутамд 10мм-ээс илүү гажиж болохгүй.

(d) Тасархай шугам

Замын тэнхлэгтэй параллель тавигдах тасархай шугамын урт нь Зурагт үзүүлсэн эсвэл Инженерийн зааварчилснаас 100мм-ээс илүү зөрж байж болохгүй.

(e) Эргэлт дээрх цагаан шугам

Эргэлт дээрх тасархай болон үргэлжилсэн шугамыг хөвч хэлбэрээр бус зөв арк хэлбэрээр, түүнээс 20мм-ээс илүү гажилгүйгээр тавина.

**1509 ТЭЭВРИЙН ХӨДӨЛГӨӨНӨӨС ХАМГААЛАХ**

Замын тэмдэглэгээний гэрэл ойлгогч пластик материал гүйцэд хаттал тээврийн хөдөлгөөнөөс хамгаална. Гүйцэтгэгч бүх шаардлагатай анхааруулах тэмдэг, хаалт, конус, самбар болон бусад хамгаалалтын хэрэгслүүдийг байрлуулах ба бусад шаардлагатай арга хэмжээг авна.

**1510 ЧАНАРГҮЙ АЖИЛ БА МАТЕРИАЛ**

Замын гадаргуу болон бусад гадаргуу дээр тавьсан боловч шаардлага хангаагүй тэмдэглэгээ болон тэмдэглэгээний материалыг Гүйцэтгэгч ирээдүйд тэдгээр нь дахин ил гарч ирэхгүй байхаар өөрийн зардлаар зайлуулна.

**1511 ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР**

(a) Замын тэмдэглэгээний халуунаар дэвсдэг гэрэл ойлгогч пластик материал

(i) Зүйл : 100мм-ийн өргөнтэй үргэлжилсэн цагаан шугам

Нэгж : км

(ii) Зүйл : 100мм-ийн өргөнтэй тасархай цагаан шугам

Нэгж : км

(iii) Зүйл : 100мм-ийн өргөнтэй үргэлжилсэн цагаан шугам

Нэгж : км

(iv) Зүйл : Цагаан үсэг, цифр, тэмдэгүүд

Нэгж : $м^2$

Замын тэнхлэгтэй параллель цагаан шугамын ажлыг километрээр хэмжинэ. Замын тэнхлэгийг хөндлөн огтлох шугамыг метрээр хэмжинэ. Инженерийн зааврын дагуу тавьсан шугамны хэмжсэн уртад төлбөр хийгдэнэ. Тасархай шугамын төлбөрт тасархай зайны хасалт хийхгүй.

Үсэг, цифр, тэмдэгүүдийг хавтгай дөрвөлжин метрээр хэмжинэ. Инженерийн зааврын дагуу тавьсан үсэг, цифр, тэмдэгүүдийг хэмжсэн талбайд төлбөр хийгдэнэ.

Дэд Зүйл 151l (a)-д заасан замын хөдөлгөөний тэмдэглэгээний ажлын нэгж өртөгт дараах ажлууд багтана. Үүнд:

- бүх шаардлагатай материалуудын хангалт, туршилт, тээвэрлэлт, хадгалалт,
- замын тэмдэглэгээний тоног төхөөрөмж нийлүүлэлт,
- шаардагдах ажиллах хүч,
- улааан шугам тавих,
- замын тэмдэглэлгээ тавих ба тээврийн хөдөлгөөний хяналт
- материалыг дэвсэх хэмжээний өөрчлөлт
- хамгаалах арга хэмжээ
- Техникийн шаардлагын Бүлэг 200-т заасан шаардлагыг биелүүлэх ба
- Бүлэг 1500-т заасан шаардлагыг биелүүлэх.

# БҮЛЭГ 1600 - НОГООН БАЙГУУЛАМЖ

## БҮЛЭГ 1600 - НОГООН БАЙГУУЛАМЖ


| | | |
|---|---|---|
| 1601 | ЕРӨНХИЙ | 16-3 |
| 1602 | НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨЛТ | 16-3 |
| 1603 | НОГООН БАЙГУУЛАМЖ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН АНХААРАХ ЗҮЙЛС | 16-4 |
| 1604 | ЗҮЛЭГЖҮҮЛЭХ ТАЛБАЙ БЭЛТГЭХ, ҮР ТАРИХ, АРЧЛАХ | 16-6 |
| 1605 | МОД, СӨӨГИЙН ҮР ТАРИХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА | 16-8 |
| 1606 | ГОЛТБОРЫН ТӨРЛИЙН УРГАМЛЫГ ТАРИХ, АРЧЛАХ | 16-10 |
| 1607 | МОД, СӨӨГИЙН СУУЛГАЦ АРЧЛАХ | 16-11 |

## 1601 ЕРӨНХИЙ

Хот, тосгоны цэцэрлэгжүүлэлтийг төлөвлөхдөө нийтийн хэрэгцээний, хязгаарлагдмал зориулалттай, тусгай зориулалттай гэсэн ангиллыг баримтална. Авто болон төмөр замын барилга байгууламжийн хамгаалалтын зурвас нь хязгаарлагдмал зориулалттай цэцэрлэгжүүлэлтийн ангилалд хамаарна. Тус бүлэгт ногоон байгууламжийн төлөвлөлтийн үндэс болон бут сөөг, зүлэгжүүлэлтийн ажлыг хийх бэлтгэл ажил, тарих, суулгалт, арчлалт, хэлбэржүүлэлтийн тухай хамруулсан болно.

## 1602 НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Ногоон зурвасын өргөнийг хүснэгт-16-1-н дагуу сонгоно.

Хүснэгт 16-1: Ногоон зурвасын өргөний хэмжээ

| Ногоон зурвас | Өргөний хэмжээ (м-ээр) |
|---|---|
| 1. Эгнээ мод буюу мод сөөг<br>А. Нэг эгнээ суулгах<br>Б. Хоёр эгнээ суулгах | <br>2<br>5 |
| 2. Нэг эгнээ сөөг<br>А. Өндөр (1.8 м-с өндөр)<br>Б. Дунд зэргийн (1.2-1.8м)<br>В. Намхан (1.2 м хүртэл) | <br>1.2<br>1<br>0.8 |
| 3. Бүлэглэж тавьсан<br>А. Мод<br>Б. Сөөг | <br>4.5<br>3 |
| 4. Зүлгэн зурвас | 1 |
| 5. Цэцэрлэг<br>А. Нэг давхар барилгажилттай<br>Б. Олон давхар барилгажилттай | <br>4<br>6 |

Тусгаарлах зурваст суулгах бутлаг ургамлын өндөр нь 0.8м-с ихгүй байх.

Ногоон байгууламжийг суулгах газрын гадаргууг 0.5-5.0% налуутай төлөвлөнө.

Эгнээлж тарих мод, бутны хоорондох хамгийн бага хэмжээг хүснэгт 16-2 дагуу төлөвлөнө.

| Ногоон байгууламжийн шинж чанар | Мод ба сөөгийн хоорондох зай /м/ |
|---|---|
| Наранд тэсвэртэй модны төрөл | 3-6 |
| Сүүдэрт тэсвэртэй модны төрөл | 2.5-5 |
| 1м хүртэл өндөр сөөг бут | 0.4-0.6 |
| 2м хүртэлх өндөр сөөг бут | 0.6-1 |
| 2м-с дээш өндөр сөөг бут | 1-1.5 |

Ногоон байгууламж ба барилга байгууламжийн хоорондын зайн төлөвлөлт

Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээнээс мод, бут сөөгийн тэнхлэг хүртэлх зайн доод хязгаарыг хүснэгт 16-3-т заасны дагуу төлөвлөнө.

| Барилга байгууламж инженерийн шугам сүлжээ | Барилга байгууламж инженерийн объектын тэнхлэг хүртэлх зай, м | |
|---|---|---|
| | Мод | Бут сөөг |
| Барилга байгууламжийн гадна хана, тоног, шугам сүлжээнээс | 5 | 1.5 |
| Цахилгаан тээврийн хэрэгслийн замын далангийн захаас | 5 | 3 |

| | | |
|---|---|---|
| Явган хүний зам, цэцэрлэгжсэн замын далангийн захаас | 0.7<br>2 | 0.5<br>1 |
| Гудамжны зорчих хэсгийн зах, замын хажуугийн бэхэлсэн зурвасын хөвөө буюу сувгийн ирмэгээс | | |
| Гэрэлтүүлгийн шугамын тулгуур, шон, гүүрний тулгуур, мордмол гүүрний тулгуур замын гэрэлтүүлгээс | 4<br>3 | 1<br>1 |
| Терралын ул, дэвсэг болон түшиц ханын дотоод ирмэг буюу улнаас | 2 | 1 |
| Гадар доорх шугам сүлжээ, ариутгах татуургын шугам, дулааны шугамаас | | |

**Тайлбар:**

1. Энэхүү норм нь 5м хүртэлх диаметр бүхий титэмтэй модонд хамаарна. Түүнээс их диаметртэй мод хүртэлх зай хэмжээг төслийн даалгаврын дагуу төлөвлөнө.
2. Цахилгаан дамжуулах агаарын шугамаас мод хүртэлх зайг цахилгаан тоног төхөөрөмжийн норм дүрмээр тодорхойлно.
3. Барилгын дэргэд суулгах мод нь БНбД 30.01.04-н 9-р бүлэгт заасан шаардлагын дагуу орон сууц, олон нийтийн байрны нарны шууд тусгал, гэрэлтүүлэг саад болохгүйгээр байх ёстой.

## 1603 НОГООН БАЙГУУЛАМЖ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН АНХААРАХ ЗҮЙЛС

Хөрс, уур амьсгалын нөхцөл, мөнх цэвдэгт хөрстэй эсэх, үеийн гүн зэргийг тооцож, суулгацын төрөл, зориулалт, түүнчлэн суулгацын материалыг зөөвөрлөн авчрах боломж зэрэгтэй уялдаатай ногоон байгууламжийг байгуулна. Үндсэн зарчмууд:

- Хуучин байсан ургамал, ялангуяа мод, сөөг, үржил шимт хөрсийг аль болох хадгалан үлдээх,
- Зориулалт, нар, салхины нөлөөлөл, агаарын бохирдолт, хөрсний нөхцөл зэрэг тухайн нөхцөл байдалтай уялдаатайгаар мод, сөөгийн нэр төрөл, тарих хэлбэрийг сонгох,
- Хүрээлэн байгаа орчны архитектурын нэгэн чухал элементийн хувьд төрөл бүрийн мод сөөгийн өнгө, титмийн хэлбэрийг оновчтой тохируулан ашиглах,
- Ногоон ургамлыг хамгаалалтын бүс, барилга байгууламжийн дэвсгэр газрын зааг болгох зэргээр боломжтой газар бүхэнд ашиглах,
- Хөрсийг сайжруулах арга хэмжээг боловсруулахдаа тухайн хөрсний үржил шим, хөрсийг зөөвөрлөх, хадгалах, хэрэглэх мод бут сөөг, ургамлын нэр төрлийг тодорхойлох,

Бэлтгэл ажил эхлэхийн өмнө хог хаягдал, том ширхэгтэй чулуу зэргийг цэвэрлэж зайлуулсан байх ёстой. Мод, сөөг тарих ажил эхлэхээс өмнө цэцэрлэгжүүлэх тохиромжийг дараах байдлаар ангилна. Үүнд:

- Үржил шимтэй хөрс (хар шороон, хүрэн, нугын хөрс) ялзмагт үеийн зузаан 15см-с багагүй, хөрсний усны түвшин нь 1м-с доош байх
- Үржил шим багатай хөрс (нуга-намгийн бор саарал, элсэнцэр, давсархаг хөрс) түүнийг хатаах, давсгүйжүүлэх, бордох, шинээр хөрс авчирч механик бүтцийг нь сайжруулах зэрэг арга хэмжээг зураг төсөлд тусгасан байх
- Үржил шимгүй хөрс (элс, чулуулаг, шаварлаг, хөрс болон тэдгээрийн хольц) огт хөрсгүй нүцгэн чулуулаг хурдас мөн энэ ангилалд хамаарна.

Хязгаарлагдмал зориулалттай цэцэрлэгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэх, гудамжны дагууд цэцэрлэгжүүлэлтийн ажлыг хийхдээ шаардлагатай тохиолдлуудад хөрсний усны түвшнийг доошлуулах, давсгүйжүүлэх, түүнчлэн үржил шим багатай хөрсийг зүлэгжүүлэхэд үржил шимтэй хөрсөөр нэмж ялзмагт хөрсийн зузааныг 20см хүргэж хучих,

мод, сөөг тарих нүхний шороог бүрэн болих, үржил шимгүй хөрстэй газарт мод, сөөг зүлэг тарихаар тухайн хөрсийг бүрэн болих зэрэг арга хэмжээг төлөвлөнө.

Барилга байгууламжийн суурийн нүх ухах, газар доорх шугам сүлжээний суваг, шуудуу малтах, өндөржилтийн зургийн дагуу хөрс хуулах буюу нэмж хучих зэрэг газар шорооны ажлын үед үржил шимт болон зарим үржил шим багатай хөрсний ялзмагжсан өнгө үеийг 20см, зүлгэн хөрсийг 6-8см зузаан хуулан авсан байх. Хуулан авсан ширэг, үржил шимт хөрсийг түр хугацаагаар хадгалах газрыг барилгын талбай дахь барилгын ажлыг явуулахад саад болохооргүй, барилгын хог, орчны үржил шингүй хөрс зэрэгтэй холилдож нийлэхээргүй газарт сонгон авна. Хуулан авсан хөрсийг буцааж хучих, түүнчлэн өнгөн үеийг үржил шимтэй хөрсөөр нэмж хучих буюу солихын өмнө ул хөрсийг 15-10см гүн сийрэгжүүлсэн байна. Үржил шимтэй хөрсийг хөлдүүгээр нь мод, сөөгийн шороонд ашиглахыг хориглоно.

Мөнх цэвдэгтэй газрын улирлын хөлдөлтийн үе нь 1.5м-с нимгэнгүй байдаг хэсгийг цэцэрлэгжүүлж болох бөгөөд үүнээс нимгэн байх хот, суурины нөхцөлд онцгой шаардлагатай гэж үзвэл дээрх үеийн зузааныг 1.5м хүртэл ихэсгэх арга хэмжээг хэрэгжүүлэх үндсэн дээр цэцэрлэгжүүлэхийг зөвшөөрнө.

Мод сөөгийг тарих хугацаа нь ургамлын амьдралын үйл ажиллагаа суларсан үе, хавар хөрс гэсэхдээ эхлээд мод навчлах үе, намар навч унах үеэс эхлээд хоногийн дундаж халуун, хүйтний хэмжээ $0^0$С-с бага болох үеийн хооронд байна.

Бут сөөгийн хоорондын зайг нормчлохгүй. Бут сөөгөөр таримал хашаа байгуулахдаа тусгай шуудуунд суулгах бөгөөд түүний хэмжээг бут сөөгийг нэг эгнээгээр тарихад 50х50см, хоёр эгнээгээр тарихад 70х50см, гурван эгнээгээр тарихад 90х60см, өөрөөр хэлбэл эгнээний тоо өсөх тутамд шуудууны өргөн 20см-р ихсэж байхаар авна.

Нийтийн хэрэгцээний болон хязгаарлагдмал хэрэгцээний зориулалттай цэцэрлэгжүүлэлтийг мод сөөгийн онцлог шинж чанаруудыг харгалзан, үзэмжтэй сайхнаар тарихаар төлөвлөнө.

Мод сөөг таригдаагүй сул газарт зүлэг, цэцгийн мандал байгуулах, орон нутгийн чулуу зэрэг материалаар ангилж хучихаар төлөвлөвөл зохино.

Замын уулзвар, явган хүний гарцын орчинд мод, сөөг тарихдаа замын хөдөлгөөний дүрмийн дагуу харааны чөлөө гаргах шаардлагыг тооцно.

Мод, сөөг тарьсан эхний жилд тэдгээрийг арчлан тордох талаар дараах арга хэмжээнүүдийг төлөвлөвөл зохино. Үүнд:

- Цэцэрлэгжүүлсэн хэсгийг тойруулан мод, төмөр, торон материалаар 5-7 жилээс багагүй эдэлгээтэй, хөнгөн маягийн хайс хийх,
- Хөрс, уур амьсгалын байдалд нь тохируулан усалгаа, сийрэгжүүлэлт, бордолтыг тогтмол хийх,

Хангай, тал хээрийн бүсэл тогтмол усалгааг 3-4 хоногт 1 удаа шүрших аргаар, оройн цагаар усалгааны шугам буюу усалгааны машинаар хийнэ.

## 1604 ЗҮЛЭГЖҮҮЛЭХ ТАЛБАЙ БЭЛТГЭХ, ҮР ТАРИХ, АРЧЛАХ

### (а) Ангилал

Зүлгийн таримлын үрийн чанарыг соёололт, ургах эрчим, 1000 үрийн жин, цэвэршилтээс хамаарч доорх байдлаар ангилна.

- Нэгдүгээр зэрэг
- Хоёрдугаар зэрэг

Үрийн чанарын үзүүлэлтээр стандартын шаардлага хангаагүй бол стандартын бус үр гэнэ.

Зүлэгт тариалах олон наст таримлын үрийн чанарын үзүүлэлт хүснэгтэд заасан шаардлагыг хангаж байх ёстой.

Хүснэгт 16-4: Олон наст ургамлын тарих үрийн чанарын үзүүлэлт

| Ургамлын төрөл зүйл | Үрийн чанарын зэрэг | Үрийн цэвэршилт, % | Бусад ургамлын үрийн хэмжээ , % | 1кг үрэнд байх хог ургамлын үр, ш | Соёололтын доод хэмжээ, % |
|---|---|---|---|---|---|
| Соргой Согоовор | I | 95 | 0.6 | 500 | 80 |
| | II | 85 | 1.5 | 1000 | 70 |
| Улаан Ботууль | I | 95 | 0.5 | 250 | 85 |
| | II | 85 | 1.5 | 350 | 75 |
| Нугын Ботууль | I | 95 | 0.5 | 250 | 85 |
| | II | 85 | 1.5 | 350 | 75 |
| Саман Ерхөг | I | 90 | 0.8 | 500 | 80 |
| | II | 85 | 2.0 | 1000 | 70 |
| Нугын биелэг | I | 95 | 0.5 | 500 | 75 |
| | II | 85 | 1.0 | 42000 | 65 |
| Дагуурын Өлөнгө | I | 90 | 1.5 | 500 | 80 |
| | II | 85 | 2.0 | 1000 | 70 |
| Сибирийн Өлөнгө | I | 90 | 0.6 | 500 | 85 |
| | II | 85 | 1.5 | 1000 | 75 |
| Шар Царгас | I | 90 | 0.5 | 500 | 85 |
| | II | 85 | 1.0 | 1000 | 75 |
| Хөх Царгас | I | 90 | 0.5 | 500 | 85 |
| | II | 85 | 1.0 | 1000 | 75 |
| Улаалж | I | 95 | 0.5 | 500 | 85 |
| | II | 85 | 1.0 | 1000 | 75 |
| Улаан толгой | I | 95 | 0.5 | 500 | 80 |
| | II | 85 | 1.0 | 1000 | 70 |
| Талын Дурваалиг | I | 95 | 0.5 | 500 | 85 |
| | II | 85 | 1.5 | 1000 | 75 |

**(б) Зүлэгжүүлэх талбайг бэлтгэх**

Зүлэгжүүлэх талбайг явган хүний замын түвшингээс 5см доор байрлуулна. Шинээр ашиглалтад орсон барилгын ойролцоох талбай болон мод сөөг тарьсан талбайг зүлэгжүүлэхдээ барилгын хаягдал хог, чулуу, хайргыг зөөж, талбайгаас зайлуулна. Талбайн хөрсийг 18см-с 20см гүн хагалж, хайрга чулууг түүж, цэвэрлэн, үлдсэн шороог буталж, нунтаглана.

Хөрсийг 25мм х 25мм диаметртэй шигшүүрээр шигшиж, ургамлын үндэс, бусад хольцоос цэвэрлэнэ.

Өнгөн хөрсийг шигшсэн элс хар шороог 1:2 хэмжээтэй хольж бэлтгэнэ.

Зүлэгжүүлэх талбайд хөрсийг 20см-н зузаантай дэвсэж, булдаж, нягтруулан, сайтар тэгшилнэ. Талбайг бэлтгэсний дараа 20см гүнд нэвчтэл усална.

**(в) Үр тарих**

Үр тарихын өмнө соёололт, амьдрах чадвар, цэвэршилт, 1000 үрийн жинг лабораторид тодорхойлно. Тариалах үрийн гормыг 1м2 талбайд тариалах үрийн хэмжээг тооцон тарина.

Хүснэгт 16-5: 1м2 талбайд тарих үрийн хэмжээ

| Ургамлын нэр | Орос нэр | Латин нэр | Үрийн хэмжээ, г |
|---|---|---|---|
| Соргүй согоовор | Костер Безостый | Poa pratence | 13.5-18.0 |
| Улаан ботууль | Овсяница красная | Fustuca rubra | 14.0-18.0 |
| Нугын ботууль | Овсяница луговая | Fustuca pratense | 14.0-18.0 |
| Саман ерхөг | Житняк гребенчатый | Agropyron cristatum | 10.5-16.5 |
| Нугын биелэг | Мятлик луговой | Bromus inermis | 21.0-30.0 |
| Дагуурын өлөнгө | Волоснец | Elymus dahuricus | 22.5-24.0 |
| Сибирийн өлөнгө | Волоснец сибирский | Elymus sibiricus | 22.4-24.0 |
| Шар царгас | Люцерна жёлтая | Medicago falcata | 21.7-27.0 |
| Хөх царгас | Люцерная синяя | Medicago staiva | 21.7-27.0 |
| Улаалж | Осока твердоватая | Carex duriuscula | 14.0-18.0 |
| Улаан тоолгой | Полевица | Agrostis clavata | 14.0-18.0 |
| Талын дурваалиг | Тимофеевка луговая | Phleum Phleoides | 14.0-18.0 |

Тарих шаардлага

Хотын ногоон байгууламж мод, мөөг, цэцэгт байгууламжтай, усан сан, оргилуур бүхий том цэцэрлэгийн сул задгай талбайг зүлэгжүүлэхэд согоовор, ботууль, биелэг өвс

Мод, сөөг, цэцгийн мандал, тоглоомын талбай, явган зам бүхий цэцэрлэгт гудамж, орон сууцны барилгын хооронд ерхөг, согоовор

Албан байгууллагын орчим, хотын төв хэсэгт ботууль болон гоё үзэмжтэй ургамлыг тасралтгүй цэцэглэж байхаар тооцоолж тарина.

Хажуу, налуу газарт хөрс хучигч галуун гичгэнэ.

Хотын доторх эргэ жалга, судгийн эргээр царгас, хийг

Биеийн тамирын талбай, цэнгэлдэх хүрээлэнд галуун гичгэнэ таривал зохионо.

Зүлэгжүүлэх талбайд олон наст ургамлын үрийг дангаар буюу хольцоор тарина.

Үрийг салхи багатай, тогтуун өдөр талбайд жигд цацаад, хөнгөн хөрсөнд 3см дунд зэрэг хөрсөнд 2см, шавранцар хөрсөнд 1см зузаан хучна. Шүдний хооронд 7-8см зайтай тармуурыг 2см хүрэл гүр ортол самнаж ховилд нь үрийг цувуулж хийгээд гадаргууг элсээр хучна. Үр тарьсны дараа хавтгай банз модоор булдаж, зөөлөн шүршиж усална.

Зүлгийн ургамлын үрийг мод, сөөг тарьсны дараа 5-р сарын 2-р 10 хоногоос 6-р сарын 30-д багтааж тарина.

Мод, сөөг тарьсан тогоонд зүлгийн ургамлын үр тарихгүй.

**(г) Зүлгийн арчилгаа**

Тарьсан үрийг соёолтол нь хөрсний 5-с 10см-н гүнд тогтмол чийгтэй байлгана. Усалгааг өдөр бүр өглөө, оройн сэрүүн 1м2 талбайд 30-40л усаар маналдуулж усална.

Үр соёолсноос хойш 20-30л ус ноогдохоор бодож, долоо хоногт 2-4 удаа гандуу үед өдөр бүр өглөө, оройн сэрүүнд усална. (Зүлгийн ургамлын үр тарьсан талбайг машинаар услахдаа хамгийн нарийн шүршүүрээр зөөлөн усална)

Цэнэг усалгааг 10-р сарын 15-30 хүртэл хугацаанд хийнэ.

Хавар цас хайлж, газар гэссэний дараа талбайг тармуураар самнаж, хагд, хог шороог цэвэрлэх, нягтарсан хөрсийг сийрэгжүүлэх, үр ургаагүй, халцарсан газрын зүлгийг нөхөн тарих зэргээр арчилна.

Хог ургамлыг эхний жил үндэстэй нь зулгаан авч зайлуулна.

Ногоон байгууламжид тарьсан зүлгийг 14 хоног тутамд 10см өндөртэй хяргаж тэгшлэхэд бутлалт сайтай өтгөн болж ургана.

Зүлэгт тариалсан таримлын өвөлжих чадварыг нэмэгдүүлэх зорилгоор цас тогтоох, цэнэг усалгаа хийх, ургамлын хучлага бий болгох зэрэг арга хэмжээ авна.

Хөрсний үржил шимийг сайжруулахын тулд хавар эрт зүлэг ургаж эхэлмэгц нэмэлт бордоог 1м2 талбайд азот 40г, Форфор 43гр бордож, зөөлөн усална.

## 1605 МОД, СӨӨГИЙН ҮР ТАРИХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

**(а) Ангилал**

Үрийг жигд гүнд, нэгэн ижил зайтай мөрөөр тарина. Үүнд:

- Өргөн мөрөөр эгнүүлэн тарих /мөр хоорондын зай 45см/
- Нарийн мөрөөр эгнүүлэн тарих /мөр хоорондын зай 10-20см/
- Ердийн мөрөөр тарих /мөр хоорондын зай 25см-р/

**(б) Үр тарих хугацаа**

Мод, сөөгийн тарьц намрын цочир хүйтрэлтээс өмнө моджиж, өвлийн хүйтнийг тэсвэрлэх чадвартай торнисон байхаар үр тарих хугацааг тогтооно. Намар тарих үрийг шууд тарихад байгалийн нөхцөлд өөрөө өвлийн турш тарилтад бэлтгэгдээд, хавар эрт соёолж, үндэс нь түргэн хөгжиж, гадаад орчны нөхцөлийг тэсвэрлэх чадвартай болно.

**(в) Мод, сөөгний үр тарих хэмжээ**

Үр тарих хэмжээг үрийн чанар, соёололт, ургах эрчим, цэвэршилт, мянган үрийн жин, мод үржүүлгийн газрын байгаль газар зүйн нөхцөл, ургуулах агротехникийн аргаас хамаарч ялгаатай тогтооно.

Мод сөөгний үр тарих дундаж хэмжээ, хүснэгтэд заасан хэмжээнд байна.

Үр тарих гүн нь тухайн ургамлын биологийн болон ургах орчны хөрс, цаг уурын онцлогоос шалтгаалан харилцан адилгүй байна. Том үрийг гүн, жижиг үрийг гүехэн тарихаас гадна бүтэц сайтай хөнгөн хөрсөнд үрийг гүн , хүнд хөрсөнд гүехэн, хуурай хөрсөнд чийг ихтэй талбайгаас гүн тарина.

Хүснэгт 16-6: Мод, сөөгний үр тарих хэмжээ, хугацаа

| Мод, сөөгний нэр | 1000 үрийн дундаж жин, г | 1 метр урт мөрөнд тарих үрийн хэмжээ, г | | Үр тарих гүн, см | | Тарих хугацаа |
|---|---|---|---|---|---|---|
| | | Ойн бүсэд | Ойт хээрийн бүсэд | Ойн ба хээрийн бүсэд | Хээрийн бүсэд | |
| Гацуур | 5.1 | 1.8 | 2.5 | 1.0-2.0 | - | Хавар, намар |
| Жодоо | 11.0 | 5.0 | 6.0 | 0.5-1.5 | - | Хавар, намар |
| Нарс | 5.6 | 1.5 | 1.5-2.0 | 0.5-1.4 | - | Хавар, намар |
| Хуш | 25.0 | 7.0 | 8.0 | 2.0-3.0 | - | Намар |
| Шинэс | 7.0 | 3.0 | 4.0 | 0.5-1.5 | 1.5-2.0 | Хавар |
| Арц | 11.0 | 2.0 | 3.0 | 1.5-2.0 | 2.0-3.0 | Намар |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Майлаас | 2.0 | 1.0 | 1.2 | 1.5-2.0 | 2.0-2.5 | Хавар, намар |
| Хайлаас | 3.9 | 0.5-1.0 | 1.1-1.5 | 1.5-2.0 | 2.0-2.5 | 6-р сард |
| Чацаргана | 13.0 | 3.0 | 3.5 | 1.5-2.0 | 2.0-2.5 | Хавар, намар |
| Нохойн хошуу | 12.0 | 2.0 | 2.5 | 1.5-2.0 | 2.0-2.5 | Намар |
| Тэс | 3.6 | 1.8 | 2.0 | 1.5-2.0 | 2.0-2.5 | Намар |
| Монос | 65.0 | 6.0 | 7.0 | 2.0-2.5 | 2.5-3.0 | Намар |
| Шар хуайс | 25.0 | 3.5 | 4.0 | 2.0-2.5 | 2.5-3.0 | Хавар, намар |
| Гүйлс | 530.5 | 38.0 | 40.0 | 2.5-3.0 | 3.0-4.0 | Хавар, намар |
| Буйлс | 259.4 | 20.0 | 25.0 | 2.0-2.5 | 2.5-3.0 | Хавар, намар |
| Өрөл | 4.0 | 0.5-1.0 | 1.5-2.0 | 1.5-2.0 | 2.0-2.5 | Хавар, намар |
| Хус | 0.2 | 0.1 | 0.15 | 0.5-1.0 | 1.0-1.2 | 6-р сард |

Мод, сөөгний үрийг тарихын өмнө хөрсийг MNS 6263:2011 стандартын дагуу боловсруулан, талбайг тэгшлэн хөрсийг сайжруулсан байна.

Үр тарилтын хэмжээг нарийн мөрдөж бүх талбайд жигд тарьсан байвал зохино. Мод сөөгний үрийг эгнээ хооронд 60-70см-н зайтай эгнүүлэн тарих эсвэл зэрэгцээ 2 мөрний хооронд 35-45см, хос мөрний хооронд 10-20см зайтайгаар туузлан тарина.

Үр тарих даланг чийгтэй хөрсөнд газраас 10-15см дээш, чийг багатай хөрсөнд газраас 5-7см доор0.9-с 1.2м өргөн байгуулна. Далангийн хооронд 30-40см зайтай байна.

Гараар тарихдаа бэлтгэсэн ховил гаргагчаар тарих мөрөө шаардагдах өргөн, гүнтэйгээр гарган, үрээ тарина.

Үрийг тарьсны дараа сэвсгэр шороо, модны үртсээр 1.5-2см хүртэл булна .

### 1606 ГОЛТБОРЫН ТӨРЛИЙН УРГАМЛЫГ ТАРИХ, АРЧЛАХ

Цэцэрлэгжүүлэлтийн зориулалтаар мод үржүүлгийн газрын бойжуулгын талбайд 2 настай тарьцыг шилжүүлж, 4-с багагүй жил ургуулсан, MNS 6255:2011 стандартын 1-р зэргийн шаардлага хангасан голтборын суулгацыг үндэстэй хамт ухаж авна.

Голтборын суулгацын үндсийг баглаж боохдоо MNS6773:2019 стандартыг мөрдөнө.

Суулгацын нүхийг MNS6255:2011 сөөгний суулгац, техникийн шаардлага хангасан суулгац суулгах нүхийг MNS6773:2019 стандартын дагуу ухаж бэлтгэсэн байна.

Голтборын суулгацыг түр хадгалахдаа MNS6773:2019 стандартын дагуу үндэс, титмийг хаталтаас хамгаалж түр хадгална.

**Голтборын суулгацыг суулгах**

Хот суурин газрыг цэцэрлэгжүүлэхэд зориулсан суулгацыг хавар 4-р сарын 15-с 5-р сарын 25 хүртэл, намар 10сарын 1-11-р сарын 1-г хүртэл хугацаанд суулгана.

Голтборын суулгацыг нүхний голд байрлуулан үндэсний хүзүүг газрын түвшингээс 15см-с багагүй гүнд суулгаж, нүхэнд шороог бага багаар хийж, үндэсний хүзүү хүртэл дүүргэн нягтруулсны дараа ханатал усалсан байна.

Голтборыг ногоон байгууламжид ганц нэгээр нь тарихаас гадна намхан сөөгүүд нэг ба олон наст өвслөг ургамлуудтай хослуулан тарьж болно.

Голтборыг зүлгэн дунд 3-7ш ширхэг байхаар ургамал хооронд 2-2.5м зайтай бүлэглэн сонгох нь илүү зохимжтой. Бүлэглэхдээ нэг юм уу өөр зүйлийг сонгож болох боловч өнгө баг цэцгийн хэлбэр, хэмжээ зэргийг хослуулж зохицуулах нь чухал.

Голтборыг эгнээгээр тарихад нягт шигүү титэмтэй үүсгэх бол ургамал хоорондын зай 1-1.5м, сийрэг титэм үүсгэх бол 2-2.5м зайтай тарина.

**Голтборын суулгацыг арчлах**

Голтборын төрлийн ургамлыг суулгах нүх нь газрын гадаргын түвшингээс доош 15см-20см байна.

Голтборын төрлийн суулгац суулгасны дараа 50л-с 60л усаар ханатал усална. Суулгацыг суулгасны эхний сард 3-5 хоногт 1 удаа, дараагийн саруудад 5-7 хоногт 1 удаа ургамлын хашлаганд 40-50л, тогоонд 30-40л усаар усална.

Хоёр дахь жилээс эхлэн 5-7-р саруудад 7 хоногт 1 удаа, дараагийн саруудад 10 хоногт 1 удаа усална.

Нэг удаагийн усалгааны хэмжээг 8-р сараас ихэсгэж, услагаа хийх хоорондох хугацааг тухайн жилийн цаг агаарын нөхцөл байдлыг харгалзан тогтооно.

Хавар 4-р сар, намар 10-р сард 3-5 удаа цэнэг усалгаа хийнэ. Голтборын төрлийн ургамлыг өсөлтийн үед нэмэлт бордоо хэрэглэнэ.

Тарьсан ургамлын орчны хөл газрын ургамлыг цэвэрлэж, хөрсийг сийрүүлнэ. Хөл газрын ургамлыг сөөгний суулгаж тарьсан эхний 3 жилд ургалтын хугацаанд 6-8 дугаар саруудад тус бүр 1 удаа түүж эсвэл хадаж цэвэрлэнэ. Цаашид жилд 1-2 удаа хийнэ.

## 1607 МОД, СӨӨГИЙН СУУЛГАЦ АРЧЛАХ

**(а) Суулгацыг арчлах**

Суулгасан мод, сөөг цаашид амьдрах эсэх нь гагцхүү арчлалт хамгаалалтаас шалтгаалдаг учир услах, бордох, хөл газрын ургамлыг устгах, хөрс сийрүүлэх, титмийн хэлбэржүүлэлт, таналт тайралт хийх зэрэг арчилгааг цаг хугацаад нь тогтмол хийнэ.

Суулгацыг суулгах үед хөрсийг ханатал услах нь үндсийг эрчимтэй хөгжих нөхцөлийг бүрдүүлнэ.

Усалгааг суулгацыг суулгасны эхний сард 3-5 хоногт 1 удаа, Дараагийн саруудад 5-7 хоногт 1 удаа 60-80л усаар усална. Хоёр дахь жилээс эхлэн 5-7-р саруудад 7 хоногт 1 удаа, дараагийн саруудад 10 хоногт 1 удаа хөрсний чийгийн багтаамж 50% -с доошгүй байхаар усална. Ургамлан хашлаганд тарьсан сөөгний уртаас метр тутамд 30-40л усаар усална. Мод, сөөг тарьсан эхний жил усалгаа хийсний дараа үндэсний хүзүү орчмын хөрсийг нягтруулна. Хавар 4-р сар, Намар 10-р сард цэнэг усалгаа хийнэ.

Модны өсөлтийг сайжруулахын тулд мод, сөөгний орчныг бордсоны дараа усална. Тарьсан модны орчин тойрны хөл газрын ургамлыг цэвэрлэж, хөрсийг сийрэгжүүлнэ. Хөл газрын ургамлыг мод, сөөгний суулгац тарьсан эхний 3 жилд ургалтын хугацаанд 6-8-р саруудад тус бүр 1 удаа цэвэрлээ. Цаашид жилд 1-2 удаа хийнэ.

Мод сөөгний титмийн жигд өсөлт, гадаад үзэмжийг харгалзан хавар эрт, намар орой титмийг хэлбэржүүлж засаж танах, үхэж, хатсан мөчрөөс цэвэрлэж, шинээр салаалсан хажуугийн мөчрийг тайрч, иш гаргаж хэлбэржүүлэх, залуужуулах, цэвэрлэгээний огтлолтуудыг хийнэ.

Хэлбэржүүлэх тайралтаар удаан ургалттай модны сүүлийн жилийн өсөлтийн 25-50%-г, түргэн ургалттай модны өсөлтийн 70-80%г тайрна.

Залуужуулах тайралтаар өсөлт нь зогсонги байдалд орсон, хөгширч муудсан, үхсэн мөчрүүдэд, найлзуур нь үзүүрээсээ хатаж байгаа мод, сөөгөнд хийнэ.

Цэвэрлэгээний тайралтаар мод, сөөгөнд өвчин, хортны голомт үүссэн, гэмтсэн, буруу ургалттай, хатаж хуурайшсан мөчир, найлзуурыг цэвэрлэх зорилгоор хийнэ.

**(б) Суулгацыг хамгаалах**

Тарьсан мод, сөөгний суулгац, зүлгийг хүн, машин, малын хөлд гишгэгдэхээс хамгаалж хайс хийж, явган хүний зам гаргасан байна.

Газар хөлдөхөөс өмнө тарьсан мод, сөөгийг ханатал усалж, суулгацыг хөлдөхөөс хамгаалж цас тогтооно. Шаардлагатай бол мод, сөөгний суулгацыг зориулалтын материалаар хучиж өвөлжүүлнэ.

Мод, сөөгний гэмтсэн хэсгийг зэсийн байван (10л усанд 300гр-с ихгүй хийж) ариутгаж, гадна талаас нь будах буюу хатуу цаасаар хамгаалж бооно.

Хугарсан, гэмтсэн, мөчир, найлзуурыг хурц хутга, мөчир тайрагч хайчаар эгц огтолж тэр хэсэгт тосон будаг, модны замаск түрхэж хамгаалсан байна.

Модны ишийг нарны төөнөлтөд түлэгдэж гэмтэх, шавж, өдөр, шөнийн температурын хэт хэлбэлзлээс хамгаалах зорилгоор шохойн уусмалаар будна.

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгааг MNS4969:2000 стандартын дагуу өгнө.

# БҮЛЭГ 1700 – ЯВГАН ХҮНИЙ ЗАМ, ТАЛБАЙ

z


| | | |
|---|---|---|
| 1701 | ЕРӨНХИЙ | 17-3 |
| 1702 | БЭЛТГЭЛ АЖИЛ | 17-3 |
| 1703 | ЯВГАН ХҮНИЙ ЗАМЫН ХУЧИЛТЫН БҮТЭЭЦ | 17-5 |
| 1704 | ЯВГАН ХҮНИЙ ЗАМЫН ХУЧИЛТ | 17-5 |
| 1705 | БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ | 17-9 |

## 1701 ЕРӨНХИЙ

Энэ бүлэгт явган хүний зам, талбайн геометр хэмжээсний хүлцэх алдаа, технологийн аргачлал болон бүтээц хийц, эдлэлд тавих шаардлагуудыг хамруулсан болно. Явган зорчигчийн чөлөөтэй зорчих нөхцөлийг хангасан зам нь доор дурдсан шаардлагад нийцсэн байна. Үүнд:

1. Явган хүний зорчих хэсэг саадгүй байна.
2. Явган хүний замын дээгүүр байрлах зүйлс 2100мм -с дээш байна.
3. Явган хүний замын хажууд байрлуулсан зүйлс 100мм-с бага байна.
4. Жигд, тогтвортой, халтиргаанаас сэргийлсэн гадаргуутай байна.
5. Гэрэлтүүлэг сайтай.
6. Дагуу налуу 8%-с бага байна.
7. Хөндлөн хэвгий 2%-с бага байна

Хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настай хүний зорчих боломжийг хангасан байна. Тус бүлэгт бэлтгэл ажил, газар шорооны ажил, хучилтын хийц барилга угсралтын ажлуудын үед тавих шаардлагуудыг хамруулсан. Бэлтгэл ажилд барилга угсралтын ажлын өмнөх ажлууд болох мэдээлэх самбар болон тав тухтай, аюулгүй зорчих нөхцөлийг хангах арга хэмжээг тусгав. Газар шорооны ажилд ул хөрс, хучилтын доорх суурь үеийн материалд тавих шаардлагуудыг тусгав. Хучилтын хийц хэсэгт төрөл бүрийн хучилтын хийцүүдэд тавих шаардлага болон хавтан өрөх технологийн аргачлалыг багтаасан болно.

## 1702 БЭЛТГЭЛ АЖИЛ

### 1702.1 Барилга угсралтын бэлтгэл ажил

Явган хүний зам, талбайн барилга угсралтын ажлыг хийхдээ гүйцэтгэгч нь зураг төсөл, техникийн шаардлагыг хангасан барилгын материал, хийц, эдлэл болон тоног төхөөрөмж ашиглан барилгын ажлыг гүйцэтгэнэ. Барилга угсралтын ажлын график төлөвлөгөө, баримт бичгийн бүрдэл, ажлын дараалал зэргийг “Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын жишиг техникийн шаардлага” ЗЗБНбД 31-008-2016 -г мөрдөн ажиллана.

### 1702.2 Явган хүний замын чанар

Барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн чанарыг сайжруулахад мэргэшсэн инженер техникийн ажилчдыг ажиллуулах нь чухал ба ажилчдыг энэ чиглэлээр мэргэшүүлэх сургалтуудад хамруулсан байх шаардлагатай. Тухайн ажлын сонгон шалгаруулалтыг зарлахдаа мэргэжлийн зэргийн нотлох баримт, баталгаажуулалтын талаах урьдчилан тусгаж, мэргэшсэн замчид, ажилчдаар барилгын ажлыг гүйцэтгүүлэх нь явган хүний замын чанар, насжилт, эдийн засагт чухал үр нөлөөтэй.

### 1702.3 Барилга угсралтын үе дэх иргэдийн санал гомдлыг шийдэх

Явган хүний зам, талбайн ажлын үед гүйцэтгэгч нь иргэд, явган зорчигчийн тав тухтай байдалд учруулах саадыг бууруулах арга зааварчилгааг боловсруулж захиалагч болон инженерээр батлуулах ба барилгын ажлын график төлөвлөгөөг чанд мөрдөж иргэдээс гаргах гомдлыг цаг тухай бүрд нь шийдвэрлэнэ.

### 1702.4 Барилга угсралтын ажлын үеийн мэдээлэх самбар байрлуулах

Явган хүний зам, талбайн томоохон бүтээн байгуулалтын ажил эхлэхээс өмнө сонин хэвлэл, цахим хуудас, дүүрэг хорооны хурлаар дамжуулан иргэдэд мэдээлэхэд анхаарч ажиллах ба барилгын талбайн эхлэл болон төгсгөл хэсэгт мэдээлэх самбарыг заавал байрлуулна. Тухайн хот суурин газрын иргэд болон жуулчдын тав тухыг алдагдуулахгүй, явган зорчигчийг замаар саадгүй зорчих нөхцөлөөр хангаж, барилгын ажлын зорилгыг энгийн иргэд төдийгүй гадаадын жуулчин ойлгохоор мэдээг самбарт тусгасан байна. Барилгын мэдээлэх самбарыг барилгын ажил эхлэхээс дуусах хүртэл талбайн эхлэл төгсгөл хэсэгт явган зорчигчийн хөдөлгөөнд саад учруулахгүй зөв байрлалд суурилуулна. Самбар суурилуулахдаа дараах зарчмуудыг баримтална. Үүнд:

1. Барилгын ажлын талбайн эхлэл, төгсгөл цэгийн ойролцоо 10м орчим зайд замын хашлага дагуу суурилуулах
2. Зорчих, хэсэг үзэгдэх орчинд саад учруулахгүйгээр суурилуулах
3. Явган хүний зорчих хэсэг ялангуяа харааны бэрхшээлтэй хүнд зориулсан хөтөч хавтан дээр суурилуулахгүй байх
4. Инженертэй зөвшилцсөний дагуу үзэгдэх орчин хангалттай ногоон байгууламжийн ойролцоо суурилуулах
5. Хэмжээ 900мм х 1800мм харьцаатай байх
6. Салхинд хийсэж унахааргүй материалтай зөөврийн самбар ашиглах
7. Барилгын ажлын нэрийг монгол, англи хэл дээр бичих
8. Самбар эхлэх, дуусах хугацааг тодорхой бичих
9. Захиалагчийн нэр, хариуцсан мэргэжилтний утас бичих
10. Зураг төсөл зохиогч байгууллагын нэр, хаяг, холбоо барих утас бичих
11. Гүйцэтгэгч байгууллагын нэр, хаяг, холбоо барих утас бичих

### 1702.5 Хамгаалалтын хаалт хашилт байрлуулах

Явган хүний зам талбайн барилга угсралтын ажлыг хамгаалалтын хашилтын дотор гүйцэтгэх ба иргэдийг төөрөгдүүлэхгүйгээр зорчих боломж нөхцөлийг заавал хангах шаардлагатай. Явган хүний замын ажил эхлэхээс өмнө хийгдэх ажил болон ажлын үе шат бүрээр нарийвчилсан төлөвлөгөө боловсруулж, хамгаалалтын хашилт суурилуулах төлөвлөгөө гаргана. Хамгаалалтын хаалт нь “Авто замын хаалт” MNS6517 стандартын шаардлагыг хангасан байна.

### 1702.6 Замын зохицуулагч

Явган хүний замын ажил хийх үед түр зам байгуулах шаардлагатай талбайд иргэдийн зорчих нөхцөлийг хангах зорилгоор замын зохицуулагчийг ажиллуулна. Зам барилгын ажлын явцад түр замын урт 10000мм – 30000мм хооронд байвал замын зохицуулагчийг 1 хүн/өдөр, 30000мм-с их бол замын зохицуулагчийг 2 хүн/ өдөр буюу замын хоёр талд байрлуулж ажиллуулна. Замын зохицуулагчийн ажлын хувцас хэрэглэлд шар хантааз, ажлын үнэмлэх, хамгаалалтын малгай, гутал, цагаан бээлий, дохиур мод, шүгэл багтана. Явган хүний зохицуулагч чиг үүрэгтэй байна. Үүнд:

1. Барилгын ажлын үед явган зорчигчдод түр замыг зааж өгнө
2. Түр замын хамгаалалтын хашилт, явган зорчигчдод зориулсан мэдээлэх самбар зэргийг тогтмол шалгана
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүн, бага насны хүүхэд, өндөр настныг замаар зорчиход тусална
4. Явган хүний замын ажилтай холбоотой иргэдийн санал гомдлыг хүлээн авч, талбайн инженерт хүлээлгэн өгнө
5. Явган хүний замын ажлын ерөнхий мэдээлэл өгөх, сурталчлан ойлгуулна
6. Явган зорчигчийн аюулгүй байдлыг хангана.

### 1702.7 Явган хүний түр зам байгуулах

Явган хүний зам, талбайн барилгын ажлыг хийж гүйцэтгэх явцад явган зорчигчдын ая тух, аюулгүй байдлын үүднээс заавал түр явган замд байгуулна. Барилгын ажлын үед түр зам гаргах боломжийг бэлтгэл ажлын үед судалж, орон зай хангалттай тохиолдолд шинээр барих болон шинэчлэх явган хүний замын хажуу талд түр замын гаргана.

Явган хүний замын өргөн 4000мм-с дээш бол барилгын ажлын хэсэгчлэн гүйцэтгэх технологийн дагуу хийх ба 4000м-с бага өргөнтэй, түр зам гаргах боломжгүй тохиолдолд авто зам дээр хаалт хийн явган зорчигчдыг чөлөөтэй зорчих нөхцөлийг заавал бүрдүүлж өгнө. Явган хүний замын хучлага байгуулахаас өмнө явган зорчигч барилгын талбайгаар өнгөрөн гарах шаардлага үүсвэл суурийн доод үе, суурийн үеийг сайтар нягтруулсан байх ёстой бөгөөд резинэн зөөлөвчтэй шалавч, модон хавтанг дэвсэж зорчигчийн аюулгүй байдлыг хангана. Түр замд дэвссэн шалавчийг хотын өнгө үзэмжид нийцсэн халтирдаггүй материалаар хийгдэнэ. Түр зам байгуулаагүй эсвэл ямар нэгэн байдлаар түр замыг

шийдээгүй бол захиалагч болон хариуцсан албан тушаалтан ажлыг зогсоох тухай шийдвэр гаргана.

### 1702.8 Барилга угсралтын талбайн бэлтгэл

Барилга угсралтын ажлыг талбайд материал, хийц эдлэл хураахдаа хамгаалалтын хашилт барьж нэг цэгт төвлөрүүлнэ. Мөн замын хавтан зүсэх ажилбараас үүсэх тоосжилтоос хамгаалах арга хэмжээ авч иргэдийн тав тухыг алдагдуулахгүй байхад анхаарна. Барилгын материалыг хураан цэгцлэхдээ гадуур нь хашилт байрлуулж, осол аваар гарахаас сэргийлнэ. Барилга угсралтын ажлын үед орчны бохирдол үүсэхээс сэргийлсэн арга хэмжээг авч ажиллана.

## 1703 ЯВГАН ХҮНИЙ ЗАМЫН ХУЧИЛТЫН БҮТЭЭЦ

Хучилтын бүтээж нь хучлага, суурь болон дэд сууриудын үеэс бүтнэ.

### 1703.1 Суурийн доод үе

Дээрээс ирэх ачааллыг хүлээн авах үе юм. Суурийн доод үе гэдэг нь далангийн дээд үе болон суурь хоёрын дунд оршдог үеийг хэлнэ. Суурийн доод үеийн шороон материал нь шороон орд, ухмалын материал болон чулууны карьераас тэсэлгээгүйгээр гаргасан зохист ширхэглэлийн бүрэлдэхүүнтэй материал байна.

1. Суурийн доод үеийн материалд тавих шаардлага
2. Нягтруулалт

### 1703.2 Суурь үе

1. Материалд тавих шаардлага
2. Буталсан чулуун суурь
3. Суурь дэвсэх
4. Нягтруулалт
5. Хүлцэх алдаа
6. Хяналт шалгалт

## 1704 ЯВГАН ХҮНИЙ ЗАМЫН ХУЧИЛТ

Явган хүний замын хучлага нь аюулгүй зорчих нөхцөл, тав тух, тэгш байдлыг хангах, замын мэдээлэгч болох гэх мэт үүрэгтэй бөгөөд өрмөл бетон хавтан, хөтөч хавтан, асфальтбетон, цементбетон, байгалийн чулуун, резин гэх зэрэг төрөлтэй.

### 1704.1 Хавтант хучлага

Хавтант хучлагыг явган хүний замаас гадна авто зам, зогсоолд өргөн ашигладаг. Хавтант хучлагын Чанарыг бататгахын тулд хавтан хоорондын зайн хэмжээг баримтлах ба завсраар нь дүүргэх элсний чанар ч мөн адил чухал үүрэгтэй байдаг. Явган хүний замын хучилтын бүтээцийн давхаргуудад ашиглаж буй материал олох хавтан, элс хайрга, зохист ширхэглэлийн бүрэлдэхүүнтэй суурийн материалуудын физик чанарууд нь чухал элемент учраас материал сонголтод анхаарна.

Хүснэгт 17-1: Хавтант хучлагын материал сонголт

| | Зориулалт | Хавтангийн төрөл | Зузаан | Гулзайлтын бат бэх, МПа | Шахалтын бат бэх, МПа |
|---|---|---|---|---|---|
| Хавтан | Явган хүний зам талбайд | Хязгаарлахгүй | ≥60мм | 5 дээш | 20 дээш |
| | Зогсоолд | Зиг заг болон тоосгон хэлбэртэй | ≥80мм | | 42 дээш |

Хавтан хоорондын зайг тохируулан, хавтангийн төрлөөс хамааран өрөлтийг зөв хийснээр дээрээс ирэх ачаалал жигд хуваарилагдаж хавтанд эвдрэл үүсэхгүй. Мөн хавтан

хоорондын зайг зөв тохируулснаар таягтай болон тэргэнцэртэй иргэд ая тухтай зорчих нөхцөлийг бүрдүүлдэг. Явган хүний замын хавтан өрөхөд хоорондын зай нь хавтангийн хэмжээнээс хамаарна.

Хүснэгт 17-2: Хавтан хоорондын зайн хэмжээ

| Хавтан | Хавтан хоорондын зай |
|---|---|
| Том хавтан | 3 мм |
| Жижиг хавтан | 2 мм |

Хавтан хоорондын зайг дараах аргаар тохируулахдаа явган хүний замын хөндлөн чигт татсан утаснаас илүү гарсан буюу чиг алдсан хавтанг буцаан тааруулахдаа модон хавтан ашиглаж резинэн алхаар тогшиж тааруулна.

Хавтан өрөх үед хавтангууд нь үндсэн хөндлөн чигээс дотогш орсон байвал нарийн шовх үзүүртэй төмөр ашиглан заадас хооронд чигжин түлхэх замаар зайг тохируулна.

Хавтан хоорондын зайг элсээр дүүргэхээс өмнө тохируулна.

**1704.2 Хавтант хучлагын элсэн дэвсгэр үе**

Явган хүний замын элсэн үе хавтангаас ирэх ачааллыг хуваарилж хавтангийн тэгш байдлыг хангах үүрэг гүйцэтгэдэг. Элсэн үед ашиглах материал гүйцэтгэлийн чанараас шалтгаалж хавтангийн өрөлт овон товонтой жигд биш болдог тул материал гүйцэтгэлд хяналт тавьж ажиллана.

1. Элсэн материалын шаардлага
   Хавтангууд хөдөлгөөнгүй байх чанарыг дээшлүүлэхийн тулд засварт нь элсээр чигжих, хавтангийн тэгш байдлыг хангаж дээрээс ирэх ачааллыг жигд хуваарилах үүрэг гүйцэтгэдэг.

   Хүснэгт 17-3: Элсэн материалын шаардлага

| Ангилал | Ширхэглэлийн хэмжээ | Бусад |
|---|---|---|
| Хавтангийн заадсанд ашиглах элс | Элсний ширхэглэлийн бүрэлдэхүүний хамгийн их хэмжээ 2.5мм-с доош, 0.08мм-н хэмжээтэй шигшүүрээр өнгөрөх хэмжээ 10%-с доош | Элсийг зөвхөн хатааж хэрэглэх |
| Элсэн үе | Элсний ширхэглэлийн бүрэлдэхүүний хамгийн их хэмжээ 5мм-с доош, 0.08мм-н хэмжээтэй шигшүүрээр өнгөрөх хэмжээ 5%-с доош | - |

2. Хавтан хоорондын заадсыг элсээр дүүргэх технологи
   Хавтангийн заадас дүүргэгч материал болох элсийг нойтон хэлбэрээр ашиглахгүй. Заадас дүүргэгч элсийг хавтангийн налуу ирмэгийн доод түвшин хүртэл хийнэ. Суурийн үеийг суултаас хамгаалахын тулд сууринд элсийг жигд тараан дэвсэх ба хөндлөн хэвгий болон замын чигийг тодорхойлж гар аргаар хэвтээ чиглэлд тэгшилгээ хийнэ.
3. Хавтангийн гадаргууг нягтруулах
   Явган хүний замын хавтан өрөлтийг хийсний дараа шаардлага хангасан хуурай элсийг хавтан хоорондын зайд чигжин резинэн ултай нягтруулагчаар нягтруулна. Хавтан хоорондыг элсээр чигжих нь хавтан өрөлтийн гүйцэтгэлд чухал үүрэг гүйцэтгэдэг тул элсэн чигжээсийг шаардлагын дагуу хийхгүй бол хавтан хөдөлгөөнд орох, суулт өгөх, эвдрэх шалтгаан болдог учраас дараах байдлаар хийнэ. Үүнд:

- Хавтан өрсний дараа элсээр чигжихээс өмнө сайтар нягтруулна.
- Нягтруулсны дараа хавтан хоорондын зайг шууд элсээр чигжинэ (1өдрийн дотор).
- Хавтан хоорондын зайг элсээр чигжихдээ элс хавтангийн өнгөн хэсэгт гарч иртэл дараах ажиллагааг үргэлжлүүлэн давтана. Элсийг хавтангийн өнгөн хэсэгт жигдхэн тараана. Энэ үед өнгөн хэсгийг шүүрээр шүүрдэж буй мэт сайтар тараана.
- Хавтан хоорондын зайг элсээр чигжсэний дараа резинэн ултай доргиурт нягтруулагчаар нягтруулна. Нэг газар олон дахин нягтруулахыг хориглоно. Нэг тэнхлэг дээр 2 удаа нягтруулалт хийнэ. Хэрэв нягтрахгүй байвал дээрх үйлдлийг 3-4 удаа давтана. Нягтруулалт хийж болохгүй газарт резинэн алхаар нягтруулна.
- Хавтан хооронд элс чигжсэний дараа хучиж хамгаална.
- Элсээр чигжсэний дараа нягтруулалт хэрхэн хийснийг шовх үзүүртэй зүйл хавтангийн завсраар шургуулан хийж шалгана. Элс чигжсэний дараа үлдсэн илүү элсийг шүүрдэж эсвэл ус цацаж цэвэрлэнэ. Явган хүний замын хавтанг тэгш хөдөлгөөнгүй суурилуулсан байх шаардлагатай бөгөөд бусад инженерийн байгууламжтай ижил түвшинд, ус цугларах тогтох байдал үүсэхээргүй байна.
-

Хүснэгт 17-4: Хавтангийн хүлцэх алдаа

| № | Нэр | | Шаардлага болон хүлцэх алдаа |
|---|---|---|---|
| 1 | Урт, өргөн | | |
| | 250мм | | ±4 |
| | 250мм-500мм | | ±5 |
| | 500мм-1000мм | | ±6 |
| 2 | Зузаан, мм | | ±5 |
| 3 | Зузааны зөрүү, мм | | ≤2 |
| 4 | Нүүр гадаргуун тэгш байдлын хазайлт, мм | | 5 |
| 5 | Ирмэгийн эвдрэл, мм | | Эвдэрсэн хэсгийн хоёр талын хэмжээ 5мм-с ихгүй байна |
| 6 | Гулсалтын эсэргүүцлийн утга | | 36 БПН |
| 7 | Давхарлалт | | Зөвшөөрөхгүй |
| 8 | Гадаргуун зуурамтгай чанар, см2 | | Зөвшөөрөхгүй |
| 9 | Цууралт,мм | Нэвчилттэй | Зөвшөөрөхгүй |
| | | Нэвчилтгүй | Зөвшөөрөхгүй |

### 1704.3 Цементбетон хучлага

Явган хүний замын цементбетон хучлагын үзүүлэлт “Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын жишиг техникийн шаардлага” ЗЗБНбД 31-008-2016 болон “Бетон. Шаардлага, гүйцэтгэл, үйлдвэрлэл ба тохирол” MNS EN 206-н шаардлага хангасан байна.

### 1704.4 Асфальтбетон хучлага

Явган хүний замын асфальтбетон хучлагын үзүүлэлт “Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын жишиг техникийн шаардлага” ЗЗБНбД 31-008-2016-н хучлага бүлэг, “Асфальтбетон хольц. Техникийн шаардлага” MNS 1592-н шаардлага хангасан байна.

Хүснэгт 17-5: Асфальтбетон хучлагын үзүүлэлт

| Төрөл | Хүлцэх алдаа, мм | Шалгах давтамж | | Шалгах арга |
|---|---|---|---|---|
| | | Хамрах хүрээ, у/м | Тоо, ш | |
| Тэгш байдал | ≤5 | 20 | 1 | 3м рейкээр шалгана |
| Хөндлөн хэвгийг хэмжих | 0 | 20 | 1 | Нивелирээр шалгана |
| Дагуу залгаасны тэгш байдал | ≤8 | 20 | 1 | 20м урттай утас татаж хамгийн их үзүүлэлтийг авна |
| Хөндлөн залгаасны тэгш байдал | ≤5 | 20 | 1 | 20м урттай утас татаж хамгийн их үзүүлэлтийг авна |

**1704.5 Чулуун хучлага**

Уулын оргимол хатуу чулуулгаас зүсэж бэлтгэсэн болон зассан чулуугаар хотын гудамж, зам, талбайн хучлага барих ажил. Замын гадаргууд дэвсэж, суурийн үеүдийг хучихад зориулсан экологийн хамгийн цэвэр, бат бэх бөгөөд урт эдэлгээтэй материал бол байгаль дээр орших төрөл бүрийн цэвэр чулуу юм. Учир нь тэлгээр нь температурын эрс өөрчлөлтөөс ямар ч эвдрэлд ордоггүйн дээр дотор нь ус орж бүтцийг эвдэж болох ан цавгүй байдаг. Байгалийн чулуунаас бүтээгдэхүүн үйлдвэрлэх орчин үеийн технологи нь төрөл бүрийн хэлбэр, загвартай бөгөөд зүсмэл, хагалмал, хагас боловсруулсан болон зүлгэж өнгөлсөн гадаргуутай гэх мэт олон янзын чулууг бэлтгэх бололцоог олгож байна. Минералын шинж чанар ба экологийн аюулгүй байдлаараа байгалийн чулуу нь цэцэрлэгт хүрээлэнгийн доторх зам, авто зам, гүүр, явган хүний зам ба зогсоолын талбай зэргийг өнгөлж хучихад өргөн хэрэглэнэ. Өрмөл чулуун хучлага нь замын бусад бүх төрлийн хучлагаас чанар ба өртгийн хувьд хамаагүй илүү бөгөөд удаан эдэлгээтэй байдаг. Нөгөө талаас чулууг зөв өрж, дэвссэн нөхцөлд суулгасан чулууг солих шаардлага огт гардаггүй онцлогтой. Зөв аргачлалын дагуу, сайн хийсэн өрмөл чулуун хучлага нь тэр болгон онцгой арчлалт шаардаад байдаггүйн дээр олон арван жилийн туршид өнгө хэлбэрээ алдалгүй, өө сэвгүй байдлаа хадгалсаар байдаг. Харин ашиглалтын явцад хучлага аль нэг хэсэгтээ ямар нэгэн хэв гажилтад орж, суулт үүссэн тохиолдолд цөөн тооны чулууг сугалан авч, эвдрэлийг засаад дахин өрж дэвсэх замаар байнга нөхөн сэргээх боломжтой. Бусад шаардлагууд нь “Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын жишиг техникийн шаардлага” ЗЗБНбД 31-008-2016-н хучлага бүлгийн чулуун хучлагын шаардлагыг хангасан байна.

Хүснэгт 17-6:Чулууны хүлцэх алдаа

| Чулууны хэмжээс ба гадна байдал | Хүлцэх алдаа, мм |
|---|---|
| Огтолсон пирамид хэлбэртэй бүх төрлийн чулууны урт | ±15 |
| Огтолсон пирамид хэлбэртэй бүх төрлийн чулууны өргөн | ±10 |
| Шоо дөрвөлжин чулууны бүх талууд | ±10 |
| Дээд суурийн ирмэг эмтэрсэн ба мөлийсөн | Зөвшөөрөхгүй |
| Доод суурийн ирмэг эмтэрсэн ба мөлийсөн | Зөвшөөрөхгүй |
| Босоо ирмэгийн эмтэрсэн өнцгийн урт | Зөвшөөрөхгүй |
| Дээд талын зэргэлдээ орших ирмэгүүдийн тэгш өнцгийн гажилт | <4 |
| Дээд талын гадаргуугийн тэгш бус байдал | <10 |

Хүснэгт 17-7: Чулууны физик, механик шинж чанар

| Үзүүлэлт | Шаардлага |
|---|---|
| Шахалтын бат бэх, кгс/см2 | >1000 |
| Хүйтэн тэсвэрлэлтийн марк, F | >100 |
| Усанд ханасан үе дэх шахалтын бат бэхийн бууралт, % | <20 |
| Элэгдэл, г/см2 | <0.5 |

### 1704.6 Резин хучлага

Резин хучлага нь нэг давхаргатай, цул, уян хатан, хурдан цутгах боломжтой хучлага юм. Явган зам, унадаг дугуйн зам, хүүхдийн тоглоомын талбай, Цэцэрлэгт хүрээлэнгийн зам зэрэгт өргөн хэрэглэдэг. Угсарч суурилуулахад хялбар боловч арчилгаа бусад хучлагын төрлүүдийг бодвол их шаардана. Хаягдал дугуйг дахин боловсруулж ашигладаг тул байгаль орчинд ээлтэй бөгөөд гадаргуу нь гулсалтын эсэргүүцэл багатай аюулгүй байдаг. Уг хучлагыг бетон, асфальтбетон, хайрган суурь, явган хүний замын хучилтын хавтан зэрэг эвдрээгүй гадаргуу дээр хэрэглэнэ. Барилгын ажлыг нар мандсанаас хоёр цагийн дараа эхлэх ба цаг агаар, салхины хурд болон агаарын чийгшлийг 75%-с бага анхаарах хэрэгтэй. Резинэн хучлагын гадаргуун зөрүү ±2мм-с хэтрэхгүй.

## 1705 БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ

### 1705.1 Хөндлөн хэвгийг талбай дээр гаргах

Явган хүний замын гадаргуун усыг саадгүй урсгах нөхцөлийг хангахын зэрэгцээ явган зорчигчийн тав тухтай орчин бүрдүүлэхийн тулд хөндлөн хэвгийг 2%е-с доош байхаар гүйцэтгэнэ. Явган хүний замын хөндлөн хэвгийг суурийн доод үеэс эхлэн гаргана. Хэрэв суурийн доод үеэс хэвгийг гаргаагүй элсэн дэвсгэр үе дээр хэвгийг гарган хийвэл явган хүний замд суулт үүсэх аюултай.

### 1705.2 Хавтанг өрөх, суулгах

Явган хүний замын хавтанг өрөхдөө явган зорчигчийн аюулгүй байдал, тав тухтай байдлыг хангах зорилгоор тэгш байдал, хавтан хооронд зай завсаргүй байх чанарыг тооцож материалд тавих шаардлага болон барилга угсралтын шаардлагыг мөрдөнө. Хавтангууд хоорондох зайгүй нягт, байх чанарыг хангахын тулд дараах зүйлсийг шалгаж хянасан байна. Хавтан суулгахаас өмнө материалын шаардлагыг хангаж байгаа эсэхийг нягтлан лабораторид шилжүүлнэ. Мөн тухайн газарт зориулах бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн газрыг өөрчилж болохгүй. Учир нь үйлдвэрлэлийн газрыг өөрчилснөөр хавтангийн геометр хэмжээ өөрчлөгдөх сөрөг талтай. Мөн тухайн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг урьдчилан авч уг хавтангийн хэмжээгээр хашлага суулгах өргөний зай хэмжээг тогтоож, хавтангуудыг өрөхөд өргөдөх болон дутах эрсдэлийг тооцно. Явган хүний хавтант хучлагатай хийцэд хавтанг буруу өрснөөс үүдэн эвдрэх магадлал их байдаг тул өрөлтөд гол анхаарлыг хандлуулах нь чухал.

Явган хүний замын хавтант хучлагын тэгш бус хэлбэр дүрстэй хавтан ашиглах өрөх тохиолдолд заавал замын зах ирмэг хэсэгт хийх зориулалтын нэг тал нь тэгш хавтан хэрэглэнэ.

### 1705.3 Хавтанг тайрах, хуваах технологи

Хавтан үйлдвэрлэгч бүрийн хавтангийн хэмжээ ялгаатай байдаг тул барилгын ажил эхлэхээс өмнө харилцагч үйлдвэрлэгч байгууллагын хавтангийн хэмжээг шалгаж урьдчилан туршилт явуулснаар замын өргөнийг тодорхойлно. Мөн замд таарах мод, шон зэрэг саадыг тооцоолон аль болох хавтанг зүсэж тайрахгүй байх зарчмыг баримталж зайлшгүй тохиолдолд дараах заалтыг мөрдөнө. Үүнд:

1. Хоёр талаас тайрсан хавтан хагарч эвдрэх магадлалтай учир нь аль болох ашиглахаас зайлсхийнэ.

2. ЗҮсэлт хийсэн хавтангийн урт өргөний харьцаа 2:1-с дээш байвал амархан эвдэрдэг тул ашиглахгүй.
3. Зүсэлт хийж 2500мм2-с бага жижиг болгосон хавтанг өрөлтөд ашиглахгүй.
4. Хавтанг хуваахад алх ашиглахыг хориглох ба заавал зориулалтын зүсэгч машин болон гидравлик таслагч машин хэрэглэнэ. Шаардлагатай тохиолдолд механик ажиллагаатай зүсэгч ашиглана.
5. Хавтанг зүсэхээс өмнө үзэг харандаагаар тэмдэглэн, зүсэгч машины ирний зузааныг тооцож зүснэ.

### 1705.4 Аливаа байгууламжийн ойролцоо хавтан өрөх технологи

Зам дээрх аливаа байгууламжийн ойролцоо дөрвөлжин зүссэн хавтан ашиглахгүй бүтэн хавтангуудыг өрж өрөлтийн чиглэл өөрчилснөөр хаягдал хавтан гаргахгүй сайн талтай. Хашлага орчмын хавтанг зайлшгүй зүссэн хавтан ашиглах шаардлага гарвал жижиг дөрвөлжин хавтан ашиглаж өрөх чиглэлийг өөрчилж хийнэ.

1. Хашлага орчмын хавтан өрөлт
2. Ус зайлуулах шуудуу орчмын хавтан өрөлт

Зам дагуух шуудуу орчимд явган хүний замын хавтанг өрөхдөө аль болох захын хавтанг ашиглахыг эрмэлзэх хэрэгтэй ба зайлшгүй тохиолдолд хавтантай ижил өнгийн бетоноор хийнэ. Бетоны өргөний хэмжээ 100мм-с ихгүй байна.

3. Үзлэгийн дугуй худаг, траншейны нүх орчмын хавтан өрөлт

Үзлэгийн худгийн тагийг замын хавтангийн хээтэй нийцүүлэн хийж болно. ҮЗлэгийн худаг орчмын хавтанг өрөхөд хавтан худгийн тагтай амлан нийлэх хэрэгтэй. Зайлшгүй шалтгааны улмаас нийлэх боломжгүй үед бетоноор шавах боломжтой бөгөөд энэ үед үзлэгийн худаг төмөр тагтай байвал 100мм-с бага, жижиг хавхалгатай байвал 50мм-с бага хэмжээгээр хавтантай өнгө дагуу бетон цутгана.

4. Үзлэгийн дөрвөлжин худаг, траншейны нүх орчмын хавтан өрөлт

Дөрвөлжин үзлэгийн худгийн орчимд хавтан өрөхдөө дараах заалтуудыг баримтална. Үүнд:

- Жижиг дөрвөлжин хавтан ашиглана.
- Үзлэгийн худгийн тагтай түвшин зөрөөгүй байна.
- Хавтан хоорондын зайг баримтална.
- Зүсэлтийг 1 удаа хийж хэлбэрийг тааруулна. Хоёр удаа зүсэлт хийж болохгүй.

5. Гэрэлтүүлгийн шонг тойруулж хавтан өрөх

Шонгийн суурь дугуй хэлбэртэй бол үйлдвэрээс гарсан хагас дугуй хэлбэртэй хавтанг ашиглах боловч өөр өөр төрлийн шонгууд нэг дор байрласан тохиолдолд ижил аргаар гүйцэтгэхэд хүндрэлтэй байдаг. Иймд талбайтай урьдчилан танилцах хэрэгтэй. Хагас дугуй хэлбэртэй хавтанг ашиглахдаа шонгийн хажуугийн хоёр эгнээ хавтанг зүсэж хаягдал хавтан гаргахгүйгээр өрнө. Олон төрлийн хэлбэртэй шонгийн ойр орчимд хавтан өрөхдөө зүсэгч машин, механик зүсэгч ашиглан дөрвөлжин хавтангаар өрөлтийг зөв хийнэ. Хэрвээ шонгийн хэлбэрээс шалтгаалж механик зүсэгч ашиглан өрөлтийг өө сэвгүй хийх боломжгүй үед инженерийн зөвшөөрлийн дагуу өнгө зохицох бетоноор цутгаж хийнэ. Өөр өөр хэлбэртэй шонгийн суурийг хавтан доор суулгаж, суурийн бетон хавтан дээр ил байх ёсгүй.

6. Замын дагуух мод ногоон байгууламжийн орчимд хавтан өрөх арга

Зам дагуух мод, бутны суурийн хэсэгт төмөр хамгаалалт хийх болон хээг тааруулж хавтан өрөх арга байдаг. Харин модны үндэснээс болж явган зорчигч замаар зорчиход хүндрэл үүсэх газар төмөр хамгаалалтыг заавал суулгана.

7. Явган хүний зам бусад байгууламжтай нийлэх хэсэгт хавтан өрөх арга

Явган хүний зам нь барилга, шат болон бусад байгууламжтай тулж байрласан тохиолдолд байгууламж хүртэл заадсыг 2-3мм байхаар хийнэ. Зайлшгүй тохиолдолд хавтанг орлуулж 100мм хүртэлх өргөнтэй ижил өнгийн бетон цутгах ба хавтангийн зузаанаас илүү гүнд цутгана.

8. Налуу газарт хавтан өрөх арга

Налуу газарт хавтанг өрөхдөө хавтан хоорондын зайг ≤3мм (том хавтан), ≤2мм (жижиг хавтан) түвшинд баримтлан суурийн үеийн нягтруулалтыг жигдхэн хийж, налуу газрын эхэнд жижиг тайрмал хавтангуудыг өрнө. Налуу газрын хавтан өрөлтийг огцом биш жигд уусгаж хийнэ. Огцом налуу үүсэх хэсгийг суурийн үеийн нягтруулалтаар жигд болгоно.

### 1705.5 Барилга угсралтын үеийн хяналт

1. Суурийн үе хангалттай эсэх
2. Автомат зүсэгч машин ашиглаж байгаа эсэх
3. Хавтангийн зүсэлтийг зөв хийж байгаа эсэх
4. Зиг заг болон олон өнцөгт хавтан ашигласан тохиолдолд захын хавтан ашиглаж байгаа эсэх
5. Замд байрлах модны төмөр хамгаалалт болон хашлага хоорондын зайг 2мм-н түвшинд мөрдөж байгаа эсэх
6. Заадас хоорондын зайн хэмжээг (2-3мм) мөрдөж байгаа эсэх
7. Элсээр чигжих тохиромжтой эсэх
8. Автомашины орц гарцын хэсэгт зориулалтын хавтан буюу 80мм зузаантай хавтан хэрэглэж байгаа эсэх
9. Хөтөч хавтанг өрөх аргачлалыг мөрдөх

### 1705.6 Явган хүний замын хавтанг хуулах

Газар доогуурх инженерийн байгууламж болох цахилгаан, холбоо, цэвэр бохир усны шугам гэх мэтийг шинэчлэх, өөрчлөх, шилжүүлэх зорилгоор явган хүний замыг хуулах тохиолдолд иргэдийн тав тухыг алдагдуулахгүйгээр аль олох түргэн хугацаанд барилгын ажил хийгдсэн газрыг хэвийн байдалд оруулна. Хуулж авсан замын хавтанг эвдэрч гэмтэхээргүй зөөж, иргэдийн хөдөлгөөнд саад учруулахгүй газар хадгална.

### 1705.7 Хашлага суулгах

Замын хашлага суулгахад хэв хашмал угсрах, хашлага хоорондын зай, бетон суурийн цутгалтын үе шат зэргийг анхаарч бэхжилтийн хугацаанд барилгын талбайд хашилт барьж хамгаалан барилгын ажлыг хийнэ. Замын хашлагын хэв хашмалыг угсрахаас өмнө сүүлийн үеийн нягтруулалтын шалган, суурийн бетон цутгахдаа замын хашлагыг хөдөлгөөнгүй байхад анхаарна. Замын хашлага (бордюр)-г суулгахаас өмнө орчныг цэвэрлэх ба барилгын ажлын үед зөөж тээвэрлэх явцад эвдэрсэн хашлагыг ашиглаж болохгүй. Хэв хашмалыг угсрахдаа шинэхэн бетоны жингийн үйлчлэлээр бий болох аливаа хөдөлгөөн, хазайлт буюу суулт зэргийг харгалзан үзэх ёстой. Замын хашлага суулгах байрлалд чигийн тэгш байдлыг хангаж утас татна. Хашлагын суурийн эхний бетон зуурмагийг зураг төсөлд заасан хэмжээгээр бага багаар дүүргэн хүрзээр жигд тарааж дээд талын хэсгийг тэгшилж засна. Бетон цутгахдаа зай завсар гаргахгүйн тулд саваа модоор жигд тараана. Хашлагыг суулгахдаа хашлага хоорондын 5-10мм зайг баримтлах бөгөөд 1х2 харьцаатай элс цементэн зуурмагийг хашлага хоорондын завсарт бетоноор дүүргэснээр хөдөлгөөнгүй болгоно. Хоёр дахь бетон цутгалтыг хийж дуусмагц 1-2 өдрийн дараа хэв хашмалыг авна. Замын хашлага нь сууриндаа ямар нэгэн хөдөлгөөнгүй суусан байна. Хэвтээ хашлагатай хэсгүүдэд замын зорчих хэсгийн ус саадгүйгээр гадагшлахаар тавигдсан байх ёстой.

Хүснэгт 17-8: Хашлага суулгах ажлын хүлцэх алдаа

| Төрөл | Хүлцэх алдаа | Шалгах давтамж | | Шалгах арга |
|---|---|---|---|---|
| | | Хамрах хүрээ | Шалгах хэмжээ | |
| Хашлагын шулуун ба алгуур байдлын хэмжээ | ≤8 | 100 у/м тутамд | 1 цэгт | 20 метрийн урттай утас татаж хамгийн их утгыг авна |
| Зэргэлдээ хоёр хашлаганы өндрийн зөрүү | ≤2 | 20 у/м тутамд | 1 цэгт | Шугаман метрээр хэмжиж, хамгийн их үзүүлэлтээр авна. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Завсрын өргөн | ±3 | 20 у/м тутамд | 1 цэгт | Шугаман метрээр хэмжиж, хамгийн их үзүүлэлтээр авна. |
| Хашлагын өндөржилт | ±8 | 20 у/м тутамд | 1 цэгт | Шугаман метрээр хэмжиж, хамгийн их үзүүлэлтээр авна. |
| Гадагш цүлхийх хэмжээ | ±10 | 20 у/м тутамд | 1 цэгт | Шугаман метрээр хэмжиж, хамгийн их үзүүлэлтээр авна. |

### 1705.8 Хашлага суулгасны дараах арчилгаа

Замын хашлага суулгасны дараа бетон суурийн бэхжих хугацаанд хашлагыг хашилтаар хамгаалж гаднын хүн нэвтрэхийг хориглоно. Шаардлагатай үед буюу хуурайшилттай хавар, намрын улиралд хашлагыг гялгар уутаар бүтээнэ.

# БҮЛЭГ 1800 - ӨДРӨӨР ТООЦОХ АЖИЛ

## БҮЛЭГ 1800 - ӨДРӨӨР ТООЦОХ АЖИЛ


| | | |
|---|---|---|
| 1801 | ЕРӨНХИЙ | 18-3 |
| 1802 | ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР | 18-3 |
| | (а) Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмж | 18-3 |
| | (б) Гүйцэтгэгчийн ажиллах хүч | 18-4 |
| | (в) Дэд зүйл дээр нэмэгдэх Гүйцэтгэгчийн ашгийн хувь | 18-4 |
| | (г) Материал | 18-4 |
| | (д) Дэд зүйл дээр нэмэгдэх Гүйцэтгэгчийн ашгийн хувь | 18-4 |

## 1801 ЕРӨНХИЙ

Гэрээний нөхцлийн дагуу Инженер зарим нэмэлт ажлыг өдрөөр тооцох ажлын зарчмаар гүйцэтгэх заавар өгч болно. Гэрээний нөхцлийн дагуу Инженер бичгээр урьдчилан зааварчлага өгч, өдрөөр тооцох ажлын зарчмаар ямар нэг ажил хийгдсэн тохиолдолд Гүйцэтгэгчид төлбөрийг нөхөн олгоно. Гүйцэтгэгч өдрөөр тооцох ажил хийх гэж байгаа тухайгаа Инженерт 24 цагийн өмнө мэдэгдэнэ.

Ажлын тоо хэмжээнд тусгасан Өдрөөр тооцох ажлын төрөлд, Инженерийн зааврын дагуу Гүйцэтгэгч буюу түүний туслан гүйцэтгэгчийн хийсэн өдрөөр тоцох ажилд ашигласан тоног төхөөрөмж, хүн хүч болон материалын зардлын төлбөрийг хамруулна.

Гэрээний нөхцлийн дагуу Инженер ажил эхлүүлэх зөвшөөрөл олгосноос хойш 56 хоногийн дотор Гүйцэтгэгч өдрөөр тооцох ажлыг бүртгэх маягтын загварыг Инженерт танилцуулж батлуулна.

Өдрөөр тооцох ажлыг гүйцэтгэж дууссаны дараа 24 цагийн дотор Гүцэтгэгч ажилд ашигласан тоног төхөөрөмж, хүн-цаг болон ашигласан материалын нарийвчилсан тайланг дээрх маягтаар гарган Инженерт өгнө.

## 1802 ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР

(a) Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмж

Өдрөөр тооцох ажилд оролцсон тоног төхөөрөмж бүрийн нэр төрлөөр ажилласан хугацаанд төлбөрийг хийнэ. Тоног төхөөрөмж бүрийн ажилласан хугацааг мотор/цагийн хэмжигчийн үзүүлэлтээр, эсвэл талбайн зураг авалтаар буюу Инженерийн зөвшөөрсөн бусад аргаар хэмжинэ. Хэрэв өдрөөр тооцох ажлыг гүйцэтгэж байгаа тоног төхөөрөмж нь хэсэг хугацаанд сул зогссон бөгөөд түүний ажилласан цагийг моторын ажилласан цагаар бус, нийт ажилласан цагаар бүртгэсэн бол төлбөрийг Ажлын тоо хэмжээнд тусгасан нэгж үнэлгээний 50%-иар хийнэ.

Тоног төхөөрөмжийн үнэлгээнд дараах зардлууд багтана. Үүнд:

(i) даамал, багийн ахлагч, бригадын дарга зэрэг хүмүүсийн тавих хяналт ба хяналтын ажилтнуудыг тээвэрлэх,

(ii) өдрөөр тооцох ажилд ашиглах тоног төхөөрмжийг талбай руу болон буцааж тээвэрлэх,

(iii) хүнд механизмын жолооч, машины жолооч, жолооч нарын туслах, засварын ажилчдын цалин ба илүү цагийн нэмэгдэл,

(iv) цахилгаан, ус, түлш, шатахуун, тослох материал ба түргэн элэгддэг эд анги болон бусад тоног төхөөрөмж,

(v) тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангахад шаардагдах цахилгааны утас, хүргэх болон буцаах хоолой шугам, уурын хоолой болон бусад багаж хэрэгсэл,

(vi) засвар арчлалт, сэлбэг хэрэгсэл, өрөмний хошуу, ир болон ирлэгээний ба засварын бүх зардлууд,

(vii) элэгдэл хорогдлын зардал, лиценз авах, даатгал, татвар, ашиг , орлого ба бусад зардал,

(viii) Техникийн шаардлагын 100-р Бүлэг болон 1901-р Зүйлд заасантай нийцүүлэх.

(б) Гүйцэтгэгчийн ажиллах хүч

Өдрөөр тооцох ажлыг гүйцэтгэсэн ажилчдын ажилласан цаг зэрэгээр төлбөрийг хийнэ.

Төлбөрийг зөвхөн гар ажиллагааг гүйцэтгэсэн ажилчид болон мастеруудад хийнэ. Үйлдвэрлэлийн бус хяналтын ажилтнуудын зардлыг Гүйцэтгэгчийн нэмэгдэл хувьд орсонд тооцно.

Ажиллах хүчний зардлыг Гүйцэтгэгчийн цалингийн бүртгэлд заасан үнэлгээний дагуу ажилчид болон мастеруудад төлсөн цагийн хөлсийг үндэслэн нөхөн төлнө. Ажилчдад олгосон цалингийн нотолгоог Гүйцэтгэгч Өдрөөр тооцох ажлын тайландаа гаргаж өгнө.

Өдрөөр тооцох ажлыг Инженерээс бичгээр урьдчилан зөвшөөрөл өгсөний дараа, Техникийн шаардлагын 108-р Зүйлд заасны дагуу ажлын бус цагаар гүйцэтгэх ба илүү цагийн хөлсийг зөвхөн Инженер зааварчилгаа өгсөн тохиолдолд хуулиар тогтоосон хэмжээгээр нөхөн олгоно.

(в) Дэд зүйл дээр нэмэгдэх Гүйцэтгэгчийн ашгийн хувь

Өдрөөр тооцох ажил гүйцэтгэсэн ажиллах хүчний зардал дээр Гүйцэтгэгчийн ашгийг нөхөх зорилгоор тодорхой хувийг нэмж төлбөр хийнэ.

Ажилчид болон мастеруудад төлсөн цагийн хөлсөн дээр нэмэгдэх хувь нь дараах зардлуудыг багтаана. Үүнд:

(i) хяналтын зардал, үүний дотор үйлдвэрлэлийн бус даамал, багийн ахлагч, бригадын дарга гэх мэт,

(ii) ажилчид, мастер, хяналтын ажилтнуудыг өдрөөр тооцох ажил хийх газар луу хүргэх ба буцааж тээвэрлэх,

(iii) дээрх ажиллах хүчний тогтвор суурьшил, шагнал, хоол хүнс, байр, амралт, хээрийн захиргааны зардал, тохижилт, даатгал,

(iv) ердийн ажлын цагаар гүйцэтгэсэн өдрөөр тооцох ажлын илүү цагийн нэмэгдэл,

(v) жоотуу, хүрз, тэргэнцэр, нийвий, дамнуурга, шат, алх, цүүц, цахилгаан өрөм, дискэн зүлгүүр гэх мэт өдрөөр тооцох ажилд хэрэглэсэн багаж хэрэгсэл болон ажлын хувцасаар хангах, тэдгээрийг талбайд тээвэрлэж авчрах, засварлах, шинэчлэх,

(vi) ажилчдын цалин, хоол хүнс, ашиг зэрэг Гүйцэтгэгчээс ажиллах хүчтэй холбоотойгоор гарсан бүх зардал,

(vii) Техникийн шаардлагын 100-р Бүлэг ба 108-р Зүйлд заасан шаардлагыг хангах.

(г) Материал

Өдрөөр тооцох ажилд ашиглагдсан материалын үнийг тухайн үеийн зах зээлийн үнээр тооцно. Тухайн үеийн зах зээлийн үнэ гэдэг нь аливаа татвар буюу хямдралыг тооцсон,тухайн орон нутгийн зах зээлийн үнийг үндэслэн тооцсон үнэ болно. Гүйцэтгэгч төлбөрийн баримт, падааныг үнийн баталгаа болгож танилцуулна. Байнгын ажилд ашигласан материалын цэвэр жин, хэмжээ, талбайг Инженерээр шалгуулж төлбөрийг баталгуужилна. Материалын хаягдлыг материалын цэвэр хэмжээнд оруулж тооцохгүй.

(д) Дэд зүйл дээр нэмэгдэх Гүйцэтгэгчийн ашгийн хувь

Өдрөөр тооцох ажилд ашигласан материалын зардлаас гадна материалын хаягдал, тухайн орон нутгийн зах зээлээс талбай руу болон талбай дотор тээвэрлэх зардал, хадгалалт, хамгаалалтын болон бусад зардалд Гүйцэтгэгчийн ашгийг нөхөх зорилгоор тодорхой хувийг нэмж төлбөр хийнэ.

# БҮЛЭГ 1900 - БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ

## БҮЛЭГ 2000 - БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ


| | | |
|---|---|---|
| 1901 | ЕРӨНХИЙ | 19-3 |
| 1902 | УСНЫ ЧАНАР | 19-3 |
| 1903 | АГААРЫН ЧАНАР | 19-3 |
| 1904 | ДУУ ЧИМЭЭ | 19-4 |
| 1905 | ХАЯГДАЛ МАТЕРИАЛЫГ ХЯНАХ | 19-4 |
| 1906 | ЯАРАЛТАЙ АВАХ АРГА ХЭМЖЭЭ | 19-4 |
| 1907 | БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭГЭЭР ЗАЙЛШГҮЙ АВАХ ЁСТОЙ АРГА ХЭМЖЭЭНҮҮД | 19-4 |
| | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ | 19-4 |
| | Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх | 19-4 |
| | Бохирдлоос сэргийлэх | 19-5 |
| | Агаарын чанар | 19-5 |
| | Чимээ шуугиан | 19-6 |
| 1908 | ХЭМЖИЛТ | 19-6 |

## 1901 ЕРӨНХИЙ

Техникийн шаардлагын энэхүү хэсэг нь байгаль орчныг хамгаалах үүднээс Гүйцэтгэгчийн явуулах үйл ажиллагаануудад тавигдах хязгаарлалтыг тогтоож байгаа юм. Байгаль орчныг хамгаалахтай холбогдуулан Инженер болон Захиалагчийн зүгээс тавигдах дүрэм журам, шаардлагыг Гүйцэтгэгч бүрэн биелүүлж ажиллана.

Гүйцэтгэгч нь урьдчилан сэргийлэх болон зайлшгүй шаардлагатай бүхий л арга хэмжээнүүдийг авч явуулах бөгөөд талбай дээр болон талбайгаас гадна хийгдэх ажлын гүйцэтгэл, холбогдох ажлуудыг энэ техникийн шаардлагад тодорхойлогдсон хууль, байгаль орчны зохицуулалтын шаардлагуудын дагуу хийгдэж байхаар явуулна.

Ажлын гүйцэтгэлээс үүсэн гарах аливаа саад бэрхшээлээс урьдчилсан сэргийлэх арга хэмжээнүүдийг авч явуулна. Нэгэнт бий болсон саад бэрхшээлийг гарсных нь дараа арга хэмжээ авахаас илүү түүнийг эх үүсвэр дээр нь дарж арилгах боломжтой бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Ашиглагдаж буй орд болон ойролцоох газруудад хог хаягдал, муудсан зүйл, хортой бодис илэрсэн тохиолдолд гүйцэтгэгч тэр бүх материалыг холдуулан цэвэрлэж өртөгдсөн газар нутгийг анхны байдалд нь оруулахаар сэргээх ажлуудыг инженерийн зааварчилгааны дагуу хийнэ.

## 1902 УСНЫ ЧАНАР

Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлээс болж усаар хангах ба усыг зайлуулах ажиллагаанд ямар нэгэн саад гарах мөн усны эх, нөөц бохирдох зэргээс урьдчилан сэргийлнэ.

Тоосжилтыг багасгах зорилгоор усыг тогтмол ба дахин ашиглаж байдаг газруудад усан дахь ямар нэг бодис, биетүүдийг ёроолд нь тунаж үлдээх зорилгоор тусгай зориулалтын усан савыг суурилуулна. Бодис биетүүдийг тунасны дараагаар усыг тоосжилтыг багасгах болон ямар нэг зүйлийг зайлахад хэрэглэнэ.

Талбай дээр гарсан ус болон бусад шингэн хаягдлуудыг цуглуулж ямар нэг бохирдол үүсгэхгүй байхаар талбай дахь тодорхой нэг газар эсвэл талбайгаас гадна асгаж зайлуулах хэрэгтэй.

Гүйцэтгэгч ажлын явцад үүсэн гарсан ямар нэг зүйлийг инженер болон холбогдох албаны хүмүүсийн зөвшөөрөлгүйгээр гол ус руу хийж болохгүй.

Гүйцэтгэгч нь талбайн дотор болон ойролцоо байгаа гол горхи, шуудуунд ажлын явцад гарсан хог хаягдал, материалууд хаяхгүй байлгах талаар бүх арга хэмжээг авна.

Гүйцэтгэгч гол горхи, суваг, шуудуу, жалга, нуур болон бусад ижил төстэй зүйлсийг ажлын гүйцэтгэлээс үүсэж бий болох бохирдлоос хамгаална.

## 1903 АГААРЫН ЧАНАР

Гүйцэтгэгч нь агаарын чанарт нөлөөлж болзошгүй тоос, хийн газ болон бусад агаарт байгаа хортой нөлөөллийг багасгах ажлын аргачлалыг боловсруулах замаар агаарын чанарт нөлөөлж байгаа сөрөг нөлөөллүүдийг багасгана.

Гүйцэтгэгч үйлдвэрлэлийн явцад материалуудыг боловсруулах болон ашиглах үед үүсч буй тоосыг дарах үүднээс байнга усалж байхаас гадна хуурай болон салхитай улиралд, нөөцөд хадгалагдаж байгаа материалуудыг чийглэж байна. Мөн онцгой тохиолдлоос бусад тохиолдолд, материал болон хог хаягдлыг зөөхөөс өмнө чийглэнэ.

Ил ачаа ачсан машин тоос шороо бохирдол үүсгэж байдаг учир ачааг ачихдаа тэвшинд тааруулан ачсан байна. Агаарын бохирдол, тоос шороо үүсгэх магадлалтай материалуудыг ачихдаа тэвшнээс дээш гаргалгүй берзентэн бүтээлгээр хучиж цэвэр нямбай орчинд ачиж тээвэрлэнэ. Берзентэн бүтээлгээр материалуудыг хучихдаа нурах болон бусад аюулгүй байдалыг хангах зорилгоор тэвшний ирмэгээс доод тал нь 300мм доош илүү гаргаж хучсан байна.

Гүйцэтгэгч хайрган болон шороон замаар тээвэр хийх үедээ тоос шороог багасгах тохиромжтой арга хэмжээг авна. Энэ арга хэмжээнд замын гадаргууг тодорхой хугацааны давтамжтайгаар услах ажил багтана.

**1904 ДУУ ЧИМЭЭ**

Гүйцэтгэгч ажлыг төлөвлөх, гүйцэтгэх үедээ дуу чимээг байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх гэж үзэх ёстой.

Гүйцэтгэгч байгаль орчны шаардлагыг харгалзан, барилгын ажлын явц болон тоног төхөөрөмж ажиллаж байх үед шаардлагагүй, хэтэрхий чанга дуу чимээ гаргахгүй байлгах үүднээс шаардлагатай арга хэмжээг авна. Гүйцэтгэгч нь барилгын ажлын үед дуу чимээг багасгах үүднээс үйлдвэр завод, тоног төхөөрөмж механизм болон дуу намсгах төхөөрөмжийг байнга арчилж засварлаж байна.

**1905 ХАЯГДАЛ МАТЕРИАЛЫГ ХЯНАХ**

Гүйцэтгэгч нь барилгын болон бусад дагалдах үйл ажиллагааны үр дүнд үүссэн бүх төрлийн хаягдлуудад хяналт тавих үүрэгтэй. Хянах боломжгүй хаягдал болон нөөцөд бүх төрлийн бензин, тос, битумэн хольц, аюултай хог хаягдал зэрэг зүйлс орохгүй. Мөн Гүйцэтгэгч нь эдгээр хаягдлуудыг зайлуулж хаяхдаа орон нутгийн нутгийн хууль дүрэм болон Инженерийн шаардлагыг хангахуйц арга хэмжээг авна.

**1906 ЯАРАЛТАЙ АВАХ АРГА ХЭМЖЭЭ**

Гүйцэтгэгч цемент, тос, химийн гаралтай бодис асгарах тохиолдолд авах арга хэмжээг төлөвлөнө.

Гүйцэтгэгч нь ийм онцгой тохиолдол үүссэн үед хэрхэн эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэх болон эдгээрийг хэрэгжүүлэх талаар ажилчдад зориулсан сургалтыг хэрхэн зохион байгуулах талаарх төлөвлөгөө зэргийг боловсруулж, Инженерт танилцуулна.

**1907 БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭГЭЭР ЗАЙЛШГҮЙ АВАХ ЁСТОЙ АРГА ХЭМЖЭЭНҮҮД**

**<u>Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ</u>**

Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн ихэнх нь зам барилгын ажлын үед гарах учир эдгээр нөлөөллийг бууруулах арга хэмжээг барилгын ажил гүйцэтгэгч авч хэрэгжүүлэх шаардлагатай. Иймд сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг Захиалагч нь Гүйцэтгэгчтэй байгуулах гэрээнд тусгах шаардлагатай.

**<u>Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх</u>**

Зам гүүрийн барилгын ажилд ашиглах шороо, чулуу, элсний карьерийг Монгол улсын газрын хэвлийн хууль болон Байгаль орчныг хамгаалах хуулийн холбогдох бүлэг, зүйл, заалтын дагуу Инженер болон Захиалагч, тухайн орон нутгийн удирдлага, байгаль хамгаалагч нартай зөвшилцөн сонгож, экологийн тэнцвэрт байдлыг нь хадгалах, нөхөн сэргээх чиглэлд нийцүүлэн ашиглалт явуулна.

Зам гүүрийн барилгад ажиллах машин механизмын нөөц шатах тослох материалыг үер уруйн усанд өртөгдөж, байгаль орчныг бохирдуулахааргүй газрыг сонгож хадгалан, ашиглалтын аюулгүйн дүрэм, шаардлагыг мөрдлөг болгон ажиллана.

Гүйцэтгэгчийн кемп, бетон хийцийн үйлдвэрлэл, трассын дагуух замын ажлын талбай нь хил зааг тогтоосон хаалт хашлагатай, бороо хур, цасны ус орох боломжгүй, барилгын материал хадгалах агуулах савтай байх шаардлагатай.

Замын трассын дагуу талбай цэвэрлэх ажил нь холбогдох бүх зөвшөөрөлд тусгасан шаардлагын дагуу хийгдэнэ. Талбай цэвэрлэх ажлыг зөвхөн төслийн тодорхойлолтонд тусгасан хэсэгт хийнэ

- Талбай цэвэрлэх явцад газрын хөрсийг 200-400мм- ээс хэтрэхгүй гүнд хуулж, бүх бут, хог хаягдал болон бусад материалыг зурганд заасан талбайгаас гаргаж, үржил шимт хөрсний овоолгод нийлүүлж хадгална.

- Зөвхөн ажлын талбайн техникийн төлөвлөгөөн дээр заасан газар дээр талбай цэвэрлэх ажлыг явуулна. Тухайн талбайн зах хязгаарыг тэмдэглэхийн тулд урьдчилан тодорхой зайтайгаар гадсан дэээр тэмдэг тавина. Талбай цэвэрлэх ажлын үеэр уг талбайг цэвэрлэхийг зөвшөөрсөн хязгаараас гадагш буй ургамлыг устаж сүйтгэж үл болно.
- Талбай цэвэрлэх ажлыг бульдозер, грейдэр зэрэг механик цэвэрлэгээний аргыг ашиглан явуулна. Гинжит машин ашигласнаар газрын хөрсийг гэмтээж, хөрсний дээд давхарга эвдэгдэх буюу гол горхины ус бохирдох нөхцөлтэй байвал бусад гар ажиллагаатай багаж, тоног төхөөрөмжийг ашиглавал зохино.
- Хөрс эвдрэх шинж тэмдэг болох дараах нөхцөлүүд үүссэн тохиолдолд холбогдох арга хэмжээг авах шаардлагатай. Үүнд: Түр зам хэтэрхий гүнзгий ховдолтой болох, бороо орсны дараа газар нойтон байхад хүнд даацын машинаар явж газар зүсэгдсэн зэрэг орно.
- Ухмалтай хэсэгт түр зам барихдаа ухмалын хажуу налуугийн өнцгийг 45° -аас ихгүй байхаар хийж, хөрс чулуу нурах, хөрс гулсахаас хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.
- Төслийн замын хөдөлгөөнийг нээсний дараагаар замын дагууд үүссэн түр замыг дахин ашиглах явдлыг бүрмөсөн зогсоохын тулд тэнд хөрс сийрүүлэлт хийх, ургамалжуулах арга хэмжээ авах, түүгээр явахыг хориглосон тэмдэг заалт хийж байрлуулна.
- Замын барилгын ажил дуусахад нүх, цооног, ажлын талбай, тээвэрлэлтийн зам дагуу эвдэрсэн бүх газруудад дүүргэлт хийн орчны гадаргын налуутай ойролцоо байдалд оруулан тэгшилж, нөөцөлсөн үржил шимт хөрсөөр жигд тараан хучина.
- Гүйцэтгэгч нь замын барилгын ажлыг дуусгаад хүлээлгэж өгөхийн өмнө тэнд түр суурьшиж байсан газрууд дахь гэр, байр, агуулах сав ба замын ажилд ашиглагдаж байсан машин механизм, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл зэргийг нүүлгэн шилжүүлж, замын дагуух талбайг бүрэн чөлөөлнө.
- Чөлөөлөгдсөн талбайг бүрэн дүүрэн цэвэрлэж ахуйн болон техникийн хог хаягдлыг тухайн аймаг сумын зөвшөөрөгдсөн хогийн цэгт тээвэрлэн зайлуулна. Тэнд ашиглагдаж байсан бие засах газар, шингэн хаягдлын нүх цооногийг дүүргэлт хийн тэгшилнэ.
- Түр суурин, тээвэрлэлтийн зам, бусад бүх элэгдэж талхлагдсан газруудад хөрсний сийрэгжүүлэлт хийж, ургамалжуулна.

Зам барилгын үед ажлын хэрэгцээнд зориулан олгосон талбайг нөхөн сэргээн орон нутгийн засаг захиргаанд хүлээлгэн өгнө.

**<u>Бохирдлоос сэргийлэх</u>**

- Барилгын ажилчдын суурингийн хатуу, шингэн хаягдлын цэг, бие засах газар түүний эргэн тойронд тогтоосон хугацаанд мэргэжпийн байгууллагаар ариутгал хийлгэнэ.
- Бие засах газар, шингэн хаягдлын цооног, хатуу хогийн сав нь бороо хурын ус орох боломжгүй дээвэр, таг хавхлагатай байхын сацуу тэгш газарт байрлагдсан байна.
- Хатуу шингэн хог хаягдлыг орон нутгийн зөвшөөрсөн хогийн цэгт зориулалтын машинаар тээвэрлэн зайлуулна.

**<u>Агаарын чанар</u>**

Тоос, машины утааг багасгах зорилгоор олон төрлийн арга хэрэгслийг ашиглаж болно. Хүснэгт 19.1-д бохирдлыг багасгах аргууд, тэдгээрийн үр дүнг жагсаав.

**Хүснэгт 19.1 Барилгын ажлын явцад агаарын бохирдлыг багасгах арга**

| Арга | Үр дүн (зардал) |
|---|---|
| Ажлын талбай руу орох хэсэг, бетон зуурах төхөөрөмжийн эргэн тойрон, материал зөөж тээвэрлэх зам, машин мөханизмын засвар хийх, тэдгээрийг байрлуулах зогсоол зэрэг хөдөлгөөн ихтэй хэсгүүдэд хучилт хийх юмуу нийлэг материал ашиглаж дэвсэх | Дунд зэрэг (зардал их) |
| Барилгын ажилд хэрэглэгдэх материалыг зориулалтын байр саванд хадгалах | Сайн (зардал их) |
| Барилгын талбайд ажиллаж буй машин, төхөөрөмжийн засвар үйлчилгээг тогтмол хийж, ажилд хэрэглээгүй үедээ унтрааж байх | Сайн (зардал бага) |
| Барилгын талбайгаас гарч явах машиныг урьдчилж бэлтгэсэн бага хэмжээний устай талбайгаар дайран өнгөрүүлэх замаар дугуйг тоос шороогүй болгох. Энэ нь хот суурин газруудад илүү ач холбогдолтой байна. | Сайн (зардал бага) |
| Машины хурдыг багасгах | Багаас дунд зэрэг (зардал бага) |
| Чулуу зүсэх, бутлах ажилд нойтон аргаар хөрөөдөх болон вакуумт бутлуур зэрэг тоос бага үүсгэх тоног төхөөрөмж ашиглах | Дунд зэрэг (зардал бага) |
| Материал нөөцлөх газар болон тоос босгодог материалуудыг ачиж буулгах явцад усалж норгох | Сайн (зардал бага/дунд зэрэг) |
| Химийн нэмэлт бодис ашиглаж тоосгүйжүүлэх | Сайн (зардал их) |
| Материал зөөж тээвэрлэх түр замын тоо, өргөний хэмжээг багасгах | Багаас дунд зэрэг (зардал бага) |
| Бетоны тоосыг үлээх аргаар бус соруулж цэвэрлэх | Сайн (зардал дунд зэрэг) |
| Тоос босгодог материалыг ажлын нэг талбайгаас нөгөө рүү зөөж тээвэрлэхдээ брезинтээр бүтээх | Дунд зэрэг (зардал бага) |
| Хэт хуучин машин механизмыг ашиглахгүй байх | Сайн (зардал өндөр) |

**<u>Чимээ шуугиан</u>**

- Чимээ шуугианы түвшин 70 дб-ээс ихгүй байх ёстой.
- Ажилчдын байр, барилгын ажлын талбайтай ойрхон байвал чимээ шуугианыг хязгаарлахын тулд механизм, тээврийн ажлыг ээлж дараатай ажиллуулах, суурьшил, хүн ам ихтэй хэсгүүдэд замын ажлын зурвасын дагуу чимээ шуугианаас тусгаарлах хаалтууд босгох
- Машин механизм, тоног төхөөрөмжийг дуу намсгагчтай ажиллуулах
- Машин механизмыг ашиглаагүй үед хөдөлгүүрийг унтрааж байх.

## 1908 ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР

Техникийн шаардлагын энэхүү нөхцлийн заалтуудыг хангах үүднээс гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэсэн ажлуудыг тусад нь хэмжихгүй. Гүйцэтгэгч нь ажлын тоо хэмжээний үнэ

өртөгт энэхүү шаардлагыг хангахтай холбогдон гарах зардлыг багтаасан гэж үзэх ба эдгээртэй холбоотой бүх нөхөн төлбөрийг гүйцэтгэгч тал төлнө гэж үзнэ.